

**Габриель Гарсиа Маркес**

## **Зуун жилийн ганцаардал**

Олон жилийн хойно хурандаа Аурелиано Буэндиа гэгчийн бие Макондогийн оршуулгы газрын хайсны дэргэд буудуулх гэж зогсохдоо, тэ жилийн нэгэн үдэш мөс үзүүлэхээр цыганууд дээр эцгийнхээ дагуулж очсоныг санаж авай. Тэгэхэд Макондо хулс, шавраар барьсан хориод навтгар овоохой бүхий жижигхэн суурин байж, хаяагаар нь галавын үеийн амьтны өндөг шиг асар том мөлгөр цагаан чулуун дундуур тунгалаг уст гол мяралзанхан урсдаг байлаа. Ертөнц шинэхэн учир олон юмс нэр усгүй, тэдгээрийг дурдах болбол хуруугаараа заан ярилцдаг байвай. Жил бүрийн гуравдугаар сард суурины захад ноорхой цыганы нэгэн овог асар майхнааа шаан бууж, шүглийн шийхнэх, бөмбөрийн пижгэнэх дуунаа эрдэмт хүмүүсийн сүүлийн үеийн бүтээлийг макондогийнхонд үзүүлдэг байлаа. Эхлээд цыган нар соронзон гүр авчрав. Мелькиадес гэдэг бавгар сахалтай, шувууны савар шиг мойног хуруутай лүглэгэр цыган Мекедоны рилү бүтээгчдийн<sup>1</sup> бүтээсэн, ертөнцийн найм дахь гайхамшиг<sup>2</sup> гэж өөрийн нэрлэсэн зүйлийн идийг олонд чадал заан үзүүлэв.

1 Рилү бүтээхүй ухаан буюу алхим бол хувилахуй ухаан шинжлэх ухаан болон хөгжихийн өмнө гарсан нэгэн чиглэл мөн. Манай эриний III-IV зуун үед Мисир газар үүсээд V-VI зууны үед Өрнөт Европт өргөн дэлгэрчээ. Рилү бүтээгчид (алхимичид) энгийн металыг алт, мөнгө болгон хувиргах мөнхийн аршаан гаргаж авах рилү (философский камень) гэгчийг олох гол зорилго тавьж байв.- Орч

2 Мисирийн цац, Эфис дэх Артемидагийн (ав хоморгын охин тэнгэр) дуган, Галикарнас дахь бунхан, Вавилон дахь Семиранмидагийн “дүүжин цэцэрлэг” Олимпи дахь Зевсийн хөшөө, Родос дахь Гелиосын хөшөө Александрын гэрэлт цамхаг энэ долоог хийж хосгүй уран гоёын учир ертөнцийн долоон гайхамшиг гэнэ. Энд энэ долоотой тэнцэх найм дахь гайхамшиг гэсэн утгаар хэрэглэжээ.- Орч

Тэрвээр хоёр төмөр саваа барьж, айл айлаар ороход төмпөн% хувин, хайч, хоовон байрнаасаа ховх хонх үсэрч, хадаас шураг хүчтэй татахын аяг даахгүй цуурч байгаа банзнаас суга суга үсрэх гэж тэмүүлэн байхыг улс хиртхийн үзжээ. Олдохоосоо огт өнгөрсөн гэж байсан юмс яг эрээд ядчихсан тэр газраас нь гарч Мелькиадесийн шидэт савааны араас хуйлран дагана. Тэр цыган испани хэлээр их л хазгай мурй дуудаж, “Эд бараа гэдэг бас амьтай байдаг юм. Гагцхүү тэр юмсыг сэтгэлийг хөдөлгөж чадах хэрэгтэй” хэмээн сүртэй гэгч өгүүлнэ. Суут байгаль эхийн бүтээн чадахыг сэтгэлдээ төсөөлөхөөр үл барам түүнээс ч хол давж, ид шид, илбэ жилбийн гайхамшгаас хэтийдсэн юмыг ч төсөөлөн сэтгэж улмаар ургуулан бодох үзэмжийн чадвартай Хосе Аркадио Буэндиа, хараахан ашиг тусаа өгөөгүй байгаа шинжлэх ухааны тэр нээлтийг газрын хэвлээс алт гаргаж авахад зохицуулж болно хэмээн боджээ.

Мелькиадес шударга хүн байсан болохоор “Соронзон тиймюманд хэрэг болохгүй” гэж сануулан хэлсэ боловч тэр үед Хосе Аркадио Буэндиа цыганы голч чигчид

итгэлдэггүй байсан учир соронзон савааг луус, хэдэн ишгээрээ арилжин авлаа. Буэндиагийн авааль гшэргий Урсула Игуаран энэ хэдэн малаараа ар гэрийнхээ уначихсан ажлыг өөд татах гэсэндээ тэр арилжааг бүү хийтүгэй хэмээн хориглож ядсан болоч эр нөхөр нь “Удахгүй чамайг алтаар драад өгнө. Хийх саваа л мэдээрэй” гэж хариулжээ. Хэдэн сар хэлсэн амандаа хүрэх гэж зүтгэн, хоёр төмөр саваагаа араасаа чирэн, Мелькаидесийн зааж өгсөн тарнийг чанга дуугаар урин урьж, хавийн газар, тэр ч байтугай голын ёроолыг хүртэл нэ нэгэнгүй самнаж үзвэй. Гэвч түүний газар дээр гаргаж ирсэ юм гэвэл арван тавдугаар зууны зэвэнд идэгдсэн битүү хуяг байлаа. Тэр хуягийг цохиход чулуу дүүргэсэн гуа адил дүнгэнэх ажээ.

Хосец Аркаио Буэндиа өөрийг ньхайгуулд дагаж явсан сууриныхаа дөрвөн хүнтэй хамт тэр хуягийг задалбал дотроос нь мах нь үгүй болсон хүний араг яс гарсныг үзсэнд хүзүүнд нь эмэгтэй хүний туг үс бүхий зэс гуу байлаа.

Гуравдугаар сард цыганууд дахин хүрч ирэв. Одоо тэд яндан дуран, сайн бөмбөрийн дайтай галт шил хоёр авчирч, үүнээ амстердамын жүүд нарын цоо шинэ бүтээл гэж зарлав. Яндан дуранг асрын дэргэд зоогоод гудамжны цаад өнцөгт цыган эмэгтэйг суулган таван реалын<sup>1</sup> хөлстэйгөөр дурангаар харуулахад цыган хүүхэн гараар илээд авахаар ойрхон харагджээ. “Шинжлэх ухаан орон зайг товчиллоо. Удахгүй хүн гэртээ сууж байгаад ертөнцийн аль ч хэсэгт болж байгаа зүйлийг харж болно” гэж Мелькаидес тунхаглан айлджээ. Халуу дүүгсэн нэгэн үдээр цыганууд асар том галт шилээр гайхалтай илбэ үзүүлж, гудамжны голд хуурай өвс овоолоод галт шилээрээ нарны туяа тусганасанд өвс дүрсхийн шатав. Соронзогоор алт олох гэсэн нь бүтээгүйд тайтгарч шатав. Соронзонгоор алт олох гэсэн нь бүтээгүйд тайтгарч амжаагүй байсан Хосе Аркадио Буэндиа галт зэвсгийг байлдааны зэвсэг болгоё гэж дорхноо боджээ. Мелькаидес түүнийг урьдынх шигээ хориглож хориглож, галт шилээ хоёр соронзон саваа, гурван алтан зоосоор соливол соль гэжээ. Урсула адраа удлан алтан зоосноосоо өгөхөөс аргагүй болсондоо ёстой буруу харж уйлж, зөв харж инээжээ. Уг нь эцгийнхээ хуруу хумсаа тайрч байж насан туршаа хураасан тэ мөнгийг ашигтайхан юманд зарах санаатай нөөгөөд орон оороо хадгалж байсан юмсанжээ. Хосо Аркадио Буэндиа эхнэрийнхээ сэтгэлийг ч засаж барьсан юмгүй шинэ туршилтыг шамдан эхэлж жинхэнэ эрдэмтэн хүний байдлаар биеэ гаргуунднь хаяж, тэр ч байтугай аминдаа ч аюул учруулахаас буцахгүй болж билээ. Тэрбээр гал шилийг дайсны цэргийн өөдөөс хэрэглэж болно гэдгийг нотлох гэхдээ биеэ төөнөсөнд, түлэнхий нь яршин удтал анихгүй зовоожээ. Буэндиа гэрээ ч шатааж үзэх осолтой санаа сэдсэн боловч эхнэр нь тас хорив. Хосе аркадио Буэндиа цоо шинэ зэсгийнхээ стратшегийн чадлыг эргэцүүлэн олон цаг тасалгаандаа сууж, тэр ч байтугай хэрэглэх удирдамж зохиож, чухам яаж хэрэглэхийг их л тодорхой, хөдөлшгүй баримттай тайлбарлажээ. Хийсэн туршлагаа тоорхойлон бичсэн олон зүйл, хэд хэдэн хуудас тайлбар зураг сэлтийг уул удирдамждаа хавсаргаж нэгэн элчээр эрх баригчдад явуулж, тэр элч нь өндө уулыг давж, өргөн мөрнийг гаталж, өрх намаг туулж, дайд бөглүүдэд уйдан зовж, догшин аратанд бариулан алдаж, тахал өвчнөөр үхэх дөхөн явсаар түмэн алжаал, буман бэрхдлийг давж их замд оржээ. Тэр үед хот орно гэдэг санахын гарз

1 эртний испанийн мөнгөн зоос, -Орч

шахам байсан боловч, Буэндиа эрх баригчдын дуудсан даруйд л очиж, бүтээсэн зүйлинхээ чадлыг цэргийн дарга нарт үзүүлж, тэр ч байтугай гэрлийн дайны нарийн

эрдмийг тэдэнд биелчлэн зааж сургахаар зэхэж байлаа. Тэгээд хэдэн жил хариу хүлээж бүр ядчихаад Мелькиадест, дахиад л урагшгүйтснээ гомдоллон хэлбэл цыган уужим сэтгэлээ ёстой нэг гаргаж, галт шилийг нь эргүүлж аваад, алтан зоосыг нь буцааж өгөөд, португалийн далайн хэдэн зураг, хөлгийн жолоодлогын олон багаж бэлэглэжээ. Мелькиадес Герман гэлэнгийн бүтээлийг гараараа товчлон сийрүүлж, од эрхсийн байрал, өнцгийг олох багажийг ашиглах аргыг бичиж Хосе Аркадио Буэндиад өгчээ. Борооны улирлын урт сард, туршилт хийхэд нь хүн саад хийх болуужин гэж байшингийнхаа мухлрын умгархан өрөөг түгжин суужээ. Гэрийн ажилд оролцохыг огт больж, од гаригийн гүдйлийг шинжин, гадаа хононо. Нарын хөөрөх туйлыг хэмжих гэж бйж наранд золтой л цохиулсангй. Багаж нь гарт нь ороод ирэхэдтэрвээр орон зайн тухай нарийн ойлголттой болж, одооноос эхлээд гэрээсээ гаралгүйгээр үзэж хараагүй далай тэнгисээр аялж, хүн амьтангүй газар орныг шинжилж, ид шидийн амьтадтй харилцаж чадах болжээ. Чухамхүү тэ л үед Хоже Аркадио Буэндиа гэр дотуураа хөлхөн, хэнийг ч анхааралгүй ганцаараа ярьчих зантай болсон бөгөөд түүнийг тэгж байхад Урусула хэдэн хүүхэдтэйгээ гадил, маланга, төмс, наанги цагшаан ауйям, пагсаа жимс арчлан тариан талбайд нуруугаа бөггийтөл ажиллаж байлаа. Гэтэл Хосе Аркадио Буэндиа толгой өөд татахгүй ажиллаж байснаа гэнэт болиод нэг л хачин болчихов. Хэдэн өдөр юманд хорлогдсон юмшиг болж, элдэв таамаг дэвшүүлэн, өөртөө ч итгэхгүй гайхан амандаа дүнгэнэтэл ярьжээ. Арван хоёрдугаар сарын нэгэн мягмар гаригт хоол идэж сууснаа эргэлзэж тээнэгэлзэж байсан зүйлийнхээ учрыг гэнэт бүрэн олжээ. Нойр алдан, олон хоног тархиа гашилтал юм бодсоноос зүдэрсэн цэгийнхээ халуурч байгаа мэт дагжин чичирсээр ширээний эхэнд магнай тэнүүн, тэр ч байтугай маш жвахлантай суугаад,

- Дэлхий чинь зүрж шиг бөөрөнхий юм гэж нээн олсноо хэлснийг хүүхдүүд нь насан туршаа мартахгүй нь лав.

Урусула багтартлаа уурлаж, “Чи солиорох мөрөөрөө солиор. Цыганы солио өвчнийг хүүхдэд бүүхалдаачих” гэж аашлаад одны байршил олох багажийг нь хэм чулуудсан боловч Буэндиа тоосон ч үгүй, айж эмээсэн ч үгүй, өөр нэг багаж хээвнэг хийж аваад, умгархан өрөөндөө сууриныхаа харчуулыг цуглуулж, хэний ч үл ойлгох огол дурдаж, дандаа дорно зүг хөвөөд байвал яг эргээд гарсан газраа хүрээд ирн эгэдгийг тэдэнд нотолжээ. Макондогийнхон Буэндиаг толгойдоо юмтай болж гэж бодоцгоож байтал азаар тэр үед Мелькиадес ирж тааран, учрыг олж хужрыг тунгаан өгчээ. Аль эрт практикаар батлагдсан байсан боловч маьондынхны огт мэдэхгүй байсан тэр нээлтийг зөвхөн од мичид ажигласаар хийсэн Буэндиагийн гоц ухаантайг цыган өндөр дуугаар магтаж, өөрийн бахархан бахдаж байгаагийн нотолгоо болгон рилү бүтээхүй ухааны лабораторийн төхөөрмж түүнд бэлэглэсэн нь сууриныхны хувь заяанд тус болох учиртай байжээ.

Яг тэр үеэр Мелькиадес хачин амархан өтлөв. Цыган эр анх тосгонд ирж байхдаа Хосе Аркадио Буэндиагийн насны хүн харагдаж байлаа. Гэтэл Буэндиа нь тэнхээ гэж тоймгүй, морь ч чихдээд унагахдаа тоохгүй хэвээрээ байхад цыган ужиг өвчинд ээргэдсэн шиг эцэж турж байлаа. Угтаа бол тэр нь ганц өвчний гай бус, хорвоо дэлхийгээр хэрэн тэнэсээр туссан олон ховорхон өвчний урхаг байжээ. Мелькиадес, Буэндиад лаборатори тоноглоход нь тусалж байхдаа, эрлэгийн элч өөрийг нь газар сайгүй дагаж яваа боловч эрлэгийнд бүрмөсөн аваачих зүрх нь арай л хүрэхгүй байгаа бололтой гэж ярьжээ. Тэрбээр хүн төрөлхтнийг дайрч байсан бүх гамшиг сүйрэлтэй тулгарч явсан боловч эсэн мэнд гарч байсан толгой билээ. Перст хулгана яр, Малайн хойгт бам, Александрийд уяман, Японд хөх гуя, Мадагаскарт булчирхайн тахал туссан

боловч үхээгүй, Сицилийн арал дээр газар хөдөлж, Магелланы хоолойд хөлөг онгоц сүйрэн олон хшний амь сүйдэхэд бас л амьд гарсан байжээ. Нострадамусын1 нууцыг мэддэг гэж ам шүд алдах энэ жигтэйхэн эр булшнаас гарч ирсэн байдалтай, бүлцгэр нүд нь юмс үзэгдлийн цаад талыг нэвт харж чаддаг байртай санагдана. Хэрээний

## 1 Нострадамус (1503-1566)- францын зурхайч эмч

дэлгэсэн далавч аятай далбагар хүрээтэй том хар бүрх, он удаад буриваад идэгдэн ногоорсон хантааз өмсөж явна. Цаглашгүй ухаалаг, туйлгүй битүүлэг боловч мах цусанд төрсөн хүн байсан бөгөөд биеийн хүндээрээ газартаа татагдаж, өдөр тутмын амьдралын зовлон зүдгээр, аж төрөлд дийлэгдэх ажээ. Өвгөрөөд тэнхээ тамир алдрах боллоо” гэж үглэх болж, аар саар юманд зарах мөнгөгүй гачигдаж, бөм өвчнөөр хамаг шүд нь юүрээд уначихсн тул инээхийг аль эрт больсон ажээ. Тэр нэгэн бөгчим халуун өдөр Мелькиадесийн нууцаа тайлснаас хойш өөрдсийнх нь их үерхэл эхэлсэн гэж Хосе Аркадио Буэндиа үзэж байлаа. Хүүхдүүд цыганы хүн үнэмшмээргүй яриаг гайхан чагнана. Тэгэхэд таван ойноос хэтрээгүй байсан Аурелиано Мелькиадесийн гэрэлтэй цонхны наана хүглийн сууж бадралт баг бишгүүрийнх шиг дуу нь элдэв аймаар юм бодогдуулж, халуунд хөлс нь шанаагаар нь хайлсан тос шиг урсан байсныг насан туршаа санаж явна. Аурелианогийн ах Хосе Аркадио түүний гайхамшигт дүрийн үр саддаа үе залган ярих дуртгал болгон үлдээнэ. Харин Урсула л цыганы ирэхэд тун таагүй байдаг байв. Энэ нь ямар учиртай вэ гэвэл тэрбээр, Мелькиадесийн шилэй хлорын мөнгөн ус санамсаргүй алдаад хагалж байх үеэр яг тасалгаанд орж ирсэн юм санж.

- энэ чөтгөрийн үнэр байна гэж Урсулагийн хэлэхэд Мелькиадес татгалзаж,
- Огт үгүй. Чөтгөр борын хүчлийн үнэртэй байдаг нь тогтоогдсон юм, энэ бол ердөө ялихгүй жаахан түргэн цагааны үнэр гэжээ.

Тэгээд Мелькиадес, шунхны тун хачирхам шингэнийг сургамжлангуй дуугаар дэлгэрэнгүй гэгч нь тайлбарласан боловч Урсула түүнийг нь огт сонирхсонгүй, хүүхдээ мөргүүлэхээр авч явжээ. Үүнээ схойш хурц үнэр гарахад, Мелькиадес санаанд нь ороод байдаг болжээ.

Бүдүүлэг лабораторид нь олон хувин, юүлүүр, шүүр, шүүлтүүрээс гадна энгийн хяс, рилүг1 хийх халуун хүзүүт шил, Иудийн Маригийн 2 хэрэглэж байсан гурван цорготой нэрэх тогооны шинэчилсэн төслөөр цыгануудын өөрсдийн нь хийсэн бүрхээр төдийхөн байдаг байлаа. Түүнээс гадна Мелькиадес долоон гаригтай тэнцэх долоон төмөрлөгийн дээж, алтны тоо хоёр дахин ихэсгэх Моисей, Зосимын томъёолол, их магистерийн3 салбарт хамаарах тэмдгэл, зургийг Хосе Аркадио Буэндиад өгчээ. Эдгээрийн учрыг олосн хүн рилү гаргаж чадах ажээ. Алтыг хоёр дахин их болгох томъёолол энгийн байсанд хорхой нь хүрсэн Хосе Аркадио Буэндиа хэдэн долоо хоног эхнэртээ тал засан тойрогуудлж байгаад нандигнадаг хайрцагнаас нь хуучны зоосыг гаргуулж, мөнгөн усны хуваагдахын тоогоор түүнийг нь олшруулахаар амлажээ. Урсула нөхрийнхөө шалаад салахгүйд аанай л цааргалж чадсангүй. Буэндиа гучин дулоныг хувинд хийж, хүхэрт хүнцэл, зэсийн үртэс, мөнгөн ус, хар тугалганы хамт хайлуулав. Дараа нь энэ бүхнээ тосон туулга бүхий тогоонд хийгээд үмхий үнэртэй өтгөн бантан болтол нь шиүүн гал дээр буцалгасан нь алт болж арвижихаасаа илүү ердийн цардуулын бурамтай төстэй юм

болчихжээ. Ахин нэрж долоон гаригийн нэр бүхий төмөрлөгтэй холин дахин хайлуулж, гермесийн мөнгөн ус,4 байвангаар боловсруулж, цагаан луувангийн тос байгаагүйн учир гахайн өөхөнд дахин буцалгах зэргээр их зоригтойгоор аз үзэн ноцолдсоны эцст, Урсулагийн үнэт өв тогооны ероолд барьцалдан наалдсан шимэлдгэрхүү юм болчихов.

Тэр үеэр цыганыг дахин ирэхэд Урсула тосгоныхныгоо түүний өөдөөс турхирсан боловч тосгоныхныг нь айхаасаа сониучирхах нь дийлжээ. Цыганууд зүйл бүрийн

1 Философский камень буюу философское яйцо гэдэг нь мегаллыг алт болгон хувиргах бэлтгэмэл. Үүнийг манай эртний орчуулгад рилү (үрэл) гэж, алхимичийг нь рилү бүтээгч гэж байсан байна. Энэ уламжлалыг энд баримтлав. – Орч

2 Иудийн Мари-рилү бүтээгч эмэгтэй (манай эриний III зууны эцэс)

3 Их магистерий-рилүний өөр нэр

4 Гермесийн мөнгөн ус гэдэг нь рилү бүтээгчдийн алт гаргаж авахдаа хэрэглэж байсан мөнгөн ус. Рилү бүтээх ухааны үндсийг тавигчдын нэг. Гермес Трисмегистийн нэрээр нэрлэжээ. –Орч

Хөгжим чих дөжрөм хангинуулсаар гудамжаар өнгөрч, зарч нь низианзныхны1 хамгийн аугаа их нээлтийг үзүүлнэ гэж зарлав. Цөмөөрөө цыганы асар тийш очиж, нэг сентаво2 төлөөд дотогш орвол Мелькиадес эв эрүүл, зав залуу, үрчлээ атираагүй, гялалзсан шинэ шүдтэй болчихсон байж байлаа. Бамтсанаас болж нүцгэн буйл үлдэж, хацар нь хонхойж, уруул нь үрчлээтсэнийг сайн мэдэх хүмүүс, жам ёсноос гадуур ид чадлтайгийнх нь энэхүү сүүлийн нотолгоог үзэхдээ хиртхийн цочжээ. Мелькиадес бүв бүрэн эрүүл шүд амнасаа гарган үзүүлж, агшин зуур урьдынх шигээ өтөлсөн өвгөн болсноо дахин шүдээ хийгээд инээмсэглэвэл ид гялалзаж яваа эр дунд насны хүн болчихсонд булгаараа бүр ч сүнсгүй айжээ. Хосе Аркадио Буэндиа хүртэл Мелькадесийн мэдлэгийг хүний хэрээс хэтрээгүй байгаа даа гэж эргэлзэхэд хүрчээ. Гэвч цыгшан хоёулхнаа үлдээд хиймэл шүднийхээ учрыг тайлж өгсөнд сая дотор нь онгойж тачигнатал хөхөрчээ. Энэ бүхэн нь нэг бодоход тун энгийн, нөгөө бодоход туйлын хачин санагдсан учир, маргаашнаас нь рилү бүтээхийг сонирхохоо огт больж, аль санасан цагтаа хоолоо идчихээд өрөөн дотуураа гутран холхих болов. “Ертөнцөд хачин юм их болдог юм байн даа. Хаяанд мань, олын цаад эрэгт элдэв янзын шидэт багж байж байхад би энд мал шиг аж төрж байдаг” гэж Урсуладаа гомдол мэдүүлжээ. Макондог анх байгуулж байх үеэс Хосе Аркадио Буэндиаг мэдэх хүмүүс Мелькиадесээс болж хчнээн хувирсныг нь гайхаж байлаа. Урьд нь Хосе Аркадио Буэндиа тэдэндээ өмнөө барьдаг хүн нь болж, тариа яаж тарих, хүүхэд хэрхэн асрах, мал яаж өсгөхийг зөвлөж, тосгоныхныгоо өнгөтэй өөдтэй байлгах гэж хар бор ажилголж шилэлгүй хийдэг байжээ. Уэндиагийн байшин тосгондоо хамгийн сайн нь байж, бусад нь орон гэрээ түүнийг нь дуурайлган янзлах гэж хичээдэг байжээ. Тэднийх саруул то мтанхим, ваартай гоё цэцгээр чимэглэсэн сүүдрэвчтэй холлох өрөө, унтлагын тасалгаа бүхий байшинтай, байшингийнхаа ард нямбай боловсруулсан ногооны тайлбай, тэр ч байтугай ямаа, гахай, тахиа налайн байх мадын хашаатай, хашаандаа лужир том туулайн бөөр

- 1 Низианзынхан - Дундад Азийн эртний Низианз хотын иргэд
- 2 Сентаво –бутархай мөнгөний нэгж

Модтой байжээ. Гагцхүү зодооч азарган тахиа л эднийд байдаггүй, эднийхээр барахгүй тосгон даяарт байдаггүй байлаа.

Урсула нөхрөөсөө дутахгүй ажилтай анхиатай авгай байлаа. Насандаа дуу дуулж лав үзээгүй, сэтгэлийн хатан тэвчээртэй, зүтгэлтэй, хэрсүү, тогдгоносон энэ эмэгтэй үүрийн гэгээнээс аваад үдшийн бүий болтол хамгийг амжуулж чаддаг ховорхон авьяастай агаад голланд даавуу цардмал банзлын нь сэрчигнэх чимээ хаа л бол дуулдаж байдаг байлаа. Урсулагийн ачаар шавар шал, шохойдоогүй хана, гар хийцийн бүдүүн хадуун тавилга нь цэвэрхэн гялалзаж, хувцас хадгалдаг хуучин авдраас нь альбаака цэцгийн үл мэдэгхэн үнэр анхилж байдаг байв.

Тосгон ыхамгийн ухаалаг хүн болох Хосе Акадио Буэндиа тосгоныхондоо байшингаа барихдаа хэн нь ч гол руу усанд явах гэж илүү ажил болохооргүйгээр барихыг тушаажээ. Мөн гудамжийг гаргахдаа халуун цагаар айл бүрд нарны гэрэл ижилхэн тусаж байхаар ухаалаг гаргажээ. Байгуулагдсанаасаа хойш хэдэн жилийн дараа Макондо, гурван зуун суугчдынх нь очиж үзсэн бүх сууринаас хамгийн цэвэр бөгөөд тохилог нь болжээ. Үнэхээрийн элэг бүтэн энэ суурингийнхнаас гуч гарсан хүн ч байхгүй, үхэж үрэгдсэн хүн ч байхгүй байжээ.

Макондог байгуулж эхлэнгээ Хосе Аркадио Буэндиа урхи тор урлаж гарчээ. Удалгүй тэрбээр гэрээрээ дүүрэн шарагч бялзуухай, ширэг бялзуухай, балч бялзуухай, заараг шувуутай болсон төдийгүй суурины бусад айлыг ч тийм болгожээ. Зүсэн зүйлийн шувуудын байнгын жигээ чих дөжрөөх учир Урсула ухаан муудах вий гэж чихэ лаваар бөглөжээ. Мелькиадесийн овог Макондод анх ирж, толгойны өвчин намдаадаг шилэн үрэл худалдаж эхлэхэд макондогийнхон уудам хөндийд нууцхан орших бяцхан сууриныг нь цыганууд яаж олоо юм бол гэж ихэд хачирхсанд цаадуул нь шувууны дуугаар олж ирлээ гэж хэлжээ.

Гэвч Хосе Аркадио Буэндиа соронон гүрийн дон тусаж, одон орны хайгуулж хийж, ал олох гэж мөрөөдөж, ертөнцийн гайхамшигийг таньж мэдэх гэж санаашрах болсноор нийтийн тулд ажиллах сонирхолгүй болж билээ. Зүгээр суудаггүй, цэвэр цэмцгэр Буэндиа яваандаа хирэндээ баригдаж, сахал үсэндээ дийлдэн тамтаггүй залхуу болж, Урсула сахлыг нь балиусаар зүдэрч баймааж нь хааяа нэг тайрч өгдөг болжээ. Хосе Аркадио Буэндиаг юманд хорлогдож гэж тосгоныхон нь бодож байлаа. Гэвч Хосе Аркадио Буэндиаг солиотой гэж итгэж байсан хүмүүс хүртэл шуудайд хүрз, зээтүү хийж үүрээд, Макондог их нээлттэй холбох зам тавихад туслаач гэж гуйхад нь ажил, төрөл гэр орноо орхичихоод араас нь дагажээ.

Хосе Аркадио Буэндиа тэр хавийн газрыг огт мэдэхгүй байлаа. Дорно зүгт давахын эцэсгүй том нуруу хөндөлсөж, түүний цаана эртний Риоча хот орших бөгөөд дээр үед тэнд Фрэнсис ДРейк их буугаар яст матар буудан зугаацаж, алсан тэр амьтдынхаа цоорхойг нь бөглөж, дотор нь сүрэл чихээд, хатан хаан Елизаветад явуулж байсан гэж өвөг Аурелиано Буэндиагаасаа дуулснаас цаашгүй. Залуудаа Хосе Аркадио Буэндиа болон бусад эрчүүл эхнэр хүүхэд, мал адгуус, эд агуурсаа аваад далайн эрэгт хүрэх гэж энэ урууг даван хоёр жил хоёр сар төөрөн мунгинаад бодлоо араг бюу орхин хуучин нутагтаа буцалтай биш хэмээн энд Маконо сууринг байгуулан суурьшсан билээ. Иймээс дорно үг замнавал гагцхүү гэдрэгээ буцна гэсэн үг байсан учир тийш явах

бодолгүй байлаа. Өмнө талд нь өвс ургамалд мөнх хучаастай намаг балчиг, зах хязгаар байхгүй гэж цыгануудын хэлдэг их хөндий байлаа. Өрнө талд нь тэр хөндийг энгүй их ус залган авч тэнд бүсгүй хүний бие, толгойтой, булбарай зөөлөн арьстай халим маягийн амьтад оршиж, сэргэр том мээмнийхээ чадлаар далайн аянчин жуулчдыг хөнөөдөг байлаа. Цыган нар шуудангийн зам гардаг хуурай газрын зах хүртлээ жил хагас шахам хөвжээ. Ингэхлээр гагцхүү умар зүгт л явбал соёлт ертөнцийн зах зухыг үзнэ гэж Хосе Аркадио Буэндиа итгэж байв. Тийнхүү тэрбээр зээтүү хүрз, ангийн бугаар зэвсэглээд, зүг чиг олох багаж, газрын зургийг үүргэвчдээ хийгээд осолтой аянд морджээ.

Эхний хэдэн өдөр гойдын саад дайралдсангүй. Голын чулуут эргээр уруудаж, хэдэн жилийн урьд хуучны хуяг олсон газраа хүрээд зэрлэг зүржийн модны дундуур одсон нарий улбаагаар ойд орлоо. Долоо хоног яваад буга намнах аз таарч, махыг нь шараад, хагасыг нь идэх, бусдыг нь давслан нөөцлөхөөр тогтжээ. Яагаа ч үгүй л шивтэр амтагдсан хөх махтай тоть алж идэх хэрэг гарах вий гэж болгоомжилсон нь тэр байлаа. Дараагийн арван өдөр нарны бараа огт харсангүй. Хөл доорх хөрс улам нойтон, галт уулын үнс шиг улам зөөлөн, ширэнгэ ахих тусам улам сүртэй болж, шувууны дуугарах, сармагчны хэрэлдэх нь дуулдахтай үгүйтэй, энэ ертөнц үүрд хөөр баяргүй, харанхуй баргар-болоо юу гэлтэй болж иржээ. Хүн анхныхаа нүглийг үйлдэхээс<sup>1</sup> өмнөх диваажин гэж ийм л байсан байх гэмээ чийг даасан, чимээгүй дүнсийсэн их ойд гишгэнгүүт л хөл нь цөмрөн шигдэж, гишгэсэн мөрөөр тосорхог, бужигнасан юм дүүрнэ. Мачетагаар<sup>2</sup> алтан сайван, ал улаан сахилдгийг тас тас цавчин явахад диван галбад мартагдсан юм сэтгэлд урган зовооно. Бүтэн долоо хоног тэд гэрэлт цохын анивалзах галаас өөр гэрэлгүй гаслангийн баргар ертөнцөөр амьсгал боогдуулсан цусны үнэрт туйлдсаар, зүүдэн өвчтэй хүмүүс шиг гэлдрэн урагшилсаар байлаа. Буцах-арга байсангүй, тэд өвс цавчин зам гаргахад дорхноо шинэ өвс урган битүүрч байлаа. “Дажгүй ээ, зүгээ л алдахгүй байвал алзахгүй” гэж Буэндиа нөхдөө зоригжуулна. Тэрбээр луужингийнхаа зүүг алдалгүй ажиглан үл үзэгдэх умар зүгт хүмүүсээ удирдан зүтгэсээр илбэдүүлсэн муу ёрын тэр газраас арайхийж гарла. Шөнө нь пад харанхуй байсан боловч агаар нь цэнгэг байжээ. Аяншиж ядарсан улс дүүжин ороо зсаж, анх удаа тайван бөгөөд бөх нойрсов. Тэднийг сэрэхэд нар дээр хөөрсөн байлаа. Тэгтэл өглөөнийнамуухан гэрэлд ойм, дал модны дунд испанийн өгөрч хуучирсан асар том цагаан хөлөг чанх өмнө нь сүндэрлэн харагдсанд мэл гайхжээ. Тэр хөлөг баруун бөөр рүүгээ ялимгүй хэлтийж цахирмаа цэцэг ороосон татлагын хоорондох бүв бүтэн шурагнаас нь далбаа дарвуул нь салбайн унжиж, зөөлөн хөвд хучсан, бас чулуужсан дун гилгэр хуяг аятай бүрхсэн их бие нь хатуу хөрсөнд бат шаан зогсжээ. Энэхүү хөлөг битүү хашигдсан

1 Яхва тэнгэр Адам, Ева гэсэн анхны хоёр хүнийг бүтээгээд, Эдемд цэцэрлэгийг арчилж, харж байлгахгаар суулгажээ. Тэгэхдээ сайн мууг танин мэдэх модны жимснээс идэхийг хоригложээ. Гэтэл зальт могой хүүхнийг нь уруу татаж, тэр жимснээс идүүлжээ. Ева өөрөө идээд нөхөртөө бас идүүлсэн байна. Ингээд хоёулаа тэр цэцэрлэгээс хөөгджээ. Үүнийг христосын домог судлалд хүний үйлдсэн анхны нүгэл гэдэг. – Орч.

2 Мачете -чихрийн нишингэ огтолдог том хутга

нэгэн зүйлд буюу сүйтгэх их хүчит цаг хугацаанд ч үл автах, шуугиант бужигнаант жигүүртэн шувууд ч үл ойртох орхигдон мартагдсан дархан газарт байгаа юм шиг санагдаж байлаа. Аянчид тэсэж чадалгүй хөлгийн доторхыг нэгжиж үзсэн боловч багшрн ургасан цэцгээс өөр юу ч байсангүй.

Хөлөг олсноор далай ойрхон байгаа нь мэдэгдсэнд Буэндиа урам хугарав. Энэ далай тоо томшгүй зовлон зүдгүүртэй тулгаран хайх үед нь олдоогүй өмнө нь давтагдашгүй саад болон хөндөлссөнд ороо бусгаа хувь заяа өөрөөр нь даажигнан тоглож байна гэж боджээ. Олоон жилийн хойно хурандаа Аурелиано Буэндиа шуудангийн их зам хэдийнээ тавигдсан энэ нутагт ирээд, намуу цэцэгт талын дунд хөлгийн шатсан сэг байхыг үзэхдээ тэр бүх түүхийг эцэг нь санаанаасаа зохиогоогүй юм байна гэдэгт сая итгэж, тэр хөлөг яаж хуурай газар ийм хол ирсэн юм бол? Гэж гайхжээ. Харин Хосе Аркадио Буэндиа дөрвөн өдөр яваад эндээс хорь орчим биеэ чилээсэнгүй. Нөхдийнхөө хамт туулсан зовлон зүдгүүртэй, тулгарсан аюул осолтой нь зүйрлүүлбэл юу ч биш энэ хөөст, бохир, үнсэн саарал далайн захад мөрөөдөл нь унтарч билээ.

- Хараал идмэр! Макондо тал бүрээсээ усаар хашигдсан юм байна гэж Хосе Аркадио Буэндиа дуу алдав.

Хосе Аркадио Буэндиагийн аянаас буцаж ирээд зохиосон тул сэжигтэй газрын зургаар хүмүүс Макондог хойг дээр байдаг гэсэн бдолтой болоод их л удаж билээ. Тэрбээр уг зургийг зурахдаа их л бухимдаж суурин байгуулах газраа тэгж бодлогогүй сонгож авсны төлөө өрийгөө шийтгэх мэт гадаад ертөнцтэй харилцахын хэцүүг зориуд өсгөн гаргажээ. “Бид эндээс хэзээ ч гарч чадахгүй нь. Шинжлэх ухааны шимийг хүртэлгүй эндээ амьдаар илжрэх нь” гэж Урсуладаа гутрангүй өгүүлжээ. Туршлагын жижиг өрөөндөө хэдэн сар үүнийгэлтэл бодсоор Макондог аятай газар нүүлгэх нь зүйтэй юм гэж шийджээ. Гэтэл эхнэр нь түүнд явахгүй гэдгээ хэлж, солиот бодлыг нь тасалжээ. Урсула шоргоолж шиг анзаарагдалгүй, уйгагүйгээр хөдлөн, нүүхээр зэхэж эхлээд байсан эрчүүлийн өөдөс тосгоны эмэгтэйчүүдийг тавив. Ямар дайсагнасан хүчнээс болоод төлөвлөгөө нь давшгүй саадтай тулгарч, эцсийн бүлэгт биелшгүй мөрөөдөл болсон бэ гэдгийг Хосе Аркадио Буэндиа хэлж мэдэхгүй байлаа. Урсула эр нөхрөө юу ч болоогүй юм шиг ажиглаж, нүүнэ гэж амандаа үглэсээр лабораторийнхоо юмыг хайрцаглаж байхыг нэг өглөө үзээд тэр ч байтугай жаахан өрөвджээ. Урсула энэ ажлаа дуусгахад нь саад хийсэнгүй. Суурины эрчүүл сэдсэн санааг дэмжихгүй гэдгийг Буэндиа мэдэж (амандаа үглэхээс нь үзвэл) байгаа юм байна гэдгийг Урсула мэдсэн боловч түүнийг хайрцгаа хадаж, бийрээ бэхэнд дүрэн, овог нэрийнхээ эхний үсгийг дээр нь бичиж байх зуур ганц ч зэмлэсэн үг хэлсэнгүй. Гагцхүү Хосе Аркадио Буэндиаг тасалгааныхаа хаалгыг нугаснаас нь салгаж эхлэхэд яах гэж ингэж байгааг нь зүрхлэн асуувал нөхөр нь “нэгэнт явах хүн байхгүй бол бид дангаараа явцгаана аа” гэж нэлээд харамсангуй дуугарав.

Урсула туйлын тайвнаар,

- Үгүй ээ\_ бид явахгүй. Хүүгийнхээ унасан газраас бид холдохгүй гэж хэлсэнд Хосе Аркадио Буэндиа,
- Энд одоохондоо хэн ч үхээгүй байгаа. Үхсэнээ оршуулаагүй л бол хн газартай холбоо байхгүй гэлээ.

Урсула зөөлөн боловч эрсхэн татгалзаж,

- Эндээ байхын тулд би үхэх хэрэг гардаг юм бол үхнэ ээ гэж хэллээ.



Эхнэрээ ийм нугаршгүй байх юм гэж Хосе Аркадио Буэндиа зүүдэлсэнгүй. Буэндиа сэтгэл татахаар сайхан юм зөгнөн ярьж, шидэт аршаан цацангуут л мод хүний хүссэнээр жимсэлдэг, өвчин анагаах зүйл бүрийн багажийг сул авч болдог гайхамшигт газар аваачна гэж амласан боловч Урсула бэлэн аманднь сэтгэл хөдөлсөнгүй боло.

- Ийм солиотой дэмий юм өдөржин бодож байхын оронд хүүхдээ харж хандаж байсан нь дээргүй юу. чи цаадуулаа хар! Золбин гөлөг шиг гаргуунд хаягдсан байна шүү дээ гэж Урсула хэлжээ.

Хосе Аркадио Буэндиа эхнэрийнхээ үгийн цаад утгыг ухаарсангүй. Нар туссан талбайд хөлнүцгэн хүүхэд тоглож байгаа нь цонхоор харагдахад, тэд яг энэ үед Урсулагийн шившлэгээр газрын ангалаас гараадирсэ юм шиг санагджээ. Тэгтэл дотор нь нэг л хачин жигтэй болж, оршиж байсан цагаасаа суга үсрэн гараад, урьд сэтгэлд ордоггүй байсан дуртгалд хөвөн одвой. Урсулаг байшингийнхаа шалыг шүүрдэж эндээс насан эцэс болтлоо явахаа болилоо гэж бодож байх хооронд Хосе Аркадио Буэндиа хүүхдүүдээ гайхан хар харсаар нүдэнд нь нулимс цийлгэнэсэнд гарынхаа араар нулимсаа арчсанаа хэнгэнэтэл шүүрс алдаад,

- За яах вэ. Хайрцагнаас юмаа гаргахад элбэлц гэж цаадуулдаа хэл гэжээ.

Ууган Хосе Аркадиа нь арван дөрөв хүрсэн, дөрвөлжин толгойтой, өрвөгөр үстэй, эцгийнхээ зоргоор занг дуурайсан хүү байлаа. Эцэг шигээ бяр ихтэй, бие томтой болж өсөх төлөвтэй боловч элдвийг ургуулан сэтгэдгийг нь дуурайгаагүй нь илт. Уул давж явах хэцүү аяны үеэр гэдсэнд олдож, Макондог байгууллахын өмнө гарсан Хосе аркадио хөвгүүнд адгуусны ямар ч шинж тэмдэг байсангүйд эцэг эх хоёр нь тэнгэрт залбирч билээ. Макондод төрсөн анхны хүн болох Аурелиано гуравдугаар сард зургаан ой хрнэ. Жаал хүү дуу цөтэй, хажиг зантай байжээ. Хүү эхийнхээ умйд байхдаа уйлж, нүдээ хараастай төржээ. Хүйг нь тасал байх зуур тэрбээр тасалгаан дотор юу байна гэж шинжих мэт толгойгоо ийш тийш эргүүлэн, тойрон байсан улсыг огт бишүүрхэж айсан янзгүй, сониучирхан харж байжээ. Тэгснээ өрийг нь харах гэж ирэгсдийг огт тоохыг больж, шаагин буух аадарт цохиулан юу юугүй уначих гэж айлгах далдуу модны навчин адры ширтжээ. Аурелиано гуравтай байхдаа гал зууханд орж ирээд, өөрийн нь буатантй буцалгам халуун шөл гамл дээрэс аваад ширээн дээр тавьж байхыг дүрлийтэл ширтэж, босгон дээр хулгасхийн зогссоноо “Одоохон унана даа!” гэж хэлснийг Урсула санаж байлаа. Ширээний яг голд тавьсан байсан бутан жаал хүүг ингэж хэлмэгц дотроосоо далдын хүчинд түлхүүлэх мэт хажуу тийшээ гулсан газарт унаад будаа болжээ. Урсула үүнд сэтгэл түгшин, нөхөртөө хэлсэн боловч цаадах нь ер хайхарч өгсөнгүй. Энэ бол гэм биш, зан байлаа. Хосе Аркадио Буэндиа хүүхдүүдийнхээ яаж байгааг огт анзаардаггүй нь, нэг талаар тэднийг оюун ыцээнд хүрээгүй гэж үздэгийнх, нөгөө талаар хэрэггүй юм оролдоод толгой өөөд татах завгүй байсных билээ.

Гэвч Хосе Аркадио Буэндиа хүүхдүүдээ дуудаж, лабораторийнхоо боолттой багажийг задлалцууснаасаа хойш хамгий сайхан цагаа тэдэнд зориулах боллоо. Хачин жигтэй газрын зураг, хүн үнэмшмээргүй зураг төслөөр удах тусмаа дүүрсээр байсан умгархан өрөөндөө тэрбээр унших, бичих, тоо бодохыг хүүхдүүдээ зааж, өөрийн мэдлэгт төдийгүй ургуулан бодох хязгааргүй чадалдаа дулдуйдан орчлон ертөнцийн гайхамшгийн туахй ярьж өгдөг байлаа. Африкийн өмнөд үзүүрт юм эргэцүүлэн бодож суухаас өөр юм хийдэггүй, ухаалаг, номхон хүмүүс байдаг, Эгейн тэнгисийг арал арал дамжин харайсаар

явган гаталж Салоник боомт хүрч болдог гэж хүүхдүүд нь тийнхүү тогтоож авчээ. Орой үдшийн цагаардалан худал зүйлийг ярьдаг байсан нь хүүхдүүдийнх нь сэтгэлд бат хоногоод, олон жилийн хойно хурандаа Аурелиано Буэндиа хайсны дэргэд буудуулах гэж зогсохдоо засгийн газрын цэргийн даргын цэргүүддээ “Бууд!” гэж тушахас хэдхэн хормын өмнө гуравдугаар сарын тэр дулаахан үдшийг дахин санаж, Мемфисийн мэргэдийн сүүлийн гайхам нээлийн тухай бүгдэд зарласаар тосгонд дахин ирэж байгаа цыганы омгийнхны лимбэ, бөмбөр, хэнгэргийн дууг алсаас сонссон эцэг нь бодисын зүйн хичээл зааж байснаа болин гараа өргөөд нүдээ гөлрөөд таг болсныг бодож билээ.

Тэд урьд нь ирж байгаагүй цыганууд байлаа. Ганцхан өөрийнхөө л хэлээр ярьдаг, арьсандаа тос түрхэн, аливаад тун овсгоотой цыганы овгийн гайхамшигт эрэгтэй эмэгтэй залуус хөгжилдөн, шуугилдан, хөгжим бүжиг болсоор гудамжнаа дүүрч, итали романс дуулдаг алаг тоть, хэнгэргийн аялгуунд алтан өндөг гаргадаг, тэгэхдээ нэг гаргахдаа зүүугаас доогүйг гаргадаг, тэгэхдээ нэг гаргахдаа зуугаас доошгүйг гаргадаг тахиа, хүний бодлыг таадаг эрдэмтэй мич, товч ч хаддаг, өвчтөний хлууныг ч буулгадаг нарийн машин, эвгүй дуртгалыг мартулдаг багаж, цагийг нөцөөхөд тусалдаг гоюу хийгээд өчнөөн төчнөөн ер бусын чамин сонин зүйлийг авчирсан нь Хосе Аркадио Буэндиа тэр бүхнийг санаж байхын тулд ой ухааны машиныг дурдтайяа зохиосон билээ. Агшин зурын дотор тогсоны бдйал ог өөр боллоо. Ямарагийн шуугиан үймээнд чих нь дөжирсөн макондогийнхон гадаанаа л төөрчихгээд их зүдэрчээ. Хосе Аркадио Буэндиа хүүхдээ шахалдаан дунд алдчихгүй гэжгараас нь хөтлөн, хувь тутамд нэг бол алтаар бүрсэн шүдтэй домч, үгүй бол зургаан гартай илбэчинтэй мөргөлдөж, тэр бөөн хүмүүсээс гарах өтөг, зандангийн холилдсон үнэрт амсыгал багтарсаар энэ үлгэрийн зүүдийн нууцыг Мелькиадесээр тайлуулах гэж түүнийг газар сайгүй эрэн галзуу юм шиг харайлгав. Мелькиадесийг цыгануудаас сураглавч цаадуул нь хэл мэдэхгүй байлаа. Тэгж тэгж Мелькиадесийн ихэвчлэн асраа шаан буудаг тэр газарт хүрч очвол уйтгартай байрын армяны цыган, хүнийг харагдахгүй блгодог тарни испаниар урьж байлаа. Цыганыг нэг аяга шар өнгөтэй ундаа хөнтөрч байхад нь Хосе Аркадио Буэндио илбийг хачирхан харж зогсоо улсын дундуур чихэлдсээр очиж, Мелькиадесийг сураглав. Цыган түүнийг гайхсан янзтай харснаа “Мелькиадес үхсэн” гэж хариулаад утаа баагьсан үмхий нойтон давирхай болон хувилсанд нөгөө үг нь цуурайтсаар үлджээ. Хосе Аркадио Буэндиа энэ үгийг дуулахдаа мэлрэн таг болж, уй гашуугаа барих гэж оолдон, хүмүүсийг өөр илбэд татагдан тартал, гунигт цыганаас үлдсэн нойтон давирхайг ууршиж дуустал зогсжээ. Сүүлд нь Мелькиадесийг Сингапурын намагт хумхаа өвчнөөр үхэж, хүүрийг нь явагийн ойролцоох далайд хамгийн гүн газар хаясан гэж цыганы нэг нь хэлжээ. Хүүхдүүд Мелькиадесийн үхсэнийг сонирхсонгүй, дээр нь бичсэн үнэн бол урьд Соломон хааных байсан нэг цацрын зарлалд Мемфисийн мэргэдийн шинэ ололтыг үзүүлнэ гэснийг үзээд эцгээ тийш чангааж байлаа. Хоёр хүү нь шалгаагаад салахгүй болохоор Хосе Аркадио Буэндиа гучин реал төлж, цацарт орвол тойлсон толгойтой, туж үс болсон биетэй, хамартаа зэс цагираг, хөлдөө хүнд төмөр гинж зүүсэн лужир том эр далайн дээрэмчдийн эрдэнэсээ хадгалдагархуу авдрыг манаж байлаа. Аварг аэр авдрын тагийг онгойлговол хүйт оргиод явчихав. Авдар дотор тоо томшгүй цагаан зүү бүхи асар том тунгалаг зүйлээс өөр юм алга бөгөөд үдшийн гэрэл түүн дээр тусаад түг түмэн өнгөөр очис ойлгон байлаа.

Хосе Аркадио Буэндиа үүнийг үзээд гайхсан боловч хүүхдүүдийнхээ тайлбарлуулах гэж тэсэж ядаж байгааг мэдэн,

- Энэ бол дэлхий дээрх хамгийн том бадмаараг гэж гүвтнэсэнд аварга эр:
- Үгүй ээ, энэ бол мөс гэж залруулжээ.

Учрыг огт ойлгоогүй Буэндиа тэр юм уу руу гараа явуулсан боловч аварга биет түүнийг хойш болгоод “Нэмж таван реал төлөөд барьж үз” гэжээ. Буэндиа таван реал өгөөд, алгаараа мөсөн дээр даран хэдэн хувь байлгав. Тэр нууц юманд хүрэхдээ зүрх нь айх, баярлах хослон егхийжээ. Энэ ер бусын сэтгэгдлээ хүүхдүүддээ яаж тайлбарлахаа мэдэхгүй, дахин арван реал нэмж төлөөд, тэднээр өөрсдөөр нь бариулж үзүүлэв. Жижиг Хосе Аркадио “Барьж үзэхгүй” гэв. Харин Аурелиано зоригтой бөхийж, гараа мөсөн дээр тавьснаа угз татан авав. Энэ чинь буцалж байна” гэж айн дуу алдахад эцэг нь түүнийг огт анхаарсангүй, үүний ид шидийн хүчээр бүтсэн нь илэрхий байгаад мансуурч, энэ агшин солиот бодлуудаа бүтэлгүй болсныг ч, халимны идэш болсон Мелькиадесийг ч мартаж орхиод, дахин таван реал төлж, шүүхэд мэдүүлэг өгч байгаа гэрчийн этгээд гараа Библи судар дээр тавьдаг шиг мөсөн дээр гараа ёслол төгөлдөр тавиад,  
- энэ бол манай үеийн аугаа их ололт гэж дуун алджээ.

\*\*\*      \*\*\*      \*\*\*

XVI зуунд далайн дээрэмчин фрэнсис Дрейк, Риоча хотыг бүслэн байлдахад Урсулагийн элэнц ээж Игуаран хонхны түгшүүртэй дүнгэнэх, их бууны сүртэй нижгэнэхэд цочихдоо галтай зуухан дээрээ сууж орхижээ. Тэрбээр ихэд түлэгдээд, эр эмийн ажилхээээ ч хийж чадахгүй болжээ. Тэгээд ганцхан талаараа, зөвхөн зөөлөн олбог дээр суух болж гаднын хүний дэргэдөр босож явахаа больсныг бодоход алха гишгээ нь ч бас барагтай болсон бололтой. Биенээс нь хярвас ханхлаад байгаа эж итгэчихээд хүний бараа огт харахыг больжээ. Цонхоор англичууд зуумхай ноход дагуулан орж ирэд, улайсан төмрөөр ичмээр газар нь хайрч байна гэж зүүдлээд байх учир гэрт унтаж чадахгүй, гадаа цурам хийлгүй үүр цайлагадаг байлаа. Хоёр хүхдийн нь эцэг, арагоны худалдаачин нөхөр нь эхнэрийнхээ зовлонг ялихгүй ч гэсэн хөнгөлөх гэсэндээ хөрөнгөнийхөө талыг эмчид өргөж эмэнд зарсан боловч нэмэр болоогүй учир мухлагаа худалдчихаад, далайгаас холдож, сарьдаг нурууны салбар ууланд байгаа номхон индаинчуудын сууринд нүүж очоод, хар дарсан зүүдэнд үзэгдэх далайн дээрэмчдийг нь оруулахгүй гэж эхнэртээ цонхгү унтлагн өрөө барьж өгчээ.

Тэр алслагдсан сууринд Хосе Аркадио Буэндиа гэрдэг нэгэн креол сууж, тамхи тарих ажил эрхэлдэг байжээ. Урсулагийн элэнц эцэг түүнтэй түншлэн ихээхэн ашигтай ажил хийж, төдөлгүй хоёулангийнх нь хөрөнгө чинээ ихээхэн зузаарчээ. Хэдэн зуун өнгөрөхөд креолоын гуч арагоны гуч охинтой гэрлэжээ. Урсула нөхрийнхөө ойворгон аашлах бүрийд, бухимдахдаа элдэв явдал болж ирсэн гурван зуун жилийг алгасаж, гагцхүү Риочаг Фрэнсис Дрейкийн бүслэн байлдсан тэр цагийг хараж гардаг байлаа. Тэгэхдээ зүгээр л сэтгэлээ онгойлгох гэж тэгж аашилдаг байсан бөгөөд үнэндээ бол насан туршдаа гэргий нхөр хоёул нэг л юманд гэмшдэг байсан нь хайр сэтгэлээс лүү тэр хорыг илүү бөх холбож өгчээ. Тэр хоёр үеэл ах дүү нар байлаа. Өвөг дээдсийнхээ ажил анхитай, ааль сайтайн ачаар муждаа дээгүүр орох болсон хуучин сууриндтэр хоёр цуг өсжээ. Тэр хоёрыг төрмөгц хооронд нэгэрлүүлнэ гэж эцэг эх нь тогтсон атлаа хоёр залууг яг гэрлэдэг болохоор тас хорьжээ. Зуун жил цус холилдсон хоёр айлын эрүүл үр сад гахай сүүлтэй хүүхэд төрүүлэх гутамшигтай юм болж болзошгүй хэмээн айжээ. Тийм аймшигт явдал урьд нь нэг гарсан байлаа. Урсулагийн агац эгч нь Хосе Аркадио Буэндиагийн авгатай суусанд хүүхэд ньгодонхойдоо үстэй годгор сүүлтэй төрж, бариу

өмд өмсөхийн оронд шулбуур өмд өмсөж бүгсүй хүнтэ йогт хавьталгүй дөчин хоёр наслаад цус алдаж үхжээ. Нэг ч эмэгтэй хүнд харуулаагүй гайхан торойнх шиг тэр сүүл нь хожмоо түүний аминд хүрсэн билээ. Учир нь махны худалдагч найз нь түүний гуйснаар мах цавчдаг сүхээрээ тэр сүүлийг нь цавчиж орхижээ. Гудайж үзээгүй хорин таван насан дээрээ байсан Хосе Аркадио Буэндиа “Надад бол ярьж л чаддаг юм бо той ч төрсөн хамаагүй” гэж ганцхан үг хэлээд тэр маргааныг тасалжээ. Дуу хуур болж, буу шуу тавьж гурав хоног хуримлажээ. Урсулагийн ээж ньхожмын үр садын талаар элдэв юм усан малж яриагүйсэн бол гэрлэсэн хоёр залуу аз жаргалтай аж төрөх байсан биз ээ. Гэтэл ээжийнхэ тэгж айлгаснаас хойш Урсула гэлэсэн эр эм хоёрын хийх ёстой юмыг хийхгүй гэж тас зөржээ. Нөхрөө хүчтэй, гүжирмэг занатай хүн учир эз дийлж магадгүй хэмээн болгоомжилж, орондоо орохын өмнө зузаан зотон даавуугаар эхийнхээ хийж өгсөн өмдийг өмсдөг байжээ. Тэр өмд нь өмнөө зузаан төмөр горхойой, өдий төдий оосор бүчтэй байлаа. Эр эм хоёр тийм байдлаар олон сар болов. Шөнөдөө хоёр залуу амраглан жаргахын оронд өчнөөн цагаар эцэж ядартлаа ноцолдох болжээ. Гэвч гярхай хөрш нар нь тэр хоёрын нэг л биш гэдгийг гадарлаж, “Урсула хадамд гараад жил болсон боловч нөхрийнхөө чаддагүйгээс юм үзээгүй хэвээрээ гэнэ” гэсэн цуу тосгоноор таржээ. Хосе Аркадио Буэндиа өөрөө үүнийг хамгийн сүүлд дуулжээ.

- Урсула, улс амьтны ярьж байгааг дуулж байна уу? гэж түүний тайван хлэхэд гэргий нь:
- Ам нь чилэхгүй бол чалчиж л байг, худлаа гэдгийг чи бид хоёр мэднэ газар гэжээ.

Түүнээс хойш хагас жил өнгөрч, нэгэн гайтай ням гаригт Хосе Аркадио Буэндиагын азарган тахиа Пруденсио Агилярын азарган тахиаг дийлэх хүртэл тэр хоёр хуучин янзаараа аж төрсөөр байжээ. Шүүгдсэндээ шар нь гозойж, цус үзээд цөс нь цалгисан Пруденгио Агиляр саравчинд байгаа бүх хүнд үгээ дуулгах гэж Хосе Аркадио Буэндиагаас зориуд холдож байгаад,

- Чамд сайн юм болжээ. Энэ тахиа л авгайг чинь нэг баярлуулж магадгүй. Харж л байя! Гэж хашгирчээ.

Хосе Аркадио Буэндиа газраас тахиагаа жишимгүй авснаа “Би одоохон ирнэ” гэж тэнд байгаа хүмүст хэлээд, Пруденсио Агилярын зүг эргэж,

- Чи харьж зэвсгээ авчир би чамайг ална гэжээ.

Тэрбээр арваад хувь болоод, бүр өвгөнийхөө барьж байсан том жадыг авч ирлээ. Суурингийнхны тэн хагас нь азарган тахиа зодолдуулаг саравчны гадаа цугларч, Пруденсио Агиляр үүдэнд нь зогосж байлаа. Тэр биеэ хамгаалж амсангүй. Анхны АУрелиано Буэндиагийн орчныхоо шар ирвэсийг тухайн үедээ хядсан шиг Хосе Аркадио Буэндиагийн аймаар хүчтэй, аюултай мэргэн шидсэн жад түүний хоолойг нэвт сүлбэжээ. Шөнө нь саравчинд талийгаачийн авсны дэргэд төрөл төрөгсөд нь сахин сууж байхад Хосе Аркадио Буэндиа унтлагынхаа өрөөнд ороод, эхнэрийнхээ хамгаалах өмдөө өмсөж байхыг үзээд жадаа хөдөлгөн “Наадахаа тайл” гэж тушаажээ. Урсула нөхрийнхөө хэр зэрэг шийдэмгийг шалгах гэж бодсонгүй. “Элдэв юм болбол чи даан шүү” гэж хэлсэнд Хосе Аркадио Буэндиа жадаа газарт шаагаад,

- Гахай сүүлтэй хүүхэд төрөх заяатай бол төрөг, өсгөхдөө л өсгөнө. Харин чамаас болж энэ тосгонд хүний амь дахиад бүү сүйдэг гэжээ.

Зургадугар сарын саруулхан, сэрүүхэн сайхан шөнө байлаа. Пурденсио Агилярынхны уйлан хайлах нь салхины дээрээс дуулдсаар байхыг ч хоёр залуу хайхралгүй үүр цайтал ороо пижигэнүүлжээ.

Улс амьтан энэ явдлыг нэр төрийнхөө төлөө тулалдсан хэрэггэж үзсэн боловч эр эм хоёр сэтгэлийн зовлон эдлэх болжээ. Нэг шөнө Урсула нойр хүрэхгүйд ус уух гэж гарвал гадаа том шавар домбоны дэргэд цонхигор царайтай Пруденсио гунигтай нь аргагүй зогсоод, хоолойнхоо цус болсон шархыг хэсэг даавуугаар бөглөх гэж оролдож байгааг харжээ. Урсула өрөөндөө ороод, эр нөхөртөө үзсэнэ яривал цадах нь огт тоосонгүй, “Үхсэн хүн булнаасаа гардаггүй юм. Бид хоёрт гэмшиглэн төрөөд л тэгж байгаа юм” гэж хэлжээ. Хоёр хоноод Урсула угаалгын өрөөнд түүний хүзүүнийхээ хатсан цусыг маалингаар арчиж байхыг үзэж, дара шөнө нь бороон дунд явж бйхыг харжээ. Хосе Аркадио Буэндиа эхнэрийнхээ хий юм үзээд байхад залхаж гүйцээд, жадаа барин гадагш гарвал үхдэл аанай л гунигтай нь аргагүй зогсож байсанд,

- Явж далд ор. Чамайг ирэх тоолонгоор чинь ална гэж мэд хэмэн зандарчээ.

Пруденсио Агиляр явсангүй, Хосе Аркадио Буэндиа ч жадаа шидэж зүрхэлсэнгүй. Буэндиа түүнээс хойш тайван унтаж чадахаа болив. Бороон дундуур үхдэлийн туйлын цөхрөнгүй ширтэж байсан нь, нүдэнд нь амьд улсаа ихэд санан уйтгарласан байдал тодорч байсан нь, даавууныхаа өөдсийг норгох ус хайн ийш тийш сандрангүй харж байсан нь сэтгэлээс гарахгүй зовоох боллоо. “Хөөрхий, тун хэцүүдэж байх шиг байна. Ганцаараа мөн ч хэцүү байх шиг байна” гэж Буэндиа эхнэртээ хэлжээ. Урсула үхсэн хүнийг туйлгүй өрөвдөж дараа дайралдахдаа зуунхан дээрх тогоо өнгийж байгааг нь үзээд, юу эрж байгааг нь тааварлаж, тавагтай ус гэрээр тавих боллоо. Нэг шөнө Хосе Аркадио Буэндиа унтлагынх нь өрөөнд үхдэлийн шархаа угааж байгааг үзэхдээ бүрмөсөн бууж өгчээ.

- За яах вэ, Пруденсио. Бид энэ тосгоноос хол гэгч яваад, хэзээ ч эргэж ирэхээ больё. Одоо чи минь явж үз гэж хэлжээ.

Тэдний уул давж, далай руу аялсны учир ийм буюу. Өөр шиг нь залуу бөгөөд адал явдлыг хайсан хэдэн найз нар нь орон байшингаа орхиж, эхнэр хүүхдээ аваад...арилсан орон эрэхээр түүнийг даган явжээ. Хосе Аркадио Буэндиа тосгоноос мордохынхоо өмнө жадаа хашаанд булж, бүх зодооч сайхан азарган тахиаынхаа хүзүүг тас цавчин ийнхүү тахил өргөснөөрөө Пруденсио Агилярын сүнсийг тайтгаруулах гэж боджээ. Урсула авдартай хуримын гоёл, жаал зугаа эд агуурс, эцгийнхээ өв болгож өгсөн хайрцагтай алтан зоосыг л авчээ. Ямар замаар явбал дээр вэ гэж хэн нь ч эргэцүүлсэнгүй. Таньдаг хүн хартай дайралдалгүй таг сураггүй алга болохыг хичээн Риаочагийн эсрэг зүгт явахаар тогтжээ. Энүүн шиг утгагүй нүүдэл ертөнцөд болж байсангүй. Нэг жил хоёр сар болоод Урсула сармагчны мах, могойн шөлөнд ходоодоо бүр муутгаад, хүнд л байдаг бие эрхтэнтэй нгэн хүү төрүүлсэн ажээ. Урсулагийн хөл нь хавдаж, судас нь цэврүү шиг томорсон учир замын тэхий хагасыг хоёр хүнээр дамнуулж туулах хэрэг гарчээ. Хүүхдүүд хэдийгээр нүд нь ширгэн, гэдэс нь цүрдийн, харваас өрөвдмөөр болсон боловч ихэнх цагт бодох санах юмгүй үсэрч дэгдэж явах тул томчуулыг бодвол аян замын гар илүү даах ажээ. Хоёр жил шахам бядан явсны эцэст нэг өглөө аянчид сарьдаг нурууны баруун бэлийг анх харсан усан нүдэт, цусан зүрхтэн болох хувьтай байжээ. Үүл бүрхсэн өндөр оргилоос халиан үзвээс өмнө нь гол мөрөн сүлжсэн нүдний хараа гүйцэмгүй уужим хөндий газар тэнгэрийн савслага хүртэл цэлийж байлаа. Харин далайн бараа алга бйвай. Амьд амьтантй дайралдахаа аль дивангарт больж намаг дундуур хэдэн сар мунгинан

тэнэсээр хайлсан шил царцаад тогтчихсон юм шиг устай чулуут голын хөвөөн дээр нэг үдэш хуарагнан буужээ. Олон жилийн хойно иргэний хоёрдугаар дайны үеэр хурандаа Аурелиано Буэндиа тэдний явсан газраар гарч очоод Риоачагийн гарнизоныг гэнэдүүлэн ззэлсүгэй хэмээн шийдэж түүгээр зургаан хоног яаад ингэж зүтгэнэ. Гэдэг ёстой солиотой хэрэг байна гэж ойлгожээ. Гжэтэл голын дэргэд буудалласан тэр шөнө эцэг нь нөхөд сэлтийнхээ хамт хөлөг нь сүйрэн явгарсан хмүүүсийн байдалтай байсан боловч бүгдээрээ насан өтөл болтлоо амьд явах эрмэлзэлтэй байжээ (Ингэж ч чаджээ). Хуарагнан буусан газар нь хөл шуугиан ихтэй хот болсон байна, байшин савны нь ханыг гялтганасан тунгалаг эдээр барьсан байна гэж Хосе Аркадио Буэндиа шөнө нь зүүдэлж, “Энэ ямар гээч хот вэ?” гэж асуувал хариуд нь Макондо гэсэн үл мэдэх, учир тугагүй нэр хэлэхийг дуулжээ. Нойрон дунд нь тэр нэр ер буын уянгатай сайхан сонсогджээ. Маргааш нь тэрбээр далайд хүрч хэзээ ч чадахгүй нь гэж хүмүүтээ үнэмшүүлээд, мод унаган голын дэргэд хамгийн сэрүүн газрыг цагаалан түүн дээр сууринаа байгуулжээ.

Хосе Аркадио Буэндиа мөс үзэн үзтэлээ нэвт гэрэлтсэн ханатай байшин зүүдэлснээ тайлж чадахгүй явжээ. Зөнч зүүднийхээ учрыг сая л ойлгож, ойрын үед ус гэдэг хамгийн элбэг хэрэглэгдэхүүнээр мөсөн тоосго цохиж, бүгдэд шинэ байшин барьж өгөх юм байна гэж шийджээ. Тэгвэл Макондо хаалганы цүү, цонхны түгжээ хүртэл улайсаад гажчихдаг халуун там байснаа мөнхийн сэрүүн хот болно. Хосе Аркадио Буэндиа мөсний үйлдвэр байгуулах гэж зүтгээгүй ньхүүхдээ, юуны өмнө рилу бүтэхүй ухаанд гаргууд авьяастай Аурелианогоо хүмүүжүүлэх гээд толгой өөд татахгүй байсных биз ээ. Туршлагын өрөөнд ажил дахин оволзлоо. Эцэг хүү хоёр Мелькиадесийн тэмдэглэлийгахин дахин уншиж, шинэ юманд хөөрдөг зангаа дарсхийж, тогооны ёроолд наалдсан хайлшнаас Урсулагийн алтыг ялгаж авах гэж уйгагүй оролдсоор байлаа. Жаал Хосе Аркадио энэ ажилд нь бараг үл оролцоно. Эцгийгээ хясны дэргэдхамгийг умартан ажиллах байх хоронд насандаа баймгүй өсгөлүүн биетэй, нэг л зүтгэвэл түүгээрээ болдог өгжүүд зантай ууган хүү нь нэгэнт томоо хар хүү болсонб айлаа. Түүний дуу нь бүдүүрч, эрүү, харцарт нь сөрвөгөр сахал ургажээ. Нэг удаа Урсула хүүгийнхээ өрөөнд ороод, хувцсаа тайлж байхтай нь дайралдаж, нөхрөөсөө өөр нүцгэн эр хүн хараагүйдээ ичих, өрөвдөх зээргцэж, амьдралыг тэтгэх махбод сайтайд нь тэр ч байтугай цочин гайхжээ. Гурав дахь хүүхдээ гэдсэнд олоод байсан Урсула нөхөрт гарч байх үеийнх шигээ айж эхэлжээ.

Тэр үед цовоо цолгин, хөгжил баясгалантай, хэл амтай нэгэн хүүхэн Буэндиагийнхаар орж гарч, Урсулагийн ажлаас элбэлцэж, хөзрөөр мэргэ үзүүлдэг байжээ. Урсула сэтгэлийн зовлонгоо хэлэв. Хүүгийн нь ер бусын өссөн нь садангийнх нь хүн гахайн сүүлтэй байсан шиг жам ёсноос гадуур санагджээ. Гэтэл хүүхэн болор хонх жингхэнэх аятай байшингаар нэг цангинатал хөхөрч, “Харин ч жаргана” гэж хэлжээ. Хэд хоноод энэ бэлгэдэн хэлснээ нотлох гэж хөзрөө барьж ирээд, гал зуухны хажуугийн юм агуулдаг өрөөндХосе Аркадиотой орон түгжжээ. Тэгээдхуучин вандан дээр хөзрөө тараан тавиад хөвгүүнийг үүний нь огт сонирхохгүй, харин ч залхуурсан байртай зогсож байхад элдэв юм чалчиж байснаа гара асунган юманд нь хүрээд авснаа “өөх, ямар лут вэ!” гэж үнэнээсээ дуу алдаад дахин үг дуугарч чадсангүй.

Хосе Аркадиогийн яс нь хавтайх шиг болж, айж зовсондоо нулимсаа барьж ядан байлаа. Эмэгтэй түүнийг ер тайтгаруулсангүй.

Гэвч Хосе Аркадио шөнөжин түүнийг эржээ. Хүүхний суганаас гарах үнэр ньханхлаад байх шиг, энэ үнэр биенд нь шингэчихсэн байх шиг шөнөжин Хосе Аркадиод санагджээ. Тэр хүүхэнтэй агуулахаас огт гаралгүй үргэлж хамт байхсан гэж цаадах нь юманд нь

хүрээд л “Пөөх ямар лут вэ!” гэж үргэлж хэлж байгаасай гэж бодогдсоор байлаа. Тэгээд бүр тэсэхээ байгаад нэг өдөр тэднийд очив. Тэгж очсон нь нэг л ёсорхуу, ойлгомжгүй болжээ. Хосе Аркадио тэднийд байхдаа ам нээсэнгүй. Одоо бол тэр хүүхэнд хүсээд байхаар юм байсангүй. Түүнийг харахад, үнэрээр нь сэтгэлд бууж байсан нөгөө хүүхэнтэй огт адилгүй юм шиг, огт өөр хүн байгаа юм шиг Хосе Аркадиод бодогдоод байлаа. Хосе Аркадио аяга кофе ууж аваад, бүүр гутарчихсан тэднийхээс гарав. Шөнө нь бас л нойр хулжин тарчилж, дахиад л тачаал хөдлөн шаналж, одоо болохоор агуулахад байсан хүүхнийг бус, үдэш өмнө нь сууж байсан хүүхнийг хүсэж байлаа.

Хэд хоноод хүүхэн Хосе Аркадиоог хөзрийн нэг илбэ заа жгөе гэж гэнэт шалтаглан дуудаад ээжтэйгээ сууж байсан өрөөнөөс нь дагуулж агран унтлагын өрөөнд оруулаад, биенд нь эрээ цээргүй хүрсэнд хөвгүүн давхийн цочиж, аятайхан болохоосоо илүү эвгүйрхэн айжээ. Тэгтэл хүүхэн Хосе Аркадиоог шөнө гэртээ очоорой гэхэд Хосе Аркадио түүнээс холдохын түүс болохдоо за хэмээн амалсан боловч очиж чадахгүй гэдгээ мэдэж байлаа. Гэвч шөнө болоходхалуун орондоо орсон хойноо, тэр юмыг хийж чадахгүй боловч түүн рүү очих ёстой гэж ойлгожээ. Харанхуйд тэмтрэн хувцаслаж байхад нь дүүгийнх нь жигпхэн амьсгалах, хажуугийн өрөөнд аавынх нь хий ханиалгах, гадаа тахи яраглан дуугарах, шумуул янгинаан шунгианах, өөрийн нь зүрх түг түг дэлсэх зэрэг урьд н анзаардаггүй байсан ертөнцийн түмэн авиа тодохон дуулдаж байлаа. Тэгээд нойрсож байгаа гудамжинд гарлаа. Хаалгаа хэлснээрээ онгорхой орхлгүй түгжчихсэн байгаасай гэж залбирах шахам явав. Гэвч хаалгыг түгжээгүй байсанд хурууныхаа үзүүрээр түлхвэл нугас нь гунигтай гэгч нь чохарсанд дотор нь ширхийгээд явчихав. Чимээ гаргахгүйг хичээн хажуулдан орвол нөгөө нэг үнэр өөдөс нь ханх тавилаа. Хосе Аркадио тэр хүүхний дүү нарын дүүжин ороо өлгөсөн үүдэн талын өрөөнд хэсэг зогслоо. Тэдний рыг хаана хаана байгааг нь мэдэхгүй учир унтлагын өрөөний хаалганд тэмтрэн явж хүрэх, хаалга нээгээдхүүхнийорыг нь андуурахгүйн тул зүгээ зөв олох хэрэгтэй байлаа Тэгээд урагш алхсанаа, өөрийнх нь бодож байснаас доор дүүжлээстэй бйасан орыг мөргө жорхивол хурхиран унтаж байсан цаад хүн нь нойрон дундаа эргэн нөгөө хажуугаараа хэвтээд “Лхагвад юмсан” гэж цөхрөнгүй дуугарах нь дуулдав. Хосе Аркадио унтлагын хаалгыг түлхвэл хаалга овон товон шаланд тээглэн хяхтанасанд яаж ч чадсангүй. Тас харанхуй дотор орчихоод гуньж бажгадсан тэрбээр бүр төөрснөө мэдэв. Давчхан өрөөнд эх нь, дунд охин нь нөхр, хоёр хүүхэдтэйгээ, нөгөө хүүхэн нь унтаж өайгаа. Тэр хүүнийг огт хүлээгээгүй бололтой. Хосе Аркадио түүнийг нөгөө үнэрээр нь эрье гэсэн боловч өөрт нь шингэсэн шиг үл мэдэгдэм боловч тов тодхон тэр үнэр хааяагүй гарна. Хосе ингэж арчаагүй юманд орох гэж хэмээн хиртхийн шивнэсээр хөдлөлгүй зогсож байтал харанхуй дунд тэмтчин ваяа хүний сарвайсан хуруу нүүрэн днь хүрэв. Ингэж хүрээсэй гэж өөрөө мээлгүй хүсэж байсан болохоор гайхсангүй, энэ гарын аягы даган, үл харагдан оронд хамаг бие н алдарчихсан хүрч, тэнд хувцсыг нь тайлан, шуудайтай төмс асгаж байгаа юм шиг сэгсчин, баруун зүүн тийш нь эргүүлж хөрвүүлэн байхад илү гартай болчихсон юм шиг, хүүхний үнэр биш шүвтэр ханхлаад байгаач юм шиг болж, эртнээс хийх юмсан гэж бодож байсан боловч хийж чадна гэж огт обдоогүй юмаа хийж байгаага бүүр түүрхэн мэдэж, яаж түүнийг хийж байгааг аа ч мэдэхгүй болж, толгой нь ч хаана байгаа юм, гар нь ч хаана байгаа юм, хэний ч толгой юм, хэний ч хөл юм гэдгийг мэдэхийг байж, тэгснээ чадахгүй болсноо мэдэрч, бушуухан зугтаад алга болохсон гэхийн хажуугаар энэ ажин түжин нам гүм, энэ айдас хүрэ м ганцаардлын дунд дандаа л байгаад байхсан гэж тэсгэлгүй хүсэж байлаа.

Тэр хүүхнийг Пилар Тернера гэдэг байлаа. Тэрбээр эцэг эхийнхээ үгийг даган Макондог байгуулснаар дууссан их аянд оролцсон юмсанжээ. Арван дөрвөн настай байхд нь түүнтэй энах унтаж, хорин хоёр хүртэл нь явсаар байсан боловч өөр тосгоныхдоо баригдаад ёс төртэй гэрлэж сууж чадахгүй байсан нэг хүнээс эцэг эх нь түүнийг холдуулах гэжээ. Ажла абөөрөнхийлчихөөд араас нь очно гэж ам шүд алдаснаас нь хойш Пилар Тернера түүнийг хүлээн мэргэжл, өндөр, нам нурутай, шар, хар үстэй янз бүрийн харчуулыг заримдаа далайгаар ирнэ, заримдаа хуурай газраар ирнэ, заримыг нь гурав хоноод ирнэ, заримыг нь сар болоод ирнэ эгэж мэргэд нь буух боловч түүнэтий уулзах найдлага алдсан ажээ. Тэрбээр тийнхүү хүлээсээр байтал эрэгтэй хүний энхрийллээс төсөөрөөд, булчин нь шуугдаж, мээм нь шалчийж гагцхүү оргилсон сэтгэл нь хэвээр үлджээ. Шинэ гайхамшигт наадмынхаа амтанд орсон Хосе Аркадио одоо түүнийг толгой эргэм тасалгаанд нь шөнө болгон очиж эрэх боллоо. Нэг удаа очиход хаалга нь түгжээтэй байсанд, нэгэнт л зүрхлээд цохисноос хойш цохиод дуусах хэрэгтэй гэдгийг мэдэн хаалгыг нь нүджээ... Тэгээд хүлээлгэж хүлээлгэж хаалга нэг юм онгойлоо. Шөнө нойр дутуугаас өдөр нь сөгтөө унавч өнгөрсөн шөнийнхийгөө санан санан сэм баясаж байдаг байлаа. Гэвч баясгалантай, хэнэггүй, доогто йПилар Тернераг гэртээ ирэхэд Хосе Аркадио сэтгэл догдолсноо нуух гэж огт хичээдэггүй байсан бөгөөд юу гэвэл гада аяваа тагтаа үргэтэл цангинуулан инээдэг энэ эмэгтэй өөрт нь амьсгаа дарах, зүрхнийхээ цохилтыг тоолоход сургасан, эрэгтэйчүүд яахаараа үхэхээс айдгийг ойлгуулсан тэр далдын хүчтэй огт адилгүй байлаа. Хосе Аркадио бодолд дарагдсан байсан учир эцэг, дүү хоёрынхоо төмрийн хольцноос Урсулагийн алтыг ялгаж авч чадлаа г хэмээн гэр дүүрэн зарлаж байхад бүрдээрээ юунд тэгтлэ эбаярлаад байгаагийнх нь учрыг олсонгүй болно.

Цаад хоёр ньгурван дөөр толгой өндийлгөхгүй ажиллаж байж алтыг ялгаж авчээ. Урсула баярлаж, тэр ч байтугай рилугээ бүтээж чадсанд нь тэнгэрт залбирч, тосгошныхныг туршлагын өрөөнд цуглахад, энэ гайхамшигтай юм болсныг мялаан гуайявын чанамалтай бингээр дайлж, өрхийн тэргүүн Буэндиа ялгарсан алттай хөөргөө үзүүлж, энэ алтыг өөрөө л дөнгөж сая зохион бүтээчихсэн юм шиг хөөрч байлаа. Алтаа хүн хүнд үзүүлсээр сүүлийн үед туршлагын өрөөндб араг үзэгдэхээ байсан ууган хүүгийнхээ дэргэд очоод хуурай шар нунтгийг нүдэн дээр нь барьж” За ямархуу байна даа?” гэж асуусанд Хосе Аркадио:

- Нохойн жогорхой шиг юм байна гэж шулуухан хэлжээ.

Эцэг нь гарынхаа араар уруул руу нь чанга гэгч дэлсээд авсанд Хосе Аркадиогийн амнаас нь цус садарч нүднээс нь нулимс гарчээ. Шөнө нь Пилар Тернера тэмтчин вяж шилтэй эм, хөвөн олж хавдсан уруул дээр ньарникаар жин тавиад, Хосе Аркадиогийн хүссэн бүхнийг гүйцэтгэхдээ янаглахын зэрэгцээгээр өвчтэй газрыг нь хөндөхгүй байж чаджээ. Тэр хоёр бүр дотно болж, өөрсдөө ч мэдэлгүйгээр анх удаагаа шивнэн ярилцаж эхэлжээ.

- Би чамтай л байгаад баймаар байна. Ерөөсөө өнөө маргаашгүй би үнэнээ хэлэхэд ингэж нуугдаж явдгаа больё гэж хөвгүүнийг шивнэсэнд эмэгтэй нь:

- Тэгвэл аятай юу. Хоёулхнаа байвал дэн асаачихаад бие биеэ харж, би санаандаа орсныг хашгирч, чи толгойдоо орсон бүхнийг миний чихэнд шивнэж байхад хэнд хаматй юм гэж хариулжээ.

Ингэж ярилцсан, ямар ч атугай нууцаар амрагласан хэвээрэ байна гэж итгэсэн, мөн эцэгтээ шаралхсандаа Аркаио тайван бөгөөд зоригро йбайлаа. Тэрбээр эрэгцүүлж тунгаасан юмгүйгээр бүгдийг дүүдээ ярьжээ.



Эхлээд жаалхан Аурелиано Хосе Аркадио гай дайрч гэж бодож, ямар албин түүнийг татаад байгааг ойлгосонгүй. Гэвч Хосе Аркадиогийн зовон догдолж байгаа нь түүнд ч халджээ. Тэрбээр ахаараа явдлыг нь нэгд нэгэнгүй яриулж, зовлон жаргалыг ойлгож, өөрөө айх, баярлах зэрэгцэж байлаа. Одоо жаал хүү Хосе Аркадиогийн ирэхийн хүлээн үүр цайтл цурам хийхийг больж, халуун нурман дээр хэвтэж байга аюм шиг орондоо ганцаараа эргэж хөрвөн, ахыгаа ирэхэд хоёулаа амьтан босох болтол ярин, удалгүй нойрмоглох явах болоод рилу бүтээхүй ухаангы ч, эцгийнхээ эрдэм чадлыг ч адилхан жигшиж, тэрүүхэндээ аминчирхан булагнах боллоо. “Хүүхдүүд маань дүйнгэ юм шиг болчихож, цагаан хорхойных л байх даа” гэж Урсула хэлнэ. Тэрбээр талхалсан мексик цайгаар ой гутам зуурмаг, хийж, хоёр хүү нь энэ эмийг санаанд оромгүй тэвчээртэй ууж орхижээ. Аурелиано ахынхаа сэтгэл дэнсэлж байгааг ойлгож байсан төдийгүй өөрө өл ийм болсон юм шиг зовж байлаа. Нэг удаа ах нь үүл борооны явдлын нарийну чрыг тоочин ярьж байхад дүү нь “Чамд тэр үед ямар байдаг вэ?” гэж яриаг нь тасалсанд цаадах нь бодож цөхөлгүй,

- Яг л газар хөдөлж багаа юм шиг болдог гэжээ.

Нэгдүгээр сарын нэгэн пүрэв гаригт хоёр цагт Амарана төрлөө. Өрөөндөө хүн оруулахын өмнө Урсула охиныг сайн үзэв. Охин хөнгөхөн, гүрвэл шиг годгоносон боловч хүнээс гажууд юмгүй байлаа. Аурелиано гэртээ олон хүн цуглахад л сая дүүтрэй болсноо мэджээ. Хүмүүсийн үймэлдэж байх далимаар Аурелиано шөнөийн раван нэгэн цагаас хойш эзгүй байгаа ахыгаа ол жирэхээр явжээ. Гэнэт тэгж шийдсэн болохоор Хосе Аркадио яаж Пилар Тернерагийн унтлагын өрөөнөөс гаргаж ирэхээ ч эрэгцүүлж амжсангүй. Хэдэн цаг Аурелиано болздог ёсоороо шүгэлдэн түүний байшинг тойрон явсаар үүр цайхад сая буцав. Эхийнхээ тасалгаанд орвол Хосе Аркадио хэдийнээ ирчихсэн, нялх дүүгээ юу ч болоогүй юм шиг өхөөрдөж байлаа.

Амарантаг гараад дөч хороогүй байтал дахиад цыганууд ирлээ. Эд бол мөс авчирдаг нөгөө хэрмэл хуурч, “гүү сааж” тоглогчид байлаа. Меликадесийн овгийхон шиг дэвшлийн зарчид бус, зөвхөн илбэр жилбэ үзүүлэгчид төдий гэдэг нь төдөлгүй мэдэгдэв. Тэд мөс авчрахдаа ч хүн ашигтай юм хийж болох байдлаар биш зүгээр циркийн үзмэр маягтай түүнийг үзүүлж билээ. Цыганууд энэ удаа бусад олон хачин юмсын зэрэгцээгээр нисдэг цийрс авчирчээ. Гэвч тэд түүнийгээ харицааны хэрэгслийг хөгжүүлэх үйлсэд нэмэр хандив өргөж байн агэж бодохгүй, харин зугаа цэнгэл гэж үзэх ажээ. Хүн амьтан суурины дээгүүр нисэж үзэх гэж хамаг мөнгөө барж байлаа. Бултаараа эх толгойгоо алдаж, үймэн бужигнаж байх сайхан самбаанд Хосе Аркадио, Пилар Тернера хоёр амьтны нүдэнд өртөнө гэж айх юмгүй дураараа болж авчээ. Олны дунд хутгалдсан жаргалтай хоёр амраг хайр сэтгэлийг шөнө нууцаар учрахад оволзоод өнгөрчихдөг цэнгэлээс нь ултай бөгөөд тайван байх юмгэж санаагүйдээ тэр ч байтугай гайхаж эхэлжээ. Гэтэл Пилар баяр хөөрийг нь хийсгэчихэв. Хосе Аркадио өөртэйгөө хамт байхад сайхан байна гэж сэтгэл нь баяссан тэрбээр өнгөцхөн юмыг ултай хэмээн эндүүрч, ганцхан үг хэлээд Хосегийн урман дээр нь ус асгаж орхив. “Чи одоо ёстой эр хүн болсон” гэж Пиларын хэлэхэд цаадах нь юу гээд байгаагийг нь ойлгоогүй тул,

- Чи хүүтэй болно гэж үг үгээр нь таслан хэлжээ.

Хэдэн өдөр Хосе Аркадио гэрээс гарч зүрхэлсэнгүй. Гал зуухны өрөөнд Пиларын цангинатал хөрөхрийг дуулангуутаа л лабораторид орчихоод байлаа. Урсулагийн зөвшөөрснөөр ажил дахин оволзож эхлээд байсан тул Хосе Аркадио Буэндиа замаа

алдсан хүүгийнхээ буцаж ирсэнд сүйд болж, эрдэнийн рилуг нэгэнт хайж эхэлсэн нууцаа хэлж билээ. Нэг орой лабораторийн цонхны дэргэдүүр нисдэг цийрсээр цыган дэлбэгч, рогсоны хэдэн хүүхэд нисэж, хүүхдүүд өөрсөд рүү нь гар даллан өнгөрөхөд ах дүү хоёр их бахадсанг боовч Хосе Аркадио Буэндиа цонх руу эргэж ч харсангүй. “Яах вэ хөөрхий, зугаацаж л байг. Бид ийм өөдгүй дэвсгэрээр нисэхгүй, хамаагүй илүү шинжлэх ухааны аргаар ниснэ” гэж хэлжээ. Хосе Аркадио хүү рилуг сонирхож байгаа дүр үзүүлэвч ыухам ямар ид чадалтайг нь огт ойлгосонгүй, их л базаахдаа муухан цуггасан лонх шиг юм байгаагаар гэж дотоо боджээ. Лабораторид ажиллаа гээд сэтгэл үйсэрх нь намдсангүй. Тэрбээр нойр, хоолноос гарч, цэгийнхээ хийж байгаага абүтэлгүй болоход урвайчихдаг шиг бүр унжийчихав. Хүүгийн их уруу царайт байгааг Хосе Аркадио Буэндиа рилу бүтээхүй ухаанд дэндүү сэтгэлээ өгөөд гогсонгор байнаг бодон лабораторид ажиллахыг нь болиулав. Аурелиано ахыгаа эрдэнийн рилуг олоогүйдээ сэтгэлийн тав алдсан бус гэдгийг ойлгосон боловч ганц ч үг алдуулж чадсангүй. Ах нь урьдынх шиг илэн далангүй байгаа больжээ. Үргэлж найрсаг, нийцтэй байдгаа болиод дуугаа хураан, уур уцаартай болжээ. Энэ ертөнцийн хамаг бүхэнд хорсон бухимдаж, ганцаараа байхын мөн болсон тэрбээр нэг шөнө дахин гэрээсээ гарсан боловч Пилар Тернерагийн руу очсонгүй, цыганы асар майхныг тойрон шавсан хүмүүсийн дунд орж явчихав. Янз янзын уран тоглолт харж хэсэг тэнсэн боловч алиныг нь ч сонирхсонгүй явсаар үзвэртэй огт хамаагүй нэг юм харсан нь сувс зүүлтээ даахгүй бөхийсөн бараг охин гэмээр нэгэ нцыган бүсгүй байлаа. Хосе Аркадио түүнээс хөөрхөн бүгүй энэ насанда үзээгүй байжээ. Нэгэн хүнийг эцэг эхийнхээ үгэнд орсонгүй гэж могой богосон нэгэнт гунигт үзвэрийг ангайн харж зогсоо улсын дотор тэр бүгүйс байж байлаа.

Хосе Аркадио тэр хөөрхий хүнийг огт харсангүй. Олон улс могой болсон хүнээс түүний гунигт явдлыг нарийвчлан шалгааж байх хооронд залуу Буэндиа эхний эгнэнд байгаа цыган бүсгүй рүү шахалдсаар очиж ард нь зогсов. Тэгээд тэр бүсгүйг шахсанд цаадах нь цааш хөндийрөх гэхлээр нь бүр чанга налсанд нөгөөхийг нь мэдэрчээ. Бүсгүй дороо таг болж, ай х гайхах зэрэгцээд сэрэлдээ итгэж өгөхгүй, эргэн харснаа Хосе Аркадио руу туягүйхэн инээмсэглэв. Энэ үед хоёр цыган могошй болсон хүнийг торонд хийж, асар руу авч явав. Зарч цыган зарласан нь:

- Ноёд хатагтай нар аа, одоо бид аймшигтай тоглолт үзүүлнэ. Харах ёсгүй юм харсан учир зуун тавин жилийн турш шөнө бүр яг энэ цагт энэ эмэгтэйн толгойг авч байгаа юм гэв.

Хосе Аркадио, бүсгүй хоёр тэр эмэгтэйн толйгог авахад байлцсангүй. Хоёул асарт орж, сэтгэл догдлон үнэсэлдсээр хувцсаа тайчин хаялав. Бүсгүй давхарлан өмссөн цээживч, шарласан торон олон банзал, өөрт нь огт хэрэггүй усан бэлхүүсэвч, хүн дшилэн зүүлт сэтээсээ салсан дхүний өөдөс амьтан үлдэв. Хөх гэхээр юмгүй, Хосе Аркадиогийн гараас нь нарийнхан хөлтэй энэ чөргөр бүсгүй тийм туяхан биенд байшгүй шийдэмгий бөгөөд халуун янаг ажээ. Гай болоход, асрын гол багананд дэн өлгөөтэй, хамаг юм ил харагдахын дээр цыганууд элдэв юм барин цацарт байн байн орж ирээд энэ тэр юм хийж, тэр ч байтугай орны дэргэд газар сууцгаан, шоо тоглох тул Хосе Аркадио төдийчинээ тачаангуй хариулж чадахгүй байлаа. Зай завсаргүй үнэсэж таалахын хоорондох ахархан чөлөөнд шалдан Хосе Аркадио орон дээр гайхшаа баран арчаагүйеэ сунан хэвтэж, нөгөө бүсгүй түүний дурыг хүргэх гэж ахин дахин оролдож байлаа. Жаахан байж байтал цацарт махлаг цыган хүүхэн нэг хүн дагуулаад орж ирсэн нь эдний омгийн ч, сурины ч хүн биш байлаа. Тэгээд хоёул орны хажууд шулуулан

хувцсаа тайчиж эхлэв. Эмэгтэй Хосе Аркадиоог санамсаргүй харснаа зүүрмэглэн байгаа арслангийн нь толгойг үзээд их л бахдаж,

- Хүү минь, хаадхыг чинь тэнгэр тэтгэн яваг гэж дуу алджээ.

Хосе Аркадиоогийн бүсгүй өөрсдийгөө зүгээр байлгаж үзэ гэж хүссэнд цаадах хёор орны хажууд газарт хэвтэв. Бусдын тачаал ивлэхэд залуугийн хуял сая хөдлөвэй. Хосе Аркадио бэлгийн бүүдээр аргын эдийг анх зүтгүүлэн оруулахад, үлгэрлэвээс өрөөстэй даалуу авандан шаамагц бутран ойдог шиг, бүсгүйн хатан яс нь зад үсэрч, хар хөлс нь чийхран гарч, хамаг бие нь шархиран өвдөж, хоёр нүдэнд нь нулимс цийлгэнэж, харин хархүүгээс нь замаг ханхлаад явчих шиг болжээ. Гэвч бүсгүй түүнийг гайхмаар баатарлаг тэвчээртэйгээр давж гарав. Хосе Аркадио нэг мэдэхнээ үүлтэй тэнгэрээс дээгүүр нисэн яваа юм шиг болж, зүрхний угаас янагийн үг урсан гарч, бүсгүйн чихээр өртөөлөн зүрхэнд нь ороод эргэн амар нь цыган хэлээр хөрвүүлэгдэн гар чбайлаа. Энэ бол пүрэв байлаа. Бямба гаригийн шөнө Хосе Аркадио толгойгоо улаан даавуугаар ороогоод, Макондонгоос цыгануудтай хамт явлаа.

Урсула хүүгээ алга байгааг мэдээд тосгоноор л нэг эрэл сурал болнн харайлгав. Цыганы асар майхан байсан газарт гагцхүү хог новш овоорон үлдэж, задгай галын үнснээс утаа уугин байлаа. Шилэн зүүлт эрэн хог ухаж байсан суурины нэг хүн урьд өшөн нь Хосе Аркадиоог тортой могой хүнтэй тэргийг түрэн жүжигчинтэй хамт явж байхыг харснаа Урсулад хэлжээ. “Хүү маань цыган болчихож!” гэж Урсула эрдэ эсандран дуулгавал цаадах нь ууган хүүгээ алга болсныг огтхон ч тоосон шинжгүй,

- Тэгвэл ч овоо шүү гээд мянгантаа талхалж, түмэнтээ хайлуулсан нэгэн бодисыг ууранд хийн нүдэх зуураа- Эр хүн болж бйга ань тэр гэж хэлжээ.

Урсула цыгануудын одсон зүгийг олж мэдээд, цыгануудыг гүйцэх санаатай уулзсанб олгоноосоо сураглан мөрөөр нь ясваар тосгоноосоо улам улам холдож, нэг мэдвэл буцахын аргагүй алс явчихсан байлаа. Хосе Аркадио Буэндиа оройн найман цагт эхнэрийнхээ байхгүй байгааг мэдэж, дэлгэсэн бууцан дээр бодисоо халаахаар тавиад жаалхан Амарантаг яаж байна хэмээн очвоос цаадах нь уйлсаар бүр ээрчихсэн байж байлаа. Тэрбээр бодож цөхсөнгүй, тосгоныхоо сайн зэвсэгтэй нөхдийг цуглуулж, Амарантаг хараад байж байя гэсэн нэг хүүхэнд өгөөд, хүнгий мөр гараагүй замаар Урсулагийн эрэлд мордлоо. Тэгэхдээ Аурелианоог авч явав. Үл мэдэх хэлээр ярих загасчин индаинчуудтай үүрээр дайралдаж асуувал цаадуул нь үүрээр хэн ч гараагүй гэж дохиж занган тайлбарлажээ. Гурван өдөр дэмий яваад тосгондоо бцаж ирэв.

Хосе Аркадио Буэндиа сэтгэлээр удтал унав. Жаахан Амарантаг эх шиг нь асарч, усанд оруулж, хуурайлж, өдөр асрагч эхэд нь дөрвөн удаа аваачиж өгөн, үдэш нь Урсулагийн хэзээ ч чаддаггүй дуу хүртэл дуулж өгдөг байлаа. Нэг удаа Пилар Тернера Урсулаг иртэл гэрийнх нь ажлыг хийж өгөөд байя гэжээ. Зовлон үзэхдээ юмыг зөнгөөрөө улам мэддэг болсон Аурелиано Пиалр Тернераг ирэхэд гэнэт учрыг гялсхийтэл олж, ямар ч гэсэн түүнээс болж ах нь босож, ээж нь алга болсон гэдгийг ойлгоод дуугүйхэн боловч голоосоо зэвүүрхэн угтсанд тэр хүүхэн тэднийд дахин үзэгдсэнгүй болно.

Яваандаа хамаг юм хэв зандаа орлоо. Хосе Аркадио Буэндиа хүүтэйгээг, нэг л мэдэхэд лабораторидоо орчихсон, тоос шороог нь цэвэрлэж, хөөрөгнийхөө галыг бадрааж, хэдэн сар шивхэн дээр хэвтсэн бодисоороо дахин уйгагүй ноцолдож гарлаа. Амранта мөнгөн ус ууршин үнэртэх тасалгаанаа уд бургасан сагсанд хэвтэж, аав ах хоёрынхоо хийж байгааг сонирхон харна. Урсулаг алга болсны дара алабаораторид хачин хачин юм боллоо.

Шүүгээнд удтал хэвтсэн хоосон лонх гэнэт даагдахгүй хүнд болжээ .Ажлын ширээн дээр тавьсан хувинтай ус гал түлээгүй байхадөөрөө буцлан, хагас цаг хэртэй даргилан байснаа юу ч үгүй ширгэж хоцров. Хосе Аркадио Буэндиа хүүтэйгээ хоёул энэ гайхалтай явдалд хөөрөн баярлаж, яагаад ингэж байгаагийн учрыг олж чадахгүй ч шинэ бодис үүсэхийн шинж гэж тайлбарлаж байлаа. Нэгэн өдөр Амранатаг суулгасан сагс хэн ч хүрээгүй байхад Аурелианогийн нүдний өмнө тасалгаан дотуур гэнэт эргэлдэж ниссэнд Аурелиано яаранб арьж авчээ. Гэвч Хосе Аркадио Буэндиа огтхон ч тэвдсэнгүй. Сагсыг хуучин байранднь аваачиж тавиад, ширээний хөлнөөс уяв. Сагс ниссэнд тэрбээр найдвар нь биелэхэд хариугүй ойртож гэ жүбр итгэжээ. Чухамхүү тэгэхэд Аурелиано аавынхаа

- Чи тэнгэрээс айдаггүй юм аа гэхэд металаас айж яв гэж хэлэхийг анх сонсож билээ.

Урсула таван сар хэртэй алга байснаа буцаж ирэв. Тэрбээр тогсонд хэний ч өмсдөггүй шинэ хувцас өмчихсөн, залуужчихсан, хөөрчихрсөн хүрч иржээ. Хосе Аркадио Буэндиа баярлсандаа арай л магнай нь хагарсангүй. “Тэгнээ ээ тэр! Би яг л ингэж бодоод байсан юм!” гэж хашгирав. Энэ ч үнэн байлаа. Лабораторид бодисын туршилт хийн, нар салхины бараа харахгүй ажиллахдаа эрднийн рилуг нээж, гэрийнхээ бүх цоож, цонхы нугасыг алт болгох аргыг олж гайхамшгийг бүтээхсэн гэхээсээ чухамхүү Урсулаг буцаж ирээсэй гэж сэтгэлийнхээ угт тэнгэрт залбиран мөргөж байсан ажээ. Гэвч эхнэр нь тийнхүү хөл алдан баярласаныг нь огт тоосонгүй.цагийн өмнөхөн л уулзсан мэт ердийн нэг шовхийтэл үнэсээд,

- Довжоон дээр гараад хараадахаач гэж хэлжээ.

Хосе Аркадио Буэндиа гэрийнхээ гадаа бөөн хүн бахйгы үзээд барьц алдсанаа их л удаж байж тайвширчээ. Эд бол цыганууд бус, макондогийнхон шиг толигор үстэй, бор арьстай эрэгтэй эмэгтэй хүмүүс, яг л тэдэн шиг хэлээр ярьдаг тэдэн шиг л сульдсанаа гайхсан улс байлаа. Тэдний дэргэд элдэв хангайн идэш уушын юм ачсан луус, гэрийн тавилга, эд агуурс зэрэг өдөр тутмын хэрэгцээт бараа ачсан үхэр тэрэг зогсож байлаа.

Тэр хүмүүс хөндийн нөгөө талаас иржээ. Тэнд хоёр өдөрчийн газарт нэг хот бий, тэнд сар бүр шуудан ирдэг, амьдралыг хөнгөвчилсөн маш ин хэрэглэдэг байжээ .Урсула цыгануудыг гүйцсэнгүй боловч нөхрийнхөө их нээлт хийх гэж дэмий хөөцөлдөж байхда аолж чадаагүй тэр замыг олсонб айжээ.

\*\*\*        \*\*\*        \*\*\*

Пилар Тернерагийн хүүг төрснөөс хойш хоёр долоо хонуулаад өвөө эмээ хоёрын д нь авчирч өглөө. Урсула авах дургуй байсанб оловч Буэндагийнхны удам ганд хаягдана гэж юу гэсэн үг вэ гэж нөхрийнхөө зүтгээд байхад яаж ч чадсангүй. Гэхдээ хүүхэд хэнээс гарснаа мэдэхгүй байх ёстой гэсэн болзол тавьжээ. Хүүд Хосе Аркадио гэж нэр өгсөн боловч тавьжээ. Хүүд Хосе Аркадио гэж нэр өгсөн боловч андуурахгүйн тул түүнийг зүгээр л Аркадио гэж дуудах болжээ. Тэр үед макондогийнхон худалдаа хийгээд завгүй, Буэндиагийнх ч ажил ихтэй байсан тул хүүхэдтэй манатай байлаа. Аркадиогуахиро овгийн индиан хүүхэн Виситасьоноор харуулав. Тэр хүүхэн нутагт нь гараад хэдэн жил болсон нойр хулжих урхагт, халдварт өвчнөөс дүүтйгэй хоёул зугта жэнд

ирсэн юмсанжээ. Эгч дүү хоёр дуулгавартай, ажилтай улс байсан тул Урсула эгчийнхээ ажилд туслалцулахаар хөлслөн авчээ. Тэгтэл Аркадио Амаранта хоёр испани хэлээр ярихаасаа түүхэнд гуахиро хэлээр ярьж сураад гүрвэл, аалзны өндгөөр хийсэн шөл идэж сурсан боловч, Урсула амьтан шувууны дүрстэй мөсөн чихэр хийх багагүй орлоготой ажил хийгээд толгой роендийх завгүй байсан тул түүнийг нь ч анзаарсангүй. Макондо огт өөр боллоо. Урсулагийн авчирсан хүмүүс Макондогийн ихээхэн ашигтай агазр байрласан, ойр орчны газры нь үржил шим сайтаг хаа л бол магтсанаар хүн амьтан, засварын газар, худалдааны хөдөлгөөнт зам бүхий олон хөлийн хот болж, тэр замаар зуузайгүй шаахай өмссөн, чихэндээ гархи зүүсэн анхын арабууд ирж, шилэн сувсыг тотитор арилжиж эхлэв. Хосе Аркадио Буэндиа борви босхисхийх завгүй болов. Тэрбээр бүтэх бүтэхгүй хоосон юм бодож байснаас бодит амьдралд оролцохыг илүүтэйд үзэж рилу бүтээх бухааны туршилтдаа сонь бууран, олон сар хайлуулж өөрчилсөөр ихээ багассан бодисоо амар заяа үзүүлж, урьд нь гудамж хаагуур гаргах, аль нэгийг нь давуутай болгохооргүйгээр шинэ байшинг хаа барихыг шийдэж байан шигээ эргээд хэрсүү, шийдэмгий боллоо. Шинэ айлууд түүнийг туйлаас хүндлэн дээлдэлж түүнээс зөвлөгөө авалгүйгээр нэг ч шав тавихгүй, нэг ч хашаа босгохгүй, тэр байтугай газар хуваарилахыг ч түүнд итгэн даатгажээ. Явуулын жүжигчин цыгануудыг нүүдлийн яармагаа мөрийтэй тоглоомын асар том газар болгочихсон буцаж ирэхэд нь ХОсе Аркадио хамт ирлээ гэж горьдоод бөөнб аяр болон тосов. Гэвч Хосе Аркадио ирсэнгүй, хүүгийн нь хаа байгааг мэдэх цорын ганц амьд амьтан гэж Урсулагын бодож байсан хүн могой ч тэдэнтэй хамт байсангүй тул цыгануудыг тэнд буулгасангүй, тэр ч байтугай тэднийг хомхой сувдаг, завхай шалиг бүхний уурхай гэж үзэн “Дахиад үүгээр бүү үзэгд” г хэмээн хөөжээ. Мянган жилийн мэргэн ухаан, гайхамшигт ололтоороо Макондог тэгж их өөд татсан Мелькиадесийн хуучин овгийг хэзээ ч найр тавин угатан гэж Хосе Аркадио Буэндиа хэлжээ. Гэвч Макондогоор дайрч гарах аянчин тэнүүлчин улсын ярих нь, Мелькиадесийн овог хүнд байвал зохих мэдлэгийн хэрийг давсан учир устаж үгүй бослон гэх ажээ.

Ямар ч гэсэн Хосе Аркадио Буэндиа элдэв юм бодож биеэ чилээхийг түр больж, ахархан хугацаанд хот нийтээрэ нэгэн жигд хөдөлмөрлөх болгож, Макондог байгуулагдсанаас хойш жиргэн цаг зарлагад байсан шувуудыг суллаад айл болгонд хөгжимтэй цаг тавьснаар амьдралын тэр жигдэрсэн явцыг өөрөө л нэг эвджээ. Арабуудаас тотитор арилжиж авсан сийлмэл модон сайхан гэгчийн тэр цагуудыг Хосе Аркадио Буэндиа тун нарийн тааруулсан нь эдгээр цаг гучин хувь болоод нэг л вальсын аялгууг хэдэн айзам тоглодог, тэгэхдээ тухай бүр шинэ айзам тоглодог, яг үд дунд тэр залсыг бүхэлд нь нэгэн зэргээр ганц ч гаж өнгө гаргалгүйгээр хөгжимдөн тоглож хотынхныг баясгадаг болжээ. Хосе Аркадио Буэндиа түүнчлэн гудамжинд хуайс модны оронд бүйлсийн мод суулгах санааг сэдэж, энэ модыг мөнхийн болгох аргыг өөрө өнээж олоодгалийгаач болохдоо энэ нууцаа өөртэйгөө хамт авч одсон билээ. Олон жилийн хойно Макондо цайран дээвэртэй модон байшинтай болсон байхад, хуучин гудамжинд нь мөчир нь хугарсан, өмхөрч өгөршсөн бүйлсийн мод ургасаар байсан боловч хэн түүнийг суулгасныг санах хүн нэгэнт байхгүй болсон байж болно.

Аав нь хотоо эмх журамтай болгож, ээж нь хөөрхөн хөөрхөн тахи, загасны дүрстэй мөсөн чихэр хийж, бальза модон ишинд суулгаад өдөрт хоёр удаа наймаалайн гэр орноо өөд татаж байх хооронд Аурелиано гагцхүү юм сурах эрмэлзлэлтэйдээ уран дархны ажилд суралцан, хүн шагайхаа байсан туршилтын өрөөнд хамаг цагаа өнгөрүүлж байлаа. Хөвгүүн өсөж ахынх нь хувцас багадах болж, эцгийнхээ

хувцсыг өмсөх болов. Гэвч одоохондоо Аурелиано эцэг, ах хоёроосоо туранхай байсан учир Виелитасон цамцыг танаж, өмдийг нарийсгаж өгөх хэрэг гарч байлаа.

Аурелиано арван зургаа долоо хүрэхдээ хоолой нь бүдүүрч, үг цөөтэй, өрөөл бусдаас бүр дөлөмтгий болоод, нүд нь анх төрөхөд нь Урсулагийн харсан шиг харцтай болж ирлээ. Аурелиано дархаараа ноцолдон, туршилтын өрөөнөөс идэж ууух гэж гар чирэхээс өөрөөр гардаггүй байлаа. Хүүгийнхээ зожиг хажиг болж байгаад сэтгэл зовсон Хосе Аркадио Буэндиа хүүдээ бүсгүй хүн хэрэгтэй байж магадгүй гэж бодоод гадаа хаалганы түлхүүр, гарын бэл хийх жаахан мөнгө өгчээ. Аурелиано хаан ус 1 бэлтгэх давсны хүчил мөнгөөрөө худалдан авч, түлхүүрээ шармалдан гоёжээ. Гэвч Аурелианогийн этгээд зан Аркадиоа, Амаранта хоёрыг бодвол юу ч биш байлаа. Нялхын цахиур нь унасан тэр хоёр бүтэн өдөржин индианчуудаас салахгүй, хормойноос нь чаргуулдан дагаж, испаниар ярихгүй, гуа-хориогоор ярих гэж зөрдүүдлэн зүтгэж байлаа. “Хэнийг муу хэлэх вэ. Эцэг эхийнхээ галзууг дурайж байгаа нь тэр” гэж Урсула нөхөртөө хэлжээ. Хүүхдүүдийнх нь энэ адайр ааш гахай сүүлнээс дээрдэх юмгүй гэж итгэсэн эхнэр аз заяагүйдээ харамсан үглэх гэтэл Аурелиано дотрыг нь эвгүй болтол ширтгээд:

- Манайд хүн ирэх нь дээ гэж хэлэв.

Урсула хүүгийнхээ тийм ийм юм болох нь гэж урьдаас мэдэн хэлэх бүрийд нь тийм байх учиргүй хэмээн батлах гэж оролддог шигээ мөн л тэгж Хүүгээ ухардуулах гэж оролджээ. Хүн ирвэл ирээ л биз. Макондоогоор өдөрб үр хэчнээн хүн дайрч байхыг тэр гэх вэ, үүнд сэтгэл зовон, тэдний ирэхийг урьдаас мэдэж ярих хэрэг огт байхгүй гэжээ. Гэвч яаж ч батлаад нэмэргүй, Аурелиано өөрийнхөөрөө зүтгэж,

- Хэн ирэхийг нь бүү мэд ээ. Гэхдээ тэр хүн замд гарах нь гарчихсан байна даа гэжээ.

Нээрэн ч ням гаригт Ребека ирлээ. Арван нэгэн наснаас хэтрээгүй жаахан охин арьс наймаалагчидтай хамт Манаурегаас бэрх зам тулж энд иржээ. Тэр худалдаачид охиныг захидлын хамт Хосе Аркадио Буэндиагийн хүргэж өгөх ёстой гэх боловч чухам ямар хүн тэднээс ингэж гуйсныг төдийлөн мэдэхгүй байлаа. Ирсэн охины хөрөнгө гэвэл хайрцагтай хувцас, эрээлэн будсан жижиг модон ганхуур сандал, зотон хүүдий гурав байсан бөгөөд тэр хүүдийд нэг юм “хар хар хар” гэж дуугарах нь охины эцэг эхийн ясыг хийсэн юм санжээ. Хосе Аркадио Буэндиад ихээхэн найрсаг тахимдуу үгээр захиа бичиж ирүүлсэн тэр хүн холдон салаад уулзаагүй удсан боловч түүнийг дотночлон үзсээр байдгаа дурдаж, Урсулагийн үзэл дүү болох, тэгээд бас Хосе Аркадио Буэндиагийн мартагдашгүй анд Никанор Ульо, түүний заяаны хань Ребека Монтиэль хоёрын төрсөн охин учраас Буэндиагийн ч холын хамаатан болох энэ хөөрхий өнчин охиныг өрөвдөн хайрлахын эрхээр өөрт н ваяулан буйяныг үйлдэж тэнгэрт хальсан эцэг эх хоёрын нь ясыг христос тэнгэрийн заншлаар нутаглуулаасай хэмээн захиатай хамт илгээлээ гэж бижээ. Захидлыг явуулагч дээрх хоёр нэр хийгээд захидлынхаа сүүлд өөрийн нэрийг гаргагдахаар тавьсан байсан боловч Хосе Аркадио Буэндиа, Урсула хоёр тийм хамаатан байсныг тэрчлэн алс холын Манауре сууринд суудаг тийм нэртэй танил байдгийг санахгүй байлаа. Өөр дэвтэй юм охиноос огт мэдэх аргагүй байлаа. Охин гэрт оронгуутаа ганхуур санадл дээрэ суун хуругаа хөхөөд, өөрөөс нь асууж байгаа юмыг ойлгож байгаагийн огт шинжгүй бүгдийг айсан нүдээр бүл тгэнэн харж байлаа. Охин хараара аширдсэн хуучин диагнаал давуу даа шинз, хугарч хагарсан чийдмэл шаахай өмсөөд, үсээ хоёр салаалан чихнийхээ ард шуун хар туузаар зангидаж, хөлсөнд нүүсэн дүрстэй сахиус хүзүүндээ зүүж, хүний хар хэл амыг хариулах зас оосортой нэг амьтны соёо зөв гартаа хийжээ. Арьс нь шарлаж,

гэдэс нь цондойгоод чулуу шиг хатуу болсныг үзэхэд бие муутай, дандаа өлөн зөлмөг байсан нь илт боловч тавагтай хоол авчирч өвдөг дээр нь тавьж өгөхөд ам хүрэхгүй жомбойн сууна. Бүгдээрээ охиынг хэлгүй дүй юм байнагж бодтол иандианууд “Юм уух уу?” гэж өөрийнхөө хэлээр асуусанд цаадах нь тэднийг таних мэт дагуулан харж, ууя гэж толгой дохижээ.

Түүнийг авч үлдэхэс өөр зам байсангүй. Аурелиано нэрийнб үх судрыг уйгагүй дуудаж өгсөн боловч нэг ч нэрийг хайхраагүй учир захидалд өгүүлснээр бол эхийг нь Ребека гэдэг байсан тул Ребека гэ жнэр өгөхөөр тогтов. Тэр үед Макондод нас барсан хүн байхгүй, оршуулгын газар чбайхгүй байсан тул нутаглуулах аятай газар олтол хүүдийтэй ясыг нуусан нь огт санаандгүй газраас гарч ирээд, өндгөө дарсан тахиа дуугарч байгаа юм шиг “хар хар хар” гэж байдаг байж билээ. Ребека гэрийнхэнд дастал нэлээд удав. Эхлээд гэрийн хүнгүй буланд ганхуур сандал дээрээ хуруугаа хөхөөд суучихдаг байлаа. Юу ч анхаарлыг нь татна гэж байхгүй, харин гучин хувь болгонд цаг дуугарах тоолонд, хий агаарт дуугий нь олж харах гэж байна уу гэлтэй айсан маягаар эргэн тойрноо харна. Түүнд юм идүүлэх гэж удав. Гэр дотуур чимээ гаргалгүй сэмээрхэн явж чаддаг болохоор хэзээний л юм олоод мэдчихсэн байдаг индианчууд Ребекаг хананаас шохойг хумсаараа холтлон аваад чийгтэй шороотой холиод идчихдэгийг мэдэн мэдтэл түүнийг яагаадөлбөрч үхдэггүй юм бол гэж бодоод бодоод олохгүй байж билээ. Эцэг эх нь үү, эсвэл өсгөж бойжуулсан хүмүүс нь үү, алиныг бүү мэд, түүнийгэнэ муу зан сурсныг мэдээд гэсгээдэг байсан бололтой, учир нь тэр шроо, шохойгоо хүний нүд хариулан их гэмшсэн байдалтай дэж, хажуудаа хүн байхгүйд чөлөөтэйхөн шиг хужирсаагаа тайлахын тулдхурааж хадгалах гэж оролддог байлаа. Ребекаг хатуу цагдах болов. Урсула гада аүхрийн цөс асгаж, байшингийн ханыг энэтхэгийн халуун чинжүүгээр арчин охины тэр муу дуршлыг анагаах гэсэн боловч уул хоолоо олж идэхдээ туйлын зальтай, овсгоотой учир, Урсула хамгийн хүчтэй арга хэрэглэхээс өөр аргагүй болов. Тэрбээр хувинтай зүржийн шүүс, гишүүнийг шөнөжин хүйтэн шүүдэрт тавиад энэ хандаа өглөө өлөг элгэн дээр нь Ребцкад өгчээ. Урсула ийм хандыг шороонд дурлах өвчинг ангаах эм болгон өгдгийг хэнээс ч дуулаагүй боловч ямар ч гашуун шингэн хоосон гэдсэнд ороход элгээр нь хатгулна гэж өөрөө л бодсон юмсанж. Ребека харахд сул дорой боловч хачин ярдаг, хэрдэ эшөрмөстэй учир эмийгу улгах гэхэд мөргөмхий бяруу шиг аашлан итэлчилж, маажиги, хазаж, нулимс, мэдэхгүй баахан үг хашигрсан нь дургүйцсан индианчуудын ам шүд алдсанаар гуахиро хэлээр хамгийнб үдүүн хараал тавьсан хэрэг байжээ. Урсула үүнийг нь мэдээд энэ эмчилгээн дээрээ суран бүсийн амт үзүүлэх эмчилгээг нэмж орхижээ. Эцсийн бүлэгт ханд уу, уран бүс үү, эсвэл хоёулаа нийлээд үү, чухам аль нь тус болов гэдгийг бүү мэд, ямар ч атугай хёор гурван долоо хоноод Ребекагийн өвчин нааш эргэх төлөв мэдэгджээ. Одоо тэрбээр өөрийг нь эгч гэдэг Аркадио, Амаранта хоёртой толгож хутга сэрээ чадамгай хэрэглэн хоолоо амтархан иддэг болжээ. Ребека испани хэлээр индианчуудын хэлээр ярьдаг шигээ чөлөөтэй ярьдаг, үйлэнд тулын уран, өөрийнзохиосон хөөрхөн үгээр цагийн вальсыг дуулдаг нь удалгүй мэдэгдлээ. Төдөлгүй охин өрхийн шинэ үбл боллоо. Ребека Урсулад төрсөн хүүхдүүдээс нь илүү эелдэг байж, Аркадио Амаранта хоёрыг дүү гэж Аурелианог ах, Хосе Аркадио Буэндиаг өвөө гэж дуудах болов. Тийнхүү Ребека Буэндиа гэдэг нэрийг авах эрхийг бусдаас дутахгүй олж авч, энэ авсан ганц нэрээ үхэн үхтэлээ хөөдөөгүй билээ.

Ребека шороо иддэг муу дуршлаа хаяж, Амаранта, Аркадио хоёрын өрөөнд унтах болсны дараа нэг шөнө хүүхдүүдтэй хамт унтдаг идиан авгай санамсаргүй сэрээд сонсвол булангийн тэндээс нэг хачин, чажарсан дуу гарч байлаа. Ихэд цочсон тэрбээр

орноосоо үсрэн босож, тасалгаанд амьтан орж ирсэн юм биш байгаа хэмээн болгоомжлон үзвээс Ребека дүүжин сандал дээрээ хуруугаа хөхчихсөн, нүд нь харанхуйд муурын нүд шиг гэрэлтэн сууж байв аа. Виситасьон түүний нүдний гялалзахыг хиртхийн үзвээс, нөгөө гайт өвчний шинж мэдэгдсэнд угсаа залгамжлах хаан ширээгээ үүрд орхиод дүүгийнхээ хамт энэ өвчнөөс зугтсан нь сэтгэлд нь сэрхийжээ. Нойр хулжиж өвчин эднийд нүүрлэх нь энэ байлаа.

Индиан Катаруе үүр цайхыг хүлээлгүй Макондогоос явав. Дэлхийн аль ч газароронд очлоо гэсэн энэ аймшигт өвчнөөс зайлж чадахгүй гэж зөнгөөрөө мэдэж байсан тул эгч нь явсангүй. Виситасьоны сандарч байгааг хэн ч ойлгосонгүй. ”Унтахгүй гэнэ ээ? Бүр л сайн биз. Энэ насандаа улам ихийг хийж амжина” гэж Хосе Аркадио Буэндиа сэтгэл хангалуун хэлжээ. Гэвч, биед зовуургүй тул нойр алга болгоход нэг их айгаад байх юмгүй, ганц хамаг юмаа мартаж эхэлдэг нь хамгийн аюултай гэж индиан вагай тайлбарлажээ. Өвчтөн нойргүй болоходоо эхлээд эхүүхэд байхынхаа явдлыг мартаж, дараа нь эд юмсын нэр, дэгээрээр юу хийдгийг мартаж, дараа нь хүн танихаа байж, тэр ч байтугай өөрийгөө хүн гэдгийг санахаа больдог, тэгээд урьдхыгаа санахаа болихоор нялх хүүхэд шиг болдог гэдгийг авгй хэлжээ. Хосе Аркадио Буэндиа элгээ хөштөл инээж, сүсэгтэй индиануудын аль ийм юм санаанаасаа зохиож байхыг тэр гэх вэ гээд тоосонгүй. Гэвч уулын хянуур Урсула, юмыг яаж мэдэх вэ гэж Ребекаг бусад хүүхдээс тусгаарлав.

Нэлээд хугацаа өнгөрч Виситасьоны айсан нь гайгүй өнгөрлөө гэж бодогдох болж байтал Хосе Аркадио Буэндиа шөнө дунд эргэж хөрвөөд унтаж чалахгүй байгаагаа гэнэт мэджээ. Урсула ч нойро хүрэхгүйд эр нөхрөөсөө “Яагаад байна?” гэж асуухад цаадах нь “Би дахиад л Пруденсио Агилярыг бодож байна” гэжээ. Тэд шөнө цурам хийсэнгүй боловч өглөө босоход бие хөнгөхөн байсанд шөнө унтаагүйгээ дороо мартаж орхив.

Шөнөжин туршилтын өрөөнд сууж Урсулад төрсөн өдөөр нь бэлэглэх хатгуурыг алтаар бүрсэн боловч огт ядарсан шинжгүй байх юмгэж Аурелиано өглөөний цайн дээр гайхан ярьжээ. Гэвч энэ хачин явдлыг хэн ч хайхарсангүй, хоёр хоногийн дараа Буэндиагийн орондоо ордог цагт цөмөөрөө огт нойр хүрэхгүй байгаагаа азаарсангүй, бодоод бодоод тавь гаруй цаг унтаагүйгээ ухаарсангүй.

- Хүүхдүүд ч унтахаа байлаа. Энэ тахал нэгэнт л гэрт ор жирсэн болохоор толгой дараална гэж мэд хэмээн индиан авгай аанай л муу амлав.

Нээрээ ч гэрээрээ нойр хулжих өвчинд нэрвэгдлээ. Өвчний анагаах чадлыг ээжээсээ таньж сурсан Урсула халуу цэцгээр ханд бэлдэж, гэрийнхэндээ уулгасан боловчхэнд ч нэмэр болсонгүй, өдөржин сэрүүнээрээ зүүдэлж унтаа үгүй хоёрын хооронд хачин бйадалтай болсон тэд өөрийнхөө зүүдийг манах төдийгүй бусдын зүүдэлж байгааг ч мэдэх ажээ. Гэрт нь зочид дүүрсэн мэт санагдана. Гал тогооны өрөөний буланд ганхуур санадл дээрээ сууж байхдаа Ребека өөртэй нь маш адилхан, цагаан хиеэвэн косчоомтой, цамцныхаа заханд алтан товчтой хүн сарнай цэцгийн баглаа барьж байн агэж зүүдэлжээ. Тэр хүний хажууд булбарай зөөлөн гартай эмэгтэй зогсоод нэг сарнай авч, Ребекагийн үсэнд хатгаж байв. энэ эрэгтэй эмэгтэй хоёр бол охины эцэг эх хоёр байна гэж Урсула мэдээд, таних гэж хэчнээн мэрийсэн болочв чадсангүй, тэднийг урьд хэзээ ч үзээгүй юм байна гэж бүр итгэв. Энэ зуур Хосе Аркадио Буэндиагийн цалгардсанаас болж тэднийд хийдэг амьтны дүрстэй чихрийг хотод гаргаж худалдсаар байлаа. Үүндээ Хосе Аркадио Буэндиа өөрийгөө зүхээд зүхээд барсангүй. Хүүхэд үүхэдгүй цөмөөрөө нойргүйн ногоон хөөрхөн тахиа, нойргүйн гоё ягаан загас, нойргүйн ялдам шар морийг хүлхсээр даваа гаригийн үүр тэмдэгрэх үед хот даяараа унтахаа больсон байлаа. Макондод тэгэхэд ажил



гэдэг барагдахгүй, цаг гэдэг хүрэхгүй байсан учир зарим нь бүр баярлажээ. Хүмүүс ажлаа шадман хийж, ахархан хугацаанд бүх юмаа жин тан болгочихсон тул одоо өглөөний гурван цагт гар хумхин суугаад цагийн вальсны янь1-ийг тоолж суудаг болов. Ядарсандаа бус нойроо сансандаа унтахыг хүсэгчид биеэ ядраах гэж байдгаараа оролож байлаа. Тэд нэг дор цуглаж, ам хамхилгүй ярьж, нэг л шогийг хэдэн цагаар давтаж, цагаан тахианы үлгэрийг бүр цөхрөнгөө бартал элдэв янзаар нэмж хачирлан ярьж байлаа. Энэ бол дуусн гэж байдаггүй үлгэр бөгөөд хөтлөгч бусдаасаа “Цагаан тахианы үлгэр сонсох уу?” гэж асуухад “Сонсьё” гэж хариулбал “сонсьё” гэж хэл гээгүй, цагаан тахианы үлгэр ярих уу үгүй юү гэдэгт л хариул гэсэн болохоос биш гэж хэлдэг, “сонсохгүй” гэвэл “сонсохгүй” гэж хэл гээгүй, цагаан тахианы үлгэр ярих эсэхийг л асуусан гэж хэлдэг, хэрэв цаадуулыгаа дуугүй байвал “Дуугарахгүй бай гэж гуйгаагүй, цагаан тахианы үлгэр ярих уу, байх уу? гэж л асуусан” гэх зэргээр шөнийг дуустал тийнхүү үргэлжлүүлэн ярьдаг байжээ.

Хот даяар халдвар тархсаныг мэдэхдээ Хосе Аркадио Буэндиа бүх өрхийн тэргүүн нарыг цуглуулж, энэ өвчний тухай мэддэг юмаа хэлж, зэрэглдээх хот сууринд халдаахгүй байх юм бодож болохоор ярилцжээ. Тэгэхд л арабуудаас тотитор сольж аваад, ямааны хүзүүнд зүүсэн байсан хонхнуудыг тайлан авч, харуулуудын хориглосоор байтал хотод орох гэж зүтгэсэн хүмүүст зориулан Макондогийн дээр өлгөжээ. Тэр үед Макондод ирэгсэд эрүү лхүн гэдгээ мэдэгдэхийн тулд хонхоо дуугарган явах ёстой байлаа. Энэ өвчин амаар дамждаг, Макондод идэх уух бүх юм нойр

## 1 Янь- Эртний монгол нэр томъёо, Оросоор “нота” – Орч

хулжих өвчний нянтай гэдэгт эргэлзэх юмгүй байсан тул хотод юм идэж уулгадаггүй байлаа. Ингэж сэрэмжилсний үрээр төлөг хотоос хальсангүй болно. Цээрийг ч тун хатуу сахиж байлаа. Хүмүүс яваадаа онц байдалдаа дасаж, амьдрал хэв зандаа орж, ажил төрөл урьдынх шигэ эявах болж, хэн ч унтах гэдэг ашиггүй зуршлыг орхисондоо харамсахыг больжээ.

Юм санахаа болихтой тэмцэх аргыг Аурелиано олсон нь хэдэн сар тусаа өгөв. Тэгэхдээ санамсаргүй олж. Нойр хулжих өвчин хамгийн түрүүнд хүрэгсдийн нэг байсан болохоор туршлага ч асар их сууж, уран дархн ажилд ч тун гаргууд болжээ. Нэг удаа алт мөнгө давтдаг жижиг дөш хэрэг болсонд нэрийг нь олох гээд чадсангүй. Эцэг нь түүнд “дөш” гэж хэлж өгөв. Аурелиано энэ үгээ цаасан дээр бичээд Багажийнхаа эх биенд наажээ. Одоо энэ үгийг мартаггүй гэдэгт итгэж байлаа. Энэ нь юм мартдаг болохын эх гэж толгойд нь тогт орсонгүй. Тэгтэл туршихлтын өөрөөнийхөө бараг бүх юмны нэрийг арайхийн санаж байгаагаа хэд хоноод мэдлээ. Тэгэхэд нь зохих нэрсийг нь бичээд наачих болж, юу хэрэглэх гэж байгаагаа бичсэн тэр нэрээ хараад эдэх болов. Эцэг нь бага байхынхаа хамгийн сэтгэл хөдлөм явдлыг мартаж боллоо гэж үглэсэнд Аурелиано түүнд олсон аргаа хэлж, Хосе Аркадио Буэндиа тэр аргыг хэлэж гэртэ эхэрэглээд дараа нь хотод хэрэглүүлжээ. Тэрбээр бэхэнд бийр дүрээд, гэрийнхээ юм бүр дээр “ширээ”, “сандаг”, “цаг”, “хаалга”, “хана”, “ор”, “хувин” гэж бичээд малынхаа хашаа, ногооынхоо талбай руу очиж “үнээ”, “ухна”, “гахай”, “тахиа” “гадил” гэж амьтан шувуу ургамлын нэрийг тэмдэглэжээ. Хүн амьтан мартаж байдлыг утйлын олон янз байгааг мэд мэдсээр юмыг

нэрээр нь танилаа ч, түүгээр юу хийдгийг санахгүй болох өдөр ирэх нь гэдгийг ойлголоо. Үүнээс хойш бүр ч төвөгтэй боллоо. Макондогийнхон мартаж өвчинтэй тэмцэх гэж хичнээн ородсон нь үнээний хүзүүнд “Энэ бол үнээ. Сүүгийг ньахвахын тулд энэ үнээг өглөө болгох саах хэрэгтэй, сүүг кофетой хольж сүүтэй кофе болгохын тулд сүүг буцалгах хэрэгтэй” гэсэн самбар өлгөснөөс тод харагдана. Тийнхүү бодит ертөнц тэдний ой ухаанаас алдагдах гэж тэмүүлж, үгийн хүчээртүүнийг түр зуур саатуулавч үг үсгийн утга мартагдмагц ой ухаан бүр алга болох нь гарцаагүй болж ирэлэ.

Хотын хаалган дээр “Макондо” гэсэн бичиг өлгөж, “Тэнгэр бий” гэсэн өөр нэг арай томхныг төв талбайд хаджээ. Хараад мартсан юмаа санаж байх янз бүрийн таних тэмдгийг байшин бүр дээр зуржээ. Гэвч тийм арга хэрэглэхэд байнгын анхаарал, сэтгэлийн асар их хүч хэрэгтэй байсан бөгөөд учир нь олон хүн нь юмыг сайхнаар сэтгэлдээ бодож түүндээ хууртжээ. Энэ нь ашиггүй боловч сэтгэлийг нь тайвшруулах ажээ. Урьд нь ирээдүйн явдлыг мэргэлдэг байсан Пилар Тернера өнгөрсөн явдлыг мэргэлдэг болж сурчихаад тийнхүү өөрийгөө хуурах явдалгазар авахад морийг нь эмээллээд өгчээ. Макондогийн нойргүй болсон иргэд Пилар Теренерагийн элдэв их юм л урнаар санаанаасаа зохиож байгаагийн хар гайгаар хэзрийн харшалдаан зөрчилдсөн бүдэг мэргийн манан дунд хөвөн, тэр мананд орсон хүн дөрөвдүгээр сарын эхээр хар үстэй эрэгтэй хүнийг эцгээ гэж, солгой гартаа алтан бөлзөг зүүсэн бор эмэгэтийг эхийгээ гэж арайхийн таньж, өөрийгөө лаврын модон дээр болжмор жиргэж байсан сүүлийн мягмар гаригт төрсөн шиг санах болжээ. Ингэж сэтгэлээ хуурахад яахын аргагүй дийлдсэн Хосе Аркадио Буэндиа цыгануудын гайхамшигт нээлтийг санаж байхын тулд зохиох юмсан гэж тухайн үедээ мөрөөдөж байсан ойн машиныг түүнд сөргүүлэн зохиохоор шийджээ. Уг машин хүний энэ насандаа олж авсан мэдлэгийн бүх нийлбэрийг өдөр бүр давтах зарчмаар ажиллах ёстой байлаа. Хосе Аркадио Буэндиа энэ оньсыг эргэлдэх толь бичгийн байдалтайгаар төсөөлж байсан бөгөөд эргэлтийнх нь тэнхлэг дээр хүн зогсож байгаад барилураар түүнийг залахад аж амьдралд нь хэтэгтэй бүх мэдээ ахархан хугацааны дотор нүдэнд нь харагдаад өнгөрөх ёстой байв. Зохион бүтээгч арван дөрвөн мянга орчим карт бөглөөд байтал хөндийн замааролсоор багласан цүдгэр хөвхөн хайрцаг, хар даавуугаар бүтээсэн жижиг тэрэгтэй хачин янзын өвгөн эрүүл хүний хонхыг уйтгартайхан жингэнүүлсээр айсуу явснаа шууд Хосе Аркадио Буэндиагийнхныг зүглэв.

Виситасьон өвгөнд хаалга онгойлгож өгөөд түүнийг таньсангүй, мартагын өвчинд эргэшгүй баригдсан хотод юу ч зарах боломжгүй гэдгийг дуулаагүй худалдаачин юм байлгүй гэж санажээ. Өтөлж доройтсон хөгшин ажээ. Хэдийгээр хоолой нь итгэл муутай чичирхийлж, гар нь юм мэдрэхээ больсон юм уу гэж бодогдмоор байсан боловч, хүн нь унтдаг, юм санадаг ертөнцөөс ирсэн гэдэг нь тодорхой. Хосе Аркадио Буэндиа гарч ирэн, өвгөнийг зочдын өрөөнд суугаад элэгдсэн харбүрхээрээ сэвэн, хананд наасан бичгийг анхааралтай бөгөөд өрөвдөнгүй уншиж байхыг хараад энэ хүнийг урьд таньдаг байгаад одоо мартчихсан байж магадгүй гэж хаширлан их л хүндэтгэнгүй амар

мэндийг нь эржээ. Гэвч зочин түүний залиг таачихжээ. Өөрийг нь мартаж, тэгэхдээ эргэн санахаар мартсан бус, өөрийнх нь сайн мэддэг шиг үхэхэд яаж мартаж вэ яг тэгж ор тас мартжээ гэдгийг ойлгов. Сая бүгдийг ойлгож, юугий нь мэдэх аргагүй юмаар пиг дүүргэсэн хөвхөн хайрцага онгойлгож эдгээрийн дотроос олон цозон шилтэй жижиг хайрцаг гаргаж, гэрийн эзэнд аятайхан өнгөтэй шилтэй шингэнийг өгсөнд түүнийг нь уувал ухаан нь цэлмэж, бүх юман дээрээ нэрийг нь бичсэн хөгийн тасалгаанд өөрийгөө харахаас өмнө ханан дээр бичсэн эрхэмсэг үгсийг уншихаасаа өмнө, тэр ч байтугай гэнэт ухаангүй баярлахаасаа өмнө ирсэн гийчнээ таньж нүдэнд нь нулимс цийлгэнэжээ. Тэр бол Мелькиадес байлаа.

Макондогийнхны ой ухаанаа сэргэснийг ёслол тэмдэглэж байх зуур Хосе Аркадио Буэндиа, Мелькиадес хоёр хууч хөөрч гарлаа. Цыган эндээс явахгүй бодолтой ажээ. Тэрбээр үнэхээр нөгөө ертөнцөд очоод ганцаар байж тэссэнгүй буцаж иржээ. Овгийнхондоо гадуурхагдаж, амьдралд дэндүү хоргодомтгой гэж шийтгэгдэн ид шидийн хүчээ алдсан тэрбээр дэлхийн элэг бүтэн байгаа энэ газар амар жимэр сууж, батиар татах ажилд биеэ зориулахаар шийджээ. Хосе Аркадио Буэндиа тийм шинэ юм гарсныг огт дуулаагүй ажээ. Гэвч өөрийгөө болон гэрийнхнийгээ солонгорсон төмөр илтсэн дээр мөнхөд тодрон үлдсэнийг үзэхдээ мэл гайхжээ. Яг энэ үед авсан зураг дээр Хосе Аркадио Буэндиа үнсэн өнгөтэй өрвөгөр үстэй, зэс товчтой цармдал захтай цамцтай, баярлах гайхах хослосон царайтай гарчээ. Урсула үхтлээ хөхөрч, түүнийг “айж хоцорсон генералтай” адилхан байна гэж баталж байлаа. Үнэнийг хэлэхэд, арван хоёрдугаар сарын цэлмэг тэр өглөө Мелькиадесийн зураг авч байхад Хосе Аркадио Буэндиа үнэхээр цэрвэж байсан бөгөөд хүний дүрс төмөр илтсэн дээр буухын хэрээр хүн барагадан гэж айж байлаа. Хамгийн зугаатай нь гэвэл энэ удаа шинжлэх ухааныг Урсула өмөөрч, нөхрийнхөө балай бодлыг тас цохижээ. Тэрбээр Мелькиадесийг урьд үздэггүй байснаа мартаад гэртээ байлгана гэжээ. Гэвч өөрөө ач нарынхаа доог болохгүй (өөрийн нь ярьж байгаагаар бол) гээд батиараа огт татуулсангүй. Энд өгүүлж байгаа тэр өглөө хүүхдүүддээ цайны нь хувцсыг өмсгөж, нүүрийг нь оодож, Мелькиадесийн гайхамшигт аппаратын өмнө хоёр минут огт хөдлөлгүй зогсоохын тулд тархины ясны шөл нэг нэг халбагыг уулгажээ. Халуун бүлээрээ авахуулсан цорынганц энэ зураг дээр Амаранта, Ребека хоёрын дунд хар хилэн костюмтай Аурелиано зогсож байлаа. Тэрбээр нэлээд ядрангүй царайтай, далдыг хардаг харцаараа харсан байсан нь олон жилийн хойно оршуулгын хайсны дэргэд буудуулах гэж зогсохдоо яг ийм байдалтай байж билээ. Гэвч энэ удаа хөвгүүн хувь ерөөл хаашаа эргэхийг мэдэхгүй, гагцхүү хавь ойрынхоо хот сууриныханд уран нарийн юм хийдэг гэж хайрлуулж хүндлүүлсэн инжаан төдий л байлаа. Урландаа Аурелиано байгаа үгүй нь мэдэгдэхгүй. Урлан нь Мелькиадесийн туршилтын өрөө ч бас болдог учир цыган эцэг хоёрыгоо шилэн савны харших, хорны тавагны мөргөлдөх чимээн дунд, хүчил асгах, хүчилд бромт мөнг уусган

баллах зэрэг бөөн аюулын дунд Нострадамусын бэлгэдэн хэлснийг тайлбарлан чанга чанга маргалдаж байхад Аурелиано огт өөр ертөнцөд оччихсон байдаг байлаа. Аурелиано ажилдаа махруу, өөртөө хонжоо харж чаддаг учраас удалгүй Урсулагийн мөсөн чихэр зарж олдгоос илүү мөнгө олох боллоо. Гагцхүү цээнд хүрсэн ийм эр яагаад эмс охидод хавьтдаггүй юм бол гэж л цөмөөрөө хачирхдаг байлаа. Нээрээ түүнд явдаг хүүхэн байсангүй. Хэдэн сар бооод Макондод хоёр зуу эргэм настай өвгөн тэнүүлч Хүмүүн Франсиско дахин ирэв. Тэрбээр хотод дандаа ирж, зохиосон дуугаа дуулдаг байлаа. Манаурегаас эхлээд хөндийн нөгөө хязгаар хүртэл мөртөө тааралдсан хот тосгонд болсон бүхявдлыг дуундаа нэгд нэгэнгүй өгүүлдэг, танил талдаа сураг дуулгах буюу гэр орондоо болсон явдлыг олон түмэнд мэдэгдэх гэсэн хүнийг хоёр сентаво өгөхөд тэр тухай нь дуунд оруурлдаг байжээ. Нэг орой Урсула хүүгийнхээ сургийг гаргаж магадгүй гэж горьдон түүний дуулахыг сонсож байгаад эхийнхээ бие барсныг санамсаргүй мэджээ. Дуу зохиох уралдаанд чөтгөрийг дийлсний учир уг алдрыг олсон, жинхэнэ нэрийг нь хэн ч мэдэхгүй тэр хүн нойр хулжих толог дэлгэрэх үед Макондогоос алга болсноо одоо Катариногийн хүрээлэнд нэг мэдээд хүрээд ирчихсэн байж байлаа. Түүний дуулахыг чагнан, дэлхийн сонин сонсох гэж цөмөөрөө тэнд очив. Хүмүүн Франсискотой хамт нэгэн тарган авгай морилон ирсэн нь, дөрвөн индиан түүнийг дамнуургаар дамжлан, номой байрын залуухан эрлийз хүүхэн дээр нь шүхэр барин нарнаас халхлан явах ажээ. Энэ удаа Аурелиано ч тийш очжээ. Тойрон хүрээлсэн сонирхогчдын дунд асар том хамелеонтой төстэй Хүмүүн Франсиско залран сууж байлаа. Тэрвээр бүүр Гуайянд байхад нь ноён Уолтер Рэлигийн<sup>1</sup> бэлэглэсэн мөнөөхөн эртний баян хуура адаран, өвгөн хүний байдлаар далайн хужирт хагарсан паривгар хөлөөрөө дууны айзамд тохируулан товшиж байлаа. Тасалгааны гүнд өөр өрөө рүү ордог нэг хаалга харагдаж, түүгээр эрчүүл ээлж ээлжээр орон, үүдэнд нь нөгөө дамнуулж ирсэн тарган авгай дэвүүрээр сэвэн сууж байлаа. чихнийхээ ард хиймэл сарнай хавчуулсан Катарино нишингийн дарс худалдаж, эрчүүдэд ойртон гара ацээртэй газар нь хүргээд авах далим алдахгүй байлаа. Аурелиано шинэ сониныг дуустал сонсоод, өөрийнд нь хэрэгтэй юм сонсоогүй учир явах гэтэл нь авгай хуруугаараа дохи ндуудаж,

- Чи ч ор, ердөө л хорин сентаво гэж хэлжээ.

Аурелиано пэндгэр авгайн өвдөг дээр байгаа аяганд мөнгийг чулуудаад, ямар учиртайг нь ч мэдэлгүй хаалга нээн орж явчихлаа. Орон дотор залуухан эрлийз хүүхэн жингэрийн дэлэн шиг мээмээ унжуулчихсан чармаа шалдан хэвтэж байлаа. Аурелианогийн түрүүнд энд жаран гурван эрэгтэй оржээ. Олон хүний уур амьсгаанд бохирдож, дээр нь хөлс хулмасны үнэр шингэсэн агаар бүгчим өмхий гэж жигтэйхэн. Бүсгүй норсон цагаан даавуугаа авч өрөөсөн сэжүүрээс н бариач гэж гуйв. Цагаан даавуу нойтон таар шиг хүнд болжээ. Хоёул түүнийг мушгин, хэвийн жинд ортол нь усыг н шавхрав.

Дараа нь сийрсийг ч сэгсэрсэнд хөлс дусалж байлаа. Аурелиано тэр бүгдийг л хийгээд байх сан гэж туйлаас хүсэж байлаа. Амрагийн ажлыг яаж хийдгийг

1 Уолтер Рэли (1522-1618)- английн далайн жуулчин, Өмнөд Америкт очсон шинжилгээний хэд хэдэн ангийг удирдаж явжээ.

Онолын хувьд мэдэж байсан боловч түүний өвдөг нь чичрэн, хөл дээрээ арайхийн тогтож байлаа. Бүсгүйг ороо засаж дуусаад хувцсаа тайл гэхэд нь Аурелиано “Намайг хүчээр оруулсан юм. Хорин сентаво аяганд хий гэсэн, бүү удаарай гэсэн” хэмээн ээдрэн хэлэхэд бүсгүй түүний байдлыг ойлгож, “Гаргахдаа дахиад хорин мөнгө өгчих юм бол жаахан удаж болно” гэж аяархан хэлэв. Ичиж зовохын туйлд хүрэн хувцсаа тайлж байхад нь өөрийнх нь нүцгэн бие ахынх нь дэргэд юу ч биш байгаа гэсэн боол а мар заяа үзүүлэхгүй байжээ. Бүсгүй хичнээн ородсон боловч Аурелиано улам арчаагүй болж “Би дахиад хорин сентаво өгчихнө” гэж цөхрөн бувтнаж байлаа .Бүсгүй баярласнаа дуугүйхэн илэрхийлжээ. Бүсгүйн арьс нь хавиргандаа наалдаж нуруу нь холгон цус шүүрчээ. Туйлдаж ядарсанаас ихэд амьсгаадна. Хоёр жилийн өмнө Макондогоос ихээ хол газарт бүсгүй өргөж авсан эмгэнтэйгээ сууж байжээ. Нэг удаа лаагаа унтраалгүй унтаж хоцроод нэг сэрвэл байшин нь бөөн гал болсонб айжээ .Тийнхүү суудаг байшин нь үнс болжээ. Түүнээс хойш эмгэн байшингийнхаа үнийг олуулах гэж түүнийг хот сууринаар авч яван, хорин сентавогоор хүний өвөрт оруулах болжээ. Өрөө дарахаас гадна замын зардал, хоол хүнс, түүнчлэн дамнуургачин индиан нарын хөлсийг төлөх учиртай тул шөн бүр далан хүнтэй унтаад байвал одоо арав орчим жил ингэж явах үлдлэ эгэж бүсгүй бодож байжээ. Эзэн эмгэнийг хаалаг хоёр дахиа тогшоход Аурелиано юу ч хийж чадалгүй, нулимсаа арайхийн барьсаар өрөөнөөс гарчээ. Энэ шөнө тэрбээр бүсгүйг өрөвдөх, хүсэх хоёр зэрэгцэн унтаж чадсангүй. Түүнийг хайрлаж, хамгаалах гэсэн юун ч дйилдэшгүй хүсэлд автжээ. Өглөө нь нойргүй хонож, тэчъяадан зовсон тэрбээр эмгэний эзэрхийлэлээс бүсгүйг өмгөөлөн авах, даланэрийн эдэлдэг тэр жаргалыг шөнө бүр ганцаараа эдэлж байхаар энэ бүсгүйтэй суух гэж хатуу шийджээ. Гэвч өглөөний арван цагт Катариногийн газар ирвэл бүсгүй Макондогоос нэгэнт явчихсан байлаа.

Цаг хугацаа өнгөрөхөд залуу хүүгийн оргилуун гоомой хүсэл намжсан боловч мөрөөдлөө биелээгүйд харамсах сэтгэл лавширчээ. Тэгээд ажилдаа хамаг сэтгэлээ тавих болж, бэлгийн ажил хийж чаддаггүй гутамшгаа нуухын тулд насан туршаа гоонь явахаар шийдэж билээ. Тэр завсар Мелькиадес Макондод зургийг нь авбал зохих бүхний зургийг авсны хойноо батиар татах аргаар Тэнгэр байгааг шинжлэх ухааны үүднээс нотлохоор шийдсэн Хосе Аркадио Буэндиад

солиот туршилтаа хийг гэж туршилтынхаа өрөөг тавьж өгчээ. Буэндиа гэрийнхээ энд тэнд авсан зургийг олон давхарлуулснаар эзэн тэнгэр гэж байдаг бол зургийг нь эрт орой хэзэ боловч заавал авна, байдаггүй юм бол байдаг гэдэг таамгийг бүрэн тас цохино гэдэгт бат итгэж байлаа. Мелькиадесийн тухайд гэвэл Нострадамусыг л лавшруулан судалж, онгож гандсан хилэн хантаазтайгаа байдгаараа амьсгаадан урьдын өнгөө аль хэдийн алдсан бөлзөгтэй хэрээний сарвуу шиг чөргөр гараараа цааса ндээр махир тахир юм сараачиж, шөнө орой болтол сууна. Макондогийн хойч ирээдүйг урьдчилаад харчих шиг, Макондо шил толь болсон том байшин бүхий үзэсгэлэнтэй сайхан хот болно, гэчв энэ хотод Буэндагийн удам судар ор мөргүй алга болох юм шиг нэг удаа санагджээ. “Дэмий бүү донгос. Шилэн байшин биш ээ, мөсөн байшин, би зүүдэндээ үзсэн юм, тэнд Буэндиагийнхнаас заавал байна” гэж Хосе Аркадио буэндиа унтууцав. Урсула олноос гажууд амьтдын энэ оронг жаахан ч гэсэн бусдын жишиг болгох гэж улайрч, том зуух барьж аваад, мөсөн чихэр дээрээ нэмж, сагс сагч талх, төрөл бүрийн жигнэмэг хийж, хөндийн за мдээр гарч худалдахад хэдхэн цагт л үзэх юмгүй гүйчихдэг байлаа. Урсула хөл жийн амрах насан дээрээ очсон боловч тэгсэнгүй, харин ч улам борви бохирохгүй зүтгэх болж байлаа. Ажлаа урагштай байгаад урамшин толгой өөд татахгүй байсан тэрбээр нэг орой индиан авгайг тогоонд элсэн чихэр хийж байх зуур цонхоор санасаргүй хараад үдшийн шар гэгээнд хоёр танихгүй бүсгүй хашаанд юм нэхэж суугааг үзэхдээ гайхаж хоцорчээ. Тэр бол Ребека, Амаранта хоёр байлаа. Тэд гурван жил эмээгээ үхлэ эгэж өмссөн гашуудлын хувцсаа дөнгөж сая тайлж, өнгөт даашинз өмссөн нь тэднийг огт өөр болгожээ. Хэний ч санаагүй байтал Ребека Амарантаг дагуулахгүй хөөрхөн болжээ. Тэрбээр арьс нимгэн, нүд том, хурц урсгал, гар уран бөгөөд тэлүүрт татсан даавуун дээгүүр гар хөдлөх нь үл үзэгдэх утсаар хатгамлаж байх мэт болно. Амарантаг гоо үзэсгэлэнгээр Ребекагаас дутуу боловч талийгаач эмээгийнхээ уулын бодь, нэр төрөө хичээх сэтгэлийг авч төржээ. Аркадио эцэг шигээ тэнхээтэй хүн болох нь мэдэгдэж байвч тэдний дэргэд хүүхдээрээ байлаа. Аурелиано түүнд үсэг бичиж зааснаас гадна уран дарх заажээ. Хүүхдүүд нь өсөж томрон удахгүй хань бүлтэй, үр хүүхэдтэй болж гэртээ багтахыг болиод туурга тусгаарлах нь г гэдгийг Урсула ойлгон, удаан жил нуруугаа бөгцийтөл ажиллаж хураасан мөнгөө гаргаж, дархцуултай хөлс хүчийг нь тохиролцон байшингаа томрулж гарав. Тэгээд айлчин гийчний морилох ёслолын нэг том танхим, халуун амиараа арван хоёул суугаад зоог барьчих сэрүүхэн тохилог хоолны өрөө, жин үдийн хурц нарнаас сарнайн том хүлэмжээр сайтар халхлагдсан урт гонхон бариулж, гонхны дагуу ваартай ойм, хайтан цэцэг тавих суурь хийлгэжээ. Бас хоёр зуух тавихын тулд гал тогооныхоо өрөөг томсгох, Хосе Аркадиогийн хойчийн явдлыг Пилар Тернерагийн мэргэлсэн өнөө агуулахыг буулгаж, хүрэлцэхээр хоол хүснний нөөц үргэлж байлгахын тулд хоёр дахин томыг барихаар болов. Хашаанд, асар том туулай бөөр модны ёроолд бүсгүйчүүл, бүстэйчүүлийн гэсэн хоёр усан

сан, байшингийнхаа ард зайтай жүчээ тахианы торон хонуурь, үнээ саах саравч, нүүдлийн шувуу дураар орж гарч болох дөрвөн талда ацонхтой тор хийлгэжээ. Нөхрийнх нь элдэв юм зөгнөн боддог нь халдсан мэт ихэд хөөрч дэвэрсэн Урсула хэдэн арван чулуучин модчин дагуулж гэрэл яаж тусах, илч хаанаас түгэх ёстой зэргийг өөрөө шийдэж, зайг баримжаагаар хуваарилаж байлаа. Макондог байгуулагдахад анх барьсан энгийн байр, багаж хэрэгсэл, барилгын хэрэглэгдэхүүнээр дүүрч, ажилчид холхилдон, өөрсдөө бусдад саад хийх мөртлөө бусдыг бүү сада болоод бай хэмээн албархаж, мөнөөхөн хүүдийтэй яс хаал бол хөлд нь тээглэж, хар яр хавиралдахад бөөн уур унтуу болох ажээ. Хөл толгой нь олдохгүй ийм бужигнаан дундаас, түүхий шохой, газрын хэвлээс олгойдох лаврын уур утаа дундаас Макондодоо хамгийн том төдийгүй тэр хавьдаа хамгийн зочирхог, сэрүүхэн байшин яаж босов гэдгийг хэн ч ойлгохгүй байлаа. Буэндиа тэр их бужигнааны ид үеэр ч эзэн тэнгэрийг гэнэдүүлэн зургийг нь авахгэж хөөцөлдсөөр байсан тул бүр ч ойлгож цөхөж байлаа. Шизэн байшин бараг бэлэн болоод байхад Урсула эр нөхрөө биелшгүй мөрөөдлийнх нь хүлээснээс гаргаж, байшингийн нүүрэн талыг өөрсдийнхөө бодсон цагаан өнгөөр бус, хөх өнгөөр будах тушаал авснаа хэлж, цаасан дээр бичсэн албан захирамжийг үзүүлэв. Буэндиа эхнэрийнхээ юу яриад байгааг даруйдаа ухаарсангүй, юуны өмнө бичсэн хүний нэрийг л сонирхон хараад

- Хэнбэ гуай нь гээ чвэ? гэж асуувал сэтгэлээр унаж хоцорсон Урсула:
- Вангийн түшмэл. Засгаас томилогдсон том дарга гэлцэх юм гэв.

Вангийн түшмэл дон Аполинар Москоте, Макондод сэмхэн ирж, жижиг бараа тотитор солих гэж ирж байсан анхны арабуудын нэгний байгуулсан “Отель Хакоба” гэсэн буурчийн газар бууснаа маргааш нь л буэндиагийн байшингаас хоёр хорооллын тэртээ шууд гудамж руу харсан хаалгатай байр хөлслөн, Хакобагаас ширээ сандал худалдан авч тавиад өөрийн авчирсан улсын сүлдийг хананд хадаж, хаалган дээрээ “Вангийн түшмэл” гэсэн хаяг бичжээ. Тэгээд үндэсний тусгаар тогтнолын ойд зориулж, бүх байшинг хөхөөр будах анхны захирамжийг гаргасан ажээ.

Хосе Аркадио Буэндиа тушаалын хуулбарыг барьсаар ирвэл, вангийн түшмэлийг үдийн зоогийн дараа даруухан контоортоо өлгөсөн дүүжин орон дээрээ амар байхтай нь таарла. “Та эндүүнийг бичсэн үү? “ гэж Буэндиа асуулаа. Дон Аполинар Москоте хэмээх хөдөлж ядсан, аймхнай байрын% ахимаг насны хүн тэр захирамжийг бичсэнээ хэллээ. ““мар эхтэй болоод ингэдэг билээ?” гэж Буэндиа дахин лавлалаа.

Дон Аполинар Москоте ширээний шургуулга ухан, нэг бичиг гаргаж ирэн өөдөөс сарвайсныг Хосе Аркадио Буэндиа авч, “Нэр дурдсан хотод вангийн түшмэлийн үүрэг гүйцэтгүүлэхээр томилов” гэснийг халти хараад,

- Энэ хотод цаасыг тоож үздэггүй юм. Манайд гүйцэтгэх хүн хэрэггүй, гүйцэтгээд байх юм ч байхгүй гэдгийг мэдтүгэй гэж тайван өгүүлэв.

Тэгээд Буэндиа жишимгүй царайлан зогсох ноён Аполинар Москотед, тосгоныг анх яаж байгуулсан, газрыг яаж хуваарилсан, зам яаж тавьснаа дуугаа өндөрлөлгүй тайлбарлаж, тийнхүү хийх ёстой бүхнийг хийхэд ямар ч засгийн газрыг үймүүлээгүй, тэгэхлээр өөрсдийг нь бүү үймүүл гэж тайван хэллээ. “Бид хорхойд хоргүй улс. Манайд хэн ч хөгширч үзээгүй. Макондод одоо болтол оршуулгын газар байхгүй байгааг үзээ биз дээ” гэж хэлжээ. Бас бид засгийн газарт зарга заалхай мэдүүлэх юм алга, харин ч манийг өөдөлж дэгжихэд саад хийгээгүйд баярлаж явдаг, хойшид чтийм байлгах байх гэж найдаж байна. Толгойтой амьтан бүхэн ирээд л тэг ингэ гэж тушааг гэж Макондог бид байгуулаагүй шүү дээ гэв. Аполинар Москоте найрсаг зөөлөн байх ёсоо алдалгүйгэр өмд шигээ цагаан бүдүүн ширхэгтэй бөс даавуун хүрмээ өмсөв.

- Хэрвээ та хотод ерийн, энгийн нэг суух гэж байгаа бол тавтай морил оо. Хүмүүсийн байшинг хөхөөр будуулж эмх замбараа алудулах гэж ирсэн бол та муу сайн новшоо аваад ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад буц. Манай байшин тагтаа шиг цав цагаан байх болно гэж Буэндиа төгсгөжээ.

Аполинар Москоте ноён царайгаа барайлган, гэдрэг ухраад шүдээ зуун, сэтгэл нэлээд долгилсон байдалтай:

- зэвсэгтэй гэдгээ танд сануулмаар байна гэлээ.

Хосе Аркадио Буэндиа урьд нь морь газарт унагаж явсан залуугийн нь тэнхээ хэдийд нь гарт нь хуралдаад ирснийг ч анзаарсангүй, нэг мэдэхэд л Аполинар Москоте ноёныг гадуур цамцны ньхоёр энгэрээс атган авч, нүдний тус газар өргөн авчраад,

- Үлдээд байгаа насандаа үхдэл чирсэнд орвол хэдэн хувь амьдыг нь чирвэл дээр юм уу даа гэж хэлж билээ.

Тэгээд тэрбээр Аполинар Москоте ноёныг заамдан өргөсөн чигээрээ гарч гудамжны голд аваачин, Макондогоос хөндий ордог зам руу харуулан хоёр хөлөөр нь тавьжээ. Хэд хоноод нөгөөх нь винтов барьсан, хөл нүцгэн, ноорхой хувцастай цэрэг дагуулж, үхэр тэргэн дээр эхнэр, долоон охиноо суулгачихсан хүрч иржээ. Хойхно нь тавилга хэрэгсэл, авдар сав, эд агуурс ачсан хоёр тэрэг ирлээ. Вангийн түшмэл суух байшин олтлоо эхнэр хүүхдээ “Отель Хакоба”-д түр буулгаж өөрөө зонтороо нээн, үүдэндэ эхоёр харул зогсоожээ. Макондогийн хуучуул урилгагүй зочдыг үлдэн хөөхөөр хатуу шийдэж, ахмад хөвгүүдээ дагуулаад Хосе Аркадио Буэндиа дээр ирж, түүгээр удирдуулан хөдлөх а гэжээ. Гэтэл Буэндиа тэднээс зөрж, Аполинар Москоте ноён эхнэр хүүхэдтэйгээ ирсэн учир гэрийнийх нь өнм хүний нэр хүндийг гутааж болохгүй, энэ хэргийг эв найраар шийдэх хэрэгтэй гээд халгаасангүй.



Аурелиано эцгээ дагаж явъя гэлээ. Энэ үед тэрбээр үзүүрийг нь цавуухан имэрсэн хар сахалтай, хожим дайнд ялгарах сүрлэг дуутай болсон байлаа. Гар хоосон тэр хоёр үүдэнд зогсоо харуулыг хайхарсангүй, вангийн түшмэлийн контоорт орж явчихлаа. Аполинар Моекоте ноён огт сандарсангүй, санаандгүй тэнд байж таарсан эх шигээ хар үстэй арван зургаан настай Ампаро, дөнгөж ес хүрч байгаа ягаан царайтай, ногоон нүдтэй Ремедиос гэдэг хоёр охинтойгоо танилцуулав. Хоёул царайлаг бөгөөд сайн хүмүүжилтэй ажээ. Буэндиа нарыг дөнгөж ормогц, ирэгсдийн нэр усыг эцгийнхээ хэлж завдаагүй байхад тэр хоёрт сандал дөхүүлж өгчээ. Гэвч эрчүүл суусангүй.

- За яах вэ, нөхөр минь. Таануус хотол үзвэл үлд. Гэхдээ гадаа хаалган дээр байгаа буу барьсан дээрэмчдээс айсан юм биш шүү, танай гэргий охидыг хүндэлсэндээ тэгж байгаа юм гэж Буэндиа хэлэв.

Аполинар Москоте ноён түгдэрсэн боловч буэндиа түүгээр үгхэлүүлсэнгүй.

- Гэхдээ бид хоёр болзол тавина. Нэг, хүн бүр өөрийн хүссэн өнгөөр л байшингаа будаж байна. Хоёрт, цэргүүдийг одоохон Макондогоос явуул. Хотын хэв журмыг бид хариуцна гэж нэмж хэллээ.

Вангийн түшмэл алгаа тэнийлгэн баруун гараа дээш өргөөд,

- Хүндэтгэлийн үг үү? Гэж асуувал, Буэндиа,
- Дайсны тань үг ээ. Танд нэг зүйлийг хэлэхэд та бид хоёр дайсан хэвээрээ байх болно гэж гашуудангуй хэллээ.

Тэр оройгоо цэргүүд хотоос явав. Хэд хоноод Буэндиа вангийн түшмэлийнд байшин олж өгөв. Аурелианоогоос бусад нь цөм тайвширлаа. Аурелиано насаар бол вангийн түшмэлийн баг аохин Ремедиост эцэг нь баймаар боловч түүнийг зүрхэндээ тээн байнга шаналах боллоо. Энэ нь гуталд орон нухах чулуу шиг амар заяа үл үзүүлэх биеийн шаналгаа байлаа.

\*\*\* \*\*

Тагтаа шиг цагаан шинэ байшингаа бүжигт найр хийж мялаав. Ребека Амаранта хоёрыг насанд хүрсэн бусгүйчүүд болсныг мэдсэн тэд үдэш байшин барих санаа Урсулад төрж билээ. Үнэнийг хэлэхэд, бүгсүйчүүдийг зочдоо хүлээгээд авахад нүүр улайхааргүй өрөөтэ болгох гэж хүссэнээс үүдэж уг барилгын ажлыг үүсгэсэн билээ. Бодсоноо гялалзтал бүрэн биелүүлэхэд саад болох юм байгаагүй тул байшинг өөрчлөн барьж байх бүх хугацаанд борви бохисхийлгүй ажиллаж, ажил дуусахаас өмнө чихэр, талх худалдаж олдсон мөнгөөрөө гэрээ гоёх, тохижуулах олон үнэт ховор эдлэл захиалсны дотор оньст төгөлдөр хуур байсан нь хотынхныг гайхуулж, залуучуудыг ихэд баярлуулсан

гайхамшигт эд байлаа. Тэр хуурыг задлан хэдэн хайрцагт хийж авчраад, венийн тавилга, богемийн болор, үнэт суулга, голланд даавуу, элдэв дэнлүү, лааны тосгуур, цэцгийн ваар, хивс бүтээлгийн хамт буулгажээ. Энэ бүхнийг нийлүүлсэн худалдааны газар италийн мастер Пьетро Креспийг төгөлдөр хуурыг угсраад, худалдаж авсан эздэд нь яаж хэрэглэдэг, зургаан хатуу цаасан бортгон дээр нүх гарган бичсэн чамин аялгуунд яаж бүгч хийдгийг зааж өгөөд ир гэж өөрийн зардлаар явуулсан байжээ.

Пьетро Креспи бол цайвар үстэй залуухан эр. Түүн шиг цэвэрхэн сайхан, төлөв төвшин хүнийг Макондогийнхон үзээгүй байлаа. Тэрбээр дэгжин харагдах гэж мэрийх тул амь тэмцэм халуунд ч мөнгөн товруутай савхин хантааз, зузаан хар цэмбэн нөмрөгөө тайлалгүй ажиллана. Хэдэн долоо хоног зочдын өрөөг дотроос нь түгжиж аваад, хөлсөө цувуулан зүтгэж, Аурелианогийн дархаа хийдэгчлэн махруун ажиллаж, тэгэхдээ тэрийн эздээс зүйг барин зайтайхан байдаг байлаа. Нэгэн сайхан өглөө Пьетро Креспи зочдын өрөөний хаалгыг нээлгүй, зэхсэн юмаа хэнд ч харуулж гайхуулалгүйгээр эхний бортогыг төгөлдөр хуурт хийсэнд алх чихэнд чийртэй тог тог хийх, банз зогсолтгүй түр няр унах чимээ гэнэт намдаад, хөгжмийн гайхмаар тунгалаг, яруухан эгшиг дуурьслаа. Бултаараа зочдын өрөө рүү гүйлдэв. Буэндиа аяны сайхныг сонсоод биширэнгүй харин өөрөө дээш доош болоод байх даралт товчийг харахдаа мэл гайхан зогсжээ. Тэр ч байтугай тэр үл үзэгдэгч хөгжимчний зургийг авах гэж Мелькиадесийн аппаратыг зоожээ. Энэ өглөө итали эр өглөөний хоол хамт идэв. Ребека, Амаранта хоёр хоол авчирч өгөөд, энэхүү тэнгэрлэг сайхан хүний бөгжгүй цагаан хуруугаараа хутга сэрээ цэмцгэр гэгч намбатай хөдлөхийг харахдаа зүрх алдаж байлаа. Зочдын өрөөний хажуугийн тасалгаанд Пьетро Креспи бүжгийн хичээл зааж эхлэв. Охидын биенд огт хүрэлгүйгээр метрономоор айзам тааруулан цохиж, янз бүрийн гишгэлтийг хийж үзүүлэв. Охидын бүжиг сурч байх зуур Урсула тасалгаанаас хором ч гаралгүй тэднийг найрсгаар ажиглаж байлаа. Энэ хэдэн өдөр Пьетро Креспи бүжгийн шаахай, биеэ барьсан нарийхан гэгчийн тусгай өмд өмсжээ.

“Дэмий юманд санаа зовох юм. Энүүнийг ямар эр хүн гэдэг юм” гэж Буэндиа эхнэртээ хэлжээ. Гэвч хичээл дуусаж итали залууг Макондогоос явсан хойно л Урсула хянах байраа сая орхижээ. Тэгээд найрт бэлтгэж эхэллээ. Урсула найрт тоотойхон хүн урив. Макондог босголцсон бүх өрхөд урилга өгсөн атал тэр үед хоёр бутач хүүхэднэмж гаргаад байсан Пилар Тернерад л өгсөнгүй. Урих хүнийг нөхөрсөг сэтгэлийн угаас боловч нэлээд алаг үзэлтэй сонгосон байлаа. Учир нь урилга авагчид нь аян хийж Макондог байгуулахаас бүр өмнө Буэндиатай үерхдэг андууд, хар багаасаа Аурелиано, Аркадио нартай үерхсэн тэдний хүү, ач нар, Ребека, Амаранта хоёрын хатм юм хатгамладаг тэдний охид, зээ нар байлаа. Маконогийн номхон захирагч Аполинар Москоте ноёны эрх мэдэл үзэмжийн төдий бөгөөд түүний үйл ажиллагаа модон жад барьсан хоёр

цагдааг хувийн задлаар байлгаж байгаагаас хэтэрдэггүй байлаа. Амиа тэжээхийн эрхээр хоёр охин нь оёдлын газар нээж, тэнд бас хиймэл цэцэг, гуайявагаар амьтан хийж, онцгой захиалгаар амрагийн захидал бичих болов. Охид даруухан, эелдэг, хотдоо хамгийн царайлаг, шинэ бүжгийг бүгдээс сайн хийдэг байсан боловч найранд уригдагсдын тоонд багтаагүй болно.

Урсула, Амаранта, Ребека гурав тавилгыг авдарнаас нь гаргаж мнгөн хэрэгслийг цэвэрлэж, сарнай овоолсон завин дотор гуниглан байгаа бүсгүйчүүдийн зургийг өлгөн, барилгачдын барьсан нүцгэн ханыг амь оруулж байх завсар Буэндиа эзэн тэнгэр гэж байхгүй юм байна гэж бат итгэн тэнгэрийг мөшгөхөө больж, оньст төгөлдөр хуурын гэдэс дотрыг уудалж, ид шидийнх нь нууцыг тайлах гэж оролджээ. Найр нөгөөдөр гэж бахиад хаанаас гараад ирсэн нь үл мэдэгдэх өдий өтдйи эрэлт боолт, дохиур цохиурыг хөглөрүүлэн бажгадаж, нэг үзүүрээс нь тэнийлгэхэд нөгөө үзүүр нь атирчих олон чавхдасны дотор толгой эргэн барьж тавьсаар уул зэмсгийг нэг эвлүүлэхчээн аяджээ. Буэндиагийнх хэзээ ч ингэж хөл болж, хөөрцөглөн бужигнаж байсангүй. Гэвч керосин дэнг яг тогтосон өдөр, цагтаа асааж амжлаа. Давирхай, нойтон шохой ханхалсаар байгаа байшингийн хаалга онгойж, Макондогийн хуучцуулийн үр хүүхэд, ойм, хайтан цэцэг бүхий гонхон, одоохондоо нам гүм байга а суух өрөө, сарнайн анхилуун үнэр түгэх цэцэрлэгийг үзээд, зочдын өрөөндөө цагаан даавуугаар бүтээсэн тул мэдэгдэх сонин зүйлийн дэргэд цугларлаа. Хөндийн хотод нэлээд дэлгэрсэн оньст хуурыг үзсэн улс түүнийг харахдаа ялихгүй урам хугарсан боловч Ребека, Амаранта хоёроор бүжгийг эхлүүлэхээр Урсула анхны бортогыг хийхэд оньс ажилласангүйд хамгийн их урам хугарчээ. Бараг сохорч, эрүү өвдөг нийлсэн Мелькадес урьдын ид чадлаа дахин гарган төгөлдөр хуурыг засах гэж оролдов. Эцэст нь Буэндиа гацсан арааг огт санамсаргүйгээр хөдөлгөтөл хөгжим дуугарч, хол хол хийнсээ дараа нь огт замбараагүй холилдон ая гарчээ. Чинээнд нь тултал татаж, гайхалтай зоримлог хөглөсөн чавхдасыг дохиур балбасаар бэхэлгээнээсээ мултран унаж байлаа. Гэвч далай эрж, давшгүй өндөр даваа давсан хорин хоёр зоригтны үр сад ая алдагдан бүдчүүлэхийг тоолгүйгээр үүр цайтал бүжиглэжээ.

Пьетро Креспи оньст хуурыг засахаар Макондод буцаж ирлээ. Ребека, Амаранта хоёр чавхдасыг засахад нь түүнд туслах зуураа вальсын хэлгий аялгууг жаал дуурайжээ. Итали залуу эелдэг, өөлөхийн аргагүй байх учир Урсула түүнийг хянаж цагдахыг больжээ. Пьетро Креспи зассан оньст хурын аянд явуулахаар төлөвлөөгүй байсан салахын бүжиг явуулж, Ребекатай орчин үеийн бүжгийн эрхэм урлагийг үзүүлжээ. Аркадио, Амаранта хоёр уран, эвлэгээрээ тэр хоёроос дутахгүй байлаа. Гэвч үзүүлэх бүжгийг зогсоохоос аргагүй болов. Учир нь үүдэнд сонирхогчдын дунд зогсож байсан Пилар Тернера, Аркадио хүүхэн шиг бөгстэй юм гэж хэлсэн эмэгтэйг үсэджээ. Шөнө дөл болсон байлаа. Пьетро Креспи салах ёс хийхдээ сэтгэл уяраам үг хэлээд, удахгүй эргэж ирнэ гэж амлалаа. Ребека түүнийг хаалган дээр гаргаж өгөөд,

хаага цоожилж, дэнлүү унтраахад өрөөндөө очоод мэлмэртэл уйлж гарлаа. Хэдэн өдөр тэрбээр тайтгарч чадахгүй уйлж, уйлсныг нь хэн ч, тэр байтугай Амаранта ч мэдсэнгүй ээ. Ребекагийн юма нуугаад байгаад гэрийнхэн нь гайхсангүй. Наанаа нийцтэй эелдэг Ребека цаанаа хажиг гажууд зантай, дотуур тамиртай байлаа. Үс зүс сайхантай, бие чийрэг, хөл зэгзгэр бүсгүй болсон боловч Буэндиагийн анх ирэхдээ авчирсан хэд хэд засагдаж, тохойловч нь ойчоод өгсөн өнөө танхуур сандалдаа суух дуртай хэвээрээ байлаа. Ребекаг өдий болсон хойноо хуруугаа хөхөх зангаа тавиагүй байгаа гэж хэн ч сэжиглэхгүй байлаа. Иймээс ая таарвал л угаалгын өрөөнд түгжиж аваад буру ухаран унтах сургууль хийдэг байлаа. Нэг оброотой үдэш сэн билээ. Үеийн бүсгүйчүүдтэйгээ хайтан цэцэгт гонхонд юм нэхэн ярилцан сууж байтал ярианы учиг гэнэт тасарч, цэцэрлэгийн нойтон жим, өтний овоолсон шороог харахдаа уйтгар гунигийн гашуун нулимс өөрийн эрхгүй мэлмэрэн иржээ. Уйлах болсноосоо хойш зүржийн шүүс, гишүүнэ хоёроор тухайн үед нь эмчилсэн муу зуршил нь юунд ч дийлдэхгүй дахичихлаа. Ребека ахин шороо идэх боллоо. Эхний удаа яахыг нь үзье гэж сониучирхан, эвгүй амтагдахад дур гутах биз гэж боджээ. Нээрээ ч үмхсэн шороогоо буцааж тургив. Гэвч уйтгарт автах тусмаа шороо амс амссаар амтанд нь анхных шигээ бүрмөсөн орчихлоо. Халаасаа шороогоор дүүргэж аваад, найз охиддоо хамгийн хэцүү шаглаасыг заан, хойноос нь сэтгэлээр унан шороо шохой идээд байхын хэрэггүй муусайн эрчүүдийн тухай ярих зуураа баярлах ч шиг, зовох ч шиг сэтгэл хачин болсоор нөгөөхөө чимх чимхээр нь сэм сэмхэн идэж бардаг байлаа. Чимх шороо идчихэд нь өөрийг нь далан таваар буулгасан цорын ганц хархүү өөрт нь ойртож, барин тавин нүдэнд үзэгдэх шиг, чийдмэл ганган савхин гутлаар ертөнцийн нөгө өхязгаарт гишгэн явахад шороогоор дамжин биеийн нь хүнд, цусны нь илч өөрт нь дамжих мэт, амыг аргаан, зүрхийг тайвшруулах шорвог шорооноос тэр нь амтагдах шиг болдог байлаа. Нэг орой Ампаро Москоте шинэ байшингаа үзүүлээч гэж гуйжээ. Амаранта Ребека хоёр вангийн түшмэлийн эрх охиныг гэнэр ирсэнд бишүүрхэн, хөндий бөгөөлд ёсорхог угтаж томруулсан байшингаа үзүүлэн төгөлдөр хуураа залган сонсгож, жимсний ундаа, жигнэмэг тэргүүтнээр дайлав. Ампаро биеэ сайхан авч явах, бусдын хайрыг татах, уян налархай аашлахын хувьд хоёр бүсгүйд үлгэр болохоор байсан тул хэдхэн минут өрөөгөөр ороод гарсан Урсула хүртэл биширч гүйцсэн байлаа. Хоёр цаг болоод ярих юмаа дуусаж байтал Ампаро Амарантагийн нүд хариулж байгаад өөр зүг анхаарангуут нь Ребекад захиаг атгуулж амжлаа. “Ноёхон Ребека Буэндиад” гэсэн захидлын хаягийг төгөлдөр хуурын заавар бичсэн шиг ногоон бэхээр нямбай нь аргагүй жирийлгэн бичсэнийг ажиглаж амжаад хурууныхаа өндгөөр нуглаад цээживчнийхээ өвөр рүү хийж Ампаро Москотег хэмжээ хязгааргүй баярласан, үхэн үхтлээ сэм сүлбэлдэхийг дуугүй илтгэсэн харцаар харжээ.

Ампаро Москоте, Ребека Буэндиа хоёр гэнэт үерхэх болсонд Аурелианогийн сэтгэлд найдвар төржээ. Жаалхан Ремедиосыг санан шаналсаар байлаа. Гэвч түүнтэй дайралдах аз таарахгүй л байв. Макондог байгуулалцсан Магнифико Висбаль, Геринельдо Маркес нарын хүү, өөрийн төө зайгүй найз Висбаль, Маркес нарын хамт хотоор явахдаа оёдлын газар орж шунаг нүдээр түүнийг хайвч зөвхөн эгч нар нь л байж байдаг байлаа. Ампаро Москоте тэднийхээр орж гарах болсон нь сайны ёр байлаа. “Ремедиос түүнтэй хамт ирэх ёстой. Заавал ирнэ” гэж Аурелиано дотоо бодож энэ үгийг өчнөөн удаа их л итгэлтэй давтан хэлж, нэг орой дархныхаа газар алтан загас хийж байтлаа гэнэт Ремедиос сэтгэлийн нь дуудлагад хариулах нь гэж гэнэт мэдэрчээ. Үнэхээр ч, төдөлгүйхэн хүүхдийн дуу гарахыг сонсоод толгой өндийлгөн үзвэл хаалган дээр ягаан органди даашинз, жижигхэн цагаан шаахай өмссөн охин зогсож байсанд дотор нь палхийгээд явчихав.

- Наанаа орж болохгүй ээ, Ремедиос! Наана чинь ажил хийж байгаа гэж Ампаро Москоте гонхноос хашгирав. Гэвч Аурелиано эгчийнхээ хэлж байгаа үгийн учрыг ухах зав охинд өгсөнгүй, амнаас нь оосорлосон алтан загасаа дээш өргөн,
- Ор ор гэжээ.

Ремедиос орж ирэн загас гээд нэг юм асуусан боловч Аурелианогийн дотор нь гэнэт бөглөрсөн давчдаад хариу хэлж чадсангүй. Энэхүү ягаан арьсыг дандаа илж, энэхүү номин нүдийг дандаа ширтэж, асуух болгондоо эцгээ дуудан байга аюм шиг хүндэтгэлтэйгээр “Ноён” гэж хэлэх энэ дууг дандаа сонсож байхсан гэж хүсэж байлаа. Өрөөний буланд ширээн дээр Мелькиадес гаргаж уншихын аргагүй тахир махир үсэг сараачиж байлаа. Аурелиано түүнд уур нь хүрч байлаа. Тэрбээр Ремедиос загасыг дурсгал болгон ав гэж дөнгөж хэлтэл охин айгаад урлангаас яаран гарав. Аурелиано түүнтэй сая болтол уулзахыг хүлээн дотроо тэвчиж явсан бол тэр оройноос тэсэж баж огт чадахгүй болоод ажлаа бүр орхилоо. Хамаг бодлоо төвлөрүүлэн Ремедиосыг сэтгэлээрээ дуудах гэж олонтаа цөхрөн оролдсон боловч цаадах нь тэр дуудлагад нь орохгүй байлаа. Аурелиано эгч нарынх нь оёдлын газар түүнийг хайн очиж гэрийнх нь цонхны буулгасан хөшигний цаанаас олж харах гэж оролдож, эцгийнх нь конторт дайралдах гэж хичээх боловч гагцхүү зүрхээрээ л түүнтэй уулзаж, сэтгэлдээ тодрох дүрийг нь ганцаардаж зовохдоо хань болгодог байлаа. Аурелиано Ребекатай хамт төгөлдөр хуурын вавьсыг чагнан хэдэн цагаар зочдын өрөөнд суух болов. Ребека Пьетро Креспигээр энэ аялгуунд бүжиг заалгаж байсан учир тэр хөгжмийг сонсож байхад Аурелиано ердөө л бүх юмыг харахад, тэр ч байтугай хөгжим сонсож байхад Ремедиос санагдах учир түүнийг чагнаж байлаа.

Энэ айлынханд хайр сэтгэлийн өвчин нүүрлэв. Аурелиано эх адаггүй шүлгээр хайр сэтгэлээ уудалж, Мелькиадесийн бэлэглэсэн хатуу цаасан дээр,

унтлагын өрөөний ханан дээр, гарынхаа арьсан дээр шүлэг бичиж, Ремедиосыг жин үдийн дуниартсан агаарт, Ремедиосыг сарнай цэцгийн зөөлөн амьсгалд, Ремедиосыг бүлээхэн талхны өглөөний үнэрт гээд хаа л бол хаа байгаагаар шүлэглэж байлаа. Ребека гэгээвчний дэргэд юм хатгамлан өдөрбүрийн дөрвөн цагт хайрт хүнээсээ захиа хүлээн суудаг байлаа. шуудангийн луус макондод сард хоёр ирдэгийг сайн мэдэх боловч андуураад хэдийд ч хүрээд ирж болзошгүй гэж цаг үргэлж харуулддаг байлаа. Гэтэл бүр хяссан юм шиг нэг удаа луус иэрэх ёстой өдрөө ирсэнгүйд Ребека энэлэн зовсондоо элий балай болон, шөнө дунд босож цэцэрлэгт ороод багтран орилж, буйлаа эмгэн хумсны дунгийн хэлтэрхийд урсаар, амиа хорлох гэсэн хүний шийдчихсэн байдлар шороог атга атгаар үмхэлж гарчээ. Тэгээд өглөө болтол бөөлжив. Тэрбээр цөхрөн тэчъяадаж ухаан алдаад дэмийрэн ярихдаа сэтгэлийнхээ нууцыг илчилжээ. Ондууцан уурласан Урсула авдрын цоожийг эвдэж, ёроолд нь ягаан туузаар ногтлон боосон, суурчиг ханхалсан арван зургаан захидал, хуучин номын хуудасны завсар хавчуулж хадгалсан навч, цэцгийн дэлбээ, дөнгөж хүрэнгүүт үйрч унах хатаамал эрвээхийг олжээ. Ребека сэтгэлээр үхэж байгааг ганц Аурелиано л ойлгож байлаа. Урсула Ребекаг сэргээх арга чарга хийж байсан тэр орой Аурелиано Магнифико Висбаль, Геринельдо Маркес хоёртой Катариногийн үрээлэнд очив. Түүнд гонхон нэмж бариад банзаар хаан, өрөө гаргасанд гандмал цэцгийн үнэр ханхлах ганц бие эмэгтэйүүд суудаг болжээ. Макондод хэдэн жил үзэгдээгүй Хүмүүн Франсиско ирчихээд, дууг нь найраг баян хуурч, бөмбөрчдийн чуулга хөгжимдөж байлаа. гурван найз нишингийн дарс захив. Аурелианотой чацуу боловч ертөнцийн явдалд түүнээс илүү боловсорсон Магнифико, Геринельдо хоёр өвөр дээрээ хүүхэн суулгаад нанчдаа яаралгүйхэн хүртэж байлаа. Өөрийг нь таалах гэсэн алтан шүдтэй, харимал насны нэг хүүхнийг Аурелиано түлхэж орхв. Уух тусам Ремедиос улам санагдаж байсан боловч сэтгэлийн шаналгаа намдах шиг болж байв. Тэгснээ Аурелиано нэг мэдэхэд хөвж явав. Удалгүй хоёр найз нь нөгөө хүүхнүүд нь огт хэлбэр дүрсгүй, өд шиг жингүй хөнгөн юмнууд болчихсон бүрэлзэх униар дунд бас хөвж, үг яривч дуулдахгүй, дохин зангавч ойлгогдохгүй байлаа. Катариног мөрөн дээр нь гара атвиад “Удахгүй арван нэгэн цаг боллоо” гэж хэлэхэд Аурелиано эргэн харвал түүний манарсан малийсан царай, чихнийх нь арын хиймэл цэцэг үзэгдсэнээ алга болсон нь мартаж тахлын үеийнх иг ухааны чагтага тасарсан хэрэг байжээ. Гагцхүү маргааш өглөө нь огт танихгүй айлд ухаан орвол өмнө нь дан цамцтай, хөл нүцгэн, үс нь сэгсийсэн Пилар Тернера зогсож, дэнгээр өөрийг нь гэрэлтүүлэн итгэж ядсан байдалтай.

- Аурелиано юу? Гэж асууж байжээ.

Аурелиано баттай гишгэж аваад толгойгоо өндийлгөв. Тэрбээр энд яаж ирснээ мэдэхгүй байсан боловч яах гэж ирснээ сайн санаж байлаа. Учир нь бага байхаасаа энэ бодлоо сэтгэлийнхээ угт хадгалж ирсэн билээ.

- Би тантай унтах гэж ирлээ хэмээн тэр хэлэв.

Аурелианогийн хувцас туж шороо, бөөлжис бослон байлаа. Тэр үед хоёр бага хүүтэйгээ суудаг байсан Пилар Тернера түүнээс юу ч асуусангүй, ор руугаа аваачин, нойтон алчуураар нүүрийг нь арчиж, хувцсыг нь тайлаад, өөрөө ч нүцгэлээд, хүүхдүүдээ хөшгөө буулгав. Тэрбээр төрсөн тосгондоо үлдсэн эр, эргэж ирнэ гэж амлаад явсан эрчүүл, хөзрийн мэргэ төөрснөөс болж будлиад гэрийг нь олоогүй эрчүүлийг хүлээснээр цөхөрчээ. Тэднийг хүлээсээр байтал түүни арьс нь үрчийж, мээм нь шалчийн, зүрхийн нь цог бөхжээ. Пилар Тернера харанхуйд Аурелианог олж, гараа гэдсэн дээр нь тавьж, эх нь шиг хүзүүг нь энхрийлэн үнэсэж, “Миний хөөрхөн балчирха” гэж хэлсэнд Аурелиано дагжтал чичирч эхэлжээ. Уйтгар гунигийн хадан эргээс тайван, итгэлтэй түдэж зоволгүй холдон одож, бүдүүлэг адгуусны үнэр, саяхан индүүдсэн угаашны үнэр ханхлах дэвсгэр болж гүйцсэн Ремедиостой учирлаа. Замд гараад тэр уйлав. Эхлээд тэр өөрийн мэдэлгүй эхэр татан мэгшиж байв. Дараа нь нулимс нь барья гэхэд болохгүй булгийн ус шиг сад тавьж, дотрыг нь горойлгон хөндүүрлээд байсан юм хага үсрэх шиг болжээ. Эмэгтэй түүний үсээр нь оролдон наадаж, амарзаяа үзүүлэхгүй бөөн хар юмнаас бие нь ангижрахыг хүлээж байлаа. “Тэр чинь тэгэд хэн юм?” гэж Пилар Тернера асуусанд Аурелиано хэн болохыг хэллээ. Тернера тасхийтэл хөрөхсөн боловч урьдын цагт тагтаа дэрхийн үргэдэг байсан тэринээд одоо хүүхдүүдээ ч сэрээсэнгүй. “Эхлээд эхнэрээ бойжуулах хэрэг гарах нь дээ” гэж тоглоом хийсэн боловч тоглосон аясны нь цааан ихэд өрөвдөж ойлгосон байдал байгааг Аурелиано мэдэв. Аурелиано эр хүний хийдгийг хийж чадах нь гэдэг итгэлтэй болоод зогссонгүй олон сар зүрхийг нь шаналгасан гашуун дарамтаасаа салаад тасалгаанаас гарахад гэнэт Пилар Тернера:

- Би тэр охинтой чинь яриад, царан дээр тавиад чамд авчраад өгье гэж н гэнэт амлажээ.

Тэрбээр хэлсэндээ хүрлээ. Гэвч тэр нь даан ч цагаа олсонгүй. Буэндиагийн гэрийнхний урьдын амгалан тайван байсан нь алдагджээ. Ребекагийн гал халуун дурлал мэдэгдлээ. Ребека дэмийрэхдээ чанга чанга хашгирах учир түүнийг нуух аргагүй байлаа. Амаранта гэнэт халуун хумхаа тусав. Амаранта ч дуралын өргөсөнд, тэгэхдээ бүтэшгүй дурлалын өргөсөнд хатгуулжээ. Угаалгын өрөөнд орж дотроос нь түгжиж байгаад, найдвартай хүслээ илтгэсэн гал халуун хайрын захидал бичиж, тэр захиагаа явуулалгүй авдрынхаа ёроолд нуун сэтгэл ханадаг байжээ. Урсула хоёр өвчтөнийг асран самгардаж байлаа. Амарантагийн сэтгэлээр унасны учрыг хэлүүлэх гэж шалгаах, цохиж асуух зэргээр удтал үзсэн боловч мэдэж чадсангүй. Тэгснээ дахин санаа авч, авдрынх нь цоожийг эвдэж, “Пьетро Креспид” гэж хаягласан боловч явуулаагүй, ягаан тузаар боож, шинэхэн цагаан сараана хавчуулсан, дээр нь дусалсан нулимс эвэрч амжаагүй

захидлыг олжээ. Урсула галуузахахд ганц хуруу дутуу олж, хөгжим худалдаж авах санаа төрсөн өдөр цагийг харааж, хатгамлын хичээл хийхийг хориглож, хүн үхээгүй байтал нэг ёсны гашуудал зарлаж, охидоо бүтэхгүй юманд найдахаа болихоос нааш гашуудлыг тайлахгүй гэжээ. Пьетро Креспитийг анхандаа тоохгүй байснаа, хөгжмийн машиныг баруун солгойгүй эдэлдэгт нь одоо бахархах болсон Хосе Аркадио буэндиа оролцоод ч нэмэр болсонгүй. Иймээс Ремедиос өөртэй нь суухыг зөвшөөрч байна гэж Пилар Тернераг ирж хэлэхэд, Аурелиано эцэг эхдээ зовлон дээр нь зовон нэмэх боллоо гэдгийг ойлгосон боловч нэгэнт л тийм үйлтэйгээс цааш үйлээ дагая гэж шийджээ. Буэндиа, Урсула хоёр хүүгийнхээ зориуд ярилцъя гэхэд өрөөнд орж, түүний хэлэхийг тэвчээртэй сонсжээ. Гэвч бэр болох хүнийхээ нэрийг дуулангуут Хосе Аркадио Буэндиа нүүрээ мэнчийлгэн дургүйцэж, “Нүдээ алдав уу, чи. Хөөрхөн, аятайхан бүсгүй мундсан биш, очиж очиж дайсныхаа охинтой гэрлэх гэдэг чинь юу билээ” гэж зандрав. Урсула харин ч хүнээ олж гэж сайшаагаад, эгч дүү долоон Москоте царайлаг бол царайлаг, ажилсаг бол ажилсаг, даруу бол даруу, хүмүүжилтэй бол хүмүүжилтэй сайн охид гэж сэтгэлд нь таардгийг хэлээд, хүүгээ ухаалаг сонгож гэж магтжээ. Эхнэрийнхээ Ремедиосыг тийнхүү учир дүрсгүй магтсанд яах ч аргагүй болсон Буэндиа Ребека, Пьетро Креспи хоёрыг бие биедээ сайн учир суулгана гэдэг болзол сөргүүлэн тавьжээ. Урсула зав гаргаж, Амарантаг мужийн гол хотод аваачъя, аялж жуулчлаад, огт өөр улстай уулзаж учраад ирэхтэйгээ сэтгэл нь тайвшрах биз гэж боджээ. Ребека тэдний шийдийг сонсоод дорхноо эрүүл болж, нөхөр болох хүндээ бөөн баяртай захиа бичиж, эцэг эхээрээ батлуулаад, зууч мууч гэлгүйгээр өөрөө шууданд захиагаа хүргэж өгчээ. Амаранта аав ээжийнхээ тогтсоныг гаднаа дагах дүр үзүүлж, халуурч чичрэхээ бага багаар больсон боловч дотроо бол”Ребекаг Пьетро Креспитай үхсэн ч суулгахгүй” гэж андгай тавьжээ. Дараачийн бямба гаригт нь Хосе Аркадио Буэндиа найрын өдөр шинээр өмссөн хар цэмбэн костюм, хатуу зах, илгэн гутал өмсөөд, Ремедиосыг гуйхаар очлоо. Вангийн түшмэл, түүний гэргий хоёр Буэндиагийн гэнэт айлчлан ирсэнд баярласан боловч яах гэж ирсний нь мэдэхгүй байсан учир сэтгэл түгшиж байлаа. Хосе Аркадио Буэндиагийн ирсэн учрыг мэдэхдээ бэр болох хүнийхээ нэрийг андуурч гэж боджээ. Андуурсан гэдгийг нь Буэндиад үнэмшүүлэхийн тулд эх нь Ремедиосыг орноос нь босгож, элчпын өрөөнд өргөн орж ирэхэд охин сайн сэрээгүй нойрмоглох, үнэхээр нөхөрт гарья гэж бодож байна уу гэж ээжийнхээ асуухад “”Хүн унтуулахгүй яасан юм” гэж уйлагнажээ. Хосе Аркадио Буэндиа эр эм хоёрын эргэлзсэн учрыг ойлгож, Аурелианоогоос асуухаар явжээ. Түүнийг буцаж ирэхэд эр эм хоёр тийм ёслолд өмсдөг хувцсаа өмсөж амжаад, зочдынхоо өрөөний тавилгыг ялихгүй засан, вааранд шинэ цэцэг нэмж суулгаад, том охидынхоо хамт хүлээж байлаа. Эвгүй юманд орсныг хэлэх үү, хатуу зах хүзүүг нь үрэн зовоохыг хэлэх үү, Буэндиа бүр гутраад бэр болох хүнээ Ремедиос яахын араггүй мөнийг хэлжээ. “энэ чинь эрүүл хүний ухаанд багтамгүй юм байна. Ремедиосоос гадна



манахй зургаан охинтой, хадамд очих насанд цөм хүрсэн, тэдний хэн ч гэсэн танай хүү шиг томоотой, ажилсаг залугийн эхнэр дуртай болно, гэтэл Аурелиано чухамхүү орондоо норгоод байдгийг нь авах гээд байдаг” хүн сэтгэлээр унасан дон Аполинар Москотег хэлэхэд түүний гэргий болох гунигтайнүд, тайвуу хөдөлгөөнтэй ануухнаараа авгай нөхрөө бүдүүн үг хэлүлээ гэж зэмлэжээ. Жмисний шүүс ууцгасны дараа эр эм хоёр Аурелианогийн эргэлтгүй шийдсэнд уяран ерөөлөө хайрлажээ. Москоте авагй Урсулатай хоёулхнаа ярилцах юм байна хэмээн гуйлаа. Урсула эрчүүлийн явдалд оролцохгүй гэж нэлээн цааргалсан боловч үнэндээ гэхэд сониуч зан нь хөдөлж, маргааш нь сэтгэл догдолж, жаахан зүрх алдсаар Москотегийнд явж очжээ. Тэрбээр хагас цаг болоод Ремедиосыг нас нь болоогүй юм байна гэсмээр буцаж иржээ. Аурелиано үүнийг сүйдтэй юм гэж бодсонгүй. Тэрбээр нэгэнт хүлээхээрээ нэг болсон болохоор одоо сүйт бүсгүйгээ хүүхэд олж чадах насанд хүртэл нь хүлээхэд бэлэн байжээ.

Амьдрал хэв зандаа эргэн орж батйал Мелькиадес үхэв. Ийм юм болно гэдэг нь мэдээж басан боловч болсон байдал нь хачин байлаа. Буцаж ирээд хэдэн сар болж байхад нь Мелькиадесийн зөнөж эхэлж байгаа нь мэдэгдэж, тэгснээ бүр удаж төдсөнгүй тасалгаан дотуур хөлөө чирэн, урьдын цагт сайхан байснаа чанга чанга үглэсээр сүүдэр шиг тэгнэж явдаг тийм нэг хэнд ч хэрэггүй өвгөн болжээ. Тийм өвгөнийг тоож харах ч, дурсаж санах ч хүн байдаггүй, нэг өглөө орондоо үхчихсэн байхад нь олдог билээ. Эхлээд Хосе Аркадио Буэндиа батиар зураг Нострадамусын зөгнөж хэлсэн үгийг бахдаж, Мелькиадест ажилд нь тусалж байлаа. Гэвч сүүлдээ түүнтэй хэл амаа ололцоход улам хэцүү болж байсан учир ганцааранг олонтаа орхих болов. Мелькиадес охорч дүлийрээд аль дивангарын түүхэн үед таньдаг байсан хүнтэйгээ одоо юм ярьж байгаа хүнээ эндүүрэн будилж, юм асуухад олон хэлний үг хольж хутган ойлгохын аргагүй юм хэлдэг байлаа. Байшин дотруур явахдаа ямагт хий тэмтчин явах боловч ойроос юмыг тааж мэддэг зөн баримжаа сайтай юм уу гэмээр эд хогшлын дундуур гайхалтай сүлжээд явчихдаг байлаа. Нэг удаа хиймэл шүдээ орныхоо дэргэд шөнө шилэн аягатай усанд хийж тавиад мартснаас хойш дахиж хийсэнгүй. Урсула байшингаа томсгох болохдоо Мелькиадест Аурелианогийн урлангийн дэргэд, гэрийн үймээн шуугианаас зайдуу гэрэлтэй том цонхтой, номын тавиуртай тусгай өрбө гаргаж өгсөн бөгбд өвгөний тоос шороо болсон, өт хорхойд идүүлсэн ном, үл мэдэх үсэг ярайтал бичсэн хугарамхай цаас, шилэн аягатай хиымэл шүдийг бүр өөрийн гараар тавиур дээр тавихад шилэн аяга дотор нь жижигхэн шар цэцэгтэй усны ургамл үлдээн байжээ. Мелькиадес хоолны өрөөнд ч үзэгдэхээ больсныг бодоход шинэ өрөө нь сэтгэлд нь таарсан бололтой. Түүнтэй Ауреианог урланд л дайралдаж болно. Тэр тэнд диван галавт авчирсан далан давхар шиг задрах цаасан дээр үл мэдэх үсгээр юм эрээчин өчнөөн төчнөөн цаг суучихдаг байлаа. Виситасьоныг өдөрт хоёр удаа хоол авчирахад урланд л идчихнэ. Сүүлдээ хоолонд муудаж, зөвхөн ногоо л идэн,

үүнээс болоод удалгүй махнаас гарсан хүний шаналангуй царатай болжээ. Арьс нь огт тайлдаггүй элин галавын хантаазанд нь ургасан шиг зөөлөн хөгцөөр бүрхэгдэж, унтаж байгаа амьтны амнаас гардаг шиг үмхий үнэр амнаас нь ханхална. Аурелиано шүлэг бичих гэж улайраад цыганы байгаа эсэхийг хайхрахаа больсон боловч нэг удаа Мелькиадесийн ярьж байгаа юмны заримыг ойлгомоор юм шиг байсанд чих тавин чагнавал ээдэрсэн битүүлэг үгсээс нь “тэндцэтгэл өдөр”, “тэнцэтгэл өдөр”, “тэнцэтгэл өдөр” гэж алх тогших шиг байн байн давтах, бас Александр фон Гумбольдт гэж хэлэхийг л ганц олж сонсжээ. Аурелианогийн дархны нь ажлас элбэлцэх болсон Аркадио өвгөнтэй ойртжээ. Мелкиадес Аркадиогийн яриа өдөхөд их л дуртай тосон авч, заримдаа испаниар бүтэн өгүүлбэр дуугарах боловч тэр нь тэр орчим байгаа юмтайнь хаа хамаагүй юм байдаг байлаа. Гэвч нэг орой цыган гэнэт сэтгэл үймэрчээ. Олоон жилийн хойно Аркадио буудуулах гэж хайсны дэргэд зогсохдоо, Мелькиадес дагжтал чичирсээр ойлгогдохгүй бичгээсээ хэдхэн хуудсыг өөрт нь уншиж өгснийг санаж билээ. Түүний аялгуулан уншсан тэр зүйл ойлгогдсонгүй боловч ая оруулсан папын лүндэн шиг санагджээ. Мелькиадес удтал инээмсэглэж үзээгүйгээ сая инээмсэглэж, “Намайг үхэхээр өрөөнд минь гурван өдөр мөнгөн ус шатаа” гэж испаниар хэлжээ. Аркадио нь Хосе аркадио Буэндиа өөр нэмж захих юм байгаа эсэхийг хэлүүлэх гэсэн боловч “Би мөнхөрсөн” гэсэн товчхорн хариу л сонсжээ. Мелькиадесийн ьсгал нь үмхий болмогц аркадио пүрэв гаригийн өглө өгол руу аваачиж усанд оруулах болов. Мелькиадес хувцсаа тачин, багачуултай цуг усанд орж, зүг чиг мэдээд байдаг зөнгөөрөө гүн аюултай газрыг тойроод гарчихаж чаддаг балаа. “Бид цөмөөрөө уснаас гарсан” гэж тэр нэг хэлжээ.

Цаг өнгөрсөөр, өвгөн ч гэрт байгаа байхгүй нь бараг мэдэгдэхгүй, гагцхүү тэр нэгэн шөнө хөгжим засах гэж өрөвдмөөр хичээнгүй оролдож нэ үзэгдсэн, ер нь бол хатаасан халуу, далдуу модны саван сугавчилчихаад Аркадио дагаж ус руу яваа нь пүрэвт нэг харагддаг байлаа. Нэг пүрэвт Аркадиогийн явж уснд орё гэж дуудахын өмнө өвгөний “Би Сингапурын намагт халуун хумхаагаар үхсэн” гэж үглэж байхыг Аурелиано сонсжээ. Энэ удаа Мелькиадес усанд орохдоо буруу газар гишгэжээ. Маргааш нь түүний хүүрийг хэдэн километр доогуур тунглагхан тохойд хайрдсан, гэдсэнд нь тахианы жаахан баас наалдчихсан байхад олжээ. Төрсөн эцгийнхээ хойноос гашуудсанаас илүү уй гашуу болсон Урсулагийн дургүйцэн татгалзсаар байтал Хосе Аркадио Буэндиа “Мелькиадес үхээгүй, үхээд босохын томъёог өөрөө нээсэн юм” гээд хүүрийг оршуулахыг хориглож, хэрэглэхээ больсон хөөргөө үлээж дээр нь мөнгөн устай хоовон тавиад, хөх хөх цэврүү үсэрч байгаа хүүрийн дэргэд тавин буцалгажээ. Дон Аполинар Москоте үйж үхсэн хүнийг оршуулахгүй бол олон нийтийн эрүүл мэндэд хортой гэж Хосе Аркадио Буэндиа хулгасхийн сануулж үзжээ. Хосе Аркадио Буэндиа “Тэгж ярихгүй, цаадах чинь амьд байгаа” гээд огт халгаасангүй, яг далан хоёр цаг мөнгөн усны уураар утсаар байсан боловч хүүр

цэлдэн хөхө болон хөөж, шийхнэн хагарч, гэрээр дүүрэн үмхий самхай ханхлуулах болов. Тэгэхэд л Хосе Аркадио Буэндиа түүнийг нутаглуулахыг зөвшөөрч, тэгэхдээ ор нэр болгох бус Макондогийн аугаа их ачтаны ёсоорбүхий л хүндэтгэл үзүүлэн оршуулахыг зөвшөөрчээ. Энэ бол тус хотод хамгийн олон хүн оролцсон анхны оршуулах ёслол байлаа. Зуун жилийн дараа Мама-Грандегийн1 дурсгалыг хүндэтгэн хийсэн оршуулгын багт ёслол л түүнээс арайхийж давжээ. Оршуулгын газар болгоход зориулан гаргасан цулгуйн дунд ухсан нүхэнд цыганыг хийж булаад, чулуун хавтан дээр түүнээс мэдэгдэж байгаа “Мелькиадес” гэсэн ганц нэрийг нь л бичжээ. Үүний дараа заншил ёсоор есөн шөнө унтсангүй. Айлынхаа нь кофе ууж, хошин шог ярьж, хөзөр тоглохоор хашаанд цугланүймэлдэж байгааг Амаранта самбаачилж, Пьетро Креспид сэтгэлтэй болсноо хэлжээ. Үүнээс хэдэн хоногийн өмнө Пьетро Креспи, Ребекатай ханилан суух болсноо зарлаж, урьд арабуудын элдэв юмс тогиор арилжиж байсан, Туркийн гудамж” гэж олны нэрлэсэн тэр газарт хөгжмийн зэмсэг, оньст тоглоомын мухлаг гаргах гэж байлаа. Эмэгтэйчүүдийг өөрийн эрхгүй санаа алдуулдаг чийдсэн юм шиг гялгар үстэй итали эр Амрантад нэг их тоогоод байхааргүй танхил охин шиг хандаж,  
- Надад нэг дүү бий. Удахгүй надад туслахаар ирнэ гэж хэлжээ.

Амаранта биеэ басамжлуулсанд тооцож, эгчийнхээ хурим хийхэд яалаа ч гэсэн, өөрөө босгоных нь дэргэд хүүрээ тавих боллоо ч гэсэн саад хийхээр шийдсэнээ их л хорсолтой хэлжээ. Ингэж занасанд гайхсан итали эр Ребекад тэсгэлгүй хэлж орхив. Урсула завгайү байсан тул Амарантагийн явахыг хойшлуулсаар байснаа гэнэт долоо хоног хүрэхгүй бэлтгээд явах болов. Амранта явахгүй гэж зүтгэсэнгүй боловч эгчийнхээ чихэнд,  
- Горьдохын гарз шүү. Намайг газрын мухарт ч аваачлаа гэсэн чиний хуримыг тарааж чадна, чамайг алахаас ч буцах юм алга гэж шивнэжээ.

Урсула байхгүй, Мелькиадес тасалгаагаар сэм явсаар байвч үзэгдэж харагдахгүй учир гэр том бөгөөд ханхай болсон юм шиг санагдаж байлаа. Ребека аж ахйгаа харж, индиан авгай талх боов жигнэнэ. Орой нь Пьетро Креспийг лаваанд цэцгийн шинэхэн үнэр анхилуулж, гар цайгах ямар нэгэн оньст тоглоом барьсаар хүрч ирэхэд сүйт бүсгүй нь элдэв хэл ам гарах болуужин гэж хамаг хаалга, цонхоо цэлийтэл нээн зочдын өрөөндөө тосож авна. Тэгж болгоомжлох нь илүүц байсан бөгөөд итали залуу жил гарунй дараа эхнэрээ болох бүсгүйн шгартнь ч хүрдэггүй, үнэхээр журамтай байлаа. Яваанда гэрт гайхалтай тоглоом дүүрчээ. Мелькиадесээс хойш уйд автсан байсан Хосе Аркадио Буэндиа бүжигчин хүүхэн, уран нугарагч сармагчин, алиа бөмбөрчин, давхидаг морь зэрэг Пьетро Креспийн авчирсан олон оньст тоглоомд сэргэн, эрдэнийн рилу бүтээхэр оролдож байсан үеийнхээ байдалд эргэж оржээ. Тэрбээр тоглоомон амтдынхаа гэдэс дотрыг уудаж, онос сэлтийг нь задлан жаргалаа

эдэлж, эдгэрийг бүр обловсронгуй болгон, дүүжингийн зарчмаар мөнхийн хөдөлгөөнтэй болгож байлаа. Аурелианогийн хувьд гэвэл тэрбээр урлангаа орхичихоод бяцхан Ремедиост бичиг зааж эхлэв. Ирэхэд нь өөрийг нь тоглуулахгүй угааж гоёод, зочдын өрөөнд суулгачихдаг учир Ремедиос хүний тэр ахыг гэхээсээ хүүхэлдэйгээ гэдэг байлаа. Гэвч Аурелианогийн тэвчээртэй, зүтгэлтэйн хэрэггарч, охин түүнд дасаад үсэг цээжлэн, дэвтэртээ өнгийн будгаар байшин, хашаатай үнээ, шар сацраг сацруулан толгойн цаагуур далдарч байгаа нар удтал зурж суудаг болжээ.

Ганц Ребека л дүүгийнхээ занасныг мартаж чадахгүй сэтгэлийн зовлонд унажээ. Тэрбээр Амарантагийн бардам зантайг мэддэг тул муухайгаар өшөө авч магадгүй гэж айж байлаа. угаалгын өрөөнд олон цагаар сууж, хуруугаа хөхөн, дахиж шороо идэх хорхойгоо арайхийн барьдаг байлаа. Сэтгэлийнхээ зовлонгоос салахыг горилон Пилар Тернераг дуудаж хөзрөөр хувь төөргөө мэргэлүүлжээ. Пилар Тернера бахь байдгаара учир нь олдхоггүй баахан юм ярьж бйаснаа,

- Эцэг эхээ оруулшахаас нааш чи жаргал үзэхгүй юм байна гэж төлөг буулгажээ.

Ребека давхийлээ. Жижигхэн хайрцаг, модон сандал, хүүдий барьсан жаахан охин Буэндиагийн анх ирсэн нь эрт зүүдэлсэн зүүдшиг нүдэнд нь бүүр түүрхэн үзэгдэв. Тэр хүүийд юу байсныг хэзээ ч мэдгүй билээ. Ёрог косчтоомтой, цамцныхаа заханд алтан товчтой халзан ноёныг санасан боловч бундангийн ноёнтон ямар ч төс байсангүй. Цэл залуу, дулаахан анхилуун хатангир гартай бундангийн хатантай огт төс байсангүй. Тэр эмэгтэй үдшийн хотын ногоон гудамжаар салхинд авч явах гэж үсэнд нь цэцэг хатгаж байсансан.

- Би юу ч ойлгохгүй байна гэж Ребекаг хэлэхэд,

- Би ч мэдэхгүй юм, гэвч мэргэнд тэгж л бууж бйна гэж Пилар Тернера зовьгуйрав.

Ребека төлөг тийм бүрхэг буусанд сэтгэү ихэд түгшин Хосе Аркадио Буэндиад хэлбэл “Хөзрийн мэргэд итгээд байхдаа яадаг юм!” гэж охино одагнасан боловч өөрөө авдар шүүгээгээ уудалж, тавилга ороо хөдөлгөж, шалныхаа банзыг ховхлон, авдаршүүгээгээ уудаж гарчээ. Байшинг тосгосноос хойш хүүдийтэй яс нүдэнд нь өртөөгүй шиг санагдаж байлаа. Хосе Аркадио Буэндиа хэнд хэлэлгүйгээр барилгачдыг дуудаж асуувал нэг нь ажилд саад болоод байхаар нь нэг унтлагын өрөөний хананд хийгээд наанаас нь шавардчихсан гэж хэлжээ. Тэд хана, хананд чихээ наан хэдэн өдөр чагнаж, хол оо “хар-хар” гэх нь сая дуулдахад ханыг цоолбол хүүдийтэй яс бүрэн бүтэн байж байлаа. Тэр өдрөө түнийг Мелькиадресийн ойролцоо пайлуургүй оршуулаад Хосе Аркадио Буэндиа хэдийгээр түр зуурхан боловч Прудесио

Агилярын тухай дуртгалаас дутуугүйгээр зовоосон сэтгэлийн бөөдийгөөс салаад гэртээ ирж гал тогоогоор өнгөрөхдөө Ребекагийн духыг үнэрлээд

- Тийм муу юм бодохоо боль. чи жаргана гэж хэлжээ.

Аркадиоог төрсний дараа Пилар Тернера Урсулад хоригдон тэднийхээр шагайхаа больсон байснаа Ребекатай найзалснаас хойш дураараа орж гарах боллоо. Пилар Тернера яргуй хөөсөн ямаа шиг дуртай үедээ тэднийхээр орон, гэрийн хамагхүнд хүчир ажлыг хийн хуяншар усаа тэнийлгэх болжээ. Заримдаа урланд орж,гэрэл зургийн илтэс боловсруулахад нь Аркадиод их л хичээнгүй, элгэмсүү туслахад нь залуу сүүлдээ зовох болжээ. Энэ эмэгтэйн дэргэд толгой нь эргэж гүйцдэг байлаа. Түүний халуун бие, хулмасны үнэр, харанхуй тасалгаандогт нийцэхгүй чанга инээдэнд Аркадиоогийн анхаарал нь сарнин юмаа онож хийж чадахгүй болдог байлаа.

Нэг удаа урланд Пилар Тернера Аурелианог алтан загас хийж байгаатай таарч, ширээ тохойлдоод, түүний угайгү нарийн урлаж байгааг нь бхарахан ажиглаж байлаа. Аурелиано Аркадиоог нөгөө өрөөндбайгааг магдалаад, сая тогойгоо өргөн ПиларТернерагийн харцтай харц тулгарч,түний бодлыг үд дундыннар туссан шиг товт тодхон уншжээ.

- За юу болов? Гэж Аурелиано асуусанд Пилар Тернера уруулаа хаазн, гунигтайяа инээмсэглэж

- Чи дайтаж явах заяатай хүн юм аа. Буу сум чинь бартьсан зара ал тусах юм байна гэв.

Аурелиано тааварлаж байснаа үнэн блсонд сэтгэл амрандахин ширэ эрүүгэ этонгойгоод, юу ч облоогүй юм шигтайван бөгөдө чангаар,

- Яах ч аргагүй минийх ээ. Би өөрөөрөө овоглоно гэж хэлжээ.

Хосе Аркадио Буэндиа цагийн оньсны нэг пүршийн нэг бүжигчид суулгаж, хүүхэлдэйг гурванөдөр өрөийн аяар зогсолтгүй бүжиглүүлж, санасандаа хүрэв. Үүнийг бодож олсондоо Хосе Аркадио Буэндиа урьд сэдэж байсан олон дэмий юмныхаа алинась ч илүү сэтгэл хөдөлж, нойр хоолноос бүр гарав.: Харж хандаж, хаая хүүе гэж байдаг Урсула нь байхгүйбайсан тул элдэв юм бодсоор насаараа элий балай өвчтэй болж, энэ өвчнөөс ангижрах тавилангүй байжээ. Шөнийн дуусан өрөөн дотуураа нааш цааш холхиж, дүүжингийн зарчмыг тэрэг, анжис болонхүнд тустай хөдөлдөг бүхэнд хэрэглэх аргыг бодон амандаа дүнгэр дүнгэр ярьдаг байлаа. Нойргүй облсондоо бүр ядарч, нэг өглөө унтлагын өрөөнд нь цас шиг цагаан толгойтой, тэнтгэр тунгар гишгэсэн өвгөнийг орж ирэхэд таньсангүй болно. Тэгж тэгж түүнийг сая таниад, үхсэн хүн ч өвгөрдөг байна гэдгийг олж мэдэхдээ ихэд гутарчээ. “Пруденсио, чи яаж энд ирэв?” гэж тэрбээр дуу алдлаа. Үхэгсдийн орондон удахда амьд хүнийг туйлгүй мөрөөсөж хэн нэгэнтэй ойр байхын хүслэн болж, үхсэн хойноо бас дахин үхэх нь ойртсонд

ухаагүй айсан Прудесио Агиляр заналт өстөндөө хайртай болжээ. Пурденсио Агиляр Буэндиаг эрээд уджээ. Риоачигоос очсон үхдэл, Валье де-Упараас болон хөндийгөөс очсон бүрлээч нараас түүнийг срураглахад хэн ч мэдэхгүй байлаа. Учир юу гэвэл Мелькиадесийг үхэгсдийн оронд очиж, үхлийн цоохор газрын зураг дээр хар цэгээр Макондог тэмдэглэтэл үхэгсэдтийм хотбайдгийг мэдэхгүй байжээ. Хосе Аркадио Буэндиа, түүнтэй үүр цайтайл ярилцав. Нойргүй хонсондоо сульдаж хоцорсон Хосе Аркадио Буэндиа хэдэн цагийн дараа Аурелианогийн урланд орж, “Өнөөдөр хэддэх өдөрвэ?” гэж асуувал Аурелиано “Мягмар гариг” гэж хариулжээ. “Би ч бас тэгж бодсон юм. Гэхдээ өчигдрийн даваа гариг одоо гүргэлжисээр байна. Энэ тэнгэрийг хар, энэ ханыг хар, энэ хайтан цэцгийг хар. Өнөөдөр чиньдахиад л даваа гариг байна” гэж аавынхаа хэлэхэд хачин аашлахад нь нэгэнт дассан Аурелиан тэр үгийг хайхарсангүй. Маргааш нь лхагвад Буэндиа дахин урланд орж ирээд: “Ямар гайтай юм бэ! Энэ агаарыг хар, нарны хангинахыг сонс, яг л өчигдөр, уржигдрынх шиг. Өнөөдөр дахиад л даваа гариг байна” гэжээ. Үдэш нь Пьетро Креспи гонхонд дайралдвал Хосе Аркадио Буэндиа асгартал уйлж, Пруденсио, Агиляр, Мелькиадес, Ребекагийн эцэг эх, өөрийн аав ээжийн хойноос, ер нь тэр үед үхэж үрэгдсэн боловч сэтгэлд нь байгаа бүхний хойноос гашуудан, аргагүй өвгөрсөн шинжтэй, муухай нь аргагүй енгэнүүлж байлаа. Пьетро Креспи утсан дээгүүр хоёр хөлөөрөө явдаг байсан хүнийг агаарт хөрөгөх дүүжинт машиных нь төсөл юу болж байгааг асуусанд, тийм дүүжин ямар чюмыг агаартгаргаж чадах боловч өрөийгөө гаргаж чадахгүй учирхийх боломжгүй гэж хариулжээ. Пүрэвт, Хосе Аркадио Буэндиа туйлын цөхөрсөн байдалтайгаар урланд дахин орж ирээд, “Цагийн машин эвдэрчихсэн байдаг. Урсула, Амаранта хоёр холын хол явчихсан байдаг” гэж бараг эхэр татан хэлж, Аурелианод хүүхэд шиг зэд загнуулаад дуулгавартай нь аргагүй таг болов. Зугаан цагийн турш юмыг өчигдөрийнхөөсөө өөр байдалтай болж уу, үгү йюү гэж гярхай гэгч нь шинжин үзэж, цагийн урагшилж байгааг нотлох өөрчлөлт гарч уу, үгүй юу гэж шаргуу нь аргагүй эрж байлаа. Шөнөжин хараатай хэвтэж, Пруденсио Агиляр, Мелькиадес болон бүх үхэгсдийг дуудан сэтгэлийг түгшээж байгаа зүйлээ хэлэхгэсэн болов хэн ч түүн дээр ирсэнгүй. Баасан гаригийн өглөө гэрийнхнээ унтаж бахиад ойр орчмынхоод байдлыг шинжиж үзэдэ даваа гаригл үргэлжилсээр байнагэдэгт очүүхэн ч эргэлзэхгүй болов. Тэгэхд нь нэг халаганаастөмөр түгжээг мулт татан аваад улаан галзуу амьтан риул бүтээлхүй ухааны багажийг будаа болгож, гэрэлзургийн туршилтын өрөө, алт мөнгөний урланг бут ниргэж, чөтгөр шүглэсэн мэтээр нэг юмыг огт мэдэхгүй хэлээр цангинуулан хшигирч байлаа. Тэрбээр байшингаа тэр аяар нь буулгаад тавичх бодолтой байсан боловч Аурелиано байлынхныгаа туслаач гэж дуудав. Хосе Аркадио Буэндиаг арван хүн барьж аван унагаж, арвандөрвөн хүн хүлж, том туулайн бөөр модруу хорин хн чирч аваачаад, голд нь барьж хүлээд орхисонд тэрбээр өнөө хачин хэлээрээ хараа л тавин, амнаасаа цагаан хөөс

цахруулан байлаа. Урсул, Амаранта хоёрыг буцаж ирэхэд гар хөл нь хүлээстэй, бороонд усан хулгана болчихсон байж байлаа. Усрула бүгуй, шилбийгнэ үрэн зулгалсан хүлээсийг тайлж ганц бүсэлхийгэр нь татсан уяаг л үлдээв. Хойрно л нар салхинаас хамгаалж дал модон саравч дээр нь барьж өгчээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Аурелиано Буэндиа, Ремедиос Москоте хоёр Никанор Рейн ламын айлдсанаар гуоавдугаар сараны нэгэн ням гаригт зочдын өрөөнд босгосон шүтээний өмнө гэрлэх ёс хийв. Бяцхан Ремедиос хүүхдийн зангаа тавиагүй байж бие гүйцсэнээс болж Москотегийнхонбүтэн сар бөөн үймээн сандраан болсноо энэ өдөр л нэг юм амсхийв. Ээж нь бүсгүй насанд хүрэхэд ямар өөрчлөлт гардгийг цагт нь хэлж өгсөөр байсан боловч хоёрдугаар сарын нэгэн орой Ремедиос эгч нарынха Аурлеианотой ярилцаж суутал зочдын өрөөнд айсандаа чарласаар гүйн орж ирж, өмдөндөө наалдсан нойтон хар юм үзүүлжээ. Хуримын сарыг товлолоо. Брэйиэг өөрөө нүүр гараа угаадаг, хувцсаа өмсдөг, гэрийн аар саар ажил хийдэг болгон сургаж дөнгөж амжив. Түүнийг орондоо норгодоггүй болгох гэж халуун туйпуун дээр шээлгэж байлаа. Энгэр зөрүүлэхийн нууцыг хүнд хэлж болохгүй гэдгийг бэрд ойлгуулах гэж нэлээд ажил болжээ. Учир нь анхны шөнө болох явдлын тухай нарийвчлан ярьж өгтөл Ремедиос гайхан хачирхахын зэрэгцээгээр бүр бахдан хөрч, тэр мэдсэнээ аль дайралдсан хүнд хэлэхэд блээн байжээ. Түүнийг зүгшрүүлэх гэж нэлээд зүдэрсэн боловч ёслол болох өдөр гэхэд аж амьдралын юмыг эгч нараасаа дутахгүй мэддэг болсон байлаа. Цэцэг, цаасан гинжээр чимэглэсэн гудамжаар цаасан бууны тас тас дуугарах, хэд хэдэн найрал хөгжмийн эгшиглэх аяар дон Аполианар Москоте охиноохөтлөн явав. Ремедиос өөрт ньцонхоороо аз жаргал ерөөсөөн айл амгийнхан руу гар даллаж, инээмсэглэл шагнаж явлаа. Хар цэмбэн косчоом хэдэн жилийн дараа хайсны дэргэд буудуулахгэж зогсохдоо өмсөж таарсан төмөр горхитой чийдмэл шаахай өмссөн Аурелиано гэргий болох бүсгүйгээ гэрийнхээ хаалган дээр тосож аваад шүтээн рүү авч явав. Царай нь цайж, хоолой нь гүдэлзэнэ. Харин Ремердиос маш энгийн, тайван байж, тэр ч байтугай Аурелиано бөлзгийг хуруунд нь зүүж өгөх гэж байгаад газар унагачихаад хүртэл биеэ барьж чаджээ. Бөлзөг унахад зочид давхиж, эргэн тойронд нь шивэр авир хийсэн боловч Ремедиос торон бээлийтэй гараа өргөж, ядам хуруугаа тэнийлгэн, тайван зогсож нөхөр болох хүнээ хаалга хүртэл дунгуйлдан одсон бөлзгийг гишгэн тогтоож аваад, царай нь час улайчихсан, шүтээн рүү эргэж иртэл хүлээж байлаа. Ремедиосын ах, эгч нар нь түүнийг бслолын үеэралдаж осолдохвийгэж айсаарбүр ядарч гүйцээд, эхэлж өнхрөө үнэсдэг юм гэж түүнд хэлж өгөн, өөрсдөө алдаа хийжээ. Чухамхүү энэ өдрөөс хойш Ремедиос гэргийн журмыг ойлгосон нь мэдэгдэж, төрлхийн эелдэг зантай

нь хамгийн хүнд үед ч биеэбарих чадвартай нь тодорчээ. Тэрбээр үнээр хэлээүүлэлгүйгээр хуримын бялуунаас хамгийн сайхнаас нь зүсэн аваад, тавган дээр тавин Хосе Аркадио Буэндиад сэрээтэй хамт аваачиж өгчээ. Туулайн бөөр модонд хүлүүлээд далдуу модон саравчинн доорхи сандал дээр эвхорэн байгаа нар салхинд хөхөрч гандсан авраг биет өвгөн баярлан инээмсэглэж, амандаа үл мэдэх уншлага уншсаар бялууг гараараа аван үмхэлжээ. Өглөө облтол үргэлжилсэн шуугиант хурим дээр ганцхан хүн баяргүй байсан нь Ребека байжээ. Урсулгайн зөвшөөрснөөр Ребека энэ өдөр гэрлэх ёстой байтал баасанд Пьетро Креспи эхийнхээ үхлүүт байна гэсэн захиа аваад хуримыг хойшлуулжээ. Пьетро Креспи захидлыг авснаасаа хойш цаг болоод мужийн гол хот орохоор мөрдөж, бямба гаригийн шөнө огт хожигдолгүйгээр Макондод ирсэн ээжтэйгээ зам зөрчихжээ. Ээж нь хүүгийнхээ гэрлэх ёслол дээр дуулахгэсэн гунигтай дуугаа Аурлениаогийн хурм дээр дуулжээ. Пьетро Креспи хуримд амжиж ирэх гэж таван морь багтраагаад ням гаригийн шнө улс амьтан тарж бахйда иржээ. Тэр өлзий бусын захидлын эзнийг хэн ч мэдэж чадсангүй. Урсула Амрантаг байцаан хоргоосонд дургүйцэн уйлж, мужаан нарын буулгаж амжаагүй байсан шүтээний өмн өөрөийгөө гэмгүйгэж ам тангараг рргөжээ.

Дон Аполинар Москоте гэрлэх ёслолыг үйлдэхийн тулд зэргэлдээх хоос үргүй юмхийсээр ширүүн дориун болчихсон өвгөн лам Никанор Рейнийг залж авчиржээ. Тэр бол ясанд тохчихсон үнсэн хөх арьстай, цодгор гэдэстэй бөгөөд өтөлсөн сахилусны царай шиг царайд нь сайхан сэтгэлийн гэхээсээ амарлингуйн байдал илүү тодрох ажээ. Хуримын дараа сүсэгтэн олондоо буцаж очих гэсэн боловч гагцхүү байгалийн хуулийг даган, үр хүүхдээ адислахгүй, шашны баярыг тоохгүй, байнга нүгэл хилэнц хийх мөртлөө өөдлөн дэвшиж байгаа Макондогийнхны хэнэггүйг харахаас айдас нь хүрчээ. Тэрбээр атар онгон энэ хөрсийг даруй хадгалах нь зүйтэй гэж үзээд, хозлуулсагсад1, буруу нотмтныг адилслаж, хууль бусаар нөхцөж байгааг хууль ёсны болгож, үхэхгэж байгаа хүмүүсийн нүглийг наманчлуулж, Макондод бас долоо хоноё гэж шийджээ. Гэтэл түүний үгийг дуулах хэн ч байсангүй. “Олон жил ламгүй болоод л ирсэн, амьдын хар нүгэл хийчихсэн хүнгүй л байна гэж түүнд хариулжээ.

Никанор лам ном номлож ядаад хүлээж авах хүн олдохгүй хутагт нарын баримлыг биеийнх нь хэмжээгээр хийж тавьсан, өнгийн шилэн шитгэмэлтэй, дэлхийд хамгийн том сүм бүтээхэд хамт хүчээ тавихаар зорив. Сүжиггүйчүүдийн төв болсон Макондог Ромоос хүртэл ирж тэнгэрт мөргөдөг эрэл мөргөлийн орон болгохын тулд тэрбээр зэс дийз тосон, айл айлаар бадар барин явав. Өглөгийн эзэд өргөл харамгүйөргөх боловч лам сүмдээ усанд үйж үхсэн хүн ч хөвөөд гараад ирэхээр дуутай хонх тавих гэсэн учир илүү их хандив нэмэрлэхийг нэхэж байлаа. Тэгж гуйсаар явтал хоолой нь сөөж, ядарснаас нь янгинах болжээ.

Нэгэн бямба гаригт лам цуглуулснаа үзэн, тэр нь сүмийн халага хийхэд ч хүрэхгүйг бодоод гутран бачимдав. Хотын талбай дээр шүтээн босгож, ням



гаригт нь толгийн үеийнх шиг хонх барин бүх гудамжаар таварган байж улс амьтныг гадаа мөргөл хийлгэхээр цуглуулав. Олон нь сониучирхаж, зарим нь хийх юм. Гүйдээ ирж, эзэн тэгрэ элчийг нь тоохгүй байгааг өрөийг нь тоохгүй байна гэж эндүүрээд хилэгнэх болуужин гэж болгоомжилсондоо бусад нь иржээ. Тийнхүү өглөөний найман цагт хотынхны тэн хагас нь

1 Хозлох гэж эрэгтэй хүний бэлэг эрхтний үзүүрийн арьсыг огтлохыг хэлнэ. Катлоик шашинд хозлуулсан хүнийг бузар гэж үздэг ажээ- Орч.

Бай дээр цуглаж, Никанор ламтан хөлгөн судрыг уншиж, мөнгө өгөхийг хоолойгоо хяхтнуулан гуйжээ. Хурал өндөрлөж, хүмүүс тарж эхлэхэд ламтан гараа өргөн хаарахыг уриалаад,

- Байзаарай. Эзэн тэнгэрийн цаглашгүй хүчтэйн маргашгүй нотолгоог та бүхэн үзэгтүн гэж хэлжээ.

Хурлын үеэр Никанор ламтанд тусалж байсан жаал хүү уур баагьсан өтгөн шоколад авчирч өглөө. Лам ундааг нэг амиар залгилчихав. Баринтагныхаа ханцуйнаас алчуур гаргаж, уруулаа арчаад, хоёргараа урагш сунган нүдээ анимв. Тэгээд Никанор лам газраас тоо хэртэй хөндийрчээ. Энэ нотлол нэн үнэмшилтэй болов. Хэдэн өдөр ла мхалуун шоколад уун газраас хөндийрөх илбэ үзүүлж хотоор явахад зарц нь өдий төдий мөнгө цуглуулж, сар бололгүй шахам сүмийг босгож эхлэв. Никанор ламыг тэнгэр л газраас хөндийрүүлсэн гэдэгт Хосе Аркадио Буэндиагаас бусад нь эргэлзэхгүй байлаа. Нэг өглөө туулайн бөөрийн ойролцоо хүмүүс ламын хөөрөхийг үзэх гэж цуглахад тэрл ганцаараа огт тоосон шинжгүй, вандан дээрээ ялихгүй цэхрэн сууж, Никанор ламыг суусан сандалтайгаа газраас тасарч байгааг үзэхдээ мөрөө хавчисхийлгэн,

- *Noe est simplicissimum. Homo iste statum quartum materiae invenit!*

Гэж хэлэв.

Никанор лам гараа өргөж, сандлын дөрвөн хөл газар хүрэв.

- *Nego stactum hoc existinetianm Dei probat sine dubio!* гэж ламтан зөрөв.

Хосе Аркадио Буэндиагийн учир олдохгүй хэл латин хэл байсныг тэж мэджээ. Арайхийж түүнтэй хэл амаа ололцох хүн олдож, Никанор лам ч түүний блартсан ухааныг сүсгийн гэгээгээр гийгүүлэх азтай тохиолыг ашиглахаар шийдэв. Орой бүр ламтан туулайн бөөр модны дэргэд сууж, лаитнаар ном унших боловч Хосе Аркадио Буэндиа түүний уран уншдаг чадлыг ч, шоколад ууж хөөрдгийг чогт тоохгүй, эзэн

- 1 Энэ маш амархан. Энэ хүн материйн дөрв дэх байдлыг нээж (лат)
- 2 Худлаа. Энэ бол эзэн тэнгэр бийг гарцаагүй нотолж байгаа юм (лат)

тэнгэрийн зургийг л маргашгүй нотолгоо болгож аваад ир гэж зүтгэж байлаа. Тэгэхэд нь Никанор ламтан эзэн тэнгэрийн зурмаг зураг, бар зургийг, тэр ч байтугай Вероникийн алчуурыг<sup>1</sup> дуурайлгамлыг авчирсан боловч Буэндиа шинжлэх ухааны үндэсгүй бүдүүлэг гар урлалыгн зүйл гээд хэрэгссэнгүй. Никанор лам Буэндиаг өөрийнхөөрөө зүтгээд болохгүй болохоор эзэн тэнгэрийг ярихаа больж зүгээр өрөвдөж энэрсэндээ ирдэг болов. Гэтэл Буэндиа бүр давраад, зөвхөн оюун дүгнэлтэд үндэслэсэн адтай нотлолоор ламын сүсэг бишрэлийн батыг алдуулах гэж оролджээ. Нэг удаа Никанор лам хайрцагтай даам, хөлөг авчирч, Хосе Аркадио Буэндиаатай тоглоё гэсэн боловч “Зарчмын асуудлаар санал нийлэхгүй байгаа хоёр өрсөдөгч даам тоглоод ашиггүй” гээд тоглож өгсөнгүй. Даам нүүхийг энэ үүднээс одоо болтол үзэж байгаагүй Никанор лам түүнийг ятгаад дийлсэнгүй. Хосе Аркадио Буэндиагийн ухаантайд гайхсан лам яагаад өөрийг нь модонд барьж хүлснийг асуусанд:

- *Nos est simplici ssimiim* Намайг солиотой болохоор хүлсэн юмгэжээ.

Энэ ярианаас хойш лам эзэн тэнгэрт баттай сүсэлдэгтээ итгэл алдахаас айн Буэндиа дээр ирэхийг болиодгагцхү сүм барих ажилд шамджээ.

Ребекад дахин найдлага төрөх болов. Нэг ням гаригт Никанор ламтан тэднийд үдийн хоол идэж байгаад, сүм баригдсаны дараа ямар сайхан сүртэй хурал хуй болж байх тухай ярьснаас хойш, сүмийг барьж дуусгахаас хойчийн тавилан нь шалтгаалах болсныг ойлгов. “Ребека л хамгийн азтай юм даа” гэж Амаранта хэлжээ. Ребека юу гэх гээд байгааг нь ойлгоогүй тул Амаранта гэмгүй царайлан инээмсэглэж,

- Сүмийг чиний хуримаар мялаана шүү лээ гэж хэлжээ.

Ребека энэ талаар яриулахгүйг оролдов. Барилгын ажил ахиц муутай байгаа учир сүм арван жилээс нааш дуусахгүй. Никанор лам түүний хэлснийг зөвшөөрсөнгүй. “Сүсэгтний өргөлб арьц нэмгэдэж байгаа учир сайхнаар бодох хэрэгтэй” гэжээ. Ребекагийн дотроо унтууцан сууж, хоолоо ч гүйцэд идэж чадалгүй орхиход

1 Хутагтай Вероника –Есүс Христосыг Калвариогын за мдээр хэвтэж байхад нь олж цагаан зотон даавуугаар нүүрийг нь арчсан гэсэндомогтой. –Орч

Урсула Амрантагийн хэлснийг сайшааж, ажлыг хурдасгахад ахиухан юм хандилана гэж амлав. Дархиаднэг ийм өргөл өргөх юм бол сүм гурван жил гэхэд бэлэнболно гэж Никанор ла мхэлэв. Тэр өдрөөс хойш Ребека Амарантатай дуугарахыг болив. Учир нь Амаранта тэр явуулгаа гэм хоргүй гэж харуулахыг хичээвч тиймгүй гэдэгт Ребека итгэж байлаа. Үдэш нь хоёул тачигнатал хэрэлдээж байгаад Амаранта “Намайг харин бүр муу юм хийгээгүйд баярлаж яв. Үгүйдээ гэхэд гурван жил чамайг цааш харуулах хэрэггүй болох нь” гэж хэлжээ. Ребека өдөөд байвал сөдөөд өгөн гэж шийджээ.

Хуримыг нь дахиад хойшлуулсныг сонсохдоо Пьетро Креспи сэтгэлээр унасан болвч гэргий болох үсгүй нь түүнд үнэнчээ дахин баталж, “Чамайг дургүйлэхүй бол хоёул эндээс оргоё” гэж хэлжээ. Гэвч Пьетро Креспи тэгж хөнгөн хөдлөхгүй хүн байжээ. Тэрбээр сүйт бүсгүй шигээ долгин зангүйг, өгсөнамыг хүндэтгэнэ гэдэг хамаагүй үрэнаран хийж болдоггүй хөрөнгөтэйадилгэж үздэж байжээ. Тэгэхэд нь Ребека эвтэйхэн арга хэрэглэх болов. Хаанаас гарсан нь мэдэгдэхгүй салхи зочдын өрөөний кероспин дэнлүүг унтрааж, Урсула хоёр залууг харанхуйд үнэсэлдэгн зогсоотой байсхийгээд дайралдах обллоо. Пьетро Креспи шинэ керосин дэнлүүний чанар муутайг будлисхийн гомдоллож, тэр ч байтугай гэрэлтүүлгийн илүү найдвартай системийг тавиахд туслав. Гэвч тэглээ гээд бохирдчихсон асахаа больж Урсула Ребекаг залуугийнхаа өвөр дээр байж байхтай дайралдана. Сүүл сүүлдээ Урсула ямар ч тайлбар сонсохыг болив. Талх барих бүх алжыг индиан вагайд даалгаад бүр залуу байхынх нь хуучирч орхисон зальд хуутахгүй гэж хартуу шийдэж, хоёр залууг харж харгалзаж байхаар дүүжин сандал дээр сууж авчээ. Ондууцсан Ребека ёсорхог, нойр хулжаасан уулзалтын үеэр Урсулагийн эвшээлгэж байгааг харахдаа “Хөөрхий ээж миньүхэхдээ энэ ганхуур дээр нүглийнхээ өр төлөөсийг эдлэх болно доо” гэж тохуурхан рьядаг байлаа. Өдөр бүр сүмийн ажлын байдлыг шалгаж, түүний ургаш ахихгүй байгаад залхаж гүйцсэн Пьетро Креспи сүйт бүгйтгэйгээ гурван сар ийнхүү хараглазанд уулзаад сүмийг хурдан бариулахын тулд Никанорламд дутаад байгаа мөнгийг гүйцээж өгөхөөр шийджээ. Амаранта энэ сониныг огт тоосонгүй. Тагтанд юм нэхэж хатгамаллахаар цугладаг найз нартайгаа дэмий ярингаа хорлонтой хорлонтой юмыг шинээр бодож олж байлаа. алдаж тооцоолсноос болоод өөрийн нь хамгийн найдвартай гэж блодож байсан нэг санаа нь бүтэлгүй болов. Энэ юу вэ гэвэл, Ребекагийн хуримын даашинзаа хадгалж байсан унтлагын өрөөний хоргоноос нафталин үрлийг авсан байлаа. Амранта үүнийг сүмийн барьж дуусахаас хоёр сарын урьд авчээ. Гэвч хурим ойртсонд Ребека сэтгэл нь улам яарч, Амрантагийн бодож байснаас хавьгүй эрт хувцас хунараа янзлахаар болжээ. Ребека хоргын нүзийг татаж, гоёлын хувцсыг боосон цаасыг эхлээд задалж, дара ань зоргыг дэлгэвэл атлаасаа даашинз, торгон

малгай, хүчээлжин титмийг нь хүртэл хорхой юу ч үгү йдчихсэн байлаа. Бобдлынх нь доор хоёр атга нафталин үрэл цацсанаа сайн санаж байсан боловч ямар ч сэжигтэй юм байхгүй учир Амарантаг буруутгаж чадсангүй. Хурим болтол сар хүрэхгүй үлдсэнд Ампаро Москоте долоо хоногийн дотор шинэ даашинз оёж өгөхөөр болжээ. Нэгэн бороотой өдөр вангийн түшмэлийн охин тэвэр дүүрэн сэвсгэр цагаан торон даашинз аван орж ирээд Ребекагаар сүүлийн удаа өмсүүлж үзэхэд Амранта золтой л ухаан балартаж унасангүй. Тэрбээр үг дуугарч чадахгүй болоод, хүйтэн хөлс нуруугий нь даган урсана. Олон сар Амаранта энэ цагийг хүлээн айн чичирч байсан бөгөөд хуримд бүрмөсөн саад хийх юм бодож олж чадахгүй, бүхаргаа барвал зориг гаргаад Ребекад хор өгөх байлаа. Ребека атлаасан даашинзандаа халууцан багтарч, Ампаоро Москоте мяган сүлбээр зүүгээр туйлын тэвчээртэйгээр торгон тэвчээртэйгээр тогон тогтоож бахиад Амранта нэхэж байгаа зүйлийнхээ гогцоог олохгүй хэдхэдэн алдаж, нэхүүийнхээ зүүгээр хуруугаа хэд хэд хатгасан боловч, хуримын урьдах сүүлчийн баасан гаригт аяга кофенд хар тамхины ханд хийгээд өгчихье гэж аймаар тайван шийджээ.

Гэвч аргалахын аргагүй гэнэтийн өөр нэг саад гарч хурим хэзээ болох нь мэдэгдэхгүй хойшлов. Ребека, Креспи Пьетро хоёрын гэрлэх ёслол хийхээр товлосон өдрөөс долоо хоногийн өмнө шөнө дунд бяцхан Ремедиос сэрвэл халуун шингэн юм доошоогоо хүрчигнэн олгойдож түүндээ бялдчихсан байлаа. Ихэр хүүхэд нь хөндөлсөн гажсан учир Ремедиос гурав хоноод цусандаа хордон нас барав. Амаранта гэмшин зовж байлаа. тэнгэрээс залхаал хайрлаж өөрийг нь Ребекад хор өгөхөөс зайлуулаач гэж мөргөн гуйж байсан тул өөрөөс нь болоод Ремедиос үхчихсэн юм шиг бодогдоод байлаа. Тэр иймгайг гуйж мөргөөгүйсэн билээ. Ремедиос гэрт баяр хөөр авчирсан билээ. Тэрбээр нөхөртэйгөө урлангийн хажуугийн унтлагын өрөөнд орж, бүх тасалгаагаа саяхан хүүхэд байхдаа тоглож байсан хүүхэлдэй, тоглоомоор чимж, түүний оргисон баяр баясгалан унтлагын өрөөний дөрвөн хана нэвтлэн найртай салхин адил цэцэгт гонхонд түгж байлаа. Ремедиос мандах нарнаар л дуулж эхэлнэ. Ребека, Амаранта хоёрын хэрүүл дундуур орж зүрхэлдэг цорын ганц хүн обл тэр байлаа. Хосе Аркадио Буэндиаг асрах амраггүй ажлыг өөртөө авч, хоолыг нь зөөж, түүний биеийг нь савандан угааж, сахал, үсийг нь бөөстөж хурстах вий гэж харж ханлаж, саравчийг үргэлж засаж янзлан бороо хурын цагаар саравчийг үргэлж засаж янзла, о бороо хурын цагаар далдуу модны нэвчийг ус нэвтэрдэггүй бэржээнхээр бүтээдэг байсан хүн бол тэр л байлаа. Үхэхийнхээ өмнөх хэдэн сард тэрбээр Хосе Аркадио буэндиатай бүдүүлэг латин хэлээр ярилцаж сурчээ. Аурелиано, ПиларТенера хоёрын хүүхдийг төрөхөд, гэрт авчран, халуун амиараа нийлж Аурелиано Хосе гэж нэр өгвөл Ремедиос түүнийг ууган хүүгээ болгохоор шийджээ. Эх хүний зөнтэй нь Урсула гайхаж байлаа. Аурелианоос олжээ. Бүтэн өдөржин тэрбээр урланд ажиллаж, Ремедиос түүнд чихэргүй, хар кофе аваачиж өгдөг байлаа. Үдэш ньхлэулаа Москостегийнд очиж Аурелиано хадам эцэгтэйгээ

даалуу салахгүй тоглож,, Ремедиос эгч нартайгаа дэмий чалчиж, үгүй болээжтэйгээ томчуулын явдлыг ярьдаг байжээ. Буэндиагийнхантай ураг барилдсанаар Макондод Аполинар Москотегийн нэр хүнд батжив. Мужийн гол хот руу үеүе вяхадаа тэрбээр Макондод сургууль бариулахыг эрх баригчдад ятгаж чадсан бөгөөд өвгийнхөө багшлах авьяасыг авч төрсөн Аркадио Москоте ятгасаар байжэ үндэсний тусгаар тогтнолын өдөр гэхэд байшингийнлолхыг нөхөөр будуулж чадлаа. Никанор лам шаардсаар байж Катариногийн байшинг бөглүү гудамжинд нүүлгэж, хотын яг төвд гаарч байсан хэдэн самууны газрыг халагав. Нэг удаа дон Аполинар Москоте мужийн төвөөс винтов буутай зургаан цэрэг дагуулан ирж, хэв журмыг сахиулах үүрэг ногдуулахад Макондод зэвсэгт хүн байлгахгүй байна гэж анх тохиролцосныг хэн ч дурсдангүй. Аурелиано хадмынхаа зүтгэлтэйг ойшоон үздэг байв. “Чи түүн шиг тарган болнодоо” гэж нөхөд нь түүнийг шоолно. Урланд байнга суусаар байтал шанаа нь улам горзойж, нүд нь улам гялалзах болсон боловч төлөв зан нь хувирсангүй шигээ жин нь өөрчлөгдсөнгүй. Аманд шулуун зураас гарсан нь ганцаараа юмыг эргэцүүлэн тунгаадаг, нэг л зүтгэвэл зорьсондоо хүрдгийн шинж билээ. Аурелиано, Ремедиос хоёр гэрийнхний хайрыг татаж, Темедиосыг бие давхар болсон гэхэд Амранта, Ребека хоёр хүртэл толхилцохоо болиод хоёр өнгийн ноосоор хоёр бариувч нөхөж хүү гарвал хөхийг нь, охин гарвал ягааныг ньөгөхөөр болж билээ. Хэдэн жилийн дараа Аркадио хайсны дэргэд буудуулах гэж зогсохгдоо хамгийн сүүлд Ремедиосыг л санана.

Урсула гашуудал чандлан зарлаж, бүх цонх хаалгыг тас хааж онц хэрэггүй бол хэнийг ч гэрт орох гэрээс гарахыг болиулж бүтэн жил чанга дуугарахыг хорьж, оршуулгын өдөр Ремедиосын шарилтай авс байсан хананд зургийг нь хар туузаар ороон өлгөж, доор нь мөнхийн зул асаажээ.

Зулыг унтраалгүй сэргээж байсан Буэндиагийн дараа үеийнхэн хуниастай банзал, цагаан шагайвч өмсөж, органди тууз зангидсан энэ охиныг харахдаа элэнц ээж гэж настай хүн байдаг хэмээн бодоод дасчихсантай нь нэг л авалцаж өгөхгүйд барьц алддаг байжээ. Амаранта Аурелиано Хосег үрчилж авав. Тэрбээр түүнийг хүүгээ болгож, ганцаардсан элгээ давтээн, хүссэнээр нь бололгүй, бодлогогүй мөргөлийнх нь гайгаар хартамхины ханд Ремедиосын аягатай кофенд орсноос эхэлж буй сэтгэлийнх нь зовлон тэгвэл баахан нимгэрэх байх гэж найджээ. Үдэшдээ Пьетро Креспи бугуйгаа хүрсэн урт ханцуйтай хар палааж өмсөж бүрсүр сүлд нь үхээд урьзынхтайгаа огт адилгүй болчихсон Ребекатай дуугүйхэн уулзахгэж бүрх малгайдаа хартууз хадан, өлмий дээрээ гишгэсээр орж ирнэ. Хуримхийх өдрийг товлон гэж бодоход ч одооариун дурсгалыг бузарлахаар байсан бөгөөд тэр хоёрын гэрлэхээр тохиролцсон нь салж ч болохгүй, байж ч болохгүй юм болж, дурлал нь хэний ч сонирхол татахгүй, харин ч утйгар төрүүлж, дэндүү гайтуулж харанхуйд үнэсэлдэж байсан янаг хос аль эрт эрлэгийнд очсон мэт облжээ. Ребека ямар ч найдлагагүй болоод сэтгэлээр унаж, шороогоо идэж эхлэв.

Бэлэвсрэл эхэлснээс хойш нэлээдгүй хугацаа өнгөрч, гонхонд хатгамалчид дахин цугладаг болжээ. Чимээ алдан дунсийсэн бүгчим халуун өдөр, яг хоёр цагт гэнэт нэгэн хүн гадаа халага түр нярхийтэл түлхэн орж ирэхэд бүх байшин дайвалзан, гонхонд үерхдэг бүсгүйчүүдтэйгээ сууж байсан Амаранта, өрөөндөө хурууаа хөхөж суусан Ребека, гал зууханд байсан Урсула, урландаа байсан Аурелиано, тэр чбайтугай өнчин туулайн ббөрийн дотор байгаа Хосе Аркадио хүртэл газар хөдөлж, байшин нь нурж байна уу даа гэж санажээ. Тэг дөрвөлжин цээжтэй, лүглэгэр том хүн хаалгаар багтаж ядан орж ирэв. Бухынх шиг лухгар хүзүүндээ Оточ охин тэнгэрийн хөрөг зүүж, гар, цээжээ хачин хачин шивээсээр туж эрээлж, баруун буруйндаа сахиуст зэс бугуйвч зүүжээ. Арьс нь хүйтэнд хөрч, халуунд халсаар шиг шиг болсон үс нь луусны дэл шиг тожийн сэрвийсэн тэр хүн эрүү зуунги, нүд гунигтай ажээ. Ирсэн хүн эмээлийн оломноос хоёрдахинзузаанүбс бүсэлж, төмөртах хадсан, хавируул төмөртэй урт савхин гутал өиглөжээ. Явахад нь бүх юм газар хөдөлж байгаа юм шиг доргин хөдлөх ажээ. Тэрбээр нэлээдгүй элэгдсэн богц барьцаар зочдын өрөө, танимаар дамжин, хайтан цэцэгтэй нам гүм гонхонд аянаг аятай түрхрэн орж зүүгээ хийд барьсанчигээрээ мэлэрсэн Амаранта, түүний найз бүсгүйчүүлтэй “Сайн байцгаана уу” гэж сульдангуй дуугаар мэндлэн, барьж явсан юмаа өмнөх ширээн дээр нь шидээд, цаашаа явав. Өрөөнөөсөө айнгуй цухуйсан Ребекатай “Сайн байна уу” гэж мэндлэв. Энэ үед хийж байгаадаа улайраад ухаан алдчихсан байсан Аурелиногийн амрыгэрэв. Огт сааталгүй явсаар, шууд гал зуух руу оронд энд л зогсож, ертөнцийн нөгөө хязгаараас эхэлсэн аяныхаа дөрөөг энд л мултлавай. “Сайн байна уу?” гэж мэндэллээ. Урсула хором хүрэхгүй ам ангайн таг болсноо ирсэнхүний нүдийг харангуутаа улга алдан, баярласандаа уйлах, хашгирах зэрэгцэн хүзүүнд нь зүүгдчихэв. Энэ бол Хосе Аркадио байлаа. Тэр мөрөндөөнаасан юмгү йвясаншигээ мөрөндөө угласан юмгүй буцаж иржээ. Тэр ч байтугай Урсула хөл залгаж ирсэн унааны нь хөлсөнд хоёрпесо өгчээ. Тэрбээр усан цэргийн этгэдүүгс холилдсон испани хэлээр ярина. Түүнийг хаана байсныг нь асуухад”Тэнд” гэж л хэлжээ. Өөртнь гаргаж өгсөн өрөөнд дүүжин орон дээр гурван өдөр унтав. Сэрэхдээ арван зургаан аргуун өндөр гүвдэж орхиод, Катариногийн газар шууд очсонд сониуч хүүхнүүд аварга биетнийг хараад сүйд болжээ. Тэгээд өөрийнхөө мөнгөөр хажуудаа байгаа хүмүүст архи авч өгөн хөгжим захиалаад, тавуул нийлээд гарыг минь ширээ рүү нугал гэж таван харцуултай бооцоо тавьжээ. Цаадуул нь гарыг нь хөдөлгөж ч чадахгүйгээ мэдээд “Ямар ч аргагүй. Гартаа шившлэгтэй бугуйвч зүүсэн байна” гэлцжээ. Хүч тамирын тоглолтод итгэдэггүй Катарино босоо лангууг байрнаас нь хөдөлгөх юм бол арван хоёр песо өгнө гэж Хосе Аркадиоотой мөрийцжээ. Тэгтэл цаадах нь лангууг толгой дээрээ өргөөд гудамжинд гаргажээ. Түүнийгарван нэгэн хүн арай хийж гэдрэг оруулжээ. Хосе Аркадио гэрийнхэнтэйгээ бараг ярилцдаггүй байв. Өдөр нь нойр аваад, шөнө нь янхны газар очно. Эх нь түүнийг хааяа нэг гэрийнхэнтэйгээ хамт хүчээр хоол

идүүлэхэд ал холын оронд өөртөө учирсан адал явдлыг бүгдийн ам ангайтал ярьдаг байлаа. Түүний сууж вясан онгоц сүйрч, Япон тэнгист хоёр долоо хоног завинд балбуулж, наранд цохиулж үхсэн нөхрийнхөө хүүрийг идэж явжээ. Давслаад наранд борц болгон хатаасан мах нь горгор бөгөөд нялуундуу амттай байсан гэнэ. Нэгэн цэлмэг өдөр Бенгалийн буланд түүний сууж явсан онгоцны баг далайн луу алсанд гэдэснээс нь загалмайтан цэргийндүүлга, бүсний горхи, зэвсэг гарчээ. Карбиын тэнгист Виктор Югийн<sup>1</sup> дээрэмчний хөлөг онгоцны хий сүгийг үзсэн нь дарвуулаа үхлийн хар салхинд салам уруулж, шураг, хөндлөвчөө далайн жоомд идүүлсэн тэр хөлөг Гваделупт очихгэж хэчнээн зүтгэвч ямагт чигээ алданхэзээ ч олж очихгүй төөрөгтэй болсон байсан гэнэ. Хосе Аркадиогийн алдар гавьяа, адал явдлаа бичсэн, өчнөөн хүлээвч огт ирээгүй захидлыг ахин дахин унших мэт Урсула дорхноо улийж “Гэтэл, хүү минь, бид чинь энд ийм том байшинтай болсон. Бас

1 Гваделуп арал дээр францын Конвентын комиссар байсанхүн, (1793) англичуудтай дээрмийн дайн хийж байжээ. Тэгээд хэчнээн ч хоол гахайд хаяж өгч байв даа” гэж санаа алддаг байлаа. Цыгануудын аваад явчихсан хүүгээ нэг суудлаар өрөөл торой идчихдэг, цэцэг гундтал хүчтэй амьсгалдаг энэ зэрлэг эр гэхэд сэтгэлд нь яагаад ч багтаж өгөхгүй байжээ. Бусад нь ч тиймэрхүү байдаг байлаа. Амаранта түүний хоол идэж байхдаа хэхэрдэгт ой гутдагаа нууж үл чадна. Эцгийн угийн мэдэхгүй Аркадио өөрт нь нүүртэй болохгэж илт оролдох Хосе Аркадиогийн юм асуухад дуугарч ядна. Аурелиано багадаа хамт нэг өрөөнд унтаж, ойр дотно байснаа сануулах гэж оролдовч Хосе Аркадио далайд тэнүүчлэн элдэв юмтай тохиолдсоор тэр бүхнийг анх харангуутаа ‘унаж үхжээ. Тэр нэгэн орой Хосе Аркадио унтлагын нь өрөөний дэргэдүүр өнгөрөхөд байшингийн хаана ч байсан дуулдахаар амьсгаадаг энэ азарга шиг эрийн дэргэд Пьетро Креспи ердөө л дэгжирхэнхээс цаашгүй хүний оронцог юм гэж бодогджээ. Ребека юунхан хээхнээр шалтаглан түүнтэй уулзах гэж оролдоно. Нэг удаа Хосе Аркадио биеийг нь эрээ цээргүй хараад “Дүү минь, чи бүр хүүхэн болж шүү” гэснээс хойш Ребека биеэ барьж огт чадахгүй болжээ. Тэгээд хуучин шигээ шороо шохойг цадахыг мэдэхгүй хомхойрон идэж, хуруугаа эвэр ургатал салахгүй хөхжээ. Шөнө нь халуурсан мэт дагжин ухаан тавьчихгүй байх гэж байдгаараа мэрийн нойргүй хонож, Хосе Аркадиогийн байшин догиулсаар ирэхийг үүр цайтал хүлээдэг байлаа. Нэг удаа Ребека үдийн амралтын үеэр тэсэж чадалгүй өрөөнд нь орвол цаадах нь завь аргамждаг бүдүүн татлагаар яс модонд бэхлэн тогтоосондүүжин орондээр дан өмдтэйгөө сур мэт сунаад хараастай хэвтэж байлаа. Ребека түүний асар том нцүгэн биеийг хараад сүрдэж буцдаг ч юм билүү гэж боджээ. “Өршөөгөөрэй, таныг энд байгааг мэдсэнгүй” гэж хүн сэрээчих вий хэмээн аяархан өршөөл эрэхэд цаадах нь “Нааш ир” гэжээ. Ребека яваад очтол бүсэлхийгээр нь залуу эрийн шүүрэн

өргөсөнд эрчилсэн хуйд дайрагдан хийсэж байна у угэж санаж, түүний сурмаг гэгч нь гуравхан дохиод л хувцсыг нь шувтатан, буяцхан шуувхай шиг шалдлаад тавьчихсанд үхчихгүй юмсан гэж өөртөө байшгүй их хүч гаргажээ.

Тэр хоёр гурав хоноод үдшийн мөргөлийг үеэр гэрлэв. Урьд өдөр нь Хосе Аркадио Пьетро Креспийн дэлгүүрээр оржээ. Итали эр ятга хөгжмөөр хүүхдүүдэд хичээл зааж байсанд Хосе Аркадио хажуу тийш дуудсан ч үгүй.

- Би Ребекатай сууна гэж шулуухан хэлжээ. Пьетро Креспийн царай нь цонхийн ятгаа нэг шавьдөө өгөөд “Хичээл дууссан” гэж хэлэв. Тэгээд хөгжмийн зэмсэг, оньст тоглоом дүүрсэн тасалгаанд хоёулахнаа үлдээд Пьетро Креспи:
- Таны дүү шүү дээ гэжээ..
- Тэр хамаагүй гэж Хосе Аркадио хариулав.

Пьетро Креспи лаваанд түрхсэн алчуураар духаа арчив.

- Энэ чинь ёсонд хазгай. Тэгээд ч хуульд харш гэж Пьетро Креспи тайлбарлав.

Хосе Аркадио, Пьетро Креспийн тайлбар тавихад нь ондууцхаасаа царай нь зэвхийрч байгаад илүү ондууцаж,

- Үхсэний чинь ёс мос. Таныг өөрийгөө ч бүү зовоог, Ребекаг бүү хоргоог гэж үүнийг хэлж байгаа юм гэжээ.

Гэвч Пьетро Креспийн нүдэнд нулимс цийлгэнэсэнд тэр зөөлөрч огт өөр дуугаар:

- За, за. Манайхан танд аятайхан байгаа бол Амаранта үлдэж байна шүү дээ гэжээ.

Ням гаригийн мөргөл дээр, Никанор лам Хосе Аркадио, Ребека хоёрын төрсөн ах дүү биш гэдгийг хэлсэн боловч Урсула тэр хоёрын гэрлэснийг хэзээ ч уучилж чадахгүй, түүнийг ёс төргүй хэрэг гэж үзэж, шинээр гэрлэгсдийг сүмээс ирсэн тэр өдөр нь “Үүнээс хойш, түүнээс цааш гэрийн босго бүү алх!” гэж хөөржээ. Түүний хувьд тэд үхсэнтэй адил болжээ. Хоёр залуу оршуулгын газрын өөдөөс харсан бяцахан байшин хөлсөлж, Хосегийн дүүжин орыг л авч очсон нь эхний үед бүх тавилгыг орлож байлаа. Гэрлэсэн шөнө бүсгүйг гутал дотор нь орсон хилэнцэт хорхой хатгаж, хэл нь татсан боловч эр эм хоёрын бал сараа1 их л дуутай шуутай нөгөрөөхөд саад болсонгүй. Шөнө найман удаа, өдрийн амралтаар гурван удаа бүхэл хорооллыг сэртэл тэр хоёрын орилолдоон янцаглахад хөрш нар нь айж, ийм хазааргүй тачаал үхэгсдийн ясыг бүү өндөлзүүлээсэй гэж мөргөдөг байлаа.



## 1 Гэрлэсний эхний сар

Ганц Аурелиано л сая гэрлэгсэдэд санаа тавьж байв. Тэрбээр Хосе Аркадиоог юмыг бодитой ойлгож, гэрийнхээ дэргэх цулгй гзарыг боловсруулж эхэлтэл жаал зугаа тавилга тэдэнд худалдан авч өгч, мөнгөөр тусалж байлаа. Амарантагийн хувьд гэвэл огт санаа оноонд ороогүй байтал хорвоо эргэсэнд сэтгэл дүүрэн болосн боловч Ребекад хорссон ньтайлагдсангүй. Тохиолдсон гутамшгийг хэрхэн цагаатгах учраа олохгүй байсан Урсулагийн хүссэнээр Пьетро Креспи мягмар гариг бүрд тэднийд өдрийн хоол идэж, өөрт учирсан гамшгийг нам тайван бөгөөд нэр төртэй давжээ. Тэр айлыг хүндэтгэсээр байгаагийн тэмдэг болгон бүрх малгайдаа хар тууз урьдын адил хадаж, Урсулад португалийн сардин загас, туркийн ягаан дэлбээний чанамал зэрэг сонин хачин бэлэг өгөн, сайныгаа илтгэн сэтгэлээ зогоож, нэг удаа тэр ч байтугай манилын дэгжин урт алчуур барьжээ. Амаранта түүнтэй маш найрсаг, эелдэг байлаа. Залуугийн юунд дуртайг нь тааж, цамцных нь хамжаарын сөдийсөн утсыг хайчилж өгөн, төрсөн өдрөөр нь арван хоёр алчуур дээр овог нэрнийх нь эхний үсгийг хатгамалажээ. Мягмар гариг бүрд өдрийн хоолны дараа гонхонд бүсгүй үйл мэтгэж байхад залуу эр түүнийг хичээнгүйлэн зугаацуулна. Хүүхэд шиг наадам хийдэг байсан бүсгүйгээ Пьетро Креспи огт өөр нүдэрэ олж харжээ. Тэрбээр гунхалзсан сайхан бус боловч хүний аяыг олж чаддаг, цаанаа наалаинхай, ялдам ажээ. Пьетро Креспи, Амрантаг сууя гэж гуйна гэдэгт хэн ч эргэлзэхгүй байлаа. Үнэхээр ч, нэг удаа ням гаригт өөртэйгөө суугаач гэж түүнээс гуйжээ. Амаранта ажлаа хийсээр чихнийхээ улайхыг болихыг хүлээж хоолойгоо төв, тайван болгож,

- Суулгүй яах вэ ээ, Креспи. Гэхдээ бид бие биеэ сайн мэдэх хэрэгтэйшүүдээ. Яарвал даарах гэж үг бий гэж хэлжээ.

Урсула бүрэргэж хоцров. Пьетро Креспийг хичнэн хүндэтгэдэг боловч Урсула түүнийг Ребекатай гэрлэхээр болсноо гэрлэж чадахгүй уадж баахан будилсны дараа Амарантатай суух гэх нь ёс суртахууны үүднээс үзвэл зөв үү буруу юугэдгийг яагада ч оноож чадахгүй байлаа. Тэгж тэгж өөртэй нь адилхан эргэлзэх хүн гаргасангүйд Креспийн Амарантагийн гуйсныг буянаараа болог гэх байдлаар бодож санасан юмгүй зөвшөөрчээ. Гэтэл өрхийн тэргүүн Аурелиано:

- Одоо хурим бодож байх цаг биш гэж учир нь мэдэгдэхгүй эрс тэс цааргалаад эхийнхээ сэтгэлийг бүр үймрээж орхив.

Хуримын төдийгүй, дайнаас бусад ямар ч явдлын талаар Аурелиано тэр үед үүнээс өөр юм хэлж чадахгүй байсныг Урсула хэдэн сарын дараа л ойлгожээ.

Хэдэн жилийн хойно хайсны дэргэд буудуулах гэж зогсохдоо Аурелиано үнэхээр гарцаагүй атлаа үлмэдэгдэх ямар учралаар энд ирснээ өөрөө сайн тайл чадахгүй байж билээ. Ремедиосын үхсэнд санаснаас гайгүй үймэрчээ. Эхлээд дотуур нэлээд автсан боловч яваандаа мартагнаад, найдаж байснаа бүтээгүйд гутрангуй, эмэгтэй хүнтэй хавьтахгүй гэж шийдэж байсан үеийнх шигээ сэтгэл алдрангуй гэж шийдэж байсан үеийнх шигээ сэтгэл алдрангуй болжээ. Тэгээд ажилдаа л бие сэтгэлээ зориулах болсон боловч хадам эцэгтэйгээ даалуу тоглодоогоо больсонгүй билээ. Гашуудлын анир чимээгүйд умбасан байшинд үдшийн цагаар ярилцаж суусаар эрчүүл улам ч дасжээ. "Аурелиано минь, даид эхнэр ав аа. Нададзургаанохин байна, дуртайгаа ав гэж дон Аполинар Москоте хэлнэ. Сонгуулийн өмнө Макондогийн түшмэл мужийн төв ордгоороо ороод улс орныхоо улс төрийн байдалд сэтгэл их зовчихсон буцаж иржээ. Либералууд дайн өдөөхгэж бэлтгэж байлаа. Тэр үед Аурелиано консервативчууд, либералуудын тухайн тун бүдэг бадаг төсөөлөлтэй байсан учир хадам эцэг нь эдгээр намын ямар ялгаатайг ерөнхийд нь хэлж өгчээ. Либералууд байна шүү, дураараа улс, олхиогүй хүмүүс, лам нарыг дүүжилж, иргэний гэрлэх салахыг члөөтэй болгож, эцэгтэй, эцэггүй хүүхдүүдийн тэгш эрхийг тогтоож, дээд засгийн газрыг унагаан улс орныг хувааж холбооны улс болгох гэж байгаа юм гэж түүнд ярьжээ. Консервативчууд бол тэдэнтэй адилгүй, тэнгэрийн мутраас төрийн жолоог гардан авсан, нийгмийн тогтвортой хэв журам, гэр бүлийн журамт ёсыг тогтоохыг нолмож, христос тэнгэр хийгээд засгийн эрх барих зарчмыг хагмаалж, улс орныг тасчуулахыг хүсэж байгаа юм гэж тайлбарлаж өгчээ. Хүнлэг сэтгэлтэйн улмаас Ауреленаино бутач хүүхдийн эрхийг хамгаалах талаар либералуудад талтай байсан боловч тараар бариад авч болохгүй хийсвэр юмны төлөө дайн дэгдээх дээр хүрнэ гэж ойлгохгүй балаа. Сонгуулийн үеэр лус төрийн ямар ч баримталалгүй хотод, хадам нь нэг түрүүчээр даргалуулсан зургаан зэвсэгт цэргийг шаардаж авчирсан нь дэндсэн юм шиг санагдлаа. Цэргүүд ирээд зогсоогүй бүх айлын нэгжиж, ангийн буу, хадуу, тэр ч байтугай хоолны хутга хүртэл хурааж, дараа нь консервативчуудаас нэр дэвшигчдийн нэрс бүхий хөх, либералуудаас нэр давшигчдийн нэрс бүхий ягаан хуудсыг хорин хороос дээш насны бүх эрчүүлд тарааж өгөв. Сонгуулийн өмнөх бямба гаригт дон Аполинар Москоте шөнө дундаас эхлээд дөчин найман цагийн турш согтууруулах ундаа зарах, нэг гэрийн улс бус бол гурваас дээш хүн цугларахыг хориглосон хуулийг өөрийн биеэр дуудаж танилцуулав. Сонгууль тайван өнгөрлөө. Ням гаригийн өглөө найман цагт талбай дээр зургаан цэргээр мануулах модон хайрцаг тавив. Нэг хүн саналаа хоёр өгчих болуужин гэж Аурелиано хадатмагйаа өдөржин шахам хайрцагны хажууд зогссон болохоор санал өгөх ажил туйлын чөлөөтэй байсныг биеэр үзэв. Дөрвөн цагт санал хурааж дууссаныг бмбөрийн дуугаар мэдээлж, дон Аполинар Москоте өөрийн гарын үсэгтэй тэмдгээр хайрцгийг лацдав. Орой нь тэрбээр Аруелианотой

даалуу тоглож суухдаа алцыг авч, саналыг тоол гэж түрүүчид тушаалаа. Ягаан хуудас хөтэй бараг тэнцүү байсан боловч түрүүч ягаан хуудсаас зөвхөн арвыг үлдээгээд хөхийн дутсаныг нөхөв. Дараа нь хайцгийг шинээр лацдаад маргааш үүр хаяарч байхад мужийн төв авч явав.

“Либеарууд дайн гаргана даа” гэж Аурелиано хэлжээ. Аполинар модоо харсан чигээрээ “Хуудсыг сольсноос дайн гарн агж бодож байгаа бол үгүй Тэднийг хэл ам гаргуулахгүй гэж хэдэн ягааныгхайрцагт үлдээсэн шүү дээ” гэж хэлсэнд Аурелиано сөрөх хүчний байдал ашиггүй байгааг дотроо тунгаагаад “Би л либерал байсан бол энэ хуудасны явдлаас л дайн үүсгэх байсан” гэж хэлжээ. Хадам нь шилнийхээ дээгүүр харж,

- Ай, Аурелиано минь, чамайг либерал байсан бол хчэнээн хүргэн минь ч гэсэн хуудас сольж байгааг харуулахгүй байсангэж хлэжээ.

Хотынхон сонгуулийн дүнд дургүйцсэнгүй,хурааж авсанхтуга, ангийн бууг цэргүүдийн эргүүлж өгөхөөс татгалзсанд дургүйцжээ. Эмэгтэйчүүд Аурелианоогоос хадамдаа хэлэд ядахдаа хоолны хутгыг эргүүлж өгүүлээч гэж гуйжээ. Цэргүүд дайнд либералуудын бэлтгэж байгаагийн эд мөрийн бармит болгож, хураасан зэвсгийг аваад явчихсан гэж дон Аполинар Москоте хүргэндээ ихэд аминчлан хэлжээ. Энэ хэлж байгаа зүйл даанч увайгүй байсанд залуу дотроо дургүй хүрч байжээ. Тэгэхдээ Аурелиано юу ч хэлсэнгүй боловч нэг орой Геринельо Маркес, Магнифико Висбаль хоёр амьхнаараа хоолны хутагын явдлыг хэлэлцэж байхдаа өөрөөс нь либерал уу, консерватив уу гэж асуусанд хором ч тээнэгэлзсэнгүй.

- Энэ хоёрын аль нэг нь болох албатай бол либерал болсон минь дээр. Консервативчууд чинь луйварчин байдаг юм байна гэж хэлжээ.

Маргааш нь нөхөд түүнийг Алирио Ногера докторынд очоод “Элгэн дээр өвдөөд байна, үзэж өгөөч” гэж гуй гэж шахсаар байгаад очуулжээ. Ингэж худал хэлэх ямар хэрэг байсныг Аурелиано огтойлгохгүй байлаа. Алирио Ногера доктор хэдэн жилийн өмнө хэсэг амтгүй үрэлтэй, “Хорыг хороор тайлдаг” гэсэн нэлээд ойлгомжгүй эмнэлгийн уриатайгаар Макондод иржээ. Үнэндээ бол Ногера эмч болж тогложээ. Бүтэлгүйхэн эмчийн гэмгүй царайн цаана эсрэг үзэлтэн нуугдаж байжээ. Таван жил цөллөгөнд байхдаа тушаанд үрэгдсэн шилбэнийхээ сорвийг өдгөө хүрсэн түрийтэй оймсоор халхалж явна. Холбооны үзэлтнүүдийн эхний үймээний дараа түүнийг баривчлахад хамгийн үзэж чаддаггүй ламын нөмрөг өмсөн Кюрасао руу оргож чаджээ. Харьд удтал цагаачлан явсны эцэт Карибын тэнгисийн бүх арлаас Кюрасаод цугларсан лус төрийг дүрвэгсдийн хэлж ирж байгаа баяртай мэдээнд зоригжсон тэрбээр хулгайн тээвэр хийдэг далбаат онгцонд сууж, дан элсэн чихрээр хийсэн үрэл дүүргэсэн баахан гожгор шил, өөрөө дуурайлгаж хийсэн Лейпцигийн их сургуулийн дипломтойгоор Риоачад иржээ. Риоачад ирээд урам нь хугарсандаа

тэр ч байтугай уйлжээ. Цагаачид холбооны үзэлтнүүдийг дэлбэрэхэд бэлхэн даринь агуулахтай зүйрлэж байсан боловч тэ дсонгуулийн өмнө бүдэг бадагхан найдвар төрүүлсэн байдал үүссэн дхууртаад гал цог нь нэгэнт унтарсан байлаа. Зорьсоноо бүтээгүйд урам хугарсан хуурамч эмч насныхаа мухрыг туайван үзэх найдвартай газрыг л ганцхан мөрөөдсөндөө Макондод бүгжээ. Тэрбээр хэдэн жил хотын талбайн ойролцоох байшинд хоосон шил дүүргэсэн цухалхан өрөөнд эрлэгийн дансанд хэдийн орчихсон өвчтөнөөс авсан барьцаараа амь зуудаг байжээ. Цаадуул нь хамаг гоочоо бараад чихэрт үрлээр сэтгэлээ хуурах болжээ. Дон Аполинар Москоте эрх барьдаг нэрнээс цаашгүй болохоор эмч ухуулга хийх авьяасаа гаргах хэрэггүй байв. Хамаг цагаа дуртгал бичи, мэнгэртэй тэмцэхэд зориулна. Сонгууль ойртсон нь засгийн тулгуурыг унагах утасны учгийг дахин олоход тусалжээ. Тэрбээр улс төрийн бодлого сайн мэдэхгүй хотын залуучуудтай холбоо тогтоож, өдөө хатгах нууц, шаргуу ажил хийв. Сонгуулийн хайрцаг байсан, залуучуудын хөнгөн зан гэж дон Аполинар Москотегийн үзсэн олон ягаан хуудас бол Ногерагийн төлөвлөгөөний нэг хэсэг байсан бөгөөд сонгууль гэдэг нүд хурсан зүйл гэдгийг өөрсдөө үзэж мэдэг гэж шавь нараараа санал өгүүлсэн нь тэр байжээ. “Хүбч хэрэглэх л ганц явууртай зүйл” гэж тэдэнд хэлдэг байлаа. Аурелианогийн найз нарынхаа олонх нь консерватив байгууллыг устгахын хүслэн болж байсан боловч, вангийн түшмэлтэй холбоотойгоос нь төдийгүй зожиг, булзаарамтгайгаас нь цэрвээд түүнд тэр туха ярьдаггүй байжээ. Түүний дээр аурелиано хадмынхаа заавраар хөх хуудсаар саналаа өгсөн нь тодорхой байлаа. Тийнхүү огт санамсаргүйгээр улс төрийн талаархэнийг найршаадаг нь илэрч, тэрч зөвхөн сониуч зандаа хөтлөгдөж, хүрээгүй өвчнөө эмчлүүлнэ гэж эмчийн очин ойворгон юм хийжээ. Аалзны шүлс, гавар ханх тавьсан, нохойн хороо шиг бохир тасалгаанд орвол хөширсөн игуан гүрвэлийн бйдалтай амьтан харагдаж, цээжээ хэрэжгэнүүлэн хяхтнуулан амьсгаадах нь сонсогджээ. Доктор Аурелианог юу ч хэлэлгүйгээр доод зовхины нь дотор талыг эргүүлэн үзсэнд Аурелиано нөхдийнхөө өөрт нь зааж өгснөөр “Тэнд өвдөөгүй ээ” гэж хэлээд “Энд өвдөөд унтуулахгүй байна” гээд хурууныхаа өндгөөр элгэн тус даржээ. Тэгэхд НОгера эмч “Тасалгаанд нар дэндүү ороод байна” гэж шалтаглан цонхоо хаагаад, эх оронч хүн яагаад консервативчуудыг алах ёстойг энгийн үгээр тайлбарлажээ. Хэдэн өдрийн турш Аурелиано цамцныхаа халаасан дшилтэй үрэлч авч явав. Хоёр цаг тутамд шилээ гаргаж, алган дээрээ гурван мөхлөг сэгсэрч унган ам руугаа шидээд хэлэн дээрэ эудаан уусгадаг байв. Дон Аполинар Москоте түүнийг хуурамч эмчид итгэлээ гэж дооглох боловч, хуйвалдаанд оролцогчид өөрийнталын хүн гэж үзэж байлаа. Макондогийн хуучцуулын бүххүүхэд хуйвалдаанд татагдан орсон боловч хэн нь ч чухам юу хийхээ сайн мэдэхгүй байжээ. Гэвч эмчийг нууцаа хэлэхэд Аурелианго дороо хуйвалдаанаас гарав. Аурелиано консервативчуудын дэглэмийг устгах хэрэгтэй гэдэгт итгэж байсан боловч эмчийн сэдэж байгааг дуулахдаа хиртхийн цочжээ.

Алирио Ногера бол ганц ганцаар нь алах талын хүн байжээ. Тэрбээр хэдхэдэн хүний амь насанд халдах явуулгыг уялдаатай үйлдэн, улмаар нийт үндэсний нэгдсэл цохиолт болгон лавшруулж, засгийн газрын бүх түшмэлийг гэр орныхны нь хамт, ялангуяа нуган хүүхдийг нь устгаж, ингэснээр консерватив үзлийн үрийг үндсээр нь таслах төлөвлөгөөтэй байжээ. Дон Аполинар Москоте гэргий, охидын хамт, мэдээж, тэр хар дансанд орсон байлаа.

- Та үхсэний нь либерал байх вэ, ердөө л яргачин байна гэж Урелиано нүүрээ ч хувиргалгүй хэлэхэд,
- Тэгвэл шилийг минь буцааж өг. Одоо энэ чамд хэрэггүй гэж эмч мөн л тайван өгүүлжээ.

Эмч түүнийг ажилд ямар ч нэмэргүй, бөгс удаантай, бүр ганцаараа байгаад сурчихсан, нялуун зантай бүтэлгүй амьтан гэж хэлснийг Аурелиано хагас жилийн дараа л сая мэдэж билээ. Нөхөд нь Аурелианог хуйвалдааныг илчилж болзошгүй гэж болгоомжлон айлгах гэсэн боловч цаадах нь хэн ч хэлэхгүй гэж тайвшруулаад харин Москотегийнхныг нухахаар очих шөнө тэднийг хаалган дээр нь тосож, үүдийг хамгаална гэдгээ хэлжээ. Хуйвалдагчид тийнхүү шийдэмгий байгаад нь хулчийж, төлөвлөснөө тодорхойгүй хугацаагаар хойшлуулжээ. Чухамхүү яг энэ үед Пьетро Креспи, Амаранта хоёрын хуримын туахй Урсула өөртэй нь зөвлөхөөр орсонд “Ийм юм бодож байх цаг биш” гэж харилусан ажээ. Аурелиано галавын үеийн гэмээр гэр бууг бүтэн долоо хоног өвөртлөн нөхдийнхөө байрыг ажин явжээ. Тэрбээр үдийн хоол идчихээд, гэрээ жаал зугаа өөд тата хболсон Хосе Аркадио, Рбека хоёрын кофе уухаар орж, оойн зургаан цагаас хойш хадамтайгаа даалуу тоглохоор очдогб айлаа. Өглөө нь цай ууж байхдаа томоо эр болсон Аркадпиотой ярилцвал цаадах нь дайн гарах нь гарцаагүй болж ирж байгаад ула хөөрөх болсныг мэджээ. Багшаасаа оон ах, сахалдаа тор очихоор болсон данхайсан хар юмнууд дөнгөж хэлд орж байга хүүхэдтэй хамт сурдаг сургууль дээрээ Аркадио либериалзмын халдвар авчээ. Тэрбээр “Никанор ламыг буудаж алаад, сүмийг нь сургууль болгож, хайр сэтгэлийг чөлөөтэй гэж зарлана” гэж донгосно. Аурелиано омгийг нь дарах гэж хичээж, түүнийг дотроо бодолтой, дороо суурьтай байхыг зөвлөсөн боловч Аркадио тайван учирлан, ухаалаг юм хэлж байгааг нь шал тоохгүй бүүр ах захаа алдаж түүнийг зүрх зориггүй гэж зэмлэжээ. Аурелино байрыгхарж байлаа. Тэгж байтал арван хоёрдугаар сарын шинэдээр Урсула ихэд сандарчихсан, урлан орж ирээд,

- Дайн гарчээ! Гэж хэлэв.

Үнэндээ бол дайны эхлээд гурван сар болсон байлаа. Улс орон даяар дайны цагийн байдал тогтоосон байлаа. Макондод үүнийг ганцхан хүн цагт нь мэдсэн нь дон Аполинар Москоте байлаа. Гэвч тэрбээр хотод гэнэдүүлэн орж ирэх тушаалтай баг цэрэг ирэхийг хүлээн, энэ тухай эхнэртээ ч хэлэхээс

хаширлажээ. Үүрийн таван жингээр цэргүд хоёр хөнгөн үхэр бууг луусаар чирсээр хотод сэмхэн орж ирээд, сургуулийн байранд хуарагнан буув. Оройн зургаан цагаас хойш хөл хорив. Айл бүрийг түрүүчийнхээс шийдэмгий нэгжиж, энэ удаа газар боловсруулдаг багажийг хүртэл хураав. Ногера эмчийг гэрээс нь чирч гулдран гаргаж ирээд, хотын талбай дээр модонд барьж хүлэн, шүүж байцаалгүй буудаж орхив. Никанор лам хөөрдөг идээ үзүүлэн тэдэнд нөлөөлөх гэсэн боловч нэг цэрэг бууныхаа бөгсөөр толгой руу нь байлгаад авав. Либералууд могой нь дарагдаж, айсандаа нам жим болов. Баргар царайлан, дуугаа хураасан Аурелиано хадамтайгаа даалуудсаар байлаа. Дон Аолинар Москоте хтын иргэний ба цэргийн захирагчийн хэргэм хүртсэн хэдий боловч дахиад л нэр хүлээснээс цаашгүй байгааг Аурелиано ойлгож байлаа. сумангийн захирагч бүх юмыг шийдэж, өглөө бүр нийгмийн хэв журам сахиулагчдын хэрэгцээнд зориулж авах шинэ онцгой татварыг бодож олж байлаа. Түүний дөрвөн цэрэг галзуу нохойд зуулгасаан эмэгтэйд гэрийнхнээс нь булаанавч, шууд гудамжнаа бууны бөгсөөр үхтэл занчжээ. Хот тийнхүү эзлэгдсэнээс хойш хоёр долоо хоноод ням гаригт Аурелиано Гернельдо Маркесийнд ирж, аяга чихэргүй кофе ууж гэж сурсан зангаараа ихэд болгоомжлонгуй гуйжээ. Гал тогоонд хлуулахнаа үлдэхдээ Аурелиано “Залуусыг бэлд. Бид дайнд мордон” гэж урьд ер анзаарагддаггүй байсан захирангуй аялгуугаар хэлжээ. Геринельдо Маркес түүнд итгэсэнгүй,

- Ямар зэвсгээр байлдах юм? Гэж асуусанд Аурелиано:
- Тэдний зэвсгээр гэж хариулжээ.

Мягмар гаригийн шөнө гуч хүрээгүй насны хорин нэгэн залуу Аурелиано Буэндиагийн удирдлагаар хоолны хутга, үзүүрлэсэн төмөрөөр зэвсэглэн, суманг гэнэдүүлэн эзэлж, буу зэвсгийг нь аваад, эмэгтэйд алсан дөрвөн цэргийг ахмадтай нь хамт талбай дээр буудан хороож, санаанд багтамжгүй нь хамт зоригтой юм хийжээ.

Тэр шөнө талбай дээр буун дуу намдаагүй байхад Аркадио Макондогийн иргэний ба цэргийн захирагчаар томилогдов. Эхнэртэй босогчид тэдэнтэйгээ салах ёс дөнгөж гүйцэтгэсэн болоод зөн нь мэдэг гээд охихоос өөр аргагүй болов. Аурелианогийн баг аллага хядлагаас ангижирсан зон олноороо үдүүлэн Манауре руу хөдөлсөн сурагтай байгаа хувьсгалч генерал Викторио Мединий цэрэгтэй нийлэхээр Макондогоос үүрээр хөдлөв. Явахынхаа өмнө Аурелиано дон Адолинар Москотег шүүгээнээс гаргаж ирээд “Хадам минь, бүү ай. Шинэ засаг танд, танай гэрийнхэнд гар хүрэхгүй гэдгийг тангаргалаж байна” гэж хэлжээ. Урт түрийтэй гутал өмсөж винтов үүрсэн босогч, оройн есөн цаг хүртэл даалууддаг байсан хүргэн хоёр нь нэг хүн гэдгийг дон Адолинар Москоте арайхийж танив.

- Аурелиано, энэ ойворгон явдал! Гэж дуу алдахад Аурелиано

- Энэ ойворгон явдал биш ээ. Энэ бол дайн. Намайг үүнээс хойш Аурелиано гэж бүү дуудаж бай. Одоо би хурандаа Аурелиано буэндиа болсон гэж хэлжээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Хурандаа Аурелиано Буэндиа гучин хоёр зэвсэгт бослого гаргаад гучин хоёуланднь ялагджээ. Тэрбээр арван долоон өөр эмэгтйгээс арван долоон эрэгтэй хүүхэдтэй болсон боловч, ууганыгаа гучин тав ч хүрээгүй байхад тэд нь ганцхан шөнө цөм алагджээ. Тэр өөрөө амийг нь хорлох гэж арван дөрвөн удаа оролдоход ч, далан гурван удааотоонд орсон ч, цаазлуулах ял заагдсан ч, нам алахаар хүлцэлтэй кофе уусан ч амьд үлджээ. Улсын ерөнхийлөгчийн шагнасан Хүндэтгэлийн одонг авахаас татгалзжээ. Улс орондоо шүүхийн ба цэргийн хэмжээлшгүй эрх дархтай хувьсгалт цэргийн ерөнхий дээд командалгч, засгийн газрынхны зүрхийг авсан хүн болсон боловч хэзээ ч зураа авахуулсангүй. Дайны дараа насан туршид нь тэтгэвэр олгоход авалгүй, насан зүг болтлоо Макондо дахь урландаа алтан загас хийн орлогоор нь амь зуужээ. Ямагт цэргийнхээ магнайд тулалдаж явдаг байсан боловч ганцхан шарх олсон нь хорь шахам жил үргэлжилсэн иргэний дайныг дуусгаж, Неерландад бууж өгөх гэрээнд гарынүсэг зурсныхаа дараа өөрөө өөрийгөө буудсанаас олсон шарх байжээ. Цээж рүү буудсан гар бууны сум нурууг нь нэвт гарсан боловч амин газрыг нь оноогүй байжээ. Энэ бүхнээс үлдсэн юм гэвэл түүний нэртэй ганц гудамж л Макондод байлаа. Өвгөрч үхэхрийнхээ өмнө өөрийн нь хэлснээр, тэр өглөө хорин нэгэн хүнтэй багаа авч генерал Викторио Мединий цэрэгтэй нийлэхээр Макондогоос явахдаа ингэнэ гэж бодоогүй ажээ.

Чвахдаа Аурелиано Аркадиод:

- Хотыг бид чамд даатгаж орхилоо. Ёс журам тогтлоо, биднийг эргэж ирэхэд улам сайн болсон байх ёстой гэж л хэлжээ.

Аркадио түүний захиасыг тун өвөрмөцөөр ойлгожээ. Мелкиадесийн нэг номын эрээн хавчуулгаас санаа авч маршалын хиаз, эполеттэй дүрэмт хувцас өмсөж, буудуулсан ахмадын алтан цацагтай сэлэм бүсэндээ агсаж явах болов. Дараа нь хоёр үхэр бууг хотын хаалган дээр зоож, өөрийнх нь урианд урамшин хөөрсөн хуучин шавь нартаа цэргийн дүрэмт хувцас өмсгөн зэвсэг бариулж, хүн гаднаас харахад хотыг авахын аргагүй мэт бодогдуулах гэж тэднийг гудамжаар сэлгүүцүүлдэг байв. Түүний энэ заль хоёр талтай болсон нь, юу гэвэл үнэхээр ч засгийнгазар бүтэн жил шахам Макондо цайзыг дайрах тушаал өгөхөөс зүрх алдсан боловч, тэгж тэгж нэг шийдэхдээ хот руу маш их

хүч хаяж, эсэргүүцлийг хагасхан цагийн дотор нуга даржээ .Аркадио эрх барьсан цагаасаа хууль дүрэм удрдах дуртай байлаа. Заримдаа санаандаа орсонбүхнийг тушааж, өдөрт дөрөв хүртэл хууль тунхаглана. Тэр арван найман наснаас заавал цэргийн алба хаадаг болгож, оройн зургаан цагаас хойш гудамжаар явсан малыг нийгмийн хөрөнгө гэж зарлаж, ахимаг насны хүмүүсийг ханцуйдаа улаан даавуу хадаж явахыг үүрэг болгов. Никанор ламыг гэрт нь хорьж, “Гарвал буудаж ална” гэж сүрдүүлээд, либералуудын ялалтыг ёслон тэмдэглэх үед л хурал хурж, хонх дэлдэхийг зөвшөөрчээ. Аркадио огтхон ч тоглох бодолгүй байгаа гэдгээ бүгдэд ойлгуулахын тулд хотын талбай дээр мануухай буудаж сургууль хийхийг тасаг цэрэгтээ тушаажээ. Эхлээд үүнийг нь хэн ч юманд бодсонгүй. Тэр цэрэг нь явж явж том хүн болон тоглож байгаа сурагч багачуул л байлаа. Гэвч нэг шөнө Аркадиог Катариногийн газарт ороход найрал хөгжмийн бүрээч шинээр тохоон томилогдсон захирагчийг бүрээ татан угтаж олныг нээлгэжээ. Аркадио эрх баригчдыг хүндэлсэнгүй гэж бүрээчинг буудахыг тушаав. Түүнийг нь зориглон эсэргүүцэгчдийг гавлаад сургуулийн нэг танхимд хорьж, “Талх уснаас өөр юм бүү өг!” гэжээ. Түүний дураар авирласныг дуулах бүрийдээ Урсула “Муу алуурчин!Аурелиано мэдэх юм бол чамайг буудаж, минийнар гэанц гарна гарн адаа” гэж аашилдаг байлаа. Гэвч яагаад ч нэмэр байхгүй. Аркадио огт хэрэгцээгүй байхад харгис явуулгаа чангалан чангалсаар Макондод байсан захирагчдын дотроос хамгийн хүний үнэргүй нь боллоо. “Одоо тэ ялгааг нь олж мэдээ. Либералын энхжин гэдэг нь энэ” гэж Аполинар Москоте нэг удаа хэлжээ. Аркадиод нэг нь алтан хошуу хүргэсэн байлаа. Тэрбээр эргүүлийн цэргээ тэргүүлэн, дон Аполинар Москотегийнд дайран орж, тавилгыг нь зомгол болгон, охидыг нь занчаад, вангийн хуучин түшмэлийг гудамжаар хуаран тийш чирч гулдран авч явав. Энэ явдлыг Урсула дуулаад ичиж зовсондоо орь дуу тавьж, давирхайдсан ташуураа ууртайяа гозгонуулан, хот дундуур ааг амьсгаагүй гүйсээр хуарангийн хашаанд харайлган орвол тасаг дон Аполинар Москотег буудахаар нэгэнт жагсаж, Аркадио буудах тушаалыг биеэр өгөх гэж байлаа.

- Тэгээд үзээрэй, муу зулбадас! Гэж Урсула зандрав.

Аркадио сэхээ авч амжаагүй байтал бухын шөрмөс гөрж хийсэн хүнд ташуур тасхийн буудлаа. “Муу алчуурин, тэгээд үзээрэй. Муу гөлөг, намайг ч бас алаад аль,. Ийм магасыг юунд өсгөлөө гэж ядахда аичиж улайхгүй байхгүй юу” гэж аашилсаар Аркадио нүүр нүдгүй шавхуурдаж, хашааны хамгийн алсын булан руу зугтан эмгэн хумс шиг атиран шигдтэл нь хөөн ороолгов. Урьд нь салам болтол буудуулсан мануухай өлгөөтэй байсан модонд хүлүүлсэн дон Аполинар Москоте ухаангүй байлаа. Тасгийн залуус Урсулаг уурынхаа хагасыг өөрсдөд нь гаргаж магадгүй гэж айгаад бут үсрэн зугтав. Гэвч Урсула тэдний зүг харсан ч үгүй, өвдсөн, уурласан хоёртоо урхиран байгаа Аркадио орхин дон



Аполинар Мостотегийн хүлээснийг тайлан, тэнхрүүлээд гэр рүүгээ авч явав. Хурангаас гарахдаа тэнд гав дөнгөтэй байсан бүх хүнийг суллав.

Үүнээс хойш Урсула хотын хэргийг эрхлэх болов. Ням гаригийн мөргөлийг сэргээж, ханцуйд улаан даавуу уяж явдгийг болиулж, Аркадиогийн хатуу хуулийг хүчингүй гэж зарлав. Урсула хэчнээн хатан зориг гаргала ач гэсэн заяа муутайдаа сэмхэн уйлдаг байлаа. Бүр ганцаардахдаа туулайн бөөр модны дор мартагдсан нөхөртэйгөө ярьж сэтгэлээ зогоодог болов. Далдуу модны навчаа хийсэн саравчийг хуу татам зургадугаар сарын аадрын шаагих чимээн дунд тэрбээр “Бид ийм л юм үздэг байж дээ. Хүүхдүүд минь мөр мөрөө хөөн тарж, гэр минь хайхараад дахиад л чи бид хоёр хоёулахнаа үлдлээ” гэж ярихад Хосе аркадио Буэндиа ухаангүй гөлийсөн чигээрээ, түүний гомдоллох үгийг тоосон ч шинжгүй байх ажээ. Буэндиа сандал дээрэ эсууж, Урсула түүний гар, хөл, биеийг ээлжлэн угаангаа гэрийнхээ явдлыг ярина. “Аурелиано дайнд яваад дөрвөн сар болж байгаа боловч сураг ажиг байхгүй л байна, Хосе Аркадио буцаж ирсэн. Чамаас л өндөр болжээ. Хамаг бие нь шивээс ээ. Ганцхан гэр орныхныхоо нэрийг хөөдсөнөөс л цаашгүй” хэмээн нөхрийнхөө нурууг савандсан алчуураар үрэнгээ ярина. Усан амлахад нь нөхрийнх нь санаа зовж байх мэт санагдахад түүнийг хууран “Би л худал бурж байхгүй юу, надад бүү итгэ. Хосе Аркадио, Ребека хоёр гэрлэсэн, тэнгэр тэгж таалсан юм байлгүй дээ, тэр хоёр жаргалтай сайхан байгаа” гэж ялгадсан дээр нь үнс цацан хүрээр авангаа ярина. Тэр бүр үнэмшмээр худал хэлж сураад, сүүлдээ түүгээрээ сэтгэлээ хуурах болов. “Аркадио их буурьтай, маш зоригтой эр болсон. Дүрэмт хувцсаа өмсөөд сэлмээ зүүчихлээр үү!” гэж ярина. Энэ нь үхсэн хүнтэй ярьж байгаатай адил байлаа. Учир нь Хосе Аркадио Буэндиа юунд ч баярлаж, юунд ч гутрахаас өнгөрчээ. Гэвч Урсула нөхөртэйгөө ярьсаар л байлаа. Түүний туйлын номхон, юуг ч мэдэхээ больсныг үзэхдээ хүлээснийг нь тайлахаар шийдэв. Хүлээсийг нь тайлсан ч байрнаасаа хөдөлсөнгүй. Нүдэнд үзэгдэх ямар ч хүлээснээс илүү хүчирхэг хүч туулайн бөөрөнд түүнийг хадсан учир тэр олс ямар ч хэрэггүй байсан мэт нар бороонд суусаар л байлаа. Өвөл их л урт болох нь гэж хүн бүрд санагдах болсон наймдугаар сард Урсула өөрийн үнэн гэж бодсоноо нөхөртөө хэлжээ.

- Биднийг аз дан дагаж байх юм аа. Нөгөө оньст хууртай ноцолдоод байдаг итали хүү Амаранта хоёр удахгүй гэрлэнэ гэж хэлжээ.

Пьетро Креспид Урсула итгэн, ирэхэд нь харж цагдаад байхын хэрггүй гэж үзэж байснаас Амаранта тэр хоёр бие биедээ үнэхээр ойр дотго болжэ. Гэвч хүргэн болох эсэх нь үл мэдэгдэнэ. Пьетро Креспи захан дээрээ жүрүрийн цэцэг хадан үдэш ирж, Амарантад Петраркагийн арва арван дөрвөн мөртийг орчуулж өгнө. Хоёул шумуул хөдөлж зочдын өрөөнд орохоос араггүй болох хүртэл сарнай, хахууна ханхалсан гонхонд сууцгаана. Эрэгтэй нь ном уншиж, эмэгтэй нь зүүгээр тор нэхэж дайн дажны эргэж хувирах дээр доороо орохыг ер

анзаарахгүй байлаа. Залуу эр Амарантагийн уриалгахан ааш, даруухан боловч сэтгэлийг зугуухан эзэмдэх ялдам занд батгана аалзны шүлсэнд орох адил оосорлогдо жнайман цагт явахаар босох бүрийдээ үл үэгдэх энэ торыг биеэсээ салгах гэж зүдрэх болжээ. Амрантатай хамт тэрбээр Италиас авсан ил захидлын хуудсаар гайхалтай сайхан цомог хийжээ. Цэцэрлэгт хүрээлэнгийн мод цэцгийн дунд буйдхан нэг буланд суугаа дурлалт хос, сум сүлбэсэн зүрх буюу хоёр тагтаа үзүүрийг нь хошуундаа зуусан алтадсан тууз хуудас бүр байна. Пьетро Крреспии ил захидлын хуудсыг нэг нэгээр нь үзүүлэнгээ “Флоренцийн энэ цэцэрлэгт хүрээлэнг би мэднэ. Гараа сунгахад шувууд нь талхны үйрмэг идэхээр нисэж ирдэг юм” гэж ярина. Заримдаа Венецийн усан будгийн аль нэг зургийг харж эх нутгаа санан мөрөөдөхдөө, сувгаас ханхлах замаг, далайн ялзарсан дунгийн үнэрийг сэтгэлдээ цэцэгсийн анхилуун үнэр шиг болгон боддог байлаа. Амранта санаа алдаж, инээж, хүүхдийн хэлээр ярьдаг гоё бүсгүйчүүл, бүсгүйчүүлийн эн эорон, урьдын сүр жавхлангаас нь хог ухсан мигуйгаас өөр эм үлдээгүй эртнийхотыг мөрөөднө. Пьетро Креспи хайр сэтгэл эрж тангис далай гатласны эцэст, Ребекатай яарч тэвдэн, адтай шунан үнэсэлдэж байснаа хайр сэтгэл гэж эндүүрч явсны эцэст жинхэнэ хайр сэтгэлтэйгээ сая учирчээ. Аз нь гозойгоод ирэхээр ажил үйлс нь мандаад өгөв. Пьетро Креспийн дэлгүүр бараг бүтэн дүүрэг эзэлж, жинхэнэ уран сэтгэмжийн цоморлиг болжээ. Тэнд Флоренцийнхийг яг дуурайлган хийсэн цаг цагт жингэнэн дуугардаг хонхны гонхон, Сорентын хөгжмийн хайрцаг, тагийг нь нэхээд таван өнгөөр ая тоглодог хятад ооны хайрцаг, дүрслэн бодож болох хөгжмийн бүх зэмсэг, зохион бүтээж болох бүх оньст төхөөрөмжийг үзэж болох байлаа. Хөгжмийн сургууль эрхлэх авьяас байхгүй дүү Бруно Креспи нь дэлгүүрээ мэддэг байлаа. Түүний ачаар туркийн гудамж арилсан орон болж, тэнд орохдоо хүмүүс Аркадиогийн харгислал, алсын дайны гамшгийн аль алиныг нь мартагнадаг байлаа. Урсулагийн тушааснаар ням гаригийн мөргөлийг дахин хийх болсонд Пьетро Креспи сүмд германы хөөрөгт төгөлдөр хуур бэлэглэж, хүүхдийн найрал дууны хэсэг зохион байгуулж, Грегорийн дүйцэн өдрөөр уншдаг эгшиглэнт уншлагыг тэдэнтэй сургуулилсан нь Никанор ламын мөргөлийг нэлээд өөд татжээ. Амранат итали залуутай сууж жаргана гэдэг хэн ч эргэлзэхгүй байлаа Тэр хоёр сэтгэлээ яаруулалгүй зөнгөөр нь тавьж гэрлэх өдрийг товлон тогтоход бэлэн боллоо. Тэдэнд саад хийх хүн байхгүй байлаа. Ребкагийн хуримыг эцэс төсгөлгүй хойшлуулсаар амьдралыг нь үрсэн гэж өөрийгөө дотроо зэмлэж байсан Урсула дахиж сэтгэлдээ лай хураахыг хүсэхгүй байв Дайн дажин болж, Аурелиано явж, Аркадио харгис авирлан, Хосе Аркадио, Ребека хоёр гэрээс хөөгдсөнөөр Ремедиосыг үхэхэд зарласан гашуудал хойш тавигдав. Хурим заавал болно гэж Пьетро Креспи итгээд, Аурлениано Хосег бараг эцгээс нь дууугүй хайрлаж, том хүүгээ болгох бодолтой байгаагаа цухуйлгажээ. Бүгдээс үзэхэд Амранта насныхаа жаргалыг эдлэх дөхөж байна даа гэж бодогдохоор байв. Гэтэл сэтгэлэ эил гаргадаггүйгээрээ Ребекагаас өөр

байлаа. Тэрбээр ширээний бүтээлэг хээлдэг, гайхамшигтай гоё саа нэхдэг, вангийн тогосыг хэрээслэн хатгадаг шигээ тайвнаар Пьетро Креспийг сэтгэлээ барьж чадахгүй болохыг хүлээж байлаа. Түүний хүлээсэн цаг аравдугаар сарын ширүүнбороотой хамт ирлээ. Пьетро Креспи Амарантагийн өвдөг дээрээс хатгамалтай сагсыг нь авч, гарыг нь алгандаа атгаад “Цааш хүлэх тэнхэлгүй боллоо. Энэ сард хоёул гэрлээ” гэжээ. Бүсгүй Креспийн хүв хүйтэн гар хүрэхэд ч давхийсэнгүй, гараа түүний гараас эвтэйхэн аваад дахин ажлаа үргэлжүүлж,

- Юун гэнэхэн юм бэ дээ, Креспи! Чамтай сууснаас үхсэн минь дээр гэж инээмсэглэн хэлжээ.

Пьетро биеэ барьж чадсангүй. Огтхон ч ичиж зовох юмгүй енгэнэтэл уйлж, хуруугаа хугалчих шахан барилсан боловч бүсгүйн шийдсэнийг болиулж чадсангүй. “Хайран цагаа бүү үр ээ. Чи үнэхээр надад хайртай юм бол энэ гэрийн хаалгаар дахин бүү шагай” гэж Амаранта түүнд хариулжээ. Урсула ичсэндээ орох гарах газраа олж ядаж байлаа. Пьетро Креспи хамаг үгээ шавхан байж гуйлаа. Тэр ч байтугай бүршалдаа буув. Оройжин Урсулагийн хормойд толгойгоо хийн уйлжээ. Урсула түүнийг тайтгаруулж байвал сүнсээ ч худалдсан хамаагүй болжээ. Бороотой шөнөөр торгон шүхэр барин байшин тойрон хөлхөж, Амарантагийн цонх гэрэлтэй байна уу үгүй юу гэдгийг ширтэн явахыг хүмүүс хардаг байлаа. Пьетро Креспи хэзээ ч энэ хэдэн өдрийнх шиг гоё хувцаслаж байсангүй. Зовсон эзэн хааных шиг түүний сайхан толгой улам сүрлэг болжээ. Тэрбээр тагтад юм оёхоор ирсэн Арантагийн найз бүсгүйчүүдийг нь хоргоожээ. Тэгээд бүх ажлаа хаялаа. Өдөржин дэлгүүрийн арын өрөөнд сууж, галзуу юм шиг захиа бичиж, дотор нь цэцгийн илтэс, хатаасан эрвээхий хийн Армантад явуулах боловч захидал нь налттай хэвээрээ буцаж ирж байлаа. Хаалгаа түгжиж байгаад цитра даран хэдэн цагаар суучихна. Нэг шөнө тэр дуулж гарав. Макондогийнхон мэл гайхан сэрж, энэ ертөнцөд байшгүй цитрийн шидэт аялгуу, энэ дэлхийд байшгүй хүчтэй хайрын сэтгэл шингэсэн хоолойг уяран чагнажээ. Тэгээд Пьетро Креспи харвал ганц Амарантагийн цонхноос бусад бүх айлын цонх гэрэлтэй байлаа. Арван нэгдүгээр сарын хоёрт, үхэгсдэд буян үйлдэх өдөрдүү нь дэлгүүрийн хаалганы цоожийг онгойлгон орвол бүх дэнлүү асаатай, бүх хөгжим нь дуурагаарстай, бүх цагийн харанга зогсолтгүй хангинаастай байж, энэ хачин аялгуунаа арын өрөөнд Пьетро Креспийг бугуйнхаа судсыг огтлоод, анхилуун гүгэл дүүргэсэн угаагуурын төмпөнд хоёр гараа дүрээд үхчихсэн байхыг олжээ.

Австай хүүрийг Урсула гэртээ тавиулна гэсээр байгаад тавиулав. Никанор лам “Амиа тэвчсэн хүний хойтохыг унших, буян хийх, ариун газар оршуулах цээртэй” гэв. “Энэ хүн хутаг оршжэ. Чухам яаж ингэснийг та ч мэдэхгүй, би ч мэдэхгүй. Таныг хчнээн дургүйцлээ ч би түүнийг мелькаидесийн хажууд тавина.” Гэж Урсула зөрөв. Тэгээд ч салах ёс хийх сүртэй ёслолын дараагаар, хотынхны цөмийнх нь нэг дуугар сайшааснаар өөрийн хэлсэнд хүрчээ.

Амаранта унтлагынхаа өрөөнөөс гарахгүй байлаа. Орондоо байхад нь Урсулагийн цурхиран уйлах, гэрт цугларсан улсын явах, шивнэн ярих, уйлаачдын<sup>1</sup> гаслан орилох дуулдаж байснаа жигтэйхэн нам гүм болж, гагцхүү хөлд гишгэлэгдсэн цэцэгийн үнэр л ханхлах болов. Оройдоо лаваандын үнэр ханхлаад байх шиг удтал бодогдоод галзуурахгүй юмсан гэж хичээн биеэ барьжээ. Урсула түүнд ойртохыг болив. Тэр нэгэн орой Амарантаг гал тогоондорж, гара цогоор төөнөн, гар нь өвдөх хосрох гэдэг туйлгүй болсноо сүүлдээ мэдэ алдаж гагцхүү түлэгдсэн махны хэншүү ханхалж байхад ч өрөвдөж харсангүй. Энэ нь сэтгэлийн зовлонг намжаах хамгийн хүчтэй эм байлаа. Хэдэн өдөр Амаранта гараа өндөгний шар уурагт дүрэн байшин дотуураа явбал, халанхай нь бага багаар эдгэж, үүнтэй хамт түүхий өндөг тусалсан мэт сэтгэлийнх нь шарх ч анилаа. Амарантагийн түлсэн гараа үхэн үхтлээ хав хив даавуугаар боож явсан нь тийм эмгэнэлтэй юм болсны цорын ганц тэмдэг болж үлдэнэ.

Аркадио гэнэт уужим сэтгэл гаргаж, Пьетрогийн нас барсанд албан ёсны гашуудал зарлах шийд гаргав. Урсула үүнийг замаа алдсан хүүхдээ голомтдоо эргэж ирж байгаа хэрэг гэж боджээ. Гэвч эндүүрсэн байлаа. Аркадио түүний гараас нэгэнт алдагдаж, тэгэхдээ цэргийн хувцас өмссөн цагаасаа алдагдсан ч бус, ерөөсөө Урсулад дотно байсангүй ажээ. Түүнийг Ребеакагийн л адил илүү ч үгүй, дутуу ч үгүй, төрсөн хүүхдээс ялгаагүй ав адил илүү ч үгүй, дутуу ч үгүй, төрсөн хүүхдээс ялгаагүй ал ав адил өсгөсөн билээ. Багад нь нойр хулжих тахал гарч, Урсула байшин барих гэж бужигнуулж, Хосе Аркадио Буэниа галзуурч, Аурелиано гэрийн мухар сахиж, Амаранта, Ребека хоёр тангараг тасарч таарсан учир Аркадио зожиг, аймхай хүүхэд болжээ.

1 Христос шашны ёсонд талийгаачийг оршуулахад гашуудан уйлдаг тусгай хүн байдаг ажээ. –Орч

Аурелиано түүнд бичиг зааж байхдаа хар элгийн хүн л ийм өайх гэхээр огт өөр юм бодож байдаг байжээ. Тэрбээр Аркадиод хувцсаа өгдөг боловч бүр тамтаг нь тасарсан хойно өгдөг, түүнийг нь Виситасьон биен тааруулан оёж өгдөг байжээ. Аркадио хөлд нь таарахгүй том гуталтай, түмэн нөхөөстэй өмдтэй, эмэгтэй хүнийх шиг бөгстөйдөө их зовдог байжээ. Тэр ихэвчлэн Виситасьон, Катаруре хоёртой л өөрийнх нь хэлээр ярина. Мелькиадес л Аркадиог үнэхээрийн сонирхдог ганц хүн байж, мэдэхгүйд эрээн цоохор бичгээ түүнд уншиж, зураг авах эрдэм зааж өгчээ. Аркадио өвгөний үхэхэд бусдаас далд яаж гашуудан уйлж, бичсэн юмыг нь ойлгохгүй мөртлөө яаж үзэж, цыганыг дахин амиуулах аргыг яаж цөхрөнгөө бартал эрж хайсныг хэн ч гадарласангүй. Сургуульдаа нэр хүндтэй, хэлснээ л хийлгэдэг багш, дзараа нь хатуу хууль

гаргадаг, гоё дүрэмт хувцас өмсдөг их эрх мэдэлтэй хүн бослноор сэтгэлийн тэр бөөдий нь арилжээ. Нэг орой Катариногийн газарт нэг нь “Чи эцэг өвгийнхөө нэрийг бузарлаж байна” гэж түүнд хэлжээ. Энэ эшазруун хүнийг ч Аркадио буудчих байх даа гэж цөмөөрөө бодож байтал харин тэгсэнгүй,

- Миний аз болоход, би Буэндиа биш гэж хэлжээ.

Аркадиогийн үрчлэгдсэн нууцыг мэддэг хүмүүс тэгж хариулахад нь цөмийг мэдчихэж гэж бодсон боловч үнэндээ бол Аркадио эцэг эхээ хэзээ ч мэдэлгүй өнгөрчээ. Тэрбээр төрсөн эх Пилар Тернерад Хосе Аркадио, Аурелиано хоёрын адил ихэд тачаадаг, зураг буулгаж байгаа харанхуй өрөөнд нь эхийгээ орж ирэхэд хамаг бие нь жирсхийгээд явчихдаг байжээ. Пилар Тернера урьдын сэтгэлийг булаах чадлаа алдаж сайхан инээдэг нь өнгөрсөн боловч Аркадио түүнийг хулмасны нь нляуун үнэрээр эрж олдог байлаа. Дайны өмнөхөн Пилар отгон хүүгээ авах гэж сургууль дээр урьдынхаасаа нэлээд оройтож иржээ. Урьд амрах өрөө байгаад сүүд нь гав тушаа хадгалах болсон тасалгаанд Аркадио түүнийг готож байлаа. Хүүхэд гадаа тоглож байсан учир Аркадио дүүжин орон дээр хэвтээд, Пиларыг энэ тасалгаагаар заавал дайрна гэдгийг мэдэн, байж ядсандаа чичирч байжээ. Пилар ч ороод ирлээ. Аркадио гараас нь шүүрэн авч дүүжин ор руу чирэв. “Болохгүй, болохгүй. Чамайг жаргаая гэж би хэчнээн бодож байгааг чи мэдэхгүй. Гэвч тэнгэр хартугай, болохгүй” гэж Пилар Тернера хиртхийн хэлэв. Аркадио түүнийг Буэндиагийнхны удмын хар бяраар бүсэлхийгээр нь хаман тэвэртэл, бие нь мэдрэгдсэнд нүд нь хранхулаад явчихав. “Нэг их ариунхан амьтан болох гэж бүү маягла. Чиний, буруу дуулаагүй бол “үгүй” гэдэггүйг толгойтой бүхэн андахгүй” гэж хэлэхэд Пилар Тернера өөдгүй заяатайдаа гомдохын дэдээр гомдож,

- Хүүхэд харчихна. Өнөө шөнө хаалга бүү түгжээрэй гэж шивнэв.

Шөнө нь Аркадио шүдээ хавчинатал чичирсээр дүүжин орон дээрээ хүлээж байлаа. Тэрбээр хүрэлзгэнэ тасралтгүй дуугарах, усны бух яг цагийн хуваарьтай юм шиг нэг л цагт урамдахыг чагнан, цурам хийлгүй байхдаа өөрийг нь хуурчээ гэж хором өнгөрөх тутам ойлгож байлаа. Сэтгэл үймрэн галзуурахад ганц хуруу дутуу байтал хаалга сэвхийтэл онгойв. Хэдэн сарын дараа Аркадио буудуулах гэж зогсохдоо энэ агшинг эргэн санана. Эхлээд хажуугийн өрөө рүү нэг хүн андууран ороод зүрх алдангуй явах, сандал түрхийтэл мөргөх нь дуулдсанаа ханахад бараа нь сүүтгэнэн харагдаж зүрхний нь түргэн түргэн цохиход агаар долгхис үүсгэн чичирчээ. Энэ зүрх Аркадиогийн цээжин дэх зүрхнээс өөрөөр цохиж байлаа. Аркадиогийн гараа сунгавал нэг хурундаа давхар бөлзөг зүүсэн гэр таарлаа. Түүнийг харанхйд алдагдан алдаж байхад нь а мөлтөс тосон нь тэр байжээ. Гүрийсэн судал, айснаас түргэн лугших судас эрхий хурууных нь угт амьдралын зураасыг үхлийн мурий зураас огтолсон нойтон алга баригдав. Тэгэхэд л энэ бол өөрийн нь хүлээсэн эмэгтэй биш байна гэдгийг

мэдэв. Хүүхнээс нөгөө нэг үнэр ханхлахгүй, өөр цэцгийн үнэр анхилна. Эрэгтэй хүнийх шиг хавтгай товчтой, хатуу мээмтэй аж. Янаглах нь эв дүйгүй бөгөөд эмх замбараагүй боловч эцсэнгүй ажээ. Энэ бол Санта Софи де ла Пьедад гэсэн туйлын хачин нэртэй бүсгүй байлаа. Пилар Тернера хадгаламжийнхаа тэн хагасыг буюу тавин песог түүнд төлж байж Аркадиогийн өвөрт оруулжээ. Аркадио энэ бүсгүйг хүнсний жижиг мухлагт аав ээждээ туслаад байж байхыг нь хэд хэд харсан боловч огт анзаардаггүй байжээ. Учир нь тэр бол шаардлага гартал хүнд анзаарагдахгүй байж чаддаг ховорхон чанартай хүн байлаа. Гэвч энэ шөнөөс хойш бүсгүй залуу эрийн суганд хоргодон мигуй шиг цагираглан хэвтэх болов. Пилар Тернера хадгаламжийнхаа үлдсэн хагасыг өгч байж эцэг эхээр нь зөвшөөрүүлсэн учир бүсгүй сургууль дээр өдрийн амралтаар ирдэг болов. Хожим нь засгийн газрын цэрэг тэр хоёрыг сургуулийн байрнаас гаргасан учир мухлагийн мухрын өрөөнд хайрцагтай цөцгийн тос, шуудайтай эрдэнэшишийн дунд үүлэн борооны явдлыг үйлдэх болов. Аркадио цэргийн ба иргэний захирагчаар томилогдож байх үеэр тэднийх охинтой болжээ.

Үүнийг нь мэдэх цорын ганц хамаатан гэвэл Аркадиотой хамаатан садны хувиар гэхээс хань хамсаатны хувиар ойр дотно болсон байсан Хосе Аркадио, Ребека хоёр байлаа. Хосе Аркадио гэр бүлийн дөнгөнд ороод хүзүүгээ гүрдийтэл зүтгэж байлаа. Ребека зан чанга, хатуу хуял ханахыг мэдэхгүй, нэр хүндэд дуртайгаараа нөхрийнхөө гань галзуу занг хазаарлаж, тэр нь хойрго, хүүхэмсүү амьтан байснаа ажлын булиа хүчтэй шар болжээ. Гэр нь цэвэр цэмцгэр байдаг байлаа. Өглөө нь Ребека цонхоо цэлийтэл дэлгэж, оршуулгын газрын тэндээс үлээх салхи тасалгаанд орж ирэн хашааны хаалгаар нэвт гарахдаа хана туурга, тавилга саван дээр үхээрийн өлөн тоос суулгана. Шороо идэхийг хорхойсдог нь, эцэг эхийн яс харжигнадаг нь, хуял тачаал хөдөлдөг нь, Пьетро Креспийн номойхон шаналдаг нь нэгэнт улирч балран мартагджээ. Өдөржин Ребека цонхны дэргэд дайн дажин болж байна гэж бодох санах юмгүй, юм хатгамлан сууж, тавиур дээр шавар ваар доргин хөдөлж эхлэхэд босож, цул шавар болчихсон тайган ноход, араас нь шувууны хоёр амтай буу үүрч, давируултай савхин гутал өмссөн тэнгэр баганадсан эрийн орж ирэхээс нь өмнө хоолыг нь халаадаг байлаа. Заримдаа нөхөр нь буга үүрчихсэн ирэх боловч ихэвчлэн хэдэн чандага буюу зэрлэг нугас холбочихсон барьж ирнэ. Захирагч болсныхоо дараахан нэг орой Аркадио тэднийд гэнэт иржээ. Аркадио тэдэнтэй гэрээс нь гарснаас хойш уулзаагүй боловч их садансан найрсаг байсанд цаадуул нь “Халуун хоол идээд яв” гэж урьжээ.

Ребекаг кофе өгөхөд л Аркадио чухам ямар хэргээр ирснээ хэлэв. Хосе Аркадиогийн талаар түүнд хов мэдүүлсэн байжээ. “Хосе Аркадио хашаан дахь газраа хагалсныхаа дараагаар хажуугийн газар руу орж, шараараа айлын газрын хашааг буулгаж, барилгыгнь газартай тэгшлээд, орчныхоо хамгийн сайн бүх газрыг авчихлаа” гэж, “Зарим тариачдын газар хэрэггүй байсан тул авалгүй татвар ногдулж, бямба гариг бүрд буугаа үүрч, нохдоо дагуулсаар ирж,

гувчуур татдаг боллоо” гэж зэс хошуулсан байжээ. Хосе Аркадио “Тэгээгүй” гэж зүтгэсэнгүй. Түүний авсан газар бол Макондог байгуулах үед Хосе Аркадио Буэндиад анх хуваарилсан газар байсан гэж шалтаг зааж, угтаа өөрсдийнхөө мэдлийн газрыг бусдад өгснөөрөө эцэг нь тэгэхэд л ухаан санаа муудсан байсан гэж нотлоход бэлхэн байлаа. Аркадио үнэн мөнийг олох гэж ирсэнгүй учир тэгж учирлахын хэрэг огт байсангүй аж. Аркадио бүртгэх товчоо байгуулах саналтай байгаагаа хэлээд Хосе Аркадио өөрөө татвар хураахаа болиод, нутгийн эрх баригчдыг татвар хураадаг болговол булааж авсан газраа хууль ёсоор эзэмших эрхийг Хосе аркадио уул товчоо өгнө гэжээ. Тэр хоёр за зүүболон тохиролцов. Хэдэн жилийн дараа хурандаа Аурелиано Буэндиа газар эзэмших эрхийг дахин хянахдаа ахынх нь нэрдээр тэдний хашаа байсан довцог дээрээс нүдний хараа хүрэх тарианы бүх газар, түүний дотор оршуулгын газрыг бичсэнийг, арван нэгэн сар хотыг захирч байхдаа Аркадио татварын мөнгө төдийгүй Хосе Аркадиоогийн эзэмшил дээр үхэгсдийг оршуулах зөвшөөрөл олгосны мөнгийг хүртэл идэж байсныг үзнэ.

Хэдэн сар болоод Урсула бүх улсын мэдчихээд сэтгэлийг нь улам зовоохын нэмэр гэж өөрөөс нь нуугаад байсан юмыг олж мэджээ. Эхлээд түүнд сэжиг төржээ. Нөхрийнхөө аманд тарвасны шүүс халбагадан хийхзуураа “Аркадио маань хувьдаа байшин барьж байгаа” гэж бахархсан дүртэй өгүүлжээ. Гэвч “Яагаад ч ювм бүү мэд энэ нэг л биш дээ” гээд өөрийн эрхгүй шүүрс алджээ. Хожим нь Аркадиоог байшингаа бариад дууссанаар барахгүй өөртөө австри тавилга захиалж байна гэж дуулахдаа сангийн мөнгө шамшиж байна гэдэгт нь эргэлзэхээ болив. Нэг удаа ням гаригийн мөргөлөөс буцаж явахдаа Урсула шинэ байшиндаа офицеруудтай хөзөр тоглож байгааг нь хараад, “Чи манай гэрийнхний нэрийг бузарлаж гүйцлээ. Тэгэхэд л Урсула, түүний зругаан сартай охинтойг, ёс төргүй сусан Санта Софи де ла Пьедад нь дахиад хөл хөүнд болсныг мэджээ. Урсула Аурелиано Буэндидад хаана ч байлаа гэсэн захидал бичиж, энэ бүх байдлыг дулагя гэж шийдсэн боловч дараа дараачийн өдөр болсон хэрэг явдлыг үзэхдээ захидал бичихээ больсон төдийгүйтэгж бичих гэж байсандаа тэр ч байтугай харамсжээ. Макондогийнхны хувь зөвхөн ярьдаг, бүдэг бадаг, алс холын юм шиг санагддаг байсан дайн сэтгэл түгшим, барим тавим болжирлээ. Хоёдугаар сарын шувартаргаар хотын захад туужуу ачсан илжиг унаж туж тоос болсон эмгэнхүрч иржээ. Огт гэм хоргүй байдалтай тул хуруулаад хөндийгөөс яваа энгийн нэг худалдаачин эхнэр гэж санаад илүү дутуу юм асуулгүй нэвтгүүлжээ. Эмгэн шууд хуаран тийш явж очив. Аркадио түүнийг хуучин ангид хүлээж авлаа. Одоо ар талын хауаран аятай болсон энэ тасалгаанд эндтэнд хуйлсан, цагиргаас өлгөсөн дүүжин ор харагдаж, өнцөг булан бүрд нь сийрс овоолж, шалан дээр винтов, карабин, тэр ч байтугай ангийн буу хөглөрч байлаа. эмгэн номхон зогсож ёслоод,

- Хурандаа Грегорио Стивенсон гэж биеэ танилцуулжээ.

Тэр муу мэдээтэй иржээ. Түүний үгээр бол либералуудын эсэргүүцлийн сүүлийн голомт дарагджээ. Риаочагаас байлдсаар ухарч яваа хурандаа Аурелиано Бэндиа түүний Аркадио руу хэл хүргүүлэхээр ирүүлжээ. “Либералуудын амь насыг өршөөж, эд хөрөнгөнд халдахгүй” гэж засгийн газрын цэрэг амлах юм бол Макондог эсэргүүцэлгүйгээр өгөх хэрэгтэй гэж хэлүүлсэн байлаа. Аркадио атигар эмгэнээс ялгарах юмгүй хачин элчийг жигших, өрөвдөх зэрэгцүүлэн хараад,

- Танд бичгээр бичсэн тушаал байгаа биз дээ гэж хэлсэнд элч:
- Яалаа гэж байх вэ. Байдал ийм байхад өөрийгөө барьж өгөх юм биедээ авч явж болохгүй гэдэг нь хэний ч мэдээжийн хэрэг гэж хэлжээ.

Тэгтэл тэр өргөн бүснийхээ цаанаас алтан загас гаргаж ирээд ширээн дээр тавив. Энэ бол хурандаа Аурелиано буэндиагийн хийсэн загасны дайнаас өмнө хүн худалдаж авсан байж болох учир батлахтэмдэгболж чадахгүй. Өөртөө итгүүлэхийнтулдэ чл цэргийн нууцыг хүртэл задалж, Карибын тэнгисийн арлаас хөөгдөгсдийг элсүүлж, буу, сум хэрэгсэл олж аван, жилийн цэсээр эрэгт гарахаар оролдох чухал даалгавар биелүүлэхээр Кюрасо орж яваагаа хэлжээ. Гэвч Аркадио туйлбартай байлаа. Чухам хэн болохыг нь мэдтэлээ элчийг харуул хамгаалалттай байлгаж, Макондо цайзыг үхэх сэхэхээ үзэн хамгаалахаар шийджээ.

Нэг их удсангүй, либералуудын ялагдаж байгаа мэдээ улам бүр батлагдсаар байлаа. гуравдугаар сарын хуучдаар нэг шөнө, цагаасаа эрт орсон бороо Макондогийн гудамжийг үерлүүлж байхад бүрээний янхийх чимээ түрүүчийн хэдэн долоо хоногийн дүнсгэр тавиан байдлыг эвдэж, хойноос нь их бууны дуу нирхийж, сус сүмийн гонхонг арчин хаяв. Эсэргүүцнэ гэдэгүнэндээ ямар ч ухаангүй хэрэг байв. Аркадио зэвсэг муутай, хорь хорьхон сумтай, дөнгөж тавин хүнтэй байлаа. Энэ хүмүүсийн дотор түүний сүржин урианд хөрөсөн, бүтэхгүй хэргийн төлөө утсан чинээ улаан амиа өгөхөөс сийхгүй шавь нар нь ч байлаа. Газар их бууны буудлагаас лоргиж, буу бзамбараагүй тачигнах, хүмүүс пир пар гүйлдэх, эмхгүй тушаал өгөх, бүрээний утгагүй дуугарах чимээ сонсдож байхад өөрийгөө хурандаа Стивенсон гэсэн хүн Аркадиотой арайхиж ярив. “Дөнгөтэй, эм хүний хувцастай ингэж шившигтэй үхэхээ байя. Үхэх заяатай бол тулалдаж байгаад үхье гэж хэлсэнд Аркадио сая үнэмшиж, түүнд буу, хорин сум өгөхийг тушаагаад, таван хүнтэй хамт хуаран хамгаал гэж үлдээн, өөрөө хориглолтыг удирдахаар штабынхантайгаа гарав. Аркадио хөндийн зам дээр гарч амжсангүй. Макондо руу ордог хаалганы дэргэд байгуулсан бэхлэлт нурж, хотыг хамгаалагчид гудамжинд байшин байшин дамжин тулалдаж, сумаа дуустал винтовоор буудаад, сүүлд нь гардан тулалдаанд оров. Тэднийг дийлэдх байдалтай болж ирэхэд эмэгтэйчүүд хоолны хутгаа бариад гудаминд гүйлдэн гарлаа. Ийм хөл толгойгүй юм болж байхад



Аркадио нэг харвал Амаранта дан унтлагын цамцтай түүнийг эрэн явж байлоаа. Хосе Аркадио Бэндиагийн хуучин гар бууг барьчихсан явах ньгалзуу солио туссан мэт. Аркадио байлдаанд буугаа хаячихсан офицерт винтовоо өгөөд Амарантаг гэрт нь хүргэж өгөхөөр нарийнгудам руу ухасхийв. Урсула их бууны сум исгэрэхийгч, нэг сум зэргэлдээх байшингийн үүрэн талыг цөм цохихыг ч тоохгүй үүндээ зогсож байлаа. Бороо зогсоон боловч гудамж нялцайсан саван шиг гулсамтгай, нойтонболжээ. Шөнө харанхуй байсан учир хар таамгаар явах хэрэг гаррав. Аркадио Урсулад Амарантаг орхиод эргэж, булангийн цаанаас өөр рүү нь гал нээсэн хоёр цэргийг буудав. Гэтэл шүүгээнд удтал хэвтсэн гар буу баарлаа. Урсула Аркадиоог биеэр халхлан түүнийг байшинд оруулах гэж түлхэн,

- Явъя гэм. Тэнэглэх чинь гүйцээ гэж загнажээ.

Цэргүүд тэр хоёрруу буугаа шагайв.

- Хатагтай, наадхүнээ орхи, тэгэхгүй бол амины чинь л хохь болно шүү! гэж нэг нь хашгирав.

Аркадиоог Урсулаг өөрөөсөө хөндийрүүлээд бууж өгөв. Хэсэг байзнатал буун дуу намдаж, хонх хангиналаа. Эсэргүүцэл хагас цагт л ларагдав. Аркадиоогийн хүмүүсээс нэг нь ч амьд гарсангүй боловч үхэхдээ үхэр буугаа гэгчээр гурван зуун цэргийн өөдөөс хатан зоригтой үзжээ. Хуаран тэдний сүүлийн тушиц газар болов. Засгийн газрын цэрэг хуаран руу шийдвэрлэх дайралт хийхээр бэлтгэж байхад өөрийгөө хурандаа Грегорио Стивеносон гэж нэрлэсэн хүн хоригдлуудыг суллаж, хүмүүсээ хурангаас гарч гадаа тулалд гэж гэж тушаав. Тэр хүн хэд хэдэн цонхоор амжин галлаж, дайсны сум тоолон унагаж байсанд довтлогсод хуаранг маш сайн хамгаалалттай юм байна гэж бодоо, их буугаар буудан нурав. Байлдааны ажиллагааг удирдаж байсан ахмад, нурсан байшин дотор хоосон буу атгасан гараа их бууны суманд тастуулсан, дан дотруу өмдтэй үхсэн хүнээс өөр хэн ч байхгүй байсанд гайхаж хоцорчээ. Үхсэн хний үс нь эмэгтэй хнийх шиг өтгөн бөгөөд урт дагзан дээр нь сам хатгаастай, хүзүүнд нь алтан загастай сахиус зүүлттэй байлаа. Ахмад нүүрийг нь харах гэж гутлынхаа хоншоороо хүүрийг эргүүлэн үзээд мэл гайхаж, “Юу гээч чөтгөр вэ!” гэж хараасанд бусад офицер хүрч ирэв.

- Энүүний хаанаас гарч байгааг хараач! Энэ чинь Грегорио Стивенсон байна гэж ахмад тэдэнд хэлэв.

Үүрээр цэргийн хээрийн шүүхийн тогтоолоор Аркадиоог оршуулгын газрын хайсны дэргэд цаазаар авав. Багаас өөрийг нь зовоодог байсан аймхай зан яагаад алга болчихсон учрыг амьд байх сүүлчийн хоёр цагт гайхаад гайхаад олсонгүй. Саяхан гэнэт зориг орсноо харуулах гэсэндээ л ялын учир нажиргүй олон заалтыг тийм тайван сонсож байсан уу гэвэл үгүй ээ. Тэр Урсулаг Хосе Аркадио буэндиатай туулайн бөөрний доор кофе ууж байгаа даа гэж бодов. Нэг

өгч амжаагүй байсан найман сартай охин, мөн наймдугаар сард төрөх хүүхдээ бодлоо. Санта де ла Пьедад өчигдөр орой байлдахаар явахад нь бямба гаригийнүдийн хоолоор хэрэглэж бугын мах давсалж байсан нь санагдаж, мөр рүү нь намиран буудаг хар үс, хиймэл юм шиг санагддаг урт өтгөн сормус нь бодогдож, гуниг төржээ. Ойр дотныхоо хүмүүсийг санахдаа уярч нялуураад байсангүй, яаж амьдарч ирж вэ гэж хатуухан бодоодүзхэдэ хамгийн их үзэн яддаг байсан хүмүүсээ хэрэг дээрээ хэчнээн хайрладаг байснаа ойлгож эхэлжээ. Цэргийн хээрийн шүүхийн дарга төгсгөлийн үгээ эхэлж байхад Аркадио бүүр хоёр цаг өнгөрөөд байгааг анзаараагүй л байлаа. Даргын хэлсэн нь: “Дээр дурдсан ял ийм өдий төдий эм мөрийн баримтаар нотлогдоогүй байлаа ч гэсэн яллагдагч захиргаандаа байсан хүмүүсийг үхлийн өөдөөс явуулж, амь насыг нь хий бүрэлгэн цагаандаа гарсан мэт гэмт хэрэг үйлсдэнд нь л цаазаар авах ял онооход бүрэн болно” гэжээ. Санасан энэ сургуульд эрх мэдэл олохтой хамт анх удаа өөртөө итгэтэй болсноо өөртөө итгэл алдахыг анх мэдэрснээ сана зогсохдоо алахын хооронд ийнхүү ёс төр болж байгаа нь утгагүй юм гэж санажээ. Үнэнийг хэлэхэд түүний хувьд үхэх ямар ч төлөвлөгөө сонсохдоо айсангүй, харин уйтгарлажээ. “Хамгийн сүүлд юу хүсэж байна вэ?” гэж асуун асуутал ганц ч үг дуугарсангүй.

- Охинд минь Урсула гэж эмээгийнх нь нэрийгөгөөрэй гэж эхнэрт хэлээрэй гээд хэсэг дуугүй байснаа нэмж мөн гэдсэнд байгаа хүүхдээ гарахад эрэгтэй бол авгыг нь бус, өвгийг нь дурсаж Хосе Аркадио гэж нэр өгөөрэй гэж бас хэлээрэй хэмээн цангинасан дуугаар хэлжээ.

Аркадиог хайсны дэргэд аваачихын урьд Никанор лам нүглийг ньнаманчлах гэв. “Надад наманчлаад байх нүгэл юу ч байхгүй” гэж хэлснээ аяга харкофе уугаадцэргүүдийг “Явал я” хэмээжээ. Буудах тушаалыг ахмад өгөхөөр болов. Түүнийг Яргачин Роке гэдэг байсан нь учиртай ажээ. Тэр бол бөөнөөр нь цаазаар авах мэргэжилтэн байжээ. Тасралтгүй шиврэх бороон дунд оршуулгын газрын зүг алхаж явахаднь тэнгэрийн хаяанд лахгва гаригийн өглөөний ягаантуяа татаж хээлж байлаа. Шөнийн манан арилахын хамт уйтгарт нь ч арилж, туйлын сониуч зан нь хөдөлжээ. Хайс руу нуруугаа харуулаад зогсохыг тушаахад нь эргэхдээ нойтон үстэй, ягаан цэцэгтэй эдээр хийсэн палаажтай Ребекагийн цонхоо цэлийтэл нээж байхыг харжээ. Аркадио түүнд харагдах гэж байдгаараа чармайв. Ребека ч хайсыг гүйлгэн харж байснаа түүнийг гэнэт хараад айсандаа мэлэрч, тэгснээ биеэ барин салах ёс нүйцэтгэн гараа даллалаа. Аркадио ч гараа даллав. Яг л энэ агшинд винтов буунуудын тортогт ам өөр рүү нь чиглэж, Мелькиадесий бичсэнээ үг үгээр нь дуудан унших, анги дотуур Санта Софи де ла Пьедадын төөрөн явах нь сонсдож үхсэн Ремедиосын царайг харах үеийнх шиг хамар нь мөс шиг хатуу болж байгаа нь мэдэгдэв. “Өө, золиг гэж, охин гарвал Ремедиос хэмээн нэр өгөөрэй гэж хэлэхээ мартаж шүү длээ” гэж дөнгөж бодож амжив. Насан турш нь зовоож байсан тэр айдас дахин

палхийтэл төрөв. Ахмад буудах тушаал өглөө. Аркадио дөнгөж цээжээ дэлгэж, толгойгоо өргөж амжаад, хонгыг нь дагаад халуун оргиулан урсаж байгаа нойтон юм хаанаас гарч байгааг ч ойлгосонгүй,

- Новшнууд! Либералуудын нам мандтугай! Гэж хашгирчээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Тавдугаар сард дайн дуусав. Засгийн газар сүржин тунхаглалдаа энэ тухай мэдэгдэхээс, самуун дэгдээгчдийг хайр найргүй гэсгээн цээрлүүлнэ гэж амлахаас хоёр долоо хоногийн өмнө хурандаа Аурелиано Буэндиа индиан домчийн хувцас өмсөөд баруун хил бараг хүчр явтлаа баригджээ. Аян дайнд мордохдоо тэрбээр хорин нэгэн хүн дагуулж гарсны арван дөрөв нь тулалдаанд амь эрстэж, зургаа нь шархтай хэвтэж байсан учир бүрмөсөн ялагдах үед нь хурандаа Геринельдо Маркес л хамт байжээ. Хурандаа Аруелиано Буэндиагийн олзлогдсон тухай мэдээг Макондод тусгай хуулиар зарлажээ. “Хүү минь амьд байна. Дайсан нь түүнийг энэрч хайрлаасай гэж тэнгэрт мөргөө” гэж Урсула нөхөртөө хэлжээ. Гурван өдөр хүзүдэ эзвон уйлаад, дөрөв дэх өдөр ньгал зууханд чавганы чанамал бэлтгэж байтлаа гэнэт хажуудаа түүний дуу гарахыг тов тодхон сонсжээ. “Энэ Аурелиано байна” гэж хашгирада, үнийгээ нөхөртөө хэлэх гэж туулайн бөөр рүү харайлган очиж “Энэ Аурелиано байна. Ямар азаар амьд гарсныгб үү мэд, ямар ч гэсэн амьд байна, бид удахгүй уулзах нь” гэжээ. Урсула уулзана гэдэг итгэж байлаа. Тэгээд гэрийнхээ шалыг угаалгаж, бараагаа сольж хураалгав. Долоо хонож байтал хурандаа Аурелиано Буэндиапд цаазаар авах ял оноож нутгийнхны нь зүрхийг үхүүлэх гэж Макондод хороох гэнэ гэсэн цуу дэгдэж, түүний совин батлагдав. Даваа гаригийн өглөө арван нэгэн цагийн алдад Амранта, Аурелиано Хосег хувцаслаж байтал гэнэт алсад замбараагүй шуугиан бүрээний дуу гарч, хормын дараа Урсула "Ав"ад ирлээ!" гэж хашгирсаар тасалгаанд гүйн орж ирлээ. Цэргүүд бүчсэн олныг бууныхаа бөгсөөр нүдсээр зам гаргаж явав. Урсула, Амранта хоёр шавааралдсан хүмүүсийн дундуур чихэлдсээр явж хажуугийн гудамжинд хүрээд Аурелиано Буэндиаг олж харлаа.: Хөл нүцгэн, хувцас хунар нь урагдсан, сахал үс нь сөрвийсөн тэрвээр угйлгачинтай адил болжээ. Аурелиано Буэндиа улайстал халсан халсан элс хөлийг нь төөнөхийг ч анзаарахгүй явна. Түүний гарыг ард ньхүлж, хүлэгний нь нэг үзүүрээс морьтой офицер барьжээ. Хажууд нь мөн л хир даг болсон,хувцас хунар нь урагдсан хурандаа Геринельд Маркесийг авч явлаа. Хоёул огтхон ч гутарсан янзгүй ажээ. Олон түмэн цэргүүдийг элдвээр хараан түрхрэлдэж байгаад тэр хоёрын сэтгэл нь хөдөлсөн байдалтай байлаа.

- Хүү минь ээ! Гэж Урсула олны шуугиан дунд тод гэгч дудаа, өөрийг нь зогсоох гэсэн цэргийг цохиод авав. Офицерийн морь цоройв. Хурандаа

Аурелиано Буэндиа давхийн зог тусаад, ээжийнхээ тэврэх гэхэд нь бултаад нүдийг нь цоо ширтэж,

- Ээж ээ, харь, Мэддэг улсаас нь зөвшөөрөл аваад шорон эргэж очоорой гэж хэлэв.

Аурелиано Буэндиа Урсулагийн ард хулгасхийн зогсож байгаа Амарантаг хараад түүн рүү инээмсэглэн “Гар чинь яагаа вэ?” гэж асуусанд Амаранта хар даавуугаар боосон гараа өргөж “Түчлхсэн юм аа” гэж хэлээд Урсулаг морьдын хөлөөс холдуулан хойш чангаав. Цэргүүд нирхийтэл хий буудав. Морьт цэргийн бар олзлогдогсдыг хүрээлнэ, хуаран руу хатируулан одлоо.

Орой нь Урсула хурандаа Аурелиано Буэндиаатай уулзахаар очив. Тэрбээр донАполинар Москотегоор хөөцөлдүүлж байгаад зөвшөөрөл олчих гэсэн боловч цэргийнхэн бүх эрх мэдлийг гартаа авсан учир түүний үгийг тоох хүн байсангүй. Никанор лам элэгний нь өвчин хөдлөөд хэвтэж байлаа. Алах ял заагдаагүй хурандаа Геринельдо Маркесийн эцэг эх хүүгээ эргэх гэсэн боловч цэргүүдэд бууны бөгсөөр занчуулаад хөөгдөн гарчээ. Тус болж чадах хүн байхгүйг үзэж, Аурелианог маргааш үүрээр буудна гэж итгэсэн Урсула өгөх гэсэн юмаа баадагнан, хуаран руу ганцаар очиж,

- Би хурандаа Аурелиано Буэндиагийн эх байна гэж хэлжээ.

Харуулууд замд нь хөндөлсөв. “Би ямар ч байсан орно. Та нар буудах тушаалтай юм бол шууд буудаадах” гэж хэлээд нэгийг нь хүчтэй нь аргагүй түлхэн зайлуулахад цээжээ нүцгэлсэн хэдэнц эрэг буугаа цэрвэрлэж байгаа тасалгаанд оров. Зузаан шилтэй саравч зүүж, аяны байдлаар хувцасласан, царай ягаан, зан эелдэг нэгэн офицер Урсулагийн араас ухасхийсэн харуулууд руу дохисонд тэд ч гарав.

- Би хурандаа Аурелиано Буэндиагийн эх байна гэж Урсулаг дахин хэлсэнд тэр офицер түүний хэлснийг залруулж,
- “Сеньор” ч байх яах в эгэж Урсула зөвшөөрөөд, - Ган уулзуулж өгвөл л боллоо гэв.

Алах ял авсан хүнтэй хүн уулзуулж болохгүй гэсэн дээрээс тушаалтай байсан боловч офицер толгой мэдээд Урсулаг арван таван минут уулзахыг зөвшөөрчээ. Урсула солих цэвэр дотуур хувцас, хурим дээрээ хүүгийнхээ өмсөж байсан шаахай, түүнийг ирнэгэж зөгнөсөн өдрөөсөө хойш хадгалсан амттан зэрэг боодолтой юмаа тэр офицерт үзүүлэв. Урьд дөнгө гав байсан өрөөнд Аурелиано суганы нь шарх хувилсан учир гараа алдлаад хэвтэж байлаа. Сахлаа хусахыг нь зөвшөөрчээ. Үзүүр нь эргэсэн өтгөх сахал нь шанааг нь улам товойлгожээ. Хүү нь урьдынхаасаа цонхигор, арай өндөр, бүр ганцаардмал болсон юм шиг Урсулад санагдав. Пьетро Креспийн ами хорлосон, Аркадиогийн

1 Качко (испани)- ганган дэгжин. Колумбад дотоод районы оршин суугчдыг тэгж нэрлэдэг.

Цадиггүй авирласан, тэгээд буудуулсан, туулайн бөөрийн доор Хосе Аркадио Буэндиа этгээд авирлаж байгаа зэрэг гэртээ болсон бүхнийг мэдэж байлаа. Амаранта хүнтэй суулгүй бэлэвсрэн, Аурелиано Хосег өсгөж, цаадах нь хосгүй ухаантай\_ хэлд орохтойгоо хамт л уншиж бичж сурсныг мэдэж байлаа. Урсула тасалгаанд орсноосоо хойш хүүгийнхээ хэрсүжжсэн царай, эзэрхүү байдал, бяр амтагдсан ханхар биенэс нэг л сүрдэн эвгүйрхээд байв. Аурелиано тэр бүхнийг ийм сайн мэдэж байгаад Урсулагийн гайхсанд “Та хүүгийнхээ далдыг хардгийг мэднэ газар даа” гэж тоглоом хийгээд “Өглөө намайг нааш нь авчирч явахад энэ бүхнийг үзэх шиг болсон юм” гэж царайгаа төв болгон хэлжээ.

Үнэндээ бол улс амьтан тойрон шуугилдаж байхад Аурелиано ганцхан жилийн дотор хотынхоо юутай их өөр болсныг гайхаж бодолдоо дарагдаж явжээ. Бүйлсний модны навч нь хувхайрчээ. Хөх өнгийг даран яагаанаар будаж, дахиад хөхөөр будах зэргээр ээлжлэн будсаар байтал байшин нь тэр гөх өнгөгүй болжээ.

- Чи юу бодож байв даа? Цаг ч явж байна шүү гэж Урсула санаа алдав.
- Тэгж байна аа, гэхдээ ... гэж Аурелиано хэлэв.

Ээж хүү хоёр уулзахын мөрөөс болж байж, асуух юмаа бэлдэж, тэр ч байтугай түүнд ньтэгж харуилна даа гэж эргэцүлж байж уулзсан боловч ердийн өдөр тутмын юм ярилцхааас хэтэрч чадсангүй. “Арвантаван минут дууслаа” гэж хуягийг хэлэхэд Аурелиано аяны орны сийрсэн дороос хөлс нэвчсэн хуйлмал цаас гаргаж ирэв. Энэ бол шүлэг байлаа. Эдгээрийн заримыг нь Ремедиосод зориулж бичээд, гэрээсээ явахдаа авч явсан, заримыг нь хожим, тулалдаан түр амсхийх хооронд бичсэн ажээ. “Үүнийг хэнд чбүү уншууларай. Өнөө орой үүгээр зуухаа галлчих” гэсэнд Урсула ам өгөөд салахын ёсыг гүйцэтгэн хүүгээ үнэсэх гэж босохдоо

- би чамд гар буу авчирсан гэж шивнэжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа харуулыг ойр байна уу үгүй юугэж хараад, мөн л аяархнаар “Надад ямар хэрэг болох вэ дээ. Гэхдээ өгчих, таныг гарахад үзчих вий” гэж хариулав. Урсула гар бууг цээживчнийхээ цаанаас гаргаж өгөхөд хурандаа Аурелиано буэндиа орныхоо цийрсэн доогуур шургуулав. “Одоо надтай салах ёс хийхийн хэрэггүй ээ. Хэнээс ч бүү гуй, хэнийг чбүү

царай алд. Намайг аль эрт буудуулчихсан гэж бодож яв” гэж зориудын тайван дуугаар хэлсэнд Урсула нулимсаа барин уруулаа хазаж,

- Шарх чинь эрхэчих вий дээ, халуун чулуугаар жигнэ гэж хэлээд эргэн, тасалгаанаас гарав.

Хурандаа Аурелиано Буэндиа хаалга хаагдтал бодлого болсоор зогсов. Тэгээд дахин хэвтэж гараа дэлгэв. Залуу насны босгыг алхсанаас хойш далдыг үзэх чадалтайгаа мэдэж, эрлэг өөрийг нь авах гэж яваагаа андуурах аргагүйр, тодхон мэдэгдэнэ гэдэгт итгэж явсан боловч одоо буудах хүртэл хэдхэн цаг үлдэж байхад тийм совин татахгүй байсанд гайхаж байлаа. Нэгэн удаа Тукуринк дэх хуаранд маш хөөрхөн бүгсүй ирж, хурандаа Аурелиано Буэндиатай уулзуулж өгөөч гэж харуулаас гуйжээ. Гүүнийг оруулжээ. Зарим хэнээтэй эхчүүд алдартай жанждын өвөрт охидоо оруулж, өөрсдийн нь хэлдгээр, үүлдэр угсаагаа сайжруулах гэдгийг бүгдээрээ мэддэг байлаа. Тэр үдэш Аурелиано Буэндиа бороод төөрсөн хүний тухай шүлгээ дуусаж байтал тасалгаанд нь бүгсүй гэнэт орж иржээ. Шүлгээ цоожлон хадгалдаг ширээний шургуулгад бичсэнээ хийх гэж цаашаа харжээ. Тэгтэл өөрийг нь буудах гэж байгааг мэдэв. !Аурелиано эргэж харалгүйгээр ширээний нүдэнд байсан гар буугаа шүүрэнгээ,

- Битгий буудаарай гэж хэлжээ.

Буугаа барьсаар эргэж харахад, бүгсүй буугаа буулгаад балмагдан зогсож байлаа. Амь насанд нь арван нэгэн удаа халдсанаас дөрвөөс ньтэгж амь гарчээ. Бас өөр нэг явдал болжээ. Үл таних этгээд Манауред байсан босогчдын хуаранд шөнө нэвтэрч ороод, түүний дотны нөхөр хурандаа шөнө нэвтэч ороод, түүний дотны нөхөр хурандаа Магнифико Висбалийг хутгалж алжээ. Түүнийг сүүлд нь барьж чадаагүй билээ. Магнифико Висбалийг чичиргээ тусахад нь хурандаа Аурелиано буэндиа орон дэрээ унтуулаад өөрөө хажууд нь дүүжин орон дээр унтсанюм санжээ. Яагаад юмыг ингэж зөнгөөрөө урьтаж мэдчихээд байгаагийнхааа учрыг олох гээд ядчихжээ. Тэр совин гэнэтхэн л тэнгэр оюуныг нь гийгүүлэх адил, агшин зуур гарцаагүй тэгэх нь байна гэсэн итгэл облон төрдөг байлаа. Болох гэж байга аюм нь заримдаа барин тавин үзэгдэх учир хурандаа Аурелиано Буэндиа биелсэн хойно л энэ чиньсовин байж шүү дээ гэж мэддэг байжээ. Заримдаа маш тод байвч биелэгдэхгүй өнгөрөх удаа ч байлаа. Тэрбээр совингоо ердийн сүсэгтэй хольдог байлаа. Гэвч түүнд алах ял оноогоод хамгийн сүүлд нь юү хүсмээр байна гэж асуусанд,

- Ялыг Макондод гүйцэтгэж өгөөч гэж хүсмээр байна гэхдээ совингоороо ингэж хэлснээ шууд ойлгожээ.

Онц шүүхийн даргыг,

- Буэндиа, биднийг мэхлэх гэж бүү оролд. Энэ бол цаг хожих гэсэн цэргийн заль байна гэж уурласанд хурандаа:
- Таануус яана вэ, дураараа бол. Миний хүсэх юм гэвэл энэ л байна гэж хариулжээ.

Түүнээс хойш совин нь татахаа бүр болив. Урсулаг гянданд эргэж ирсэн өдөр тэрбээр удтал эргэцүүлэн бодоод жам ёсоороо бус, зандалчдын дур зоргоор үхэх гэж байгаа учир эрлэгийн элч түүнийг авах гэж байгаагаа энэ удаа мэдэгдэхгүй байж болох юм гэж шийджээ. Хувилсан шархандаа шаналаад цурам хийсэнгүй. Үүр цайхын өмнөхөн гудамд хөлийн чимээ гарахад “Ирж явна” гэж бодоод гэнэт аавыгаа санажээ. Хосе, Аркадио Буэндиа ч үүрийн үнэгэн харанхуйгаар туулайн бөөр модны доор эвхрэн суугаад бас хүүгээ бодож байжээ. Аурелиано Буэндиа санаагаар унасан ч үгүй, сандарч айсан ч үгүй, гагцхүү ингэж зуурдаар үхээд өөрийн нь дуусгаж чадаагүй юм яаж дуусахыг үзэж чадахгүй нь гэж бодохдоо уур хүрч байлаа... Хаалга онгойж, цэрэг аягатай кофе барин орж ирэв. Маргааш нь хурандаа Аурелиано Буэндиаг суга нь өвдөн солиорох шахаж байтал энэ явдал яг цагтаа давтагдав. Пүрэв гаригт Урсулагийн авчирч өгсөн амттанг тарааж, өөрт нь багадсан цэвэр дотуур хувцас, чийдмэл шаахайгаа өмсөв. Баасан болсон боловч түүнийг буудаагүй л байлаа.

Үнэнийг хэлэхэд, цэргийн эрхтнүүд ялыггүйцэтгэхээс зүрх алдаж байв. Хотынхон даяараа дургүйцэж байгааг үзэхдээ хурандаа Аурелиано буэндиаг буудчихвал Макондод төдийгүй нийт тойрог даяар улс төрийн хүнд уршиг дагавар учирч магадгүй гэж бодож, мужийн төвөөс яахыг асуужээ. Хариу хараахан ирээгүй байсан бямба гаригийн шөнө Яргачин Роке ахмад бусадофицерын хамт Катариногийн газарт очржээ. Бүх хүүхний дотроос ганц нь л сүрдүүлгэнд нь үхтэл айсанд өрөөндөө аваачжээ. “Хүн алж явдаг хүнтэй тэд унтах дургүй байгаа юм. “Хурандаа Аурелиано Буэндиаг буудсан офицер бүх цэргийнхээ хамт газрын мухарт нуугдлаа ч гэсэн эрт орой аль нэгэн цагт цөмөөрөө заавал алагдана” гэж амьтан хэлцэж байна. Чухам яаж алахыг бол хэн ч мэдэхгүй байгаа юм” гэж тэр хүүхэн учрыг тайлжээ. Ахмад Яргачин Роке бусадтайгаа ингэж болох юм гэж ярилцаж, цаадуул нь дарга нартайгаа хэлэлцжээ. Хэн ч нэгэндээ хэлсэн юмгүй цэргийнхэн Макондогийн дүнсгэр тайван байдлыг үймүүлээгүй байтал “Дарга нар хариуцларгыг өөртөө ногдуулахыг хүсэхгүй, цаазаар авахад оролцохоос арга саам хийн бултаж байгаа юм гэнэ” гэсэн яриа хот даяар ням гаригт тарчихсан байлаа. Ялыг тогтоол ёсоор хорин дөрвөн цагийн дотор гүйцэтгэ!” гэсэн тушаал даваа гаригт шуудангаар иржээ. Орой нь офицерууд нэрсээ зургаан цаасны өөдсөндээр бичиж малгайд хийгээд сугалбал Яргачин Рокегийн аз хээр хаяхад нэртэй цаас нь таарчээ. “Үйлтэй юм үйлээрээ болохоос. Янхны хүү болж төрөөд тэр л чигээрээ цааш хардаг байж” гэж ихэд гутрангүй хэлжээ, Үүрийн таван жингээр

тэрбээр мөн л сугалаа сугалуулан тасаг цэрэг сонгож аваад, хашаанд жагсааж, алагдах ялтай хүнийг сэрээж,

- Явъя, Буэндиа. Цаг чинь болж гэж бахь байдаг үгээ хэлжээ.
- Аа! Тийм бий. Хувилсан шарх маань хагарч байна гэж зүүдлээд гэж хурандаа хариулав.

Ребека, Аурелианг буудах гэж байна гэж мэдсэнээс хойш өдөр бүр өглөөний гурван цагт босдог болов. Хосе Аркадиогийн хурхирахад доргих орон дээрээ сууж, харанхуй өрөөнөөсөө дутуу онгойлгосон цонхны засвараар оршуулгын газрын хайсыг ширтдэг байлаа. Тэрбээр Пьетро Креспигээс захиа хүлээдэг байсан шигээ цаашаа тэвчээртэйгээр долоо хоног хүлээв. “Энд түүнийг буудахгүй ээ. Чухам хэн нь алсныг мэдэгдүүлэхгүй гэж шөнө орой болсон хойно хуаранд буудаадтэнд нь булчихна” гэж Хосе Аркадио түүнд хэлнэ. Ребека хүлээдгээрээ хүлээж “Ийм ичих нүүрэндээ илэг наасан новшнууд түүнийг энд л буудна” гэж хэлдэг бавй. Үүнд тэр бат итгэж байсан учир хаалгаа тэгж нээгээд түүн рүү салах ёс гүйцэтгэн гараараа тэгж даллана гэж хүртрэл бодсон байлаа. “Айсан зургаахан цэргээр хамгаалуулаад гудамжаар авч явахгүй л дээ. Олон түмэн яахаас ч буцахгүй байгаа гэж цаадуул чинь мэднэ шүү дээ” гэж Хосе Аркадио зүтгэнэ. Нөхрийнхөө учирлаж байгааг хайхралгүй Ребека цонхны дэргэдээс салахгүй,

- Ёстой ичдэггүй новшнууд гэдгийг нь чи харна аа, гайгүй! Гэж зөрнө.

Мягмар гаригт өглөөний таван цагт Хосе Аркадио кофегоо ууж дуусаад, нохойгоо тавьж байтал Ребека гэнэт цонхоо хаан унан тусаад орны толгойгоос зууран “Аваад явж байна. Ямар сайхан эр вэ!” гэж санаа алдав. Хосе аркадио цонхоор хараад цайж байгаа үүрийн цонхигор туяанд зүүгээ үзэхдээ гэнэт дагжин чичрэв. Дүү нь өрөийнх нь залуудаа өмсөж байсан өмдийг өмсжээ. Тэгээд хайсны дэргэд нэгэнт оччихсон, буглаа нь халуу оргин өвдөх тул ташаа тулан зогсжээ. Ердөө л зургаан хорголжны амт зэхгэж тэгж үйлээ үзэж, тэгж махаа идсэн гэж үү! Гэтэл яаж ч чадахгүй болоод байдаг” гэж амандаа үглэн үглэсээр байхад, ахмад Яргачин Роке уурлаад байгааг нь биеэ барьж байна гэж, үглэж байгааг нь уншлага уншиж банй агэж бодоод өрөвджээ. Цэргүд буугаа өргөхөд хурандаа Аурелианогийн хор нь буцалж нэгэн гашуун, нялцгай юм аманднь дүүүрч хэл хөшөөд нүд нь бүрэлзээд явчихав. Үүрийн мөнгөн туяа гэнэт алга болж, богино өмд өмсөж, хүзүүндээ эрвээхий зангиатай хүүхэд байсан нь, эцэг нь нэгэн тунгалаг орой цыганы асарт авч орон мөс үзүүлж байсан нь нүдэнд нь дахин тодрон үзэгдэв. Хашгирах чимээ гарахад цэргүүдэд сүүлчийн команд өгч байна гэж бодоод сумны зам татуулан айсах нь харагдана даа гэж ихэд сониучирхан нүдээ нээвэл гараа өргөн зогссон Яргачин Роке, ангийн аймаар том буу барин буудахад бэлтгээд зам хөндлөн гүйж яваа Хосе Аркадио хоёр л харагдав.



Ахмад Хосе Аркадио руу хандаж,

- Бүү буудаарай. Таныг над руу эзэн тэнгэр илгээж гэж хэлэв.

Ингээд дахин нэг дайн эхлэв. Ахмад Яргачин Роке, түүний зургаан цэрэг хурандаа Аурелианогийн хамт Риоачад алагдах ял заагдаад байсан хувьсгалч генерал Викторио Мединаг суллахаар явжээ. Цаг хожихын тулд тэд Макондог анх байгуулахдаа Хосе Аркадио Буэндиогийн явсан замаар нурууг давах гэж шийдсэн боловч ингэнэ гэдэг санасны гарз юм байна гэдгийг долоо хонолгүй ухаарчээ. Аурелианог цаазлахад хэрэглэх гэж авсан хэдхэн сумтай боловч тэд аюултай газраар, уулыннамыг барьж явах хэрэг гарав. Хотын харалдаа хуарагнан бууж, нэг нь хувцсаа солиод, гэргээн цагаан өдрөөр алтан загас барин гудамжаар хөлхөж, нуугдсан либералиуудтай холбоо тогтоож, цаадуул нь “Анд явлаа” гэж өглөө гараад эргэж ирэхгүй алга болдог байлаа. Тэд арайхийж даваан дээр гарч Риоачагийн барааг харвал генерал Викторио Медина нэгэнт хороолгосон байлаа. Талынхан нь хурандаа Аурелиано Буэниаг Карибын тэнгисийн эрэг хавийн хувьсгалт хүчний командлагч гэж тунхаглаж, генерал цол олгосонд албан тушалааг нь бол авахыг зөвшөөрсөн боловч генерал цолыг авахаас цааргалж, консервативчуудын засгийн разрыг түлхэн унагахаас нааш энэ цолыг авахгүй гэж өөртөө андгайлжээ. Гурван сарын дотор мянга гаруй хүн зэвсэглэж чадсан боловч бараг цөмөөрөө амь үрэгдэв. Амьд үлдэгсэд нь дорнод хийлийг даван гарав. Тэднийг Антилын арлуудаас гарч, дахин эх орондоо буцаж ирээд Кабо-де-ла Велагийн хошуунд буулаа гэж хожим нь дуултал, “Аурелиано Буэндиа үхлээ” гэсэн засгийн газрын гарын баяртай мэдээ улс орны өнцөг буланбүрд цахилгаан утсаар таржээ. Гэтэл хоёр өдрийн дараа түрүүчийнхтэй бараг уралдаанд ирсэн нэгэн урт цахилгаан утсанд өмнөдийн талд шинэ бослого гарсныг мэдээлсэн байлаа. Тийнхүү хурандаа Аурелиано Буэндиад явахгүй газар байдаггүй гэсэн дмог гарчээ. “Хурандаа Вильянувед ялалт байгуулж гэнэ ээ”, “Туакамайялед дийлдэж, мотилонес, овгийн индиануудад идүүлж гэн ээ”, “Хөндийн нэгэн сууринд үхсэн гэнэ”, “Урумитад дахиад бослого гаргасан гэнэ” гэх мэт авцалдаагүй цуу дэгдсээр байлаа. Тэр үед либералуудыг парламентад оруулах талаар хэлэлцээ хийж байсан либерал намын удирдагчид түүний адал балмад явдалтан, манай намын удирдагчид манай нам төлөлөөгөөгүй гэж мэдэгджээ. Засгийн газар түүнийг ихзамын дээрэмчин болгож толгойг нь таван мянган песогоор үнэлжээ. Арван зургаан удаа ялагдсаныхаа дараа гуахирагаас гарч, сайтар зэвсэглэсэн хоёр мянган индиан цэргээ авч Риоачаг гэнэдүүлэн довтолж, хотыг хамгаалж байсан суманг ховх цохив. Хурандаа Аурелиано Буэндиа Риоачад төв штабаа байрлуулж, консервативчуудын эсрэг бүх ард түмний дайн зарлав. Засгийн газраас түүнд ирүүлсэн албан ёсны анхны бичигт босогчдын цэргийг дорнод хил рүү ухрахгүй бол хурандаа Гериельдо Маркесийг дөчин найман цагийн дотор буудна гэж сүрдүүлсэн байлаа. Тэр үед штабын дарга болоод байсан

хурандаа Яргачин Роке командалгчдаа цахилгаан утсыг гардуулахдаа ихээхэн уруу царайтай байсан боловч цаадах нь санаанд оромгүй баяртайгаар уншада,  
- Сайхан хэрэг! Манай Макондо цахилгаан утасны газартай облж гэж дуу алджээ.

Хуоандаа Аурелиано Буэндиа тун эрс тэс хариу өгчээ. Гурван сарын дараа Макондод төв штабаа нүүлгэж очно. Тэгэхэд хурандаа Геринельдо Маркесийг амьд бахйгүй байвал тэр үед олзлогдох бүх генералыг шууд буудаад, дараань бүх офицерыг цаазаар авч, дайны эцэс хүртэл ингэх тушаалыг захиргаандаа байгаа хүмүүст өгнө гэжээ. Гурван сарын хойно хурандаа Аурелиано Буэндиагийн ялгуусан цэрэг Макондод орж очиход хөндий орох зам дээр түүнийг тосон тэвэрсэн анхны хүн бол хурандаа Геринельдо Маркес байлаа.

Буэндиагийнх ёстой хүүхдийгн зуд болсон балйаа. Урсула Сатна Софи де ла Пьедадыг ууган охин болон Аркадиоог буудуулснаас хойш тавансарын дараа төрсөн хоёр ихэр хүүтэй нь авчирсан байлаа. аркадио охиндоо Урсула гэж нэр өгөөрэй гэж гэрээсэлсэн байсан боловч Ремиос гэж нэр өгөв. “Аркадио ингэж хэлэх гэсэн гэдэгт би итгэж байна. бид түүнийг Урсула гэж нэрлэхгүй, ийм нэртэй насаараа жаргахгүй” гэж өөрийгөө зөвтгөжээ. Хоёр ихэрт Бага Хосе Аркадио, Баг аАурелиано гэж нэр өгчээ. Амаранта цөмийг нь асрамжиндаа авав. Зочдын өрөөнд модон сандал тавьж, айлынхныхаа хүүхдүүдийг нэмэн цуглуулж, хүүхдийн асрамжийн газрархуу юм байгуулан байлаа. Пуужин тас няс буж, хонх дүн дан дуугарах аялгуунаа хурандаа Буэндиаг хотод орж ирэхэд төрсөн гэрийн нь халаган дээр хүүхдүүд найрал дуу дуулж угтав. Өлгө шигээ өндөр болсон хувьсгалт цэргийн офицерын дүрэмт хувцастай Аурелиано Хосе бүхий л дүрмээр ёслол түүнийг угтав.

Гэртээ ирээд дуулсан юм бүгд нь сайхан байсангүй. Хурандаа Аурелианога цаазын газраас зугтсанаас хойш жилийн дараа Хосе Аркадио, Ребека хоёр Аркадиогийн барьсан байшинд нүүж оржээ. Хурандаагийн амийг Хосе Аркадиогийн аварсныг хэн ч мэдсэнгүй. Хотын талбайнхамгийн сайхан газарт, шувууны гурван бүлийн үүрээ зассан бүйлс модны сүүдэрт барьсан шинэ байшин ёслолын хаалгатай, дөрвөн цонхтой байлаа. Энд эр эм хоёр гал голомтоо тулж ундай устай айл боллоо. Ребекагийн хуучин найз нар, түүний дотор одоо болтол эрд гараагүй Москотегийн дөрвөн охин хэдэн жилийн өмнө хайтантай гонхонд юм хатгамалладаг байснаа сэргээж эднийд цуглах боллоо. Хосе аркадио булааж авсан газраа ашиглаж, консервативчуудын засгийн газар эзэмших эрхийг нь бататгаж өгчээ. Оройхон шиг тэрбээр сүрэг зуумхай нохойгоо дагуулж, алсан чандагаа ганзаглаж, буугаа үүрчихсэн морьтой ирж яваа нь харагддаг байлаа. Есдүгээр сарын нэг өдөр аадар цутгах төлөвтэй болсон учир урьдынхаасаа эрт гэртээ иржээ. Гадаанаа нохойгоо уяж, хоолны өрөөнд Ребекатай мэндэлж, туулайгаа байзнасхийж байгаад давслах гэж гал зууханд

оруулж тавиад, унтлагынхаа өрөөнд хувцсаа солихоор оржээ. Нөхрөө унлагын өрөөнд орох үед угаагуурын өрөөнд усанд орж байсан учир юу ч мэдээгүй гэж хойно нь Ребека ам шүд алдсан билээ. Ребекагийн хэлж байгаа нь сэжигтай байсан боловч өөрийг нь аз жаргалтай болгосон хүнийг алахын хэрэг юу байв гэдгээс өөр үнэмшмээр юм бодон олж чадсангүй. Энэ нь тайлагдаагүй үлдсэн цорын ганц нууц билээ. Хосе Аркадиоог унтлагын өрөөний хаалгыгхаатал гар буу тас хийж, хаалган доогуур цус урсан гарч ирээд, зочдын өрөөгөөр дамжин, гадагш жирэлзэн гарада овон товонтой явган замаар хирийж, хотгор руу нэг орж, гүдгэрээр нэг даван, Туркийн гудамжаар тууш мяралзсаар ич этгэд рүү чиглэснээ солгой этгээд рүү тахирлаж Буэндиагийн байшин руу огцом эргэн, хаалттай хаалган доогуур нь шурган ороод зочдын өрөөг тойрч, хивс муухай болохгүй гэж ханын ёроолоор урсан,хоёрдахь зочдын өрөөгөөр өнгөрч, хооллох өрөөнд хоолын ширээний дэргэд томоор дугуйрснаа хайтантай гонхон дотуур мурилзан гүйж, Аруелиано Хосед тоо бодохыг зааж байсан Амарантагийн сандал доогуур мэдэгдэлгүй өрнөгөөд агуулахыг дамжиж, Урсулагийн байсан гал зууханд орж очив. Талхны гурил зуурч, гучин кзургаа дахь өндгөө хагалах гэж байсан Урсула

- Хутагт Эх дагина минь! Гэ ждүү алдав.

Тэгээд цус хаанаас эхэлж гарсныг мэдэхээр урссан замыг нь өгсөж, агуулахаар дайрч, “Турав дээр гурвыг нэмбэл зургаа болно, зургаа дээр гурвыг нэмбэл ёс оолно” хэмээн Аруелиано Хосегийн давтаж байгаа хайтант гонхноор өнгөрөөд хоолны ба зочдын өрөөгөөр хөндлөнгэрч, гудамжаар шув шулуухан хэсэгн явснаа булан тойрч ич этгээд рүү эргэж, дара ань солгой этгээд рүү эргэж, Туркийн гудамж руу орж, хормогч, улавчтай яваагаа ч анзааралгүй хотын талбай дээр гарч ирээд огт орж үзэггүй байшин руу орж, унтлагын өрөөний хаалгыг түүлхвэл хүү нь дутуу тайлсан гутлаа дараад түрүүлгээ харан уначихсан, баруун чихнээс нь гарсан Цус хэдийн тогтоод шатсан даринь хэншүү амьсгал боогдуулан ханхалж байлаа. Хосе Аркадиоогийн биед нэг ч шарх байсангүй, түүнийг ямар буугаар буудсаныг ч ол жтогтоож чадсангүй. Түүнчлэн даринь нь хурц үнэрийг арилгах гэж хүүрийг гурван удаа үрчүүрээр савандаж угааж, дараа нь цуутай даваарзүлгэж,тэгээд болохгүй болохоорнь үнс, нимбэгний шүүсээр арчиж, сүүлд нь цайруулагч уусмалтай торхонд хийж, зургаан цаг облгосон боловч шингэсэн үнэрийг арилгаж чадсангүй. Сүүлдээ хүүр бээх янзтай болж ирсэнд шалавхан оршуулахаас аргагүй болов. Талийгаачийг хоёр метр гучин сантиметр урт, нэг метр арван сантиметр өргөн тусгай авсандхийж, нимгэн төрмөөр доторлож, ган боолтоор боож битүү тагласан боловч дахины үнэр оршуулгын цувуу өнгөрсөн гудамж бүрд ханхалсаар байж билээ. Чулуу шиг хатуураад томорчихсон элэгтэй Никанор лам өөд болоочийн хойдхыг орон дээрээсээ уншжээ. Хожим нь булшийг хэдэн давхар үртэс, түүхий шохойгоор бөглөсөн боловч даринь үнэр, гадилын компаний инженерүүдийн төмөр бетоноор бүрэн бүртэл олон жил

хангалсаар байж билээ. Авсыг авч гарангуут Ребека гэрийнхээ халагыг тас түгжиж аваад энэ хорвоогийн жаргалыг огоорч, энэ хорвоогийн хамаг бүхнийг жигшихийн дээдээр жигшиж, өөрийгөө амьдаар нь оршуулжээ. Тэрбээрбүр хөгшин болсон хойноо, хуучин мөнгөн өнгөтэй шагайвч, жижигхэн цэцэг хадсан бүрх малгай өмсөж ганцхан удаа гудамжинд гарсан нь Макондод Хэрмэл жүүд<sup>1</sup> ирж, хотод аймаар

1 Хэмэл жүүд буюу Агосфер нь христос домгийн баатар. Есүс Христос Голгоф буюу Гавал тогой руу цаазлуулахаар явж байхда аамаръя гэж гуйсанд Агосфер доромжлоод амруулалгүй цааш явуулсан учир өөрөө булшинд тайван байх хувьгүй болоод Христосыг хоёр дахиа тэнгэрээс бууж иртэл үеийнүед хэрэн тэнэж явах гэсгээл хүртжээ. Хэрмэл жүүд очсон газартаа муу ер уддаг гэсэн дмогтой. – Орч.

Халуун авчирсан учир шувууд цонхны торыг цөм цохин тасалгаанд орж ирээд шалан дээр үхэтхийн унаж байсан тэр үед байлаа. Нэг шөнө гэрийн нь халагыг эвдэх гэсэн хулгайчийг цэцэн гэгч буудаж алж байхад нь сүүлийн удаа харжээ. Түүнээс хойш, ганц дотно хүнзарц Архенидагаас өөр хн түүнтэй уулзсангүй. Ребека өөрийн үеэл ах гэж үздэг хамбад захиа явуулдаг гэсэн яриа байдаг боловч захианыхаа хариу авч байна гэж огт дуулдсан удаагүй билээ. Хотынхон түүнийг ор тас мартжээ.

Хурандаа Аурелиано ёслол төгөлдөр буцаж ирсэн боловч нэг их тух тавтай байж чадсангүй. Засгийн газрын цэрэг эсэргүүцэлгүйгээр цайзыг орхисон нь илберал санаа бодолтой ард иргэд ялж байна гэж буруугаар бодоход хүрсэн ч босогчид үнэнийг мэдэж, тэр тусмаа хурандаа Аурелиано Буэндиа хэнээс ч илүү мэдэж байлаа. Тэрбээр таван мянга гаруй цэрэг захирч, далайн эргийн хоёр муж улсыггарта авасан байсан боловч тэр орны бусад нутгаас таслагдаж, далай руу шахагдан, ул стөрийн тун тодорхойгү байдалд орсноо ойлгож байлаа. Засгийн газрын ихб ууны эвдсэн сүмийн гонхонг сэргээх гэхэд нь Никанор лам хэвтрээсээ “Христосын шашинг өмгөөлөгчид сүмийг эвдэж, буруу номтнууд түүнийг сэргээх гэж байдаг ямар гээч жигтэй юм болж байна!” гэж хэлсэн нь учиртай. Хурандаа Аурелиано Буэндиа аврагдах арга чарг ахайнэ, босогчдын бусад бүлгийн дарга нартай зөвлөлдөн, цахилгаан утасны газарт өчнөөн цаг болж, тухай бүр тэндээс дайн мухарджээ гэж улам итгэсэн гардаг байлаа. босогчид амжилт олоходтэр доор нь ардтүмэнд мэдээлдэг боловч, хурандаа Аурелиано Буэндиа газрын зураг дээр тэр ялалтын жинхэнэ цар хэмжээг тэмдэглэхдээ өөрийнх нь алдарт дайчид ширэншгэ руу улам лавшран

орж,хумхаа, шумуул хёороос сэргийлэн, давших ёстой чиглэлийнхээ эсрэг л яваад байн гэдэгт итгэж байлаа. “Бид цаг алдаж байна. Намын тэр новшнууд конгресст суудал олж аван тавтал ньбид цаг алдах болно” гэж офицерууддаа гомдол мэдүлдэг байлаа. Саяхан буудуулахаар хүлээж байсан тасалгаандаа өлгөсөн дүүжин орон дээр дээш харж хэвтээд нойргүй хонож байхдаа хурандаа Аурелиано Буэндиа тас нар хувцас өмссөн тэр хуулийнхныг яаж байгаа бол гэж төсөөлөн бодож, тэр өглөө эрт ерөнхийлөгчийн ордноос тасхийм жаварт гарч, захаа чихэндээ хүртэл босгоод,гараа үрчин, шивэр авир хийж, шөнийн баргар зоогийн газарт орж%, “Ерөнхийлөгч “за” гэхдэ юухэлэх гэв” үгүй” гэхдэ эюу хэлэх гэв?” хэмээн хэлэлцэж, санаж байснаас огт өөр юм хэлэхдээ ерөнхийлөгч юу бодож байв гэж таахгэж ородон байгаа даа гэж бодож, гэтэл хурандаа Аурелиано Буэндиа өөрөө гучин таван градусын халуунд шумуултай зодолдож, цэргүүдээ далай руу үсрэхийг тушаах аймшигт цаг гарцаагүй дөхсөөр байгааг мэдэж байх юм даа гэж боддог байлаа.

Нэг шөнө тийнхүү эргэлзэж тээнэгэлзэн байхдаа гадаа цэргүүдтэй дуу дуулж байгаа Пилар Тернерагийн дууг сосноод мэргэлж өгөөч гэж гуйжээ. ПиларТернера гурвантаа хөзрөө дэлгэж, гурвантаа холиод ерөө л “Амаа мэдээ бай! Чухам юу болохыг мэдэхгүй байна. Төлөгт маш тод бууж байна, амаа мэдээтэй бай!” гэж л хэлжээ. Хоёр хонож байтал нэг хүн дагуул цэрэгт чихэргүй кофе өгч, тэр нь цааш нь дамжуулан ийнхүү гар дамжсаар Аурелиано Буэндиад хүрч иржээ. Хурандаа, кофе ууна гээгүй байсан боловч нэгэнт аваад ирсэн хойно гээд ууж орхижээ. Адуу ч эд бад хийм тунгара хор хийсэн байжээ. Хурандаа Аурелиано Буэндиаг гэрт нь авачихад булчин нь хатууран татвалзаж, хэл нь унжчихсан байлаа. Усуула хүүгээ эрлэгийн элчээс булааж авав. Ходоодыг нь бөөлжүүлэх эмээр угааж, ээсэн хилэн хөгнжилд ороон, хоёр өдөр дөндөгний шар уулгавал зовсон бие сая хэвийн халуунтай болжээ. Дөрвө дэх өдөртөө хурандаагийн өвчин нааш эргэв. Урсула болон офицерүүд шаардаж баймааж нь түүнийг оронд нь долоо хоног хэвтүүлэв. Аурелиано шүлгийг нь шатаагаагүйг тэвдэхэд л мэджээ. “Юугий нь яарах вэ гэж бодсон юм. Тэр орой зуухандаа хийх гээд гэж санасан юм” гэж Урсула тайлбарлав. Ремедиосын тоосонд дарагдсан хүүхэлдэйнүүдийн дунд элий байлхан бахйдаа хурандаа Аурелиано Буэндиа гар бичмэлээ уншиж, амьдалынхаа бүхий л гол гол үеийг санажээ. Тэр дахиад шүлэг бичиж эхэллээ. Удтал өвдөж, элдэв байдлаас болж мухардсан дайныг өвчиндөө мартсан тэрбээр үхэлтэй наадаж явахдаа олсон туршлагадаа тулгуурлан шүлэглэх болжээ. Тэгэхэд л сая ухаан нь саруулсаж, тов тодхоноор бодох болжээ. Нэг орой тэрбээр Геринельдо Маркесаас:

- Нөхөр минь,чи юуны төлөө тулалдаж байгаагаа хэлээч? Гэж асуусанд хурандаа Геринельдо Маркес,
- Нөхөр минь, би тулалдах ёстой юмныхаа төлөө, либералиуудын агуу их намын төлөө тулалдаж байна гэж хариулжээ.

- Юуны өглөө тулалдаж байгаага мэдэж байдаг чи сайхан юм аа. Б бардам зангаасаа болоод л тулалдаж байгаа юм гэдгээ зөвхөн одоо л ойлгож байна гэсэнд хурандаа Геринельдо Маркес:
- Энэ ч муу шүү гэжээ.

Маркесийн тэгж сэтгэл түгшсэн нь хурандаа Аурелианод зугаатай санагдав.

- Тэр ч тийм. Гэхдээ юуны төлөө тулалдаж байгаага мэдэхгүй байснаас дээр гээд нөхрийнхөө нүдийг ширтэн инээмсэглэсэнээ –Бас чам шиг хэнд ч хэрэггүй юмны төлөө тулалдсанаас дээр юм аа гэж нэмж хэлжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа либералнмын удирдагчдыг өөрийг нь дээрэмчин гэж хэлснээсээ олын өмнө буцтал тус орны дотоодод байгаа босогчдын багуудтай хоорондоо холбоо барихгүй байлаа. нэрэлхэхээ боливол л дайн байрнаасаа хөдөлнө гэдгийг хурандаа Аурелиано Буэндиа мэдэж байлаа. Өвдсөн биш юмыг сайтар эргүүлж тойруулж бодох зав гарав. Тэгээд Урсулаг ятган байж өвөөгийнхөө алтнаас үлдсэнийг нандин авдарнаас нь гаргуулж их мөнгөтэй болж аван хурандаа маань Геринальдо Маркесийг Макондогийн иргэний ба цэргийн захирагчаар томилон орхиод тус орны дотоодод босогчидтой холбоо тогтоохоор хотоос хөдлөв.

Хурандаа Геринельдо Маркес хурандаа Аурелиано Буэндиагийнхамгийн итгэлт хүн төдийгүй гэрийнхэнд нь төрөл саднаас нь өөрцгүй байдагбайлаа. Зөөлөн, бүрэг, уулаас еэлдэг хэдий боловч түүний хувьд захирагч болж албан тасалгаанд сууснаас цэрэг болж дайны талбарт тулалдсан нь дээр байлаа. Улс төрийн зөвлөхүүд Маркесийн толгойг эргүүлж, учир ньолдохгүйонолоор түүнийг төөрөлдүүлж ядах юмгүй балйаа. Гэвч тэрбээр хуандаа Аурелиано Буэндиагийн насны наран хэлбийхдээ алтан загасаа хийн санаа амар нүд аних юмсан гэж мөрөөддөг байсан тэр амар жимэр байдлыг Макондод тогтоож чадав. Геринельдо Маркес эцэг эхтэйгээ хамт байсан боловч долоо хоногт хоёр гурван удаа Урсулагийнд хоол иддэг байв. Аурелиано Хосед хар багаас нь цэргийн эрдэм зааж, зэвсэг бариулан сургаад тзүүнийг эр хүн болгох гэж Урсулагийн зөвшөөрснөөр хуаранд хэдэн сар байлгажээ. Үүнээс олон жилийн өмнө бараг хүүхэд байхдаа Геринельдо Маркес, Амарантад хайр сэтгэлээ ханзалож билээ. Гэвч цаадах нь Пьетро Креспид сэтгэл алдсан байсан учир гагцхүү инээгээд өнгөрчээ. Геринельдо Маркес хүлээхээр шийджээ. Шоронд байхдаа нэг удаа Амарантад захидал явуулж, арван хоёр пүүсүү алчуур дээр эцгийнхээ нэрний эхний үсгийг хатгаж өгөөч гэж гуйж зурвастаа мөнгө хавчуулан илгээжээ. Долоо хоногийн дараа Амаранта шоронд алчуурыг хатгамаллаад мөнгөний нь хамт авчирч, хоёул удтал хууч хөөрч билээ. Амарантаг явах болоход “Би эндээс гарахдаа чамтай сууна” гэж Геринельдо Маркес хэлжээ. Амарнта инээгээд өнгөрсөн боловч түүнээс хойш хүүхдэд ном зааж байхдаа түүнийг бодож, Пьетро Креспийг хайрлаж байсан орь залуугийнхаа гал халуун хайраар

түүнийг хайрлахсан гэж хүсжээ. Хоригдолтой уулзахыг зөвшөөрдөг бямба гаригт гэрээр нь орж, эцэг эхтэй нь хамт шорон руу очдог байлаа. Тийм нэгэн бямба гаригт Урсула гал зууханд орвол Амарнат жигнэмэг жигнэж, болохто йнь хамт хамгийн сайхныг нь шилж аваад зориуд оёсон алчуурт боон явах гэж байжээ. Урсула ихэд гайхжээ. Тэгснээ,

- Цаадахтайгаа суучихгүй юу. Дахиад чамд ийм хүн олдохгүй шүү гэж зөвлөжээ.

Амаранта ярвайснаа,

- Эрчүүлийн араас хөөцөлдөх маань гайгүй хэвтэнэ. Геринельдо Маркесийгнэг л цагт алуулаху чир өрөвдөөд л жигнэмэг зөөж байна гэж хариулжээ.

Түүнийг алуулна гэж өөрөө ч сайн итгэлгүй хэлсэн байтал, яг тэр үеэр нь засгийн газраас самуун дэгдээсэн цэрэг “Риоачаг өгөхгүй бол хурандаа Геринельдо Маркесийг буудна” гэж нийтэд зар тараажээ. Хоригдолтой уулзуулахыг болив. Амаранта унтлагын өрөөнөөс гарахыг болиод, Ремедиосыг үхэхэд өөрөө алчихсан мэт шаналсан шигээ дэмий юм ярьж байх хоёр дахиа ёр удлаа гэж гэмшин усан нүдэлж гарав. Эх нь охиныхоо сэтгэлийг засаж, хурандаа Аурелиано Буэндиа, Геринельдог буудуулахгүй байх арга заавал сүвчэгчилнэ, дайн дуусахад Геринельдогийн сэтгэлийг татах талаар өөрөө санаа тавина гэж амлажээ. Геринельдогийн сэтгэлийг татах талара өөрөө санаа тваина гэж амлажээ. Геринельдо Маркес иргэний ба цэргийн захирагч гэсэн том цолтой болчихсон хүрч ирэхэд Урсула түүнийг төрсөн хүү шигээ угтаж, гэртээ байлгах гэж эвтэйхэн билгүүрдэж, Амарантаг гэргий болгоно гэж бодож байсныг нь тэр хүнд сануулж өгөөч гэж тэнгэрт хичээнгүйлэн мөргөжээ. Урсулагийн гуйсан нь тэнгэрийн сонорт хүрсэн бололтой. Хурандаа Геринельдо Маркес, Буэндиагийн д өдөр хоол идэхээр ирээд, хайтан цэцэгтэй гонхонд үлдэж, Амарантатай даам нүүдэг байлаа. Урсула тэр хоёрт кофе, жигнэмэг аваачиж өгөн, хүүхдүүдээ үймүүлээд байхвий гэж өөрөө харж байдаг болов. Амранта залууд нь тарчлааж байсан хайрын галынүнсэнд булагдсан нурмыг хөөрөгдөн сэргээх гэж мэрийхээрээ мэрийж байлаа. Тэрбээр Геринельдо Маркесийг үдийн хоол идэхээр болон орой даам тоглохоор ирээсэй гэж өдөр өнгөрөх тусам улам тэсэж ядан хүлээх болов. Гунигтай,шүлэг шиг нэртэй<sup>1</sup>, даам нүүхдээ хуруу нь үл мэдэгхэн чичирч байдаг энэ дайчны дэргэд байхад цаг харвасан сум шиг өнгөрдөг байлаа. Гэвч тэр өдөр хурандаа Геринельдо Маркесийг гэргийгээ болооч гэж гуйхад Амаранта бас л зөвшөөрсөнгүй.

- Би хэнтэй ч суухгүй. Чамтай бол бүр ч үгүй. Чи Аурелианод маш сайн, түүнтэй сууж болохгүй болохоор л надтай сууя гэж байгаа юм гэж хэлжээ.

Хурандаа Геринельдо Маркес тэвчээр сайтар хүн байлаа. “Би хүлээе ээ. Хэзээ нэгэн цагт чамайг үгэндээ оруулж чадна” гэж хэлээд тэднийхээр орж

гарсаар байлаа. Амаранта өрөөгөө дотроос нь түгжээд сэтгэлийнхээ ёолох дууг хүчээр дарж, дайны тухай сүүлчийн сонинг Урсулад ярьж байгаа тэр хүний дууг сонсохгүй гэх чихээ бөглөж, түүнтэй уулзахсан гэж тэсгэл алдан алдаад, биеэ барьж чаддаг байлаа.

Хурандаа Аурелиано Буэндиа тэр үед нэлээд завтай байсан учир хор долоо хоног тутамд ажил хэргийнхээ явцын тухай тодорхой мэдээ Макондод ирүүлдэг байлаа. Гэвч явснаасаа хойш найм орчим сарс болоод Урсулад нэг л захидал бичжээ. Тусгай элч лацдан тамгалсан дугтуйг хүргэж ирсэнд задлан үзвэл хурандаагийн

1 Геринельдо ардын туулийн баатар, вангийн охины сэтгэлтэй болсон харлиг залуу

дармалдан бичсэн хуудас цаас гарч “Аавыг хайрлаж бай, удахгүй таалал болох нь” гэсэн байсанд Урсула сэтгэл зовж “Нэгэнтр Аурелиано тэгж байгаа бол мэдэж байгаа хэрэг” гэж сандарчээ. Тэгээд эр нөхрөө унтлагын өрөөнд оруулалцаад өгөөч гэж хүмүүсээс гуйвал тэр урьдын адил хүнд, даагдахгүй хэвээрээ байсны дээр он удаан жил туулайн бөөрний доор суусаар биеэ сул тавьж сураад, долоогийн долоон эр түүнийг сандлаас нь өргөж чадалгүй ор руу чирч аваачжээ. Нар салхинд гандаж, бороо хуранд цохигдсон хэнхгэр том өвгөнийг өрөөнд оруулахад өрөө нь нэлдээ цэцэглэж байгаа туулайн бөөр, мөөг, чийгний нэхширмэл үнэр болж билээ. Маргааш өглөө нь үзвэл ор нь хоосон байлаа. Урсула хамаг өрөөгөөр явж хайсан боловч байхгүй байсанд гарч харвал Буэндиа туулайн бөөр модон доороо оччихсон байжээ. Тэгэхд нь түүнийг ортой нь барьж хүлжээ. Буэндиа урьдын тэнхээ огт тариагүй обловч ер эсэргүүцсэнгүй. Түүний хувьд яасан ч ялгаагүй байжээ. Туулайн бөөр модны доор дахин очсон нь зориуд тэгэхээс тэгэх гэсэн бус, бие нь тэнд дассанаас л болжээ. Урсула нөхрөө асарч тойлж, идэх уухыг нь зөөж, Аурелиногоос гарсан сургийг түүнд дулугах боловч үнэнийг хэлэхэд цаадах нь ганц Пруденсио Агиляртай л удтал ярьж дасжээ. Үхээд үрэгдээд бүүр авах танаггүй болсон Пруденсио Агиляр түүнтэй хуулчих гэж өдөрт хоёр ирнэ. Хоёул тахиа баахан ярьж, үржүүлгийн газар хамтран байгуулаад, гайхалтай сайхан шувуу тэжээж, аль нь дийлэх нь хамаагүй болох учир дийллээ барилаа гэх юмгүй, гагцхүү хойд насанд эцэс төгсгөлгүй үргэлжлэх залхуут ням гаригийгзугаатай өнгөрүүлэх тухай ярилцана. Энэ пруденсио Агиляр Хосе Аркадио Буэндиагийн нүүр гарыг угааж, хооллож ундлан, Аурелино гэдэг нэртэй, хаа нэгтэй дайтаж яваа хурандаа цолтой үл таних хүний тухай сонин сонин юм ярьж өгдөг байлаа. Хосе Аркадио Буэндиа ганцаараа үлдээд, эцэс төгсгөлгүйгээр тасалгаагаар явж байна гэж



зүүдлэн тайтгаруулдаг билээ. Орноосоо босоод хаалгаа нээн, төмөр давтаж хийсэн тушлэгтэй яг л тийм ор, яг л тийм гөрмөл сандалтай, арын ханандаа Оточ охин тэнгэрийн жижиг дүртэй тасалгаанд орж, тэндээсээ яг үүнтэй адилхантасалгаанд орж, цаашаа бас адилхан тасалгаанд оронд яваад л байна, яваад л байна гэж зүүдэлдэг байлаа. Хоёр талаар эгнүүлээд тавьчихсан толины хоорондуур явж байгаа юм шиг тасалгаа тасалгаагаар ороод явахад сайхан байдаг байв... дараа нь Пруренсио Агиляр мөрнөөс нь татахад аажмаар сэрж, нөгөө олон таслагаагаараа гэдрэг явсаар ирж, жинхэнэ тасалгаандаа Пруденсио Агиляртай уулзана. Гэвч орондээр очсоноосоо хойш хоёр долоо хоноод, нэг шөнө дунд тасалгаанд байж байтал нь Пруденсио Агиляр мөрнөөс нь татсанд түүнийг жинхэнэ тасалгаа гэж бодоод буцаж явсангүй, тэндээ үүрд үлджээ. Маргааш өглөө нь Урсула нөхөртөө өглөөний цайг өгөхөөр гудмаар явж байтал хар цэмбэн хувцастай, нүд рүүгээ дарж өмссөн дэлбэгэр хар бүрхтэй гунигтай харцатай загзгар эр өөдөөс нь ирж явсанд “Тэнгэр минь, энэ чинь Меликадес гэж ам алсдан ч болох юм” гэж боджээ. Гэвч энэ бол нойр хулжаадаг өвчнөөс амь зулбан яваад сураг ажиггүй болсон Катауре байжээ. Виситасьон түүний яах гэж ирснийг асуухад өөрийн овгийн аялгуулсан, ёсорхуу хэлээр,

- Би хааныг нутаглуулах гэж ирлээ гэж хариулав.

Тэгэхэд нь цөмөөрөө Хосе Аркадио Буэндиагийн өрөөнд ороод түүнийг байдгаараа татаж чангааж, чихэнд нь хашгирч, гуугалж, хамрын нүхэнд нь толь ойртуулж үзсэн боловч сэрээж чадсангүй. Дараахан нь мужаан авс хийхээр бүрлээчээс хэмжээ авч байгаад цонхоор харвал гадаа жижигхэн жижигхэн шар цэцгийн хур орж байлаа. Цэцэгс дуугйү асгарах аадар аятай шөнөжин буусаар байшингийн бүх дээврийг дарж, хаалгыг дарж гадаа унтаж байсан малыг даран өглөө болоход Макондог хивс аятай битүү бүрхэж, хүрз тармуураар оршуулгын жагсаалын замыг цэвэрлэх хэрэг гарч билээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Амаранта гөрмөл ганхуур сандал дээр сууж юм хатгамаллаж байснаа өвөр дээрээ тавиад, Аурелиано Хосег хацар эрүүгээ хөөсөртөл савандан суран бүсэнд тонгоргоо нийлээд, анх удаагаа сахлаа вч байхыг харж байлаа. Аурелиано халиун унгарилаа живэр болгохгэж оролдон, хамаг батганыхаа толгойг авч, дээд уруулаа эсгээд яг л урьдынхаа хэвээр үлдсэн боловч сахал авахгэж ингэж төвөг болж байгаагий нь Амаранта үзэхдээ Аурелиано Хосе ингээд хөгшрөх тийшээ болдог байжээ гэж бодоод

- Чиний насанд Аурелиано яг л ийм байж билээ. чи эр хүн болжээ гэж хэлэв.

Тэр эр хүн болдгоо аль хэдийнээ болчихсон байсан боловч түүнийг хүүхдээрээ байна гэж бодсоор байсан. Амаранта угаагуурын өрөөнд дэргэд нь хувцсаа ердийнхөөрөө тайлсан хэвээрээ байжээ. Пилар Тенерагаас хүүхдийг авснаас хойш хувцсаа тийнхүү дэргэд нь тайлаад сурчихсан байлаа. Жаал хүү анхлан түүний хоёр хөхний хоорондох гүн хонхорхойг шохоорхож, учир мэдэхгүй гэнэхнээрээ байсан болохоор яагаад ийм болчихсныг асуухад Амаранта “Ухсаар ухсаар ийм болгочихсон юм” гэж гараараа яаж ухсаныг зааж үзүүлжээ. Олоон жилийн хойно Амаранта Пьетро Креспийн нас барснаас хойш жаал сэтгэлийн хямрал гайгүй болоод, дахин Аурелиано Хосетай хамт усанд ордог болоход хөвгүүн хонхорхойг нэгэнт хайхрахаа болиод, хүрэн товчтой сэргэр мээмийг харахдаа урьд өмнө байгаагүйгээр чичрүүдэс нь хүрч билээ. Аурелиано Хосе бүүр жаахандаа үүр гэгээрмэгц дүүжин орноосоо гарч Амарантагийн өвөрт орж, биенд нь наалдахад харанхуйгаас айхаа больдог байж билээ. Гэвч эгчийнхээ нүцгэн биеийг анзааран харснаас хойш харанхуйгаас айсандаа бус, үүрээр халуун амьсгалаар нь төөнүүлэх гэж туйлгүй хүсэхдээ өвөрт нь орох болжээ. Хожим нь тэр хоёр хамт нүцгэн унтаж, биесээ тамлан янаглалцах болосн төдийгүй буланд нуугдаж, хий л гарвал үл дарагдах байнгын хуялд автан дуртай цагтаа унтлагын өрөөнд түгжих болжээ. Нэг удаа тэр хоёрын сайхан үнэсэлдэж эхэлж байтал Урсула агуулахаар орж ирээдтэр хоёрыг золтой л харчихсангүй. “чи авга эгчдээ их сайн юм аа?” гэж Урсулагийн гэнэ сэрэггүй асуусанд ач нь “тийм” гэжээ. “Сайн хэрэг ээ” гэж Урсула хэлээд, талхны гурил хэмжиж аваад гал зуух руу буцаж явжээ. Энэ ялихгүй явдлаас Амаранта ухаан оров. Хүүхэн арай ч дэндэж, хүүхэдтэй зүгээр нэг үнэсэлдэж тоглож байгаа ус, оройтсон тачаал, аюултай бөгөөд ямар чирээдүйгүй тачаалын бамбалзуур намгаар явж байгаагаа ойлгож, үүнийг бүрмөсөн цэглэв. Тэр үед ийм явдал болсонтой аргагүй эвлэрч, хуарандаа хонох болжээ. Бямба гаригт тэрбээр цэргүүдийн хамт Катариногийн газар очино.

Түүнээс хойш удаагүй байтал Макондод дайны тухай их зөрчилтэй мэдээ ирэх болов. Босогчид удаа дараа ялалт байгуулж байна гэж засгийн газар албан ёсоор хүлээн зөвшөөрч байсан боловч Маркондогийн хүлээн зөвшөөрч байсан боловч Макондогийн офицерууд бууж өгөхөөс гарцаагүй болж байгаа тухай нууц мэдээ авч байлаа. Дөрөвдүгээр сарын шинэдээр хурандаа Геринельдо Маркест зарлага ирэв. Либерал намын удирдагчид тус орны дотоод мужийн босогчдын багийн удирдагчидтай хэлэлцээ үнэхээр хийж, удахгүй либeарлууд гурван сайдын суудал авах, парламентад либералуудын цөөнхийг байгуулах, зэвсгээ хураалгасан босогчдыг өршөөх ийм гурван болзлоор засгийн газартай түр найрамдал байгуулах гэж байгааг элч баталлаа. Тэр элч түр найрамдах болзлыг зөвшөөрөхгүй байгаа ухрандаа Аурелиано Буэндиагийн маш нууц тушаалыг хүргэж иржээ. Хурандаа Геринелодо Маркест хамгийн найдвартай таван хүнийг сонгонавч, тус орноос гарахад бэлхэн байхыг тушаасан байлаа. Тушаалыг маш нууцаар биелүүлэв. Түр найрамдахыг албан

ёсоор зарлахаас долоо хоногийн өмнө, Макондод элдэв цуурхал дэгдэж байх үеэр ухрандаа Аурелиано Буэндиа, түүнд үнэнч арван офицер, тэдний дотор Яргачин Роке нар хотод шөнийн харанхуйгаар сэмхэн ирж, суманг гэр гэрт тараагаад, зэсвгээ бужл, архваа устгаад, үүрээр хурандаа Герниельдо Маркес, түүний таван хүний хамт Макондогоос оджээ... Уг ажиллагааг түргэн зуур маш чимээгүй явуулсан учир Урсула нэг хүнийг цонх гогшшд, “Хурандаа Аурелиано Буэндиатай уулзах бол түргэн гар” гэж шивнэхэд сая мэдэж орноосоо үсрэн босоод, унтлагынхаа хувцастай гудамжаар харайлгасан боловч хэнтэй ч тааралдсангүй, гагцхүү хар хурдаараа давхин одох морьдын төвөргөөнийг л дуулж, хэсэг морьтон тоос гозойлгосор далдарч байхыг харжээ. Хойд өдөр нь л мэдвэл Аурелиано Хосе аавтайгаа хамт явчихсан байлаа.

Засгийн газар сөрөх хүчин дайн дууссан тухай хамтарсан албан мэдээг утнхагласнаа схойш аравхонож баттал “Өрнөд хил дээр Аурелиано Буэндиа анхын бослого гаргаж гэнэ.” Гэмээн амьтан шуугиад явчихав. Цөөн тоотой, зэвсэг муутай босогчдын баг ганц долоо хоноргт л сарнив. Либерал, консервативчууд эвлэрснээ улс оронд итгүүлэх гэж байдгаараа чармайг байх хоорлонд хурандаа Аурелиано буэндиа долоон зэвсэгт бослого гаргажээ. Нэг шөнө тэрбээр далбаа онгоцон дээрээс Риоачаг их буугаар буудаж, үүний нь хариуд тус хотын суман хамгийн нэртэй арван дөрвөн либералыг орноос нь чирч босгоод буудаж орхижээ. Хурандаа Аурелиано Буэндиа хилийн гаалийн цэгийг эзэлж аваад, арван тав хоног тогтоон барьж тэндээс бүх нийтээрээ дайнд босохыг үндэстэнд уриалжээ. Өөр нэг удлаа тэрбээр нийслэлийн дүүрэгт байлдааны ажиллагаа явуулахын тулд хүний мөр гараагүй шивэр модондундуур мянга таван зуун километр газар туулах гэсэн бүтэшгүй төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэж битүү ширэнгэн дундуур гурван сар будлин хэржээ. Нэг удаа Макондод хорь хүрэхгүй километр ойртсон боловч засгийн газрын цэргийн тэргүүний ангиудад шахагдан, уул руу ухарч, олон жилийн өмнө эцгийнхээ испанийн хөлгийн сэг олсон тэр нэгэн илбэдүүлсэн цоорхойн хажууханд очиж билээ.

Яг тэр үеэр Виситасьон үхэв. Тэгэхдээ нойр хулжих өвчин тусаж зуурдаар үхэхээс айж хаан ширээгээ хаяж ирсний хэрэг юу билээ, өөрийн үхлээр үхэх гэсэн санаандаа хүрчээ. Хорь гаруй жил ажиллахдаа хураасан мөнгөө орон доорх аварнаас нь авч хурандаа Аурелиано Буэндиад явуулаарай гэж эцсийн захиасаа захижээ. Гэвч хурандаа Аурелиано Буэндиа мужийн төвийн ойролцоо эрэгт буух гэж байгаад амь үрэгдсэн гэсэн цуурхал гарсан учир Урсула тэр мөнгөнд огт гар хүрсэнгүй. Хурандаа Аурелиано Буэндиагийн тухай ганц ч сурах гарахаа больсон учир түүний үхсэн тухай сүүлийн хоёр жилд дөрөвдөхөө ирж байгаа албан ёсны тэр мэдээг ч зургаан сар хэртээ үнэн гэж үзжээ. Урьдах бэлэвсрэл дуусаагүй байхад Урсула, Амаранта хоёр дахин гашуудал зарлачихаад байж байтал Макондод хчин мэдээ ирсэн нь хурандаа Аурелиано буэндиа амьд боловч өөрийн орны засгийн газартай тэмцэхээ болиод,

Карбиын тэнгисийн бусад улсад ялгууснаар тулалдаж байгаа холбооны үзэлтнүүдтэй нийлсэн бололтой гэсэн мэдээ байлаа. Түүний сураг өөр хүний нэрээр гарахбүрийд эх нутгаасаа бүр холдсон байдаг байлаа. Тэр үед тэрбээр Төв Америкийн холбооны үзэлт бүххүчийг нэгтгэж, Аляскаас Патагони хүртэлх нийт тив даяар консервативчуудын засгийн газрыг түлхэн унагах үзэл санаанд автсан байсан нь хожим мэдэгдэнэ. Урсула хүүгээ Макондоогоос вьясаар хэдэн жил болсны дараа анхны захиа авсан нь, Кубийн Сантьяго хотоос гарч гар дамжин үнгэгдсээр үсэг нь балрах шахсан захидал байлаа.

- Аурелианотйогоо уулзахаа өнгөрчээ. Энэ байдлаар бол жил болоход ертөнцийн хүрэх нь гэж Урсула захиаг уншаад дуу алджээ.

Урсулагийн ингэж хэлээд захидлыг хамгийн түрүүнд үзүүлсэн хүн нь гэвэл дайны дараагаар Макондогийн захирагчаар томилогдсон консерваивч үзэлтэй генерал Хосе Ракель Монкада байжээ. “Ай хөөрхий, энэ Аурелиано консерватив үзэлтэн байгаагүй нь юутай тоогүй” гэж генерал Монкада дуугарчээ. Монкадоа үнэхээр хурандаа Аурелиано Буэндиаг бахархдаг байв. Консерватив намын энгийн хүмүүсийнадил Хосе Ракель Монкада намынхаа олон нөхдийн нэгэнадил цэргийнхнийг итгэлтэй эсэргүүцдэг байлаа. Цэргийнхэн бол “Муу хүн самбаанд, чоно бороонд” гэгчээр энгийн иргэдэд эр бар гаргаж явда, авах танаггүй залхуу, яс хаяагч, нэр тушаал хөөцөлдөгч гэж үздэг байлаа. Ухаалаг, нүдэнд дулаан, үргэлж баясгалантай явдаг, тамсаг, тахианы зодооны үлэмж хорхойтон генерал Хосе Ракель Монкада нэг үе хурандаа Аурелиано Буэндиагийн хамгийн аюултай дайсан байлаа. Тэрбээр далайн эргийн уудам нутагт шинээр гарч ирсэн цэргийнхний дотор нэр хүндтэй болжээ. Нэгэн удаа стратегийн бодлын улмаас нэг цайзыг хурандаа Аурелиано Буэндиагийн цэрэгт өгөх болоход хоёр захидал түүнд орхижээ. Нэлээд дэлгэрэнгүй нэг захидалдаа генерал дайн явуулах энэрэнгүй аргын төлөө хамтарсан кампани явуулъя гэж санал болгосон байлаа. Нөгө өзахидлаа босогчдын эзэлсэннутагт сууж байсан гэргийдээ өгүүлж, тэндээ зурвас хавсаргаж, захидлыг хаягаар хүргэж өгөхийг хүссэн байлаа. Түүнээс хойш дайны хамгийнх цус урсгасан үед ч хоёр командлагч олзлогсдыг солилцох түр эвлэрэл байгуулдаг байлаа. Генерал Монкада баяр ёслолын байдалтай амсхийх үеэрхурандаа Аурелиано Буэндиад шатар заадаг байлаа. Тэр хоёр их найз болжээ. Тэр ч байтугай хоёр намынэгэл хүмүүсийн ажиллагааг уялдуулж, ингэснээр цэргийнхний болон мэргэжлийн улс төрийн бодлогтнуудын нөлөөг устгаж, нам намынхаа номлолоос аль сайныг нь хэрэглэх энэрэнгүй байгуулал тогтоох боломжийг эргэцүүлж байжээ. Дайн дуусаж, Аурелиано Буэндиа хорлон сүйтгэх эцэст төгсгөлгүй ажиллагааны бартаат замд ороход генерал Монкада Макондогийн захирагчаар томилогджээ. Тэрбээр дахиад энгийн хувцас өмсөж, цэргээ зэвсэггүй цагдаагаар сольж, өршөөл үзүүлэх хуулийг хүндэтгэх үүрэг тавьж, дайнд амь үрэгдсэн зарим либералын ар гэрт тусалж байлаа. Тэр ч

байтугай Макондог муниципийн<sup>1</sup> тойргийн төв гэж зарлаж, захирагч байснаа шүүгч болж хотод амар төвшин байдал тогтоогоод хмүүүс дайныг аль дивангарын хар дарсан зүүд мэт бүүр түүр санах болжээ. Элэг муудаж шаналсан Никанор ламыг анхны холбооны үзэлтний дайнд оролцож явсан Коропель ламаар сольж, түүнийг макондогийнхон “хөндий цээж” гэж дуудах болжээ. Бруно Креспи Ампаро Москотетой гэрлээд тоглоомын дэлгүүрээ улам өөд татан, Макондод таедр байгуулсанд Испанийн явуулынтаетрын жүжигчид ирж тоглох болжээ. Театр нь дээвэргүй том савбөгөөд модон вандан тавьж, грек багийн дүрстэй хилэн хөшиг зүүж, пиуг арслангийн толгойг дуурайлган хийсэн хоёр кассад том гэгч ангайсан амаар худалддаг байлаа. Тэр үед л сургуулийн барилгыг засаж янзлав. Хөндийн нэг хотоос өвгөн дон Мельчор Эскалоно багшаар ирж, залхуу сурагчдыг чулуу дэвссэн хашаан дотуур мөлхүүлж, аманцруудад нь энэтхэгийн м дарвингуулсан чижнүү идүүлж, эх эцэг нар түүнийг нь сайшаах болжээ. Санта Софи де ла Пьедалы дүрсгүй хоёр ихэр Бага Аурелиано, Бага Хосе Аркадио нэрийг нь тавьсан хөнгөн цагаан жижиг сэнжтэй аяга, үнсэн самбартайгаа сургуулийн ширээнээ эхний сурагчидтай хамт суужээ. Ремедиос эх шигээ царайлаг тул Сайхан Ремедиос гэж алдаршиж эхлэв. Үхэл зовлон үзэж, ажил төрөлд дарагдавч Урсула ануухаараа байлаа. Санта Софи де ла Пьедадаар туслуулж байгаад нарийн боов дахин зөндөөнөөр хийж зараад, хүүгийнхээ дайнд зрасан зардлыг нөхөөд зогсоогүй хэдэн тарвас хөндийлөн хатааж, дотор нь шижир алт дүүргээд унтлагынхаа өрөөнд хадгалжээ. “Тэнгэр намайг

1 Муниципи –засаг захиргааны нэгж.

аваагүй цагт галзуугийн энэ байшинд мөнгө хүрэлцэхээрээ л байх болно” гэж дандаа ярьдаг байлаа. Иймрхүү байдалтай байж байтал Аурелиано Хосе Никарагуад байсан холбооны үзэлтний цэргээс оргож, германы хөлөг онгоцонд гэрээ байгуулсан усан цэргээр ороод, морь шиг том бие, индиан шиг бор царайтай, урт гэгчийн үстэй болчихсон, Арамантай суух далд бодолтойгоор гэртээ ирж билээ...

Амаранта яах гэж буцаж ирснийг нь Аурелиано Хосергоор үг хэлүүлэлгүй харангуут л мэджээ. Хоол идэж байхдаа бие биеэ харж чадахгүй харц далдирдаг байлаа. Аурелиано Хосе эргэж ирснээсээ хойш хоёр долоо хоноод урсулагийн нүүрэн дээр Амарантагийн нүдийг ширтэж, “Чамайг дандаа бодож явлаа” гэж хэлжээ. Амаранта уулзахгүйг хичээн түүнээс зугтаж сайхан Ремедиосоос үл холдоно. Нэг удаа Аурелиано Хосе “Гартаа хар уяагаа хэдий болтол зүүж явах юм бэ?” гэж асуухад нь Амаранта өөрийнх нь одоо болтол эр хүнтэй хавьтаагүй байгааг нь битүү хэлж байгааг ойлгон хацар

нь улайснаа үүндэ эөөрөө уур нь хүрчээ. Аурелиано Хосег эргэж ирснээс хойш унтлагынхаа өрөөний хаалгыг түгжиж унтдаг болсон боловч хажуугийн өрөөнд тайван хухирч байхыг нь шөнө сонсоод болгоомжлохоо мартаж орхижээ. Түүний буцаж ирснээс хойш хоёр сар шахам болж байтал Амаранта нэг шөнө түүнийг унтлагынх нь өрөөнд сэвхийтэл ороод ирэхийг мэдсэн чзугтаж хашгирахын оронд харин ч сэтгэл амран тайвшрах шиг болоод орондоо таг болжээ. Энэ шөнөөс хойш тэр хоёр өглөө болтол дэмий л ноцолдож хонох боллоо. Үүрээр Аурелиано Хосе явах боловч шөнө халага түгжээгүй байхад дахин орж ирээд, хурьцал нь улам өрөнхүүхнийг барьж авна. Амарантаг хүсэхнь тийнхүү хэзэ ч намдахгүй байлаа. Холдож яваадахвал Амарантаг мартаж магадгүй гэж гэрээсээ зугтаж, түүнийг мартаг гэхдэ зэвсэг нэгт нөхдөдөө чин зоригто йгэж хэлүүлэн харгис хэрцгий авирлаж дайны бузар булайд түүний дүрийг хэчнээн хутгавч мартаж ер чадсангүй. Амарантагаас ангижрахын тулд үхэх арга хайн харьд зовж явтлаа нэг хүн эгчтэйгээ сууж, тэр нь бас үеэл эгч нь байж, тэгэхлээр тэр хүний хүү өөрийнхө өөвөө болсон нэг шогийг дуулжээ.

- Авга эгчтэйгээ сууж болно гэж үү? Хэмээн Аурелиано Хосегийн гайхан асуухад нэг цэрэг
- Авга эгчээр барах уу. Хар лам нарын эсрэг бид юунд тулалдаж байна гэж санана вэ? Төрсөн эхтэйгээ ч суусан болохоор болгохын тулдбиш үү?! Гэж хариулжээ.

Ингэж ярилцсанаас хойш хоёр долоо хоноод Аурелиано Хосе оргожээ. Түүнд хоргоолгоод залхаж гүйцсэн Амранта “Чи мал юм аа. Ромын папын зөвшөөрвөл л авга эгчтэйгээ сууж болно гэдгийг чи мэдэггүй юм гэж үү?” гэжээ. Их хутагт Амарантаг өөрт нь нүүр өгдөгболгох юм бол бүх Европыг мөлхөж ч гэсэн туулаад, Ром орно, түүний гутлыг ч хамаагүй үнсэнэ гэж Аурелиано Хосе хэлжээ.

- Ганц зөвшөрөөхд ч учир байгаа юм бишээ. Тэгж суувал гахай сүүлтэй хүүхэд гардаг юм гэж Амаранта булзаж үзэв.

Аурелиано Хосе түүний юу ч гэж хэлсэн тоохгүй

- Матар төрсөн ч яадаг юм гэж зүтгэжээ.

Нэг үгээр хүсэл хангагдаагүй зовсон Аурелиано Хосе Катариногийн байшинд очиж, унжсан мээмтэй, гарын аяа хямдхан хүүхэн олж, тачаалаа түрнамжаажээ. Одоо тэрбээр Амарантаг тоохгүй царайлан буулгаж авах гэж үзэв. Гонхонд оёдлын машин сурмаггэгч нь торчигнуулан байхад хажуугаар нь гарахдаа ганц үг дуугарахаа больсонд Амаранта мөрөн дээрээс нь нэг юм аваад хаячих шиг болж, яагаадыг бүү мэд, гэнэт хурандаа Геринельдо Маркесийг бодож, орой даам тавьдаг байснаа гуниглан санаж, тэр ч байтугай антлагынхаа

өрөөнд ороод ирээсэй гэж бодох болжээ. Аурелиано Хосе айлгах гэсэн биш ал дэлэм алсданаа төсөөлөөгй л явав. Нэг шөнө тоохгүй дүр үзүүлэн явж тэсэхээ болиод Амарантагийн өрөөнд орвол түүнийгогт халгаасангүй, хаалгаа үүрд түгжиж орхив.

Аурелиано Хосег Макондод буцаж ирээд хэдэн сар болж байтал малига цэцгийн үнэр ханхлуулсан махлаг хүүхэн тав хэрийн насны хүүхэд дагуулан ирж. “Энэ бол хурандаа Аурелиано Буэндиагийн хүү учир Урсулагаар адилуулахгэсэнюм” гэжээ. Нэргүй тэрхүү хэний хүүхэд вэ гэдэгт эргэлзэхюм байсангүй, хурандааг жааханд нь мөс үзүүлэх гэж авч явах үед яг ийм байж билээ. Хүү нүд нь харатай төрж, орчин тойрноо ихэмсгээр харсан, юмыг нүд цавчилгүй ширтдэг нь айдас төрүүлдэг гэж эхийг нь хэлэхэд Урсула “Эцгээ өвчжээ. Харахад нь ширээ өөрөө хөлдөг ганц юм л дутаж” гэж хэлэв. Эцэг нь хүүгээ гэж үзээгүй цаг эцгээрээ овоглохыг хулуиар хориглодог тул жаал хүүд Аурелиано гэж нэр өгөөд эхээр нь овогложээ. Генерал Монкада загалмай зүүлгэсэн эцэг нь болов. Амаранта хүүхдээ өөрт нь орхиод яв гэсэн боловч эх нь өөрөө хүмүүжүүлнэ гэжээ.

Урьд нь Урсула үүлдэр сайтай тахианд эм тахиаг гаргадаг шиг алдартай дайчны өвөрт бүсгүйчүүдийг оруулдаг заншил байдаг гэж огт дуулаагүй байсан боловч энэ жилийн турш тийм ёс байдагт бүр үнэмшив. Хурандаа Аурелиано Буэндиагийн бас есөн хүүхдийг адислуулах гэж тэднийд авч иржээ. Хамгийн том нь болох хар үстэй, ногоон нүдтэй, эцгийн талын сандантай огт төсгүй хачин хөвгүүн арав гаруй настай байлаа. Янз бүрийн насны янз бүрийн зүстэй тэр хүүхдүүд цөм бүстэй бөгөөд харахад ганцаардсан бадйалтай тул буэндиагийн удам судар гэдэгт эргэлзэх зүйлгүй балйа. Тэр олны дотроо Урсула хоёрыг л нүдэлж хоцорчээ. Нэг нь насандаа байшгүй том биетэй хүү цэгийн ваар хэдэн тавгийг нядааж өгсөн нь тэр хүүгийн гар нь хүсрэн бүхнээ будаа болгох увдистай юм уу гэмээр байлаа. Нөшгөө нь бордуу цэнхэр нүдтэй, охин хүүхдийнх шиг урт мушгирсан үстэй, цавйар царайтай хүүхэд байлаа. Тэр энд өсөж, эндхийнбүх юмыг мэддэг юм шиг огтхон ч бишүүрхсэн янзүгү йгэрт орж ирээд урсулагийн унтлагын өрөөндэх хайрцаг руу шууд очиж “Би оньстой бүжигчин авна” гэж хэлжээ Урсула цочих шиг болов. Хайрцгаа нээн, Мелькиадесийнүеийн хуучин, тоос шорхоо болсон юмсыг онгичиж, хуучин оймсонд боосон тэр оглоомыг олжээ. Түүнийг Пьетро Креспи авчирч өгөөд аль эрт мартаж охисон байлаа. дайн дажны эрхээр очсон газар бүрдээ хурандаа Аурелиано Буэндиагийн охисон бүх хүүхэд Аурелиано Буэндиагаан орхисон бүх хүүхэд Аурелиано гэдэг нэртэй эх нарынхаа овогтой болсноос хойш арван хоёр жил ч өнгөрөөгүй байлаа. тийм хөвгүүд арван долоо байна. Эхний үед Урсула тэдний халаасанд нь мөнгө дүүргэж, Амаранта авч үлдэх гэж зтгэж байсан боловч сүүлдээ хоёулаа жаал зугаа бэлэг өгөөд, загалмай зүүлгэсэн эхийн байдалтай л болов. Урсула тусгай дэвтэрт хүүхдийн овог, эхийн хаяг, хүүхдийн төрсөн өдөр, газрыг бичиж байхдаа, “Эднийг адислаж байгаараа

элбэрэл журмыг гүйцэтгэж байга аюм. Аурелиано буцаж ирээд тэдний хувь заяаг шийдэх учиртай тул санхүүг нь жин тан байлгах ёстой” гэдэг байв. Нэг удаа үдийн хоол идэж байхдаа генеал Монкзадатай хуандаа Аурелиано Буэндиагийн сэжиглэмээр үр төлтэй байгаа тухай үг хэлэлцэж суугаад түүнийг эргэж ирж хүүхдүүдээ гэртээ цуглуулж аваасай даа гэж хэлэхэд Монкада:

- Эчг минь санаа бүү зов. Аурелиано таны бодож байгаагаас эрт ирнэ гэж учиртай гэгч хэлжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа өнөөг хүртэл өөрийн гаргасан бослогын дотроос хамгийн удаан, шийдэмгий, цуст бослогыг толгойлохоор эх нутагтаа ирж явсныг генерал Монкада мэдэж байсан боловч хоолны үед хэлэлгүй нуугаад өнгөрчээ.

Байдал анхны дайны өмнөх хэдэн сарынх шигдахин түгшүүртэй болов. Хотын зөвлөлийн даргын санаачилсан тахианы зодооныг явуулахаа болив. Сумангийн дарга ахмад Акилес Рикардо иргэний зарсгийн эрхийг ч хэрэгдээрээ гартаа авлаа. Либералууд түүнийг хутган үймүүлэгч гэж зарлав. “Нэг л аймара юм болох нь Оройн зургаан цагаас хойш гадаа бүр гар” гэж Урсула Аурелиано Хосед хэлж гуйсан боловч нэмэр бослонгүй, урьд аркадио эмгэнийг тоодоггүй байсан шиг Аурелиано хосе түүний үгэнд ордоггүй байв. Тэрбээр гэртээ буцаж ирэдэ биеэ ордоггүй байв. Тэрбээр гэртээ буцаж ирээд биеэ оторлоодб айх болможтойд эрэмшээд Хосе Аркадио авга шигээ хурьцахуйн цэнгэлд дуртай, хашин хойго зантай болжээ. Аурелиано Хосе Амарантад тачаах нь намдаж, сэтгэлд нья мар ч сорви үлдсэнгүй. Давалгааны аясаар хөвөн явах мэт шаариг цохиж, тохиолдлын хүүхэнтэй энгэр зөрүүлэн уйтгараа гаргаж, Урсулагийн мөнгөө хадгалдаг нууц газрыг сэм өнгийдөг байлаа. Сүүлдээ гэртээ хувцсаа солих гэж л нэг ирэх болов. “Эд цөмөөрөө адилхан. Багадаа тайван үг дууламтайг, хорхойд хоргүй гэмээр байдаг мөртлөө сахлаа цухуйв уу үгү йюу нүгэл хилэнц үйлдэж гарах юм” гэж Урсула үглэнэ. Аурелиано Хосе эхийг Пилар Тернера гэдгийголж мэдээ, гэрт нь үдээр хажуулж байх дүүжин ор түүгээр хийлгэж авснаараа Аркадитой адилгүй байлаа. Хоёул зүгээр нэг эх хүү хоёр байсангүй, ганцаардахын цагт бие биендээ хань болж байлаа. Пилар Тернерагийн сүүлчийн өч бөхөж, инээд нь бадралт баг бишгүүрийн дуу шиг намуун болж, дайралдсан амьтанд даруулсаар байтал хөхнь шулбайж, гэдэс нь хулхайж, булчин нь шуугдаад, янхан хүүхний л оноо төөргөөр орсон обловч огоот харуусах юм байсангүй. Халбийтал таргалсан хэл амтай, хаандаа нүүргүй болсон нууц амраг шиг дээгүүр зангаа тавиагүй тэрбээр шал дэмий горьдохоос наашгүй хэзрийн мэргээ орхиж бусдын амрагийн явдлаар сэтгэлээ зогоон, санаа амарс уух болов. Аурелиано Хосегийн үдээс хойш амардаг байшин айлынх нь бүсгүйчүүдийн нууц амрагуудтайгаа уулздаг газар болжээ. Пилар аа, биднийг орууличх л даа” гэж бүр өрөөнд орж ирчихсэн хойноо ичиж барих юмгүй гуйна.



“Тэг ээ, тэг” гэж Пилар хариулаад, дэргэдээ хүн байвал ‘Улс амьтныг өвөртөө ороод сайхан байхыг харахад өөрт минь ч сайхан болдог юм’ гэж тайлбарладаг байлаа.

Тэгж тус хүргэсэндээ хөлс мөнгө авна гэж зангүй,. Насны наран хэвийтэл нь хөлс мөнгө ч өгдөггүй, хайр сэтгэл ч бэлэглэлдэггүй, гагцхүү хүслээ хангаад өнгөрдөг тоо томшгүй эрчүүдийн өвөртөө оруулахыг гуйхад нь хэзээ ч “Үгүй” гэдэггүй байсан шигээ гэртээ оруулаач гэж залуусын гуйхад мөн л ерөөс цааргалдаггүй байв аа. Эхийнхээ дурэлзсэн сэтгэлийг авч төрсөн таван охин нь арван хэдэн насандаа амьдралын нугачаат замаар таран оджээ. Гэртээ өссөн хоёр хүүгийн нэг нь хурандаа Аурелиано Буэндиагийн тугийн дор тулалдаж яваад амь үрэгдэж, нөгөө нь арван дөрөвтөйдөө хөндийн нэг хотод сагстай тахиа хулгайлах гэж байгаад шархтан баригджээ. Аурелиано Хосе нь нэг ёсондоо Пилар Тернерагийн төлөгт тавин жил цэцгийн ноён болж бусан өндөр, бор эр болсон боловч мөн л мэргэд бууж байсан бүх хүмүүсийн адил дэндү орой, эрлэгийн элчид тамгалуулчихсан хойноо сэтгэлийг нь эзэмджээ. Тэгснийг нь Пилар Тернера мэргэлж мэдээд,

- өнөө шөнө бүү гар, эндээ унт, Кармелита Монтъел чамтай унтуулж өгөөч гэж аль эртний гуйгаад байгаа юм гэж хэлжээ.

Аурелиано Хосе эхийнхээ дууг түгшсэн өнгөтэй байгааг анзаарсангүй.

\- Шөнө дунд хүлээж бай гэж хэлээрэй гэж хариулжээ.

Тэгээд испанийн жүжигчид “соррын хутаг”<sup>1</sup> жүжиг тавьж байгаа театрт очив. Угтаа бол энэ нь Соррилийн эмгэнэл жүжиг байсан боловч либеарлууд консервативчуудыг “гот” гэж хочилдог байсан тул ахмад Акилес Рикардогийн тушааснаар нэрийг нь өөрчилсөн байжээ. Хаалган дээр пиугаа үүүлж байхдаа ахмад Акилес Рикардо буутай хоёр цэргийн хамт орж ирсэн бүх хүнийг нэгжиж байгааг ажиглав. “Ахмад аа, аядаарай.. Надад гар хүрэх гүн хараахан төрөгүй байгаа” гэж Аурелиано Хосе сануулбал ахмад түүнийг хүчээр нэгжи гэж оролдсонд биедээ зэвсэг авч яваагүй мөртлөө булт үсрэн зугтав. Цэргүүдл ахмадын “Бууд!” гэсэн тушаалыг дагасангүй, нэг нь “Энэ чинь Буэндиа шүү дээ” гэж тайлбарласанд галзуурах мэт уурласан ахмад винтов шүүрэн аваад, олны дундуур дайран гарч, буугаа шагайн,

- Хулчгарууд! Хурандаа Аурелиано Буэндиа өөрөө ч байсан би буудна гэж хашгирчээ.

Хорин настай, онгон хальстайгаа бүсгүй Кармелита Монтъел цэцгийн усаар биеэ арчиж, Пилар Тернерагийн орон дээр төгрин дэлбээ цацаж байтал буу дуугарав. Хэзрийн төлөгт бууснаар бол Аурелиано Хосе, амарантагийн өгөөгүй жаргалыг тэр бүсгүйтэй эдэлж, хамт зургаан хүүхэд өсгөж, нас өндөр болсон хойно гар дээр нь нас барах ёстой байсан боловч нуруугаар нь орж,

цээжийг нь цөм цохисон сум өхзрийн мэргийн учрыг сайн олсонгүй бололтой. Гэвч тэр шөнө үхэх цондонтой байсан Азкилес Рикардо, Аурелиано Хосегоос дөрвөн цагийн урьд үнэхээр үхэв. Ахмад дөнгөж буулдангуутаа хоёр суманд оногдон өөрөө унаж, олонхүн:

- Либерал нам мандтугай! Хурандаа Аурелиано Буэндиа мандтугай! Гэж шөнийн харанхуйд нижгэнүүлэн хашгирав.

Шөнийн арван хоёр цагт Аурелиано Хосегийн шархнаас цус шүүрэхээ больж, кармелита Моньтелийн хувь заяаны тухай төлөг төөрч байхад жүжгийн хүрээлэнгийн өмнүүр дөрвөнзуун хүн жагсан өнгөрч, гудамжны

1 Испанийн яруу найрагч, жүжгийн зохиолч Хосе Соррилийн (1817-1893) нэг эмгэнэлт жүжгийг хэлж банья. Уг жүжгийн жинхэнэ нэр нь “Готын хутаг” юм.

Голд орхисон ахмад Акилес Рикардогийн хүүрэн дээр бууныхаа бүх сумыг шигтгэжээ. Нормсон талх шиг нялцайж доторх тугалгандаа даагдахгүй шахам хүндэрсэн хүүрийг цэрэг хамжин байж түрдэг тэргэн дээр гаргажээ.

Засгийн газрын цэргийн цадиггүй авирлаж байгаад эгдүүцсэн генерал Хосе Ракель Монкада улс төрийнхөө бүх холбоо сүлбээг ашиглаж байгаад дахин дүрэмт хувцсаа өмсөж, Макондогийн иргэний ба цэргийн эрхийг гартаа авлаа. Гэвч ийм илбэн тохинуулах үйл ажилагаа явуулснаараа жамтай юмыг жамаас нь болиулна гэж найдахгүй балаа. Есдүгээр сарын мэдээ зөрчилтэй байлаа. Засгийн газар орон даяар хяналтаа тогтоосон гэж мэдэгдэж байсан боловч дотоод хэд хэдэн муж улсад зэвсэгт бодлого гарсан тухай нууц мэдээ либраллуудад ирж байв. Эрх баригчид хурандаа Аурелиано Буэндиаад цаазаар авах эчнээ ял ногдуулсан тухай цэргийн онц шүүхийн шийдвэрийг тунхаглахдаа л сая улс орон байлдааны байдалтай байгааг хүлээжээ. Хурандааг олзлон авсан эхний суман л тогтоолыг гүйцэтгэх ёстой байв. “Тэгэхлээр хүү иржээ” гэж Урсула генерал Мокандад баялан хэлэхэд цаадах нь энэ тухай ямар ч мэдээ аваагүй байлаа.

Үнэндээ бол хурандаа Аурелиано Буэндиа сарын өмнө нутагтаа буцаж ирсэн байлаа. Хурандаа Аурелиано Буэндиагийн эргэж ирсэнтэй холбогдоод янз бүрийн цуурхал дэгдээж, түүнийг хоорондоо хэдэн зуун километрийн зайтай газарт нэг зэрэг байнагэж хэлцэх тул генерал Монкада хүртэл хурандаа Аурелиано уэндиагийн эргийн хоёр муж улсыг эзлэн авсныг албан ёсоор зарлалат ирсэн гэж итгэхгүй байж билээ. “Эгч минь, танд баяр хүргэе. Удахгүй та хүүтэйгээ энд уулзана” гэж Генерал Монкада Урсулад

хэлжээ. Тэгэхэд л Урсула анх удаагаа сэтгэл зовж “Дүү минь та яадаг билээ?” гэж асуужээ. Монкада ингэж өөрөөсөө олонтаа асуужээ.

- тэрүүн шиг л үүргээ биелүүлэх болно доо.

Аравдугаар сарын нэгэндүүрээр хурандаа Аурелиано Буэндиа сайн зэвсэг бүхий мянган цэрэгтэйгээр Макондог дайрч, суман эцсээ хүртэл эсэргүүцэх тушаал авав. Үдээр генерал Монкада Урулатай хоол идэж байхад, самуун дэгдээгчдийн их бууны дуу хотоор нэг нүргэлэн захиргааны сангийн байшингийн нүүрийг цөм авав. “Биднээс дутуугүй зэвлэглэсний дээр байлья гэж байлдаж байна” хэмээн генерал Монкада санаа алджээ. Өдрийн хоёр цагт их бууны буудалцаанд газар доргиж байхад тэрбээр тулалдаанд ялагдах нь гарцаагүй боллоо гэсэн бат итгэлтэйгээр Урсулатай салах ёс хийжээ.

- Аурелианог энэ гэрт өнөө орой бүү ирээсэй гэж тэнгэрт залбирья. Хэрэв ирдэг юм бол түүнийг миний орноос тэврээрэй. Би түүнтэй уулзахгүй байх гэж хэлжээ.

Генерал Монкадаг, Аурелиано Буэндиад урт захидал бичиж дайныг улам энэрэнгүй болгохыг хоёулаа бодож байснаа сануулж, цэргийнхний хээл хахууль, хоёр намын улс төрийн бодлоготнуудын ирэхүү өнгөлзлөгийг эрс шийдэмгий дийлж гарахыг ерөөгөөд, Макондогоос зугтах гэж бахиаднь шөнө нь барьж авчээ. Генерал Монкадаг цэргийн хувьсгалт онц шүүхээс хэрхэхийг шийдтэл Урсулагийнд харгалзан байглаж байсан учир маргааш нь хурандаа Аурелиано Буэндиа энд үдийн зоог хамт барьжээ. Халуун бүлээрээ тайван уулзсан нь энэ байлаа. Хоёр дайсан дайтаж байгаагаар мартаад урьдын явдлаа санан хууч хөөрч байхад, хүү нь эх орондоо булаан эзлэгч болж ирсэн гэсэн эвгүй бодол Урсулагийн сэтгэлээс гарахгүй байлаа. Дагаж ирсэн өдий төдий харуул манаа нь Аурелианог босго алхангуут ямар ч аюул осолтой юм алга гэж итгэлтлээ бүх тасалгааг нь урвуулж хаяснаас хойш тийм бодол төржээ. Хурандаа Аурелиано Буэндиа тэднийг хориглосонгүйгээр үл барам захирангуй дуугаар тушаал өгч, гэрээ тойруулан харуул гарган гаргатал нэг ч хүнийг, тэр ч байтугай Урсулаг өөртө гурван метрээс дотогш ойртуулахгүй байлаа. Тэрбээр онцгойлох тэмдэггүй, борог бөс даавуу цэрэг хувцас, шавар шавхай, цус нөж болсон давируул бүхий түрийтэй савхин гутал өмсжээ. Бүсэндээ зүүсэн том амтай гар бууны нь гэр тайлаастай, бууныхаа бариул дээр гар ямагт тавиастай нь харц шигээ сэрэмжилсэн, шийдэмгий байдалтай, ихэд халцарсан толгойнь удаангалаар төөнөсөн юм шиг харагдана. Карибын тэнгисийн шорвог усанд угаагдсан нүүр нь хүрлийн гөлийжээ. Хүйтэн цэвдэг сэтгэл шиг барагтайд арилахгүй ам бөхтэй нэгэн хүч түүнийг хөгшрөөхгүй бариад байлаа. Одоо тэрбээр урьдынхасаа өндөр, цонхигор, янхигар болсон шиг санагдана. Ойр төрлийн бүхнийгээ энэрч хайрлах сэтгэлийг албаар дарж байгаа нь энх мэдэгдлээ. “Тэнгэр минь. Яахаас ч сийхгүй хүний байдалтай болжээ” гэж

Урсула сэтгэл түгшин бодов. Үнэндээ ч тийм бажээ. Амарантад ацтек ноосон алчуур авчирч өгсөн нь хоол идэж суухдаа хууч хөөрч, хошин шог ярьж байгаа зэргээс нь урьдын Аурелиано хааяа нэг санагдах нь зүйрлэвээс үнсэнд булагдсан цогийг үзэхэд гал байж дээ гэж бодогддог лугаа адил болой. Амь үрэгдэгсдийг нийтийн булшинд оршуулж амжив уу үгүй юу, цэргийн онц шүүхийг шийдвэрээ түргэвчил хэмээн Яргачин Рокед тушааж, өөрөө консервативчуудын дэглэмийн ганхсан барилгыг үнсэн товрог болгох эрс шинэтгэл хийнх зүдэргээтэй ажил барьж авлаа. “Бид либерал намын завшаанч бодлоготнуудаас түрүүлэх хэрэгтэй. Тэднийг сая нэг ухаан ороод харахад нь бүгдийг хийчихсэн байх болно” гэж туслагчиддаа хэлжээ. Чухамхүү энэ үеэр сүүлийн таван жилд бүртгэгдсэн газар эзэмших эрхийг шалгахгаар шийдээд, Хосе Аркадио ахынхаа хуулиар зөвшөөрүүлээд дээрэм хийж байсныг илрүүлэв. Бүртгэлийг даран хүчингүй болгоод бас ч гэж найрсаг ёсыг бодон хамаг ажлаа хойш тавиад өөрийн шийдсэнийг Ребекад хэлэх гэж очжээ.

Нууц хайрын нь итгэмжит асан, зөрүүдийнхээ хүчээр амийг нь аварсан ганц бие бэлэвсэн эхнэр зочдын өрөөнд байгаа нь нөгөө ертөнцөөс гарч ирсэн сүг сүүдэр мэт бодогджээ. Өвч хар хувцас өмссөн, өр зүрх нь хэдийн үнс облсон энэ эмэгтэй дайн болж байгааг ч мэдээгүй боллолтой. Ребекагийн яс нь арьсаа нэвт гэрэлтэх мэт, өөрөө чөтгөрийн гал дүүрэн агаар дундуур хөдлөх мэт сэтгэл төрнө. Намгийн ус шиг мэлийсэн энэ агаарт даринь үл мэдэ үнэр ханхалсаар ажээ. Бэлэвсрэлийн ёсыг ингэж хатуу сахихаа больж, гэрийнхээ цонх салхивчийг онгойлгож, Хосе Аркадио алсанд хүн амьтныг уулчлахыг хурандаа Аурелиано Буэндиа зөвлөсөн боловч Ребекад эгэл хорвоогийн өчүүхэн баяр хөөр хэрэггүй байжээ. Энэ жаргалыг шорооны нялуун амт, Пьетро Креспийн сүрчиг ханхалсан захидал, эр нөхрийнхөө халуун өврөөс дэмий л эрээд эцэст нь энэ байшинд амрыг олж, урьд уулзаж учирч байсан хүмүүсийнх нь дүр элдвийг ургуулан бодох сэтгэлд нь биежин амилж, битүүлэн хаасан тасалгаагаар нь яг л хүн шиг хэрэн явдаг байлаа. сүлжмэл ганхуур сандал дээрээ Ребека налан суугаад, хурандаа Аурелиано Буэниаг урьд наснаас хүрч ирсэн хий үзэгдэл мэт ажин хараад, Хосе Аркадиогийн өвөрчилсөн газрыг хууль ёсны эздэд нь буцааж өгөх гэж байгааг сонсохдоо огт тоосон янзгүй,

- Дураараа л бол, Аурелиано. Чамайг төрөл саднаа бодохгүй хүн гэж санаад байсан юм, одоо үзвэл эндүүрсэнгүй ээ гэж санаа алджээ.

Газар эзэрмших эрхийг дахин хянаж үзээд дуусаж байхад цэргийн хээрийн шүүхийн ажиллагаа ч дуусаж, хурандаа Геринельдо Маркесийн даргалсан угхуралдаанаас босогчдод олзлогдсон бүх офицерыг буудан алах шийдвэр гаргав. Хамгийн сүүлд генерал Хосе Ракель Монкадаг шүүв. Урсула түүнийг өмөөрч, “Макондод байсан бүх захирагчдын дотроос ганц урдаа барих нь. Найрсаг зөөлөн сэтгэлтэйг нь гэрийнхэнд сайн байдгийг нь чи мэдэх

болохоор надаар хэлүүлэх юу байх вэ” гэж хурандаа Аурелиано Буэндиад хэлсэнд хурандаа түүнийг зэмлэнгүй харж,

- Би шүүхийн шийд гаргах эрхгүй. Хэлэх юм байгаа бол цэргийн шүүхэд л очиж хэл гэж татгалзав.

Урсула цэргийн шүүхэд өөрөө очсоноор барахгүй Макондогийн уугуул иргэд, босогчдын дарга нарын эхчүүлийг авч очив. Уул давах зориг таянд зарим нь оролцож явсан хотын настай авгайчуул генерал Монкадаг ам нийлэн магтав. Хамгийн сүүлд Урсула үг хэлэв. Түүний гунигтай боловч хотойшгүй байдал, нэр хүнд, үгийн их итгэл төгөлдөр өнгө шүүхийнхнийг эгшинзуур эргэлзүүлэв. “Та бүхэн энэ аймшигт наадамд их л буурьтай ханджээ. Тэр чинь зөв өө. Та нар хийх ётсой юмаа хийж. Гэвч тэр чинь зөв өө. Та нар хийх ёстой юмаа хийж. Гэвч бид энэ ертөнц дээр шороо хөдөлгөж яваа цагт та нарын эх хэвээрээ л байна, та нарын ямар ч мундаг хувьсгалчид болсон байлаа гэсэн хүүгийн элбэрэл журмыг мартвал бид өмдийг тань шувтлаад, бөсгийг нь тань суран бүсээр ороолгох эрхтэй” гэж онц шүүхийн гишүүдэд хэлжээ. Шүүхийнхнийг зөвлөлдөхөөр гарахад хуаран болсон сургуулийн танхимд энэ үг хангинасаар байлаа. шНө дунд генерал Хосе Ракель Монкадад цаазаар авах ял оноов. Хурандаа Аурелиано Буэндиа Урсулад зад загнуулсан боловч ялыг хөнгөлсөнгүй. Үүр цайхын өмнөхөн тэрбээр гав дөнгө хадгалсаар байгаа тасалгаанд хоригдол дээр орж ирээд,

- Ах минь, таныг би буудаж байгаа юм биш, хувьсгал буудаж байга юм шүү гэж хэлэв.
- Генерал Монкада түүнийг орж ирэхэд орноосоо ч боссонгүй.

Дүү минь, тонил цаашаа гэж хариулжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа буцаж ирснээсээ хойш энэ агшныг хүртэл генералыг өрөвдөхгүй байх гэж биеэ албадсан билээ. Одоо хараад өвгөрч, гар ньт салганаж, үхэхээ ердийн дуулгавартай хүлээж байгааг харахдаа гайхаж, өөртөө ихэд жигших сэтгэл төрсөн боловч түүнийгөө нигүүлсэх сэтгэл төрж байна гэж андуурчээ.

- \Аливаа цэргийн онц шүүх хоосон сүр байдгийг та ямар надаас дор мэдэв гэж . үнэндээ, та бусдын ялт хэргийн төлөөсийг л эдэлж байна. Энэ удаа бид яаж байгаад ч хамаагүй дайнд дийлж гарахаар шийдсэн юм. Миний оронд өөрөө байсан бол ингэх байгаагүй гэж үү?! Гэж хэлжээ.

Генерал Монкада цамцныхаа хормойгоор яст мэлхийн хуяган хүрээтэй зузаан шилээ арчих гэж босоод “Тийм ч байх аа. Намайг буудах гэж байгаад би гутарч байга юм биш. Явж явж бидэн шиг улсын хувьд үхэх ёстой үхлээрээ л үхэж байгаа хэрэг” гээд шилээ оон дээрээ тавиад, цагнаасаа гинжин оосрыг нь аваад, “Мэргэжлийн цэргийн хэнхгүүдийг тэгж үзэн ядаж, тэдэнтэй тэгж

тэмцэж, тэднийг тэгж хараадаг байсан чи өөрөө тэдэнтэй адилхан болчихсон нь л хайран байна. Ямар ч сайхан үзэл санаатай байлаа гээд гэгэнт ингэж дор орсон бол яагаад ч зөвтгөх араггүй” гэж хэлээдхурмиын бөлзөг. Оточ охин тэнгэрийн дүртэй сахиусаа тайлж, цаг, нүднийхээ шилтэй хамт тавьсанаа,

- Ингээд ахиад байх юм бол чи манай орны түүхэнд хамгий харгис, хамгийн цуст дарангуйлагч болохоор барахгүй, сэтгэлээ тайвшруулах гэж Урсула эгчийг ч буудахаас буцахгүй болно гэж үгээ дуусгав.

Хурандаа Аурелиано жишим ч үгүй байлаа. Тэгэхэд генерал Монкада нүдний шил, тэнгэрийн дүр, цаг, бөлзөгөө түүнд өгөөд огт өөр дуугаар,

- Би чамайг загнах гэж дуудсан юм бишээ. Энүүнийг гэргийд минь явуулаарай гэж гэсэн юм гэсэнд хурандаа Аурелиано Буэндиа юмыг нь халаасандаа хийгээд,
- Манауред л суугаа хэвээрээ юу? Гэвэл
- Манауредээ, түрүүнд миний захиаг явуулсан сүмийн цаадах нөгө өл байшиндаа гэж баталсанд,
- Захиасыг дуртайяа биелүүлэе. Хосе Ракель гэж хурандаа хэлжээ.

Түүнийг хөхөвтөр будан татсан гудамжнаа гартал нүүр нь нойтон болсонд өөр нэгэн үүрээр яг ингэсэн нь санагдаад ирэхэд хуарангийн хашаанд гүйцэтгэх тушаал өгснийхөө учрыг сая л ойлгожээ. Хаалганы өөдөөс харан жагссан тасаг цэрэг төрийн тэргүүнийг угтан байгаа юм шиг түүнийг мэндчилэв.

- гарга гэж тэр тушаалаа.

\*\*\* \*\*

Хурандаа Геринельдо Маркес дайны нэмэргүйг анхалж ойлгожээ.Макондогийн иргэний ба цэргийн захирагчийн хувиар хурандаа Аурелиано Буэндиатай долоо хоногт хоёр удаа утсаар ярьдаг байв Эхлээд тэд жинхээн болж байгаа дайны явцыг хэлэлцэн тодорхойлж, байдал нь нүдэнд тод бууж байгаагаас ургуулан ямар шатандаа явааг нь хэдийд ч тогтоож, ямар чиглэлээр өрнөхийг хэдийд ч тогтоож, ямар чиглэлээр өрнөхийг хэдийд ч угтан харж чадаж байжээ. Хурандаа Аурелиано Буэндиа хамгийн ойр шадар нөхөдтэйгөө ч илэндалангүй бахйыг цээрлэдэг боловч тэр үед бас ч гэж нэгийнчөлөөтэй байдаг байсан нь шугамын нөгөө үзүүр шууд мэгэддэг байлаа. Үзтэл нэг иххэрэгцээ байхгүй байхад яриагаа сунжруулж, наадуулынхаа гэр орныхных нь талаар сониндуулгахад юм хэлдэггүй байла. Гэвч дайн улам их нутаг хамарч, улам ширүүсэхэд түүний дүр бүдгэрэн бүдгэрсээр тэргэж

оноохын аргагүй облов. Цэг, зураас гэх ньтухай бүрлуам холдон маймарч, эвлэж нийлэн үг болохдоо утга санаа огт гарахаа больж байлаа. Энэ үед хурандаа Геринельдо Маркес утсыг зөвхөн чагнах болж, өөр ертөнцийн үл таних хүнтэй харилцаж байгаа юм шиг төвөгшөөх болжээ.

- Ойлго л оо, Аурелиано. Либералуудын нам мандутугай! Гэж ярианыхаа төгсгөлд түлхүүрээр цохих болов.

Сүүлдээ хурандаа Геринельдо Маркес дайнаас бүр хөндийрөн төсөөрөв. Урьд залуудаа дайн гэхээр хийморь нь сэргэж, байлдан тулалдахын дон тусаж явсан бол одоо бүр уйдан залхаж гүйцэв. Амарантагийн ажлын өрөө л түүнд байгад байгууштай танц газар болжээ. Тэгээд орой болгон тэнд ирнэ. Сайхан ремедиосыг оёдлын машины хүрдийг эргүүлэхэд цасан цагаан голланд даавууг хуньж өгч байгаа Амарантагийн гарыг нь харж суухад сайхан байдаг билээ. Эзэгтэй зочин хоёр удтал дуугүй сууж, гагцхүү бие биеийн байхад сэтгэл өег байдаг байлаа. Маркесийн хайрын гал бөхөөгүй хэвээрээ байгааг үзэхдээ Амаранта сэтгэлийнхээ угт баярлаж байхад тэрбээр ая нь олдохгүй энэ эмэгтэйн зүрхний нь далд болдлыг огт тааж чаддаггүй байлаа. Хурандаа Геринельдо Маркес Макондод буцаж ирснийг Амаранта мэдээд баярласандаа золтой л амьсгал хураасангүй. Гэвч хурандаа Аурелиано Бэндиагийн шуугиант бараа бологчдын нэгл болж, солгой гар сойлттой орж ирэхэд нь хараад хүний газар, гүний нутагт хатуу ширүүн амьдралд нухлагдан овор суугаад хир даг, хөлс хулмас, тоос шороо болж, биенээс нь туж адууны хөлс шивх ханхалж байсандурам хугарсандаа эгээ л ухаан алдаж унасангүй. “Тэнгэр минь” би ийм хүн хүлээгээгүй сэн” гэж боджээ. Гэвч маргааш нь сахал самбайгаа авч, цэвэр цэмцгэр ус анхилуулсан хүрч ирээд, тана шигтгэсэгн мөргөлийгн судар өөрт нь бэлэглэсэнд хэлэх үг олдохгүйдээ,

- энэ эрчүүд гэдэг хачин улс шүү. Нэг насаараа лам нартай тэмцэж байж мөргөлийн ном бэлэглэж байдаг гэж дуугарчээ.

Түүнээс хойш дайны хамгийн эгзэгтэй үед ч хурандаа, Амаранта дээр орой болгон ирж байлаа. Сайхан Ремедиосыг байхгү байвал оёдлын машины гарыг эргүүлэх ч удаа байв. Түүний хоёргүй сэтгэлтэй, хосгүй үнэнчид уярч, ийм их эрх дархтай хүн өөрт нь ингэж унаж, сэлэм, буугаа зочдын өрөөнд орхичихоод ажлын нь өрөөнд гар хоосон орж ирж байгаад сэтгэл нь хөндөлдөг байлаа. Гэвч дөрвөн жилийн турш хурандаа Геринельдо Маркесийг хайр сэтгэлээ удаа дараа хамгаалахад Амаранта огт халгаадаггүй, гэхдээ хурандаад хайртай дуртай болж чадаагүй ч гэсэн хамт суухад аятай байдаг тул сэтгэлд нь сэв суулгахгүйг ямагт хичээдэг байжээ. Саяхан болтол хавь ойрдоо болж байгааг ч огт тоодоггүй байсан, олон хүн ухаан дутуу гэлцдэг Сайхан Ремедиос Геринельдо Маркесийн хувиршгүй бат сэтгэлтэйд уяраад, гэнэт түүнийг өмөөрөв. Өөрийн нь өсгөсөн охин цоморлигоо дөнгөж нээж байгаа цэцэг шиг цэвэрхэн, Макондод төрж

байгаагүй хөөрхөн бүсгүй болсныг Амранта сая л олж харахдаа мөнөөхөн Ребекаг үздэггүй байсан шигээ хархор буцалж эхэлжээ. Хар хороосоо болоод хийх ёсгүй юм хийх вий. Сайхан Ремедиосыг үхүүлж хожим нь сэтгэлийн тамд бүү унагаарай гэж тэнгэрт мөргөсөөр тэрбээр хуурай охиноо тасалгаанаас хөөж гаргажээ. Яг тэр үед хурандаа Геринальдо Маркес дайн дажныг жигших болж иржээ. Энэ яваа насныхаа хамаг өнгийг өргөн байж олсон алдар гавьяагаа ч Амарантагийн төлөө гаргуунд гаргахаас буцахгүй, цээжиндээ байгаа уран үгээ шавхаж, зүрхэндээ бялхсан цаглашгүй уян хайраа илчилсэн боловч Амарантаг ам алдуулж чадсангүй. Наймдугаар сарын нэгэн үдэш Амаранта өөрийг нь сууя гэж шалдаг хүндээ дөнгөж сая эцсийн хариу өгч,

- Хоёул бие биеэ мартъя. Дурлалцаж байх нас биш болжээ гэж хэлээд гэжүүд зангийнхаа горыг эдлэн гол нь харласар унтлагынхаа өрөөг түгжжээ.
- Тэр үдэш хурандаа Аурелиано Буэндиа хурандаа Геринельдо Маркесийг утсандээр дууджээ. Урагш ахихаа байсан дайны явцад оруулахаар шинэ юмгүй ердийн нэг яриа болж өнгөрлөө. Яриад дуусахад хурандаа Геринельдо Маркес хүнгүй гудамжийг тйоруулан харж, бүйлсийн мөчирт бөнжийн тогтсон усны дуслыг үзээд ганцаардан зовж байгаагаа улам ч ойлгож,
- Аурелиано, Макондод бороо орж байна гэж гунигтайяа тогшжээ.

Шугамын нөгөө үзүүрт удтал чимээгүй болов. Тэгснээ аппаратаас хурандаа Аурелиано Буэндиангийн хариуг цохисон ягшмал цэг, зураас гарч эхэлжээ.

Тэр нэг зураасыг тайлан уншихад,

- бүү тэнэгт, Геринальдо! Наймдугаар сард бороо орохгүй яадаг юм гэжээ.

Хурандаа Геринельдо Маркес ингэж эрс хариуланд нэлээд сэгэл түгшжээ. Гэвч хоёр сарын дараа Аурелиано Макондод буцаж ирэхэдгайхаж, тэр ч байтугай бараг айх шиг болжээ. Урсула хүртэл хүүгийнхээ өөрчлөгдсөнд мэл гайхжээ. Аурелиано сүр мур бадруулалгүй, бараа дагуул бололгүй, аагим халуун шатаж байхад цув өмсчихсөн хүрч иржээ. Гурван явдаг хүүхнээ авч ирснээ гурвууланг нэг байшинд оруулж, тэндээ дүүжин орондээрээ хэвтэн хамаг цагаа өнгөрүүлэх болов. Байлдааны тухай яаралтай мэдээ сэлтийг чүү чамай зав гарган уншина. Нэг удаа хурандаа Геринельдо Маркес хилийн нэг хотод босогчдын цэргийг байлгаад байвал олонулсын асуудал болон хүндэрч бозошгүй байгаатай холбогдуулан уг хотынхныг нүүлгэх тушаал өгөхийг түүнээс хүссэнд тэрбээр

- Ийм мууайн юмаар намайг бүү үймүүл. Эзэн тэнгэрээс л асууж зөвлө гэж тушаажээ.

Энэ бол дайны хамгийн эгзэгтэй үе байлаа. Эхний үед хувьсгалыг дэмжиж байсан либерал газрын эзэд газар эзэмших эрхийг дахин хянаж үзэхэд



саад хийхийн тулд консерватив газрын эзэдтэй нам нийлж, сэм сүлбэлджээ. Гадаадад дайнаас хөлжиж авсан либерал бодлоготнууд ширхүүн арга хэмжээг нь ил эсэргүүцэж байхад ч хурандаа Аурелиано Буэндиа идэвх орсонгүй. Таван боть болсон шүлгэндээ ч салхи оруулахаа больж тэдгээр нь авдарны ёроолд хэвтэж байлаа. Шөнө юм уу үдийн амралтаар гурван хүүхнийхээ нэгийгдүүжин орон дээрээ дуудаж, хүслээ бүдүүн ибарагдуухан хангачихаад сэгэл огт зовсон шинжгүй таг унтаад өгнө. Бодлогогүй зүрхтэйгэсээ үл итгэхийн золлонг дандаа эдлэх тавилантайгаа ганцаараа мэдэж байлаа. Эхлээд дайснаа дарж дархан цолоо мандуулан эх орондоо буцаж ирсэндээ ташуурсан тэрбээр алдар жавхлангийн хөлгүй ангалын дээрээс өнгийжээ. Хурандаа дайтах эрдмийнхээ их багш, барсан хэвнэгээрээ томцуулыг бахахруулж, багачуулыг гайхуулж явсан герцог Мальборогийн ич этгээдэд морилж байхыг сайханд боддог болжээ. Чухамхүү тэгэхд л нэг хүнийг, тэр ч байтугай Урсулаг өөртөө гурван алхмаас дотогш ойртуулахгүй байх гэж шийджээ. Түүнийг хаана ч очсон дагалт нар нь шалан дээр тойрог зурж, энэ тойргийн дотор өөр хүнийг оруулдаггүй, хурандаа Аурелиано Буэндиа энэ тойргийн голд зогсоод товч бөгөөд эрс тушаал өгөн ертөнцийн хувь заяаг шийдвэрлэдэг байлаа. Генерал Монкандаг буудаж алсныхаа дараа Манауред очингуутаа гэрээсийг нь яаран биелүүлсэнд бэлэвсэн эхнэр нүдний шил, бөлзөг, сахиусыг нь авсан боловч түүнийг босго ч алхуулсангүй.

- хурандаа, таныг оруулахгүй ээ. Та тэр дайн тулалдааныхаа газарт дарга юм байгаа биз, бор гэртээ бол би дарга аа гэж хэлжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа огт уурласан янзгүй байсан боловч бие хамгаалагчид нь бэлэвсэн эхнэрийн гэрийг тонож, галдсаны дараа сая сэтгэл амарч билээ. “Сүнсээ бодоорой, Аурелиано. Чи амьдаараа ялзарч байна” гэж тэгэхэд хурандаа Геринельдо Маркес түүнд сануулжээ. Тэр үеэр хурандаа Аурелиано Буэндиа босогчдын цэргийн командлагчдын хоёрдахь зөвлөгөнийг хуралдуулав. Идеалст, нэр алдар хөөцөлдсөн, нийгэм олондоо шоовдологдосн хүмүүс, тэр ч байтугай ердийн гэмт хэрэгтэн хүртэл ёсон жорын амьтад иржээ. Тэдний дотор сангийн мөнгө идчихээд шийтгэлээс мултрах гэж хувьсгалд нэгдсэн нэг консерватив түшмэл ч байлаа. Олон нь юуны өлөө байлдаж байгаагаа ч мэдэхгүй байв. Үзэл бодол нийлэхгүй учир дотроосоо дэлбэ үсрэхэд бэлхэн зүсэн бүрийн энэ олны дунд генерал Теофило Варгас гэсэн эзэрхэг, хүрлэгэр эр ялгарч байлаа. Тэр бол бүдүүлэг, бичиг мэдэхгүйд, далд хорон санаатай, бэлгэдэх вивангардич авьяастайгаараа хүмүүсийг улайрган амьтад болгох чадалтай цэвэр индиан хүн байлаа. Хурандаа Аурелиано Буэндиа улс төрийн бодлоготнуудын мэх гохтой тэмцэхэд босогчдын бүх командлалыг зөвлөгөөн дээр нэгтгэх гэж тооцоолж байв. Гэвч генерал –Теофило Варгас хурандаа Аурелиано Буэндиагийн төлөвлөснийг нурааж, хэдэн цагийн дотор хамгийн туршлагатай дарга нарын

эвслийг хагаралдуулж, ерөнхий командлалыг гартаа авчээ. “Энэ өөтгөртэй мэдээтэй байхгүй бол горьгүй! Ийм хүн бидэнд цэргийн яамны сайдаас ч аюултай” гэж Аурелиано Буэндиа дарга нартаа хэлжээ. Тэгтэл энгүүндээ аймхай гэж зард гарсан нэгэн залуу офицер долоовор хуруугаа гозойлгон,

- Ядах юу байсан юм, цааш нь харуулчихгүй юу гэж хэлэв.

Хурандаа Аурелиано Буэндиа өөрийн нь бодохоос агшны төдий түрүүлж хэлсэн тэр саналын цэвдэгт сэрдийхсэнгүй, чухам ямар байдалтай хэлсэнд нь сэрдхийжээ.

- Намайг тийм тушаал өгнө гэж бү горьдоорой гэж хариулжээ.

Үнэхээр ч тийм тушаал өгсөнгүй. Гэвч хагас сарын дараа генерал Теофило Варгас отоонд мачетегаар тас цавчуулж хурандаа Аурелиано Буэндиа ерөнхий командалыг авав. Босогчдын бүх дарга нар өөрийг нь зрөнхийлөн захирагчаа болгосон тэр шөнө хуранда гэнэт цочин сэрэд “Хөнжил аваад ир” гэж хашгирч гарав. Гадаа зуурам халуун байхад ч дотор нь хүйт оргин шаналж, олон сар нойрноос гарснаа сүүлдээ бие нь дарсах шиг болжээ. Эрх дарх ихтэй болсондоо хөөрөхийн зэрэгцээ гэнэт гэнэт биеэ машид голно. Дотор үргэлж хүйт оргих өвчнөө ангаах гэж генерал Теофило Варгасыг алахыг зөвлөсөн залуу офицерыг буудахыг тушаажээ. Түүний тушаал өгөхөөс нь өмнө тэр байтугай бодохоос нь өмнө биелж, түүгээр барахгүй өөрийнх нь хүргэж зүрхлээргүй хязгаараас ямагт давчихаад байлаа. Хэмжээлшгүй их эрх мэдлийнхээ цөлд ганцаардан төөрч, хөл алдаж байгаагаа мэдлэ. Эзэлж авсан хотод орохд нь хурсан олон өөрт нь баяр хүргэн, хашигаралдахад уцаар хүрч, эд дайсанд мөн л ингэж баяр хүргэж байсан даа гэж хардана. Түүний хаана ч очсон, өөрийнх шиг нь харцтай, өөрийн шиг нь луутай, өөрийнх нь мэндэлж байгаа шиг итгэл муутайхан мэндэлж байгаг залуус дайралдан, өөрсдийгөө өөрийнх нь хүү гэж хэлнэ. Өөрийг нь хувилж олшруулаад тараачихсан юм шиг хачин сэтгэл төрөвч ингэлээ гээд нэмэргүй, улам л ганцаардан зовож ажээ. Офицер дарг анараа хуураад байна гэж сэрдэх болж, герцог Мальбород ч сонь буурчээ. “Саяын бүрэлэч л өмнөө барьдаг найз минь байж” гэж тэрбээр ярихдуртай байлаа. Байнга итгэл алдсаар, сунжирсан дайнаа дуусгаж ч чадахгүй, байж ч чадахгүй, хэрэг дээрээ доороо л торйон эргэлдсээр ядраад, улам хөгширч, улам тамирдаж, яахаараа тэр вэ, яах вэ, хэдий болтол ингэх юм бэ гэдгийг улам ойлгохоо байж байлаа. Шохойгоор зурсан тойргийн гадна заавал хүн байна. Мөнгөгүйдэх нэг нь мөнгөгүйдэж, хөхүүл ханиалга тусах нэг нь тусаж, энэ зүдэг дайнаас уйдаж гүйцсэн учир мөнхийн нойроор нойрсохыг хүсэх нэг нь хүсэж, сүүлийнхээ хүчийг шавхан “Номхон!” тушаалаар “Хурандаа, байдал тайван байна” гэж илтгэх нь илтгэсээр байлаа. Гэтэл тайван байна гэгч нь эл эцэс төгсгөлгүй дайнд хамгийн аюултай байсан бөгөөд энэ нь шинэ юм юу ч гарахгүй байна гэсэн үг байлаа.

Ганцаардах үйлээ дагаж, далдыг мэдэхээ больсон хурандаа Аурелиано Буэндиа авсанд орон ортлоо дарч урьдын явдлаа дурсан дотроо бүлээцүүлсээр Макондод насныхаа эцсийг үзэхийг хүсжээ. Ооо бол наазгай нь бүр дэндэж улс төрийн нэн чухал асудлыг хэлэлцэхээр либерал намын төлөөлөгчид ирлээ гэхэ ч дүүжин орон дээрээ эргэж хэвтсэндээ нүдээ ч нээсэнгүй.

- Янхнууд дээр аваачаад өгчихгэж бувтнажээ.

Төлөөлөгч болж ирсэн сүртүүг цамц, бортого млагайтай зургаан өмгөөлөгч арван нэгдүгээр сарын цонох наранд ихээхэн тэвчээртэй байж байлаа. Өдрийн ихэнхэд тэднүүс унтлагын өрөөнд түгжээд сэм зөвлөлдөж, орой нь харуул гаргуулж, баян хуурчдын чуулаг аваад, Кагориногийн газарыг тэр аяар нь хөлслөн авна. “Цаадуулдаа саад болоод юу хийх вэ. Тэдний юу гэх гээд байгааг би сайн мэдэж байна” гэж хурандаа Аурелиано Буэндиа хэлжээ. Хойшлогдож хойшлогдож арван хоёрдугаар сарын эхээр болсон хэлэлцээг дуусашгүй маргаан болно гэж олон хүн бодож байсан боловч тэгсэнгүй ердөө л цаг хүрэхгүй үгүйтэй л болжээ.

Энэ удаа хурандаа Аурелиано Буэндиа бүгчим зочдынөрөөнд үхдэлийн хулдас шиг цагаан даавуугаар бүтээсэн оньст хуурын дэргэд бие хамгаалагчдынхаа шохойгоор зурсан тойргийн доторорсонгүй, цуваар биеэ хулдаад, улс төрийн зөвлөх нарийнхаа хажууд сандал дээр сууж, төлөөлөгчдийн саналыг дуугүйхэн чагнаж байлаа. Нэгд, газар эзэрмших эрхийг дахин хянаж үзэхээ болих, газрын эзэн либералуудаар намыг дахин дэмжүүлэх, хоёрт, католик шашинтны дотор тулах хүчтэй болохын тулд сүмийн нөлөөтэй тэмцэхээ болих, эцэст нь гэр бүлийн бат холбоо, ариун журамт байдлыг хадгалахын тулд эцэгтэй, эцэггүй хүүхдийг тэгш эрхтэй байлгах гэхээ болихыг түүнээс хүсжээ.

- Тэгэхээр бид зөвхөн засгийн эрхийн төлөө тэмцэж байгаа болох нь ээ гэж уг бичгийг уншиж дуусахад хурандаа Аурелиано Буэндиа инээмсэглэсэнд нэг өлөөлөгч:

- Тактикийн үүднээс бид программдаа эдгээр засварыг оруулсанюм. Одоо ард түмний дотор дэмжлэгтэй болно гэдэг хамгийн гол нь. Тэгээд байр нь харагдах биз гэж тайлбарлав.

Хурандаа Аурелиано улс төрийн нэгэн зөвлөгч хажуунаас яаран оролцож,  
- энэ чинь ухаангүй явдал байна. Та нарын загварыг зөв гэвэл консервативчуудын дэглэмийг сайн гэх болох нь. Та бүхний засварыг ашиглан, та бүхний ярьж байгаагаар бид ард түмний дотор өргөн түшиг тулгууртай болдогюм аа гэвэл консервативчуудын дэглэм ард түмний дотор тулгууртай байсан гэж хүлээх хэрэгтэй болох нь. Та бүхний засварыг ашиглан, та бүхний ярьж байгаагаар бид ард түмний дотор өргөн түшиг тулгууртай болдог юмаа гэвэл консервативчуудын дэглэм ард түмний дотор

тулгууртай байсан гэж хүлээх хэрэгтэй болох нь Эцэст нь би хорин жил үндэстний эрх ашгийн эсрэг тэмцсэн болж таарах нь ээ гэв.

Тэрбээр цааш ярих гэсэн боловч хурандаа Аурелиано Буэндиа болиулж: “Доктор, та цагаа дэмий бүүр үр. Хамгийн гол нь үүнээс хойш бид зөвхөн засгийн эрхийн төлөө л тэмцэх болж гэж хэлээд инэмсэглэсээр төлөлөөгчдийн гардуулсан цаасыг авч, гарын үсэг зурахаар бэлтгэн,

- Нэгэнт тийм бол бидэнд татгалзах юм алга гэжээ.

Офицерууд нь байдал ингэж эргэсэнд гайхан бие биеэ харав. Хурандаа Геринельдо Маркес:

- Уучлаарай, хурандаа, энэ чинь урваж байгаа хэрэг гэж аяархан хэлэв.

Хурандаа Аурелиано Буэндиа бэхэнд дүрсэн үзгээ хийд барьж, арцагчийн дээрээс эрх мэдлийнхээ хүнд лантууг буулгаж,

- Зэвсгээ хураалга гэж тушаажээ.

Хурандаа Геринельдо Маркес босож, буугаа ширээн дээрээ тавив.

- Хуаранд оч. Та хувьсгалт онц шүүхийн мэдэлд шилжлээ гэж хурандаа Аурелиано Буэндиа тушаалаа.

Дараа нь тунхаглалд гарын үсэг зураад төлөөлөгчдөд эргүүлэн өгч,

- Ноёд оо, бичгээ авагтун. Наадхынхаа хэргийг нь л гаргаарай гэжээ.

Улсаас урвасан хэрэгтэй хурандаа Геринельдо Маркесийг хоёр хоноод цаазаар авахаар яллав. Орондоо дахин хэвтэж авсан хурандаа Аурелиано буэндиа түүнийг өршөөгөөч гэж яаж ч гуйсан хэрэгсэхгүй байлаа. Хороохын урьд өдөр Урсула өөрийг нь үймүүлэхийг хориглосон тушаалыг зөрчиж, унтлагынх нь өрөөнд оржээ. Хар хувцас өмссөн, ер бусын сүрлэг тэрбээр уулзсан гурван минутын турш суусангүй “Геринельдог буудна гэдгийг чинь мэдэж байна. Үүнийг болиулах талаар би юу ч хийж чадахгүй. Гэвч нэг зүйлийг сануулж хэлье. Геринельдогийн алагдсан байхыг үзмэгцээ чамайг хаана ч байсан чирч гаргаж ирээд өөрийн гараар тонилгоно гэдгээ өөд болсон аав, ээж хоёрынхоо нэр дурдаж, Хосе Аркадио Буэндиагийн дурсгалыг санаж, эзэн тэнгэрийн нэр браьж тангараглая” гэж хэлээд тасалгаанаас гарахынхаа өмнө хариу хэлэхийг нь хүлээлгүй,

- Чи гахай сүүлтэй төрсөн хүний хийх байсан юмыг л хийж байна гэж хэлж!ээ.

энэ урт шөнө хурандаа Геринельдо Маркесийг эрт урьдын цагт Амранатгийн ажлын өрөөнд үдэш өнгөрүүлдэг байснаа санаж суухад, хурандаа Аурелиано Буэндиа ганцаардахын битүү хальсыг цаг цагаар элтлэн хагалах гэж оролдож

байлаа. Эцэг нь мөс үзүүлэхээр авч явсан тэртээх нэгэн үдшээс хойш хувь зохиолоор ногдсон хамгийн жаргалтай сайхан үе гэвэл урландаа алтан загас хийж байсан үе л ажээ. Гучин хоёрдайн дэгдээж, эрлэгийн элчтэй тохиролцсон бүхнээ зөрчиж, алдрын шивх дотор гахай шиг хөлбөрч байж буюу дөч шахам жил оройтож байж сая л эгэл жирийн амьдралын давуутайг ухаарчээ.

Үүрээр, цаазаар авахад нэг цаг үлдээд байхад шөнө нойргүй хоносондоо сульдаж гүйцсэн тэрбээр модон дөнгө бадяг өрөөнд орж “Жүжиг дууслаа. Манай согтуучууд чамайг буудчихаагүй дээр явъя” гэж хурандаа Геринельдо Маркест хэлжээ. Хурандаа Геринельдо Маркес жигшиж байгаагаа нууж чадахгүй,

- Больё оо, Аурелиано. Чамайг биеэ худалдсан хөлсний амьтан болж байгааг харсанд орвол үхсэн минь дээр гэж хариулсанд хурандаа Аурелиано Буэндиа:
- Чи түүнийг үзэхгүй ээ. Гутлаа өмс, энэ новшийн дайныг дуусгахад минь тусал гэж хэлжээ.

Тэгж хэлэхдээ тэрбээр дайныг дуусгах нь эхлүүлэхээсээ хавьгүй хэцүү гэдгийг харахан мэдээгүй байлаа. Босогчдод ашигтай найрамдлын болзол Засгийн газраар гаргуулах гэж жил шахам цуст харгислал үйлдэх, энэ болзлыг хүлээж авах хэрэгтэй гэдгийг өөрийн талхынхныг бас нэг жил ятгах хэрэг гарлаа. Ялалтаа худалдаж идэхгүй гэсэн офицеруудынхаа бослогыг даран хүний санаанд багтамгүй цэвдэг авирлаж, тэднийг дахин эсэргүүцүүлэхгүй тулд дайсны цэргээс тусламж авахаасаа ч цээрлэсэнгүй.

Насандаа хэзээ ч үүнээс илүү сайн байлдаж байсангүй. Байдал эргэхэд л улс төрийн бодлоготнуудын урвуулаад тавьчихдаг хийсвэр лоозон, урианы төлөө тулалдаагүй, өөрийгөө чөлөөлж авахын төлөө тулалдаж байна гэж бодохоос урам зориг нь хөгждөг байлаа. Урьд ялахын төлөө тэмцэж байгаа хурандаа Геринальдо Маркес түүнийг хэрэггүй ихээр зориг гаргаж байна гэж зэмлэдэг байлаа. “Санаа зоволтгүй ээ. Үхнэ гэдэг бодсон шиг тийм амар юм биш” гээд хурандаа Аурелиано Буэндиа инээмсэглэдэг байлаа. түүний хувьд бол энэ нь үнэн байлаа. Өөрийн нь үхэх өдөр тэнгэрээс тогтоогдсон гэдэгт итгэж, ингэж итгэсэндээ цагаа болтол үл үхэх далд хүчийг олж, дайн тулалдаанд тохиолдох аюулаас зайлан чадах болоод үүнийхээ хүчээр дайсандаа ялагдаж чаджээ. Ингэж ялагдана гэдэг ялахаас хавьгүй хэцүү тул илүү цус урсгах, илүү олон хүний амь нас сүйтгэх хэрэг гарчээ.

Хурандаа Аурелиано Буэндиа хорин жил дайн тулалдаан хийх завсартаа гэртээ мундахгүй ирж очиж байсан боловч байнга дагалт цэрэг дагулан яаруу тэвдүү явдаг, Урсулаг хүртэл түгшээдэг домгийн гэмээр алдрыг олсон зэргээсээ ойр дотныхоо хүмүүст хүний хүн шиг болчихжээ. Сүүлийн удаа Макондод ирж, гурван явдаг хүүхэндээ тусгай байшин хөлслөхдөө гуйлган байж гэр орныхонтойгоо үдийн хоол хоёр гурав хамт идэж уулзсан билээ. Сайхан

Ремедиос дайны ид дундуур төрсөн ихэр хоёр хүү түүнийг бараг таньдаггүй байлаа. Залуу насаа алтан загас урлаж өнгөрүүлсэн ах өөрийгөө хүн төрөлхтнөөс гурван метр тусгаарласан домогт дайнч хоёрыг нэг хүн гэж Амарантагийн сэтгэлднэг л багтаж өгдөггүй байлаа. Гэвч дайн зосгоохтухай, сураг гарахад цөмөөрөө л хурандаа Аурелиано Буэндиаг удахгүй гэртээ ирж дахин ойр дотныхоо хайрыг авсан эгэл жирийн хүн болно гэж бодох болж, эх үр, элбэрэл журмын сэтгэл гэдэг удтал мартагдсан байснаа ер бусын хүчтэйгээр дахин сэргэлээ.

- Одоо л нэг юм гэртээ эр хүнтэй болохнь гэж Урсула хэлжээ.

Амаранта түүнийг үүхд алдагдсан байх гэж эхэлж сэжиглэжээ. Дайн зогсоох гэрээ байгуулахаас долоо хоногийн урьд тэрбээр бараа бологчгүйгээр, зөвхөн хоёр хөл нүцгэн цэрэг дагуулан гэртээ ирж цадуулыгаа жанжны эдлэл хэрэглэлээс үлдсэн эмээл, илжигний тоног шүлэгтэй хайрцгийг тагтанд хурааж байх зуур Амарантагийн ажлын өрөөний дэргэдүүр гарахдаа дүүгийнхээ дуудахад хэн сэн билээ гэсэн байдалтай харахад нь Амаранта:

- Би Амаранта байна аа гэж буцаж ирсэнд нь баярлан эелдгээр хэлээд – Харахгүй юу? Гэж хар даавуун боодолтой гараа үзүүлжээ. Хурандаа Аурелиано Буэндиа тээр жилийн нэгэн өглөө Макондод хороолгох ял заагаад туугдаж ирэхдээ энэ бодлыг анх харсан шигээ инээмсэглээд,

- Аймаар юм. Цаг яасан амархан явна вэ! гэж хэлэв.

Засгийн газрын цэрэг байшингийн дэргэд манаа гаргав. Хурандаа Аурелиано Буэндиа басамжлуулах, доромжуулахын гутамшгийг үзэхээр нэг болж, биеэ үнэд оруулах гэж дайныг улам сунжруулсан гэсэн зэмтэйгээр буцаж иржээ. Суганы нь шарх дахин буглан, халуурах, даарах хоёроос давжтал чичирнэ. Үүнээс зурган сарын өмнө Урсула тэр найрамдал байгуулах гэж байгааг дуулаад хүүгийнхээ унтлагын өрөөг онгойлгож цэвэрлээд, өнцөг булан бүрийг нь утан ариутгаж, Ремедиосын өгөршсөн хүүхэлдэйнүүдийн дунд насныхаа эцэс болтол тайван сууг гэж боджээ. Гэвч өнгөрсөн хоёр жилд тэрбээр амьдралтай эцсийнхээ дансыг бодоод, өвгөрдгөө өвгөрөөд өнгөрчихсөн байжээ. Усрулагийн туйлын нямбай цэвэрлэсэн урлангийнхаа хажуугаар өнгөрөхдөө цоожинд нь түлхүүр шургуулаастай байгааг ч анзаарсангүй. Он цагийн эргэлтээр орон байшин нь үл ялиг боловч элэг эмтрэм эвдэрснийг, оронгэрийн бараа хараагүй удсан ч, урдынхаа юмыг нандигнан санадагсан бол муу ёр гэж сэжиглэхээр хуучирсан байсныг ч ухаарах сөгөө байсангүй. Байшингийнх нь ханын шавар ховхорч, өнцөг буланднь аалзны шүлс сагсайж, хайган цэцэг нь тордлогогүй орхигдоод, халаганы нь энгэсэг шоргоолжинд идүүлж энэх нь хөвдөд баригдсаныг харахдаа дотор нь өмрөх шинж огтхон ч орсонгүй, уйтгар гуниг гэгч юмны муу санаатай тавьсан олон урхины нэгэнд ч орсонгүй. Түүнийг бороо өнгөрөөх гэж түр орж ирсэн хүн

шиг игонхонд гутлаа ч тайлаагүй, цуваараа хулдан, хайтан цэцэг дээр борооны дусал шаагин буухыг оройжин харж суусанд Урсула өөрийнх нь дэргэд удахгүй нь гэдгийг мэджээ. “Дахиад л дайтахаар явах юм болов уу? Дайнд явдаггүй юм бол үхэх нь л байна” гэдэг бодол Урсулад сэрхийтэл ороод ирэхэд совин татаж байна гэж боджээ.

Оройн хоолон дээр бага Аурелиано зөв гараараа талх авч, солгойгоороо халбага авсанд ихрийн өрөөсөн бага Хосе Аркадио солгойгоороо талх, зөвөөрөө халбага авчээ. Тэр хоёрын хөдөлж барих нь ав адилхан байсан нь хоёр ихрийг өөд өөдөөсөө хараад сууж байна гэхээсээ нэгнийх нь дүрс толинд тусаж гэмээр байлаа. Тэр хоёр бие биетэйгээ үйлийн үргүй адилхан гэгээ мэдсэн тэр өдрөө шинэ ирсэн ахдаа үүнийгээ харуулах гэж зориуд тэгж тогложээ. Гэвч хурандаа Аурелиано Буэндиа юу ч анзаарсангүй. Бодол санаа нь огт өөр юман дээр байсантул Сайхан Ремедиосыг хоолны өрөөний хажуугаар чармаа шалдан яваад өнгөрөхийг ч харсангүй. Ганц Урсула л бодлыг нь тасалж зүрхлэв.

- Дахиад дайнд явах гэж байгаа бол өнөө орой бидний ямар байдалтай байгааг тогтоож ав аа гэж хоолны дундуур хэлжээ.

Сэтгэл хоосорсныг нь бүх хүн амьтны дотроос Урсула цорганцаараа олж харж чадсаныг хурандаа Аурелиано Буэндиа ойлгоод, гайхсангүй боловч олон жилийн хойно анх удаа нүүрийг нь эгцлэн харваас арьс нь туж үрчлээтэж, шүд нь мөлийн элэгдэж, үс нь өнгөгүй хуурай, харц нь гайхангуй болсон байлаа. Бутантай буцалсан шөл шаландээр унах нь” гэж хэлэхэд нь үнэхээр унаад хагарсан тэр өдөр сэтгэлд ньүлдсэнээжинхээ дүртэй одоогийн байдлыг жишин бодож үзжээ. Тавь гаруй жил өдөр тутам сэтгэлийн зовлон эдэлж ажлын хүндэд нухлагдан зүтгэж байснаас туж шалбархай, халцархай, эвэр сарь, шарх сорви болохыг нь агшин зуур харж, үүнд нь өрөвдөн хайрламаар байвч огт тэгэхгүй байгаагаа мэджээ. Тэгэхэд нь зүрхний утг өрөвч зөөлөн сэтгэлээс нь юу үлдэж вэ гэж эцсийн удаа хүчлэн хайсан боловч юу ч олж чадсангүй. Эрт урьдын цагт сан бол өөрөөс нь Урсулагийнхтай адил үнэр гарахад үгүйдээ гэхэд ичмээр ч юм шиг болж, ээжийгээ байн байн боддог байжээ. Гэтэл дайнд энэ бүхэн алга болсон байлаа. Тэр ч байтугай гэргий Ремедиос нь охин нь болох насны танихгүй эмэгтэйн байдлаар бүдэг бадаг санагдах ажээ. Энгэр зөрүүлээд өнгөрсөн өөрийн нь үрийг далайн эргээр нэг тараасан өдий төдий эмэгтэйчүүдийн дотроос сэтгэлд хоногшин хоцорсон нь үгүй ажээ. Ихэвчлэн тэд харанхуй болсон хойно орж ирээд, үүр цайхаас өмнө явах тул маргааш нь хамаг бие нь алдарсан байдгаас биш, санаанд үлдэх юм байдаггүй байлаа. Он цаг, олон дайндулирч балраагүй нэг юм гэвэл хүүхэд байхдаа, Хосе Аркадио ахтайгаа аминчирхан нийлдэг байсан нь л ажээ. Гэхдээ түүнд хайртай байсангүй.

- Уучлаарай, Дайн л ганц аллаа гэж Урсулагийн дээр хэлсний дараа гэмшингүй өгүүлжээ.

Маргааш нь энэ ертөнцөд шороо хөдөлгөж явсантай холбоотой бүхнийг устгав. Урланд өөртэйгөө холбоогүй юманд л гар хүрсэнгүй, хувцсаа дагуул нартаа бэлэглэж, Пруденсио Агилярыг алсан жадаа эцгийнхээ их л гэмшингүй булсан шиг гадаа зэвсгээ мөн л тэгж булав. Цорын ганц сумтай гар буугаа л авч үлдлээ. Урсула хөндлөнгөөс нь огт оролцсонгүй, гагцхүү зочдын өрөөндөө мөнхийн зул гэрэлтүүлж байдаг Ремедиосийн зургийг авах гэхэд нь л авахуулсангүй. “энэ зураг чиний юм биш ээ. Энэ бол манай гэрийн шүтээн” гэж хэлжээ. Дайн зогсоох гэрээнд гарын үсэг зурахын өмнө, гэрт хурандаа Аурелиано Буэндиагийн гэж хэлэхээр бараг ганц ч юм байхгүй болсонд авдартай шүлгээ талхны газар Санта Софи де ла Пьедадыг гал түлэхгэж байхаднь авчирч,

- наадахаараа гал ноцоочих. Хуучин новш сайн шатна гэж баахан боодолтой шарласан цаас түүнд сарвайжээ.

Дуугай номой, тэр ч байтугай хүүхдүдийнхээ үгнээс зөрдөггүй Санта Софи де ла Пьедад нэг л хориотой юм хийлгэх гэж байга аюм шиг санагдаад болохгүйд,

- Энэ чухал бичиг үү? Гэж асуусанд хурандаа:

- Үгүй ээ. Ийм юмыг хувьдаа л бичдэг юм гэж хариулбал

- Тэгвэл та өөрөө шатаа л даа гэжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа цаасыг шатааснаар бахахү йавдрыг сүхээр эвдэн,галд хийв. Үүнээс хэдэн цагийн өмнө Пилар Тернера өөрийг нь эргэж иржээ. Олон жил уулзаагүй хурандаа Аурелиано Буэндиа түүний хөгширсөн, таргалсанд инээд нь урьдынх шиг хангинахаа больсондгайхаж, тэгэхдээ хөзрөөр мэргэлэхдээ хчнээн гаргууд болсоныг гайхжээ. Хурандаа өөрийнх нь мандаж явахад “Амаа л мэдэж яваарай” гэж Пилар Тернерагийн хэлсэн нь төөрөг зурагтай нь гайхалтай тохирсныг санаж билээ. Пилар Тернератай уулзсаны дараагар удалгүй, шархны нь идээг авсан хувийн эмээчээ нэг их сэжих авахуулалгүйгээр “Зүрх хаана байдгийг зааж өгөөч” гэсэнд нь эмч иодтой хөвөнгөөр цээжин дээр нь дугуйлан зурж өгчээ.

Дайн зогсоох гэрээнд гарын үсэг зурах маягаар гаригт бороотой хүйтэн байлаа. Хурандаа Аурелиано Буэндиа урьд ихэвчлэн таван цагт орж ирдэг байснаараа эрт ирж, чихэргүй кофе уухад “Чиг яг ийм өдөр төрж билээ. Нүдээ хараастай гарахад чинь цөмөөрөө цочсон сон” гэж Урсула хэлэв. Гэвч тэрбээр жагсан явах цэргийн хөлийн чимээ, бүрээний дохио өгөх, өглөө эртийн нам гүмд тод сонсдох огцом тушаалөгөх дууг чагнаж байсан учир Урсулагийн хэлснийг анзарсангнйү. Өдий олон жил дайтахдаа хурандаа Аурелиано Буэндиа ийм дуунд дассан баймаар боловч залуудаа нүцгэн хүүхэн анх харсан шигээ өвдөг нь сулран чичирчээ. Тэгэхд тэр хүүхэнтэй суусан бол дайн тулаан гэж явах ч үгүй, алдар нэрийг олох ч үгүй, ердөө л нэргүй гар урлалч, жаргалтай мал л явах сан гэж уйтгарын торонд орооцолдон байхдаа бртүүрхэн боджээ.



Өчнөөн жил өнгөрсөн хойно гэнэт ингэж урьдын явдлыг санагалзахдаа аэглөнийхө өцайг уух дургутжээ. Өглөний зургаанцагтхурандаа Герхнельдо Маркесийг босогчийнхэдэн офицертой хамт ирэхэд хурандаа Аурелиано Буэндиа дуугүй дээрээ дуугүй, бодлогошронгуй дээрээ бодлогошронгуй, ганцаармал дээрээ ганцардмал болсон байлаа. Урсула түнд шинэ цув нөмргүлэх гэж оролдож, “Засгийн газрынхан юу гэж бодох юм бэ. Чамайг бууж өгөөд цув авах ч мөнгөгүй болж гэнэ шүү дээ” гэж ятгажээ. Хаалган дээр очоод бороо асрагч байгааг үзэхдээ эцгийнхээ хуучин эсгий бүрхийг өмсөхөөр болов.

- Аурелиагно тэнд хэцүү байвал ээжийгээ санаарай, за юу гэж эх нь гуйлаа.

Хурандаа Аурелиано Буэндиа хөндийхөн инээмсэглэж, хуруугаа гозойлгон гараа өргөөд, ганц үг дуугаралгүй босго алхан гарч хот дундуур амьтанд зануулахдаа зануулж, загнуулахдаа загнуулж, зүхүүлэхдээ зүхүүлсээр явжээ. Урсула хаалгаа түгжээд, насны хэмжээ гүйцтэл дахиж онгойлгохгүй гэж шийдэв.”Эмэгтэйчүүдийнхээ энэ сүмд цоожтой насаа барья. Үхэж байвч энэ муусайн амьтдын бах тавыг хангаж, нулимсаа үзүүлэхгүй” гэж боджээ. Хүүгийнх нь юмнаас юу үлдэж вэ гэж хайсан боловч хүний урманд ганц ч ширхэг юм олсонгүй.

Бууж өгөх ёслол Макондогоос хорин километрийн тэртээ аварга том сейбо модны доор болж, түүний дэргэд хожим нь Неерланди хот байгуулж билээ. Борооноор үймсэн тагтаан сүрэг шиг цагаан хувцастай шааг шуг гэсэн баахан гэлэнмаа нар засгийн газар, намын төлөөлөгч босогчдын төлөөлөгч, зэр зэвсгээ хураалгах бүрэн эрхт төлөөлгчийг үйлчилж байлаа. хурандаа Аурелиано Буэндиа үс нь халцарсан балиар луусаар ирэв. Сахал самбайгаа ч хусаагүй, бугласан шархандаа зовохоосоо илүү булт мөрөөдлөө баларсныг ойлгохдоо шаналж байлаа. Учир нь хамаг найдвар тасарч, хүрсэн алдар цуу, хүсэх нэр төр ч нохойн замаар оржээ. Дайн зогсоох гэрээнд гарын үсэг зурж байгаа нь эмгэнэлтэй явдал мөний учир түүний хүссэнээр хөгжим дуугаргах, бүрээ тарах, хонх цохих, уухай хашгирах болон баяр баясгалангийн ямар ч байдал үзүүлэхийг хоригложээ.

Гэрээ байгуулах ажиллагаа нь гарын үсэг зурах төдий үргэлжлэв. Төлөөлөгч нар хуучирч муудсан циркийн асрын голд энгийн модон ширээнээ сууж, хурандаа Аурелиано Буэндиаг үнэнч офиц?рүд тойрон зогсож байлаа. Гарын үсэг зурахын өмнө улсын ерөнхлйгчийн бие төлөөлөгч бууж өгсөн тухай акт унших гэсэн боловч хурандаа Аурелиано Буэндиа эсэргүүцэж “Албархаж цаг үрээд яах вэ” гээд бичгийг уншилгүй гарын үсэг зурахаар бэлтгэв. Гэтэл нэг офицер нь асрын нозоором нам гүмийг эвдэж,

- Хурандаа, биднийг нигүүлсэж, түрүүлэн үсгээ бүү зур аз гэж хэлжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа зөвшөөрөв. Үзэг цаасан дээр чахрах байдлаар нь тийм үсэг бичиж байна гэж танигдахаар нам гүмийн дунд баримт бичиг ширээ тойроод ирэхэд хамгийн эхний хэсэг онгорхой үлджээ.

Тэгтэл нэг офицер:

- Хурандаа, нэрээ авч гарах боломж танд бас байна шүү! гэж хэлжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа царайгаа ч хувилгасангүй баримт бичгийн өнгөн хувь дээр гарын үсэг зурав. Тэгээд сүүлийн хувь дээр гарын үсэг зурж амжаагүй байтал босогч цэргийн нэгэн офицер хоёр авдар ачсан луус хөтөлсөөр асарт орж иржээ. Шинэ ирсэн хүн хэчнээн залуу боловч хэрсүү чанга байдалтай ажээ. Тэр бол Макондо тойргийн босогчдын сангийн нярав байлаа. Тэр офицер харнагдаж үхэх гэж байга луусаа чирэх нь холгүй, зургаан өдөр зүтгэж байж амжиж иржээ. Тэрбээр илжигнээс авдрыг туйлын болгоомжтой буулган онгойлгоод, далан хоёр алтан тоосгыг ширээн дээр нэг нэгээр нь хураав. Энэ их хөрөнгийг цөмөөрөө мартсан байжээ. Сүүлийн жилд төв командлал задран хувьсгал нь мувьсгал болж толгойлогчид нь цас урсган өрсөлдсөөр нийтээр эх толгойгүй юм облоод,гулууз болгон цутгаж дээрэс нь шавардсан босогчдын алт хариуцаж харах эзэнгүй, харж хамгаалах харуулгүй үлджээ. Хурандаа Аурелиано Буэниа даланхоёр алтан тоосгыг бууж өгөх баримтад оруулж, ямар ч яриа хөөрөөгүйгээр гарын үсэг зурав. Сульдаж ядарсан залуу офицер чихрийн шүүсний алтлаг өнгөтэй том нүдээрээ нүдийг нь харан зогссоор байсанд,

- Өөр юу гээ вэ? гэж хурандаа Аурелиано Буэндиа асуусанд цаадах ньт шүдээ зууж,

- Надад хүлээж авлаа гэсэн баримт өг гэжээ.

Хурандаа Аурелиано Буэндиа баримтыг өөрийн биеэр өглөө. Тэгээд хандмаа нарын өгсөн аяга нимбэгний шүүс ууж, жигнэмэгний хэтэрхий идэдэ, өрөийг нь амрулахаар блэтгэсэн аян майханд ороод цамцаа тайл, ор сандайлсаан суугаад, өөрийнхөө эмчийн иолоор цээжин дэрэ ньзурж өсөндугуй руу өдрийн гурван цаг арван таван минутад буудаж орхивой. Яг энэ үед Урсула зуухан дээр хөөрүүлэхээр тавьсан хоовонтой сүүнийхээ тагийг сөхвөл сүү нь буцлаагүй байсанд гайхан үзтэл дотор нь өт язганаж байсанд,

- Аурелиано алчихаж! Гэж дуу алджээ.

Ганцаараа байсаар сурчихсан зангаараа гадагш гарвал бороонд норж, үхсэн үеийнхнээсээ хавьгүй өвгөрсөн нөхөр нь уйтгарлан суугаа үзэгдлээ. “Хүү чинь хорлогджээ. Хэн ч нүдийг нь аниулах гэж санаа тавьсангүй” гэж Урсула ярив.

Шөнө Урсула од харвах лугаа адил тэнгэрт дугуй дугуй улбар туяа зурайж байхыг нулимс бүрхсэн нүдээр хараад үхэхийн ёр гэж санажээ. Хурандаа Аурелиано Буэндиаг цусанд барилдан дэрийсэн цуванд хулдаастай авчрахад

Урсула туулайн бөөр модны доор нөхрийнхөө өвдгийг түшин уйлсаар байжээ. Аурелианогийн хараастай нүд нь галзуу юм шиг гялалзаж байлаа.

Нэвт гарсан сум аминд нь аюултай, цэвэрхэн бөгөөд шулуухан учи эмч иод шингээсэн утас хэнхдэг рүү ядах юмгүй шургуулаад, нуругаар нь гаргаад иржээ. “Энэ бол миний нээлтийн дээж, Нэг ч амин сүдас дайралгүйгээр сум гарч болох цорын ганц газар энэ” гэж сэтгэл хангалуун хэлжээ. Хурандаа Аурелиано Буэндиа өрийг нь өрөвдөн хойдохын зам мөрийг нь тэнгэрт даатгах гуниг дүүрэн тамалга уншиж байгаа гэлэнмаа нар тойрчихсон байгааг хараад, анх санаснаараа ам руугаа буудах минь яалаа, мэргийг нь оноогүй хэмээн Пилар Тернераг хэрэггүй даажигнах гэлээ гэж амаа барьжээ.

- Жаахан ч эрх мэдэлтэй байсан бол таныг үг өчиггүй буудаж орих сон. Таныг амийг минь аварлаа гэж биш, амьтны элэг доог болголоо гэж тэр шүүгэж эмчид хэлжээ.

Амиа хорлох гэснээрээ хэдхэн цагийн дотор хурандаа Аурелиано Буэндиа урьдын сайн нэрэ эолж авав. Алтан тоосгоор барьсан тасалгаанд суух гэж дайнд урвасан гэсэн цуу тараагчид түүний амиа тэвчих гэснийг ариун явдал гэж үзэж, зовсон хүн гэ жхэлцэх болло. Улсын ерөнхийлөгчийн шагнасан Хүндэтгэлийн одонг хурандаагийн авахгүй гэсний нь дараа улайран эсэргүүцэгчид ч түүн дээр ирж, гээрний болзлыг хүлээж авахаа болиод шинэ дайн эхлэхийг гуйж байлаа. Урьдын гэмээ цагаатгах гэж ирүүлсэн бэлэг сэлтээр байшин нь дүүрлээ. Урьдын зэвсэг нэгт нөхдийнхөө хожуухан ч гэсэн ийнхүү дэмжсэнд сэтгэл хөдөлсөн хурандаа Аурелиано буэндиа тэдний хүссэнийг биелүүлэхэд болох юм гэж үзэж байлаа. Нэг үе тэрбээр шинэ дайн үүсгэх өдрийн бодол шөнийн зүүд болж, тэр ч байтугай хурандаа Геринельдо Маркес дайн зарлах шалтаг л гарахыг л харж байна уу даа гэж боджээ. Нээрээ ч шалтаг гарав. Улсын ерөнхийлөгч дайнд оролцсон либерал, консервативчуудын хэргийг тусгай комиссор нэг бүрчлэн авч үзэж, конгрессоор төсвийн тухай хууль батлуулахаас нааш тэдэнд цэргийн тэтгэвэр олгохоос цааргалав. Хурандаа Аурелиано Буэндиа “энэ бол цадиггүй явдал. Тэр тэтгэврийг хүлээх юм бол нас гүйцэхгүй” хэмээн аянга буулгаж байлаа. Илаарьшиж байх үед нь Урсулагийн худалдан авч өгсөн ганхуур сандлаас анх босож.. өрөөн дотуураа цааш нааш алхсаар ерөнхийлөгчид өргөх шазруун айлтгалыг хэлж өгч бичүүлжээ. Хэзээ ч хэвлэгдээгүй энэ цахилгаан утсандаа тэрбээр Неерландын гэрээний болзлыг зөрчлөө гэж ерөнхийлөгчийг зэмлээд, ойрын хоёр долоо хоногт тэтгэмжийн асуудлыг шийдэхгүй бол үхэх сэхэхээ үзэн дайтна гэж далайлгажээ. Түүний шаардсанньтуйлыншаударга бйсан тулд дайнд ороцсон консервайтв нмынхан ч дэмжинэ гэж найдаж облохоорбайлаа. Гэвч засгийн газархаюу өгөхийнорондхурандааг хамгалах нэрийдлээр гэрийнхнь дэргэдэх хамгаалатыгнэмэгдүүлж,түүн дээр хүн оруулахыг хориглов. Засгийн газар өөртөө аюултай босогчдын бусад дарга нарын талаар ч иймэрхүү арга хэмжээг

юмыг яаж мэдэх вэ гэж авчээ. Ажиллагааг шуурхай, эрчимтэй бөгөөд амжилттай явуулсан тул гэрээ байгуулснаас хойг хоёр сар болоод хурандаа Аурелиано Буэндиаг хөл дээрээ бүрэн ёсох еед хамгийн итгэлтэй шадар туслагч нар нь нэг бол алагдаж үгүй бол нутаг заагдаж, эсвэл засгийн газартзүтгэх бослон байлаа.

Арван хоёрдугаар сард Аурелиано Буэндиа унлагын өрөөнөөс гарад, дайн хийнэ гэж санасны гарз гэдгийг дор нь ойлгожээ. Урсула насандаа байшгүй хөнгөн шингэнхөдөлж бүх байшингаа дахин шинэчлэв. Хүүгийн нь амьд үлсдэн гэж тэр өдөр эрбээр “Миний ямар хүн болохыг одоо тэд мэднэ ээ, гайгүй! Энэ галзуугийн байшин шиг гоё, зочломтгой нэг ч айл байхгүй болно” гэж хэлжээ. Тэр байшингаа угалгаж будуулан тавилгаа сольж, цэцэрлэгээ додомдож, шинэ цэцэг суулгаж, бүх хаалга цонхоо цэлийтэл дэлгэж, зуны нүд гялбам гэрлийг унтлагын өрөөнд хүртэл оруулжээ. Тэгээд давхцсан олон гашуудлыг тайлсныг бүхэн дуулгаж, өөрөө хуучин хар палаажая тайлж, залуу хүн шиг гоёжээ. Гэрт оньст хуурын хөгжилтэй аялгуу дахин сонсдох боллоо. Амарантад үүнийг сонсгоход нь Пьетро Креспийн үдшийн бүрийд ханхлах, жүрүр, лаваандын үнэр санагдаж, ганирхарсан зүрхний нь угт дахин хорсрол, тэгэхдээ улирах цагийн эрхэнд цэвэршиж, гайгүй болсон хорсол зангирчээ. Нэг орой Урсула зочдынхоо өрөөг цэвэрлэж байгаад, байшинг хамгаалж байгаа нэг цэргээс элбэлцэхийг гуйжээ. Дарга нь болох залуу офицер халжилцах болов. Урсула шөнийн хоногоор шинэ шинэ юм тэднээр хийлгэх болов. Мөн хоол идүүлж, гутал өгч, тэдэнд бичиг үсэг заах болов. Хожим засгийн газар харуул гаргахаа зогсооход нэг цэрэг гэрт үлдэж, Урсулад олон жил ажил хийж өгч билээ. Сайхан Ремедиосын хайхраагүйд ухаан тавьсан залуу офицер шинэ жилийн үүрээр цонхны нь доор үхсэн хэвтэж байлаа.

\*\*\* \*\*

Олон жилийн хойно Бага Аурелиано үхэх өдрөө хүлээж байхдаа зургадугаар сарын тэр нэгэн бороотой өдөр ууган хүүгээ харах гэж унтлагын өрөөнд орсноо санаж билээ. Хүү нь Буэндиагийнхны удам гэхээргүй чөргөр уйланхай, боловч эцэг нь ямар нэг өгөхийг бодож цөхсөнгүй:

- Хосе Аркадио гэж нэр өгнө гэжээ.

Жилийн өмнө суусан сайхан хүүхэн Фернанда дель Карпио нөхрийнхөө хэлснээс зөрсөнгүй. Харин Урсула л сэтгэл тавгүй болсноо нууж чадсангүй. Энэ гэр бүлийн удаан түүхийн туршид нэг нэрийг ахин дахин өгснөөс Урсула нэг юмыг оройруугаа ортол ойлгосон нь юу вэ гэвэл бүх Аурелиано зожи, хурц ухаантай байхад бүх Хосе Аркадио огцом түргэн, овсгоо сүйхээтэй, эмгэнэлэй тавилантай улс байлаа. Гагцхүү Бага Хосе Аркадио, Бага Аурелиано нар л тэдгээрийн аль алинд нь орохгүй байлаа. Багадаа тэр хоёр үйлийн үргүй адилхан хоёул өрөмний өт шиг цовхчсон хүүхдүүд байсан тул

Санта Софи де ла Пьедад өөрөө хүртэл тэднийг ялгагдаггүй байлаа. Угаалгынх нь өдөр Амаранта нэр нэрийг нь цохисон бугуйвч бугуйнд нь зүүж, нэрийнх нь эхний үсгийг шаглаж өгсөн боловч ихэх хоёр сургуульд явдаг болохдоо хувцас бугуйвчаа, тэр ч байтугай нэрээ сольдог цамцаар нь Бага Хосе Аркадио гэж таньдаг боловч ногоон цамцтай жаал хүүгийн гарт “Бага Аурлеиано” гэсэн нэртэй бугуйвч байгааг, цагаан цамцтай жаал гартаа “Бараг Хосе Аркадио” гэсэн бугуйвчтай атлаа өөрийгөө Бага Аруелиано гэж зүтгэж байгааг үзээд барьж алдаж гүйцжээ. Түүнээс хойш хэн ч алин болохын эндүүрэлгүйгээр хэлж чадахаа больжээ. Тэр ч байтугай том бодохдоо огт өөр өөр болсон боловч Урсула тэднийг хувцсаа сольж өмсөн амьтны толгой эргүүлэн наадаж байхдаа өөрсдөө самуураагүй байгаа даа гэж өөрөөсөө асуудаг байлаа. Ихэр хоёр цээнд хүртлээ зэрэг ажилдага хос оньс аятай байлаа. Хоёул зэрэг сэрнэ, нүүр гараа угаах болоход хоёул зэрэг угаах гэнэ, нэг нь өвдөхөд нөгөө тэр өвчнөөр заавал өвдөн. Тэр ч батугай адилхан зүүд зүүдэлнэ. Хөвгүүдийг зүггүйтэх гэхдээ л бие биеэ дуурайж байна гэж гэрийнхэн нь бултаараа бодоод, Санат Софи де ла Пьедадыг тэр хоёрын нэгэнд нимбэгтэй ус өгтөл үнэн учрыг огт тухайлахгүй байжээ. Тэгэхэд яасан бэ гэвэл нэг нь тэр ундааг дөнөж амстал нөгөө нь “наадах чинь амгүй юм” гэжээ. Санта Софи де ла Пьедад нээрээ аяганд чихэр хийхээ мартсан байж, үүнийгээ Урсулад хэлжээ. “Цаадуул чинь цөмөөрөө адилхан, төрөхийн газлуу ю” гээд Урсула огт тоосонгүй. Он жил өнгөрөхөд улам ч учир олохоо байжээ. Хувсаа сольж наадсаны дараа Ага Аурелиано гэж нэршсэн хүү Хосе Аркадио Буэндио өвөө шигээ булиа эр болж, бага Хосе Аркадио нэртэй болсон нь хурандаа Аурелиано Буэндиа шиг туранхай болж, ихэр хоёрт дундын гэмээр ганц юм байсан нь тэднийхэнд байдаг ганцаардангуй байдал ажээ. Чухамхүү нуруу туруу, нэр ус, зан байдал тохирохгүй байгаагаас нь Урсула ихэр хоёрыг багадаа нэрээ самуурчихсан юм болов уу гэж бодсон байж болох юм.

:Дайны ид дундуур тэр хоёрын гол ялгаа харагдав. Бага Хосе Аркадио “Хүнийг яаж бууддагийг үзүүлээч” гэж хурандаа Геринельдо Маркесаас гуйжээ. Урсула хориглосон боловч Маркес түүнд үзүүлжээ. Гэтэл Бага Аурелиано хүн цаазалж байгааг харна гэхээс хиртхийн цочиж гэртээ байхыг илүүд үздэг байлаа. Арван хоёртой болохдоо Урсулагаас цоожтой өрөөнд юу байгааг асуужээ. “Бичиг цаас л бий. Мелькиадесийн ном, насныхаа сүүлийн хэдэн жилд зохиосон хачирхалтай тэмдэглэл байгаа” гэж Урсулагийн хариулсан Бага Аурелиано сэтгэл ханахын оронд улам сонь гозолгон өөд уруугүй шалсаар байж, юм огт сандаахгүй гэж ам өчиг өгч Урсулагаас түлхүүрийг авчээ. Мелькиадесийн хүүрийг гаргаснаас хойш тэр тасалгаанд хэн ч орсонгүй, хаалганд нь дүүжилсэн цоожны өргөс сэлт зэврээд барьцалдсан мэт санагдав. Гэвч бага Аурелиано цонхыг нээхэд \өдөр бүр нарны гэрэл орж байсан юм шиг өөрөө цэлхийн, өлөн шороо, аалзны шүлс өчүүхэн ч байхгүй, Мелькиадесийг оршуулсан өдрөөс ч цэвэр цэмцгэр байж, нагбуманд нь бэх дундраагүй дүрэн,

огт зэврээгүй төмөр гадар нь гялтагнан, Хосе Аркадио Буэндиагийн мөнгөн ус хайлуулсан хөөрөгт гал ноцоостой чигээрээ байж байлаа. Он удсанаас үрчийн, наранд борлосон хүний арьс шиг шарласан даавуунд боолттой ном тавиур дээр өрөөстэй, басхүү гар бичмэл бүв бүтнээрээ тавиастан байлаа. Өрөө олон жил цоожтой байсан боловч агаар нь бусад өрөөнөөс цэвэр байх шиг санагдах ажээ. Хэдэн долоо хоногийн дараа ч бүх юм яв янзаараа байж, Урсула шалыг нь угаахаар хувинтай ус, сойзтой ирвэл үнэндээ хийх юм байсангүй. Бага Аурелиано нэг ном шагайгаад суучихсан байлаа. Жаал хүү тэр хавтасгүй номынхоо нэрийг мэдэхгүй боловч нэг эмэгтэй дан цагаан будаа идэж, тэгэхдээ ширхэг бүрийг нь хоёр алтан савхаар авч иддэг тухай, бас нэг загасчин хөршөөсөө торны живүүр зээлж аваад шанднь загас өгсөнд гэдэснээс нь асар том очир алмаас гарсан тухай, юу санасан есөн хүсэл биелүүлдэг дэнлүү, нисдэг хивсний тухай өгүүлснийг нэгд нэгэнгүй амтархан уншиж байлаа. Гайхаж хоцорсон хүү Урсулагаас тэр бүхний үнэн эсэхийг асуусанд тэр “Үнэн, олон жилийн өмнө цыган нар Макондод шидэт дэнлүү, нисдэг цийрс авчирсан” гэж хариулж,

- Зртөнц мөхөх тийшээ хандаж байна. Тийм юм дахиад дайралдахгүй гэж санаа алджээ.

Номын хуудасдутуугаас олон өгүүллэг хагас байсан боловч бүхэлд нь уншиж дуусаад гар бичмэлийг тайлах гэж зорив. Энэ нь барж идэхгүй йхоол байлаа. Үсэг нь дан дээр хатаахаар тавьсан доогуур хувцас аятай бөгөөд жирийн бичиг гэхээсээ дууны ноотгэмээр ажээ. Нэгэн халуун үдээр Бага Ариуелиано гар бичмэлийг шимтэн үзэж суутал өрөөнд нь хүн байгааг мэдэв. Гэрэл тусах дөрвөлжин цонхны дэргэд Мелькиадес өвдөг дээрээ гараа зөрүүлээд сууж байлаа. Нас дөч хэтрээгүй харагдаж байлаа. эртний мөнөөхөн хантааз, хэрээний далавч шиг хүрээтэй бүрх өмссөн агаад хөлс нь цонхигор шанааг нь дагаад хайлсан өөх шиг урсах ажээ. Аурелиано, Хосе Аркадио хоёрын хүүхэд байхдаа харсан яг тэр байдалтай байжээ. Мелькиадесийг тэднийхэн үе дамжуулан дурсаж ирсэн, Бага Аурелиано өвөөгөөсөө олж дуулсан болохоор дор нь тань:,

- Сайн байна уу гэж хэлэхэд Мелькиадес:

- Сайн, сайн байна уу, залуу минь гэжээ.

Түүнээс хойш хэдэн жилийн турш тэр хоёр орой болгон шахам уулздаг байлаа. Мелькиадес ертөнцийн тухай жаал хүүд ярьж, хуучирсан ухаанаа түүнд зах гэж оролдсон боловч гар бичмэлээ тайлбарлахаас дургүйлхэж”Зуун жил болохоос нааш гар бичмэлд юу байгааг хэн ч мэдэх ёсгүй” гэж хэлжээ. Бага Аурелиано ингэж уулздагаа тас нуудаг байлаа. Нэг удаа Урсула түүнийг яг Мелькиадестэй байж байтал нь орж ирсэнд Аурелиано ингэж амьхнаараа байдаг нь баларчээ гэж айсан боловч Урсула цыганыг олж харсангүй.

- Хэнтэй яриад байна вэ? гэж түүний асуусанд Бага Аурелиано:

- Хэнтэй ч яриагүй ээ гэж хариулав.

- Элэнц эцэг чинь ийм хүн байж билээ. Бас л ганцаараа яриад байдаг байсан сан.

Энэ зуур Бага Хоcе Аркадио хүн буудаж алж байгааг үзэх гэсэн санаандаа хүрчээ. Зургаан буу зэрэг нэрхийж, хөх гал манасхийнг цуурай н ууланд хадаж, цаазлуулж багаа хүн гунигтаяа инээмсэглэн, самгардангуй харж байсныг, цамц нь цус болсон боловч зогсоор, шонгоос салгаж, дүүрэн шохойтой том авсанд хийж байхад инээмсэглэсээр байсныг насан туршаа мартаггүй. “Амьд байна. Амьд бхайд нь оршиуулж байна “гэж Бага Хоcе Аркадио боджээ. Жаал хүү үүнээс жигшиж тэр цагаас хойш дайн, цэргийн гэсэн юм бүрийг үзэн ядаж, тэгэхдээ хүнийг цаазаар авдаг гэж үзэн ядсангүй, буудуулсан хүнийг амьдаар нь оршуулдаг аймар заншилтайд нь үзэн яджээ. Бага Хоcе Аркадио сүмийн гонхонд хонх цохиж, Хонхилдог цээжийн оронд ирсэн Антонио Исабель лам тусалж, хурал хурах, сүмийн хашаанд зодооч тахиа маллахад нь хамжилцдаг болсныг хэн ч анзаарсангүй. Хөвгүүн үүнийгээ мэдэгдээд, хурандаа Геринельдо Маркест журамт либералын жигшин үзэх ажил хийлээ гэж зад загнуулахдаа “Би консерватив үзэлтэй ч болчихсон юм гэж санагдах юм даа” гэж хариулжээ. Өөрийнхөө ийм төөрөгтэй гэдэгт итгэж байлаа. Хурандаа Геринельдо Маркесийн түүнд дургүй байгаагаа хэлэхэд Урсула:

- Юун ашгүй юм! Гэж жичийгээ магтаад –Ядахдаа энэ маань санваар хүртвэл эзэн тэнгэр манайхыг буяны мөрт оруулж юуны магад гэж хэлжээ.

Антонио исабель лам шавьдаа хишиг хүртээхгэж бани агэж Урсула дуулав. Ламтан тахианы хүзүүний үсийг хусангаа түүнд тэнгэрийн сургаалын хураангуйг зааж, эм тахиаг үүүрдэнд өндгөн дээр хэвтүүлэх зуураа эзэн тэнгэр хүнийг бүтээснийхээ хойд өдөр л дэгдээхийг өндөгөн дотор өйжуулах болсны учрыг энгийн жишээгээр тайлбарлаж өгчээ. Байдлаас үзэхэд тэгэхэд Антонио Падре лам зөнөж эхлэн, хэдэн жилийн хойно бүр мунаж хоцроод “Чөтгөр тэнгэрт тэсэргүүлэн дийлээд тэнгэрийн суудалд залран, сэрэмж муутанг торондоо оруулах гэхдээ өөрийнхөө хэн болохыг нуусан бололтой” гэж хэлжээ. Бага Хоcе Аркадио ийм зүрхтэй багшаар ном заалгасан учир хэдхэн сарын дотор чөтгөрийн толгойг эргүүлэх шашны нарийн ухааныг мэддэг болсон төдийгүй азарган тахиа зодолдуулах мэргэжилтэн болжээ. Тэгээд тэр тахиачин боллоо. Түүнийг шувууныхаа сайныг авч анх гэртээ ирэхэд Урсула “Наадуулыгаа өөр газарт аваач. Тахианаас болж манайхан амссан зовлон багадаагүй” гэж загнажээ. Бага Хоcе Аркадио үг зөрөлгүй, шувуугаа авч явсан боловч Пилар Тернерагийн сургуулилуулах болж, Пилар Тернера ч ачаа хажуудаа байлгах гэхдээ дураар нь тавьжээ. Удалгүй Бага Хоcе Аркадио тахианы зодоонд Антонио Исабель ламын зааж өгсөн заль мэхийг овсгоотой хэрэглэж, шувуугаа олон болгоход төдийгүй, эр хүнийхээ хэрэгцээг хангахад хүрэлцэхээр их мөнгө

олох болов. Тэр үед Урсула, Бага Хосе Аркадио ихрийн нь өрөөсөнтэй нь жишиж, яг адилхан байсан хоёр хүүхэд ийм өөр өөр болчих гэж байх уу гэж гайхаш тасарч байлаа. Гэвч хөгшин түүнийг эргэцүүлэн удтал тархиа гашилгах хэрэг гарсангүй, учир нь төдхөн бага Аурелиано залхуу, задгай болж эхлэв. Мелькиадесийн өрөөнд ном бясалгаж байхдаа хурандаа Аурелиано Буэндиагийн залуугийнх шиг зожиг, дотроо юм бодсон хүн байлаа. Гэвч Неерландын гэрээ байгуулахын өмнөхөн нэгэн санаадгүй явдлаас болж, тэрбээр аглагийн өрөөнөөсөө гарч амьдралтай нүүр тулгарч билээ. Найраг баян хуурын хонжворт сугалааны пиу худалдаж байсан залуу хүүхэн түүнтэй гэнэт танимхайран мэндэлжээ. Өөрийг нь ихрийн нь өрөөсөнтэй урьд ихээхэн андуурдаг байсан тул түүнд нэг их гайхсангүй. Бүсгүй өөрийнх нь сэтгэлийг татах гэж уйлагнаж байхад ч, дагуулаад өрөөндөө авчирахад ч эндүүрснийг нь хэлээгүй билээ. Анх ингэж уулзсанаас хойш хүүхэн түүнд учиргүй дасаж, баян хуурыг түүгээр авахуулах гэж, тэр ч байтугай пиуг түүнд тааруулжээ. Хоёр долоо хоноод Бага Аурелиано нэг хүн гэж хүүхний андууран өөртэй нь болоод ихрийн нь өрөөсөнтэй ээлжлэн нийлж байгааг мэдэхдээ учраа ололцох гэсэнгүй, харин ч үнэнийг тас нууж байлаа. Мелькиадесийн өрөөгөөр шагайхаа болив. Гашуудал тайлаагүй байсны улмаас гэрт хөгжим дуугарахыг хориглосны дээр Хүмүүн Франсискогийн шийрийг хатаагч хэрмэл хөгжимчдийн зэмсэг хэмээн найраг баян хуурыг үзэж байсан Урсулагийн үглэхийг ч хайхрахгүй баян хуураа сонсголоороо дарж сурах гэж гадаа өнжих болжээ. Тэгж, тэгж Бага Аурелиано сайн хуурч болж, эхнэр хүүхэдтэй болсон хойноо ч хөгжмөө тоглож, Макондод хамгийн хүндтэй хүний нэгэн болжээ.

Хоёр сар шахам тэрбээр нөгөө эмэгтэйг ахтайгаа хувааж хэрэглэжээ. Бага Хосе Аркадио мөрдөн ажиглаж, хийх гэж байсан юмыг нь сандааж, шөнө нь түүнийг дундын хүүхэн дээр очихгүй нь гэж мэдэж аваад өөрөө тууж хүрдэг байлаа. Нэг өглөө мэдвэл торгон өмд өмссөн байлаа. Хоёр хоноод угаагуурын өрөөнд ахтайгаа тааралдвал цаадах нь хананд нүүрээ наачихсан, хамаг бие нь хөлөрчихсөн, цус нулимс болчихсон байж байв. Тэгэхэд Бага Аурелиано учрыг ойлголоо. Нөгөө хүүхэн муу өвчин халдаалаа гэж хөөснийг улайж, Пилар Тернера өөрийг нь эдгээх гэж оролдож байгааг хэлжээ. Бага Аурелиано халуун марганцуугаар сэмхэн угааж, шээс хүргэдэг янз бүрийн эм ууж, гурван сар далдуур зовсны эцэст сая хоёул эдгэрчээ. Бага Хосе Аркадио хүүхэнтэй дахиад учирсангүй. Бага Аурелиано гуйж гувшсаар байж, уучлуулаад түүнтэй үхэн үхтэлээ явжээ. Тэр хүүхнийг Петра Котес гэдэг байлаа. Тэрбээр дайны үеэр сугалааны орлогоор амь зуудаг санамсаргүй суусан нөхрөө дагаж Макондод ирээд түүнийг үхэхэд нь ажлыг нь залгуулан хийжээ. Ирвэснийх шиг шар нүдтэй учир ширүүн дүртэй харагдах боловч өгөөмөр уужим сэтгэлтэй, амрагийн ажилд аргагүй дүйтэй, цэвэрч нямбай, залуухан эрлийз хүүхэн байлаа. “Бага Хосе Аркадио зодооч тахиа үржүүлж, Бага Аурелиано нууц амрагийнда зад найрлан найраг баян хуур дарж байна” гэж Урсула дуулахдаа



ичиж зовсондоо золтой л галзуурсангүй. Хоёр ихэр эднийхний аль мууг дуурайсан мөртлөө ганц ч өөдтэйг авсангүй. Үүнээс хойш түүнээс цааш эдний удам судрынханд Аурелиано, Хосе Аркадио гэсэн нэр өгөхгүй гэж Урсула шийджээ. Гэвч Бага Аурелианогийн ууган хүүг төрөхөд эцгийнх нь хүссэнээс зөрж зүрхэлсэнгүй.

- За яах вэ, тэгье, гэхдээ би өөрөө наад хүүг чинь өсгөнө гэж Урсула хэлжээ.

Урсула нас сүдэрт зуу хүрч, нүд нь бараг юм үзэхээ больсон боловч бие хөнгөн, зан тогтуун, ухаан саруулхан хэвээрээ байлаа. Тэр хүүг гал голомтыг нь балласан дайн дажин, зодооч тахиа, завхай хүүхэн, солиот бодол гэсэн дөрвөн хорыг мэдэхгүй, уг удмынхаа нэрийг дахин өргөх сайн хүн болгон өсгөж өөрөөс нь өөрхөн ч чадахгүйгэж игэж байлаа. “Үүнийг лам болгоно оо. Тэнгэр таалж насыг минь уртасгадаг л юм бол пал лам болгохдоо болгоно” гэж сүртэй нь арагүй амлажээ. Урсулагийн ингэж хэлэхэд унтлагын өрөөнд байгсад төдийгүй бусад өрөөгөөр дүүрэн цулаад байсан бага Аурелианогийн шуугиант найз нар хүртэл хөхрөлджээ. Дайн нэгэнт мартагдаж, аливаа муу муухайг хадгалж үлддэг санааны мухарт л хоцорсон байснаа шампан дарсны бөглөө пүс пүсхийн мултрах үед л гэнэт сэтгэлд харван орж иржээ.

- Лам болох хүүгийн төлөө гэж Бага Аурелиано дуу алдав.

Зочид нэгэн дуугаар ерөөлийг давтав. Дараа нь гэрийн эзний баян хуур хангинаж, пуужин агаарт хөөрч, зон олонд зориулж захисан баярын бмбөр пижгнэлээ. Үүр цайхад шампани дарсан шал согтсон зочид зургаан тугал муу хийж, махыг нь гадаад байгаа улсыг идэг гэж явуулжээ. Гэрийнхэн үүнд огт ондууцсангүй. Бага Аурелиано гэрийнхээ хамаг ажлыг мэдэх болсноос хойш ингэж найрлах нь ерийн юм болж, тэр ч байтугай хутагт лам төрсөн шиг ийм хүндтэй шалтгаан байхгүй йбайхад ч найрладаг болжээ. Огт хүч санаа тавиагүй байхад хэдэн жилийн дотор мал шувуу нь ер бусын үржиж, Аурелиано тэр хавьдаа хамгийн баян хүний нэг болсон нь гагцхүү амны хишиг гэхээс өөр аргагүй. Гүү гурван ихэр унага гаргаж, тахиа өдөрт хоёр өндөглөж, гахай арьсаа язартал таргалж байсанд хүн амьтан үүнийг нь илбэ жилбэ гэхээс өөрөөр тайлбарлаж чадахгүй байлаа. “Мөнгөө хадгал аа. Дандаа ийм азтай байна гэж байхгүй!” гэж гоомой жичдээ Урсулаа яншдаг байлаа. Гэвч Бага Аурелиано үгийг нь үл тооно. Нөхдөө дайлан хэдийчинээ олон шампан дарсны бөглөө мултлах тусам аз хийморь нь өөртнь бус, гагцхүү шим ертөнцийг сэргээх чадалтай Петра Котесийн амрагийн сэтгэлд байна гэдгийг төдийчинээ итгэх облж байлаа. Чухамхүү үүний хүчинд л хөлжиж байгаа гэдэгт бат итгэн, Петра Котейг малынха ойролцоо байлгаж, Фернанда хүүхэнтэй гэрлэж, үр хүүхэдэй болсон хойноо ч гэргийнхээ зөвшөөрснөөр нууц амрагтайгаа уулзсаар байжээ. Тэрбээр өвөг дээдэс шигээ чийрэг, том боловч тэднийг бодвол хөхүүн баясгалантай, хамгийн сэтгэлийнг татсан эр болж, тэгээд ч малаа маллах

зав бараг байдаггүй байлаа. Петра Котесийг аваад малынхаа хашаандочих, хоёул бэлчээрээр морьтой явахад л түүнийтамгатай мал, бүр замгүй үрждэг байлаа.

Бага Аурелиано Петра Котес хоёрын насны уртад сайн сайхан бүхэнгэнэт ирж байсан шиг энэ их эд баялаг тэнгэрэс унан даржээ. Дайн дуусан дуустал Петра Котес сугалааныхаа орлогоор амь зууж, Бага Аруелиано Урсулагийн хурааснаас хэд гурван юм салгачих санаатай сугалаа өөрөө ч хийдэг байлаа. Хоёр амраг дэндү хөнгөмсөг, эртхэн орондоо орж өглөө болтол загас наадуулан эрхлэхээс өөрийг мэдэхгүйг, тэр ч байтагуй шашнаас цээрлэсэн үед ч уул ажлаа хийж л байдаг байлаа. “Чи энэ хүүхнээс нэг болно оо, гайгүй! Толгой чинь эргэсэн нь багадаад одоо гэдсээрээ хатгуулж ойчих гэж байгаа юм. Тэгээд гэдсэн дээр чинь хүйтэн бах тавих хэрэг гарна даа” гэж жичийнхээ үлгэн салган юм хөлөө чирэн ирж байгааг хараад загнадаг байлаа. Бага Хосе Аркадио өөрийг нь хэн орлосныгт их ээ хожуу мэдээд дүүгийнхээ, хүүхний юунд нь болсныг ойлгосонгүй. Түүний санаж байгаагаар бол Петра Котес унтахад төдий л сайнгүй, янаглах барихыг огт мэддэггүй ердийн нэг хүүхэн байсан. Гэвч Бага Аурелиано Урсулагийн үглэн дуулахыг ч ихрийнхээ өрөөсний элэглэн дооглохыг ч хайхрахгүй, Петрагийн байшингийн хөлсийг төлөөд байхуйц мөнгөтэй ажил олох сон, нэг шөнө тэр байшиндаа түүндээ тэврүүлээд хамтдаа үхчих юм сан гэдгээс өөр юм бодохгүй байлаа. Хурандаа Аурелиано Буэндиа насны эцэст амар сайхандаа жаргахын хүслэн болж урлангаа дахин нээхэд Бага Аурелиано алтан загас урлахыг унацтай ажил хэмээн боджээ. Хамгаас уйдсан хүний ёсоор хурандааг ухаанд багтамгүй тэвчээр гаргаж хатуу гулууз металлыг боловсруулан аажмаар алтан хайрс болгож байгааг ажиглаж цухалхан тасалгаанднь олон цагаар байдаг болжээ. Бага Аурелианод ажил туйлын хүнд, Петра Котесийг мөрөөдөх нь туйлын их бөгөөд хэцүү байсан тул гурван долоо хоноод урлангаас алга болжээ. Яг тэр үеэр, сугалааны хонжворт тавиулах гэж хэдэн чандага амраг бүсгүйдээ авчирч өгчээ. Гэтэл чандага нь учиргүй түргэн төрж үржээд, Петра Котес пиугаа арайхийж амжиж зарж байлаа. Эхлээд Бага Аурелиано үржих гэдэг замаа алдаж байгааг анзаарсангүй. Гэвч хотынхон сугалаагаар чандага хожно гэхээс дургүй нь хүрдэг болсны хойно тэд нэг шөнө хашаанд бөөн шуугиан гарахад сэржээ.

“Бүү ай, чандага байна” гэж Петра Котес хэлэв. Гэвч гадаа үргэлж түжигнээд тэр хоёрыг унтуулахгүй зовоожээ. Өглөө нь Бага Аурелиано хаалга нээгээд үзвэл хашаанд чандага пиг дүүрч, өглөөний туяанд үс нь хөхрөн солонгорч байв. Петра Котес солиотой юм шиг тачигнатал хөхөрч Бага Аурелиано даажигнах хорхойгоо барьж чадалгүй,

- наадуул чинь дөнгөж урьд шөнө гарсан нь гэж хэлсэнд Бага Аурелиано
- Ямар аймаар юм бэ! Үнээг ингэх гээд үзвэл яасан юм бэ? гэж дуу алдав.

Удалгүй Петра Котес хашаагаа дундлах гэж чандагаа үнээгээр арилжиж, үнээ нь хоёр сар болоод гурван ихэр гаргажээ. Үүнээс хамаг юм эхлэв. Нүд ирмэхийн зуурт Бага Аурелиано бэлчээр, сүргийн эзэн болж, агтны жүчээ, гахайн хороогоо арай ядан томсгож амжиж байлаа. Энэ нь зүүд шиг санагдаж, Аурелиано үүнийг бодохоос инээд нь хүрч, баярласан хэрээ бархирах гэгчийн үлгэрээр орж “Үнээнүүд минь тугаллаад бай, нас гэдэг ахархан” гэж хашгирч байлаа. Жичийгээ аль нэгэн хар хэрэгт орооцолдоогүй байгаа, амьтны мал зүгээр байлгахгүй хулгай зэлгий хийдэг болоогүй байгаа гэж Урсула айж, барж ядсандаа шампан дарсаар толгойгоо хөөсөртөл угаан зугаацаж байгааг харах бүрийдээ дэндүү балгадаж байна гэж толгой түрийгүй загнадаг байлаа. Урсулагийн ийнхүү эрүүдэхэд Бага Аурелиано залхаж, гүйцээд, нэг үүрээр халамцуухан буцаж ирэхдээ хайрцагтай мөнгө, лааз цавуу, багс авч, Хүмүүн Франсискогийн хуучны дууг хангинатал дуулсаар байшингийнхаа ханыг нэг песогийн<sup>1</sup> дэвсгэрээр гадна дотногүй өвч нааж орхижээ. Онъст хуур авчирсан цагаас хойш ямагт цагаанаар буддаг байсан хуучин цагийн байшин лалын сүмийн сэжиглэмээр байдалтай болов. Урсула ба гэрийнхэн нь дургүйлхэн загнаж гудамжинд шавсан хүн амьтан хайран мөнгийг яйран болгон баярхаж байгааг нь үзэнхөгжилдөж байхад Бага Аурелиано байшингийнхаа нрэн талад аваад гал зуух хүртэл, тэр байтугай угаалгын

## 1 Песо –Колумбийн мөнгөний нэг

өрөөг ч марталгүй наагаад үлдсэн мөнгийг гадагш цацаад,  
- Одоо мөнгө гэж надад үглэхээ болио биз гэж хэлжээ.

Нээрээ ч тэглээ. Урсула удирдан мөнгийг наалдсан шавартай нь хамт хуулан авч байшинг дахин цагаанаар будав. “Эзэн тэнгэр минь, энэ хотыг анх байгуулж байх үеийнх шиг биднийг ядуу болгож хайрла, үрэлгэн байсны төлөөсийг хойд насанд бидэнд бүү эдлүүлж хайрла” гэж Урсула мөргөж байлаа. Гэвч түүний ингэж гуйн мөргөснийг огт ондоогоор ойлгож байлаа. Нэгтийн дэвсгэрийг хуулж байсан нэг ажилчин дайны сүлээр хэний ч юм авчирсан хутагт Иосифийн том гөлтгөнө баримлыг санаандгүй дайрчихсанд баримал унаж, хага үсэрсэнд үзвэл дотроо хөндий, тэр хөндийд алтан зоос пиг чихсэн байжээ. Энэ хутагтын энд яагаад ирчихсэнийг санах гэж бөөн юм болжээ. “Энүүнийг гурван хүн дамжилж ирсэн юм. Бороо өнгөртөл энд байлгая” гэж гуйхаар нь “Хүний замд саад болохооргүй буланд тавьчих” гэсэнд, тийш нь эвтэйхэн тавьж

харагдсан юм. Сүүлд нь хэн ч авна гэж ирээгүй, тэндээ л байж байгаа нь энэ” гэж Амаранта ярих.

Сүүлийн үед Урсула баримлын өмнө зул өргөж сөхрөн мөргөдөг болсон нь хутагтад мөргөсөн бус хоёр зуун килограмм шахуу алтанд мөргөсөн болж таарч, ийнхүү өөрөө мэдэлгүй буруу номын юм хийж байснаа хожуухан мэдээд бүр ч гутарчээ. Бөөн овоолоостой мөнгийг шалнаас цуглуулж аваад гурван шуудайд хийж, үл таних гурван хүн эрт орой хэзээ нэгэн цагт ирж авах байх гэж нууцхан газар булжээ. Олоон жилийн хойно эрүү өвдөг нийлэн ядарч байхдаа Урсула гэртээ орж ирсэн явуулын улсын ярианд оролцож “Хутагт Иосифийн баримлыг бороо өнгөртөл энд байлгахаар орхисон улс биш биз? Гэж шалгаадаг зантай болж билээ.

Урсулагийн сэтгэлийг зовоосон элбэг дэлбэг байдал тэр үед ердийн юм байлаа. Макондо үлгэрт гардаг шиг амар сайхандаа жаргаж байлаа. Хуучцуулын шавар, хулсаар барьсан байшингийн оронд нар хаах модон самбар бүхий цонх, үд дундын бүгчим халууныг сэрүү татуулан дарах цементээн шалтай тоосгон барилга бослоо. Хосе Аркадио Буэндиагийн урьд байгуулсан суурингаас их юм үзсэн тоост бүйлсийн мод, тунгалаг уст гол хоёр үлдэж, Бага Хосе Аркадио голын гулдралыг цэвэрлэж, голоор хөлөг онгоц явуулах санаа үүсгэх үед чулуу засдаг хмүүс галбын үеийн амьтны өндөг шиг чулууг нь галзуу юм шиг бутлан үйрүүлж хаяжээ. Үхэр чулуу олонтой, боргио харгиа ихтэй тул Макондогоос далай хүртэл хөлөг онгоц явуулна гэдэг бол Хосе Аркадио Буэндиагийн зөгнөлтэй тэнцэх солиотой санаа байлаа. Гэвч Бага Аркадио төслөө гүйцэлдүүлнэ гэж санаанд оромгүй муйхарлан зүтгэжээ. Үүнээс өмнө тэр элдэв хэтийдсэн юмыг ургуулан бодож байсан нь огт үгүй. Петра Котсетэй түр явж байсныг нь тооцохгүй бол эмэгтэй хүнтэй хавьтаж явсангүй. Урсула энэ жичийгээ Буэндиагийнхны удмын дотроос хамгийн дорой нь тахиа зодолдуулах наадамд ч шалгарч чадахгүй хүн гэж боддог байлаа. Гэвч нэг удаа хурандаа Аурелиано Буэндиа дайтаж явахдаа далайгаас арван хоёр километр зайтай газарт хайрдан хоцорсон испанийн нэгэн хөлгийн сэг харлан байхыг биеэр үзсэнээ ярьжээ. Энэ явдлыг зохимол зүйл гэж эртнээс нааш үзэж ирсэн боловч Бага Хосе Аркадио огт өөрөөр ойлгожээ. Тэгээд тахиагаа үнэ хаялцуулан зараад мөнгөөр нь ажилчид хөлсөлж, багаж худалдан авч, чулуу булталж суваг татаж, усан доорххсийг цэвэрлэж, тэр ч байтугай боргиог тэгшилж, урьд хожид үзэгдээгүй ажил хийж гарчээ. “Үүнийг би андахгүй. Цаг хугацаа гэдэг нэг л тойргоор эргэж байдаг шиг байна, бид чинь эхэлсэн цэгтээ эргээд ирлээ шүү дээ” гэж Урсула үглэв. Бага Хосе Аркадио голг хөлөг онгоц явж болохоор боллоо гэж бодохдоо Бага Аурелианод сэдсэнээ нэгд нэгэнгүй ярьж, түүнд орох мөнгийг аваад удтал алга болов. Ихрийнхээ өрөөснөөс мөнгө салгаж үрэн таран хийх гэхдээ хөлөг худалдаж авна гэж заль зохиосон байна гэж макондогийнхон шивэр авир хийх болж байтал хот руу нэг жигтэй хачин хөлөг ирж явна хэмээн цуурхах боллоо. Хосе Аркадио

Буэндиагийн учир нажиргүй үүсгэлийг аль хэдийнээ мартсан макондогийнхон гол руу гүйлдэн очиж, Макондогийн дэргэд зогссон анхны бөгөөд сүүлчийн хөлөг эрэг рүү дөтлөн айсууг хараад нүдэндээ ч итгэсэнгүй. Энэ нь ердөө л бальсан I гуалин холбосон сал бөгөөд

## 1 Халуун орны мод – Орч

эрэг дагаж яваа хорин эм том төмөр татлагаар чирч, хошуун дээр Бага Хосе Аркадио баярласандаа нүдээ гялалзуулан зогсож, тэр төвөгтэй ажлыг удирдаж байлаа. Тэрбээр францын сайхан дууч эмс авчирчээ. Тэд содон өнгөтэй шүхрийн доор цонох нарнаас хоргодож ганган сайхан мөрөндөө торгон алчуур тохож, нүүрэндээ оо энгэсэг тавьж, үсэндээ амьд цэцэг хатгаж, гартаа алтан бугуйвч гялалзуулан зүүж, шүдэндээ очир алмас гялтгануулан шигтгэжээ. Бальсан сал бол Бага Хосе Аркадиогийн урсгал сөрөн Макондод авчирч чадсан цорын ганц хөвдөг хэрэгсэл байсан хэдий боловч бодож үүсгэсэнээ бүтэхгүй болсон гэж хүлээхгүй харин ч хийсэнээ байгалийн хүчнийг хүний зориг ялсны аугааа их бэлгэдэл гэж тунхаглаж байлаа. Бага Хосе Аркадио ганц улаан мөнгө үлдээлгүй тооцоогоо хийгээд дахиад л толгой өөд татахгүй зодооч тахиа маллах болов. Тэр бүтэлгүй санаачилгаас үлдсэн юм гэвэл Макондод францын дууч эмсийн бий болгосон шинэ амьсгал бөгөөд тэд амраглан янаглах уламжлалт аргыг гайхамшигт урлагаараа өөрчилж, нийгмийн сайн сайхны төлөө нүд цавчилгүй зүтгэсэнээр Катариногийн хуучирсан хүрээлэнг газартай тэгшилж, мухар гудамжийг хятад дэнлүүтэй, гунигт аялгуу бүхий бадралт баг бишгүүртэй шуугиант яармагийн байдалтай болгожээ. Чухамхүү франц дууч эмс л макондогийнхныг тэр аяар нь гурван өдөр ухаангүй болгож, Бага Аурелианог Фернандо дель Карпиотай танилцуулсан билээ.

Богд наадмын дагинаар сайхан Ремедиос уригджээ. Жич охиныхоо сэтгэл догдлуулам үзэсгэлэн гоог харахдаа сүрддэг Урсула тийнхүү дагина болгоно гэхэд саад хийж чадсангүй. Энэ үеийг хүртэл Сайхан Ремедиосыг зөвхөн Амарантатай л гадаа гаргадаг, сүмийн мөргөлд явахад нь хүртэл нүүрийг нь гивлүүрээр бүтээлгэж явуулдаг байлаа. Огт сүжиг бишрэлгүй мөртлөө ламын хувцас өмсчихөөд Катариногийн хүрээлэнд шүтээнийг доромжлон байхдаа сийхгүй хүмүүс ч хөндий даяар үлгэрийн дагина шиг хөөрхөн гэж бахархах, сүрдэх зэрэгцэн цуурхдаг Сайхан Ремедиосын царайг халти болтугай ч харах гэж сүмд очдог байлаа. Тэр сониуч хүмүүс түүний царайг хартал нэлээд хугацаа өнгөрсөн бөгөөд харсан олон хүн амар тайван унтаж чадахаа больдог тул уг нь хараагүй нь ч дээр байх байсан билээ. Тэдний аль эртнээс мөрөөдсөнийг гүйцэлдүүлж өгсөн явуулын нэгэн тайж өөрөө амар заяа үзэхээ байж, хүнээ алдан гуйлгачин болоод, хэдэн жилийн дараа төмөр зам дээр унтаж хоцроод

шөнийн галт тэргэнд дайруулан тас татуулж билээ. Түүнийг анх сүмд ногоон тансран косчоомтой, хатгамаллаж оёсон хантаазтай орж ирэхэд их холоос, магадгүй өөр орноос Сайхан Ремедиосын илбийн чадалд татагдан наашаа зорьж иржээ гэж цөмөөрөө ойлгожээ. Тэр залуу эр царайлаг бөгөөд гоолиг, биеэ авч явах байдал тавиан бөгөөд ёс төртэй нь, түүний хажууд Пьетро Креспи ч арван сараа гүйцээгээгүй санагдах бөгөөд олон эмэгтэйчүүд, гивлүүр зүүлгүүштэй хүн чинь л энэ байна даа гэж жөтөөрхөнгүй инээмсэглэн шивэр авир хийж байлаа. Макондод таньдаг хүнтүүнд байсангүй. Ням гаригийн үүрээр үлгэрийн хаан хүү шиг мөнгөн дөрөөтэй, хилэн тохоштой морь унан ирж, мөргөлийн дараа хотоос явчихдаг байлаа.

Түүнийг сүмд орж ирэнгүүт л хүмүүс ажиглаж, Сайхан Ремедиос тэр хоёрын хооронд хэн нь хэнийгээ вэ гэдгээ дуугүй үзэх ирүүл тулалдаан, хайрлан дурлах төдийгүй хагацан үхэж дуусах гайтай өрсөлдөөн эхэлжээ гэж цөмөөрөө боджээ. Зургаа дахь ням гаригт тайж шар сарнай барин орж ирээд аанай л зогсоогоороо хурал хурахыг сонсоод дуусангуут нь Сайхан Ремедиосыг тосон очиж, сарнайг барив. Бүсгүй ийм бэлэг өгөхийг хүлээж байсан мэт сурмаг гэгч нь аваад, агшин зуур гивлүүрээ сөхөн үл таних хүний өөдөөс инээмсэглэжээ. Бүсгүйн хийсэн юм гэвэл ердөө л энэ байлаа. Гэвч энэ нь залуугийн хувьд гай болж яг энэ үеэр түүний дэргэд байсан хүмүүсийн хувьд мартагдашгүй юм болжээ.

Түүнээс хойш тайж Ремедиосын цонхон дор найрал хөгжим авчран өглөө болтол тоглуулах нь цөөнгүй болов. Тэднийхний дотроос Бага Аурелиано тэр залууг цор ганцаараа өрөвдөж, тэгж зүтгэхийг нь болиулахыг оролдож “Хайран цагийн гарз даа. Энэ айлын хүүхнүүд илжигнээс ч зөрүүд гэж мэд!” хэмээн нэгшөнө хэлжээ. Тэгээд тэр үл таних залууд үерхье гэж гуйж, шампан дарсанд сэлэхийг уриалж, Буэндиагийнхны эмэгтэйчүүд чулуун зүрхтэй гэж хэлж ядаад дийлсэнгүй. Шөнө болгон хөгжим хангинаад байхад тэсэх аргагүй болсон хурандаа Аурелиано Буэндиа тайжийг гар буугаар гунигийг нь эмчилж өгнө гэж сүрдүүлжээ. Гэвч дурласан залууг хэн ч бодсоноос нь няцааж чадсангүй. Тэгээд хээнцэр сайхан залуу цөхрөлийн туйлд хүрээд хөөрхийлөлтэй ноорхой амьтан болжээ. Түүнийг хаанахын хэн гэдгийг хэн ч мэдээгүй боловч “Алс хол байдаг эх нутагтаа эрх ямбаасаа татгалзаад эд хөрөнгөө орхиод ирсэн юм гэнэ” гэсэн цуу гарчээ. Тэр хэрүүлч, архичин, зодооч амьтан болж, Катариногийн хүрээлэнд ямагт хоног төөрүүлдэг болжээ. Эмгэнэлт явдлынх нь хамгийн гачлантай нь гэвэл хаан хүү шиг нүдээ бүлтэртэл гоёчихоод сүмд анх ирэхэд нь ч түүнийг Сайхан Ремедиос тоогоогүй ажээ. Ремедиос зүгээр нэг аальгүйдэхдээ бус, тэр хүний ер бусын аашилсан нь зугаатай санагдсанаас шар сарнайг авч, өөрийнхөө царайг үзүүлэх гэсэндээ бус, түүний царайг сайн харж авах гэсэндээ гивлүүрээ ялихгүй сөхжээ.

Үнэнийг хэлэхэд Сайхан Ремедиос огт өөр ертөнцийн хүн байлаа. Тэр хорь хүрсэн боловч уншиж ч, бичиж ч, халбага сэрээ барьж ч чадахгүй, гэр

дотуураа чармаан нүцгэн явдаг, элдэв ёс төрийг уулаас үзэн яддаг байлаа. Харуулын дарга залуу офицерыг өөрт нь сэтгэлтэй болсноо хэлэхэд түүний хөнгөмсгийг гайхаад л өнгөрчээ. “Үгүй мөн тэнэг амьтан аа! Надаас болж үхэх гэж байна гэнэ. Би ямар түүнийг тэгээд аль гэсэн юм уу?” гэжээ. Офицерыг цонхон доор үнэхээр үхсэн байхад Сайхан Ремедиос хэлж байснаа баталж,

- Харахгүй юу. Усан тэнэг амьтан байсан байна гэжээ.

Ааддыг хардаг чадалтайдаа эд юмсын иуг чанарыг олж хараад өнгөний, гадна талыг орхидог гэж бодмоор байлаа. Үгүйдээ гэхэд хурандаа Аурелиано Буэндиа тэгж үзнэ. Сайхан Ремедиосыг бүгдээрээ ухаан дутуутай гэдэг байхад, Аурелиано Буэндиа л ухаан сэргэлэн гэдэг байлаа. “Түүнийг харахад хорин жил дайн болоогүй юм шиг” гэж тэр хэлэхдээ дуртай. Урсула ч бас тэнгэр тэднийд ийм ариухан охин заяасанд баярлавч, жич охиныхоо үзэсгэлэн гоод зовж, сайн юм биш, чөтгөр хорлох гэхдээ ийм болгож гэж бодож байлаа. Иймээс Урсула Сайхан Ремедиосыг амьтнаас хол байлгаж, эхийнхээ хэвлийд байхдаа муу юм халдахааргүй болсныг нь мэдэхгүй, хорвоогийн муу зуршлаас хамгаалах гэж хичээж байлаа. Урсула жич охиноо багт наадам гэж нэрлэдэг чөтгөрийн шөнийн худалдааны хөөрхөн хүүхнүүдийн дагина болгоно гэж санах ч дургүй байв. Гэвч бар болж тоглох гэсэн хүсэлдээ хөтлөгдсөн Бага Аурелиано, Антонио Исабелийг очиж, “Багт наадам ол буруу номтны баяр биш, католик шашны нандигнан сахисан ардын заншил” гэж Урсулад хэлж өгөөч гэж ятгажээ. Нээрээ ч ламын ярианд итгэсэн эмгэн хэчнээн дургүй байлаа ч гэсэн сайхан Ремедиост ттитэм өмсүүлэхийг зөвшөөрчээ.

Ремедиос Буэндиа баярын дагина болох нь гэсэн яриа хэдхэн цагийн дотор ойр орчимд тарж, бүсгүйн ер бусын гоо үзэсгэлэнтэй тухай огт дуулаагүй байсан хамгийн бөглүү газарт ч хүрч, Буэндиагийнхны нэрийг самууны бэлгэ тэмдэг гэж үздэг байсан хүмүүсийг түгшүүлжээ. Тэгж түгшсэн нь дэмий байжээ. Тэрүед хамгийн гэм хоргүй хэн байна вэ, нэрлэ гэвэл өвгөрч, цөхөрч гүйцсэн, ард түмний амьдралтай ямар ч холбоогүй болсон хурандаа Аурелиано Бэндиаг л нэрлэж болох байлаа. Буэндиа урландаа зожгорон сууж, гагцхүү алтан загасаа худалдаж л гадаад ертөнцтэй харилцдаг байлаа. Дайн зогсоох гэрээ байгуулсны дара агэрийг нь хамгаалж байсан цэргүүдийн нэг алтан загасыг нь хөндийн хот, сууринд авачиж хуладаад, тэндээс алтан зоос ачсан, шинэ сонин дуулсан буцаж ирдэг байлаа. Консервативчуудын зарсгийн газар либералуудаар дэмжүүлэн хуналийг өөрчилж, ерөнхийлөгч бүрийг засгийн эрхэнд зуун жил байхаар болгосон гэнэ, ариун хутагт хамбатай гэрээнд1 арайхийн гарын үсэг зурсан гэнэ, Ромоос хамба ламтан ирсэн нь өвч алмаас эрдэнэ босон титэмтэй, цул алтан сэнтийтэй байсан гэнэ, либерал сайд нар өмнө нь өвдөг сөхөрч, бөлзгийг нь үнсэж байгад узргаа авахуулсан гэнэ, бага зүүлсэн үл мэдэгдэх улс нийслэлд тоглож байсан

испанийн жүжигчийн хулгай хийж, маргааш өглөө нь улсынерөнхийлөчгийн зуны өргөөнд чармаа шалдан бүжиглөж байсан гэнэ

1 Аль нэг улсын засгийн газар, Витакн хоёрын байгуулдаг гэрээ. Үүнд төр, тухайн орон байгаа затолг шашин хоёрын харилцааг тодорхойлдог. Энд либералиуудын урвамтгайг харуулжээ.

Гэж дуулснаа ярьж өгдөг байлаа. “Надад улс төрийн бодлого бүү ярь. Загасаа л зарж байвал барав” гэж хурандаа хэлжээ. Хурандаа улс орны байр байдлын талаар огт сонсохыг хүсэхгүй, урлангийнхаа мухар сахиж, алтан загас гүйлгэж байна гэдгийг Урсула дуулахдаа инээжээ. Загасаа алтан зоосоор арилжаад, энэ зоосоороо дахин загас хийх зэргээр нэг хийснээ ингэж арван гурав дахин загас хийх зэргээр нэг хийснээингэж арвангурав дахихы нь ямар хэрэгтэйг хэчнээн хар ухаантай ч нэг л ойлгож өгөхгүй байлаа. Ийнхүү орчиж эргэхийг таслахгүйн тулд худалдааныхаа хэрээр их ажиллах хэрэгтэй. Үнэндээ гэхэд хурандаа Аурелиано Буэндиад худалдаа хийх нь бус, ажил хийх нь гол байжээ. Хайрсыг хоногт суулгаж, нүдний нь оронд бадмааргийн хэлтэрхий шигтгэж, заламгайг нь өнгөлж, сүүлийгнь тааруулахдаа ганц түүндээ улайраад дайтан тулж явснаа түүнээс болж гутарч гонсойж байснаа санах огтхон ч завгүй болдог байжээ. Онч, ур орох инжааны ажилд биеэ огоорон зүтгэснээс хурандаа Аурелиано Буэндиа дайны бүх жилд өтлөснөөсөө лүү энэхэн хугацаанд өтөлж, удаан сууснаас нуруу нь бөгтийж, чимхлүүр ажлаас нүд нь муудсан боловч сэтгэл санаа төвширчээ. Засгийн газар насан туршийн тэтгэвэр олгон гэж амласан боловч уг асуудал гагцхиаад байгаа учир либерал, консерватив нийлсэн хэсэг ахмад зүтгэлтэн туслахыг гуйж ирэхэд хурандаа “Наадхаа март аа. Олгохгүй юмыг олгох байхгэж насан туршаа тарчлахгүй гэсэндээ тэтгэвэр авахгүй гэснийг минь та нар мэдэж байгаа газар” гэжээ. Эхний үед хурандаа Геринельдо Маркес оройдоо түүн дээр ирж, хоёул байшингийн хаалганы гадаа сууж, хууч хөрөдөг байла. Гэвч Амаранта үс нь улам халзран, учиргүй овор суусан ядрангүй энэ хүнийг харахдаа элдэв юм бодон тэсэж байхын араггүй боло учир мөрөөрөө байтал нь тэгэхээс тэгэх гэж хямсалзаж хялбалзсаар, цаадах нь онцгой юм бобол л өдрийн од шигүзэгддэг болж, тэгсээр удалгүй саа тусаад огт ирэхээ больжээн. Олноос оорцог, олон таван үггүй, орон гэртээ шинэ амьсгал р орж багйааг хайхардаггүй хурандаа Аурелиано Бэндиа насны мухарт санаа амар байя гэвэл ганцаараа л байхаас сайхан юмгүй гэж ул улмаар ойлгожээ. Шөнө норй сэрвэлзэх учир түрхэн зуур духийснээ өглөөний тавагн цагт босож, гал зууханд



орж, аяга хар кофегоо аанай л уугаад, өдөржин урландаа түгжин ажиллаж, өдрийн дөрвөн цагт гаран, тагтан дотуур мухар сандал чирсээр цог мэт улайрах сарнайн бутыг ч, шингэх гэж байгаа нарны цацраг туяаг ч, үдшийн нам гүмд тогоонд ус пур пур буцлахыг сонсон байхад ямар уйтгартай байдаг вэ тийм арилшгүй гунигт автсан Амарантагийн ихэмсэг дүрийг ч огт анзаарахгүй явж өнгөрөөд, хаалганыхаа гадаа шумуул хөдөлтөл суудаг байлаа. Нэгэн удаа хажуугаар нь өнгөрч яваа хүн түүнд зориглон хандаж,

- хрундаа юу хийж байна даа? Гэж асуусанд,
- Австай хүүрийг минь хэзэ үүгээр авч гардаг бол гээд хүлээгээд сууж байна даа гэжээ.

Тийнхүү Сайхан Ремедиосыг баярт дагинаар оролцуулах гэж байгаагаас болж хурандаа Аурелиано Буэндиогийн нэрийн амнаас ховхлохгүй хэлцэх босонд зарим хүмүүс сэтгэл түгшсэн нь ямар ч ул үндэсгүй байлаа. гэвч олон хүн өөр бодолтой байв. Макондогийнхон айхавтар гай зовлон учрах гэж байна хэмээн санаанд оролгүй, хотын талбайд баяр баясгалан төгөлдөр дүүрчээ. Багт наадмын галзуу мэт хөгжил цэнгээ туйлдаа хүрч, бар болж тоглох гэсэн санаанда ахүр чшавай нь ханасан Бага Аурелиано хоолойгоо сөөтөл зогсоо жолоогүй архирсаар бужигнах бум, түжигнэх түмийн дунд явж байтал хөндийн замаар багт наадмын хувцастай баахан улс гарч иржээ. Тэнд саная гэвч санаанд багтмааргүй хөөрхөн хүүхнийг алтадсан жуузан дээр дамнан авч явлаа. Макондогийн амгалан иргэд маргад титэм, үен хэвнэгтэй нүд гялбам хүүхнийг сайн харж авах гэж түр багаа авчээ. Тэрбээр ёстой хатан хааны эрх дархтай дээд төрөлт болохоос гялтгануур, хочргор цаасаар гоёсон гаднаа гяланцаг амьтан биш санагдаж байаа. Олны дотор гярхай улс цөөнгүй байж үүнийг ялуувга гэж сэжиглэж байсан боловч Бага Аурелиано тийнхүү үймэхийг дор нь зогсоож, шинээр ирсэн улсыг хүнндэт зочид хэмээн карлаж, Соломон хаан шиг мэргэн шийд гаргаж, СайханРемедиос нар зээлдсэн дагина хоёрыг нэгэн суудалд суулгаваай. Бядан явагчийн<sup>1</sup> хувцастай

<sup>1</sup> Бядан явагч -Аравийн хойгиийн нүүдэлчин, хагас нүүдэлчид. “Бедиун” гэсэн араб үг манай хэлэнд орж ирэхдээ бядан болж сунжран гадаад үг гэдэг нь мэдэгдэхгүй болжээ. Манайхан гадаад үгийг орчуулахгүй авах болбол чухамхүү ингэж авиан зүйдээ тохируулан авлах ёстой гэдэг нь харагдаж байна. – Орч. Цастай тэр улс шөнө дөл болтол нийтийн баяр хөөрт оролцоод, тэр ч байтугай гайхалтай, сайхан цаасан буу тавьж, гарамгай гоё уран дасгал үзүүлэн, баяр ёслолд нэмэр хандив өргөсөн учир цыганы аль эрт мартагдсан урлагийг цөмөөр санахад хүрчээ. Гэвч хөгжилдөөний ид үед бүх юм балрав.

- Либерал нам мандтугай! Хурандаа Аурелиано Буэндиа мандтугай! Гэ жнэг нь хашгирав.

Бууны амнаас гал манас манасхийн цаасан бууны гал бүдгэрч, айн хашгирах чимээнд хөгжмийн ая дарагдаж, баяр хөөр маань үймээн сандраан болоод явчихнлаа. Олоон жиийн хойно нэр зээлдэгч дагины бараа бологчид нь үнэндээ жинхэнэ цэргийн суман байж, бядан явагчийнхаа цагаан нөмрөгийн дотор байлдааны буу нуусан байсан гэж ард олон ярилцаж байлаа. Засгийн газар ингэж ярилцаж багааг онц хуулиар няцааж, цус урсгасан энэ явдлын учрыг олно гэж амлажээ. Гэвч үнэн учрыг хэн ч олсонгүй. “Дагины бара бологчид ямар ч хэрэггүй байхад даргынхаа тушаалаар байлдааны байдлаар жагсаж, бөөгнөрсөн олныг хайр найргүй бууджээ” гэсэн цуу дийлжээ. Хотод нам тайван байхал тогтож, хуурамч бядан явагч нэг ч байхгүй болоход талбай дээр таван алиа салбадай, дөрвөн ховжилмаа, арван зургаан хөзрийн ноён, угрван хөгжимчин, францын хоёр пэр,<sup>1</sup> японы гурван хатан хаан гэсэн алагдаж, шархтсан хүмүүс үлдсэн байлаа. Улс амьтны мэгдэн сандарч, үймэн бужигнаж байх хооронд Бага Хосе Аркадио Ремедиосыг аюулгүй газар нууж, Бага Аурелиано палааж нь урагдаж, үен нөмрөг нь цус нөж болчихсон нэр зээлдэгч дагиныг тэвэрсээр гэртээ авчирч билээ. Түүнийг Фернанда дель Карпиа гэдэг ажээ. Тус орны таван мянган хамгийн сайхан хүүхнүүдийн дотроос хамгийн гоо сайхан гэж сонгон авч, Мадагаскарын хатан хаан болгоно гэж амлан Макондод авчирсан юм санжээ. Урсула түүнийг төрсөн охин шигээ асрав. Хотынхон бүсгүйг бруушаахын оронд түний гэнэхнийг өрөвдөх болжээ. Талбай дээр амьтныг хядсанаа схойш хагас жилийн дара шархтнууд эдгэрч, ах дүүсийн булшин дээрх сүүлийн цэцэг гандахад Бага Аурелиано Фернанда дель Карпиогийн эцэгтэйгээ суудаг

1 Франц, Английн дээд язгууртны цол, 2 Орч,

холын хотод очиж түүнийг Макондод авчраад чилийсэн хорин өдөр нижгэр хурим хийжээ.

\*\*\* \*\*

Хоёр сар болов уу үгүй юу хоёр залуу эгээ л салж сарнисангүй. Учир нь бага Аурелиано Петра Котест тал засаж, Мадагаскарын хатан хааны гоёлын хувцастай зургийг нь авчээ. Үүнийг Фернанда мэдэнгүүтээ хамаг инжээ авдрандаа хийж аваад хэнитэй ч салах ёс хийлгүйгээр Макондогоос яваад өгчээ. Бага Аурелиано эхнэрээ хөндийн замд гүйцэж очоод ёстой далан таваар бууж өгөн, “Дахиад тэгэхгүй” гэж удтал гуйж гувшиж баймааж нь буцааж авчраад, нууц амрагаасаа дахин хөндийрөв.

өөрийнхөө хүчтэйд итгэсэн Петра Котес ер санаа зовсонгүй. Петра Котесийн хүчинд л тэр эр хүн болсонгүй, элдэв бүтэх бүтэхгүй юм мөрөөдсөн балчир амьтан байхад нь Мелькиадесийн өрөөнөөс гаргаж, энэ ертөнцөд байрыг нь олгож өгсөн хүн хэн бэ гэвэл Петар Котес. Төр төлөхийн битүүлэг, зожиг, тэрүүхэндээ юм санаашраад суучихдаг байснаа огт өөр сэргэлэн, нийцтэй, цагаан цайлган зантай, амьдралын баяр баясгаалнтай, наргиж цэнгэх дуртай, юманд гар татдаггүй болсон нь аль ч талаараа Петра Котесийн багаасаа мөрөөддөг байсан тийм эр хүний байдалтай болсон нь Петра Котесийн л ач. Тэгтэл хархүү нь гэрлэлээ. Бүсгүй хүүхэд болгон эрт орой нэгэн цагт гэрлдэг газар. Бага Аурелиано гэрлэх гэж байгаага түүнд хэлэхээс зүрх алдсаар уджээ. Тэгэхдээ бүр хүүхэд шиг аашилж, Петра Котесийг өөрөө хөндийрэх байх гэж горилон зүв зүгээр байхад нь өө хайж, өөнтөглөн гоморхох болов. Нэг удаа Бага Аурелиано амраг бүсгүйгээ оргүй юмаар өөлж байтал цаадах нь урхинд нь орсонгүй.

- Чи өнөө дагинатай суух гээд л ингээд байна гэж амыг нь таглачихжээ.

Бага Аурелиано ичихдээ уурласан дүрэм үзүүлж, өөрийөгө хүнд ойлгогдохгүй үйлтэй толгой, ингэж доромжлуулж байхада таарсан амьтан гэж гомдоллоод нууц амрагийндаа очихыг больжээ. Петра Котес огтхон ч сандарч сүдй майд болсонгүй, амар ч байгаа араатан аятай тайван байж, хөгжмийн аялгуу, бүрээний дуу, нижгэр хуримын чимээ шуугианыг чагнахдаа тэр бүхнийг Бага Аурелианогийн аанай л нэг дүрсгүйтэж байгаагийн дайтай бодож, шал тоохгүй байжээ. Өөрийг нь өрөвдөж, үг хэлсэн хүний өөдөөс их л амгалан инээмсэглэж, “Санаабүү зов оо. Миний өмнө дагинас ч шонгүй” гэж хэлдэг байв. Хаяад явчихсан амрагийнхаа өмнө шившсэн зул асаа гэж хөрш эмэгтэйнхээ хэлэхэд,

- Түүнийг эргүлж авчрах цорын ганц зул нь бөхөөгүй мандаж байн агэж итгэлтэй бөгөөд учиртайхан хэлжээ.

Яг түүнийг бодож байсанчилан, Бага Аурелиано бал сар өнгөрөнгүүт тэднийд Иржээ. Тэрбээр салдагүй хэдэн найзаа хэрмэл гэрэл зурагчинтай дагуулан ирж Фернандагийн багт наадамд ирэхдээ гоёж ирсэн палааж, цус болосн үен нөмрөгийг авчирчээ. Хөгжилдан найрлаж байхаад Бага Аурелиано, Петра Котесийг дагина болгон хувцаслаж, “Мадагаскарын цорын ганц насан туршийн эзэгтэй” гэж зарлаж, зургийг н авахуулан найз нартаа өгчээ. Петра Котес энэ наадамд дуртай оролцсоноор барахгүй өөртэй нь эвлэрэх ийм арга обдож олсноос үзэхэд их л ядарч дээ гэж дотроо өрөвдөж билээ. Оройн долоон цагт Петра Котес дагиныхаа хувцастай бүхлээрээ Бага Аурелианог өвртөө оруулав. Бага Аурелиано гэрлээд хоёр сар ч болоогүй байсан боовч энгэр зөрүүлэх ажил нь тийм сайн бус байгааг Петра Котес дорхноо мэдээд өшөөгөө авч чадсандаа ганц бах нь ханаж байлаа. Гэвч үүнээс хойш хоёр хонож байтал

Бага Аурелиано, биеэр ирж зүрхэлсэнгүй бололтой хүн явуулж, хоёр тийшээ болох талаар тохиролцъё гэж хэлүүлсэнд Петра Котес амрагийнхаа гаднаа ёсыг баримталж, өөрийгөө гаргуунд гаргах гэж байгааг мэдэж, санаснаас удаан хүлээх хэрэггарах нь гэж ойлгожээ. Ингэлээ гээд Петра Котес сэтгэлээр унасангүй. Бага Аурелианогийн хүссэнийг хүлцэнгүй дагасанд цөмөөрөө түүнийг өрөвдэлтэй хөөрхий бүсгүй гэж боддог нь батажжээ. Хайртай хүнээс нь үлдсэн юм гэвэл хос чийдмэл шаахай л байлаа. Түүнийг үхэхдээ өмсөж үхнэ гэж Бага Аурелиано хэлдэг байжээ. Петра Котес шаахайг даавуунд өрөөн, авдрандаа хийгээд цөхрөлгүй хүлээхээр сэтгэл шулуудаж,

- Нэг цагт ирэхдээ л ирнэ, үгүй дээ гэхэд энэ шаахайгаа өмсөх гэж ирнэ хэмээн боджээ.

Их л удаан хүлэх байх гэж бодсон нь харин тэгсэнгүй. Үнэнийг хэлэхэд, Бага Аурелиано чийдмэл шаахайгаа өмсөх хэрэг гарахаас хавьгүй өмнө Петра Котест эргэж очих нь гэдгээ хуримынхаа шөнө мэджээ. Учир нь Фернанда ёстой эрэгнээс гарсан юм шиг хүн байлаа. Тэрбээр далайгаас мянган километрийн тэртээ орших баргар хотод төрж өссөн ажээ. Хий юмны гүйдэлтэй шөнө хаадын сүнсийг тээн аваачих сүйхийн дугуй тэр хотын чулуун гудамжаар түрчигнэн одох нь сонсогддог байлаа. Орой бүрийн зургаан цагт хотын гучин хоёр хонхноос бэлэвсэрлийн уйтгарт аялгуу дуурьсана. Колоничлолын ед барьсан, булшны хавтангаар өнгөлсөн хуучны байшинд хэзээ ч нар үл орно. Хашаан дахь майлсны орой, цэцэрлэг дэх чийг даасан тубероз цэцгийн гудам, унтлагын өрөөний онгож гандсан хөшгийг харахд хүүийн газар л ийм нам гүм байдаг гэж санагдана. Фернанда том оо болтлоо хажуугийнхаа байшинд гарах төгөлдөр хуурын гунигт эгшгээс өөр юм огт сонсоогүй ажээ. Тэнд нэгэн хүн жил тутам, өдөр тутам сайн дураараа үдийнхээ амралтыг алдан алдан хөгжимддөг байлаа. Цонхны барамнас бужигнах гэрэлд царай нь шар ногоон туяатай харагдах өвчтэй эхийнхээ хажууд сууж, нэгэн хэвээр зогсолтгүй дуугарах уйтгарт аялгууг чагнаж, өөрийг нь энд бэлэвсэрлийн цэцэг сүлжин махаа идэж бахиадэнэ хөгжим тэртээ тэнд, холын хол газарт дуугарч байх юм даа гэж бодож суудаг байлаа. Өвчнөө дахин хөдлөхөд хар хөлс нь дааварласан эх нь удам угсааныхныгаа урьдын цагт цалгиж явсныг ярьж өгдөг байлаа. Фернанда бүүр жаахандаа нэгэн саруулхан шөнө өвч цагаан хувцастай сайхан хүүхнийг цэцэрлэг дотуур нь гарч бунхан руу очихыг харжээ. Сайхь хий юм өөртэй нь үйлийн үргүй адилхан мэт санагдаж, хорин жилийн хойно өөрөө ингэж яваа мэт бодогдон сэтгэл нь хачин догдолжээ. “Чиний элэнц эх, хатан хаан байхгүй юу. Цэцэрлэгт губерроз цэцэг огтолж байгаад үнэрт нь хордоод өөд болчихсон юм” гэж эх нь бүгшүүлэн ханиалгахын чөлөөнд хэлжээ. Олон жилийн хойно Фернанда өөрийгөө элэнц эхтэйгээ адилхан гэж бодох болж нээрээ багад нь элэнц эх нь үзэгдсэн юм болов уу гэж эргэлзвэл ээж нь охиноо, яагаад итгэхгүй байгаа юм” гэж загнан

- Манай эд хөрөнгө барагдашгүй, хүч чадал шавхагдашгүй. Чи хатан хаан болохдоо л болно гэж хэлжээ.

Тэднийд мөнгөн хэрэгсэл тавьсан, нимгэн бүтээлгээр бүтээсэн урт ширээндээр голдуу ганц жигнэмэг, аяга устай хольсон шоколад тавьж өгдөг байсан боловч эхийнхээ үгэнд итгэжээ. Түүний эцэг дон Фернанда өөрт нь инж худалдан авч өгөх гэж байшингаа барьцаанд өгөхөд хүрч байсан хэдий боловч бүсгүй хуримаа хүртэл домогт хаант улсыг мөрөөдсөөр байжээ. Гэнэндээ ч ингэж санааширсангүй, өөрийгөө томд обдсондоо ч тэгж мөрөөдсөнгүй. Бүсгүйг ердөө л тэгж хүмүүжүүлсэн байжээ. Фернанда ухаа орсон цагаасаа л мэдхийнх овгийн сүлдтэй алтан хөтөвчинд мөр үздэг байжээ. Арван хоёртой болохдоо сүмийн сургуульд орохоор гэрийнхээ босгыг алхан гарч, нумт хөнгөн тэргэнд суусан атал хүрэх газар нь хоёрхон хорооллын цаана байжээ. Шинэ хүүхэд өөрсдөөс нь хөндий, өндөр түшлэгтэй сандал дээр сууж, завсарлагаанаар ч нийлэхгүй байсанд ангийн нь охид гайхаж байтал гэлэнмаа нар 3нэ таануустай адилгүй. Хатан хаан болох хүнб аайгаа юм” гэж учрыгтайлж өгчээ. Тэгэхэд Фернанда тэдний насандаа харсан хамгийн хөөрхөн, хамгийн төвшин даруухан бүсгүй байсан учир найз нар нь түүнд үнэмшжээ. Найман жил өнгөрөхөд латынаар шүлэг бичиж, даруулт хуураар тоглож, харцуултай шонхроор авхийх тухай, тэргүүн хамбатай нотлохуйн ухааны 1 тайх ярьж, гадаадын эрх баригчидтай төрийн хэрэг пап ламтай, шашны хэргийг ярьж сураад төрсөн гэртээ эргэн ирж, бэлэвсрэлийн цэцэг сүлжих ажилдаа дахин оржээ. Ирэхэд нь гэр нь ханхай хоосон болчихсон байлаа. Сургуулийн мөнгө төлөх хэтэгтэй байсан болохоор хамаг юмаа цувуулж худалдаад хамгийн хэрэгтэй тавилга цэцэглэг дэн, хоол цайны мөнгөн хэрэгслийг л авч үлджээ. Халуун хумхаа нь даамжирсаар эх нь үхжээ. Өвч хар хувцас өмсөж, бариу црдмалзахтай цамц өмсөж, цагийнхаа алтан оосрыг цээжээрээ хөндлөн уясан эцэг нь даваа гариг бүрд хоол унд авах мөнгөн

- 1 Нотлохуй ухаан буюу аполгетика нь христосын шашны төгөлдөр бөгөөд үнэнийг нотлох зорилгоор шашны судлал. – Орч.

Зоос охиндоо өгөөд долоо хоногт сүлжсэн бэлэвсрэлийн цэцгийг нь авч одно. Өдрийн ихэнхэд өрөөндөө түгжин сууж, хааяа нэг гадагш гарахдаа заавал зургаан цагаас өмнө эргэн ирж охинтойгоо хамт мөргөл хийнэ. Фернанда хэнтэй ч үерхэж байсангүй. Улс орон нь дайн дажны хөлд сүйдэж байна гэж хэзээ ч ер сонссонгүй.

Төгөлдөр хуурын өдөр бүрийн дасгалыг сонсохоо хэзээ ч алгасаж байсангүй. Хатан хаан болох горь тасарч эхэлж байтал гол халаганы түншүүрийг яаруухан хоёр цохих нь гэнэт дуулджээ. Фернанда халага нээж өгвөл бөхөлзөж дохилсон, хацар дээрээ сорвитой, энгэр дээрээ алтан одонтой, сүртэй цэргийн хүн ор жирэд, эцэгтэй нь өрөөнд нь түгжээд суучихав. Хоёр цаг болоод эцэг нь өрөөнд орж ирээд ”Юмаа зэх. Ч хол юманд явах боллоо гэжээ. Тийнхүү фернандаг Макондод авчирчээ. Энд амьдралын хүнд лантуу бүхий л жингээрээ ганцхан буухдаа эцэг эхийнх нь их л овжноор өөрөөс нь нууж байсан бодит үнэнийг хайр найргүй илчилжээ. Гэртээ буцаж ирээд, хаалгаа түгжиж аван, хачин муухай доромжлуулсандаа багтарч, сэтгэлд нь суусан сэвийг арилгах санаатай дон Фернандогийн гуйж гувшиж, учирлан үглэхийг ч хайхрахгүй удтал уйлж билээ. Тэгээд үхэн үхтлээ унтлагынхаа өрөөнөс цухуйхгүй гэж сэтгэл шулуудаад байтал хойноос нь Бага Аурелиано иржээ. Бөөдий болсондоо ондууцан хилгэсэн Фернанда хэн болохоо мэдүүлэхгүй гэж худал хэлсэн болохоор түүний ирсэн нь сэтгэлд багтамгүй аз байлаа. Бага Аурелиано үл таних бүсгүйн эрэлд омрдохдоо уулынхны аялгаар ярьдгар, оршуулгын цэцэг сүлждэг гэсэн гарцаагүй батай хоёр тмдгийг мэдэж байжээ. Тэрбээр эцэж алжахыг тоохгүй эржээ. Тэгэхдээ Хосе Аркадио Буэндиагийн Макондог уайгуулах гэж уул давсаншиг эрэмгий зоригтой хурандаа Аурелиано Буэндиагийн явуургүй дайн хийсэн шиг бардам омогтой, Урсулагийн гал голомтныхоо төлөө зүтгэсэн шиг нөр хичээнгүй эржээ. Хаана оршуулгын цэцэг сүлждэгийг сураглахад “Аль сайныг нь ав” гээд айл айл руу дагуулж явдаг байлаа. Орчлонд төрсөн хамгийн хөөрхөн хүүхэн хаа суудгийг асуухад эх бологон өрийнхөө охин руу түүнийг авч очдог байлаа. Будангуйн мананд будилж, мартхуйн орноор мунгинаж\_ цөхрөнгүйн далайд умбаж явлаа. Бодсон юм цурай болон дуурсаг, уйтгарлаж гуньхарахад хий үзэгддэг шар цөлийг гаталжээ. Олон хоног үзүүргүй эрэлд хатсаны эцэст үл мэдэх нэгэн хотод ирвэл гучин хоёр хонх нь гашуудал зарлах мэт уйтгартай жингэнэх ажээ. Энэ хотыг ч, эдгээр хонхыг ч, умрын шорвог салхинд идэгдсэн туургыг нь ч, өмхөрч харласан модон тагтыг нь ч, бороон ьусанд угаагдан арилах шахсан “Бэлэвсрэлийн цэцэг худалдан” гэсэн бичээстэй энэ хорвоогийн хамгийн уйтгартай хаягийг нь ч огт үзэж хараагүй, ер сонсож дуулаагүй боловч яг мөн байна гэж дор нь таньжээ. Энэ агшнаас Фернанда ширээт эхээрээ хамгаалуулан төрсөн гэрээ бүрмөсөн орхисон тэр хүйтэн өглөө хүртэл тун бага хугацаа өнгөрч, гэлэнмаа нар инжийн хувцсыг нь ам мөлтөс оёж, цэцэглэг дэн, мөнгөн хэрэгсэл, алтан хөтөвч, хоёр зуун жил гэр бүлийнх нь сүйрч ирэхэд хуримталсан гадаа хэвтэхэд гарар эргүүлэмгүй баахан хог новшийг арахийн авдарлаж амжжээ. Дон Фернандо охиноо хүргэж өгөхөөс татгалзаж, өр ширээ дарчихаад хожим очно гэж амлан, охиноо адислаад, дахин өрөөндөө орон түгжиж, тэндээсээ гашуудлын тэмдэг, овгийн сүлдтэй товчхон захидал охиндоо явуулах болж энэ захидал нь эцэг охин хоёрыг оюуны хувьд анх холбож өгчээ.

Фернандагийн хувьд тэндээс мордсон өдөр нь жинхэнэ ёсоор төрсөн өдөр болсон байхад Бага Аурелианогийн хувьд аз жаргалыг бараг олоод эргүүлэн алдсан өдөр боллоо.

Фернанда шармал цэцгэн хээтэй гоё хуанли авч ирсэн бөгөөд үүнд номын багш нь хурьцлыг тэвчих өдрийг улаан бэхээр тэмдэглэж өгсөн байжээ. Зовлонг тэвчих долоо хоног,<sup>1</sup> хориотой ням гариг, сар бүрийн эхний баасан гариг, мөргөлийн өдөр, мацаг болон цээр өдөр түүнчлэн бие эвгүйрхэх үед хурьцах хориотой гэх зэргээр хуанлийн өдрүүдийг улан тоонолж тэмдгээр ярайтал дарсны дотор хориогүй дөчин хоёрхон өдөр байгааг нь олж үзэхэд бэрхтэй байжээ. цваандаа энэ хорио цээр байхгүй болно гэдэгт эргэлзэхгүй байсан Бага Аурелиано хуримыг тогтоосон цагаас нь сунжруулав. Шампан дарс, бренди шарзны суларсан лонх замаа алдаж байшинд багтахгаа байх тул үргэлж хогчинд явуулах болсондоо залхсан, үүний зэрэгцээгээр

1 Евангелийн домог ёсоор Христосын цовдлуулж зовж байсан долоо хоног Улаан өндөгний баярын өмнөх долоо хоног. –Орч.

Ханилж байгаа хоёр тусдаа сөөлжин унтаж байхад дуу хөгжим тасрахгүй, мал нядлах зогсохгүй байгаад сониучирхсан Урсула өөрийнхөө хуучин явдлыг санахдаа Фернандагаас “Хамгаалах өмд өмсөн юм биш биз?” Гэж асуугаад “Тэгвэл хэзээ нэгэн цагт хотынхны доог болж, муу юм болж магадгүй!” хэмээн сануулжээ. Гэвч Фернанда хуримнаас хой хоёр долоо хоног өнгөрөхийг зүгээр л хүлээж байн, тэр цаг болоход нөхөртэйгөө хавьтана гэж хэлжээ. Цээрийн хугацаа дуусахад Фернанда ннэхээр нүглээ наманчлахын үүднээс онгон биеэ эвдүүлэхээр бэлдэж, унтлагынхаа өрөөний хаалтыг нээсэнд Бага Аурелиано орвол энэ дэлхийд хосгүй хөөрхөн хүүхэн хэвтэж, нүд нь үргэсэн согооных шиг бөлтөлзөж, дэрэн дээр бутран байх урт үс нь элгэн хүрэн өнгөөр гялтганан байлаа. Фернандаг урт ханцуй, газар шүүрсэн урт хормойтой цагаан цамц өмссөний хэвлийн тус газар том гэгчийн цоорхой чадмагай имхэрдэн гаргасныг тэр даруйдаа анзаарсангүй болно. Тэгээд харахдаа инээдээ барьж чадалгүй

- Насандаа би олон юм үзсэн дээ, энүүн шиг тусгүй юм үзсэнгүй. Би чинь гэлэнмаатай суучихсан юм байна шүү дээ гэж дуун алджээ.

Сар болоход эхнэрээрээ цагаан цамцыг нь айлуулж чадалгүй, Петра Котесийн зургийг хатан хааны хувцастай авах гэж очсон нь тэр юм санжээ. Хожим нь Фернанда гуйлгаж баймааж нь буцаж ирээд, эвлэрэн сэтгэл хөөрсөндөө цамцаа тайлж нөхрийнхөө сэтгэлийг амраасан боловч гучин хоёр хонхтой хот руу өөрийг нь эрж очихдоо түүний мөрөөдөж байсан шиг сэтгэлийг

нь амарлиулж чадсангүй билээ. Бага Аурелиано түүнтэй сууснаар гагцхүү урам хугарахын зовлон хурааснаас цаашгүй. Ууган хүүгээ төрөхийн өмнөхөн нэг шөнө Фернанда нөхрөө өөрөөс нь урван, Петра Котес руу сэм яваад байх болсныг мэджээ.

- Тиймээ, үнэн. Малаа өсгөх гэсэндээ тэгсэн юм гэж тэр биеэ гаргуунд нь хаячихсан хүний байдалтай дуугарчээ.

Фернанда нөхрийнхөө хачин тайлбарт итгэглээ нэлээд удсан боловч тийм гэдгийг хаашаа ч гарахгүй нотлоод өгөхийн цагт түүнээс явдаг хүүхнийхээ өвөрт үзэхгүй гэсэн ам л авч. Ийнхүү сургуул хэн хэндээ саад болохгүй аж төрөх боллоо. Аурелиано хоёр хүүхэндээ уриалагхан, найрсаг, Петра Котес дийлж гарсандаа бах нь ханаж байхад фернанда тэдний явдлыг мэдээгүй царай гаргадаг байлаа.

Фернанда нөхөртэйгөө учраа ололцсон боловч, бусад Буэндиа нартай хэл амаа ололцож дөнгөсөнгүй. Шөнө нь эр эмийн ажил хийсэн бол өглөө нь заавал өмсдөг хар ноосон дээлийг хаяулах гэж Урсула гуйгаад цөхчихжээ. Энэ дээлийг өмсөхөд айлынхан нь шивэр авир хийгээд байдаг облсон байлаа. Бас урсула Фщернандаг угаагуурт гүүр гараа угаадаг, жорлонд бие засдаг болгож барсангүй, алтан хөтөвчө загас хилигэхээр хурандаа Аурелианод зарчих гэж ятгаад дийлсэнгүй. Амаранта Фернандагийн үг хазгай дууддаг, юмыг цээрлэн нэрлэдэгт нь тэсгэлгүй эгдүүцэн, түүнтэй дан ойлгомжгүй үгээр ярьдаг байв.

- Онфа изфи техте ктофо вофорофититфи носфо отфос овфоственнофогофо дерьфемафа гэж Амаранта гэнэт гэнэт хэлчихндэг байлаа.

Нэг удаа Фернанда илт тохуурхаж байгаад нь уурлаж юу гээч юу яриад байгааг нь асуусанд Амарант цээрлэж хуарлах юмгүй,

- Чамайг бөгс, их мацаг хоёрыг ялгадаггүй амьтан гэж байна гэжээ.

Түүнээс хойш тэр хоёр дуугарахыг больжээ. Тун их хэрэг гарвал зурвас бичилцэх ч юм уу хүнээр дамжуулж ярилцдаг болов. Фернанда нөхрийнхөө гэрийнхэнд илэрхий нүд үзүүрлэгдэж байсан хэдий боловч өвөг дээдсийнхээ сайхан ёсонд Буэндиагийнхныг заншлуулах гээд зүтгэсээр байлаа. Хэн дуртай нь хүссэн цагтаа гал зууханд хоол унд и идэж уудгийг болиулж, хооллох өрөөнөө цав цагаан бүтээлгээр бүтээж, цэцэглэг дэн мөнгөн хэрэгсэл тавьсан том ширээнд хатуу тогтоосон цагтб үгдийг суулгадаг боов. Хоол идэхийг Урсула өдөр тутмын амьдралын хамгийн төвөггүй ажлын нэг гэж боддог байтал түүнийг нь баяр ёслолын дэг үүсэж, олон таванг үггүй Бага Хосе Аркадио хүртэл дургүйлхжээ. Гэсэн хэдий боловч тэр шинэ дэг нь оройн хоолны өмнө уншлага унших шинэ журмын адил дийлж, энэ нь хөршнийнх нь анхаарлыг татаж, удалгүй Бэндиагийнхан бусад усан нүдэт, цусан зүрхтний адил хооллодоггүй, хоол идэхдээ хурал хурж байдаг болсон гэнэ гэсэн цуу



гарчээ. Уулаас эцэг эхийнхээ сүсэг бишрэлийг авсан Фернанда яс тогтоосон жаягийг юм облгонд хатуу барих гэх тул уламжлалыг баримталдагтаа бус сэтгэлээ гэнт хөөрөхөд л сүжигтэй болдог Урсулатай хүртэл зөрчилдөхөд хүрч байлаа. Усрулаг мэдрэхүйн таван эрхтэнтэйгээ байхад түүний тогтоосон хуучин ёс заншлыг гэрт бас ч гэж баримталж, юмыг зоригтой зоригтой шийдэхэд гэрийнхэн нь үгнээс нь гардаггүй байсан боловч юм харахаа больж, насанд дарагдаад, ажил төрөлдөр оролцохоо болиод ирэхийн цагт Фернандагийн тогтоосон журам чангарч, ганцаараа л тэднийхний хувь заяаг шийдэж байдаг болжээ. Фернанда нарийн боов, мөсөн чихэр хийхийг зохсигүй ажил гэж үзэж, түүнийг дор нь болиулав. Урьд нь үүр цүүрээс аваад үдэш орой болтол дэлгээстэй байдаг хаалгыг эхлээд наранд унтлагын өрөө халаад байна гэдгээр шалтгалан үдийн амралтын үеэр хааж, сүүлд нь бүр ойнгойлгохыг болив. Макондог байгуулсанаас хойш тотгон дээр өлгөөстэй байсан арц, тариа хоёрыг авч хаяад оронд нь Христын зүрхтэй ховд хийжээ. Хурандаа Аурелиано Буэндиа ингэж шинэчилж байгааг ажиглаад яах гэж ингэж байгааг нь ойлгожээ. “Бид чинь язгууртан болж байна. Энэ янзаарб ол бид дахин консервативчуудын эсрэг дайн хийж, тэгэхдээ зөвхөн тэдний оронд хааныг ширээнд залах гэж л тулалдах болох нь” гэж эсэргүүцжээ. Фернанда түүнтэй хавиргалдалгүй эвтэйхэн бултаад байв. Цаанаа бол хурандаагийн дураараа байдагт, тогтоож байгаа хатууу журмг нь дагахгүй байгаад тун дургүй байлаа. Өглөөний таван цагт аяга кофе уудаг, урландаа новшиххуу байдаг, цоортол өмссөн цуваа тайлдаггүй, үдэш гэрийн гадаа сууж заншсан зэрэгт нь ондууцна. Гэвч Фернанда энэ гэрийн ганхаж хоцорсон энэ баганатай эвлэрэхээс өөр араггүй байсан бөгөөд учир нь хурандаа бол насанд дарагадж, урам, хугараад номхорсон зэрлэг араатан, “Өтөлснөөс биш үхсэн биш” гээд нэг догширвол сүйд хийж мэдэх амьтан гэж мэдэж байлаа. Нөхрийгөө ууган хүүдээ элэнц эцгийнхээ нэрийг өгнө гэхэд тэднийд ирээд дөнгөж ж жил болж байсандаа баригдаад зөрж зүрхлээгүй билээ. Анхны охиноо төрөхөд Фернанда эхийнхээ нэрээр “Рената” гэнэ” гэж шууд зүтгэв. Урсула нярай охинд Ремедиосын нэрийг өгнө гэж дайрав. Баг Аурелиано дунд нь эвийг нь олох гэж гүйж, цаад хоёр нь ширүүн маргасны эцэст охиныг Рената гэж нэрлэхээр болсон боловч, эцгийнх нь төрөл садан, хотынхон Ремедиос гэдэг нэрийг товчлон Меме гэж дуудах болжээ.

Шинэхэндээ Фернанда эцэг эхээ дурсдаггүй байсан боловч хуурчаад ирэхдээ эцгийгээ хосгүй хүн болгон дүрслэх болов. Хоолны үед эцгийгээ орчлонгийн явдлыг огоорсон, аажмаар ариун хутаг болж байга аонгцой хүн болгон ярина. Хадам эцгийг нь ийнхүү хэрээс хэтэртэл магтан мандулж байгаад гайхсандаа Аурелиано тэсэж чадалгүй даажигнасан үг эхнэрийнхээ хойгуур тарааж бусад нь түүнийг өлгөж авна. Гэрийнхнийгээ эвсэг байлгах гэж махардаг, тэдний эв түнжин муутай байгаад Далудур шаналж явдаг Урсула хүртэл бяцхан ачийгаа”Гэгээн хутагтын зээ, хатан хаан, малын хулгайч хоёр хүү учир папын

сэнтийд сууна” гэж нэг удаа хэлж орхижээ. Сэм нийлэгчид хэчнээн элэг доог хийвч Бага Аурелианогийн хүүхдүүд нагац аавыгаа тэнгэрийг бишрэн шүлэглэсэн захидал, Христосын мэндэлсэн өдрөөр хаалгаар арайхийн багтаж ордог том хайрцагтай бэлэг явуулдаг дмогт хүн гэж бодож заншжээ. Дон Фернандо овгийн эдлэнгээсээ үлдсэнийг ач нартаа явуулдагб айлаа. Түүгээр нь хүүхдийн өрөөнд босоо хүний дайтай богдсын дүртэй шүтээн бүтээж тэдгээр богдост шилэн нүд хийсэн нь амьд юм шиг сүрдмээр болж чадамгай оёсон цэмбэн баригтан өмсгөсөн но Макондогийнхны өмсөж байсан хувцсаас хамгийн сайн нь байлаа. Эзэд ноёдын эртний баргар лавирангийн оршуулгын сүрлэг зүйс буэндиагийн гэрэлт байшинд бага багар нь шилжлээ. “Гэр бүлийн оршуулгын газрын юмыг бидэнд тэр аяар нь явуулжээ. Унжгар уд1 бунхны хавтан хоёр л дутаж бах шив” гэж Бага Аурелиано нэг удаа хэлжээ. Хайрцагт тоглочихмоор юм ер байдаггүй боловч хүүхдүүд ахван хоёрудгаар сар гарахыг бүтэн жил тэсэж ядан хүлээдэг, учир нь хуучны, санаанд оромгүй эдлэл гар чирэхэднэгэн хэвийн амьдрал нь өөрб олох шиг болдог байжээ. Бяцхан Хосе Аркадиоог төрснөө хойш Христосын мэндэлсэн

1 Унжгар удыг гашуудлын бэлгэдэл гэдэг –Орч.

өдөр арав дахиа гарч түүнийг шашны сургуульд явуулах гэж байтал туйлын бөхөлж хадсан, чийг авахуулахгүй гэж завсар заалхайг нь давирхайдсан өвөөгийн лужир том авдар урьдынхаасаа нэлээд эрт ирсэн нь, “Дээд төрөлт хатагтай донья Фернанда дель Карпио де Буэндиад” гэж гот үсгээр хаягласан байжээ. Фернандаг унтлагын өрөнд захидлыг уншиж байх хооронд багачуул хайрцгийг ухасхийн онгойлгож гарав. Бага Аурелиано урьдынх шиг тэдэнд хамжилцаж байлаа. хэдүүлээ давирхайг нь ховхолж, хадаасыг нь сугалж, дээрээс чигжсэн модны үртсийг гаргавал доороос нь зэс шургаар шурагдсан урт авдар гарлаа. Бага Аурелиано найман шургийг наймууланг нь авч тугалган тагийг сөхөнүүтээ дуу алдаад хүүхдүүдээ хойш нь түлхэж арайхийн амжив. Авдранд тас хар хувцастай, энгэртээ залгалмай зүүсэн дон Фернандогийн шарил байж байлаа.

Ренатаг төрснөөс хойш асар удаагүй байтал Неерландын хэлэлцээрийн ээлжит ойгоор хурандаа Аурелиано Буэндиагийн ойг тэмдэглэх заавар гэнэт гарчээ. Ийм шийдвэр албан ёсны бодлоготой авцалдахгүй байсан учир хурандаа шуудхан эсэргүүцэж, ой тэмдэглүүлэхгүй гэв. “Би “ой” гэдэг үгийг одоо л дуулж байна. Энэ нь юу ч гэсэн үг байлаа гэсэн илт доромжилж байгаа хэрэг” гэж хэлжээ. Инжааны давчхан урланд зүсэн бүрийн элч төлөөлөгч шавах болов. Энэ удаа урьдынхаас хавьгүй хөгшин, хавьгүй сүрлэг хар хувцастай өмгөөлөгчид дахин ирсэн нь урьдын цагт түүнийгялаа батгана шиг шавж

байсан хүмүүс байжээ. Тэднийг харахда адайныг мухардуулах гэж тэднийд ирж байсныг санаж, эрээгүйгээр магтахад нь тэвчиж чадсангүй. “Зүгээр байлгаж үз” гэж шаардаад, тэдний мэтгээд байгаа шиг үндэсний эрх чөлөөний тэмцэгч лут амтаног биш урьд байгуулсан гавьяа зүтгэл юу ч үгүй, алтан загасныхаа дунд хэнээр ч өргүүлж тэтгүүлэхгүй зөнгөөрөө байж байгаад нүд анья гэсэн энгийн муу дархан гэж хэлжээ. “Улсын ерөнхийлөгч Макондод болох ёслол дээр биеэр хүрэлцэн ирж, Хүндэтгэлийн одон гардуулах гэж банья” гэж дуулахдаа бүр ч эгдүүцжээ. Хурандаа Аурелиано Буэниа “ерөнхийлөгчийн азсгийн газрын бузар булай, ёсон бус явуулга үйлдэж байгаагийн шийтгэл болож бус, хорхойд хоргүй мөрөөрөө нэгэн өвгөнийг хүндэтгэхгүй байгаагийн шийтгэл болгож ерөнхийлөгчийн духанд сум зоох хожуухан боловч сайхан завшааныг тэсэж ядан хүлээх болно” гэж ерөнхийлөгчид нэгд нэгэнгүй уламжлахыг тушаажээ. Хурандаа Аурелиано Буэниа үүнийгээ их заналатй хэлсэн тул улсын ерөнхийлөгч яг явах гэж байснаа болиод одонг бие төлөөлөгчөөр илгээжээ. Хурандаа Геринельдо Маркес тал талаасаа шахаж шаардуулсар байнгын хэвтрээ орхиж хуучин зэвсэг нэгт нөхрөө ятгах гэж иржээ. Хуучин анд Геринельдо Маркесийгээ дамнуурга дээр, том том дэрэн дунд сууж дөрвөн хүнээр дамнуулан иэрхийг хараад залу наснаасаа ялахдаа хамт ялж, ялагдахдаа хамт ялагдаж явсан хуучин нөхөр нь нөхрийн сэтгэлийг бодож ирж дээ гэдэгт огтхон ч эргэлзсэнгүй. Гэвч ирсэн үнэн учрыг мэдэхдээ дамнуургыг хурандаа Маркестэй хамт урлангаас гарахыг тушаав.

- Чамайг буудсан бол чамд их л тус хүргэх байж дээ гэдгийг даанч хожуу ойлголоо гэж Аурелиано Маркест хэлжээ.

Ийнхүү ойд Буэндиагийнхнаас хэн ч очсонгүй. Ой багт наадмын долоо хоногтой огт санаандгүй таарсан боловч засгийн газар улам л элэг доог хийх гэж зориуд ингэж тааруулж байна гэсэн бодол хурандаа Аурелано Буэндиагийн сэтгэлээс гарахгүй бав. Хүн огт шагайдаггүй урландаа суугаад цэргийн хөгжим хангинах, ёслолын буудлага инжгэнэх, тэдний гудамжийг өөрийн нь нэрэмжит болгож үг хэлэхийг чагнаж байлаа. Хурандаа яаж ч чдахгүй байгаадаа хор нь хөдлөн уйлж, зонсервативчуудтай цусан далай, махан овоо болтол дайтаж, үнсэн товрог хийх залуугийн чадалгүй болсондоо ялагдсанаас хойш анх удаа гутарчээ. Ёслолын цуурай намжаагүй шахам байтал урлангийн хаалгыг Урсула тогшсонд хурандаа:

- Надад сүү саад бол. Би юм хийж байнагэвэл,

- Хаалга нээ. Ёслолтой ямар чхамаагүй юм гэх Урсулагийн дуу тайван бөгөөд энгийн дуулджээ.

Тэгэхэд оньсыг мултлан, хаалгыг нээл гудамд төрх , өнгө өөр өөр болвч дэлхийн бөмбөрцгийн аль ч өнгцөгт байсан үл андуурагдах адил царатй арван доллон залуу зогосж байлаа. эд бол хурандаагийн хүүхдүүд байжээ. Тэднүүс бие

биеэ танихгүй, хоорондоо хэлэлцэж тохирон юмгүй, гагцхүү ой хийх сургаар далайн эргийн хамгийн алсын нутгаас иржээ. Тэд эцгийнхээ нэрийг бахархал болгон авч, эхээрээ овогложээ. Урсулаг баярлуулан, Фернандаг уурлуулан гурав хоног байхдаа гэр дэхийг тэмээ туйлчихсан юм шиг хөл, толгойг нь алдуулж дөнгөв. Амаранта хуучин бичиг хараа онгичин баймааж нь тэднгий төрсөн, адиласан өдрийг урсулагийн тэмдэглэсэн дэвтрийг олж нэр нэрийн ард хаягийг нь бичиж авлаа. Энэ нэрсийг уншихад дайны бүх хорин жилийг нэхэн санаж болох байлаа. Тэр нэгэн өглөө Макондогоос бослогын сургаар хорин нэгэн хүнийг тэргүүлэн явснаас сүүлд гэртээ цусанд дарайсан цувтай буцаж ирсэн хүртэл хурандаагийн шөнийн бүх аяныг дурдан сэргээж болох байлаа. Бага Аурелиано садан нараа ирснийг шампан дарсаар мялааж, хөгжим дуу болсон нижгэр найр далим үсэргэн хйиж энэ найрыг хурандаагийн ойгоор зохиосон багт наадмын хожимдсон ч гэсэн хариу гэж тооцвой. Гийчид гэрийн бүх ваарын тэн хагасыг хиар буулгаж, бухын хөнжил дээр зогсоон сэвэх гэж хөөцөлдөн сарнайн бүх бутыг сүйтгэж, бүх тахиаг буудаж, Амарнатагаар Пьетро Креспийн гунигт бүжиг хийлгэж, Ремедиост өмд өмсүүлж, сургаагны оройд өлгөсөн юм авахуулах гэж авируулж, хоолны өрөнд гайхад тос түрхэн оруулж Фернандаг дайруулсан боловч тэгж зүтгүйтэж байгааг нь хэн ч зэмлэсэнгүй, тэдний тэгж эх толгойг алудулан бужигнуулсан нь харин ч анагаах чадалтай байжээ. Хурандаа Аурелиано Буэндиа эхээд өхвгүүдээ баахан сэжиглэж, тэр ч байтугай заримыг нь өөрийнхөө хүүхэд мөн эсэхд эргэлзэж байсан боловч тэднийтэгж аашилсанд уйтгар нь гаран зугаацаж, явахад нь нэг нэг алтан загас өгчээ. Зожиг Бага Аркадио хаяла нараа тахиа зодолдуулах тэмцээнд урьж, Аурелиано нарын олон нь тахиагчдын элдэв булхайг анддаггүй, Антонио Исабель ламын булхайцыг доор нь барьсан учир тэр нь эгээ л золгүй юм болж тарсангүй. Бага Аурелиано садангийн энэ олон улс наргин цэнгэнэхд хэчнээн сайхан далим өгч байгааг хараад, гэрээ ажил хийлгэхээр шийджээ. Гэвч тэгж хүсэхэд нь ихээхэн хөдөлгөөнтэй, өвөг шигэ эюмыг шижиж сонсжиж явдаг асар том эрлийз Гунигт Аурелиано л ганцаараа зөвшөөрчээ. Жаргал эрэн дэлхийн талыг тойрч үзсэн учир хаан суух нь түүнд ялгаагүй байлаа. Бусад нь эхнэр хүүхэдтэй хараахан болоогүй боловч нэгэнт замаа сонгосон гэж бодож байжээ. Тэд цөмөөрөө чадамгай гар урлалчин, гэрийн эзэн, төвшин улс байжээ. Лхагва гариг буюу их мацгийн эхний өдөр хурандаагийн хүүхдүүдийг тарж явахаас өмнө Амарната тэдэнд жанч өмсгөж, сүмд аваачив. Тэднийг мөргөлийн дуганд орвол Антонио Исабель ламтан духан дээр нь загалмай зурж бгөхөд 1 тэд бишрэхээсээ илүү тоглоом хйиж байлаа. Буцаж ирээд хамгийн отгон нь загалмайа арилгах гэсэнд арилсангүй, ах нарынх нь ухан дээрх тэмдэг ч бас арилшгүй болжээ. Савантай усаар угааж, үрүүлээр үрж, сүүлд нь уушгин чулуу, цайруулдаг уусмал хүртэл хэрэглэсэн боловч загалмайг арилгаж чадсангүй. Гэтэл Амаранта хийгэд сүмд очсон бусад хүмүүсийнх нь амархан арилчихжээ. Урсула ах дүү нартай салахёс

гүйцэтгэхдээ “Бүр ч сайн юм боллоо. Одоо та нарыг хэн ч андуурахгүй” гэж хэлжээ. Тэд найрал хөгжимчдөөр удирдуулан, агаарт пуужин буудсаар бөөнөөрөө гарахад Буэндиагийн удам угсаа олон зуун жил тасрахгүй нь гэсэн бодол хотынхонд төрж билээ. Гунигт Аурелиано солиот зохион бүтээгч Хосе Аркадио Буэндиагийн мөрөөдөж байсан мөсний үйлдвэрийг хотын захад байгуулав.

Гунигт Аурелиано Макондод ирснээсээ хойш сарын дараа бүгдийн танил хүндтэй хүн болсныхоо хойно эх, нөхөрт гараагүй дүүдээ (хурандаагийн охин биш юм сажээ) суучихаар байр эрэн явсаар тайлбайн өнцөгт байгаа эзэнгүй байрын навсайж муудсан том байшинг сонирхов. Байшингийн эзэнг асуувал одоо эзэн байхгүй. Урьд нь сууж байсан юм, үхэхийнхээ өмнөх хэдэн жилд жижигхэн хиймэл цэцэгтэй бүрх, будангуй саарал өнгөтэй шагайвч өмсөн шуудангийн конторт очиж, хамбад захиа явуулахаар талбай дээгүүр гарч явахыг хоёрхон харсан гэж хэлжээ. Тэр бэлэвсэн эхнэрийн цорын ганц дотны хүн нь хатуу сэтгэлтэй зарц авгай байсан нь гэртээ орж ирсэн нохой муур болон бусад ямар ч амьтныг алж гудамжинд хүүрийг нь хаяж, тэр нь бээгээд хотоор нэг үмхий самхай болдог байсан гэж бас дуулав. Түүний хаясан сүүлийн амьтны сэг наранд

1 Католик шашинтны “үнсэн лхагва” гэж нэрлэдэг мацгийн эхний өдөр. Лам мөргөлчдийн духанд үнсээр загалмай зурдаг. –Орч.

Борц бослноос хойш өчнөөн удаж, гэрийн эгзэгтэй, зарц эмэгтэй хоёрыг дайн дуусахаас бүр өмнө үхэж үрэгдээд, хахир өвөл, хүчит шуурга болоогүй тулдаа байшин нь байж байгаа юм гэж цөмөөрөө боддог байжээ. Хаалганы нь нугасыг зэв идчихсэн учир гагцхүү хэрж гүйсэн аалзын шүлсэнд л торон тогтоож байх мэт санагдаж, цонхны нь жааз чийгэнд хөөж, гонхны нь хагарч барзайсан цементэн шалын завсар заалхайгаар өвс, хээрийн цэцэг ургаж, гүрвэл хийгэд элдэв хорхой гавьж гүйлэдж байгааг харахад энд наана хэлэхэд тавин жил хүн сууж байсан шинжгүй. Уулын дагуу Гунигт Аурелиано эзэнгүйн ийм оон баталгаа байхгүй байлаа ч гэсэн байшинд яваад орчих байлаа. Тэрбээр голын хаалгыг мөрөөрөө түлхэн орвол өмхөрч илжирсэн мод нь бутран унасанд тоос манаран, морин шоргоолжны банзанд үүрээ засахдаа зөөж ирсэн шохро бужигнаад явчихав. Гунигт Аурелиано тоос дарагдахыг хүлээзнэн, босгон дээр зогсож, тоос намдахад зочдын өрөөний голд өнгөрсөн зууны хийцтэй хувцас өмссөн туранхай эхнэр зогсож байгааг харжээ. Нүцгэн толгой дээр нь хэдэн шар өвсө сөрвийж, бас ч гэж сайхнаараа байгаа том нүдний гал бөхөж, ганцаардсаар хатаж хоцорсон царай нь үрчийж хорчийхоороо нэг болжээ.

Нөгөө ертөнцөөс босоод ирсэн юм уу гэмээр энэ хүнийг харахдаа балмагдан цочирдсон Гунигт Аурелиано арайхийн сэхээ авч үзвэл, тэр хуучин цагийн байлдааны гар буу өөдөөс нь шагайж байсанд,

- Өршөөгөөрэй гэж арайхийн дуугарчээ.

Авгай хуучин новш дүүрэн хөглөрсөн тасалгааны голд хөдлөлгүй зогсоод, тэвхийсэн мөртэй, духан дээрээ үнсэн загалмай зурагтай энэ аварга эрийг анхааралтай сонжин харахад, тоос манан дунд хоёр амтай буу үүрч, чандага холбон брасан байх шиг болж, урьдын адил будантан үзэгдсэнд,

- Тэнгэр минь! Болиоч. Одоо санаанд ийм юм бүү оруулж тамлаач гэж сөөнгөтөн дуу алдвал Гунигт Аурелиано:

- Би байшин хөлслөх гэсэн юм гэж хэлжээ.

Тэгэхэд авга буугаа өргөж, гар огтхон чичрэхгүйгээр цохонднь үнсэн загалмай руу нь онилон замгийг нь шийдэмгий татаж,

- Яв гэжээ.

Үдэш нь хоолон дээр Гунигт Аурелиано өдрийн явдлыг ярихад, үүнийг дуулан сэтгэл ихэд гутсан Урсула нулимс мэлмэрүүлж: “Ээ тэнгэр минь. Хөөрхий минь амьд мэнд юм сан уу!” гэж толгойгоо үхтгээн дуу алдав.

Он жил улирч, дайн дажин болж, гай зовлон нүүрлээд тэрбээр Ребекаг онхи мартаж орхисон байлаа. Ребекаг амьд гэдгийг мэдсээр байсан цорын ганц хүн бол нас хөгшрөвч нэхэл хатуу хэвээрээ Амаранта байлаа. Тэрбээр зүрхээ хүйт оргиход өнчин дэрэн дээр өглөө сээхдээ ч, унжсан мээм, хонхойсон гэдсээ савандаж, эмгэдийн хувцас хийдэг цагаан ёрог даавуугаар хийсэн банзал, цамц өмсөж байхдаа ч, хир хилэнцээ наманчилж байгаагийн тэмдэг болсон гарынхаа хар боодлыг сольж байхдаа ч Ребекаг л боддог байлаа. Унтаж байсан ч, сэрүүн байсан ч, хамгийн сайхан үед ч, хамгийн гутарсан цагт ч, хэдийд ч Амаранта Ребекаг бодож, ганцаар байсаар, дуртгал нь цэгцэрч, уйтгар гуниг төрүүлдэг элдэв хангайн хог новш амьдралаар зүрхэнд нь хурсан байснаа арилж үгүй болоод хамгийн гашуун дуртгал нь товойн үлдэж, хэзээ ч мартагдахааргүй болжээ. Ребека гэж хүн байдгийг Сайхан Ремедиос Амарантагаас дуулжээ. Тэр муудсан байшингийн хажуугаар гарах тоолондоо Амранта өрсөлдөгчийнхөө нэртэй холбоотой эвгүй, ичгүүртэй явдлыг ярьж, ингэснээрээ Ремедиосыг түүнд өөртэйгөө адил хорсдог болгон, үхсэнийхээ ч хойно хорслоо бусдад үлдээх гэж оролдсон боловч тэр нь нэмэргүй болсон бөгөөд учир нь Сайхан Ремедиосыг түүнд өөртэйгөө болсон бөгөөд учир нь Сайхан Ремедиос аливаа тэчъяадал, ялангуяам бусдын хорсол тэчъяадлыг тоодоггүй байла. Урсула Амарантатай огт адилгүй сэтгэл өвөрлөж, Ребекагийн тухай сэтгэлдээ огт муу юм үлдээсэнгүй, хүүхдийд хар хар хийсэн эцэг эхийнхээ ястай хамт анх авч ирсэн байдлаар нь

санаж Буэндиагийнхны гэгдэж явдах эрхгүй шившигт юм хийснийг нь мартаж орхижээ. Бага Аурелиано ЗРебекаг гэртээ авчрах харж асрах нь зүйтэй юм” гэсэн боловч Ребека үгэнд нь оролгүй, өөрийнхөөрөө зүтгэсэн тул сайхан санаа нь бүтсэнгүй болно. Өчнөөн жил зовж, ядуу зүдүү байсан болохоор ганцаараа байхын амтанд жаргасан нэр зүүж тух тав алдахыг хүсэхгүй байлаа.

Хоёрдугаар сард Макондод духандаа үнсэн загалмай зурагтай Аурелиано Буэндиагийн арван зургаан хөвгүүнийг дахин ирэхэд, Гунигт Аурелиано наргиж цэнгэж байхдаа тэдэнд Ребекагийн тухай дуулгаж, тэд хэдхэн цагийн дотор байшинг нь хуучин хэвд нь оруулж хаалга, цонхны жаазыг сольж, хананд нь тулгуур хийж, нүүрэн талыг нь баясгалантай гэгээн өнгөөр удаж, гонхны шалыг дахин цементлээд байшингийн дотор талыг засах гэсэн боловч зөвшөөрүүлж чадсангүй. Ребека хаалганд ч ойртож ирсэнгүй. Ах дүү нарыг засвараа пижгэнүүлээд дуусахад өртөг хөлсийг нь бодоод, өөртэй нь цуг байсаар байгаа зарц эмгэн Архенидагаар атга зоос явуулсан нь сүүлийн дайны үеэс гүйлгээнээс гарсан зоос байлаа. Гэвч Ребека түүнийг зарагддаг гэж бодсоор ажээ. Тэгэхэд л энэ ертөнцөөс хэнчээн хол тасарсныг нь бүгдээрээ ухаарч, улаан гол нь торж байгаа цагт ээн хорионоос нь гаргаж чадахгүй нь гэдгийг ойлгожээ.

Хурандаа Аурелианогийн хөвгүүд хоёр дахиа ирэхэд тэдний нэг Арвай Аурелиано Макондод хоцорч, Гунигт Аурелианотой хамт ажиллаж эхлэв. Арвай Аурелиано адислуулахаар тэднийд авчирсан хурандаагийн анхны хүүхдийн нэг бөгөөд гартаа дайралдсан хэврэг бүх юмыг ирсэн доороо хэмхчиж хаясан учир Урсула Амаранта хоёр түүнийг маш сайн санаж байлаа. Эхлээд дээшээ авирах гэж эрмэлздэг байснаа яваандаа больж, одоо дунд зэргийн нуруутай, цагаан бурхантаж цоохор болсон нүүртэй хүн болсон боловч хүрснэ эвдэх гайхалтай хүч нь хэвээрэ үлджээ. Өчнөөн төчнөөн таваг хадгалж, тэр ч байтугай хүрээгүй байтла ахагалчих тул Фернанда үнэт хэрэглэлээ хагалуулж дуусахаас өмнө цайран таваг яаран худалдан авч өгсөн боловч тэр нь ч удалгүй хонхойж ёнхойсон байлаа. Арвай Аурелиано ийм анагаагдашгүй гэмтэйдээ өөрөө хүртэл аргаа бардаг боловч эхэлж харангуут л итгэл төрөх цагаан санаатай, гайхмаар ажилсаг тул хайрыг булаана. Арвайн аурелиано ахархан хугацаанд мөсний үйлдвэрлэлийг ихэд нэмэгдүлж нутгийн ахдээр гүйхээ больсон учир Гунигт Аурелиано бараага хөндийн бусад сууринд борлуулах талаар бодох хэрэг гарав. Тэгээд нэг санаа төрснөө хэрэгжүүлсэн нь фабрикийн үйлдвэрлэлийг шинэчлэн сайжруулахад төдийгүй Макондод бусад газартай хоблоо тогтооход шийдвэрлэх үүрэгтэй болов.

- Төмөр зам тавих хэрэгтэй гэж Гунигт Аурелиано хэлжээ.

Макондод “төмөр зам” гэдэг үг анх сонсогдсон нь тэр байлаа. Тухайн үед Хосе Аркадио Буэндиагийн гэрлийн дайн хийх удирдамждаа хавсаргасан байсан бүдүүвчтэй яг адилхан зураг Гунигт Аурелиано зураад ширээндээрээ тавьсныг Урсула харахдаа цаг гэдэг орчин гэргэж байдаг юм биш байгаа гэсэн сэжиг нь

батажжээ. Гэвч Аурелиано өвгөөсөө огт ондоо нь гэвэл нойр хоол алдсангүй, мангуу юм шиг гөлийж хэнийг ч зовоосонгүй, харин ч хүний санаанд оромгүй элдэв төсөл гаргаж, түүнийгээ ойрын үед биелүүлнэ гэдэгт хатуу итгэж, орох өртөг, хийхн хугацаатай холбогдсон бүх тооцоог чадамгай зохиож, эргэлзэж тээнэгэлзэх, цөхөрч гутрахын зовлонгуй бодсоноо биелүүлж байлаа.

Бага Аурелиано хуранда Аурелиано Буэндиатай адилгүй, харин юманд огт хаширдаггүйгээрээ элэнц эцэгтэйгээ адил байж, ихрийнхээ өрөөсний хөлөг онгоц явуулах гэсэн үргүй ажилд мөнгө гаргахаасаа гар татаагүй шигээ Гунигт Аурелианогийн төмөр зам тавих төсөлд гар татсангүй. Гунигт Аурелиано хуанлийг хараад “Борооны улирлын дараа эргэж ирнэ” гээд лхагвад явчихжээ. Түүнээс хойш түүний сураг тасрав. Арвай Аурелиано фабрикийн илүүдэлд даргадж гүйцэхдээ усны оронд жимсний шүүсээр мөс гаргах гэж туршин, мөхөөлдөс үйлдэврлэх аргыг огт санамсаргүйеэ олоод борооны үе дуусаж зун өнгөрсөн боловч ахаасаа чимээ сураг байхгүйд үйлдвэрийг нэгэнт өөрийнхөө болсон гэж бодож байлаа. Гэвч өвлийн эхээр, өдөр дулаарсан цагаар голд цагаан хэрэглэл угааж байсан нэг эмэгтэй их л айчихсан, төв гудамжаар чарлан гүйж,

- Тэнд нэг аймаар юм явж байна. Дугуйтай гал зуух шиг юм, араасаа бүхэл бүтэн хот чирч явна гэж ярьжээ.

Тэгтэл ч аймаар чанга шийхтнах шуухитнах, аахилах уухилах чимээ Макондог доргиулав. Хэдэн долоо хоногийн өмнө хэсэг ажилчин, зам төмөр тавьж байгааг олон хүн харсан боловч тоосонгүй, цыганууд л дахин эргэж ирээд аль дивангарынх шигээ шүгэл, хэнгэргээ дуургаргаж иерусалимын суутнуудын бүтээсэн ямар гээчийг нь бүү мэд балай шингэнийг дээд зэргийн чанартай гэж магтан илбэ жилбэ үзүүлэх гэж байгаа биз бодоцгоожээ. Гэвч макондогийнхон чанга гэгч шийхтнах, уухилах дуунаас сандрахад болихдоо гудамжинд бужигнан гарч үзвэл Гунигт Аурелиано цэцгээр алаглуулан чимсэн бүх тэрэгнээс баяр хүргэн гараа даллаж явахыг харжээ. Эхний удаа тийнхүү найман сар хожимдорж ирсэн тэрхүү гэмгүй байрыншар галт тэрэг Макондод өчнөөн эргэлзээтэй, эргэлзээгүй зүйл, өчнөөн сайн муу, өчнөөн өөрчлөлт, гамшиг зовлон, уй гашуу авчрах учиртай байжээ.

\*\*\* \*\*

Макондогийнхон тоо томшгүй гайхамшигт нээлтэд алмайрч, гайхаад гайхаад барахгүй байлаа. Гунигт Аурелианогийн галт тэргээр хоёр дахиа явахдаа авчирсан машины гаргаж байгаа цийлгэр цахилгаан гэрлийг тэд хараад шөнө нь үл унтана. Уг машины “”түг түг” гэх дуунд их удаж, багагүй чармайж



байж дасжээ. Тэд дэгжиж байгаа худаладачин дон Бруно Креспи арслангийн ам хэлбэртэй касс бүхий хүрээлэнд үзүүлсэн хөдөлдөг зурагт дургүйцэж, нэг кинонд үхээд оршуулж, үзэгчдийн хойноос нь өчнөөн гашуудсан баатар нөгөө кинон эв эргүүл,% сав саруул байгаагаар барахгүй бүр араб болчихсон явж байгааг үзэхдээ ондууцжээ. Баатруудынхаа эрээн бараан хувь заяаг хуваалцах гэж хоёр сентаво төлсөн олон урьд хожид үзээгүй доромжлолыг тэвчиж чадсангүй, хамаг сандлыг нь яйчин хаяжээ. Дон Бруно Креспийн шаардсанаар вангийн түшмэл “Кино бичүүр гэдэг бол байхгүй юмыг байгаа юм шиг харуулдаг багаж учир үзэгчид тэгж сүйд болох хэрэггүй” гэсэн тусгай хууль гарган тайлбарласанд оон нь цыганд дахиад муухай залилуулаа гэж шийдээд өөрсдийн золон багадаагүй байхад зохиомол хүмүүсийн зохиомол зовлонгийн төлөө уйлахаа больё гэгцгээгээд сүүдэр ший үзэх больжээ. Хуучирсан бадралт баг бишгүүрийн оронд франц хөгжилтэй дууч эмсийн авчирсан, нутгийн айрал хөгжимчдийн орлогыг ихээхэн багасгасан эгшиг тайхцгийг ч ингэ жүзэх болов. Эхний үед хотлоороо сониучирхан хориотой гудамжнаа очигчид олширч, тэр ч байтугай зарми хүндтэй хатагтай нар эрэгтэй хүни хувцас өмсөөд учир битүүлэг шинэ хөгжмийг ойроос үзэх гэж очиж байна гэлцэх болов. Гэвч эгшигт хайрцгийг дэргэдээс нь гайгүй сайн хараад энэ нь дууч эмсийн баталсан, бүх нийтийн бодсон шиг шидэт тээрэмб иш ердө өнэг муу оньст тоглоом байна, түүний эгшиг, найрал хөгжмийн сэтгэл хөдөлгөм, амьдралын үнэнийг харуулсан хүнлэг аяны хаана нь ч хүрэхгүй юм байна гэж үзжээ. Үүнд туйлын их урам хугарчээ. Удалгүй эгшигт хайрцаг дэлгэрч, айлб үхэн эгшигт хайрцагтай болсон боловч томчуул өөрсдөө зугаацах гэж түүнийг авсангүй, багчуул хүүхдээ зугаацуулах гэж авсан нь цаадуул нь тэр зугаатай машины гэдэс дотрыг гарган шавиагаа ханатал тоглож байх болов. Гэвч хотын мэр сэр хүн харицлах утас төмөр замын ертөөн дээр тавьсныг үзэхдээ эргүүлдэг урт бариултайд нь эхлээд бүдүүндүүхэн эгшигт хайрцаг юм уу гэж бодсон боловч түүгээр ярьж үзээд үнэхээр ярьж болж байсанд юунд ч итгэхээ байсан улс хүртэл сэрдхийжээ. Макондогийнхны хэчнээн болтол гайхаж чадахыг эзэн тэнгэр шалгахаар шийдэж, нэг бахдалыг нь төрүүлж, нэг урмыг нь хугалж, нэг тээнэгэлзүүлж, нэг үнэмшүүлэх зэргээр янз бүр болгосоор байсану чир үнэн, худал хоёр хэдий хэр зайтайг хэн ч хэлж чадахааргүй болсон шиг санагдаж байлаа. Ийнхүү биетэй, биегүй хоёр толгой эргэм хутаглаж, туулайн бөөрийн доор байсан Хосе Аркадио Буэниагийн сүнс гэгээн цагаан өдөр байшин дотуур туйлгүй бачимдан тэнүүчлэх болов. Төмөр зам албан ёсоор нээгдэж, галт тэрэг тогтмол ирэх болж, ширээ сандал тавьсан, харилцах утас зоосон, пиу зарах жижиг цонх гаргасан өртөөний даруухан модон байшин баригдсаны дараагаар хамгийн энгийн ажил эрхэлдэг хамгийн энгийн хүмүүс гэж Макондогийн гудамжнаа өөрсдийгөө нэрлэвч циркийн жүжигчид гэвэл илүү онох бүстэй бүсгүй улс үзэгдэх боллоо. Хотынхон цыгануудад мэхлэгдсээр хаширчихсан

учир тэр хэрмэл илбэчид гудамжаар явж шүгэлтэй хоовон, мацгийн долоо дахь өдөр сүнс аврахын тулд мацаг барих ёсны номыг авахуулах гэж оролдон, түүнийгээ бүтнэ гэж горьдохын зовлон байсан боловч шалаад салахгүйд нь залхаад авахын түүс болсон хүмүүс болон олдохгүйд мундахгүй алмай амьтдын хүчээр их л хөлжиж амжжээ. Эдгээр луйварчингуудтай хамт нэг лхагва гаригт малийтал инээсэн, балтгар намхан мистер Герберт Макокод морилж, дараа нь Буэниагийн үдийн хоол идэхээр иржээ. Тэр морь унахад өмсдөг өмд, түрий, илчүү дуулга өмсөж, ган хүрээтэй шил зүүсэн нь шилний цаанаас нүд нь молор аятай гялалзана.

Гадилын нэг хонгорцог тэр чигээр нь идтэл түүнийг хэн ч анзаарсангүй. Бага Аурелиано мистер Герберттэй “Отель Хакоба”-д испани хэлээр хагай мурий “Сул өрөө байхгүй байна” гэж ондууцан үглэж байхад нь санамсаргүй дайралдаад, явуулын улсыг авчирдгаараа авчирсан нь тэр байжээ. Мистер Герберт уяатай хэдэн хөөрдөг бөмбөлөгөтэй яваа бөгөөд эдгээрээр бөмбөрцгийн талыг тойрч, их ррлого олж байсан гэх боловч Макондогийнхноос түүгээр нь хөөрөх хүн олдсонгүй. Учир нь уяатай хийт бөмбөлөг гэдэг бол цыганы нисдэг цийрсээр нисэж үзсэн тэдний хувьд алхам ухарсан хэрэг байлаа. Мистер Герберт долоо хоноод түрүүчийн галт тэргээр явахаас аргагүй болжээ.

Ихэвчлэн үдийн хоолон дээр өгдөг судалтай гадил жимсний хонгорцгийг ширээндээр тавихад тэр нэг ширхгийг тасалж аваад төдий л амтархсан янзгүй иджээ. Гэвч дараа дараагаар аван, ам хамхилгүй ярьж, санаас сайн зажилж, тамсаг хүний амтархах байдлаар эхний хонгорцгийг идэж бараад, хоёр дахийг гуйжээ. Тэгснээ дандаа бибедээ авч явдаг багажны хайрцагнаас гэртэй нарийн багаж гаргаж ирэн, очир алмаас худладн авч байгаа хүн шиг нэг гадилыг гярхай нь арагүй шинжиж, тусгай сумчаар зүсэжэ үзэн, эмийн сангийн жинлүүрээр жигнэж, зэвсгийн дархны хэмжүүрээр хэмжиж үзэв. Дараа нь хайрцагнаасаа өөр жиж бүрэн багаж гаргаж ирээд, агаарын халуун, чийг, гэрлийн байдлыг тодорхойлов. Энэ ёсорхуу ажиллагаа их л зугаатай байсан учир тэнд байгсад хоолоо тайван идэж чадахгүй, мистер Гербертийг ийм тийм байн агэж тодорхой юм хэлэх байг гэж хүлээсэн боловч ойлгочихоор тоймтой юм ер хэлсэнгүй. Сүүлд нь мистер Герберт хотын орчим шүүрэн ховоо, сагс барьчихсан, эрвээхий хөөцөлдөж байгаа нь харагджээ. Дараагийн лхагва гаригт хэсэг инженер, агрономич, ус шинжээч, газар хэмжээч ирж, мистер Гербертийн эрвээхий браьж байсан газрыг хэдэн долоо хоног шинжжээ. Хойхон нь сеньор Жек Браун шар галт тэрэгний сүүлд залгаастай, мөнгөөр чимж, хамба хилэнгээр гадарласан буйдан ортой, цэнхэр шилэн дээвэртэй вогооноор иржээ. өөр нэг вогооноор хар хувцастай ихэмсэг хуулийнхан,, урьдын цагт хурандаа Аурелиано Буэндиаг хаа л бол дагаж явдаг байсан мөнөөхөн өмгөөлөгчид ирж, ноён Брауныг тойрон бужигнасанд уяат агаарын бөмбөлөгтэй, өнгийн эрээвхийтэй мистер Герберт, дугуйтан бунхан, герман зуудаг нохойтой сеньор

Брауны нэгэн адил тэр агрономич, ус шинжээч, газар хэмжээч нар нэг л дайныг ёрлож байх шиг ард олны совин татаж байжээ. Гэвч эргэцүүлэн бодохын зав болсонгүй, сэжигч маконогийнхныг юу болж байгааг ухаарч амжаагүй байтал, чөтгөр алгад гэж, хотод нь нимгэн төмрөөр дээвэрлэсэн модон саравч дүүрч, тэдгээрт харийн хүмүүс суух боллоо. Тэр хүмүүсийн зарим нь ногоонд, зарим нь задгай чиргүүлд, нөгөө зарим нь ногоонд, зарим нь задгай чиргүүлд, нөгөө зарим нь тэр ч байтугай вогооны дээвэр дэр сууж дэлхийн дөрвөн зүг найман зовхисоос галт тэргээр наашаа цувж байлаа. Удалгүй гринго1 торгон палааж, том хив бүрх өмссөн хүүхнүүдээ авчирч, төмөр замын нөгөө талд бас нэг хот байгуулж, гудамжаар нь далдуу мод суулгаж, байшингийнхаа цонхонд төмөр тор хадаж гонхондоо цагаан ширээ тавьж, адартаа асар том далавчтай сэнс дүүжилж, тогос бөднө зугаалах өргөн ногоон нуга байгуулав. Асар том, цахилгаанжуулсан тахианы хонуурь аятай энэ бүх хороллоо өндөр төмөр тороор хүрээлж, зуны сэрүүхэн сард өглөөгүүр тэр торон дээр хараацай пиг сууж нүүгэлтэн хар юм харагдах бүлгээ. Макондод харийнхан юу эргж байна вэ, нээрээ тэд ивээн тэтгэгчид мөн үү гэдгийг хэн ч тухайлж мэдэхгүй байтал нүүж ирэгсэд бүх юмны хөл толгойг алдуулж орхилоо. Цыгануудын замбараа алдуулдаг нь эдний дэргэд юу ч биш, түр зуурын, тэгээд бас ойлгомжтой байдаг байжээ. Урьдын цагт хурмаст тэнгэрийн бошгыг л дагадаг шидтэний хүчээр тэд борооны цагийг өөрчилж, тариа боловсрох үеийг богиносгож, голыг урсаж байсан углдралаас нь гарган цагаан чулуу, хүйтэн усыг нь хотын нөгөө үзүүр рүү, оршулгын газрын цаагуур аваачлаа. Чухамхүү тэгэхэд л Хосе Аркадиогийн булшны гандсан тоосгон дээгүүр төмөр бетрон цутгаж, түүний яснаас

1 Гринго- Латин Америкт америкчуудыг ингэж муучлан нэрлэжээ. –Орч.

Гарч байгаа дарийн үнэрийг голын усанд шингээхгүйг хичээжээ. Хүүхнээ авчраагүй харийнханд зориулж шунал тачаал ихтэй франц дууч эмсийн гудамжийг төмөр тортой хотоос ч том хот болгож, балар эртний үед ч мэддэг байсан толгой эргүүлэх бүхий л уран аргад суралцсан, унжгар хүний урмыг сэргээх, зүрхгүй хүний зоригийг чангалах, шунахай хүний хүслийг гүйцээх, даруу хүний онгодыг бадраах, омогтой хүний хулхийг буулгах, даяанч хүнийг дахиж хүмүүжүүлэхээс сийхгүй олноос онцгой янхан завхуулж хүүхнүүд ачсан галт тэрэг нэгэн сайн лхагва гагигт ирлээ. Араб мухлагуудын оронд нээгдсэн гадаад оарааны дэлгүүрийн гэрэл таялзах Туркийн гудамжнаа адал явдлын эрэлчингүүд, бямба гаригийн шөнө бөөн бөөнөөрөө язганалдаж, мөрийтэй тоглоомын ширээний хажууд, буудлагын газрын дэргэд, заяаг мэргэлдэг, зүүдийг таадаг нарийнгудамжинд, шарсан мах ундаа өрсөн ширээний тушаа хөшилдөн

хөлхөлдөх агаад ням гаригийн өглөө энэ ширээ хааяа нэг согтоод тэрийн уначихсан хүмүүс, олонхдоо бол шөнийн зодооны үеэр суманд оногдож, нударгалуулж, хутгалуулж, лонхонд цохиулж үхсэн хүмүүсийн хүүрэн дунд далай доторх арал аятай ёрдойн байдаг байлаа. Макондод ирж байгаа улс амьтан гэж замаа алдаж, хэнээс ч болох болохгүйг асуулгүйгээр аль дайралдсан цулгуй газар өөртөө байшин баригсдын тавига, авдар сав, барилгын хэрэглэгдэхүүн хаа л бол мөрт хөглөрөөд, эвсэл хос хоёр гэгээн цагаан өдөр бүгдийн нүдэн дээр буйлсийн модонд дүүжилсэн орон дээр хурьцал үйлдэж байга ануд халтирам юм дайралдаад эхний үед гудамжаар явахын аргагүй байлаа. Антилийн арлын номхон негрүүд л цорын ганц намуухан хороолол байгуулж, хотын захад модон байшин ивээстэйгээр гудамжлуулан брьж, үдэш нь цэцэрлэгтээ суугаад хэний ч ойлгохгүй этгээд хэлээрээ г гунигт тамлага аялдаг байлаа. Мистер Гербертийг айлчилсанаас хойш наймхан сар өнгөрөхөд өчнөөн юм өөрчлөгдөж, Маконогийн хуучуул хотоо танихгүй шахам болжээ.

- ёстой учир нь олдохгүй юмыгбид өөрсдөө л хийчихлэ э дээ. Нэг муу грингог гадилаар дайллаа гэж тэр гэж хурандаа Аурелиано Буэндиа хэлдэг байлаа.

Бага Аурелиано хар мянган гадаадынхныг харахдаа ганц бах нь ханаж байв. Удалгүй гэрээр нь танихгүй улс, энд тэндхийн засаршгүй наргиачингууд дүүрч хашаанд шинэ унтлагын өрөө барьж, хоолныхоо өрөөг өргөтгөж, хуучин ширээгээр арван зургаан хүн суух шинэ ширээгээр сольж, шинэ сав суулга, ширээний хэрэгсэл худалдаж авсан хэдий боловч тэднийг хэдэн ээлжээр хооллох хээрг гарч байлаа. Фернанда хэчнээн дургүй гэлээ ч замбараагүй зочдыг арга буюу хатан хаан шиг дайлж, цаадуул нь тагтанд шавар шавхай чирч авчран, шууд цэцэрлэгт шээж, үдийн амралтын үеэр дайралдсан газраа сийрсээ дэвсэж, хүүхнүүдийн ичингүйрэх, эрчүүлийн таагүйхэн мушийхыг ч тоохгүй толгойдоо орсон юмыг чалчина. Амаранта энэ хар бор амьтдын хөлд дарагдаж байгаад эгдүүцэн, хуучных шигээ дахин гал тогоонд хоол ундаа идэж уух болов. Хурандаа Аурелиано Буэндиа урландаа мэндийг нь мэдэхээр орж ирэгсдийн олонх нь өөрийг нь таашаасандаа буюу хүндэлсэндээ бус, түүхэн дурсгал, ховор эрдэнийн дайтай бодон шохоорхож яваа гэдгийг сайн мэдээд хаалгаа түгжих болж, гадаа хаалган дээрээ хааяа л нэг гарах боллоо. Гагцхүү Урсула хөлөө арайхийж даан, хана түшин тэмтэрч явах болсон боловч галт тэрэг ирэх бүрийн өмнө хүүхэд шиг баярлан, “Мах, загас бэлд. Гадаадынхан юу ч идэх гэж магад, бүх л төрлийн юм хий” гэж Санта Софи де ла Пьедадын тайван захиргаанд очихын мөрөөс болсон дөрвөн тогооч хүүхэнд хэлдэг байлаа. Галт тэрэг өдрийн дүн халуунаар ирнэ. Үдийн хоолноор байшинд зах дээр байгаа юм шиг дүнгэнэж, хөлс нь гоожсон хооллогсод гар султай эздийгээ ч танихгүй бөөнөөрөө шуугилдан орж ирээд, ширээний хамгийн олигтой газар нь олж, тогоо дүүрэн мах хатаасан тарвас, ногоо, тавагтай цагаан будааг бие биетэйгээ мөргөлдөн зөөж, бүтэн торх жимсний ундааг худаг шиг шанагаар аягална.

Хөл толгой нь олдохгүй юм болж, Фернанда олон хүн хоолоо дахихад цөхрөнгөө барж, алмай хооллогч гэрийг нь гуанзтай андууран, тооцоо хийхийг шаардахад захын наймаачин эхнэрийн бүдүүн үгээр сэтгэлдээ байгааг уудалчихмаар болдог байлаа. Мистер Гербертийн ирснээс хойш жил гаруйхан өнгөрсөн боловч гринго нар Хосе Аркадио Буэндиагийн нөхдийнхөө хамт их нээлт хийх замыг эрж байхдаа туулж өнгөрсөн тэр илбэдүүлсэн газар гадил суулгах гэж байгаа ганц зүйл л мэдэгджээ.. Хурандаа Аурелианогийн духандаа үнсэн загалмай зураастай хоёр хүү хот руу цутгах галт уулын хайлмаг шиг асар их урсгалд хамагдан ирээд, ирэн учраа тайлбарлахдаа:

- Бүгдээрээ л ирээд байхаар нь бид ирлээ гэж хэлсэн нь тэнд ирсэн бүх хүний учрыг хэлчих шиг болжээ.

Гадилын хөл үймээнд автаагүй цорын ганц хүн бол Сайхан Ремедиос байлаа. Бүсгүй орь залуу чигээрээ ингээд тогтчих шиг болж, өдөр ирэх тутам элдвээр ёсорхохыг үзэж чадахгүй, овлож живлэх, үл итгэх аливаа явдлыг улам огоорч, эгэл жирийн байдалар өөрийгөө л болгож байхыг жаргал гэж үзэж байлаа. Эмэгтэйчүүд яагаад цээживч, банзал өмсөж биеэ зовоож байдгийг ойлгохгүй, углаад өмсчихдөг элбэгдүүхэн хувцас бүдүүн зоргоор оёж өмсөөд, хувцастай обловч нүцгэн байга аюм шиг байхаар яаж байх вэ гэдгийг хялбархан шийджээ. Түүний бодлоор бол гэрт нүцгэн байх нь хамгийн тохиромжтой гэж бодож байлаа. Хонгоо шүүрсэн урт сайхан үсээ жаахан тайрч, гээг облгон сүлжээч, сам хатгаж, тууз зангидаач гэж үгэлцгээгээд амар заяа үзүүлэхгүй тул үсээ бүр авахуулаад, үсээрээ хутагт нарын барималд хиймэл халимаг хийжээ. Энгийн байх гэж зөнгөөрөө эрмэлздэг нь хамгийн гайхалтай нэг юм байсан нь юу вэ гэвэл, тэрбээр өөрийн биед эвтэйг бодоод хийц загварыг хайхрахгүй болох тусам, өөрийнхөө зөнгөөр байхыг бодоод ёсорхож барихыг орхих тусам улам сэтгэл булаам үзэсгэлэн гоо болж,эрчүүлтэй харьцах нь улам нүүрэмгий болж байжээ. Хурандаа Аурелиано Буэндиагийн хөвгүүдийн анх Макондод ирэхэд жич охины нь яс махны тасархай гэдгийг санахдаа Урсула аль эрт мартсан айдас нь төрсөнд цочиж “Гайгүй мэдээтэй бай! Эдний хэнээс ч гэсэн хүүхэд олбол гахай сүүлтэй гарна шүү” гэж Сайхан Ремедиост захижээ. Сайхан Ремедиос хуланц эхийнэхэ үгийг төдий л тоосонгүй, удалгүй эрэгтэй хүний хувцас өмсөөд, шонгийн оройд өлгөсөн юм авчирч авах гэж элсэндээр хөрвөөхөд энэ тэсвэрлэшгүй юмыг харахдаа сэтгэл бүр хямарсан арван долоон үеэл нь золтой л ам мурийсангүй. Иймээс Урсула тэднийг ирэхэд хэнийг ч гэрт хонуулдаггүй. Макондод суудаг дөрвөн нь дайдуухан газар байр хөлсөлж авчээ. Сайхан Ремедиос Урсулагийн ингэж облгоомжиж байгааг дуулсан бол элэг нь хөшиж үхэх байсан биз ээ. Алтан дэлхийгээс халин хальтлаа бүсгүй эр хүний амгаланг алдагдуулж байх тавилантайгаа мэдсэнгүй. Урсулагийн хорьсоор байтал хоолны өрөөнд орж, тийнхүү орж ирэх тоолонд нь харийнхан цочирдон сандардаг байла. Сайхан Ремедиосын өмссөн бүдүүн

хувцасны дотуур юу ч байхгүй гэдэг нь нүднээ дэндүү илхэн тусна. Үсийг нь авчихсан бөв бөөрөнхий толгойгоо хөдөлгөх нь өдөж сөдсөн хэрэг биш, ялихгүй сэрүүцэх гэж гуяа ичиж зовох юмгүй ил гаргадаг, хоол идчихэдээд хуруугаа бах нь ханасан янзтай долоодог нь ч муугаар уруу татах гэсэн хэрэг биш байлаа. Буэндиагийнхнаас хэн нь ч мэдээгүй байсан нэг зүйлийг гадаадынхан дорхноо олж мэдсэн нь юу вэ гэвэл Сайхан Ремедиосоос сэтэгл түгшээн бие сульдаасан нэгуур гараад байдаг, тэрнь түүнийг гараад явчихсан хойно хэдэн цагийн турш агаарт байсаар байдаг байлаа. Дурлахын золлон үзсэн, даян дэлхийгээр тэнэж,энгэр зөрүүлэхийн амтыг таньсан эрчүүл “Сайхан Ремедиосын төрөлхийн үнэрийг үнэртээд сэтгэл хөдөлдөг шиг тэгж хэзээ ч хөдлөж байгаагүй” гэж ам алдаж байлаа. Хайтан цэцэгтэй гонхонд, зочдын өрөөнд, гэрийн лаь ч буланд тэд Сайхан Ремедиосын байсан газрыг алдалгүй зааж, байснаас нь хойш хэдэн цаг өнгөрснийг хэлж чаддаг байла. Тэрбээр хэн ч андуурахын аргагүй содон үнэр агаарт үлдээж, тэр үнэр гэрийн бусад үнэртэй хэдийн нийлэн гэрийнхэнд нь дасал болчихсон боловч харийнханд тун содон байжээ. Иймээс залуу офицер дурласнаас болж яагаад үхсэн, хол нутгаас ирсэнтайж яагаад сэтгэлээр унасныг тэд л зөвхөн ойлгож байлаа. Сайхан Ремедиос хаа л бол хаа бүсдын сэтгэлийг үймрүүлж эрчүүлд баларлаа гэсэн аргалшгүй сэрэл төрүүлдгээ өөрөө мэдэхгүй, тэдэнтэй илэн далангүй харьцаж, энгийн ялдам аашаараа ганц мөсөн алдаг байлаа. Урсула жич охиноо бусдын нүдний хор оруулахгүй гэж Амарантатай хамт гал зууханд хоол иддэг болгоход цаадах нь элдэв ёс журам сахих гэхгүй чөлөөтэй болсондоо харин ч баярлажээ. Үнэнийг хэлэхэд, хэзээ хаана хоол идэх нь хамаагүй, хоолыг тогтсон цагт идэлгүй, идмээр болсон үедээ л идэхийг урьтал болгодог байжээ. Заримдаа өглөөний гурван цагт жаахан өл дарчихаад орой болтол өдөржин унтчих,хэдэн сараар өдөр шөнөө солин байснаа гэрт тогтоосон ёсондоо огтын санамсаргүйгээр эргэж ордог байлаа. Гэвч өглөөний арван нэгэн цагт орноос бослоо ч чарма нүцгэлээд хоёр цаг угаалгын өрөөнд түгжиж, хилэнцэт хорхой алан, нойроо сэргээн. Тэгээд усан сангаас тарвасны хальсан саваар ус утган биен дээрээсээ асагдаг байлаа. Ингэхдээ их л удаж, үүнийхээ хажуугаар олон ёс гүйцэтгэх учир Ремедиосыг муухан мэддэг хүн бол өөрийнхөө л биеийг шохоорхож суудаг юм уу даа гэж бодохоор байдаг байлаа. Гэвч угтаа бол энэхүү нууц зан үйлд сэрэл хөдөлгөх юм огт байсангүй, гагцхүү юм идмээр облтлоо цаг нөгцөөж байгаа нь тэр ажээ. Нэг удаа түүнийг дөнгөж биеэ угааж эхэлтэл нэгэн харийн хүн дээврийн ваарыг ховхлон зайлуулаад, нүцгэн байхыг нь харахдаа амьсгаа амч чадахгүй болжээ. Бсгүй ваарны цоорхойгоортүүний аргаа барсан янзтай байгааг харахдаа ичсэнгүй, харин сэтгэл түгшиж,

- Мэээтэй, унуужин! Гэж дуу алдсанд тэр хүн:
- Таныг л харах гэсэн юм гэж шуухитнасанд бүсгүй:

- Уухай, тийм бий. За яах вэ, дээвэр илжирсэн, болгоомжтой л байгаарай гэж хариулжээ!

Харин хүний нүүрэн гайхах, шаналах байдал хосолж, гайхалтай зрэгэлээ сарничих вий гэж айхдаа тачаалаа хөдлөхийг арайхийн барьж байх мэт санагдаж байлаа. Ремедиос түүнийг дээвэр цөмөрчих болуужин гэж айн зовж байна даа гэж бодоод хүнийг ийм аюулгүй байдалд удаан байлгаад яах вэ гэж ердийнхөөсөө хурдхан биеэ угаах гэж хичээв. Бүсгүй дээрээсээ ус асгаж байхдаа, “Дээвэр ийм болсон нь тун тоогүй, боон илжирсэн навчин дотроос цоохойгоор угаалгын өрөөнд хилэнцэт хорхой орж ирэх байх” гэж ярьсанд ийнхүү шулганахыг нь харийн хүн өөртөө талтай байгааг нуухдаа тэгж байна гэж санаад, түүнийг биеэ савандаж эхлэхэд азаа туршаад үзэх хорхойгоо дарж чадахгүй,

- Таныг савандаад өгөх үү? Гэж шивнэвэл бүсгүй,
- Сайхан сэтгэл гаргасанд гялайлаа, өөрийн минь хоёр гар болоод байна аа гэж хариуланд,
- Үгүй ядахда нурууг чинь савандаад өгье л дөө гэж гуйжээ.

Бүсгүйг биеэ арчиж байх зуур харийн хүн нүдэндээ нулимс мэлтэлзүүлэн, өөртэйгөө суугаач гэж гуйжээ. Усанд рж байга ахүхэн харах гэж хоолоо бараг мартчихаад бүтэн цаг алдаж байгаа эрваа амьтантай хэзээ ч суухгүй гэж бүсгүй үнэн сэтгэлээсээ хэлжээ. Тэгээд харийн хүн олны сэжиглэж байсан шиг Ремедиосыг хувцсаа нүцгэн биен дээрээ үнэхээр өмсөхийг нүдээр үзэж, халуун төмөрөөр үүрд тамгалуулсан юм шиг болж, тэсэж чадалгүй, хоёрваар суга татаад угалагын өрөө рүү буух гэжээ.

- Наана чинь их өндөр, та үхэвзэй! Гэж бүсгүй айн дуу алдав.

Өмхөрсөн дээвэр уулын чулуу нурах аятай пижгэнэн унасанд сайхь эр айсандаа ганцхан чарлаад, цементэн шалан дээр тархиа хага унан, дорхноо амьсгаа хураав. Хоолны өрөөнд байсан харийнхэн тэр шуугианаар гүйн ирээд, хүүрийг яаран зайлуулахдаа түүний атрхинаас Ремедиосын хачирхам үнэр сэнхийж байгааг мэдэв. Энэ үнэр талийгаачийн биенд бат шингэснээр барахгүй гавлынх нь хагарахайнаас цус бус, мөнөөхөн учир битүүлэг үнэр бүхий заар шүүрч байлаа. Рмедиосын үнэр эрчүүдийг үхсэн хойно нь ч тарчлааж, ясыг нь үйрч алга болтол байсаар байх нь гэдгийг бултаараа ойлгожээ. Гэвч тэр аймшигт явдлыг Рмедиосоос болж үхсэн түрүүчийн хоёр хүний үхэлтэй хэн ч холбож бодсонгүй. Бас нэг хүний үхэлтэй хэн ч холбож бодсонгүй. Бас нэг хүн үхсэний сүүлд л гадаадынханр, макондогийн олон хуучуул “Ремедиос Буэндиа хайрын илч түгээхээсээ илүү үхлийн хөнөөлт уур түгээдэг” гэсэн яриаг домог гэж үзэхээ больжээ. Хэдэн сарын дараа Сайхан

Ремедиосыг үерхдэг бүсгүйчүүлтэйгээ гадилын тариалан үзэхээр явсан эр нэг өдөр уг явган ярианы үнэнд үнэмшихээс аргагүй болж билээ. Макондогийнхон эцэс төгсгөлгүй гудамлан тарьсан, чийг ханхалсан гадил модны хоорондуур явахыг ихээхэн чамин зугаалга гэж үзэх болжээ. Тэнд хачин нам гүм бөгөөд нэр нам гүмийг өөр газраас энд авчраад тавьчихсан юм шиг, хэн ч ашиглаагүй учир эвдрээгүй онгоноороо байгаа юм шиг санагдана. Заримдаа алхмын цаана хэлсэн үг дуулдахгүй мөртлөө заримдаа тариалангийн нөгөө захад хэлсэн үг тов тодохон дуулддаг байлаа. Макондогийн бүсгүйчүүл энэ хачин байдлыг нь ашиглан наадж, бие биеэ даажигнах, айлгах зэргээр тоглоод үдэш нь үүнийгээ балай зүүд аятай дурсан ярьдаг байлаа. Гадилын цэцэрлэгт гудамж хачин нам гүм гэж Макондод ихэд зард гарсан учир гэмгүй зугаацахад нь Урсула Ремедиосыг хориглож чадсангүй, бүрх малгай болон өмсвөл зохих бүх юмаа өмсөж яваарай гэж захиад тариалан руу явуулжээ. Охид тариалангийн гортигт ортол агаарт үхлийн үнэр сэнхийгээд явчихжээ. Усны шуудуу татаж байсан эрчүүл нэгэн илбийн хүчинд автан, үл үзэгдэх аюултай тулгарах мэт болж, зарим нь энгэнэтэл уйлмаар болоод тэсгэлгүй уйлчихжээ. Ремедиос болон түүний сүнс нь зайлах шахсан найз нара өөрсдийг нь дайрахад бэлхэл улангассан бөөн харчуулаас хажуугийн байшинд ам мөлтөс нуугдав. Жаахан байж байтал дөрвөн Аурелиано ирж тэднийг хоргодсон газраас нь гарагж авав. Үнсэн загалмайг нь үзэхдээ хүмүүс язгуурын тэмдэг, аюулыг зайлуулах сахиус гэж бишрэн айжээ. Нэг ажилчин үймээнийг далимдуулан Ремедиосын гэдэснээс базаад авсан нь үлгэлэвээс бүргэд ангалын ирмэгээс зуурдагтай адил болжээ. Энэ тухай Ремедиос хэнд ч хэлсэнгүй. Хурц гэрэл агшин зуур нүдийг нь гялбуулах мэт болж, дээрэлхсэн этгээд тийш эргэн үзвэл зүрх шимшрэм цөхөрнгүй харж байгааг нь үзэхдээ өрөвдөх сэтгэл төржээ. Үдэ нь Туркийн гудамжнд энэ ажилчин тэгж хүрснээ ид хав болгон ярьж, биеэ их азтай гэж сайрхаж байтлаа хэдэн хувь болоод адуунд цээжээ хэмх өшиглүүлэн, хэсэг харийнхан үхэж байгаа хүн дээр очвол цаадах нь зам дээр цусандаа хахаж цацан амь тэмцэн татвалзаж байлаа.

Сайхан Ремедио үхэл тарих увьдастай гэсэн таавар дөрвөнтөө гарцаагүй нотлогдлоо. Сайрхах дуртай эрчүүлээс мэр сэр хүн ийм хөөрхөн хүүхэнтэй нэг шөнө өнгөрөөвөл үхсэн ч хамаагүй гэж ярих боловч хэрэг дээрээ хэн ч тэгж чадсангүй. Хайр дурал гэдэг хүн үүсэхтэйхамт бий болсон хамгийн эгийн сэтгэлтэй л байсан бол хэн ч Сайхан Ремедиосын сэтгэлийг эзэмдэж чадаад түүнд ойртоход учрах аюулд автахгүй байх байсан боловч чухамхүү ийм сэтгэлтэй болох гэж хэний ч толгойд орсонгүй. Урсула жич охиноо анхаарахаа бүрмөсөн болив. Урьд нь охиыг олны төлөө аврах гэж найдсаар байхдаа арг гэрийн жирийн ажилд дуртай облгох гэж оролдоож байлаа. “Эрчүүдэд чиний боож байгаагаас илүү их юм хэрэгтэй. Чиний бодож байгаас гадна хоол бэлдэх, шал шүүрдэх, аар саар юманд санаа зовох гэж бас байна” гэж их л учиртай хэлдэг байлаа. Тачаалаа хангачихаад Ремедиосын ухаанд



багтамгүй цалгар назгайг ганц өдөр чаутгай тэвчих эр хүн ертөнцөд байхгүй гэдгийг Урсула баттай мэдэж байсан учир жич охиндоо гэр бүлийн жаргал эдлүүлэх гэснээрээ биеэ хуурч байна гэдгээ мэдэж байлаа. Отгон Хосе Аркадио төрж, түүнийг пап лам болгох гэж хатуу шийдээд жич охиныхоо хойноос санаа тавихыг арга буюу больжээ. Тэгээд заяа нь мэдтүгэй, бөөрөнхий хорвоод юу эс болохыг тэр гэх вэ, хар толгойдоо булуу хураах бодь амьтан дайралдана биз хэмээн боджээ. Амаранта Ремедиосыг гэрийн ажилд сургах гэж оролдохоо Урсулагаас өмнө больсон юм санж. Бүр урьд нь ажлын өрөөнд зээнцэр нь үгүйдээ гэхэд оёдлын машины гэр эргүүлэхэд ч дургүйлхдэгийг Амаранта үзэхдэ эердөө л тэнэг юм байна гэж боджээ. Амаранта “Чамайг сугалааны хонжворт тавива таарна” гэж хэлдэг байлаа. Хожим нь Урсула Ремедиосыг “Сүмд очихдоо нүүрээ гивлүүрээр хааж бай” гэхэд Амаранта ингэж битүүлбэл анхаарал татаж, туйлын сониуч нэг эр гарч ирээд сайхан бүсгүйн зүрхэнд байгаа эмзэг газрыг тэвчээртэй эрж болзошгүй гэж горьджээ. Гэтэл бүсгүй, хүн тайжыг ч аль ч талаараа дагууламгүй санагдсан хархүүг халгаасангүйд Амаранта горь тасарчээ. Фернанда Ремедиосыг ойлгоё гэж ч бодсонгүй. Цуст багт наадмын үеэр түүнийг дагины хувцастай анх хараад эгэлгүй амьтан байна гэж санажээ. Гэвч Ремедиосыг хоолоо хуруугаараа этэн идэж, ганц ухаалаг үгийн хариугүйд Буэндиагийнхнаас ухаан дутуучуул нь урт насалдагт харамсжээ. Хуранаа Аурелиано Буэндиа Ремедиосыг өөртэйгөө уулзаж учирч явсан хүмүүсийн дотроос хамгийн ухаалаг хүн гэж итгэдэг, хэлдэг, хүнийг даажигнах чадлаа гарган минут бүр нотолдог боловч төрөл төрөгсөд нь бүсгүйгд зөнд нь орхижээ. Сайхан Ремедиос ийнхүү ганцаардахуйн цөлөөр огтхон ч зовж зүдрэлгүй тэнүүчилж, ер хардарж зүүдэлдэггүй тайван нойрссоор, ямар хуваарьгүй хооллосоор, огт дурсах саах юмгүй удтал дугүй явсаар аажимдаа насанд хүрч байлаа. Гуравдугаар сарын тэрнэгэн өдөрхүртэл ийм байлаа. Тэр өдөр Фернанда цэцэрлэгт татсан хэцнээс цагаан даавууг авч эвхэх гэж бүсгүй сүвтэй бүхнийг элбэлүцүүлэхээр дууджээ. Тэд ажлаа эхэлж амжаагүй байтал Амаранта Ремедиосын царай нь цайгаад, тэр ч байтугай шингэрээд явчих шиг болохыг ажиглаад,

- Яав бие чинь муу байна уу? гэж асуув.

Цагаан даавууны нөгөө сэжүүрээс барьж байсан Сайхан Ремедиос:

- Үгүй ээ, харин ч хэзээ ч ийм сайн байгаагүй гэж шаналангүй инээмсэглэв.

Ремедиос дөнгөж ингэж хэлтэл гялтганасан урьхан салхи гарч, Фернандагийн гараа сцагаан даавууг алдуулж, агаарт энгэрээр нь дэлгэжээ. Амарантагийн банзлын тор үл мэдэг хийсэншиг болох тэрхэн агшинд Сайхан Ремедиос унахгүйн тул цагаан даавууны булангаас зууран дээш хөөрч эхлэв. Бараг таг сохорсон ч гэсэн ухаан саруулхан хэвээр байгаа Урула л энэ дийлдэшгүй салхи ямар салхи болохыг мэдэж, гуялалзсан урьсгалынх нь аяар

цагаан даавууг тавин харвал Сайхан Ремедиос дэрвэлзэх цасан цагаан даавуун дунд салах ёс гүйцэтгэн гар даллан далласаар хөрөхөн оож, цон нисэж, мандирваа цэцэглэх агаарын давхрааг орхиод, өдрийн дөрвөн цаг ч болоогүй байсан агаарыг нэвтлэн гараад, ой дуртгалын хамгийн өндөрт нисэгч шувуухайн ч гүйцэхээргүй алсын тэр агаарт үүрд замхран алга боловай.

Бүсгүй явж явж, хатан зөгийн хаашаа ч зайлахгүй үйлээ дагаж, харин гэрийнхэн нь түүний нэрийг бодон тэнгэрт хөөрсөн гэсэн үлгэрзохиож байна шгэж харийнхан боджээ. Жөтөөрхөж үхэх дөхсөн Фернанда ид шидэд яваанда итгэх болж сүүлд нь цагаан даавууг минь эргүүлж өгөөч гэж эзэн тэнгэрийн чихийг удтал халууцуулжээ. Макондогийн хуучцуулын олонх нь ид шидтэнд итгэж, зул өргөж, хойдхын ерөөл унших боллоо. Хурандаа Аурелиано Буэндиагийн бүх хөвгүүдийг зэрлэгээр хядсан тухай мэдээ хотод тарж улс амьтныг хиртхилигэн айлгаагүй сэн болтэр гахйалтай явдлын тухай их л удаан ярилцах байсан биз ээ. Хүүхдүүд нь эмгэнэлтэйгээр үрэгдэх нь гэж совин татаад байсан боловч тэр зөн барим тавим болоогүй байлаа. Хөрөөчин Аурелиано Аркайя Ауреиано хоёрыг харийнхны дүйвээнээр ирж, Макондод сууя гэхэд эцэг ньхэрэггү йгэж хорьжээ. Харанхуй болоход л гудамжаар явах аргагүй болсон хотод тэдний юу хийхийг ойлгохгүй байлаа. Гэвч бага Аурелианогоор дэмжүүлсэн Арвай Аурелиано, Гуниг Аурелиано хоёр үйлдвэр дээрээ тэдэнд ажил өгчээ. Хурандаа аАурелиано хэдийгээр яагаад байгаа нь тодорхойгү йболовч тэдний тэгж шийдсэнийг нэг л сайшаахгүй байлаа. Макондод үзэгдсэн анхын машин буюу бүхээгийг нь буулгадаг, хотын нохдыг хуцтал чарладаг дохиотой ягаан машинд ноён Брауныг сууж явааг хуучин дайчин харахдаа энэ гриног хүмүүс зусардан билбүүрдэж байгаад эгдүүцэн, буу үүрэн, эхнэр хүүхдээ орхин, дайнд мордож байсан тэр үеэс хойш эрчүүдийн зан нэгл өөрчлөгдсөнийг ойлгожээ. Неерландын гэрээнээс хойш хотын ядарсан номой консервативчуудын дотроо сшилэгдсэн, ямар ч санаачилга гарагах эрхгүй хотын дарга нэр зүсэншүүгч нар Макондод эрх барьж байлаа. Хурандаа Аурелиано Буэндиа дан модон бороохойгоор зэвсэглэсэн хөл нүцгэн цагада нарыг хажуугаараа өнгрч явахыг харахдаа “Увайгүйчүүдийн захиргаа гэдэг энэ. Бид өчнөөн дайтахдаа байшингаа хөхөөр буудалхгүй гэж л байлдсан хэрэг байж” гэж хэлдэг байлаа. Гадилын кмодани байгуулагдахад нутгийн түшмэдийн орыг зоргоороо туйлдаг харийнхан авч, ноён Браун өндөртушаалынхаа эрх ямбыг тааваар эдлэг, халуунд халалг?й шурмууланд хатгуулалгүй, ер нь хотод суудаг хүмүүсийн үзэж байдаг зовлон зүдгүүрийг бүү амсаг гэж тэднийг цахилгаанжуулсан хонуурьт суулгажээ. Урьдын цагада нарын орыг мачете барьсан хөлсний алуурчид эзлэв. Хурандаа Аурелиано Буэндиа урланаа түгжин суугаад, эдгээр өөрчлөлтийг эргэцүүлж, хийсэн дайныхаа эцсийг үзээгүй нь засахын араггүй алдаа байсныг ганцаараа зожгорон суусан урт удаан жилд анх удаагаа батай ойлгон зүрх шимширчээ. Яг энэ үеэр бүгдийн аль эрт мартчихсан хурандаа Магнифико Висбалийн ах долоон настай

ачийнхаа хамт талбайн нэг мухлагт нимбэгийн ундаа уух гэж очжээ. Жаал хүү санамсаргүй хажуудаа байсан цагдаагийн бага даргын дүрэмт хувцсан дээр ундаагаа асгачихсанд тэр зэрлэг этгээд хурц мачетегаар жуаал хүүг тас тас татаад, ачаа өмөөрсөн өвгөний толгойг ганцхан цавчаад хаячихжээ. Өвгөний толгойгүй биеийг хэдэн эрчүүлд гэр рүү нь дамжлан хүргэж, нэгэн эмэгтэй толгойг үснээс нь барин явж байгааг болон бхүүхдийн цогцсыг ус облсон хүүдйд хийсэн байхыг хот даяараа харжээ.

Хурандаа Аурелиано Буэниа үүнийг үзэхдээ нүглээ наманчилж суухаа болив. Галзуу нохойд хазуулсны учир цэрэгт бууны бөгсөөр цохиулж үхсэн эмэгтэйн хүүрийн дэргэд залуудаа уур омог шатаж байсан шигээ дахину ур хилэн бадарчээ. Тэрбээр гудамжинд үгэнд дурлан бөөгнөрч зогсоо улсыг харж, өөрийгөө хязгааргүй үзэн ядсанаас дахин сэргэсэн аянга мэт дуугаар цээжиндээ багтахгүй оволзох жигшил хорслоо гаргаж

- За байзаарай, удахгүй би хөвгүүддээ буу өгөөд, энэ муусайн гринго нарыг цааш харуулуулъяа, гайгүй! Гэж занажээ.

Дараагийн долоо хоногт үл үзэгдэх этгээдүүд эрэг хавийн газраар хурандаагийн арван долоон хөвгүүнийг чандага аятай авлав. Тэгэхдээ тэдний үнсэн загалмайн голыг яг онохыг хичээх ажээ. Гунигт Аурелианог ээжийнххээ гэрээс оройн долоон цагт гартал харанхуйд буу тасхийж, сум яг цохонд нь туссан байлаа. Арвай Аурелиано голдуу цохонд нь туссан байлаа. Арвай Аурелиано голдуу хонодог үйлдвэртээ орон дээрээ үхсэн байхыг үзвэл хөмсөгний нь хооронд мөс хагалдаг төмрийг ишинд нь тултал шаасан байлаа. Хөрөөчин Ауреиано сэтгэлт бүсгүйгээ киноноос гэрт нь хүргэж өгөөд, Туркийн хурц гэрэлтэй гудамжаар харьж явтал алуурчин түүнийг гар буугаар буудаж, буцалж байгаа тогоотой тосонд унажээ. Алуурчин нь бөөн улсын дунд олдсонгүй. Үүнээс таван минутын дараа Аркайя Аурелианогийн нэгэн эмэгтэйтэй байж байтал өрөөний үүдийг хүн тогшиж “Бушуулаарай, ах дүү нарыг чинь алж байна” гэж хашгирчээ. Эмэгтэйн сүүлд ярих нь: “Аркайя Аурелиано орноос суга үсрэн босоод, халага нээтэл хаалганы цаанаас маузераар тархийг нь хага бууджээ”. “Үхэл нүүрлэсэн энэ шөнө гэрт дөрвөн бүрлээчийн хойноос ном уншихаар бэлтгэж байхад Фернанда нөхрө хотоор эргэн ухаангүй харайлгажээ. Гэтэл хурандаагийн нэртэй бүхнийг хядаж байгаа юм байна гэж Петра Котес бодоод түүнийг хувцасныхаа шүүгээнд нуучихсан байжээ. Үл үзэгдэх дайсан духандаа үнсэн загалмай зураастай ах дүү нарт л хилэгнэсэн болох нь авсан цахилгаан утаснаас тодорхой болсон тул Петре Котес, Бага Аурелианог тэндээс дөрөв хонуулаад гаргажээ. Амаранта зээ нарынхаа нэрийг бичсэн дэвтрийг олж аваад цахилгаан утас ирэхийн тоогоор нэрийг нь дарсаар байтал хамгийн ууган нь нэр үлдсэн байлаа. Бор арьстай, гэрэлтсэн ногоон нүдтэй тэр хүнийг гэрийнхэн сайн санаж байлаа. Түүнийг Амраг Аурелиано гэдэг, салбар уулсын хөндийд байдаг сууринд мужаан хийдэг байлаа.

Түүнийг алуулсан тухай мэдээ ирэх байх гэж Бга Аурелиано дэмий л хоёр долоо хоног хүлээгээд, юу ч мэдээгүй сууж байх гэж бодон амь насанд нь аюул учраад байгааг дуулгахаар элч мордуулжээ. Элч амраг Аурелиног аюулаас мултарсан гэсэн мэдээтэй эргэж иржээ. Ах дүү нарыгхядсан шөнө хоёр хүн ирж, гар бууныхаа бүх сумыг түүнд зориулсан боловч духан дэрэх загалмайг нь онож чадсангүй. Амраг Аурелиано хашаа даван зугтаж, өөрт нь мод зардаг индианчуудтай найз байсны хүчээр жим бүрийг андахгүй тул ууланд нуугдаж амжжээ.Түүний сураг тэгээд тасарчээ.

Хурандаа Аурелиано Буэндиагийн хувьд энэ нь хар өдөр байлаа. Улсын ерөнхийлөгч утас ирүүлэн эмгэнэл илэрхийлж, талийгаачдыг магтан, хэргийг нарийн нягтална гэж амлажээ. Ерөнхийлөгчийн тушаалаар хотын зөвлөлийн дарга оршуулах ёслолд дөрвөн цэцэг авчран, аван дээр тавих гэхэд хурандаа түүнийг гудамжинд хөөж гаргажээ. Оршуулгын дараагаар, улсын ерөнхийлөгчийн нэр дээрхатуу үгтэй цахилгаан бичиж, шуудангийн конторт биеэр аваачиж өгсөн боловч холбоочин дамжуулахаас татгалзав. Тэгэхэд нь түүндээ туйлын зэвүүрхсэн өгүүлбэр нэмээд,дугтуйд хийж, шуудангаар явуулав. Тэрбээр уй гашууд автсангүй, харин уур хилэн нь чинээндээ тулж, яаж ч чадахгүй байгаадаа арга нь барагдаж байлаа. Гэргийнхээ бие барахад ч, дайны үеэр анд нөхдийнхөө аль сайныг нь амь эрстэхэд ч олонтаа ингэсэн билээ. Тэр ч байтугай Антонио Исабель ламыг алуурчдын хамсаатан, дайсны танихад амархан байлгах гэж хүүхдүүдийн нь духанд арилахгүй загалмай санаатайгаар зурсан гэж зарлажээ. Ухаан ялихгүй орон гаран болсон, сэтийннээс ном айлдахдаа Ариун судрыг гуйвуулан тайлбралаж мөргөлчдийг айлгах болсон өтөл өвгөн лам мацгийн эхний өдөрт зориулсан нс зуурдаг цөгцөө аван тэднийд ирж, энэ үнсээрээ гэрийнхнийг зурж, усаар амархан угааддагийг батлаж гэжээ. Гэвч золгүй явдал хүмүүсийн зүрхийг авчихсан тул Фернанда хүртэл зуруулахыг зөвшөөрсөнгүй бөгөөд Буэндиагийнхнаас мацгийн анхын өдөр мөргөлийн сүмд өвдөг сөхөрч байхыг хэн ч түүнээс хойш харангүй болно.

Цаг явсаар байсан боловч хурандаа Аурелиано Буэндиа тайвширч чадахгүй байлаа. Алтан загасаа дархлахаа болиод албан хүчээр л юм идэж, цуваа шалан дээгүүр чирэн, дотроо бугсан бухимдсаар зүүдэн өвчтэй юм шиг тэр дотуураа холхино. Гурван сар өнгөрөхөд үс нь бүр цайж, урьд живэр сахлын нь үзүүр сөрвийн байдаг байсан бол одоо налбайн унших болсон боловч нүд нь төрөхдөө бүгдийг айлгасан шигээ, урьдын цагт сандал хөдөлгөдөг байсан шигээ адтай гялалзах боллоо. Тэрбээр цээжиндээ түймэр шатахад тэсэж чадахгүй, хоосон алдарт хүрэх аюулт замаар залуу зандан цагт нь өөрийг нь хөтөлж байсан тэрхүү зөн совинг сэргээх гэж дэмий л оролдов. Тэрбээр хэн нь ч,юу нь ч өчүүхэн төдий дотно санагдахаа больсон энэхүү хар элгийн гэрт төөрсөөр мөхөж байлаа. Дайны өмнөх үеийн ул мөр юу үлдэж вэ гэж нэг удаа Мелькиадесийн өрөөнд орвол хог тоос, олон жил эзгүй байснаас оворрсон новшноос өөр юм байсангүй. Эртнээс нааш хүн нээгээгүй х номын хавтас,

чийгэнд цохиулан хөвсийсөн хатуу цаас зэвхий цагаан хөгцөнд идэгдэж, хамгийн цэвэрхэн, тунгалаг агаартай байдаг өрөөнд ялзарсан дуртгалын тэсвэрлэшгүй үнэр ханх тавьж байлаа. Өөр нэг удаа Урсулаг туулайн бөөр модон доор талийгаач нөхрийнхөө өвдгөнд толгойгоо наан уйлж суухыг харжээ. Тэнхээт өвгөнийг тавин жилийн салхи шуурганд бөхийсөн байхыг харах хувь гэрийнхний нь дотроос ганц хурандаа Аурелиано Буэндиад ногдоогүй билээ. “Эцэгтэйгээ мэндлээч” гэж Урсула хэлжээ. Хурандаа модны дэргэд түр саатахдаа хоосон болсон энэ газрыг харахад ямар ч сэтгэл төрөхгүй байгаагаа бас дахин мэджээ.

- Өнөөдөр юу ярьж байна даа? Гэж хурандаагийн асуусанд Урсула:
- Уйтай байна аа. Чамайг удахгүй үхэх нь гэж боджээ гэж хариулбал хурандаа:
- Хүн үхэх ёстой болохоороо үхдэггүй, чадах цагтаа л үхдэг юм гэж заавд хэлээрэй гэж инээмсэглэжээ.

Талийгаач эцгийнх нь ингэж ёрлосон нь хурандаа Аурелиано Буэндиагийн цээжинд улалзан байсан бардам омгийн нурмыг дөнгөж хутгаснаас цаашгүй боловч тэрбээр тэр цогийн түр дүрсхийснийг урьдын хүч тэнхээ гэнэт ундрал ирлээ гэж эндүүрчээ. Тэгээд хутагт ээжээрээ хэлүүлэх гэж хоргоожээ. Хашир хүн гэж хаширсан хүнийг хэлнэ гэгчээр Урсула “Түүнийг хэзээ ч чамд хэлэхгүй ээ. Мөнгөний эзэн нь ирэдэ л гаргаж авна биз” гээд огт хавьтуулсангй. Хомхой сувдаг сэтгэлгүй байсан хүн мөнгө олох гэж өдрийн бодол, шөнийн зүүд болж, тэгэхдээ өдөр тутмын хэрэгцээнд хэрэглэх хэдэн зоос бус, тоймгүй их мөнгө олохгэх болсон учрыг хэн ч олохгүй байлаа. Хэдий хэр их мөнгө хэрэгтэй байгааг нь дөнгөж дуулахдаа Бага Аурелиано мэл гайхаж хоцорчээ. Хуучин намын нөхөд нь хурандаагийн мөнгө гуйснаас хойш уулзалгүй зугтах болов. Яг энэ үед тэрвээр “Либералиуд өглөөний мөргөлд очдог, консервативчуул үдшийн мөргөлд очдогоороо л ганц ялгаатай юм байна” гэж хэлжээ. Гэвч хурандаа байдгаараа мэрийж улс амьтнаас өөд уруугүй шалж, нэр төрөө ч бүр гаргуунд нь гарган улайран чармайж улангасан зүтгэсээр газар бүрээр орж баймааж нь найман сарын дотор Урсулагийн нууснаас их мөнгө цуглуулж чадав. Тэгээд өвчтэй хурандаа Геринельдо Маркес дээр очиж, даяар олныг хамарсан шинэ дайн үүсгэхэд туслахыг гуйжээ.

Хурандаа Геринельдо Маркес саад баригдан оронд хадагдсан боловч нэг хэсэгтээ бослогын зэвэрсэн хөшүүргийг хөдөлгөж чадах цорынганц хүн үнэхээр байсан юм. Неерландын гэрээний дара ахурандаа Аурелиано Буэндиаг алтан загасаар сэтгэлээ зогоож байх зуур хурандаа Геринельдо Маркес эцсээ хүртэл үнэнч байсан босогчдын офицеруудтай холбоо барьж байлаа. Тэдэнтэй хамт тэрбээр өдөрбүр басамжуулан айлтгал, итгэл бичж, “Маргааш ирээрэй”, “Одоо удахгүй”, “Та бүхний хэргийг зохих ёсоор анхааралтай судалж байна” гэх хариуг элтэл сонссон юм. Энэ нь нэг ёсондоо дайн байлаа. Тэгэхдээ энэ бол

ялагдах учыиртай дайн, ахмад, зүтгэлтгнүдэд насан туршийн тэтгэвэр өгнө гэж амлаад, хэзээ ч олгоогүй “та нарыг хүндлэгч” “та бүхний дуулгавартай зарц” гэж өөрийгөө нэрлэгчдийн эсрэг дайн байлаа. Дайнаасаа дажин гэгчээр хорин ижл үргэлжилсэн цуст дайнд, тэр хүмүүс үргэлж луу уншиж энэхүү дайнаас бага хохирсон билээ. Амь насанд нь гурвантаа халдахад амьд үлдэж, тавантаа шархтаад үхэлгүй тэсэж, тоо томшгүй хүнд туладаанаас эсэн мэнд гарч байсан хурандаа Геринельдо Маркес нэг насаараа хүлээхийн хэцүүг давалгүй, хөгшрөх гэдэг эцсийн бүрэн ялагдлаа хүлээгээд, шалан дээр цонхоор туссан нарын дөрвөлжин гэрлийг харан, ганхуур сандал дээрээ Амарантаг обдсоор сууж абйдаг болжээ. Хамтран зүтгэгчтэйгээ дахин уулзсангүй, тэднээс хэд нь улсын ээлжит ерөнхийлөгчийн хамт зургаа авахуулсан нь сонинд нийтлэгдсэн байхыг л ганц үзжээ. Хурандаа Геринельдо Маркес тэр ерөнхийлөгчийн нэрийг мэдэхгүй байлаа. Дайчид асны нүүрэн уур хилэн тодхон илэрчээ. Ерөнхийлөгч өөрийн дүртэй тэмдгийг энгэртээ зүүж явгэж тэдэн бэлэглээд, цус нөж, тоос шороо болсон нэг тугийг үхэхдээ авсаа бүтээгээрэй гэж тэдэнд эргүүлэн өгчээ. Хамгийн тэтгэмж авбал зохих ахмадууд олны хайрлах хишгийн хар буланд тэтгэвэр хэзээ тогтоохыг өнөө болтол хүлээж, зарим нь өлбөрөн, бадарсан хилэнгийнхээ хүчээр бусад нь амьдрач, хамгийн муу нэртэйгээр аажмаар өтлөн өнгөрч байлаа. Иймэс хурандаа Аурелиано Буэндиаг үхэх сэхэхээ үзэх хайр найргүй дайны галыг, гадаадын булаан эзлэгчдээр дэмжүүлсэн өмхөрч гүйцсэн шившигт дэглэмийг газрын хөрснөөс арчин хаях дайны түймрийг шатаая гэж ирэхэд хурандаа Геринельдо Маркес өрөвдөх сэтгэлээ барьж чадсангүй.

- Ай Аурелиано минь, чамайг хөгширсэн гэж би мэдэж байсан, бодсоноос хавьгүй хөгширснийг одоо л ойлголоо гээд санаа алджээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Сүүлийн хэдэн жилийн хөл үймээн дунд Урсула Хосе Аркадиоог пап ламын сэнтийд суулгахаар бэлтгэх зав олж чадахгүй байсаар байтал шашны сургуульд явуулах хугацаа нэгэнт тулж, алдсанаа сандан мэгдэн нөхөх хэрэг гарав. Хосе Аркадиогийн охин дүү, хатуу Фернанда, гутруу Амаранта хоёрын хамжин өсгөсөн Меме бараг энэ үед хийдийн сургуульд орж, даруулт хуур тоглож сурах насанд хүрчээ. Лам болох унжгар хүүгийн сэтгэлийг хатуужуулахад хэрэглэж байгаа аргаа төдий л тустай биш санагдахад Урсула эргэлзэн зовж, үүний бурууг насанд дарагдсандаа өгөхгүй, бас ч гэж гэгээтэй байгаа болохоор нүдээ хаасан хар үүлэнд ч өгөхгүй, өөрийн яг тэр гээд хэлчихэж чадахгүй байгаа нэг л зүйлээс, цагийн ханшийг муутгаж байна гэж өөрийн бүүр түүрхэн төсөлөж байгаа нэг л зүйлээс хамаг юм болж байна гэж үзэж байлаа. Өдөр тутам хийдэг нь бүтэж өгөхөө больсонд бухимдан, “цаг

урьдынхаасаа огт өмнөө болжээ” гэж үглэдэг байлаа. Урсула урьд хүүхдээ яасан өсөж өгдөггүй юм бэ гэж боддог байжээ. Одоо болохноо, ууган хүү Хоес Аркадио нь цыган дагаад явчихаас өмнө хэчнээн их хаугцаа өнгөрч вэ, биеэ зөгий шиг эрээлчихсэн, хлэ яриа нь зурхайчийнх шиг ойлгодохгүй болчихсон ирэхээ сурьд хэчнээн юм болж вэ, Амаранта, Аркадио хоёр индиан хэлийг мартаж, испаниар ярьдаг болтол гэрт нь хэчнээн юм болж вэ, хөөрхий Хоесе Аркадио Буэниа туулайн бөөр модны доор хэчнээн өдөр, хэчнээн шөнө суув, түүний үхэхэд хэчнээн удаан уй гашуу болов, хурандаа Аурелиног гэрт үхлүүт авч иртэл хэчнээн шар махтайгаа хатав! Төчнөөн удаан дайтаж, төчнөөн зовлон зүдгүүр үзсэн мөртлөө Аурелиано тэгэх тавь ч хүрээгүй байж шүү. Урьд нь Урсула бүтэн өдөржин мөсөн чихэртэй зууралдаад хажуугаар нь хүүхдэдээ нүд тавиад, харцаар нь тосон туулга өгөх цаг болжээ гэдгийг мэдэж болоод байдаг сан. Гэтэл одоо өглөөнөөс орой болтол Хоесе Аркадиог харахаас өөр огт хийхн юмгүй байтлаа цаг муудсаны харгаагаар нэг ч ажил гараас гаргаж амжихгүй байлаа. Үнэндээ гэвэл Урсула хэдэн настайгаа ч мэдэхээ болиод, өөрийгөө хөгширсөн гэж бодохгүй байтлаа цаг муудсаны харгаагаар нэг чажил гараас гаргаж амжихгүй байлаа. Үнэндээ гэвэл Урсула хэдэн настайгаа ч мэдэхээ болиод, өөрийгөө хөгширсөн гэж бодохгүй, хаа л бол чихэлдэж, юм юманд хошуу дүрж, “Хутагт Иосифын баримлыг бороо өнгөртөл байлгах гэж орхиогүй биз?” хэмээн гадаадынхныг үргэлж шалгаан тэдэнд ад болж байлаа. Хэдийд Урсулагийн хараа муудаж эхэлснийг хэн ч сайн хэлж чадахгүй байлаа. Түүнийг үхэхийн өмнөх хэдэн жилд хэвтэрт орсон хойнонь ч хүмүүс насны доройтол болж гэж боож байснаас биш таг сохорсон гэж мэдсэнгүй. Урсула нүдээ муудаж байгааг Хоесе Аркадиог төрөхийн өмнө мэджээ. Эхлээд өвчин хүрч гэж бодоод толгойн ясны шөл сэмхэн ууж, зөгийн бал нүдэндээ дусаасан боловч харанхуй манан нүдийг нь улам бүрхэж байгаад удалгүй итгэжээ. Тийнхүү цахилгаан гэрэл гэж юу болохыг төдий л мэдэхгүй хоцров. Учир нь Макондоод анхны цахилгаан дэнлүү тавихад Урсула бүдэгхэн туяа татлаа гэхээс цаашгүй болсон байв. Сохорч байгаагаа ганц ч хүнд хэлсэнгүй, хэлбэл өөрийнхөө хэнд ч хэрэггүй амьтан болсноо нийтэд мэдэгдэн гэсэн үг байлаа. Урсула хүнд мэдэгдэлгүйгээр юмсын хоорондох зай, хүмүүсийн хоолойг махран тогтоож, гэрэлт ертөнцийг нүдээрээ харахгүй болохын цагт ойгоороо харах гэж бэлджээ. Сүүлд нь үнэр гэнэт сайн ялгах болсон нь тус болж, харанхуйд юмны бараа, өнгийг бодвол үнэр хавьгүй тод мэдэгдэж, шившигтэй илчлэгдэхээс аврагдав. Урсулагийн хувьд орчлон хав харанхуй болсон боловч зүү сүвлэж, товчны нүх эмхэрдэж, сүү хөөрснийг дор нь мэддэг байлаа. Ямар газар ямар юм байгааг андахгүй санаж байсан тул заримдаа өөрөө сохорсноо ч мартаж орхидог байлаа. Нэг удаа Фернанда хуримын бөлзгөө алга болчихлоо гэж гэрээрээ нэг орь дуу болонд Урсула хүүхдийн унтлагын өрөөний жижиг тавиур дээрээс олж өгчээ. үүдн нэг сүрхий юм байсангүй. Гэрийнхнээ гэр дотуур цааш нааш холхиж байхад урсула гэнэдэж баригдахгуйн

тулд бүтэнүлсдэн мэдрэхүйн дөрвөн эрхтэнээрээтэдний хөдөлж явахыг ажиглаж, хүн бүр өөрөө мэдэлгүй нэг л замаараа явж, нэг л ижил хөдөлгөөн хийж, бараг нэг л цагт нэг л ижил үг хэлдгийг удалгүй мэджээ. Тэгэхлээр юм гээнэ гэдэг тэр сурсан журмаа зөрчсөн хэрэг. Иймээс Урсула Фернандагийн үглэн дуулахыг сонсохдоо, тэр өдөр түүний сурснаасаа өөр юм юу хийлэ эгэж боод Меме шөнө нь бясанд хазуулсан учир хүүхдийн орны сийрсийг салхинд тавьсныг санажээ. Фернандаг тэгж байхад хүүхдүүд дэргэд нь байсан учир тэдний хүрэхгүй цорын ганц газар болох тавиур дээр бөлзгөө тавьсан байж таарна гэж боджээ. Фернанда болохоор бөлзгөө явдаг газраараа л хайж, чухамхүү сурсан зандаа баригдаад хаясан юмаа олж чадахгүй байгаагаа мэдэхгүй байжээ.

Хосе Аркадиог сургаж хүмүүжүүлж байсныхаа хүчинд Урсула гэрийнхээ юмыг яльгүй өөрчлөгдөхийг андахгүй мэдэж байлаа. Ухаа нь Амаранта унтлагын өрөөнд хутагтуудын барималд хувцас өмсгөж байна гэж дуулахдаа жаал хүүд өнгө ялгаж сургаж байгаа дүр үзүүлж,

- За их сахиулсан Рафаилийн хувцас ямар өнгөтэй байна, хариулаарай гэнэ.

Тийнхүү Урсула жаал хүүгээс хэрэгтэй юмаа мэдэж авна. Түүнийг шашны сургуульд явахаас бүр өмнө Урсула хутагт нарын баринтгийн даавууг тэмтэрч үзээд л өнгийг нь мэдэж сурчээ. Заримдаа огт санаандгүй юм болно. Нэг удаа Урсула хайтан цэцэгт гонхонд юм хатгамаллан суусан Амарантаг очиж мөргөжээ.

- Тэнгэр минь, мөрөө харж яваач гэж Амаранта ондууцсанд Урсула:

- Чи л байхгүй юу, суудаг гараа суухгүй гэж хариулжээ.

Урсула өөрийнхөө зөв гэдэгт баг итгэж байв. хэсэг бодож байгаад жилийн улирал солигдохын хэрээр нар тэнгэрт байраа аажмаар мэдэгдэхгүй өөрчилдөг, гонхонд суугчид өөрсдөө мэдэлгүй суудла аялихгүй хөдөлгөн өөрчилдөг байна гэж урьд нь хэний ч толгойд ороогүй юмыг гэнэт нээн олжээ. Түүнээ схойш Урсула Амарантагийн хаан сууж байгааг алдалгүй мэдэхийн тулд тэр өдрөө хэдэн болохыг зөвхөн санаж байх хэрэгтэй болов. Урсулагийн гар өдөр ирэх тутам улам салгалах болж, хөл нь тугалга цутгачихсан юм шиг даагдахаа больсон боловч атигар жаахан бие нь хаа л болнүдэнд өртөж байдаг байлаа. Урсула ар гэрийн бүх ажлыг ганцаараа үүрч байсан үеийнх шигээ шаламгай хэвээрээ байлаа. Насан зүг болсон хойноо нарны гэрэл үзэхгүй ганцаардан байхдаа гэрийнхээ дотор болж байгаа өчүүхэн төдий явдлын учрыг туйлын гярхай тайлах болж, урьд борви бохисхийлгүй зүтгэж байснаас олж үзээгүй байсан юмаа анх тодоос тод үзжээ. Хосе Аркадиог сургуульд оруулахаар бэлтгэж байхүеэр Буэндиагийн гэр бүлийн бүхий л амьдралыг нэгд нэгэнгүй эргүүлэн бодож үзээд, үр ач нарынхаа тухай огт өөр бодолтой болжээ. Хурандаа Аурелиано Буэндиа Урсулагийн урьд бодож



явсан шиг дайнд хатуу сэтгэлтэй болоод гэрийнхнийгээ гэхээ байсан бус, шрөөсөө л эхнэр Ремедиостдоо ч, нэг шөнө энгэр зөрүүлээд өнгөрсөн олон хүүхэндээ ч ялангуяа хөвгүүддээ хайргүй болжээ гэж Урсула итгэв. Хурандаа Аурелиано Буэндиа бүх хүний боддог шиг идеализм баримталдагдаа ч өдий төдий дайн хийсэнгүй, булт хүний боддог шиг ядарч залхсандаа ч баттай ялалтаас татгалзсангүй, харин жинхэнэ хилэнцэт ихэрхүү зантай байсан ганцхан л шалтгаанаар ялахдаа ялж, ялагдахдаа ялагдаж явжээ гэдгийг Урсула гадарлажээ. Аминаас илүү хайрладаг энэ хү нь төрөлхөөсөө хайрлах чадваргүй байжээ гэж дүгнэжээ. Уйлах нь их л өрөвдмөөр мөртлөө тодхон байж, хажууд унтаж байсан Хосе Аркадио Буэндиа сэрчихээд, зөнч хүн болох нь гэж бэлгэшээн баярлажээ. Бусад улс түүнийг далдыг хардаг хүн болох нь гэлцэж байв. Урсула өөрөө болохоор хэвлийд дуугарна гэдэг аймшигтай гахай сүүлтэй гарахын эхний ёр гэж гэнэт сэжиглэн цочоод, умайд нь алаад өгөөч гэж тэнгэрт гуйн мөргөжээ. Гэвч хэвлийд байхдаа хүүхдийн уйлсан нь зөнч, вивангардичийн бэлгэтийн тэмдэг бус, хайр сэтгэл байхгүйн гарцаагүй шинж гэж Урсула хөгширсөн хойноо ухаарахдаа ойлгож, үүнийгээ байн байн ярьдаг байлаа. Хүүгээ ингэж өөрөөр цэггнэх болсноос, хүүгээ өрөвч сэтгэлтэй болгож би л чадсангүй гэж ихэд өрөвджээ. Урсула Амарантагийн цэвдэг сэтгэлтэйгээс айж, түүний цаагуураа шаналж явдагт нь зовдог байлаа. Гэтэл Амаранта нь ялдам зөөлөн сэтгэлтэй эмэгтэ йхүний охь манлай байсан гэж одоо эхэд нь санагдаж, Пьетро Креспийг зүй бусаар зовоосон нь бусад хүний бодсон шиг өс авах гэж улайрсных бус, хурандаа Геринельдо Маркесийг удтал тамлан амьдралыг сүйтгэсэн нь бусад улсын үзсэн шиг хорлонт, шаралхуу, арилшгүй гутралынх ч биш гэж бодогдох болжээ. Үнэндээ бол аль алин нь хязгааргүй их хайр, туйлын аймхай зан хоёрын үхэх сэхэхээ үзсэн тэмцлийн уршиг байж, энэ тэмцэлд Амарантагийн энэлсэн зүрхийг зогсоо зайгүй тарчлааж байсан ухаангүй айдас дийлжээ. Тэр үед Урсула Ребекагийн нэрийг улам олон дуудаж сэтгэдээ дүрийг нь урьдынхаараа хайрлан дурсаж, хожимдсон гэмшил, гэнэтийн бахархал төрснөөс улам ч санаж, ангир уургийг нь шимээгүй, газрын шороо, ханын шохой идэж өссөн, Буэндиагийн яс махны тасархай биш, булшинд нь ч яс нь харжигнан дуугарсаар байсанүл таних улсын үр Ребека, сэтгэл яаруу, өвөр халуун Ребека л тэндээс цор ганцаараа хатан зоригтой, үр удмынхандаа байгаасай гэж мөрөөдөж байсан хатан зоригтой байсныг ойлгожээ.

Урсула хана тэмтрэн явахдаа

- Ребека минь, чамд би мөн ч мөсгүй аашилж байжээ гэж бувтнадаг байлаа.

Урсулаг сахиулсан Гаврийл мэт зөв гараа урагш сунган явах бослноос хойш дэмийрч байна гэж бүгдээрээ бодох болов. Гэвч энэхүү дэмийрлийн мананг далдыг харах нарны гэрэл гэнэт гийгүүлдгийг Фернанда ажиглажээ. Урсула сүүлийн жилд гэрт хэчнээн мөнгө зорсныг түгдрэлгүй хэлж чаддаг байлаа. Гал

зууханд эх нь бутанд шөл хутгаж байгаад, үгийг нь хүн чагнаж байгаа гэж мэдэлгүй “Анх ирсэн цыгануудаас худалдаж аваад, Хосе Аркадиоог дэлхийг жаран тав тойрохоос өмнө алга болсон эрдэнэ шишийн тээрэм одоо болтол Пилар Тернерагийн байгаа юм байна” гэж гэнэт хэлэхэд нь Амаранта мөн тэгж боджээ. Нас мөн л зуу хүрсэн ч эрүүл чийрэг, хөнгөншингэн хэвээрээ, урьд тагтаа шувуу үргэтэл инээдэг байсан бол одоо хүүхэд айхаар балхайж бүдүүрсэн Пилар Тернера Урсулагийн хэлснийг гайхсангүй, өтгөс настны үл саарах саруул ухаан заримдаа хөзрөөс мэргэн байдаг байна гэдэгт итгэж эхэлжээ.

Гэсэн хэдий боловч Урсула, Хосе Аркадиоог хөлийг нь дөрөөнд хүргэж амжихгүйгээ мэдээд сэтгэлээр унав. Зөнгөөрөө тод хардаг байсан юмаа нүдээрээ олж харах гэж оролдоод алдаж эндэх боллоо. Нэг өглөө жаал хүүгийн толгойд сүрчиг гэж эндүүрээд бэх хийчихжээ. Юм юманд оролцох гэж махран зүтгэсээр дараа дараагаар алдан будилж, улам улам сэтгэл гансрах болсныг мэдэж, өөрийг нь улам бүр хүлж байсан харанхуйн торноос гарах гэж дэмий л оролдож айлаа. Ингэж будлиу болсон нь нас өтөлсөн, нүд балайрсныг анх давж гарсны шинж биш, харин цагийн дэс алдагдсаны уршиг гэж гэнэт түүний толгойд зурсхийжээ. Турк худалдаачин перкааль даавуу хэмжиж өгөхдө өзалилдаг шиг эзэн тэнгэр сар жилийг холь хутгахаас өмнө бүх юм шал ондоо байжээ гэж тэр бодно. Одоо бол хүүхдүүд түргэн өсдөг болсноор барахгүй хүмүүсийн чанар урьдынхаас муудсан ажээ. Сайхан Ремедиос бие сэтгэлээрээ тэнгэрт хальж амжаагүй шахам байхад нүнжиггүй Фернанда “Цагаан даавууг минь яахлаараа аваад явчихдаг байна?!” гэж эндтэнд очиж янших болов. Арван зургаан Аурелианогийн шарил булшиндаа хөрч амжаагүй байхад Бага Аурелиано бөөн архичин гэртээ дахин авчирч, дуу хуур, архи дарс болж, христос шажинтан бус, золбин ноход үхсэн аятай аашилжээ. Эрүүл биеэ өвчтэй болтол зүтгэж, өчнөөн чихэр хийж зарж баймааж нь босгосон энэ галзуугийн байшин муу муухайн уурхай болох учиртай байжээ. Урсула, Хосе Аркадиоогийн хайрцагт нь юмыг нь хийж байхдаа болохгүй бүтэхгүй бүхнийг дурсан санаж, “Авсанд орж шороонд булуулсан нь дээргүй юү” гэж өөртөө хэлж, “Хүнийг төмрөөс бүтсэн, өчнөөн их зовлон даадаг гэж үнэхээр боддог уу?” гэж эзэн тэнгэрээс аймшиггүйе лавлаж, тийнхүү асуун лавлахдаа улам будлин орооцолдож байв. Харийнхан шиг толгойдоо орсон бүхнийг хэлж авах, ганцхан хором, богинохон агшинд нэг сайн агсам тавих юмсан гэж бодовч насан туршаа өөрийгөө гаргуунд гаргасаар ирсэн болохоор яршигшаадаг байснаа одоо нэг л нэг зад агсамнамаар болж, ганц удаа ч гэсэн юуг ч тоохыг байж, амьтны аяар явсан бүх л зуунд цээжиндээ хуримталсан муу үг бүрийг нэгмөсөн гаргамаар болно.

- Аа бузар цус! Гэж Урсула хашгирав.

Хайрцагт хувцас хийж байсан Амаранта ээжийгээ хилэнцэт хорхойд хатгуулчихлаа гэж бодоод,

- Хаана байна гэж сандран асуусанд
- Юу? Гэжээ.
- Хилэнцэт хорхойгэж Амарантагийн хэлэхэд Урсула зүрхэн тус хуруугаараа хатгаж,
- Энд гэж хэлжээ.

Нэгэн пүрэв гаригт Хосе Аркадио шашны сургуульд мордов. Хосе Аркадио явах үедээ алжаангуй, төвлөрөнгүй, өөрийн нь сургаснаар ганц ч нулимс унагалгүй, зэс товчтой, захандаа цардмал эрвээхийтэй ногоон хилэн косчомтой, халууцан бүгчимдсэн байснаар Урсула төсөөлж, тэр л байдлаар нь үргэлж санах болно. Хосе Аркадио явсан хойно Урсулагийн гэрт олоход амар байхгэж толгойд нь хийдэг байсан сүрчгийн үнэр өрөөнд үлджээ. Хүүг гаргаж өгөх хоолон дээр байхад гэрийнхэн нь сэтгэл хөдөлсөнө нуухгэж хөгжилдөн хөөрөлдөж Антонио Исабель ламын шог юм ярихад их л хөөрөнгүй тосож авч байлаа. Мөнгөөр бөгжилж, хилэнгээр бүрсэн хайрцгийг авч гарахад гэрээс авс аваад гарч байгаа юм шиг санагджээ. Хурандаа Аурелиано Буэндиа үдэлцэхээс татгалзаж,

- Энэ л бидэнд дутаж гэнэ. Ариун пап гуайтан! Гэж амандаа гүвтнэжээ.

Гурван сарын дараа Бага Аурелиано, Фернанда хоёр Мемег сүмийн сургуульд аваачиж өгөөд, даруулт хуур авчирч, оньст хуурын оронд тавив. Яг энэ үеэр Амаранта хулдас<sup>1</sup> шидэж эхлэв. Гадилын дон намдав. Макондогийн уугуул иргэд харийнханд түрэгдсэн боловч урьдын багаахан орлогоо арайхийн хадгалан үлдээд хөлөг онгоц живэхэд амьд гарсан мэт баярлажээ. Буэндиагийнх зочдыг урьж хооллодог хэвээрээ байлаа. Хэдэн жилийн гадилын компани байхгүй

1 Үхэгсдийг оршулахад өмсгөдөг хувцас Оросоор “саван” гэдэг.

Болсон хойно урьдын тайван амьдрал сэргэж билээ. Гэвч Фернанда хамаг юмыг мэддэг бослон учир урьдлын зочирхог уламжлал үндсээр өөрчлөгдөжээ. Урсула харанхуйн оронд цөлөгдөж, Амаранта оршуулгын хулдас толгой өөд татахгүй оёж, хаан ширээ горилогч асан хүүхэн хлэж барих хүнгүй болон дуртай хүндээ хоол өгөөд дургүйдээ өгөхгүй, эцэг эхийнхээ сургасан хатуу хэм хэмжээг тэдэнд тулгах болжээ. Буэндиагийн гэр Фернандагийн чанга гарт орон, харийнхны амархан олсон хөрөнгөө хамаа намаагүй үрэн аран хийж байгаад мэл гайхсан хотынхны дотор хуучирсан дадал зуршлын тулгуур болж байлаа. фернанда гадилын компанитай холбоогүй хүнийг л шударга төвшин хүн гэж үзэж байлаа. Тэр ч байтугай нөхрийнхөө ихрийн өрөөсөн Бага Хосе Аркадио

гадилын хумхаагийн эхний үеэр гайхамшигтай сайхан зодооч тахиагаа зараад, тариалан дээр харгалзагчаар ороход нь ад шоо үзэх болж,  
- Энэ харийнхны халдвараас ангижраагүй цагт түүнийг үүдээрээ шагайлгахгүй гэж хэлжээ.

Гэртээ байхад тэсвэрлэхийн аргагүй болсон тул Бага Аурелиано Петра Котесийнд тааваараа байх болов. Эхлээд эхнэрийн ажлыг хөнгөлөх нэрийдлээр найр наадмаа тэднийд хийх болов. Дараа нь мал үр төлө муутай боллоо гэдэг шалтаг заан үхрийн хороо, адууны жүчээг тийш нв зөөв. Эцэст нь нууц амрагийн сэрүүхэн юм гэж хэргээ явуулдаг жижиг контороотийш нь нүүлгэв. Фернанда нэг мэдвэл нөхөртэй нэр хэмээснээс цаашгүй болсон байлаа. Бага Аурелиано гэртээ бараг хоол идэхгүй шөнийн бор хоногт л нэг үзэгдэнэ. Энэ нь гадаа ёсыг бодсон хэрэг бөгөөд үүнийг нь цөмөөрөө мэдэж байв. Нэг удаа гэнэ алдаж, Птра Котесийн өвөрт өглөө болгочихсон байлаа. Одоо ч бөөн хэрэг мандлаа гэж бодож байсан чинь эхнэр нь өчүүхэн ч зэмлэсэнгүй, тэр ч байтугай гомдсондоо хөнгөхөн санаа ч алдсангүй боловч тэр өдрөтөө нууц амрагийн руу нь хоёр авдартай хувцсыг нь явуулсан байлаа. Тэгэхдээ гэгээн цагаан өдөр явуулж, хотын гудамжны голоор, хотынхны нүдэн дээр авч яв гэж тушааж, замаа алдсан нөхрө өийм гутамшгийг тэвчилгүй, байдгийнхаа баруун хаяанд толгойгоо унжуулаад буцаж ирэхгүй хаашаа гарах вэ гэж санажээ. Фернанда ийм баатарлаг зориг гаргаснаараа нөхрийнх нь зан, макондогийнхны араншин эцэг эх хоёрынх нь зантай огт хавьтахгүйг муухан мэддэг нь харагдав. Хоёр авдрыг харсан бүхэн тэр гурвын явдлыг нэгд нэгэнгүй мэддэг байсан учир ёстой юм ёсоороо л дууслаа гэж бодож байжээ. Аурелиано болохоор дураараа болж авсныгаа гурван хоног найрлан мялаажээ. Нөхрийнхөө гай дээр гамшиг нэмж Фернанда урт хар хувцас өмсөж, хэрэглэгдэхээ больсон зүүлт зүүж, илүүц бардам байдалтай байснаараа их л овортой харагдаж байхад жинхэнэ торгоор хийсэн содон палааж өмссөн нууц амраг нь алдсан юмаа эргүүлж авлаа гэж ойлгоснос нүд нь баяраар гийж, дахин залуужин гялалзаж байлаа. Бага Аурелиано Петра Котест дахин биеэ зориулж, ихрийнх нь өрөөсөнтэй андууран өөртэй нь унтаж, ах дүү хоёртой зэрэгявж байхдаа хоёрын дайтай хайрлаж чаддаг хүнийг тэнгэрээс заяаж, урьд өмнө байгаагүй аз дайрлаа гэж бодож байсан урьдын цагийнх шиг нь залуугийн цогоор биеэ зориулж байлаа.. Дахин сэргэсэн тачаал ханах гэж байхгүй, ширэнэд сууж байснаа бие биенийхээ нүдийг гэнэт хараад, үг ч дуугаралгүй, хувингийнхаа тагийг тагличихаад, янаглан амраглаж л байвал өлсөж үхсэн ч хамаагүй облж унтлагын өрөө рүү ордог байлаа. Бага Аурелиано францын дууч эмс рүү сэм үсэрч байхдаа харснаасаа санаа авч, Петра Котест хамба ламынх шиг лавиртай ор авч өгч, цонхонднь хамба хилэнхөшиг зүүж, улын болроор хийсэн асар ом толиор унтлагын өрөөний тааз, туургийг бүрхжээ. Тэгээд урьдынхаасаа ч илүү наргианч, ойворгон болжээ. Өдөр бүр өглөөний арван нэгэн цагт галт тэргээр

түүнд хайрцагтай , шампан дарс, бренди шарз ирнэ. Өртөөнөөс буцах замдаа Бага Аурелиано нугийн ч бай, явлуулын ч бай, таньдаг ч бай, таньдаггүй ч бай энэ тэр гэх юмгүй дайралдсан хүн толгойтой бүхнийг дагуулан авчирдаг, энэ нь үлгэрлэвээс гэнэт эхэлэн кумбиамбад<sup>1</sup> хүн бүр татагдан ордгийн адил ажээ. Тэр ч байтугай үлойлгогдох хэлээрээ ярьдаг бултамхай ноён Брауныг хүртэл дохиж зангаж байгаад авчирч Петра Котесийнд цаадах нь мал болтлоо хэд хэд ууж, тэр ч байтугай хаа л бол салахгүй дагуулж явдаг германы зуумхай нохойгоо техасын дууны

## 1 Кумбиамба- колумби ардын бүжиг

аянд нэг удаа бүжиглүүлж, өөрөө найраг баян хуурын эгшгийг даган арайхийн аялсан болж байлаа.

- Үнээнүүд минь, тугаллаад бай, тугаллаад бай, нас гэдэг ахархан гэж Бага Аурелиано сайхан зангаа хөдлөхөөр хашгирна.

Тэрбээр хэзээ ч тэр үеийнх шиг сайхан байсангүй, хэзээ ч үүнийг үүнээс илүү хайрлаж байсангүй, хэзээ ч мал нь ийм тоймгүй өсөж байсангүй. Буцаад ирэхэд булаг шиг оргилох, дайраад ирэхэд далай шиг цалгих найранд зориулж өчнөөн тугал, гахйа, тахиа нядалсан нь хашаан доторх газар цусанд бялдан харласан байж билээ. Цг, гэдэс дотрыг зогсоо зайгүй хаяж, хоолны үлдэгдлийг асгаж, энэ бүхнийг цаг тутам л шатааж байхгүй бол махчин шувуу зочдын нүдийг ухчих гээд байдаг байлаа. Бага Аурелиано хоолонд маш сайн, тэр ч байтугай Хосе Аркадиоогийн дэлхий тойроод буцаж ирсний дараа идэж байсантай ч зүйрлэхгүй сайн учир амархан таргалж, царай нь хүрэнтэж ягааран малийж, яст мэлхийн хоншоортой төсөөтэй болжээ. Бага Аурелианоогийн идэмхий, ер бусын үрэлгэн, ижилгүй зочломтойгн тухай цуу хөндийгөөс халин дуурсаж, хамгийн зартай ховдгуудын анхаарлын татажээ. Пьера Потесийнд болж байгаа юм идэх балай тэмцээнд оролцохоор цуутай цуутай хэнхгүүд эргэ орчмын бүх газраас Макондод ирж байлаа. Бага Аурелиано, Камила Сагастуме гэгчийг ирсэн тэр гайт бямба гариг хүртэл хэнийг ч өмнөө оруулахгүй байлаа. Тэр Камила Сагастуме гэгч бол улс орон даяар “мэгж” гэсэн учиртай хочийг олж зард гарсан, эрт үеийн хүн чулуу шиг болсон, хүн, амьтан хоёр нь бараг мэдэгдэхээ больсон эмэгтэй билээ. Тэмцээн мягмар гаригийн өглөө болтол үргэлжлэв. Эхний хоногт Бага Аурелиано нэг тугалын махыг төмс, саа\яа, шарсан галын хачиртай эд бад хийгээд, бүтэн хагас айхцаг шампан дарс цөлөөд дийлнэ гэдэгтээ бат итгэлтэй байв. Хэнэггүй өрсөлдөгчөөсөө өөрийгөө бадрангуй, сэргэлэн гэж санаж байлаа. Мэгжийн идэх нь илүү мэргэжсэн байдалтай ч гэрт дүрсэн ёсон жорын амьтдан түүнд ньтөдий л баясан хөхихгүй

байлаа .бага Аурелиано ялахгэж улайгаад ичиж зоврхыг ч мартаж, махыг шүдээрээ зулшгааж байхад Мэгж мэс засалчийн эрэдмтэй юм гэхээрхэсэг хэсэг болгон огтлоод, яаралгүйхэн , тэр ч байтугай нэлээд амтархан идлэж байлаа. Тэрбээр аварга том, айхтар тарган, аймаар лагс боловч их л эелдэг ялдам ажээ. Црай хосгүй хөөрхөн, гар булцгар булбарай, байдал өөрийн эрхгүй дур булаам учир орж ирэхэд нь Аурелиано хоолны ширээн дээр бус, орон дотор хүчээ соривол таарах байж гэж амандаа дуугарчээ. Мэгж тугалын утсан бүтэн мах цааш харуулахдаа хамгийн дээд зэргийн ёс журмыг огтхон чгажуудуулсангүйг Бага Аурелиано харахдаа цадахыг мэддэггүй, сайхан ааштай сэтгэл булаам энэ амьтан угтаа бол бүгсүйчүүдийн дээд нь байна гэж үнэнээсээ хэлжээ. Тэгээд ч эндүүрсэнгүй. Түүнийг ирэхээс өмнө “хомхой ёл” гэж цуу тарсан нь үндэсгүй байжээ. Улсын цуурхдаг шиг тэрбээр шарын махыг ч хэрчигч биш, грекийн циркийн сахалт хүүхэн ч биш байж хариндууны сургуулийн захирал байсан юм санж. Гэрийн хүндтэй эх болсон хойноо хүүхдээ сайн хооллох, тэгэхдээ хорхойг нь зориуд хүргэх бус, сэтгэлийг нь туйлын тайван болгох байдлаар сайн холлох арга олох гэхдээ их идэхийг сурчээ. Сэтгэл тайван хүн ядартлаа тасралтгүй хоол идэж чадна гэсэн онолыг тэр практикаар шалгажээ. Тийнхүү сургуль, гал голомтоо орхин ирэхдээ спортын нэр алдарт шунасангүй, замбараагүй иддэг гэж улс орон даяар алдаршсан хүнтэй тэмцэлдэж үзэх гэсэн ёс суртахууны шалтгааныг баримталжээ. Камила Бага Аурелианог харангуутаа л идэж барахгүйдээ бус, илүү зангаасаа болж дийлдэх хүн байна гэж ойлгожээ. Үнэхрээр ч, эхний шөнө өнгөрөхөд Камила юу ч болсон шинжгүй байхад БАга Аурелиано их нээж, дэмий чалчсанаас тамир алдрангуй байв. Хоёул дөрвөн цаг унтлааа. Дараа ньтавин зүржээр хийсэн шүүс, найман литр кофе ууж, гучин түүхий өндөр соржээ. Хоёр дахь өдрийн өглөө олон цаг сэрүүн байсны дара ахоёр гахай, гадилын бүтэн хонгорцог, дөрвөн авдар шампан дарс цохиод, Мэгж Бага Аурелианог өөрийнх нь аргыг өөрөө мэдэлгүй олж, тэгэхдээ өөрөөс нь ялгаатай нь гэвэл хар аяндаа л олчихов уу гэж сэжиглэжээ. Ингэснээр учраа нь түүний бодсоноос хавьгүй аюултай болов. Гэтэл Петра Котесийг ширээн дээр хоёр шарсан шанагт хяруул тавихад Бага Аурелиано тархинд цус харвахын даваандээр очсон байлаа.

Идэж барахааргүй байвал орхи. Хоёул хайнцсан больё гэж Мэгж түүнд чин сэтгэлээсээ хэлжээ.

Өрсөлдөгч нь залгих тоолондоо үхэл рүү явж байхад түүний хоолойгоор яаж ч юм давах билээ. Гэвч Аурелиано тэгж хэлээхд нь басаж байна гэж бодоод цацагт хяруулыг явуулж орхисонд иддэг иддэг гэхэд тэр нь дэндээд ухаан алдав. Мөлжсөн ястай тавган дээр нүүрээрээ даран унаад, амнаас нь галзуу нохойнх шиг хөөс сахарч, хоолой нь хоржигноод явчихжээ. Дотор нь харанхуйлж байхад өндөр цамхгийн чанх орой дээрээс ёроолгүй ангал ру нисгэчих мэт санагдаж ингэж доош и ниссээр явада яг газарт хүрэхэд л үхэх гэсэн бодол сүүлийн удаа түр ухаан ороход нь гялсхийж,

- Намайг Фернанда дээр аваач гэж дөнгөж хэлж амжжээ.

Түүнийг гэрт нь хүргэж өгсөн найз нар нь нууц амрагийн орон дээр үхэхгүй гэж эхнэртээ өгсөн амандаа хүрч байна гэж бобджээ. Петра Котес авсанд орохдоо Бага Аурелианогийн өмсөнө гэсэн чиймдэл шаахайг цэвэрлэж, хэнээр явуулдаг юм билээ гэж хүн хайж байтал амьд мэнд гарлаа гэж дуулжээ. Долоо хоноодбие илаарьшиж, хоёр долоо хоноод үхээд боссоноо тэмдэглэн урьд хожид үзэгдээгүй их найр хийжээ. Тэрбээр Петра Котесийнд суусан хэвээр байсан боловч өдөр бүр Фернандаг эргэж, заримдаа гэрийнхэнтэйгээ хамт хоол идэж байсан нь зарим зүйрлэвээс үйлийн үрээр бүх юмны байр солигдож тэрнууц амрагийнхаа нөхөр, эхнэрийнхээ нууц амраг болсон мэт болжээ.

Фернанда жаал санаа амрав. Хаягдсан эхнэр тэсэхийн арагүй уйтгарт өдрүүдэд ганцаардаж, үдэрэ хөгжим тогломж, хүүхдүүдээсээ ирсэн захидлаа уншиж л цаг барж байлаа. Сард хоёр удаа Хосе Аркадио, Меме хоёрт их л урт захидал бичих боловч түүнд ньганц ч үнэн м байдаггүй байлаа. фернанда өөрийн золгүй явдлыг хүүхдүүдээсээ нууж байв. Энэ гэрийн уйтгар гунигийг чадамгай нууж байлаа. Наранхайтан цэцэг гийгүүлж, гудамжнаас гэнэ гэнэ баярын хөгжил шуугиан цуурайтавч, үд дунд нохой гаслам халуун болсон хэвээр боловч хадмынх нь гэр эцэг эхийнх нь дүнсгэр гэртээ өдөр ирэх туса мдалихан болж байлаа. Фернанда гурван амьд сүг, Хосе Аркадио Буэндиа гэсэннэг үхсэн сүгийн дунд ганцаардан явна. Хосе Аркадио Буэндиагийн сүнс зочдын өрөөний харанхуй буланд суугаад түүний хөгжим тоглохыг нь их анхааран чагнана. Урьдын хурандаа Ауреиано БУэндиа ёсто йл сүг болжээ. Найдваргүйшинэ дайн үүсгэх гэж Гернельдо Маркесийг ятгараах сүүлийн удаа гарснаас хойш гэрийн мухар сахиж, туулайн бөөрийн хажууд бие засах гэж л урлангаасаа цухуйх болов. Гурван долоо хоноод нэг ирдэг үсчингээс ондоо хүн өөр дээрээ үл оруулна. Өдөрт Урсулагийн аваачиж өгснийг иднэ. Алтан загасаа урьдынх шигээ хичээнгүйглэн урласаар боловч түүнийг нь гоёл болгож бус түүхийн дургсал болгон авч байгааг мэдэхдээ худалдахаа болив. Нэг удаа гадаа түүдэг асааж, хуримын өдрөөс хойш унтлагын нь өрөөг чимэглэж байсан Ремедиосын хүүхэлдэйг шатаасанд гярхай Урсула хүүгийнхээ хийж байгааг мэдсэн боловч болиулж чадсангүй.

- Чи чулуу шиг зүрхтэй юм гэсэнд цаадах нь:

- Юун зүрх, тасалгаанд хив их байхад гэж хариулжээ.

Амаранта оршуулгын хулдсаа нэхсээр байлаа. Меме Амарантад захиа бичиж, тэр ч байтугай бэлэг явуулдаг, Хосе Аркадио нэрийг нь ч дурсах лдургүй байдгийн учрыг Фернанда ойлгохгүй байлаа. Фернанда энэ тухай Амарантагаас Урсулагаар асуулгасанд Амраната “Тэд үүнийг мэдэхгүй байсаар үхнэ” гэж хариулжээ. Амарантагийн ингэж хариулсанны тайлагдашгүй оньсого болон Фернандагийн сэтгэлд хадагджээ. Өндөр, цэх, ихэмсэг Амаранта, хөөс шиг

хөвсгөр, цас шиг цагаан банзал дандаа өмсдөг, нас явж сэтгэлийн шаналалд автаар байвч омог бардам зангаа тавиагүй. Амаранта духан дээрээ өөрийн үнсэн загалмай буюу онгон хальстайгаа байгаагийн загалмайг авч явнам билээ. Тэрбээр үнэхээр тийм тэмдэгтэй бөгөдө гагцхүү тэр тэмдэг нь гарт нь хар боодлын доор байлаа. Амаранта боодлыг шөнө ч үл авах бөгөөд өөрөө угааж индүүнэ. Амаранта бүхий л насаараа хулдас бэлджээ. Өдөр нь нэхсэнээ шөнө нь задалдаг, тэгэхдээ ганцаардаж зовохгүйн тулд бус, харин ганцаараа байхын тулд ингэдэг бололтой.

Нөхрөө явсны дараа Фернанда Мемег амралтаараа гэртээ ирээд, эцгийгээ байхгүй байгааг мэдчих вий гэж яс хавтайж байлаа. Бага Аурелианогийн ухаан алдаж унаснаас хойш тэгж айхаа больжээ. Мемег ирэх үеэр тэр хоёр Аурелианог журамт эцэг, дуулагвартай хань хэвээрээ байан гэж охиндитгүүлэхээр үл барам гэрийн утгар гунигийг мэдүүлэхгүй байхаар тохиролцжээ. Жил бүр хоёр сар Бага Аурелиано үлгэр жишээ хань болон тоглож, баяр наадам хийн, зочдыг зайрмаг жигнэмагээр дайлж, баясгалантай сэргэлэн Меме хөгжим троглон, цугласан улсыг зугаацуулдаг байлаа. Тэгэхэд л Меме эхийнхэ эзанг тун бага дуурайсан нь харагдлаа. Меме Амаранта биеэрээ байлаа. Гэвч Амаранта ба бусад бүх хүнээс өөр нь гэвэл Меме энэ гэр бүлийнхний ганцаарддаг хувь тавилангаар хараахан ороогүй, хавь орчныхондоо маш сэтгэл дүүрэн, тэр ч байтугай өдрийн хоёр цагт зочдын өрөөнд орж, хөгжимдөх дасгалаа заавал хийдэг байлаа. Гэртээ байхдаа дуртай, харихад нь залуучууд өөрийг нь баярлан шуугин угтдагийг жилжингээ мөрөөддөг, эцэг шигээ наргиж цэнгэх, хэнийг ч хөл алдан зочлохоос буцахгүй зантай нь ив илт ажээ. Гурав дахь удаагийн амралтаар Меме хэнээс ч асуулгүй, хэнд ч урьдчилж хэлэлгүйгээр дөрвөн гэлэмаа, ангийнхаа жаран найман охидыг манайд долоо хоног бай гээд дагуулаад ирэхэд нь эцгийнхээ муу занг дуурайсны анхны тэмдэг мэдэгдэн билээ.

- Яасан гайтай юм бэ! Энэ хүүхэд эцэг шигээ ухаангүй юм гэж Фернанда уйлагнажээ.

Хөх дүрэмт палаажтай охидыг унтуулах ор, дүүжин ор айлынхнаасаа гуйж, есөн ээлжээр хоол идүлж, угаалгын өрөөний хуваарь гаргаж, өдөржин гэр дотуур цааш нааш холхиулахгүйн тулд дөчин мухар санадр түр хэрэглэх хэрэг гарлаа. Ёстой нэг баларч гүйцэж байлаа. Шааг шууг хийсэн тэр олон охидын сүүлч дөнгөж өглөөний хоол идэж дуусахад эхний ээлж нь өдрийн хоол идэж дуусахад эхний ээлж нь өдрийн хоол идэж болж, дараа нь оройн хоол идэх болдог учир долоо хоноход сурагчид дөнгөж гадилын тариалан л үзэж амжжээ. Шөнө болоход гэлэнмаа нар шавь нараа оронд ньхөөж оруулах гэж үйлээ үздэг, тэднийг яаж ч хичээлээ гэсэн сургуулийн уйтгарт сүүлд дуу дуулсан эцэхээ мэддэггүй охид бөөнөөрөө гадаа заавал үлдчихсэн байдаг байлаа. Нэг удаа тэд бус болох гээд дандаа ус болж явдаг Урулагэгээ л дайраад



унагаачихсангйү. Нөгөө нэг удаа хурандаа Аурелиано охидын дэргэд туулайн бөөр модны доор шээчихсэнээс болж гэлэнмаа нар баахан хэл ам хийв. Амранат шөлөнд давс хийж байгаад нэг гэлэнмааг гал зууханд орж ирнэ” Тогоонд юун цагаан нуниаг хийв?” гэж үгэнд дурлахад нь,

- Хүнцэл гэж хариулаад бас бөөн хэрэг мандуулжээ.

Ирсэн үдшээ охид унтахын өмнө бие засах гэж жорлонд оочирлоод, сүүлийнх нь шөнийн нэг цагийн орчим түүнд оржээ. Тэгэхэд нь Фернанда далан хоёр хөтөвч авч өгсөн боловч шөнө оочирлодгийг нь болиулаад өглөө зогсдог болгосноос цаашгүй. Учир нь үүр цайхаас аваад жорлонгийн хажууд охид хөтөвчөө угаах гэж шлээ харан жагсах болов. Зарим сурагч салхинд цохилуж, зарим нь шумжууланд хатгуулан%, хазуулсан газар нь үсэрхийлэн хавдсан боловч олонхи нь хүнд сорилтыг хатан зоригоор давж, өдрийн хамгийн халуун цагт ч цэцэрлэгээр аргалж байгаад гүйлддэг байлаа. Зочдыг явсан хойно үзвэл бүх цэцэг няц гишгэгдсэн, тавилга сэлт хэмхэрсэн, хана туурга сараачигдаж зурчигдсан нь залбирч, эвдэрч хэмхэрсэн юм ч яамай гэж боджээ. Ор, сандлыг эздэд нь эргүүлж өгөөд, далан хоёр хөтөвчийг Мелькиадесийн өрөөнд өржээ. Урьдын сайн цагт энэ гэрийн оюуны бүх амьдрал болж байгаад орхигдсон тасалгаа түүнээ схойш “хөтөвчийн тасалгаа” гэгдэх болжээ. Хурандаа Аурелиано Буэндиагийн бодлоор бол энэ нь яг оносон нэр бөгөөд Мелькиадесийн өрөө тоосонд \дарагддаггүй, эвдэрч мууддагүйд гэр хотлоороо гайхдаг боловч хурандаа бол түүнийг хогийн газар гэж боддог байжээ. Ямар ч байлаа гэсэн хурандаа хэнийх нь зөв облохыг ер сонирхдог янзгүй. Фернандаг хажуугаар нь хөтөвч зөөн өдөржин гүйж юм хийлгэхгүй байсанд л тасалгаанд юу хадгалагдах болсныг мэдсэн ажээ.

Тэр үед Бага Хосе Аркадио дахин ирэв. Тэрбээр хэнтэй ч мэндлэлгүй, шулуухан явсаар гудмын нөгөө үзүүр хүрч урланд ороод хурандаатай юу ч юм аминчлан ярилцжээ. Урсула түүнийг харахгй байсан боловч харгалзагч нарын өмсдөг савхин гутлын дуугарах чимээгээр таниад, гэрийнхнээсээ, ихрийнхээ өрөөснөөс түүний хэчнээн холдон хөндийрсөнд, хүүхэд байхдаа хувцсаа солин амьтны толгой эргүүлэн тоглож байсан хоёр одоо огт төсгүй болсонд гайхаж байлаа. Бага Хосе Аркадио өндөр, туранхай бөгөөд ихэмсэг, сарациных<sup>1</sup> шиг бодлогошронгуй, гунигтай бор царай нь нэг л баргар

1 Сарацин – Эртний Аравийн нүүдэлчин овог. – Орч.

Сүүдэртэй байлаа. Тэрбээр эцгийн талынхнышг дуурайхаасаа эх Санте Софи де ла Пьедадыг илүү дуурайсан бөгөөд Урсула манайхан гэж ярихдаа нэрийг нь орхичихоод, түүндээ өрөийгөө зэмлэдэг байлаа. Бага Хосе Аркадио дахин

гэртээ ирж, хурандаа ажлаа орхин тийүүнтэй урландаа уулзаж байгааг Урсула мэдэхдээ урьдын явдлыг нэхэн санаж, Бага Хосе Аркадио бага байхдаа ихрийнхээ өрөөсөнтэй байраа сольж гэсэн сэжиг нь батжиж нөгөөх нь биш чухамхүү энэ л Аурелиано гэж нэртэй болох ёстой байх хэмээн боджээ. Түүний яаж амь зуудгийг хэн ч нарийн үл мэднэ. Нэг үе “Малгай тавивал манайх, маргааш явбал хүнийх” гэгчээр явж, Пилар Тернерагийн зодоо ч тахиа үржүүлж, захимдаа тэнд хонож, франц дууч эмсийн унтлагын өрөөнд бараг бусад бүх хоногийг төөрүүлдэг байлаа. Хүсэж сонирхсон, хичээж эрмэлзсэн юм байхгүй, амьдралын давалгаанд туугдан хөвж явдаг, Урсулагийн одны аймгийн төөрч тэнэсэн нэгэн од байлаа.

Үнэнийг хэлэхэд, Бага Хосе Аркадио хурандаа Геринельдо Маркесийн хүн яаж бууддагийг үзүүлэх гэж бус, буудуулж байгаа хүний гунигтайхан бөгөөдтохуутайхан инээмсэглэхийг насан туршаа санаж яваг гэж өөрийг нь хуаранд аваачсан тэр нэгэн өглөөнөөс хойш тэдний хүн биш болж, өөр бусдынх нь байж нэгэнт чадахгүй болжээ. Аль эртнээс буюу хүүхэд байхаас сэтгэлд үлдсэн цорынганц юм гэвэл энэ л байлаа. Дивангалбын үеийн хантааз, хэрээний далавч шиг хөвөөтэй бүрх өмссөн өвгөн тэнгэр гялалзсан харагдах дөрвөлжин цонхын дэргэд хачин сонин юм ярьж байсныг бас санадаг байлаа. Гэвч хэдий үед ингэж байлаа гэдгийг Бага Хосе Аркадио мэддэггүй. Тэр өвгөн сэтгэлд нь сэв ч суулгаагүй, сайн юманд ч сургаагүй, дүр нь бүүр түүхэн л үлдэн байдаг бол хүн будахыг үзсэн нь бүх амьдралынх нь замыг тодруулж өгсөн ажээ. Нас ахихын хэрээр энэ дүр цагийн урсгалаар ойртох мэт сэтгэлд нь тов тодхон санагдах болжээ. Урсула, Бага Хосе Аркадиоогоор хурандаа Аурелиано Буэндиаг хар нүхнээс нь гаргуулах гэж үзээд алдав. “Цаадхыгаа кинонд явъя гээ. Кинонд дургүй нь дургүйл л дээ, гэхдээ эрүүл агаарт гараг” гэж гуйжээ. Гэвч Бага Хосе Аркадио түүнийгуйсныг хурандаагийн адил чихний харжуугаар өнгөрсүүлснийг, тэрхоёр хоёулаа яг адилхан ямар ч юм сонирхдоггүйг Урсула асар удалгүй анзаарчээ. Урланд хаалгаа түгжээд өчнөөн цагара юу ярьдгийг Урсула мэдэхгүй. Гэвч эд бол тэднийхний доор ойролцоо юм бодож санаж явдаг хоёрхон хүн гэдгийг Урсула ойлгож байлаа.

Үнэнийг хэлэхэд, Бага Хосе Аркадио Урсулагийн гуйсныг бүтээе гэж бодсон нь биелүүлж чадахгүй байв. Сурагч охидын хөлд дарагдсан нь хурандаагийн тэвчээрийг баржээ. Тэрбээр хив хорхойн амтат зууш болсон Ремедиосын хүүхэлдэйг аль хэдийн үгүй хийсэн боловч унтлагын өрөөнд хив хорхой бас л их байна гэдгээр шалтаглан урландаа дүүжин ор өлгөж, бие засах гэж л гадаа гарах боллоо. Урсула хурандаатай хамгийн энгийн яриа ч үүсгэж чаддаггүй байв. Хүүгийнхээ урланд орохдоо, тавагтай хоол руу ч харахгүй, ширээний нөгөө булан тийш түлхэж орхиод, шөл нь царцаж байна уу, мах ньхөрч байн у гэж сана азовохгүй, алтан загасаа л засаж янзалсаар суух болно гэдгийг мэддэг байлаа. насны наран хэвийсэн хойноо дайн хийхэд нь хурандаа Геринельдо Маркесийн туслахаас татгалзсанаас хойш улам ч догширчээ. Улам

зожиг, улам түгжигдмэл болж, гэрийнхэн нь түүнийг үхсэнээс өөрцгүй бодох болов. Аравдугаар сарын арван нэгэнд хажуугаараа өөнгөрч явсан цирк довжоон дээр гарч харахаас өмнө хурандааг хүнлэг сэтгэл гаргаж байхыг хэн ч анзаарсангүй. Энэ нь хурандаа Аурелиано \Буэндиагийн хувьд сүүлийн хэдэн жилийн бусад бүх өдрөөс ялгарах юмгүй өдөр байлаа. Өглөөний таван цагт хашаанд бах, хүүрэлзэгэнэ дуугарахд сэржээ. Бямбад эхэлсэн бороо аанай л шивэрч байлаа. Цэцэрлэгийн модны навчиндз борооны шижгэнэн шивнэхийг сонсдоггүй юм аа гэхэд ясаа хүйт оргиход бороо орж байна гэдгийг тэртэй тэргүй мэдэх сэн билээ. Хурандаа Аурелиано Буэндиа аанай л ноосон цув, маш хуучны загвартай “готын дотуур өмд” гэж өөрөө нэрлэсэн урт бүдүүн даавуун дотоож өмссөн балаа. Усанд орох гэж байсан учир өмдөө өмссөн боловч товчилсонгүй, цамцныхаа заханд дандаа хийдэг алтан чагтаа хийсэнгүй. Дараа нь цуваа толгой дээгүүрээ юүндэншиг нөмрөөд, налмийн унжсан сахлаа дээш имэрснээ гадаа бие засахаар гарчээ. Нар гарах болоогүй, Хосе Аркадио буэндиа бороонд илжирсэн далдуу модны навчин саравчин доороо унтсаар байлаа. Хурандаа аанай л эцгийгээ харсангүй, хий сүг шаахай дээрээ халуу оргитол шээхэд срж, хүүдээ үл ойлгогдох нэг юмхэлсэн боловч цаадах нь дуулангүй. Хурандаа хүйтэн чийгтэйд даарсандаа бус, аравдугаар сарын мананд сэгэл нь нэг л тавгүй байсандаа дараа усанд орьё гэж шийджээ. Урлан руугаа орох гэж явтал Санта Софи де ла Пьедад зуух галлаж утааны үнэр гарсанд, галзууханд орон гүцтэй кофе буцлахаар аяга чихэргүй кофе авъя гэж санажээ. Санта Софи де ла Пьедад өглөө бүр асуудаг шигээ “Өнөөдөр хэдэн бэ? Ямар гариг вэ?” гэж асуусанд” Аравдугаар сарбын арван нэгний мягмар гариг” гэж хариулжээ. Байгаа үгүйг нь урьд ч сайн мэддэггүй байсан, одоо ч сайн мэдэхгүй байгаа эмэгтэй өмнө нь зогсож, царай нь тайван, галыгн гэрэлд шаргалтан байхыг хараад, нэг удаа дайны ид дундуур, мөн л аравдугаар сарын арван нэгэнд харжуудаа нутаж байгаа хүүхнийг үхчихэж гэдгийг амьтны зөнгөөр мэдээд сэрснээ санажээ. Тэр хүүхэн үнэхээр үхчихсэн байж билэ. Сайхь хүүхэн “Өнөөдөр хэдэн бэ?” гэж уг явдал болохоос цагийн өмнө асууж байсан учир тэр өдрийг тогтоожээ. Гэвч үүнийг санахдаа ч Аурелиано Буэндиа совингоо огт байхгүй болсныг үл анзаарчээ. Гүцтэй кофе буцалтал зүгээр суухаар гэж тэр эмэгтэйг бодож, тэгэхдээ уйтгар төрж сүйд болох болов уу гэж айсангүй. Хав харанхуйд бүдэчсээр өвөрт нь орж ирсэн болохоор эмэгтэйн нэрийг ч яаж мэдэх вэ, царайг нь ч яаж харах вэ дээ. Өдий төдий хүүхэн яг л ийм замаар өөр дээр нь ирж байсан болохоор хурандаа чухамхүү тэр эмэгтэй анхны янаглалын элчинд ухаан жолоо алдаж, нулимсандаа золтой л живчихэлгүй, “Үхэн үхтлээ чамайг хайрлана гэж үхэхээсээ цагийн өмнө ам тангараг тавьж байсныг санасангүй. Урландаа эргэж ирээд энэ эмэгтэйг ч, өөр эмэгтэйгч бодсонгүй, төмө лаазанд хадгалж байсан алтан загасаа тоолох гэж гэрэл асаав. Загас нь арван долоо болсон байлаа. Загасаа зарахаа больсноос хойш өдөрт хоёр загас хийгээд, хорин тав хүрэхтэй ньхамт сөөрөг нь хөөрөгтөө хайлуулж, дахин ажлаа эхэлдэг байлаа.

Өглөөжин юу ч бодолгүй ажиллаж, ажилдаа улайраад арван цагт бороо ширүүссэнийг ч анзаарсангүй, урлангийн хажуугаар нэг нь “Гэр туж ус болох нь, хаалгаа хаагаарай!” гэж хашгиран өнгөрөхийг ч мэдсэнгүй. Урсулаг хоол авч орон, гэрэл унтраатал өөрийгөө ч мартаж орхисон байлаа.

- Ямар их бороо орж байна аа! Гэж Урсулагийн хэлэхэд,
- Аравдугаар сар хойно араг байж уу гэж хариулжээ.

Ингэж хэлэхдээ энэ дөрийн анхныхаа алтан загасанд бадмаараг нүд шигтгэж байсан тул дээш ч харсангүй. Гагцхү ажлаа дуусгаж загасаа лаазтай бусад загас руу нийлүүлээд сая шөлөө уухаар суужээ. Параа нь сонгинотой жигнэсэн мах, цагаан будаа, мөн тавган дээр байсан шарсан гадилыг их л удаан иджээ. Сайн муу ямар ч үед холонд нэг л адил байдаг байв. Хоолны дараа амармаар болов. |Шинжлэх ухааны үндэстэй гэмээр мухар сүжгээс болоод хоолоо шингэтэл хоёр цагер ажил хийдэггүй, ном уншдаггүй, усанд ордоггүй, хурьцал үйлддэггүй билээ. Ингэх хэрэгтэй гэж сүсэглэн итгэснээс хурандаа Аурелиано Бунэдиа хэд хэдэн удаа цэргээ цус харвах аюулд орулах вий гэхдээ хоолны дараа байлдааны ажиллагаа эхлэхийг хйошлуулж байлаа. Тэрбээр орон дээрээ хэвтэж, тонгоргоор чихээ ухаж байгаад дорхноо унтчихав. Өөрөө цагаан ханатай хоосон байшинд орж байна, энэ босгоор алхаж байгаа анхны хүнболох учир их л зовж байна гэж зүүдэлжээ. Урьд шөнө, ер нь сүүлийн хэдэн жил олонтаа яг ингэж зүүдэлж байгааг зүүдэн дундаа санаж, сэрэхдээ үүнийг санахаа больчихдог, яагаад гэвэл эргэж зүүдлэгддэг зүүд зөвхөн зүүдэнд л дахин санагддаг юм байна гэж ойлгожээ. Үнэхээр минутын дараа үсгийн урлангийн хаалга тогшиход хурандаа нүдээ нээн, санамсаргүй дугхийж, юу ч зүүдэлж амжсангүй гэсэн бат бодолтой сэрээд.

- Өнөөдөртөө хэрэггүй. Баасанд ир! Гэж үсчинд хэлжээ.

Гурван өдөр хусаагүй тул бууралтаж яваа сахал нь ургасан боловч энэ удаа больё, баасанд тэртэй тэргүй үсээ авахуулах тул нэгмөсөн авахуулья гэж боджээ. Өдөр тухгүй унтсаны дараа хамаг биений нь хүйтэн хөлс чийхарч, суганы нь шархны сорви шархиран өвдөв. Бороо зогсоон боловч наргараагүй байлаа. Хурандаа Аурелиано Буэндиаг чнаг хэхрэхэд, шөлний исгэлэн амт тагнайд нь амтагдсан нь цуваа нмөрөөд, жорлон яв гэж бие махбод шаардаж байгаагийн дохио байлаа. Тэнд гаргадгаа гаргаснаас хойш нэлээн саатсанаа, одоо очиж ажлаа хийх цаг болж гэдгийг зуршлаараа ойлгов. Өнөөдөр чинь мягмар, гадил\ын компани ажилчдадаа цалин тавьж байгаа учир Бага Хосе Аркадио ирсэнгүй гэж жорлонд сууж байхдаа боджээ. Тэгж обож байснаа нэг мэдэхэд дайны тухай бодож хэлсэн байлаа. Сүүлийнүед нэг юм бодоход л дайны тухай бодол руу орчихсон байдаг болжээ. Хурандаа Геринельдо Маркес “Духандаа цагаан сартай морь олж өгөн” гэж нэг амлаад дахиад тэр тухай дурсаагүйг санах. Дараа нь дайны хэсэг бусад явдлыг санаж, урьдын

явдлаа ингэж бодоход баяр ч төрсөнгүй, учир нь дайны тухай нэгэнт бодохгүй байж чадахгүй байсан болохоор сэтгэл хөөрч зоволгүгйээр тайван бодож сурсан юм санжээ. Урлсан руугаа явж байхдаа агаар хуурай болсныг анзаарч, усанд орох гэсэн боловч угаалгын өрөөнд Амарнат орчихсон байв. Тэгээд хоёр дахь загасаа хийж эхэллээ. Сүүлийг нь хийж байтал гэнэт нар тэнгэрийн хаяанаа сэрчээрээ тэмүүлэн гарч ирээд, эргэн тойрны бүх юм загасчны хуучин завь адил чахраад явчих шиг санагдав. Гурван өдрийн бороонд угагдсан гаарт нисдэг шоргоол дүүрчээ. Нэг мэдвэл шээс нь учиргүй хүрсэн байсан боловч загасаа эвлүүлж дуутстал тэсэв Дөрвөн цаг арван минутад гадаа гартал зэс бүрээний холоос цангинах, том бөмбөрийн сүртэй нижгэнэх, хүүхэд багачуудын баясан хашгиралдах дуу чихийг нь дэлсэхэд олон жиийн хойно анх удаа уйтгар төрж, эцгийнхээ мөс үзүүлэхээр өөрийг нь цыганууд дээр авч очсон тэр гайхамшигт өдөр дахин санаанд нь оров. Санта Софи де ла Пьедад гал зууханд хийж байснаа охиод гудамжинд гүйн гарч,  
- Энэ чинь цирк байна! гэж хашгирчээ.

Хурандаа Аурелиано Буэндиа туулайн бөөр мод руу явах оронд бас гудамжинд гарч, гудамжаар явж байгаа жагсаалыг харж байгаа бөөн улсын дунд оров. Зааны нуруун дээр алтанхувцас өмссөн эмэгтэ явж байлаа. Ганц бөхтэй хөөрхийлөлтэй тэмээ явж байлаа. Голланд бүсгүйн байдлаар хувцасласан баавгай хөгжмийн аяар хөдлөн халбагаар төмпөн нүдэж явлаа. Тэднийг өнгөрсөн хойно нарны гэрэл туссан хоосон газар, нисэлдэх шорголж яая даа байз гэсэн байдалтай хэдэн алмай амьтнаас өөр юу ч үлдсэнгүй, дахиад л хөөрхийлөлтэйгээ ганцаардан хоцорвой. Тэгэхэд цикийг бодсоор туулайн бөөр тийш явж, шээж байхдаа түүнийг бодох гэсэн боовч сэтгэлд нь орж өгөхөө болив. Тэгээд хүзүүгээ нугжийлгэн, духаараа туулайн бөөр мөргөн таг боллоо. Гэрийнхэн нь болсон явдлыг хойд өдөр мэджээ. Арван нэгэн цагт Санта Софи де ла Пьедад арын хашаанд хог хаях гэж гарахдаа туулайн бөөр рүү харцага нилсэлдэж байгааг үзжээ.

\*\*\* \*\*

Мемегийн сүүлийн амралт хурандаа Аурелиано буэндиагийн үхсэн гашуудлын өдөртэй давхцав. Хаалга цонхоо бин битүү хаасан гэрт баяртай манатай байлаа. Юм ярихад шивнэн ярьж, хоол идэхдээ чив чимээгүй идэж, өдөрт гурван удаа уншлага уншиж, өдртийн амралтийн үеэр хийдэг хөгжмийн дасгал оршуулгын хөгжим аятай хийдэг хөгжмийн дасгал оршуулгын хөгжим аятай сонсдож байлаа. Фернанда хурандааг цаагуураа үзэж чаддаггүй байсан боловч үхсэн дайсныхаа дусргалыг засгийн газрын ёслол төгөлдөр хүндэгээнд цочирдон гайхаж тийм хатуу бэлэвсрэл зарлажээ. Бага Аурелиано

охиныхоо амралтаар урьдынхаараа гэртээ хонож, Фернанда хууль ёсны ханин йэрхээ сэргээх талоаар жаал зуга аюм хийсэн бололтой бөгөөд учирнь Мемег жил бооод ирэхэхдохин дүү нь дөнөгж гарсан байлаа. Эхийнх нь хүссэнээс зөрж, тэр охинд Амаранта Урсула гэж нэр өгчээ.

Меме сургуулиа дүүргэлээ. Сургууль төгссөнийг нь тохиолдуулан хийсэн баяраар түүнийг арван долдугаар зууны үеийн ардын аяыг гялаллзтал тоглсоны дараа “Даруулт хуурчийн мэргэжил олголоо” гэсэн дипломыг санал нэгтэй баталжээ. Мөн тэрбаяраар гашуудал тайлсан билээ. Мемегийн гайхалтай хувирч чаддагнь уран чадвараасаа илүү зочдод гайхагдаж байлаа. Хөнгөмсөг, тэрч байтугай яльгүй нялхамсуу зантайг харвал ултай суурьтай юм хийж чадахгүй гэж бодгдмоор боловч хөгжмөө бариад суухаараа төрөл аржилсанюм шигболж, бүрнээ насанд хүрсэн хүний буурьтай болчихдог байлаа. Үнэнийг хэлэхэд, Меме хөгжимд оцнгой дур авьяасгүй боловч эхийнхээ үгнээс зөрж чадахгүй, даруулт хуураар дээд зэргээр сайн тоглож сурахгэж биеэ албаджээ. Тэрбээр өөр ямар чажлыг тэгж биеэ албадан байж сурч чадах байлаа. Бга байхынхаа Фернандагийн хахир чангад, бүх юмыг бусдын өмнөөс шийдэж байдагт залхаж, эхийн хатуу гараас гарч байвал түүнээс хэцүү хүтүүг үзсэн ч яах вэ гэж боддог болжээ. Сургууль төгссөн ёслол дээр бүсгүй готоор 1 дармалдаж, гоё үсгээр бичсэн үнэмлэхтэй бослноороо дуулгавартайдаа төдийгүй яс амар байх гэсэндээ авсан үүргээсээ чөлөөлөгдлөө гэж санаж, одоо л нэг зөрүүд Фернанда музейд л тавивал таарах бослон эд байна гэж гэлэнмаа нарын шоолсон хөгжмийг дахин тоглуулах гэхгүй бахй гэж боджээ. Ингэж тооцоолсон нь эндүү болжээ гэж эхний хэдэн жилд санагджээ. цагаад гэвэл хотынхны тэн хагас нь гэр бүлийн дайллага, буян хийх концерт, сургуулийн үдэшлэг, эх оронч ёслол Дээр түүний даруулт хуурын эгшгэнд нойро авч амжсан боловч Фернанда охиынрхоо авьяас билгийг үнгэлж чадах хүн гэж үзсэн шинэ хүн бүрийг гэртээ урьсаар байлаа. Гагцхүү Амаранта бие барж, гэрийнхэн дахин бэлэвсрэлийн ёс үйлдэхэд Меме хөгжмөө цоожлоод эхийгээ хэдийд, хэнээс болж түлхүүр алагболж вэ гэж мөшгөж мөрдөнө гэж айлгүйгээр түлхүүрийг нэг шүүгээнд нуужээ. Тэр хүртэл бсгүй тухайн үедээ сургууль хийж байсан шигээ авьяасаа олонд эвчээртэйгээр үзүлсээр байлаа. Ингэснээрээ ч дураар байх боломж олж авч балйаа. Ингэснээрээ ч дураар байх боломж олж авч байлаа. Фернанда охиныхоо үг дууламтгайд сэтгэл дүүрэн, олон нийтээр ур чадварыг бахдан хэлэлцэж байгаад омог бардам байсан учир гэртээ найзохидоо бөөнөөр нь авчрах, гадилын тариалангаар зугаалах, Антонио Исабель ламбугайн сайшаасан киног бол Бага Аурелианотой буюу итгэж болох хатагтай нартай үзэхээр явахыг нь хориглдоггүй байлаа. Наргиж цэнгэж байхад нь Мемегийн жигнхэнэ сонирхол тодорно. Бүсгүй дэг жруам, сахилга бат гэхээр үстэй толгой нь арзайдаг, шуугиант найр наадам гэхээр нүд нь сэргэдэг, найз бүсгүйчүүлтэйгээ тэр энүүнд дурласан, энэ тэрүүнд дурласан гэж хошуу худалдацгааж, тамхи татаж сурах гэж оролдож, эрчүүдийг тийм ийм гэж хэл

амаа билүүдэн хэдэн цагаар нэг далдхан газар суухдаа дуртай байлаа. Нэг удаа агурван лонх нишингийн ром архи уучихаад, хувцсаа тайчин, чиний бие минийхээс тийм байна, минийх чинийхээс тийм байна гэх зэргээр зүйрлүүлэн хэмжиж гарчээ. Меме тэр үдшийг хэзээ ч мартахагүй. Амуу соёлжны үндэс

## 1 Гот үсэг- өнцөгтэй дармал үсэг

зажилсаар хоолны өрөөнд орвол Фернанда, Амаранта хоёр хар цагана дуугүй хооллон сууж байсанд ширээнэ эочиж уухад тэр хоёрын хэн нь ч түүний нэг л хачин байгааг мэдсэнгүй. Үүний өмнө Меме найз бүсгүйнхээ унтлагын өрөөнд нулимсаа гартал инээж, сүнсээ зайлтал уйлан хоёр цаг үймрээд, урьд сүмийн сургуулиас оргомоор оргомоор, “Тэр даруулт хуураараа өөртө л бургуй тавь” гэж хэлмээр хэмээр байвч зүрх хүрдэггүй байснаа сая дотроо уужрахад гэнэт бөөн зориг оржээ. Ширээний эхэнд сууж мөнхийн рашаан мэт дотрыг нь аятайхан болгох тахианы шөл идэж байхад нь Фернанда Амаранта хоёрын үнэн дур дурайтал харагджээ. Тэдний засдаг зантай, мулгуу урхаантай, дэгүүр сэвэх солиот бодолтойг нь улаан нүүрэн дээр нь хэлээд тавьчихмаар болсноо арайхийн амаа татжээ. Хоёр дахь амралтынхаа үеэр Меме эхийнхэ эзанг сайн мэддэгийн хувьд, эцгээ ёсыг бодсондоо гэртээ байдгийг дуулаад, түүний талд орж билээ. Хожим нь Петра Котесийн тухай өөртөө төсөөлөөд эцгийнхээ нууц амрагийг эхээ дуртайяа болгох сонгэж бодож билээ. Меме энэ бодож байгаагаа ил гаргаад хэлчих юм бол ямар хэрэг мандах болгэж согтуу ухаанаараа баясан бодоок, дотроо инээд нь хүрч байсанд Фернанда ажиглаад,

- Чи яав? Гэж асуувал Меме:

- Зүгээр. Та хоёрт хэчнээн хайртайгаа сая л мэдлээ гэж хариулжээ.

Амаранта энэ үгэнд үзэн ядах өнгө илэрхий сонсогдсонд хиртхийн айжээ. Гэтэл Фернанда сэтгэл уяраад, шөнө дунд Мемег толгой нь ангалзан, бөөлжиж эхлэхэд золтой л галзуурсангүй. Фернанда охиндоо бүтэн шил тосон тууга уулгаж, гэдсэн дээр нь халуун жин, толгойд нь хүйтэн жин тавьж, этгээд байрын шин э франц эмчийн хоёр цагүзсэний эцэст эмэгтэй хүний жирийн өвчин байна гэсэн бүрхэг онош тавин цагаан хоол идүүл гэснээр цагаан хоол өгч таван өдөр гэрээс гаргасангүй. Меме зүрх үхэж, сэтгэлээр унаж, ингэж шалдаа буусан учир хүлээхээс өөр мэх байсангүй. Таг сохорсон боловч тэнхлүүн, гярхай хэвээрээ Урсула л хар ухаанаараа онош тавьж: “Миний бодоход, согтуу хүнийгл тэгж эмчилдэг сэн дээ” гэж өөртөө хэлжээ. Гэвч дорхноо энэ бодлоо орхиж, тэр чбайтугай өөрийгөө гоомойдож байна гэж зэмлэжээ. Бага Аурелиано

Мемегийн гутранги байгааг үзэхэд гэмших сэтгэл төрж, охиноо хойшид харж хандаж явна гэсэн ам өгчээ. Тийнхүү эцэг охин хоёрын хооронд халуун дотно харьцаа үүсэж, эцэг нь архидан цэнгэж, ганцаардан зовохоос түр холдоход, охин нь ээжтэйгээ гарцаагүй түнжин хагардаг дээр тулаад байсан нь хойшилж хаширтал харж цагдахаас ангижрав. Тэр үед Бага Аурелиано Меметай үдэш цуг байвал болох нь тэр гээд хэнтэй ч уулзахыг больж, түүнтэй кинонд явах юм уу, цирк үзэж, завтай цагийнхаа ихэнхийг охиндоо зориулах болов. Сүүлийн хэдэн жилд Бага Аурелиано замбараагүй таргалж, өөрөө гутлаа үдэж, урьдсынх шиг хүссэнээ хийж чадахгүй болсондоо заннь их хувирчээ. Охинтойгоо хамт байх болсноор урьдынх шигээ хөгжилтэй болж, түүний дэргэд байхад сэтгэлнэг л өег байснаар архи дарстай нөхөрлөдөг нь аажмаар багасав. Мемехаврын яргуй шиг цэцэглэж байлаа. Амаранта нэг их хөөрхөн байгаагүй шиг Меме бас тийм хөөрхөн биш боловч нүдэнд дулаахан, эгэл даруухан, харангуут л сэтгэл татах увдистай байлаа. Түүний орчин үеийн байдалтай нь хуучирсан бөөрөнхий үзэлтэй, хахир зангаа нууж чаддаггүй Фернандагийн хувьд доромжлол болдог боловч Бага Аурелиано түүнийг нь сайшааж, элдвээр өөгшүүлдэг байлаа. Бага Аурелиано охиноо хутагт нарын аймтгай харцнаас багын айдаг байсан унтлагынх нь өрөөнөөс гаргаж, шинэ өрөө засаж өгөөд, хаан ширээ шиг ор, том гоёлын ширээ тавьж, хилэн хөшиг хийж, ингэснээрээ Петра Котесийн байрыг яг дуурайлгаж байгаага аанзаарсангүй. Бүр ч гар султай байж, хэчгнээн мөнг өгч байгаагаа ч тооцоолдоггүй, Меме өөрө өл халааснаас нь авдаг байлаа. Бага Аурелиано гадилын компанийн дэлгүүрээс авч болох эмэгтэй хүний гоо сайхны бүх шинэ зүйлийг охиндоо авч өгчээ. Мемегийн унтлагын өрөөнөө хумс өнгөлдөг зүлгүүр, үс эргүүлдэг хайч, шүд өнгө оруулдаг, гоо сайхны шинэ зүйл, өнгө зүс сайхан болгох хэрэгсэл өдий төдийгөөрөө дүүрчээ. Фернанда энэ тасалгаанд орох брийдээ охины нь гар нүүрийн хэрэгсэл хийдэг шигээ франц дууч эмсийнхтэй адилгэж бодохдоо эгдүү нь хүрдэг байлаа. Тэр үед Фернанда ярдаг зантай, сул биетэй Амаранта Урсулатай ноцолдоод, үл үзэгдэх оточтой сэтгэл догдлуулсан захидлаар харилцаад завгүй байжээ. Иймээс эцэг охин хоёрын сүжирхээд байгааг мэдэхдээ Мемег Петро Котесийнд хэзээ ч аваачихгүй гэсэн ам Бага Аурелианоогоос аваад л зогсжээ. Ингэж болгоомжилсон нь илүүц байлаа. Учир нь аав охин хоёрын дотно байгаад Петро Котес урам хугарч, мемергийн тухай сонсохыг ч хүсэхгүй байжээ. Бага Аурелианогийн нууц амраг урьд нь айгаагүйгээрээ айж, Меме хүсэх юм бол үхтлээ хайрлуулж явахаар боллоо гэж бодож байсан янаг хүнийгнь холдуулж, Фернандагийн чадаагүйг чадна гэж зөнгөөрөө мэдэж байлаа. Бага Аурелиано нууцхан армагийнхаа ууртай ширэв татахыг анх үзэж, хорон үгээр дайрахыг оснсож, нөгөө авдрыг нь гэрт нь буцаах вий гэж жаахан эмээх болов. Гэвч үүндээ ч арай тулсангүй. Петра Котесийн амрагаа судалсан шигхэн чэрэгтэй хүнийг тэгж судлаагүй. Амьдралаа элдвээр засаж залруулж, өөрчилж барьж төвөг удахад Бага Аурелиано туйлаас



дургүй тул авдрыг нь буцаахгүйгээ Петра Котес мэдэж байлаа. Иймээс Петра Котесавдрыг нь гэртээ байлгаад, хайртыгаа урдаа барьдаг ганц аргаараа охиноос нь булааж авах гэж үзэв. Тэрбээр дэмий хүчин сүйтгэжээ. Меме эцгийнхээ хэрэгт оролцох гээгүй, хэрвээ оролцдог юм аа гэхэд Петра Котест л ашигтай байх байв. Мемед хүн хорлох зав ч байсангүй. Өдөр бүр гэлэнмаа нарын зааснаар унтлагынхаа өрөөг цэвэрлэж, ор дэрээ хураана. Өглөө нь гонхонд хувцсаа янзалж, нэг бол юм хатгамаллаж, үгүй бол Амарантагийн хучин гар машинаар юм оёж байдаг билээ. Үдийн хоолны дараа бусад нь хоёр цаг унтаж байхадтэрбээр даруулт хуураа дарах сургууль хийгээд, ингэж биеэ гаргуунд гаргаснаар Фернандаг тайтгаруулж байгаагаа мэддэг байлаа. Мөн ийм л бодлоор сүмийн зах, сургуулийн баяраар концерт тоглоно. Гэвч урилга ирэх нь улам цөөрсөөрб айлаа. Орой нь энгийн гэг палааж, үдээстэй өндөр өсгийтэй өмсөж аваад, аэцэгтэйгээ нэгтийшээ явахгүй бол үерхдэг охидтойгоо оройн хоол идэхээр вядаг байв. Гэвч Бага Аурелиано дандаа шахам охин дээрэ эижр, кинонд дагуулан явна.

Мемегийн найз гэвэл гурван америк бүсгүй байлаа. Тэр гурав цахилгагнжуулсан хонууриасаа алудуран гарч, Макондогийн охидтой үерхэх болжээ. Тэдний нэг нь Патриц Браун байлаа. Бага Аурелиангийн дайлж зочилсонд баярласан ноён Браун Мемег гэртээ оруулж, бямба гаригийн бүжигт урьжээ. Энэ бүжиг дээр л гринго уугуул нутгийнхантайгаа харилцдаг байлаа. Фернанда Мемегийн уригдсаныг дуулахдаа Амаранта Урсула, үл үзэгдэх оточ нарын тухай бүр мартаж орхиод, орилж чарлаж, уйлж хайлж сүйд болжээ. “Чи бодоод үз, хурандаа булшиндаа юу бодож байгаа бол!” гэж тэр Мемед хэлжээ. Фернанда, Урсулагаар дэмжүүлэх гэж ч үзэв. Гэвч Фернандагийн бодсоноор болсонгүй, ганцхан, шүтээнээсээ няцалгүй, протестант шашинд орохгүй л бол бүжигт очих, үе тэнгийн америк бүсгүйчүүлтэйгээ найзлахад буруу нь юу байх вэ гэж сохор эмгэн хэлжээ. Хуланц ээжийнхээ хэлсэн санааг ойлгож, түүнээс хойш бүжигт очсоныхоо маргааш заавал эрт боод сүмд очдог болов. Фернанда байрыг харсхийж байтал Меме даруулт хуур дарахыг нь америкчууд сонсьё гэж байна хэмээн хэлж, түүнийг татгалзах аргагүй болгов. Хөгжмийг гэрээс зөөн, ноён Браунд аваачлаа. Тэднийдз залуу хөгжимчинд үнэн зүрхнээсээ алга ташиж, чин сэтгэлээсээ баяр хүргэж, түүнээ схойш бүжигт төдийгүй ням гаригт усан санд орох, долоо хоногт нэг удаа үдийн хоолонд урих болов. Меме мэргжлийн усчин шиг сэлж, одон бөмбөг тоглож, виргиний гахайн утсан махыг залаат шөгшгойн хамт идэж сурчээ. Бүжиг хийж, усанд сэлж, теннис тоглосоор өөрөө мэдэлгүй англи хэл сурчээ. Бага Аурелиано охиныхоо амжилтад баярлаж, хэрмэл худалдаачнаас олон өнөгтө хавчуулгатай зураган боть англи нэвтэрхий толь авч өгсөнд Меме чөлөө заваараа унших болов. Энэ номыг уншсанаар бүсгй найз нартайгаа нийлэх, хайр сэтгэлийн тухай чалчихаа больсон ньо, уншиж гэгээрэх гэсэндээ ч бус, ердөө л хот нийтээрээ мэддэг юмыг далан долоо ярьж байх ямар ч хүсэлгүй болсондоо тэгжээ. Өөрийн

согтсон нь хүүхдийн саваагүй зангийнх гэж бодогдох болж, тэр нь их л инээдтэй санагдаж, эцэгтээ хэлбэл цаадах нь бүр ч хөгжиж “Эх чинь мэдсэн бол доо!..” гэж элгээ хөштөл инээн хэлжээ. Охин нь нууцаа итгэж хэлэх тоолонд нь ингэж хэлдэг байлаа.”Хүнд сэтгэлтэй болбол түүнийгээ нууж хаалгүй хэлнэ” гэсэн ам охиноосоо авч, амралтаараа эцэг эх дээрээ ирэн нэгэн хонгор үстэй америк залуу аятайхан санагдсаныг Меме ч удалгүй эцэгтээ хэлжээ. “Үгүй мөн золиг оо! Эх чинь мэдвэл дээ!..” гэж бага Аурелиано инээжээ. Гэвч залуу эр нутагтаа буцаад үхсэн амьд нь мэдэгдэхгүй боллоо гэж Мемем эцэгтээ хожим нь дуулгажээ. Меме хэрсүү ухаанаараа эцэг эх хоёрынхоо эвтэй найртай байхад тусалсан боловч Бага Аурелиано яваандаа дахин Петро Котесийнх руу шогших болов. Наргиж цэнгэхэд бие сэтгэл нь урьдынх шигээ нэг их хөгжихөө бльсон боловч наргиж цэнгэх, гутлын үдээсээр хүлж тогтоосон товчтой найраг баян хуураа хайрцагнаас гаргах далимыг алдаггүй байлаа. Гэттээ Амаранта хулдсаа хатгамалласаар, Урсула хөгширч харанхуй орчлонд улам лав орж, туулайн бөөр модон доор байгаа Хосе Аркадио Буэндиагийн хий биеэс өөр юмыг олж харахаа больжээ. Фернанда эрх мэдлээ лавшруулж байлаа. Хүүдээ сар бүр захидал явуулж, байдлыг бүх үнэнээр нь бичиж, гагцхүү үл үзэгдпэх оточ нартай захидлаар харилцдаг тухай, тэд бүдүүн гэдэсний хоргүй хавдар тусаж гэж оношлоод сэтгэлээр засан ховсолж эмчлэх гэж байгаа тухай л нуужээ. Амьдралын хатуу хүтүүд нухлагдсан Буэндиагийнхан одоо л нэг амар заяа үзэж, он удаан жил төвшин жаргах нь дээ гэмээр байтал Амаранта гэнэт үхэж дахин бөөн явдал болов. Түүнийг үхнэ гэж хэн ч санаагүй байлаа. Амаранта хөгширсөн, хүн амьтантай нийлэхээ байсан боловч нуруу цэх, тэнхлүүн царигтай, төмөр шиг биетэй боловч нуруу цэх, тэнхлүүн царгигтай, төмөр шиг биетэй хэвээрээ санагдаж байлаа. Хурандаа Геринельдо Маркесийг өөрөөсөө бүрмөсөн холдуулснаасаа хойш өрөөгөө түгжиж байгаад, дотроо онгойтол улийж авсан бөгөөд, юу бодож байсныг ньхэн ч мэдсэнгүй болно. Амаранта унтлагынхаа өрөөнөөс гарч ирэхдээ нэгэнт бүх нулимсаа барсан байлаа. Сайхан Ремедиосын тэнгэрт халихад ч, бүх Аурелианог алагдахад ч, ертөнцөд хамгийн хайртай хүн болох хурандаа Аурелиано Буэндиаг үхэхэд ч уйлсангүй. Түүнд тийм хайртай байснаа хүүрийг ньтуулайн бөөр модны доороос олоход л сая ойлгожээ. Амаранта үхдэлийг өргөлцөн оруулж, цэргийн хувцсыг нь өмсгөж, үсийг нь самнаж, сахлыг нь авч, ид алдраа мандуулж явахдаа өөрийнх нь имэрдэг байснаас илүү живрийг нь имрэн сөрвийлгөжээ. Цөмөөрөө хөдөөлүлэх ёсыг сайн мэддэгт нь дассан болохоор хэн ч түүнийг ахдаа хайртайдаа тэгж байн агж бодсонгүй. Амаранта католик шашны амьдралтай холбооогнь олийгохгүй, үхэлтэй холбоотойг нь мэддэг, католицизмыг шашин бус, нутаглуулах, дэг ёс мэтээр үздэг гэж Фернанда зэвүүцэн ярьдаг байв. Гэвч Амаранта бодолдоо даргадаад, католик шашныг өмөөрсөн ороо бусгаа үгийг нь сонсдоггүй байв. Хөгширсөн обловч сэтгэлийн шаналгаа нь мартагдсангүй. Он удаж хал үзсэн боловч хаширсангүй. Пьетро Креспийн вальсын аялгуу

дуугарахад залуугийнх шигээ л уйлмаар болдог байлаа. Хатуу цаас нь чийгэнд ялзарч гэж шалтаглан бортогой аяыг хо дээр өөрийн гараар хаясан боловч сэтгэлд нь эдгээр нь эргэлдсээр, хуурын дохиурыг хөдөлгөсөөр байх мэт болсоор байлаа. Нэг үе зовлонгоос өөр юм өөрөөс нь хойш үлдэхгүйд з зовж, нөгөө үе үүндээ байж чадахгүй болтлоо бухимдан, хуруугаа зүүгээр хатгаж, дурлалын анхилам үнэрт, өтөндз идүүлсэн цэцэг өөртэй нь хамт үхэх нь гэж бодохоос бүр ч тарчлан,галзууран алддаг байлаа. Хурандаа Аурелиано Буэндиа дайныг бодохгүй байж чаддаггүйчлэн Амаранта Ребекаг бодохгүй байж чаддаггүй байлаа. Гэвч ах нь тайван бодож чаддаг байхад Амаранта бодоходоо байж яддаг байв. Амаранта Ребекагаас өмнө үхүүлж бүү гэсгээрэй гэж тэнгэр бурхнаас гуйж олон жил мөргөжээ. Өрсөлдөгч асныхаа байшингийн хажуугаар гарахдаа улам эвдэрснийг нь хара хбүрийдээ, гуйж мөргөснийг нь тэнгэр болгоожээ гэж баярладаг байв. Нэг удаа гонхонд юм оёж суутал нь яг энд сууж, яг ийм байдалтай, яг ийм гэрэлтэй байхад Ребекаг үхлээ гэж өөрт нь хэлэх нь байна гэсэн гүн итгэл гэнэт төржээ. Түүнээс хойш Амаранта захидал хүлээдэг шиг тэрхүү мэдээг хүлээх болж, зүгээр суувал цаг өнгөрөхгүй, ихэд чилээх бадйалтай тул, тэр чбайтугай товчийг ханзлаад дахин хаддаг байлаа. Амаранта гоёмсог хулдсаа Ребекад зориулан оёж байна гэдэгт гэрийнхнээс нь хэн нь ч эргэлзэхгүй байла. Ребека үрчгэр арьстай, толгойдоо хэдэн шар үстэй сүг болж хувирсан байсныг Гунигт Аурелианоогоос сонсохдоо түүний ярьсан тэр сг өөрийн нь сэтгэлдээ бодож байсантай яг таарсан учир огт гайхсангүй билээ. Ребекагийн хүүрийг засаад, нүүрний сэвийг парафины тосоор шаваад, хутагт нарыг үсээр хиймэл үс хийж, хүүрийг сайхан бэлтгээд ёрог хулдсанд ороож, гадна талыг нь ямаан хилэнгээр бүрж, улаан торгоор доторлосон авсанд хийж, олон хүн дагуулан явж, түүнийг өтний идэш болгоно гэж шийджээ. Амаранта тэсгэлгүйеэ хорсон, тэгнэ ингэнэ гэж бодож байхдаа Ребекад хайртай байсан ч ингэх байсан гэж гэнэт толгойд нь оржээ. Амаранта ингэж бодохдоо цочсон боловч санаагаар унасангүй, бодсоноо улам нарийвчлан боловсруулж, удалгүй оршуулах ёслолын жинхэнэ мэргэжилтэн болжээ. Тэр аймаар юмыг төлөвлөхдөө тэнгэрт хэчнээн мөргөвч Ребекагаас түрүүлж үхэж болзошгүй гэдгийг дутуу болжээ. Гэтэл яг тэглээ. Цагаа болохоор Амаранта санаснаар болсонгүй гэж гудайсангүй, харин ч эрлэг хэдэн жилийн өмнөөс насны хэмжээ болж байгааг нь мэдэгдэн энэрэл үзүүлсэнд бүр санаа амарчээ. Мемег сүмийн сургуульд явуулсны дараахан нэгэн халуун үдээр Амаранта эрлэгийн элчийг хажууд нь юм оёж суухыг дор нь таниад ахиулан харвал нэг их аймаар юмгүй, Урсулад тусалж, байх үедээ Пилар Тернера ийм байсан болв уу гэмээр цэнхэр палаажтай, урт үстэй, ялихгүй хуучны маягийн нэг эмэгтэй байлаа. Фернанда гонхонд эрлэгийн элчтэй хэд хэд дайралдахдаа түүнийг яг л хүн шиг барим тавим байсаар байтал, тэр ч б байтуагй нэг удаа Амарнатагаас “Зүү сүвлээд өгөөч” гэж гуйсаар байтал олж харсангүй. Эрлэгийн элч Амарантаг хэдэн сарын хэдний өдөр үхэхийг нь хэлсэнгүй. Ребекагаас түрүүлэх эсэхийг нь

ч дурдсангүй, гагцхүү “Ирэх дөрөвдүгээр сараны зургаанаас л өөртөө хулдас оёж эхэл” гэж айлджээ. Эрлэгийн элч Амарантаг хулдсыг санаснаараа төвөгтэй, гоё оёж болно, тэгэхдээ Ребекагийнх шиг гараа гаргаж оёх хэрэгтэй гээд ажлаа дуусгасан өдрийнхөө шөнө зоволгүй, уйтгарлалгүй, айж барих юмгүй үхнэ гэж айлджээ. Амаранта аль болохуйц ихээхэн цаг зарахын тулд шилмэл мяндсан утас захиж, хулдсаа нэхэж эхлэв. Тэгэдэ гараа гаргаж зөвхөн нэхэхэд л дөрвөн жил зарав. Дара ань хатгамаллаж гарлаа. Тойрох аргагүй тэр өдөр ойртох тусам, чухал ид шидийн л юм болдоггүй бол Ребекагийн үхэх хүртэл хулдас хийхийг сунжруулах аргагүй гэдгийг улам тод ойлгож, ажилдаа улайсаар тайвширч горь нэгэнт тасрахад бүр анаа амарчээ. Чухамхүү тэгэхэд л хурандаа Аурелиано Буэндиа алтан загас тарсалтгүй хийж байсаны учрыг олжээ. Амарантагийн хувьд гадада ертөнц гэдэг нь бейин гадна тал болж, дотоод ертөнц нь ямар ч гутралд автахааргүй болжээ. үүнийг олон жилийн өмнө ойлгосон болоосой, сэтгэлдээ байгааг тунгааж, орчлон ертөнцийг өөрөөр харж, Пьетро Креспигээс гардаг лаваанд цэцгийн үнэрийг үдшийн бүрэнхийд санахдаа сэрдхийхгүй болж, Ребекаг, хайртайдаа ч бус, үзэн яддагтаа ч бус, ганцаардаж байсныг нь ясандаа тултал ойлгохдоо үгээгүй хоосон байдлаас гаргах байсан сан гэж Амаранта амаа барьжээ. Нэг орой Амаранта Мемегийн үгнээс үзэн ядсан өнгө сонсохдоо өрөийн эсрэг хандсанд бус, өөрийнх нь шиг цэвэр ариун гэж бодогдом боловч хорсолд эвдэрсэн өрөөлийн залуу наснаас өөрийгөө олж харсан учир сэрдхийжээ. Гэвч одо юуг ч өөрчлөх хөг өнгөрсөн гэдгийг ойлгохдоо сэтгэл гутарсангүй, үйлээ дагая гэж боджээ. Үхэхдээ өмсөх хувцсаа оёж дуусгах гэж л ганц санаа тавих боллоо. Эхний үед ажлаа удаашруулах гэж элдвэ хэрэггүй юм блодож олдог байсан бол сүүлдээ харин ч яарах болов. Дуусахад долоо хоног үлдмэгц бодож үзвэл хоёрдугаар сарын дөрөвний орой сүүлийн учиг авах байсанд ямар учиртайг Мемед хэлэлгүйгээр тавны өдөр тоглохоор товлосон концертоо хойшлуулаач гэж битүүхэн хэлсэн боловч Меме түүнийг нь тоосонгүй. Тэгэхлээр нь дөчин найман цаг хойшлуулах арга сүвэгчилж, хоёрдугаар сарын дөрөвний үдэш шуурганд цахилгаан станц эвдэрсэн тул эрлэгийн элч хүссэнээр нь болгож байна гэж боджээ. Гэвч маргааш нь өглөөний найман цагт Амаранта эмэгтэй хний гараар бүтсэн хамгийн гоё хулдсын сүүлийн шаглааг тавиад орой нь үхнэ гэдгээ тайван, ямар ч илүү дутуу санаагүй хэлжээ. Үхэхээ гэрийнхэндэ этөдийгүй, бүх хотынхонд дуулгаж, үхэхдээ амьтан хүнд баян хийвэл харуу амьдарч ирсний гэгийг цагаатгаж болно, ингэхийн тулд үхэгсдэд захидал хүргэж өгвөл хамгийн тохиромжтой юм гэж шийджээ.

Амаранта буэндиа энэ ертөнцөөс одож, үхэгсдийн орноо шуудан хүргэж өгөх нь гэсэн мэдээ Макондо даяар үдээс өмнө тарж, өдрийн гурван цагт хайрцаг дүүрэн захидал цугласан байлаа. Захидал бичээгүй нь амаараа мэнд дамжуулж, Амаранта түүнийг ньталийгаачийн овог нэр, үхсэн өдөртэй хамт дэвтэртээ тэмдэглэж аван “Санаа зоволтгүй ээ. Очингуутаа олж мэдээд захидлыг нь

дамжуулна” гэж тайвшруулаж байв. Энэ бүхэн нь ший аятай санагдаж байлаа. Амаранта огтхон ч айж түгшсэн, уй гашуу болсон шинжгүй, хийх юмаа хийлээ гэж бодсоноос бүр залуужсан мэт байла. Хацар нь хонхойж, үүдэн шүд нь унаагүй сэн бол цэх, гуалиг тэрбээр огт оворгүй харагдаж байлаа. Захидлыг давирхайдсан хайрцагт хий гэж зөвлөөд, булшинд чийгэнд цохиулахгүйгээр яаж тавивал таарахыг зааж өгөв. Өглөө нь дуудуулсан мужааан өөрөөс нь авсны хэмжээ авч байхад хувцасны хэмжээ авахуулж байгаа юм шиг тайван зогсож байлаа. Сүүлийн хэдэн цагт их л идэвхийлж байгааг нь үзэхдээ Фернанда түүнийг үхнэ гэж тоглоом хийсэн юм биш байгаа даа гэж сэжиглэжээ. Урсула Буэндиагийнхны өвдөж зоволгүй үхдэгийг мэдэх болохоор Амарантаг үнэхээр үхэх дохио авчээ гэдэгт итгэж байсан боловч, захидал явуулж байгаа мангуурсан улс захиа занга энэ тэр гэж үймж, түүнийгээ хурдан хүргүүлэх гэж яарч байгаад охиныг нь амьдаар оршуулчих вий гэж айж байлаа. Иймээс Урсула зандарч хашгирч, маргаж хэрэлдсээр гадны улсыг хөөн өдрийн дөрвөн цаг гэхэд гаргаж дуусав. Энэ үеэр Амаранта юмаа тарааж өгөөд, солих дотуур хувцас, угладаг тансран шаахай л үлдээн, харуулсан банзаар хийсэн ерийн авсан дээр тавьсныг үхсэний нь дараа өмсүүлэх ёстой байлаа. Хурандаа Аурелиано буэндиаг үхэхэд урландаа өмсдөг улавчнаас өөр юм байхгүй байсан тул шинэ шаахай худалдан авах хэрэг гарсныг санаж, шаахай авахаа мартсангүй. Таван цагийн өмнөхөн Бага Аурелиано Мемег концертод хүргэж өгөхөөр ирээд, гэрээ оршуулгын байдалтай зассан байхыг үзэхдээ гайхжээ. Энэ үед хамгийн сэргэлэн хэн байсан бэ гэвэл Амаранта байж, тэр ч байтугай хөлдөө ургасан эврийг авах зав олжээ. Аурелиано, Меме хоёр түүнтэй тоглоомтойёо салах ёс гүйцэтгэн, долоо хоноод дахин амилахад тань зориулж найр хийнэ гэж амлажээ. “Амаранта Буэндиа үхэгсдэд авч очих захиа цуглуулж байна” гэсэн сураг дуулсан Антонио Исабель лам “тослох ёс”<sup>1</sup> үйлдэхээр заларч ирээд үхэх гэж байгаа хүнийг угаалгын өрөөнөөс гарч ирэхийг хорь гаруй минут хүлээжээ. Түүнийг зөөлөн даавуу цамцтай, үсээ задлан унжуулаад өмнө нь очиход өтөлсөн лам өөрийг нь даажин хийж байна гэж үзээд ариун

1 Католик облон үнэн алдартны шажинд өвчтэй буюу үхэх гэж байгаа хүний биеийг оливын тосоор тосолж, уншлага уншдаг зан үйл бий.

Хишиг<sup>1</sup> залж ирсэн хөвгүүнийг гэдрэг буцаажээ. Гэвч хориод жил нүглээ наманчилахаас зугтсан Амарантагаар далим гарсных нүглийг наманчлуулах гэвэл цаадах нь “Хийсэн гэм унал байхгүй тул сэтгэл төвшин” дах нь “Хийсэн гэм унал байхгүй тул сэгэл төвшин” гэж шулуухан хэлжээ. Фернанда үүнд нь эгдүүцэв. Фернанда хэлж байгааг нь Амарантаг дуулчих вий гэж ч санаа зовох юмгүйгээр “Үнэнээ хэлж шившгээ тарьсанд орвол хэлэхгүй байж

байгаад үхсэн нь дээр гэж үзэхээр ямар аймшигт хилэнц үйлдчихсэн хэрэг вэ?” гэж чанга гэгч дуугарч орхижээ. Тэр үед Амаранта хэвтэж, Урсулаг өөрийнх нь онгон хальстайгаа байгааг олонд хэл гэжээ.

- Хэн ч бүү уруу татагдугай. Амаранта Буэндиа энэ ертөнцөд ямар байдалтай ирлээ. цг тэр хэвээрээ буцлаа гэж Фернандаг дуулдаг гэж хашгирав.

Дахиад тэр боссонгүй. Өвчтэй хүн шиг дэрээ налаад, урт газгээ сүлжээд, чихэндээ хавчуулав. Эрлэгийн элч авсанд тийм байдалтай байх ёстой гэж хэлж өгсөн юм санажээ. Дараа нь Амаранта Урсулаг “Толь авчирч өгөөч” гэж гуйгаад, дөч гаруй ижл завсарласны эцэст он жил, зовлон зүдгүүрт үрчийсэн нүүрээ харада яг өөрийнх нь бодсоншиг байсанд гайхжээ. Унтлагын өрөөнд чимээгүй болж байгаагаар Урсула бүрий болж байгаа юм байна гэж ойлгов.

- Фернандатай салах ёс хий. Эвлэрэх нэг агшин гэдэг нөхөрлөж өнгөрөөсөн бүхэл бүтэн амьдралаас ч илүү байдаг юм гэж Урсула гуйсанд Амаранта:

- За даа, хэрэггүй биз ээ гэж хариулжээ.

Яаруу босгосон тайзан дээр дахиан гэрэл асаж, концертын хоёрдугаар хэсэгт эхлэхэд Мемегийн сэтгэлээс Амарантагийн гарахгүй байлаа. Яг тоглож байтал жүжгийн дундуур нэг хүн болсон явдлын тухай чихэнд нь шивнэж, концертоо зогсоов. Бага Аурелиано гэрт орж, амьтны дундуур чихэлдсээр очиж үзвэл гэртээ өтөлсөн авгай ганган гэгчийн хулдсанд ороолттой царай нь хувиран цайчихсан, гараа хар даавуугаар боосон чигээрээ хэвтэж байлаа. Авсыг зочдын өрөөний голд хайрцагтай захидлын дэргэд тавьжээ.

1 Ариун хишиг гэдэг нь талх дарс хоёр бөгөдө энэ хоёрыг Христосын бие, цусыг бэлгэдэн хишгийн багварт хадгалж байгаад сүсэгтэнд хишиг болгон хайрладаг, сүмд очиж хишиг хүртээх ёслолд оролцож чадаагүй хүнд авчирч өгдөг ажээ. – Орч.

Амарантагийн хойноос буян үйлдсэн ес хоногийн дараа Урсула хэвтэрт ороод дахиж боссонгүй. Санта Софи де ла Пьедад чавганцыг өргөх болов. Унтлагынх нь өрөөнд идэх уух юм, нүүр гар угаах ус зөөж, Макондод болж байгаа бүхнийг ярьж өгдөг байлаа. Бага Аурелиано Урсулаг байнаг эргэж тойрч, янз бүрийн хувцас авчирч өгөхөд Урсула орныхоо хажууд өдөр тутам хэрэглэдэг зүйлийнхээ хажууд хураан, удалгүй гар хүрэх газарт байхгүй юмгү й болжээ. Тэрбээр өөрийг нь хуулж төрсөн бяцхан Амаранта Урсулагийн хайрыг таатж, түүнд бичиг зааж өгөв. Түүний нүд муудсан гэдгийг цөмөөрөө ойлгож байсан боловч хэн нь ч таг сохорсныг нь одоо болтол мэдэхгүй, ухаан саруул, бусдын тусламжгүйгээр болоод байдагт нь зуун насныхаа хүндэд дарагджээ гэж бодож байлаа. Тэр үед Урсула завтай, бодох санах юмгүй болсон тул гэрийн

амьдралыг ажиглаж байх боломжтой болж, Мемегийн дотуур шаналж байгааг анх анзаарч,

- Нааш ир ээ, юу болоод байгаагаа муу эмгэндээ аминчлаад хэлчих гэж бүсгүйд хэлжээ.

Меме ичингүйрэн инээд алдсанаа яриаг дүйвүүлээд өнгөрөв. Урсула ч дахиж шахаж шалгаасангүй боловч Мемег орж ирэхээ больчиход нь сэжиглэх болов. Меме одоо урьдынхаасаа эрт босож, гэрээсээ л гарахгүй бол тайван сууж чадахгүй, шөнийн дуусан орондоо эргэж хөрвөж, тасалгаагаар эрвээхий нисэхэд нь нойр нь хулжаад байгааг Урсула мэдэж байлаа. Нэг удаа Урсула Мемегийн эцэг рүүгээ явлаа гэж хэлж байхыг сонсоод, түүний дараахан Бага Ауреиано ирж охиноо хаана байгааг асууж байхад Фернанда ажиг сэжиг авахгүй байгаад гайхаж билээ. Меме нууц ажилтай, яаруу хэрэгтэй, далдуур санаа тавих юмтай болсон нь, Фернанда кинон дээр Мемег эрэгтэй хүнтэй үнэсэлдэж байхад нь бариад бөөн юм болсон тэр нэг оройноос бүүр өмнө мэдэгдэж байлаа.

Сэтгэлийн гансралд бүрэн автсан Меме өөрийг нь Урсула ч л барьж өглөө гэж боджээ. Угтаа бол өөрөө өөрийгөө барьж өгсөн байлаа. Меме сохор хүн ч сэжиглэхээр ул мөр аль эртнээс үлдээж байсан боловч Фернанда үл үздэх оточ нартай нууцаар харилцаад тийнхүү мэдтэлээ удсан хэрэг байжээ. Гэвч охин нь удтал дуугаа хурааж, нэг бол зүв зүгээр байж байгаад давхийж, зан нь эрс хувирч, үг дуулах нь муудаж эхлэснийг Фернанда яваандаа ажиглажээ. Тэгээд Мемегийн алхах гишгэх бүрийг сэмхэн тандах болов. Үерхдаг бүсгүйчүүдтэйгээ гарахад нь хорихгүй, бямба гаригийн баяраар хувцаслахад нь тусалж, бүсгүйг хар авахуулчихаар ганц ч юм асуухгүй байлаа. Фернанда Мемегийн үгийнх нь байрыг харж хийх гэснээ хийхгүй байгаагийн олон баримттай болсон боловч гарцаагүй барьтлаа сэжиглэж байгаагаа хэлсэнгүй. Нэг орой Меме эцэгтэйгээ кинонд явлаа гэж хэлэв. Жаахан байж байтал Петра Котесийнхоос баярын цаасан буу тавих, өр ямар ч хууртай андуурах аргагүй Бага Аурелианогийн найраг баян хуурын эгшиглэх чимээ дуулдав. Тэгэхэд нь хувцсаа өмсөөд, киноны хүрээлэн рүү очвол эхний эгнээнд охин нь сууж байгаа харагдлаа. Сэжиглэж байсан нь гарцаагүй болсонд Фернанда сэтгэл үймэрч байгаад Мемег үнэссэн х үний таньж амжаагүй боловч шүгэлдэх, нэрхийтэл хөхрөлдөх дуу дундуур “Уучлаарай, хонгор минь” гэж хэлэхийг нь дуулаад л үг дуугүй Мемег танхимаас гулд татан гарч, Туркийн хөл ихтэй гудамжаар нүдний булай болгон чирж явсаар, гэртээ авчирч, унтлагынх нь өрөөнд цоожлов.

Хойд өдөр нь зургаан цагт нэг хүн Фернанда дээр ирэхэд дуугаар нь түүнийг танив. Ирсэнхүн нас залуу, царай уйтгартай бөгөөд фернандза цыгантай уулзаж явсан бол гунигт хар нүдийг нь харадатэгж их гайхахгүй сэн биз ээ. Өр нимгэн өөр эмэгтэй бол залуугийн санаашрангүй байдалтай царайг

хараад Мемег ойлгох сон билээ. Ирсэн хүн элэгдсэн ёрог даавуун косчоом өмсөж, тордох гэж их л мэрийсэн, цайран зос хэдэн давхар түрхсээр байгаад тэр нь хагарсан шаахй өмсөж, өнгөрсөн ням гаригт хуладан авсан сийрсэн бүрх барьжээ. Сайхь эр их айж байлаа. Насандаа хэзээ ч ингэж айж байгаагүй, хойшдоо хэзээ ч ингэж айхгүй биз ээ. Гэвч сандралгүй, хэнэггүй байдалтай зогсож байсан тулдаа дорд үзэгдэлгүй гарч чадав. Хүнд ажилд эвдэрсэн хумстай бохир гараас бусад бүх юмыг нь харахад төрөлхийн боь сэтгэлтэй нь илт байлаа. Гэсэн хэдий боловч Фернанда энэ хүнийг үзэнгүүтээ хар ажилчин байнагэж ойлгожээ. Цайныхаа цорын ганц косчоомыг өмссөнийг гадилын тариалан дээр ажилласаар хамуурсан хүнийг шигхөрзийснийг ажиглаж, түүнд ам нээх ч зам өгдөггүй, тэр ч байтугай үүдээр ч оруулсангүй, гэр дүүрэн шар эрвээхий болсон учир хаалгаа түүс болж,  
- Явж үз. Ёстой төртэй айлд танд хийх юм байхгүй гэж хэлжээ.

Тэр хүнийг Маурисио Бабилонья гэдэг байлаа. Макондод төрж өсөөд, гадилын компанийн засварын газар туслах механик хийдэг байлаа. Мемей тариалангийн руу явахаар Брауны охин Патрицитай машин авахгэж очоод санамаргүй танилцсан юм санжээ. Жолооч нь өвчтэй байсан учир машиныг Маурисио Бабилонья барих болж Меме жолоочийн хажууд сууж, жолооны бүх оньсыг харах гэсэн хүсэлнь биелжээ. Маурисио Бабилонья жинхэнэ жолоочтой адилгүй уриалгахнаар нэгднэгэнгүй тайлбарлаж өгчээ. Энэ нь Меме дөнгөж ноён Брауныхаар орж гардаг болсон үеэр, машин барих нь эмэгтэй хүний ажил биш гэж үздэг байсан үеэр таарчээ. Иймээс Меме онолыг тайлбарлуулан сэтгэл ханаад хэдэн сар Маурисио Бабилоньтятай уулзсангүй. Тариалан дундуур зугаалж явахад түүний эрэлхэг бөгөөд гоолиг байдал анхаарлыг нь татаж, гагцхүү ширүүн гар нь л сэтгэл дундуур санагдсаныг дэндүү биендээ эрэмшдэг ньтун эвгүй бодогдсоныг Патрицитай ярьж байснаа хожим нь санажээ. Нэг бямба гаригт Меме эцэгтэйгээ кинонд явж, Маурисио Бабилоньяг ёрог косчоомтойгоо өөрсдөөс нь холгүй сууж байхыг дахин харжээ. Анзааран үзвэл цаадах нь кино төий л сонирхсон юмгүй байн байн эргэн харж тэгэхдээ харах гэхээсээ илүү харж байгаагаа мэдэгдэх гэж тэгж эргэх ажээ. Меме ийм бүдүүлэг аашилж байгаад дургүй нь хүрэв. Кино тарахад Маурисио Бабилонья, Бага Аурелинотой ирж мэндлэхэд л Меме тэр хоёрын бие биеэ таньдгийг, Маурисио Бабилонья урьд нь Гунигт Аурелиногийн жижиг цахилгаан станцад ажиллаж байсныг мэджээ. Маурисио Бабилонья захиргаанд байсан хүний зангаар эцгийг нь их л хүндэлж байлаа. үүнийг мэдсэнээр Меме түүний их зангайд дургүй хүрдэг байснаа болив. Тэр хоёр хоёулхнаа уулзаж байгаагүй, мэнд усаа мэдэхээс өөр үг солиогүй мөртлөө гэнэт нэг шөнө Меме түүнийг хөлөг онгоц живж байхад өөрийг нь аварч байна, гэтэл баярлах бус уур нь хүрч байнагэж зүүдэлжээ. Меме түүний хүссэнийг л өөрөө дагаж байна гэж зүүдэлж, гэтэл Маурисио Бабилонья төдийгүй өөрийг нь хөөцөлдсөн ямар ч



хүнээр гуйлгана гэж боддог байсандаа сэтгэл тайвангүй болсон боловч, сэрэхдээ Маурисио Бабилюнъяг үзэн ядсангүй, харин уулзах сан гэж тэсгэлгүй мөрөдөх болжээ. Долоо хоног өнгөрч өгөхгүй удах шиг облж, сэтгэл нь улам түгшиж, бямба гариг гэхэд байж суух аргагүй болж, Маурисио Бабилюнъя өөртэй нь кинон дээр мэндлэхэд зүрхээ хэнхдэгээ дэлбэлчих шахан цохиж байгааг мэдэгдүүлэхгүй гэж байдгаараа чармайжээ. Баярлах, уур хүрэх хоёр давхацсан тэрбээр гара аанх өгч, Маурисио гарыг нь анх атгажээ. Меме Сэтгэл хөдөлснөөс болоод гараа өгсөндөө хором хэртэй гэмшсэн боловч түүний гарыг мөс шиг хүйтэн, чийгтэйг үзэхдээ бах нь ханажээ. Маурисио Бабилюнъяд бүтэшгүй юманд санаархаж байна гэдгийг нотлохоос нааш ганц хором амар зая үзэхгүй нь гэдгээ шөнө нь мэдээд, долоо хоног ганцхан тэр тухай боджээ. Патрици Брауныг машин авахаар өөртэйгөө хамт явуулах гэж янз бүрийн арга зохиож үзэв. Тэгээд шар үст америкийг Макондод ирснийг далимдуулж машины шинэ загвар үзье гэж түүнийг гараашид чирч очив. Мемц Маурисио Бабилюнъяг харахдаа биеэ хураах гэж оролдохыг больж түүнтэй хоёулхнаа байх сан гэж туйлгүй хүсэж байгаагаа ойлгожээ. Маурисио Бабилюнъя хаалгаар орж ирэнгүүт нь үүнийг нь бас ойлгочихсоныг үзээд уур нь хүрэв.

- Би шинэ загвар харах гэж ирлээ гэж Меме хэлэв.
- Муугүй л шалтаг байна гэж цаадах нь хариулав.

Маурисио Бабилюнъягийн их зангийн дөл түлэх шиг болсонд Меме түүнийг доромжлох арга цухалдан эрж байтал тэгэх зав өгсөнгүй. “Айлтгүй ээ. Эмэгтэй хүн эрэгтэй хүнд ухаан жолоо анх алдаж байгаа нь энэ биш” гэж дуугаа намсган хэлэв. Меме өөрийгөө арчаагаа алдсан мэт бодож, шинэ загварын машинаа ч харалгүй гараашаас явж, шөнөжин орондоо хөлбөрч, бухимдан уйлжээ. Өөрийнх нь сонирхож эхэлж байсан шар үст америк одоо өлгийнөөсөө гараагүй амьтан шиг санагджээ. Шар эрвээхий л үзэгдвэл Маурисио Бабилюнъя хүрч ирж байна гэдгийг чухамхүү эгэхэд л ажиглажээ. Урьд нь шар эрвээхийтэй дайралдаж тэгэхдээ гараашт л их дайралддаг байсан болохоор будгийн үнэрээр л их эргэлддэг юм байх гэж бодож байлаа. Үзэгчдийн харанхуй танхимд өөрийнх нь толгой дээр шар эрвээхий эргэлдэж байсан тухай хүмүүсийн ярихыг сонсжээ. Гэхдээ Меме өөрийг нь Маурисио Бабилюнъя олны дотроос ганц өөрт нь харагддаг хий юм аятай дагаад салаха болих үес л шар эрвээхийг түүнтэй холбоотой юм байна гэж ухаарчээ. Концерт, кинон дээр сүмд хурла хурж байхад Маурисио Бабилюнъя ямагт олны дотор байх бөгөөд түүнийг хаана байгааг мэдье гэвэл шар эрвээхийг харцаараа эрэхэд л болдог байлаа. Нэг удаа Бага Аурелиано энэ эрвээхий бүчээд яршигтай гэдэг нь гэж хараал тавин үглэхэд Меме урьд нь амласнаараа нууцаа эцэгтээ хэлчих дөхсөн боловч “Ээж чинь мэдсэ бол доо!” гэж энэ удаа ердийнхөөрөө инээхгүй гэдгийг зөнгөөрөө мэдээд амаа хамхижээ. Нэг өглөө Фернанда Меме хоёр сарнайн бут тайран засаж байтал Фернанда гэнэт чарлан, Сайхан Ремедиосын тэнгэрт ниссэн тэр газраас

охиноо хажуу тийш нь татан зайлуулав. Гэнэт агаар чичрэх шиг болж, охин нь бас дээш хөөрөөд явчих гэж байгаа мэт санагдан ухаан алдчихжээ. Гэвч энэ нь эрвээхий байлаа. Эрвээхий нарын гэрлээс гараад ирэв үү гэлтэй гэнэт нүпдний өмнө гарч ирсэнд зүрх нь ёг хийжээ. Яг энэ агшинд Маурисио Бабилонья боодолтой юм барьчихсан, цэцэрлэгт орж ирээд “Патрици Браун энэ бэлгийг явууллаа” гэж хэлжээ. Меме царайгаа улс хийхэд чармайн төв болгоод тоомжиргүй янзтай инээмсэглэж, “гар шороотой байгаа тул гонхны цэцгийн тавиур дэрэ тавьчихгүй юу” гэж хэлжээ. Фернанда тэр хүнийг бараг анзаарсангүй, урьд нь дайралдаж байснаа ч саналгүй, түүнийг гэрээсээ хөөж гаргана гэдгийг ч зөгнөсөнгүй, гагцхүү өвчтэй, шар арьстайг нь л ажиж,

- Ямар хачин хүн бэ! Царайг нь харахад эрлэгийн дансанд орчихсон хүн байна гэж хэлжээ.

Эхийгээ эрвээхийг мартахгүй байж магадгүй гэж Меме санаж байла. Сарнайн бут тэгшлэн засаж дуусаад, гараа угааж, боодолтойг унтлагынхаа өрөөнд авч орон задалбал хятад тоглооморхуу таван давхар хайрцаг байж, хамгийн доторх жижгээс нь дөнөгж бичигт тайлагдаж байгаа хүний их хэчээнгүйлэн бичсэн “Бямбад кинон дээр уулзъя” гэсэн зурвас байлаа. Боодолтойг гонхонд удаан хэвтсэн болохоор Фернанда задалж үзсэн байвал яана гэж Меме өнгөрсөн хойно их л айжээ. Маурисио Бабилоньягийн зоригтой, гүйдэг ухаантай нь бүсгүйд аятайхан санагдав. Гэвч өөрийг нь заавал болзоонд очно гэж их л гэнэхнээр итгэж байгадашар нь хөдөлжээ. Бямба гаригийн орой Бага Аурелиано завгүйг Меме мэдэж байлаа. Гэвч долоо хоногийн турш туж сэтгэл зовлонтой байж байгаад, “Бямбад кинонд хүргэж өгөөд, тарахад аваач” гэж эцгийгээ ятгав. Танхимын гэрэл асаатай байхад толгой дээр нь шөнийн эрвээхий зогсолтгүй эргэлдсээр байв. Гэрэл унтрахад Маурисио Бабилонья хажууд нь суужээ. Меме аймшигт намагт шигдэн тарчилж байх шиг, машины тос ханхалсан, харанхуй танхимд харагдахтай үгүйтэй байгаа энэ хүн л эртээрийг зүүдэлснээр өөрийг нь тэр намгаас татаж гаргах мэт санагджээ.

- Та хэрэв ирээгүй бол намайг дахиад хэзээ ч харахгүй байсан гэж залуу хэлэв.

Өвдөг дээр нь хүнзд гараа тавихад нь энэ хормоос хойш хоёр биендээ түшиг болно гэдгийг Меме ойлгов.

- Ярих ёсгүй юм ярьдаг чинь л миний дургүйг хөдөлгөдөг гэж бүсгүй инээмсэглэв.

Меме залууд ухаангүй дурлажээ. Нойр хоолноос гарч, хн амьтнаас дайжин, эцэг нь хүртэл тээртэй санагдах болжээ. Фернандагийн толгойг эргүүлэхийн тулд энд тэнд урилгатай, энд тэнд ажилтай гэсэн ээдэрсэн баахан шалтаг зохион олж, үерхдэг бүсгүйчүүлтэйгээ нийлэхээ байж, Маурисио бабилоньятай л уулзаж байвал яахаас ч буцахгүй, хэдийд ч хаана ч уулзсан хамаагүй болжээ.

Эхлээд ширүүн дориун нь төдгүй санагддаг байлаа. Гараашийн арын цулгуйд анх уулзахад цаадх нь Мемегийн хамаг тамирыг барж, адгуусны байдалтай болгожээ. Энэ нь бас л янаглаж амраглаж байгаа хэрэг юм гэж Меме хожим нь ойлгоод, хайртыгаа л зөвхөн мөрөөдөж, машины тос, цайруулагч уусмалын нь ухаан алдуулам үнэртийг дахин дахин үнэртэхийн хүслэн болжээ. Амарантаг үхэхийн өмнөхөн Меме хэсэгхэн зуур гэнэт ухаан саруулсаж, хойчийн цагт жаргана гэж итгэл байхгүйд айн сандарчээ. Тэгэхэд л хөзрөөр мэргэлдэг нэг эхнэр байдаг гэж дуулаад, сэмхэн очив. Тэр бол Пилар Тернера байлаа. “Суу. Буэндиагийнхны хувь тавиланг урьдчилан хэлэхэд хөзрийн хэрэг байхгүй ээ” гэж Пилар Тернера хэлжээ. Зуун настай төлөгчийг элэнц эхээ гэдгийг Меме мэдсэнгүй, тэгээд хэзээ ч мэдэлгүй өнгөрч билээ. Чухамхүү хайр дурлалын ийм шаналгааг гагцхүү энгэр зөрүүлж баймааж нь тайтгаруулж болно гэж Пилар Тернерагийн ятгаж, ихэд илэн далангүй тайлбарлахыг сонссон учир Меме түүнийг элэнц эхийгээ гэхэд итгэл ч үгүй байсан биз ээ. Маурисио Бабилюня ч унтах хэрэгтэй гэж хэлэдг байсан боловч Меме түүнд итгэхгүй, аливаа хар ажилчны адил бүдүүн хадуун учир тэгж ярьж байна гэж дотроо бодож байжээ. Хүн уулаасаа гэдсээ цадахад хоолонд дургүй болдогчилон түүнтэй унтчихвал хайр сэтгэл нь алга болно гэж боддог байлаа. Пилар Тернера Мемег сэнхрүүлээд зогссонгүй, өвгө эцгийг нь дараа нь Аурелиано Хосег олсон хуучин ороо хэрэглэж болно гэжээ. Түүнээс гадна хүсэхгүй байвал гичний уураар утан жирэмслэхгүй байж болох арга зааж өгч, хэрэв тийм золгүй юм болбол бүхнээс, тэр ч байтугай “с”-тгэлийн зовлонгоос” ангижрах ундааны жорыг өгчээ. Ийнхү ярилцсаны дараа Меме үерхдэг бүсгүйчүүдтэйгээ архидсан өдрийнх шигээ зүрх оржээ. Гэтэл Амаранта үхэж, бодсоноо биелүүлэхэ нь саад болов. Хойдын буян үйлдэх ёс хоногт тэрбээр Маурисио Бабилюнягаас ганц хором холдсонгүй. Цаадах нь гэрт дүүрсэн олны дотор л явж байлаа. Дараа нь бэлэвсрэлийн урт өдрүүд эхэлж, заавал гэртээ түгжиж суух хэрэг гарсан учир хоёр амраг түр холдон саллаа. Тэр өдрүүдэд сэтгэл туйлгүй догдолж, зүрх аргалшгүй шаналж, амрагаа тэсгэлгүй санасан учир Меме гэрээс гарсан анхныхаа үдэш Пилар Тернерагийнд шууд очив. Тэгээд бүсгүй эсэргүүцсэн ч үгүй, ичсэн ч үгүй, маягласан ч үгүй Маурисио Бабилюняд биеэ өгч, тэгэхдээ ийм ажилд гарцаагүй авьяастай, ухаалаг зөнтэйгөө харуулсан нь хардамтгай эр бол яасан туршагатай юм гэж эндүүрэмээр байжээ. Эхийнх нь хатуу гараас гаргах гэсэндээ охиныхоо хэлсэн шалтаг болгоныг шуудхан баталдаг Бага Аурелианогоор тэр хоёр түрээ барин долоо хоногт хоёр учирсаар гурван сар гаруйн нүүр үзжээ.

Кинон дээр Фернанда тэр хоёрыг гэнэдүүлэн барьсан үдэш Бага Аурелиано гэмшиж, Мемег урьд амласнаараа дотроо байгааг уудлан хэлбэл сэгэл нь онгойх байх гэж итгээд цоожтой байгаа унтлагынх нь өрөөнд иржээ. Гэвч Меме тас зөрөв. Мемегийн өөртөө туйлийн итгэж, ганцаараа байх гэж мугуйдлан зүтгэж байгааг Бага Аурелиано үзэхдэ аав охин хоёр ерөөс дотно байсангүй,

тэгэхэд ердөө л сэтгэлээ хуурч байж гэж санажээ. Тэрбээр Маурисио Бабилоньятай яриад үздэг юм билүү, хуучин эзний нэр сүрээр түүнийг болиулж магадгүй болов уу гэж бодсон боловч Петра Котес эхнэрүүдийн явдалд бүү хуруу дүр гэсэнд охиноо удаан хоригдохоо зовлон нь илаарь болно биз гэж сэтгэлээ тайвшруулан, яахаа мэдэхгүй гайхаш алдран байлаа.

Меме зовж байгаа шинж огт байхгүй, харин ч шөнө нь бөх унтаж, өдөр нь юмаа тайван, хийж, хоолоо тогтомл идэж, сайн шингээж байгааг Урсула хажуугийн өрөөний чимээгээр мэдэж байлаа. Мемегийн хоёр сар хоригдсоны дараа Урсула түүний бусадтай адил угаалгын өрөөнд өглөө оролгүй, оройн долоон цагт ордгийн учрыг л олохгүй байлаа. Хилэнцэт хорхойд хатгуулав да агэж хэлэх гэсэн боловч Меме түүнийг өөрийг нь барьж өгсөн гэж бодоод, хуланц эхтэйгээ үг хэлцэхээс зугтаж, эмгэн ч охиныг сургаж браьж улиглаад яах вэ гэж үзжээ. Харуй бүрий болохын алдад гэрт шар эрвээхий дүүрнэ. Орой бүр Меме гуаалгын өрөөнөөс гар яваад, эрвээхийг хор цацан устгаж байгаа Фернандатай дайралддаг байлаа. “Ямар лай вэ. Шөнийн эрвээхий гай уддаг гэж надад насан турш минь сургасан юм” гэж Фернанда үглэн дуулна. Нэг удаа Меме угаалгын өрөөнд байж байхад фернанда санаандгүй унтлагын өрөөнд орвол өрөгөөр нь дүүрэн эрвээхий болсон байсанд хөөж гаргах гээд гартаа дайралдсан даавуу автал гич бутран унасанд үүнийг охины нь оройн угаалгатай холбоотой байна гэж ухаараад ухаангүй айжээ. Фернанда энэ удаа урьдынх шигээ аятай далимыг хүлээсэнгүй, маргааш нь л өөр шиг нь уулынхнаас гаралтай хотын шинэ даргыг үдийн хоолонд урьж, тахиаг нь хулгайч аваад байгаа бололтой тул арын хашаанд шөнө манаач гаргаж өгөөч гэж гуйжээ. Энэ бүх сарын турш угаалгын өрөөнд орой болгон өөрийг нь хүлээж байсан шигээ хилэнцэт хорхой, шар эрвээхий дунд хайр сэтгэлдээ догдлон чичирсээр нүцгэн байж байсан Меметэй уулзахаар дээврийн ваарыг ховхолж байхад нь Маурисиор Бабилоньяг харуул бууджээ. Сум нуруунд нь тусаж, залуу эр үхэн үхтлээ оронд хадагдав. Тэрбээр залуугийн явдлаа бодон тарчилж, шар эрвээхийнээс амар заяа огт үл үзэн зовж, тахианы хулгайч гэгдэн бүгдэд орхигдоод, өчүүрхэн ч гомдол тавилгүй, огтхон ч бухимдаж бугсалгүй, хэнийг ч барьж өгөлгүй, гав ганцаархнаа байсаар бүр өвгөн болсон хойно үхжээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Нийт Макондод үхлийн гай татах хэрэг явдал Меме Буэндиагийнх хүүг авчрах үед нэгэнт ойртсон байлаа. Хотынхон үймэлдэн сандралдаад, гэр бүлийн хэрүүл уруулыг анхаарахтай манатай байсан учир Фернанда энэ аятай байдлыг далимдуулж, тийм хүүхэд төрөөгүй мэт тас нуухаар шийдэв. Зээгээ авахаас өөр араг түүнд байсангүй. Угалгын өрөөний усан санд хүүг живүүлчихье гэж

дотроо шийдсэнээ яг цагаа болоход арай ч зүрх хүрэхгүй байсаар хэчнээн дургүй ч үхэн үхтлээ хүүг тэвчин байх хэрэг гарчээ. Хүүг Аурелиано Буэндиагийн урлан байсан өрөнд түгжив. Жаал хүүг голоор сагстай хөвж явахад нь олсон юм гэж Санта Софи де ла Пьедад итгүүлж чадав. Урсула хүүгийн төрсөн нууцыг мэдэлгүй байсаар үхэх учиртай байжээ. Жаахан Амаранта Урсула урлан руу шагайн, Фернандагийн жаал хүүг хооллож байхад харсан ч сагстай хөвж явсан гэдэг ярианд үнэмшжээ. Охиныхоо хамьдралыг үрж зэрлэг авирласанд нь эхнэрээсээ бүр хөндийрөөд байсан Бага Аурелиано ачтай болсноо гурван жилийн хойно л Фернандагийн цалгардсан завшаанаар хүн гэхээсээ, нэвтэрхий толинд зурсан махчин гэмээр сэгсэрсэн үстэй шалдан амьтан хорих өрөөнөөс гүйн гарч, минут хэртэй гонхонд орж ирэхэд нь л мэдсэн билээ.

Фернанда дүүрсэн нь хувь заяагаа ингэж балайгаар эргэнэ гэж бодож байсангүй. гутамшигт явдлаас үүрд ангижирлаа гэтэл тэр хүүхэд ирснээр дахиад гэр нь шившигтэй явдалд орооцолдсон мэт бодогджээ. Шархтай Маурисио Бабилоньяг аваачиж амжаагүй шахам байхад Фернанда нэр төрийг хөөдсөн бүх ул мөрийг арилгах төлөвлөгөөг нэгд нэгэнгүй гаргаж амжсан билээ. Тэрбээр нөхөртэйгөө ч зөвлөлөгүйгээр маргааш нь пүүгээгээ зэхэж, жижигхэн хөвхөн хайрцагт охиныхоо гурван ээжлийн дотуур хувцас хийгээд галт тэрэг хөдлөхөөс хагас цагийн өмнө унтлагын өрөөнд нь орж,

- Явъя, Ренета гэжээ.

Фернанда юу ч тайлбарлаж ярьсангүй. Меме ч тэгээсэй гэж хүсэхгүй байлаа. Хаашаа ч явах гэж байгаага мэдэхгүй, ер нь яргын газар аваачлаа ч гэсэн түүнд хамаагүй байлаа. Арын хашаанд буу дуугарч, Маурисио Бабилоньягийн ёолоод явчихыг дуулснаас хойш Меме ганц ч үг дуугараагүй, насныхаа эцсийг үзтэл ч дуугарахгүй. Эхийгээ “Унтлагын өрөөнөөс гар” гэхэд үсээ ч самнаагүй, нүүрээ ч угаагаагүй байсан боловч дуугүйхэн гарада, зүүдэгн өвчтэй юм толгой дээгүүрээ эргэлдэх шар эрвээхийг ч анзаарах сөгөөгүй галт тэргэнд суужээ. Охиныхоо хар цагаан дуугарахаа байсанд албаар тэгэв үү, эсвэл хэцүү гай дайрнаас хэл нь татав уу гэдгийг Фернанда хэзэ ч мэдсэнгүй, мэдэх ч гэж оролдсонгүй. Хуучин илбэдүүлсэн газрыг хэрхэн туулснаа ч Меме бараг анхаарсангүй. Төрмөр замын далангийн хоёр талара хязгааргүй үргэлжлэх сүүдэрт гадилын тариаланг ч харсангүй. Халуун наранд хатаж, тоос шороонд дарагдсан цэцэрлэгтэй гринго нарын цагаан байшинг ч жигүүрийн асарт хөзөр тоглож байгаа богино өмдтэй, хөхө судалтай цагаан цамц өмссөн хүүхнүүдийг ч харсангүй. Тунгалаг уст голд бүсгүйчүүд загас адил тонгочин, сайхан том мээмээ гарган галт тэрэгний зорчигчдын аазгайг хөдөлөгж байхыг ч харсангүй, ажилчдын суудаг бохир, арчаагүй саравчийг, энэ саравчийн тойронд шар эрвээхий эргэлдэж байгааг ч, хаалган дээр нь туранхай, цонхигор хүүхдүүд хөтөвч дээрээ сууж, их гэдэстэй хүүхнүүд хажуугаараа өнгөрөх галт

тэрэгний араас хараал хэлэн зогсохыг ч харсангүй. Урьд сүмийн сургуулиас буцаж явахдаа энэ бүхнийг халти үзээд бөөн баяр болж байан бол одоо сэтгэлд үлдэх юмгүй байлаа. Чийг татуулан халуу дүүгэх гадирын тариаланг өнгөрч, испани хөлгийн шатсан сэг хэрзийсээр байга анамуу цэцэгт нугыг гаталж, дараа нь мөнөөхөн тунгалаг агаарт гарч, зуу шахам жилийн өмнө Хосе Аркадио Буэндиагийн мөрөөдлийг балласан хөөст бохир далайд тулж ирэхэд ч цонхоороо шагайсангүй.

Өдрийн таван цагт галт тэрэг эцсийн өртөөн дээр ирж, Фернанда Мемег вагоноос гаргав. Хоёулаа сарьсан багваахай шиг жижигхэн тэргэнд суувал морь нь мэнгэртнэй юм шиг аахилж, дүнсгэр хотоорөнгөрөхөд түүний урт гудамжин дээгүүр Фернандагийн залуудаа үдийн амралтаар өдөр бүр сонсдог байсан нэгэн аялгуу дуурсаж байлаа. Тэд голын хөлөг онгоцонд суувал зэвэнд идэгдсэн төмөр бүрээс нь пийшин шиг халуун өөнөж, модон хүрд нь галын шахуурга аятай ус сэлүүрдэн пал пүлхийнэ. Меме өрөөнд ороодтүгжчихэв. Фернанда орны нь дэргэд тавагтай хоол өдөрт хоёр уда атваьж, огт ам хүрээгүй чигээр нь өдөрт хоёр ухаадаг байла. Меме өлбөрч үхэхгэсэнгүй, гагцхүү хоолны үнэр авч чадахгүй, усыг ч тогтоохгү бөөлжиж гаргачихаад байлаа. Гичний уураар утсаннь тус болоогүй гэдгийг Меме хараахан мэдээгүй айсанчлан Фернанда ч жил шахамын дараа хүүхдүүдийг өөрт нь аваачин өгөн өгтөл огт сэжиг байсангүй. Усан онгоцны бүгчим өрөөнд төмөр ханын байнгын чичиргээнд балбуулж, онгоцны хүрдээр голын ёроолоос гарч ирэх лаг шаврын тэсвэрлэшгүй үмхий үнэрт зовсон мемэ сар өдрөө мартжээ. Сүүлчийн шар эрвээхий сэнсэнд орж үхтэл их л өнө болж Меме Маурисио Бабилонья үхэж, нөхөж болшгүй юм болж гэдгийг сая ухаарчээ. Гэвч Меме хайртай хүнээ мартсангүй. Тэрбээр Бага Аурелианогийн дэлхийн хамгийн хөрхөн хүүхэн эрэн төөрч будилж явсан зэрэглээт цөлийг луустай туулж явахдаа ч түүнийгээ бодож, индианы жимээр ууланд гарч, гучин хоёр сүмийн хонхны бэлэвсрэлийн аялгуу хангинасаар байх чулуут огцом гудамжтай баргар хотод хүрч ирэхээ ч түүнийгээ бодсоор абйлаа. Тэр хоёр хуучны эзгүй байшинд хивэн хорхой язганах өрөөнд шалан дээр банз зэрэгцүүлэн дэвсэж ор хийгээд хонов. Хүүршсэн хөшгийг цонхноос авч, нүцгэн банзан дээр дэвссэнд хөдлөхийн тоолонгоор нөгөөх нь үйрч унаж байлаа. Цурам хийлгүй хонохдоо Меме Христос тэнгэрийн мэндэлсэн баярын тэр нэгэн битүүнд тугалган австай хүргүүлж ирсэн хар хувцастай хүн хажуугаар нь өнгөрөөхийг давхийн харахдаа хаан байгаагаа гадарлажээ. Хойд өдөр нь Фернанда үдийн мөргөлийн дараа түүнийг баргар байшинд аваачив. Эхийнхээ хатан хаан болохоор бэлтгэж байшинг таньж, аян нь энд дуусаж байгааг ойлгов. Фернанда контоорт нэг хүнтэй ярьж байх хооронд Меме испанийн хамба нарын тосон будгийн эртний хөрөнг өлгөсөн хүлээн авах өрөөнд хүлээж, хар цэцэгтэй хив палааж, цөлийн мөсөнд маажийсан өндөр өсгийтөөс өөр хувцасгүй учир дааран чичирч байлаа. Өрөөний голд цонхоор тусах шар гэрэлд зогсоодд Маурисио Бабилоньяг бодож

байтал дотроос маш хөөрхөн гэлэнмаа гурван ээлжийн дотуур хувцастай хөвхөн хайрцгийг нь барин гарч ирээд явуут гараа сунган,

- Ренета, явъя гэжээ.

Меме түүний гараас браьж, дув дуугүй хөтлөгдөн одвой. Фернанда охиноо эцсийн удаа харвал цаадах нь сүмийн хэрэмний саяхан хаагдсан төмөр торон хаалганы цаана гэлэнмаагийн алхааг гүйцэх гэж шогшиж байлаа. Меме Маурисио Бабилоньяг, машины тосны үнэр, шар эрвээхий дагуулыг нь бодож, хожим хойно намрын нэгэн өглөө Краковын баргар эмнэлэгт хүний нэрээр, ганц ч үг дуугаралгүй амьсгаа хураатлаа насан туршдаа бодсоор байх болно.

Фернанда зэвсэгт цагдаа нараар хамгаалуулсан галт тэргээн макондод эргэж ирэв. түүний аялан явж байхад зорчигчдын царай түгшүүртэй, хот тосгоны гудамжаар цэрэг цуух дүүрэн, нэг л лут ювм болох төлөвтэй байсанд чухам ямар учиртайг ойлгосонгүй. Макондод ирсэн хойноо л Бага Хосе Аркадио гадилын компанийн ажилчдыг ажил хая гэж хатгаж шүтгэж байгааг дуулжээ. “Энэ л бидэнд дутаж гэнэ. Манайд анархист гарч ирж” гэж Фернанда боджээ. Хоёр долоо хоногийн дараа ажил хаялт хэлэж, уршигтай юм болох байх гэж бүгдээрээ болгоомжилж байсан боловч тэгсэнгүй. Ажилчид гадицыг ням гаригт тайрч ачихаас татгалзаж, шаардаж байгаа нь гарцаагүй зөв болж, Антонио Исабель лам хүртэл түүнийг тэнгэрийн бошигт нийцэж байна хэмээн сайшаажээ. Энэ болон дараачийн хэдэн сард гарсан ажил хаялт ялсаннь урьд хотыг франц дууч эмсээр л дүүргэж чадах хүн гэж зард гарсан байсан Бага Хосе Аркадиогийн өчүүхэн биеийг алдаршуулжээ. Бага Хосе Аркадио хөлөг онгоцны утгагүй аялал зохион байгуулах гэхдээ зодооч тахиагаа гэнэт зарчихсан шигээ гадицын компанийн харгалзагчийн тушаалыг орхиод ажилчдын талд оржээ. Төдий л удалгүй Бага Хосе Аркадио нийгмийн хэв журмын эсрэг олон улсын хийж байгаа хуйвалдааны тагнуул төлөөлөгч гэж зарлав. Аймаг цуу дэгдэж байсан тэр долоо хоногийн нэгэн шөнө Бага Хосе Аркадио нууц хурлаас буцах замдаа нэгэн үл мэдэгдэх хүнд дөрөв буудуулсан боловч азаар амьд гарав. Дараа дараачийн сарын байдал маш түгшүүртэй байсан учир Урсула хүртэл гэгээ үл үзэх ертөнцдөө түүнийг мэдэж, хүү Аурелианогийнхоо үрлэн эмэр халаасаа дүүргэж явсан тэргэйт үеийг үзэх шиг болжээ. Урсула Бага Хосе Аркадиотой уулзаж, үзсэнээ түүнд хэлж өгөх гэсэн боловч аминд нь халдсан шөнөөс хойш ихрийнх нь өрөөсөнг хаана байгааг хэн ч мэдэхгүй байн гэж Бага Аурелиано хэлжээ.

- Яг л Аурелиано. Ертөнцийн бүх юм орчин эргэж байдаг юм уу даа гэж Урсула дуу алджээ.

Фернанда тэр үеийн үймээн сандраанаас хөндий байлаа. Охиных нь хувь заяаг өөртэй нь ярилгүйгээр дураараа шийдсэнд эгдүүцсэн нөхөтэйгө зад

хэрэлдсэнээс хойш хүн хартай уулзахыг больжээ. Охиноо сүмээс гаргаж авна, хэрэг болбол цагдаагийн тусламж авна гэж Бага Аурелианогийн сүрдүүлэхэд Фернанда Мемег сайн дураараа сахил хүртсэн гэсэн бичиг үзүүлжээ. Угтаа бол Меме төмөр торны дотор оросн хойноо, гэрээс нь аваад явахад эсэргүүцээгүй шигээ явал яаг гэсэн байдлаар нэрээ тавьсан юм санжээ. Бага Аурелиано Маурисио Бабрилоньяг тахиа хулууу гэж гэрт нь очсон гэдэгт итгээгүй шигээ эхнэрийнхээ үзүүлсэн баталгаа бичиг дотроо үнэмшихгүй байсан боловч нэгэнт л тийм юм бол одоо яах вэ гэж бодоод биеэ зовоолгүйгээр Петра Котесийн суганд хоргодон, дахин галзуурсан мэт цэнгэж, зад найрлах болов. Фернанда бүх хотыг хамарсан түгшүүрийг тоохгүй, Урсулагийн усан амлаж байгааг хайхрахгүй бодож боловсруулснаа улам нягтлан бататгаж байлаа. Тэрбээр санваартнаа улам нягтлан бататгаж байлаа. Тэрбээр санваартны мяндаг удахгүй авах гэж байсан Хосе Аркадиод дэлгэрэнгүй захидал бичиж, дүү Рената нь шар хумхаа тусан, өөд облсон гэж дуулгажээ. Дараа нь Амаранта Урсулаг Санта Софи де ла Пьедадаар харуулаад, Мемегийн золгүй явдлаас болж, үл үзэгдэх оточ нарай харилцаа тасарсан байснаа сэргээв. Юуны өмнө тэрбээр зайнаас мэс засал хийх эцсийн өдрийг товлов. Гэвч үл үзэгдэх оточ нар Макондод замбараагүй явдал дуусаагүй байхад мэс засал хийх нь болгоомжгүй хэрэг гэж хариулжээ. Фернанда хүлээх тэвчээр хүрэхгүй, хэрэг явдлын учрыг сайн мэдэхгүй учир “Хотод ямар ч үймээн самуун байхгүй, хадам дүүгий нь тэнэг явдлаас хамаг хэрэг болж байгаа юм, тэр л тахиа зодолдуулж, хөлөг онгоц голоор явуулна гэж мангуурч байсан шигээ одоо үйдвэрчний эвлэл гэж дэмийрч байгаа юм” гэж дараагийнхаа захидалд бичжээ. Тэднийг тохиролцож амжаагүй байтал нэгэн халуун хлагва гаригт сагс барьсан чавгнац хаалгыг нь тогшжээ. Санта Софи де ла Пьедад хаалгыг нээж өгөөд, нэг хүн бэлэг явуулж гэж санан, гоё гэгчийн торон алчуураар бүтээсэн тэр сагсыг авах гэтэл чавганц “хатагтай Фернанда дель Карпио де Буэндиад маш нууцаар сагсыг өг гэж зарлиг болсон” гээд өгсөнгүй. Сагсанд Мемегийн хүү байжээ. Фернандагийн номын багш асан лам жаал хүүг төрөөд хоёр сар болж байгаа, эх нь ам нээж өөрийн хүслийг айлтгаагүйн учир өвгийнх нь нэрээр Аурелиано гэж нэрлэлээ гэж захидалдаа бичсэн байлаа. Фернанда хувь тавилан өөрөөр нь ингэж даажин хийж байгаад дотор нь арзганаж байсан боловч гэлэнмаагаас үүнийг нууж чадав.

- Голоор сагстай хөвж явахад нь оллоо гэж хэлье хэмээн Фернанда инээмсэглэв.
- Хүн итгэхгүй дээ гэж гэлэнмаа дуугарав.
- Ариун сударт айлдсан байхад нь үүнд бүгд итгэдэг байхад яагаад надад итгэхгүй байдаг билээ гэж Фернанда зөржээ.

Гэлэнмаа буцах галт тэрэг хүлээж тэднийд үдийн хоол идэж, сүмд зарлиг болсноор хүүхдийн тухай ганц дурсаагүй боловч Фернанда өөрийнх нь



гутамшгийг үл таашаах гэрч хажууд нь байгаад доторнь багтарч, муу мэдээ хүргэж ирсэн элчийг дүүжилж алдаг дундад эртний заншил хуучирсанд харамсаж билээ. Тэгэхэд л Фернанда гэлэнмааг явангуут жаалыг усан санд живүүлж орхиё гэж шийдсэн боловч зүрх нь арай хүрсэнгүй, эзэн тэнгэр хязгааргүй хишгээ хайрлаж, энэ дарааснаас салгахыг тэвчээртэй хүлээхээр болжээ.

Жаал Аурелианог ойтой болж байтал Макондогийн байнгын түгшүүртэй байдал гэнэт туйлдаа хүртэл даамжирлаа. Нууц байдалд ороод байсан Бага Хосе Аркадио болон үйлдвэрчний эвлэлийн бусад удирдагчид долоо хоногийн шувтаргаар гэнэт хотод үзэгдэж, гадилын компаний бүсэн дэх суурингуудад жагсаал зохион байгуулав. Цагда анар хэв журам зөрчих эсэхий л харзнасхийж байлаа. Гэвч даваа гаригийн шөнө үйлдвэрчний эвлэлийн удирдагчдыг орноос нь чирэн босгож, гар хөлд нь тавин жингийн гав дөнгө зүүгээд мужийн гол хотын гянданд явуулав. Тэдний дотор Бага Хосе Аркадио, Макондод нутаг заагдан сууж байсан, өөрийн загалмай зүүлгэсэн эцэг Артемио Крусийн<sup>1</sup>баатарлаг гавьяаг биеэр үзсэн гэж ярьдаг, мексикийн хувьсгалд оролцож явсан хурандаа Лоренсо Гавилан баригджээ. Гэвч засгийн газар, гадилын компани хоёр баривчлагдагсдын хоолны мөнгийг хэн төлөхийг тохиролцож чадаагүй учир тэднийг гурван сар бололгүй дахин суллав.

1 Мексикийн зохиолч Карлос Фунтесийн “Артемио Крусийн үхэл” гоманы баатар.

Энэ удаа ажилчид хүнсний бүтээгдэхүүн чанар муутай, ажлын нөхцөл тэсвэрлэхийн аргагүй хүнд хүчир байгаад дургүйцэн байгаагаа илэрхийлжээ. Түүнээс гадна ажилчид цалинг жинхэнэ мөнгөөр тавихгүй, компани дэлгүүрээс вергиний гахайн утсан махнаас өөр юм авах аргагүй цаасан мөнгөөр өгч байна гэж гомдол тавьж байлаа. Цаасан мөнгөний системнийг илчиллээгэж Бага Хосе Аркадио гянданд хорьжээ. Компани энэ системд дулдуйдаж худалдааны флотын зардлыг хямдруулж байга аюм, учир нь жимс ачсан хөлөг буцахдаа, дэлгүүрийн бараа ачиж ирж байна, энэ ачаа байхгүй бол гадил ачдаг усан боомт хүртэл Шинэ Орлеанаас хоосон явах байсан гэдгийг ХОсе Аркадио тайлбарлажээ. Ажилчид бас ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний талаар сэтгэл дундуур байлаа. Компанийн эмч нар өвчтөнийг үздэггүй, эмнэлгийн с өмнө зүгээрл оочирлуулан зогсоогоод, эмнэлгийн сувилалч өвчтөний хумхаатаж уу, загтаж уу, түгжрээ болж уу гэдгийг харгалзалгүйгээр зэсийн байвангийн өнгөтэй үрлийг хэлэндээр нь тавьж өгнө. Эмчилгээг ёстой хавтгайруулж байсан учир хүүхдүүд оочирт хэд дахин зогсоод үрлийг залгахын оронд гэртээ аваачин лотоо тоглохдоо хасааны оронд хэрэглэдэг байлаа.

Ажилчид нурж унах гэж байгаа саравчинд багтаж ядан суудаг. Инженерүүд тэдэнд бие засах газар барьж өгч хүч зарсангүй, сууринд тавин хүн тутамд нэг явуулын жорлонг Христосын мэндэлсэн өдрөөр тавьж, удаан эдлэхийн тулд энэ төхөөрөмжийг яаж ашиглахыг нийтэд үзүүлжээ. Урьдын цагт хурандаа Аурелиано буэндиаг шавж байсан хар сүртүүгтэй зөнөсөн өмгөөлөгчид, одоо гадилын компаний эрх ашгийг хамгаалж, ажилчдын бүх шарадлагыг илбэ жилбэтэй л дүйцэхүйц овсгоотойгоор няцааж байлаа. Ажилчид айлтгал бичиг зохиож, бүх нийтээр санал нэгтэй сайшаан, гадилын компанийн сонорт албан ёор хүргэтэ нэлээд хугацаа оров. Ноён Браун айлтгал бичгийн туха сонсмогцоо шилэн дээвэртэй ганган вогооноо галт тэрэгний араас зүүгээд пүүсийн хамгийн том төлөлөгчдийн хамт Маркондогоос алга болж өгөв. Гэвч дараагийн бямбад ажилчид тэдний нэгийг нас хүйд нүцгэн хүүхэнтэй хэвтэж байхад нь олж аван, айлтгал бичгийн хуулбарт гарын үсэг зуруулж чадав. Тэр хүүхэн түүнийг өвөртөө оруулан аргалж байхаар зөвшөөрсөн юм санж. Гэсэн хэдий боловч уйтгартай хуульчид гадилын компанитай энэ хүний огт холбоогүй болохыг шүүхэд нотолж, гаргасан нотолгоондоо улс амьтныг эргэлзэх вий гэхдээ нэр зээлдэгч хэмээн гяндан хорьжээ. Хожим нь ажиличд гуравдугаар зэргийн вогооноор нууж аялж явсан ноён Брауныг браьж аваад айлтгал бичгийн өөр нэг хувь дээр гарын үсэг зуруулав. Маргааш нь тэр шүүхэд очихдоо тас хар үстэй болчихсон, испаниар ус цас шиг ярьж байлаа. Тэр бол Макондод төрсөн, мөн тэнд Дагоберто Фонсека нэр авсан, эмийн өвс худалдаалдаг гэмгүй иргэн болохоос гадилын компанийн ерөнхий захирал, Алабама муж улсын Пратвилл хотын иргэн ноён Жек Браун биш гэж өмгөөлөгчид нотолжээ. Удалгүй, ноён Браунд хүрэх гэж ажичлдын дахин оролдсоны дараагаар хуулийнхан түүний үхсэн тухай магадагааны хувилбарыг олон нийтийн газарт өлгөснийг үзвэл зургадугаар сарын есөнд Чикаго хотноо гал унтраах машинд дайруулж үхсэнийг элчин консул болон элчин сайдын яамны зөвлөхүүдийн баталсан тухай өгүүлсэн байлаа. Ажилчид орон нутгийн эрхтэн дархтны энэ будлиан булхайгаас залхан төвөгшөөгөөд, шүүхийн дээд байгууллагад годмлоо мэдүүлэв. Гадилын компани хүмүүсийг түр ажил л үе үе хөлсөлдөг, хэзээ ч байнгын ажилчин авч байгаагүй бөгөөд авч байхгүй учир ажилчдын шаардлага хуульд огт нийцэхгүй гэж хуулийг завхруулагчид нь мэтгэжээ. Тийнхүү виргиний гайхан утсан мах, ид шидийн чадалтай үрэл, Христосын мэндэлсэн өдрөөр байгуулсан жорлонгийн тухай яриаг зохиомол хэмээ няцааж, ажилчид гэж байгаагүй гэж шүүхийн шийдвэрээр тогтоон, газар бүрд ёслол төгөлдөр тунхаглажээ.

Хүчтэй ажил хаялт эхлэв. Гадилын тариалан дээр ажил зогсож, жимс модондоо ялзран зуун хорин хайрцаг чирсэн галт тэрэг төмрзамын мухар салаан дээр хөдөлгөөнгүй зогсож байлаа. Хот суурингаар ажилгүйчүүд дүүрлээ. Туркийн гудамжинд дуусах гэж байхгүй бямба гариг эхэлж, “Отель Хакоба”-гийн биллиардын танхимд тоглоомчингууд ээлжээ хүлээн өнжин хонон

шахцалдах болов. “Арми нийгмийн хэв журмыг сэргээх тушаал авч гэнэ” гэсэн зар тарсан өдөр Бага Хосе Аркадио яг тэнд байж байлаа. Хэдийгээр тэр адыг мэдэх совингүй боловч энэ мэдээг дуулахдаа хурандаа Геринельдо Маркес хүн буудаж алахыг өөрт нь харуулсан тэр нэгэн өглөөнөөс хойш хүлээсэн үхлийн дохио ирэх нь энэ гэж боджээ. Гэвч муу совин татлаа гээд уулын тэвчээртэй байдлаа алдсангүй. Тэр шааригийг цохиураар цохин, санаснаараа хэд хэдэн шаариг зэрэг оруулав. Хэсэг зуур болтол бөмбөрийн пижгэнэх, бүрээний янгинах, гудамжнаа хүмүүс үймэн хашигралдах дуу гарахад Бага Хосе Аркадио шаариг цохих төдийгүй, хүнийг цаазаар аваачиж байгааг харсан өдрөөс хойш өөрөө өөртэйгөө дуугүй тоглосон тоглоом дууслаа гэдгийг ухаарав. Тэгэхэд гадаа гарч үзвээс тэнд гурван хороо бөмбөрийн дуугаар хөл нийлүүлэн алхаж, тийнхүү алхахад нь газар доргиж байлаа. Энэхүү олон толгойт лууны үмхий үнэр наран гийсэн үдийн агарт шингэв. Цэргүүд тагдгар пагдгар бөгөөд бүдүүн хадуун ажээ. Тэднэс морины хөлс, наранд дэлгэсэн түүхий ширний үнэр ханхалж, уулынхан шиг хийх гэснээ олон үггүй, огт буцахгүй хийх зоригтой нь мэдэгдэж байлаа. Бага Хосе Аркадиогийн дэргэдүүр бүтэн цаг явж өнгөрөхөд нь хэдхэн салаа л тойроод л яваад байга мэт бодогджээ. Учир нь бүгдээрээ ихэр юм шиг ав адилхан, бүгдээрээ дашмаг зүүж, хүнд үүргэвч үүрсэн, жадыг нь тэнийлгэсэн гутамшиг т буу мөрлөсөн, бүгдээрээ тушаалыг сохроор дагах мангуу байдалтай, нэр төрөө бодон яахаас ч сийхгүй царайтай ажээ. Урсула уйтгарт хэвтрээсээ тэдний алхааг сонсоод, хуругаа загалмайлан гараа өргөжээ. Санта Софие де а Пьедад индүүдэж эхлээд байсан эрээн бүтээлэг дээрээ тонгойн агшин зуур таг болж, Бага Хосе Аркадио хүүгээ бодож байхад, цаадах нь "О"ель Хакоба"-ийн үүдэнд сүүлийн цэрэг хажуугаар нь хэрхэн өнгөрч байгааг хэнэггүй харж зогслоо.

Байлдааны цагийн хуулиар цэргүүд маргаан зууч болох ёстой байтал хоёр талыг эвлэрүүлэх гэж өчүүхэн ч оролдсонгүй. Цэргүүд Макондо дундуур гарч сүр хүчээ үзүүлээд буу зэвсгээ ацлан тавиад гадилыг хураан, галт тэргийг мухар замаас гарган ачаалж гарав. Саяхан болтол тайванхүлээж байсан ажилчид зөвхөн мачетегаар зэвсэглэж ойд гарч урвагчидтай тэмцэв. Тэд компанийн байшин, дэлгүүрийг галдаж, одоо пулемётоор галлан замаа цэвэрлэх болсон галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулахын тулд төмөр замын даланг нурааж, харилцах утасны болон цахилгаан мэдээний шугамыг тасалж байлаа. Услах сувгийн ус цусанд будагдлаа. Цахилгаанжуулсан хонуурьятаа энх тунх, эсэн мэнд сууж байсан ноён Брауныг гэр орныхны нь хатм, нутгийнхны нь гэр бүлийнхны хамт цэргээр хамгаалуулан Макондогоос гаргаж, аюулгүй газарт аваачжээ. Хэрэг явдал даамжран, хүч тэнцвэргүй, цус асгаруулсан иргэний дайн болох осолтой болж иртэл эрх баригчид Макондод бүгдээрээ цуглахыг ажилчдад уриалав. “Мужийн иргэний ба цэргийн тэргүүн ирэх баасан гаригт хотод ирж, мөргөлдөөний учрыг олно” гэж уриалгад заасан байлаа.

Бага Хосе Аркадио баасан гаригт өглөөнөөс аваад өртөө рүү цувсан олны дотор байлаа. Урьдын өдөр нь тэрбээр үйлдвэрчний эвлэлийн удирдагчдын зөвлөлгөөнд оролцож, зөвлөлгөөнөөс хурандаа Гавилан тэр хоёрт ард олны дотор явж, байдлыг харгалзан тэдний үйл ажиллагааг чиглүүлэхийг даалгажээ. Баг Хосе Аркадио сэтгэл тогтохгүй, нэг л хачин байлаа. Цэргүүд галт тэрэгний буудлын талбайн эргэн тойронд пулемёт зоож, төмөр торон хашаатай гадилын компнийн хойг их буугаар хамгаалсан гэдгийг мэдсэнээс хойш аманд нь үргэлж шорвог гашуун амт амтлагдсаар байжээ. Өдрийн арван хоёр цагт ажилчин, эмэгтэй, хүүхэд нийлсэн гурван мянга гарууй хүн хожимдож байгаа галт тэрэг хүлээн, өртөөний өмнөх цулгуйд дүүрээд, цэргүүдийн пулемёт зоон хаасан хажуугийн гудамжинд бөөгнөрч байлаа. Эхний үед энэ нь баярын зугаага болж байгаа юм шиг санагдаж байлаа. Олон түмэн Туркийн гудамжнаас шарсан махтай лангуу, ундаатай бүхээгийг тоохгүй хөхиүн сэргэлэн байцгаала. Гурван цаг дөрхөж байтал албаны хүмүүсийн суусан галт тэрэг маргаашнаас нааш ирэхгүй нь гэсэн сураг гарав. Алжааж ядарсан олон урам хугаран санаа алджээ. Нэг ахлах дэслэгч хурсан олонруу амыг нь харуулан дөрвөн пулемёт зоосон өртөөний барилгын дээвэр дээр гарч бүгдийг чимээгүй бай гэж уриаллаа. Дөрөв, долоо хэрийн насны хоёр хүүхэдтэй, тарган авгай Бага Хосе Аркадиогийн дэргэд зогсож байв. Тэр эмэгтэй багыгаа гар дээрэ аваад, Бага Хосе Аркадиогийн дэргэд зогсож байв. Тэр эмэгтэй багыгаа гар дээрээ аваад, Бага Хосе Аркадиог танихгүй мөртлөө томыгоо өргөж тэнд юу ярьж байгааг чангнуулаач гэж гуйжээ. Бага Хосе Аркадио жаал хүүг мөрөн дээрээ суулгав. Олон жилийн хойно тэр жаал үзсэнээ, мужийн тэргүүний дөрөвдүгээр хуулийг чанга яригч хоолойгоор ахлах дэслэгч хэрхэн дуудан сонгосныг бүгдэд ярьж, үүнийг нь хэн ч үл итгэнэ. Тэр зааварт генерал Кортес Варгас, түүний нарийн бичгийн дарга хошууч Энрике Гарсиа Исара гарын үсэг зурж, түүний наян үгтэй гурван зүйлд ажил хаягсдыг “бүлэг дээрэмчин” гэж нэрлэж, тэднийг сум хайрлалгүй буудах онц эрхийг цэргүүдэд олгосон байлаа.

Зааврыг уншиж дуусахад хурсан олон дургүйцэн нижгэнэв. Тэгтэл дээвэр дээрх дэслэгчийн оронд ахмад гарч ирээд чанга яригч хоолойгоо савлан, юм ярих гэж байна гэж дохилоо. Олон чимээгүй болов.

- Ноёд, хатагтай нар аа, та бүхэнд тарахад таван минутын хугацаа өгье гэж ахмад аяархан, удаан бөгөөд ядрангүй хэлэв.

Исгэрч шүгэлдэх, амандаа дүнгэнэх, хашгирч бархирах чимээ цаг тоолж эхэлснийг зарлан бүрээний дууг дарав. Хэн ч байрнааса хөдөлсөнгүй.

- Таван минут өнгөрлөө. Дахиад нэг минут болбол гал нээх болно гэж ахмад мөнөөхөн аялгаараа хэлэв.

Хүйтэн хөлс нь чийхарсан Бага Хосе Аркадио жаал хүүг мөрнөөсөө буулгаж эхэднь өгөв. "Энэ шаарнууд л эхэлж буудна даа" гэж эмэгтэй шивнэв. Бага Хосе

Аркадио юм хариулж амжаагүй байтал хурандаа Гавилан нөгөө эмэгтэйн хэлсэн үгийг цуурай шиг чангаар паргин давтаж байх нь дуулдав. Бага Хосе Аркадио байдал түгшүүртэй болж, гайхмаар на мгүм болсонд мансууран, эрлэгийн элчийн нүд цавчилгүй ширтэн байгаад мэлэрсэн энэ олныг байрнаас нь хөдөлгөх хүч байхгүй гэдэгт бат итгэж, өлмий дээрээ өндийн, энэ яваа насандаа анх удаа дуугаа өндөрлөн өмнөө зогсогчдын толгой дээгүүр,

- Новшнууд! Өнөөдөр оодровч маргааш өөдлөхгүй ээ! гэж хашгирлаа.

Бага Хосе Аркадио г дөнгөж хэлж дуустал аймара бус, харин үгүй байлгүй дээ гэмээр юм боллоо. Ахмадыг гал нээх тушаал өгмөгц арван дөрвөн пулемёт дорхноо нижгэнэв. Гэвч энэ бүхэн жүжигт гардаг шиг л санагдаж байлаа. Пулемёт хахаж цацан тачигнаж, галаар галзуурсан мэт тургивч шавааралдан зогсон олон ганхийх дуу гарсангүй, тэр ч байтугай ганц ч удаа шүүрс алдсангүй, гэнэт бүгдээрээ чулуу болоод суманд даагдахаа больсон юм уу гэмээр божээ. Гэнэт өртөөний зүгээс амь тавьж байгаа хүний “А-а-а-а, ээж ээ!” гэж чарлах дуу мэнэрсэн байдлыг сарниулав. Галт уул нүргэлэн дэлбэрэх, үерийн ус хүрхрэн буух, газар хүчтэй хөдлөх гурав зэрэгцэх аятай, хурсан олон голоосоо түрхрэн хөдөлж, агшинзуурын дотор талбай даяараа пижигэнэв. Бага Хосе Аркадио жаал хүүгийн гараас дөнгөж шүүрэн автал эх нь нөгөө хүүхэдтэйгээ пархийн зугтаах олонд хамагдав.

Бага Хосе Аркадио өөрийг нь өргөөд, айж сандарсан олны дунд шахагдан, хөл нь газарт хүрэхгүй хөвөх мэт талбайн хажуугийн гудамжинд хэрэхэн хамуулан орсныг жаал хүү олон жилийн хойно ярьж, айлынхан нь түүнийг зөнөсөн өвгөн гэж шоолох болно. Энэ гудамж руу орсон бөөн улс өнцөг рүү дөхөж явтал тэнд зоолттой байсан дулемёт хэрхэн гал нээхийг хүмүүсийн дээр өргөгдсөн жаал хүү харжээ. Хэд хэдэн хүн:

- Хэвтээрэй! Хэвтээрэй! Гэж зэрэг хашгирав.

Урьд эгнээнд явсагдсад пулемётын галд хяргуулан ойчив. Амьд үлдэгсэд газар унахын хооронд тайлбай руу эргэн хуйларчээ. Айж сандарсан хүмүүс луугийн сүүлэнд ширвүүлэх мэт бөөнөөрөө нөгөө тийшээ хуйлрахад пулемёт зогсоо зайгүй тачигнаж, нөгөө гудамжнаас бас нэг луугийн сүүлэнд цохиулагсад өөдөөс нь хуйлран ирлээ. Улс амьтан хашигдсан мал аятай түгжигдэж, усны асар том эргүүлгэнд орон татагдах мэт захаасаа пулементын галын хайчинд хяргуулан гол руугаа хурайлдан тэмүүлж байлаа. Нэгэн эмэгтэй цулгуйн голд сөхрөн суугаад загалмайлан залбирч, яагаад ч юм суманд оногдохгүй байгаа нь жаал хүүд харагдав. Бага Хосе Аркадио нүүр цусанд будагдан газар унахдаа жаал хүүг яг тийш нь чулуудаж амжтал асар том хүн давалгаан тэр цулгуйг, сөхөрсөн эхнэрийг, халуу дүүгсэн өндөр цэлмэг тэнгэрийг, Урсула Игуараны амьтны дүрстэй мөсөн чихэр өчнөөнийг зарсан энэ хилэнцэт ертөнцийг арчин хаявай.

Хосе Аркадиогу ухаан орвол эргэн тойрон хав харанхуй, өөрөө дээшээ хараад хэвтэж байлаа. Учиргүй урт, анир чимээгүй галт тэргэнд явж байга болотой, толгойных нь цус барьцалдан хатаж, хамаг бие нь шархиран өвдөж байв. Нойр нь хүрч байна гэж жигтэйхэн. Айдас хүйдэс, бузар булайгаас хол, аюул осолгүй газар хэдэн цаг унтаад авкъя гэж бодоод өвчин багатай хажуугаараа эргэхдээ л хүрэн дээр хэвтэж байгаагаа мэдэв. Хүүрийг вагонд пиг чихэж, дундуур нь явах гудам үлээжээ. Амьтныг яргалснаас хойш хэдэн цаг өнгөрсөн бололтой, учир нь хүүр намрын гөлтгөнө шиг хүйтэн бөгөөд тэмтрээд үзэхэд царцсан хөөс мэт болжээ. Хүүрийг энд авчрагсад гадилын хонгорцгийг хураадаг шиг эгнүүлэн хураах завтай байжээ. Энэ хар дарсан зүүднээс зайлах гэж Бага Хосе Аркадио вогоон дамжин галт тэрэгний толгойн зүг млөхөж явахдаа унтаа тосгоны дэргэдүүр галт тэрэгний өнгөрөхөд банзны завсраар гялсхийн гэрэлд гологдол гадил аятай далайд хийхээр авч яваа, үхсэн эрэгтэй, үхсэн эмэгтэй, үхсэн хүүхдийг харж байлаа. Тэрбээр хоёрхныг таньснаас нэг нь сэрүүн ундаа зардаг эмэгтэй, нөгөө нь хурандаа Гавилан байсан бөгөөд хурандаа гараа мексик мөнгөн горхитой бүсээр ороосон нь сандран үймсэн олны дунд түүгээрээ өрөтө зам гаргах гэсэн бололтой. Бага Хосе Аркадио хамгийн эхний вагон хүрээд харанхуй руу үсэрч, галт тэрэг өнгөртөл шуудуунд хэвтэв. Энэ түүний үзсэн цуваан дотроос хамгийн урт нь байлаа. Эх түүний үзсэн цуваан дотроос хамгийн голд нь бас нэг толгой хавчуулжээ. Ачааны хоёр зуугаад вагоон байлаа. Галт тэргэнд ямар ч гэрэл байсангүй, тэр ч байтугай улаан, ногоон дохионы дэнлүү ч байхгүй, зам төмөр дээгүүр чимээгүйхэн гулссаар байлаа. Вогооны орой дээр пулемёттой цэргийн бараа харлан харагдана.

Шөнө дундын алдад аадар цутгав. Бага Хосе Аркадио хаана галт тэрэгнээс үсэрснээ мэдэхгүй байсан боловч галт тэрэгний явсан зүгийн эсрэг явбал Макондод очно гэж ойлгож байлаа. Гурван цаг гаруй явтал үүрийн үнэгэн харанхуйд хотын захын байшин харагдав. Бороонд шалба норж, толгой нь заадсаараа салчих шахан ангалзана. Кофены үнэрээр нэг айлын гал зуухны өрөөнд орж явчихвал хүүхэд тэвэрсэн эмэгтэй зуухан дээрээ тонгойн зогсож байлаа.

- сайн байна уу. Би Бага Хосе Аркадио Буэндиа байна гэж тэнхэл алдран хэлжээ.

Тэрбээр амьд гэдгээ мэдүүлэх гэж нэрээ бүтнээр нь үсэглэн хэлэв. Ингэсэн нь ч сайн болов. Учир нь тэр эмэгтэй цус нөжинд хутгалдсан, эрлэгийн дансанд орсон байдалтай, баргар эцэнхий хүнийг халаган дээрээ зогсож байгааг харахдаа хий юм байна гэж боджээ. Тэр Бага Хосе Аркадиогу таньдаг байлаа. Хувцсыг нь галын дэргэд хатгал нөмрөх хөнжил авчирч өгөв. Шархаа угааг гэж ус халааж өгөв. азаар звөхөн арьс нь л хэгзэрсэн байжээ. Толгой боох цэвэр цагаан

даавуу авчирч өгөв. Буэндиагийнхан чихэргүй кофе уудаг гэж дуулсан тул аяга чихэргүй цай авчирч өгөөд, хувцсыг нь галын дэргэд өлгөв.

Бага Хосе Аркадио кофег ууж бартлаа ганц үг дуугарсангүй.

- Тэнд лав, гурван мянга байсан байх аа гэж тэр шивнэв.
- Юу тэр вэ?
- Алагдсан улс аа. Өрөөтндээр цугларагсад цөмөөрөө байх аа гэж тайлбарлав.

Тэр эмэгтэй Бага Хосе Аркадио өрөвдөнгүй харав. “Энд хүн амьтан үхээгүй шүү дээ. Танай садангийн хурандаа Аурелиано Буэндиагийн үзэс хойш Макондод юу ч болоогүй” гэж тэр хэлэв. Гэртээ харьтлаа Бага Хосе Аркадио гурван айлаар ороход “Үхсэн хүн байхгүй” гэж нөгөө л хэлдгийг өөрт ныхэлжээ. Галт тэрэгний буудлын дэргэдэх талбайгаар дарйвал шарсан махны ширээг давхарлан хураасан нь бараалан харагдаж, хүн яраглсны ул мөр байхгүй байлаа. Бороо зүсрэн орох тул гудамж хоосон, хаалга цонхоо бин битүү хаасан байшингуудад амьтай голтой юм байгаагийн шинж алга байлаа. Өглөөний мөргөлд дуудах хонхны дуу л тэнд хүн амьтан бий гэдгийн цорынганц баталгаа болж байлаа. Бага Хосе Аркадио хурандаа Гавиланы хаалгыг тогшвол өөрийн нь олон харсан жирэмсэн хүүхэн “Явчихсаан, нутаг буцсан” гэж айсан янзтай хэлээд, халагаа тасхийтэл хааж орхив. Цахилгаанжуулсан хонуурийн гол хаалга дээр нутгийн хоёр цагдаа зогсож, цув, хулдаасан юүдэн өмссөн нь бороонд цохиулах чулуун баримал аятай харагдана. Захын нарийн гудамжинд Антилийн арлын негрүүд хоолой нийлүүлэн тамалга татаж байлаа. Бага Хосе Аркадио хашаа давж, гэрийнхээ гал зууханд оров. Санта Софи де ла Пьедад “Фернандад бүү харагдаараай. Босолж байгаа шүү” гэж шивнэв. Санта Софи де ла Пьедад нэг л нууц хэлэлцээг биелүүлж байгаа мэ хүүгээ “хөтөвчийн өрөөнд” оруулж, Мелькиадесийн сал унах шахсан эвхдэг орыг тавьж өгөөд, өдрийн хоёр цагт Фернандаг унтахаар хэвтэхэ цонхоор таваг хоол өгчээ.

Бага Аурелиано бороонд дайрагдаад гэртээ унтсан учир өдрийн гурван цаг гэхэд тэнгэр онгойхыг хүлээн сууж байлаа. Санта Софи де ла Пьедад дүүгийн нь ирснийг сэм дуулгавал тэр Мелькиадесийн өрөөнд оров. Бага Аурелиано ч талбай дээр ажилчдыг хядсан гэдэгт ч галт тэргээр тэдний хүүрийг ачин далай руу аваачсан аймаар явдалд ч үнэмшсэнгүй. Ажилчид өртөөнөөс явах тушаалыг дагаж, гэр гэртээ тайван тарсангэсэн засгийн газрын онц мэдэгдлийг өчигдөр орой нь Макондод дуудан сонгосон байлаа. Үйлдвэрчний эвлэлийн удирдагчид дээд зэргийн эх оронч үзэл гаргаж, шаардлагаа эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, саравчны дэргэд бие засах газар байгуулах гэсэн хоёр зүйл болгон цөөрүүлсэн гэж бас уг мэдэгдэлд ард түмний сонорт толилуулсан байлаа. Бага Аурелиано хожим нь мэдвэл, цэргийн эрхтнүд ажилчдын хэргийг зохицуулаад, энэ тухай ноён Браунд яаран дуулгавал тэрбээр шинэ шаардлагыг биелүүлэхээр зөвшөөрснөөр барахгүй компанийн хөрөнгөөр гурван өдрийн ардын зугаалга зохиож, найрамдал байгуулсныг ёслол тэмдэглэх санал

тавьжээ. Гэвч цэргийнхнийг хэдний өдөр хэлэлцээрт гарын үсэг зурах вэ гэж асуухад тэр цонхоор гилбээ гялалзах тэнгэрийг харснаа төдийд гэхийн аргагүй дохиод,

- Тэнгэр ч мөн муухай аашилж байна даа. Борооны үед бид ажилладаггүй гэж хэлжээ.

Гурван сар бороо ороогүй, гантай байлаа. Ноён Браун ингэж шийдсэнээ дөнгөж хэлтэл гадилын тариалангийн бүсэн аадар цутгаж, Бага Хосе Аркадио Макондо орох замдаа тэр бороонд дайралдсан нь тэр байжээ. Азарган бороо үүнээс хойш долоо хоноход ч орсоор л байлаа. Засгийн газар өөрийн мэдэлд байдаг мэдээллийн бүх хэрэгслээр үхсэн үрэгдсэн хүн байхгүй, ажилчид сэтгэл дүүрэн гэр гэртээ очсон, гадилын компани бороо арилтал ажлаа зогсоосон гэдгийггалбан ёсоор мянгантаа давтаж, ард иргэдэд түмэнтээ урилгалсаар хүн бүрийг тийм бодолтой болгож чаджээ. Зүсэрсэн их аадар сүйд хийж, яаралтай арга хэмжээ авах хэрэг гарч юуны магад хэмээн байлдааны цагийн байдлыг халаагүй боловч цэгийг хуаранд нь татав. Өдөр нь цэргүүд өмднийхээ шуумгийг өвдгөө хүртэл шуун уруйн ус бургилан урсах гудамжаар тэнэн, хүүхэдтэй цаасан онгоц хөвүүлэн тоглоно. Шөнө нь хөл хорих цаг эхлэнгүүт бууныхаа бөгсөөр айлын халагыг хэмж цохин, сэжигтэй этгээдийг орноос нь чирэн босгоод, эргэж ирэхээргүй газарт авч оддог байлаа. Цэргийнхэн гэмт хэрэгтэн, алаач, хядаач, дөрөвдүгээр зааврыг зөрчигчдийг эрэн хайж, алж устгасаар байгаа боловч баривчлагдсан улсын хувь заяа цу болсныг мэдэх гэж горилон сумангийн даргын өрөөнд дүүрсэн төрөл садныханд нь хүртэл болсон явдлыг үгүйсгэж, сумангийн дарга “Та бүхэн ердөө л зүүдэлж, Макондод тийм юм болж байгаагүй, хэзээ ч болохгүй. үүн шиг азтай хот хаана байна” гэж мэтгэдэг байлаа. Тийнхүү үйлдвэрчний эвлэлийн бүх удирдагчдыг устгав.

Ганц Бага Хосе Аркадио л амьд үлдэв. Хоёрдугаар сард нэг шөнө гэрийн хаалгыг начигнатал нүдэв. Бууны бөгсөөр балбаж байгааг нь ягаад ч эндүүрэх аргагүй байлаа. Бороонд ээрэгдээд гарч чадахгүй байсан бага Аурелиано халагаа нээвэл норсон цувтай зургаан цэрэг офицерийн хамт зогсож байлаа. Тэд ганц ч үг дуугаралгүй, гэр дотрур явж зочдын өрөөнөөс агуулах хүртэл бүх өрөө, бүх шүүгээг нэгд нэгэнүй нэгжив. Урсула өрөөнд нгь гэрэл асаахад сэрээд, нэгжлэг хийж байхад амьсгал даран хэвтэж, хуруугаараа загалмай дүрслэн, цэргүүдийн ява зүгт чиглүүлээд байлаа. Санта Софи де ла Пьедад Мелькиадесийн өрөөнд унтаж байгаа Бага Хосе Аркадио сэрээж амжсан боловч зугтаж амжихгүй болсон нь илт байлаа. Санта Софи де ла Пьедад дахин хаалгыг түгжихэд Бага Хосе Аркадио цамц, гутлаа өмсөөд тэдний орж ирэхийг хүлээн орон дээрээ суув. Энэ үед тэд урланг нэгжиж байлаа. Офицер дүүжлээстэй цоожийг тайлахыг тушаагаад, дэнлүүнийхээ гэрлийг хурднаа тойруулан тусгаж, алжны ширээ, хүчилтэй цозгор байж байгааг хараад эн дхүн суудаггүй юм байна гэдгийг ойлгов бололтой. Гэсэн хэдий



боловч Бага Аурелиано-гоос “Өөрөө уран дархан хийдэг үү?” гэж цохиж асуусанд цаадах нь энд хурандаа Аурелиано Буэндиагийн урлан байсныг талийбарлав. “Тийм байж!” гэж офицер хэлээд дэнлүүгээ асааж, сайтар нэгжихийг тушаавал цэргүүд цозгор шилний доор төмөр лаазанд хайлуулаагүй хэвтэж байсан арван найман алтан загасыг гаргаж ирэв. Офицер тэдгээрийг ширээндээр асгаад, нэг нэгээр нь авч нарийвчлан үзсэнээ нэлээд зөөлөрч “Та бүхнийг дургүйлхэхгүй бол нэгийг авъя. Тухайн үедээ эдгээр нь самуун дэгдээгчдийн таних тэмдэг байсан. Одоо нандин дурсгал болжээ” гэв. Тэр цэл залуу, бараг хүүхдээрээ гэмээр боловч ихл эрэмшингүй ажээ. Түүнд сэтгэл татмаар нэг л байгаа нь сая л мэдэгдэв. Бага Аурелиано нэг загасыг түүнд бэлэг болгосонд офицерын царай хүүхдийнх шиг гийж, загасыг халаасандаа хийгээд, бусдыг лааз руу буцаан шидээд байранд нь тавив.

- Ийм бэлгийг үнэлж баршгүй. Хурандаа Аурелиано Буэндиа манай хамгийн аугаа хүмүүсийн нэг байсан юм гэж хэлэв.

Гэвч ийнхүү хүнлэг үг хэлж уярлаа гээд сурсан зангаа тавьсангүй. Мелькиадесийн өрөөний хаалганы дэргэд Санта Софи де ла Пьедад эцсийнхээ мэхийг хийж, “Энд хүн суухаа больсоор зуун жил болж байна” гэж хэлсэн боловч офицер өрөөг онгойлгуулж дэнлүүгээ гүйлгэн тусгавал Бага Аурелиано, санта Софи де ла Пьедад хоёр Хосе Аркадиогийн нүүрэндээгүүр гэрэл гялсхийгээд өнгөрөхд бөлтгөнөсөн нүдийг нь хараад, нэг түгшүүр өнгөрөхөд, ондоо нэг түгшүүр эхэлж байна, хүлцэнгүй л байхаас өөр аврал байхгүй гэдгийг ойлгожээ. Гэвч офицер дэнлүүгээрээ тасалгааг үргэлжлүүлэн гэрэлтүүлж, шүүгээнд давхарлан өрсөндалан хоёр хөтөвчийг олж хартлаа юу ч сонирхсон шижнгүй байлаа. Тэгээд л гэрэл асаав. Бага Хосе Аркадио урь урьдынхаасаа сүрлэг төгөлдөр болчихсон, бодлогошрон орны ирмэг сандайлан сууж, босохоор бэлдэж байлаа. Түүний цаана дэлгэж онгичсон ном, хуулиастай бичиг бүхий тавиур, бэх нь дүүрэн хэвээрээ байгаа нагбумтай цэвэрхэн хураасан ажлын ширээ харагдана. Бага Аурелианогийн багынх нь л санахынх агаар цэвэрхэн, тунгалаг, юм нь аанай л тоос тогтдоггүй, эвдэрч хуучирдаггүй хэвээрээ байлаа. Үүнийг ганц хурандаа Аурелиано буэндиа л анзаардаггүй байсан сан. Гэвч офицер хөтөвчийг л анхаарч,

- Ам бүл хэдүүл билээ? гэж асуув.

- Тавуул.

Офицер хачирхав бололтой. Тэгснээ Бага Аурелиано, Санта Софи де ла Пьедад хоёрын Бага Хосе Аркадио ч офицерын өөрийг нь харж байгаа мөртлөө харахгүй байгааг ойлгов. Офицер гэрэл унтраагаад хаалга хаав. Цэргүүдтэйгээ ярьж эхлэхэд нь залуу офицер Мелькиадесийн өрөөг хурандаа Аурелиано Буэндиагийн хардаг шиг харсныг Бага Аурелиано мэдэв.

- Энд үнэхээр зуун жил амьд амьтан ороогүй юм байна. Аягүй бол могойтой ч байж мэднэ гэж цэрэгтээ хэлжээ.

Хаалга хаагдахад Бага Хосе Аркадио өөрийнх нь хувьд дайн дууссаныг мэдлээ. Үүнээс олон жилийн өмнө хурандаа Аурелиано Буэндиа дайны бишрүүлэн таах хүчтэйг түүнд ярьж, өөрийнхөө амьдралаас өдий төдий жишээ дурдан хэлснээ батлах гэж оролдож байж билээ. Тэгэхэд Бага Хосе Аркадио итгэсэн. Гэвч энэ шөнө офицер өөрийг нь харахгүй ширтэж байхад сүүлийн хэдэн сарын түгшүүр, гяндангийн бузар булай, өртөөн дээрх үймээн сандрал, хүүр ачсан галт тэрэг зэргийг санаад, хурандаа Аурелиано Буэндиа ердөө нэг бол овтой амьтан, үгйү бол тэнэг амьтан байж гэж боджээ. Дайнд яадгийг ганцхан үгээр “айдаг” гээд хэлчихийн оронд далан долоон үг хэлэхийн хэрэг юу байв. Тэрбээр Мелькиадесийн өрөөнөө увдист гэрэл, борооны шаагих чимээгээр хамгаалагдаж, өөрийнхөө үзэгдэхгүйд сэтгэл амарч, насан туршаа тайван байж үзэггүйгээ үзжээ. Амьдаар минь оршуулчих вий гэж ганц хиртхийдэг байлаа. Өөрт нь хоол зөөдөг Санта Софи де ла Пьедад үүнийг хэлсэнднь аль болох урт насалж, хүүгээ амьдаар нь оршуулаагүй гэдгийг биеэр шалгахын тулд чадах бүхнээ хийнэ гэжээ амлажээ. Ийнхүү Бага Хосе Аркадио айх юмгүй болж аваад, Мелькиадесийн бичгийг судалж, ойлгохгүй болох тусмаа улам шамдаж байлаа. Борооны шаагихад дасаж, хоёр сар болоод чимээ гэж ялгахаа болиод, Санта Софи де ла Пьедадыг орж ирэхэд л хүний бараа харж, хоолыг цонхны тавцан дээр тавиад гаднаас цоожлохыг гуйдаг байлаа. Гэрийн бүх хүн, тэр ч байтугай Фернанда Бага Хосе Аркадио мартаж орхижээ. Фернанда нөхрийн нь ихрийн өрөөснийг офицер тасалгаанд олж харсангүй гэдгийг дуулснаас хойш гэртээ байхад дургүйцэхийг больжээ. Бага Хосе Аркадио хорионд орсноос хойш хагас жилийн дараа цэрэг Макондогоос явахад Бага Аурелиано бороо арилтал хүнтэй чалчих сан гэхээс хэл ам нь загатнаж, тасалгааны цоожийг аван ортол өнөө олон хөтөвчнөөс үмхий самхай ханх тавьж байлаа. Хөтөвчийг зохих юманд нь хэрэглээд шалан дээгүүр тавилсан байлаа. Толгой халзарсан Бага Хосе Аркадимо тасалгаанд ханхлах ой гутам үнэрийг огт тоохгүй, үл ойлгогдох бичгийн ахин дахин уншиж байлаа. Түүнээс сахиулсан тэнгэрийнх шиг гэрэл цацарч байлаа. Хаалга нээгдэх чимээнээр толгойгоо өргөж харснаа дахин тонгойход нь бага Аурелиано, элэнц эцгийнхээ засрашгүй төөргөөр орсныг харцнаас нь ганц хараад л мэдвэй.

- Гурван мянга гаруй хүн байсан. Буудал дээр цугласан бүх хүн тэнд яах аргагүй байсан даа гэж цаадах нь дуугарав.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Бороо дөрвөн жил, арван нэгэн сар, хоёр өдөр оров. Заримда овоо наадмаар болоход макондогийнхон одоо л тэнгэрийн муухай арилах нь гэж гоёлын хувцсаа өмсөж, илаарь болж байгаа хүн шиг туниагүйхэн инээмсэглэх боловч тэгж түр амсхийсний дараа бүр ч ширүүн ордогт удалгүй дасжээ. Аянгын дуу үргэлжлэн нүргэлж тэнгэр нурчих мэт болж, умраас хавсарга тавин, байшингийн дээврийг хуу татаж, хана туургийг нурааж, сүүлийн гадицыг орвонгоор нь суга татаж байлаа. Урсулагийн сэтгэлд байн байн ордог нойргүй болсон тэр үеийнх шиг энэ гамшгийг дагалдаад уйтгааг гаргах ерөндөг аяндаа олдож байлаа. Бага Аурелиано зүгээр суухтай хамгийн шаргуу тэмцэж байлаа. Тэрбээр ялихгүй ажлаар гэртээ ирээд ноён Брауны зад удаж урьсан бороонд дайрагдсан байлаа. Фернанда ханын шүүгээнээс эвдэрсэн шүхэр олоод аваад яв гэхэд нь Бага Аурелиано “Хэрэггүй, бороо өнгөртөл энд байя” гэж хэлжээ. Хатуу ам тангараг өгөөгүй хэдий обловч хэлсэндээ хүрэхээр хатуу шийджээ. Дотуур хувцас нь Петра Котесийнд үлдсэн учир гурав хоноод л бүх хувцсаа тайлан, дан дотуур өмдтэйгө үлдээд хувцсаа угаалгадаг байлаа. Уйдаагүйн тул гэрийнхээ эвдэрч хэмхэрснийг засаж гарав. Хаалганыхаа нугасыг засаж, цоожо тосолж түгжээг шурагдаж, оньсыг тэнийлгэжээ. Хэдэн сарын турш тэрбээр бүүр Хоес Аркадио Буэндиагийн үед цыгануудын мартсан бололтой хайрцагтай багаж сугавчлан гэр дотуур тонголзон явах нь харагддаг байлаа. Биеийн ажил хийгээд тэр юм уу, тоймгүй уйдсандаа ч тэр юм уу, эсэхүл арга буюу хоолоо хассанаас тэр юм уу гэдэс нь хөхүүртэй дарс дундрах шиг шуугдаж, асар том яст мэлхийн малигар хоншоор шиг царай нь хүрэн улаан өнгөө алдаж, давхар эрүү нь арилан, эцэстээ тэрбээр гутлаа өөрөө үдэж чадахаар болтлоо туржээ. Фернанда түүний хаалганы оньсыг хичээнгйлэн засаж, ханын цагийг задалж байааг харахдаа, хурандаа Аурелиано Буэндиа алтан загас хийдэг шиг, Амаранта товч хадаж, хулдас оёдогшиг, Бага Хоес Аркадиогийн эртний бичиг уншдаг шиг, Урсулагийн урьдынхаа юмыг л дурдаж байдагшиг нэгнумаа далан долоо дахих өвчин тусаагүй байгаа даа гэж боджээ. Гэтэл тиймгүй байлаа. Гагцхүү бороонд бүх юм эх адгаа алдаж, тэр ч байтугай хэрэггүй оньсыг гурав хоноод л тосолж байхгүй бол арааны нь хооронд цэцэг ургаж, хоргойн саа зэвэнд баригдаж, чийг болсон цагаан даавууг шар хөгц бүрхэж байлаа. Агаар чийгэнд туйлын нэвчсэн учир загас нээлттэй хаалгаар орж ирэн, тасалгаан дотуур хөвсөөр цонхоор гараад явчихав болохоор болжээ. Нэг өглөө Урсула срэвэл хамаг бие нь суларсан байсанд удаагүй ойчихын дохио гэж бодоод “Дамнуурга дээр тавиад Антонио Исабель ламд хүргэж өгөөч” гэж гуйсанд Санта Софи де ла Пьедад үзвэл эмгэний нуруунд нь хануур хорхой туж шигдсэн байлаа. Цус бэлцийтэл сорж томорсон хорхойг галаар түлэхийг түлж, түүхийг нь түүлээ. Шуудуу татан, усыг эрээс урсгаж, өрөө тасалгаанаас бах, эмгэн хумсыг цэвэрлэсний дараагаар л сая шалыг арчиж, орны хөлд ивсэн тоосгыг авч, шаахайтай явж болохоор боллоо. Бага Аурелиано шальтай шальгүй өчнөөн төчнөөн

ажилд дарагдаад хөгширч байгаагаа анзаарсангүй, нэг орой ганхуур сандал сууж, үдшийн шар гэгээг халиан, Петра Котесийг сэтгэл огт хөдлөх юмгүй бодон сууж байгаад гэнэт өтөлж байгаагаа мэджээ. Нас бие гүйцэх тусам улам аятайхан болоод байгаа Фернандагийн хүйтэн өвөрт ороход саад болох юм байхгүй мэт санагдавч бороонд бүх хүсэл нь ага болоод, нэг их цадчихаад одоо яасан ч яах в эгэж тайвширсан хүний байдалтай болжээ. Урьдын цагт сан бол бүтсэн хүний байдалтай болжээ. Урьдын цагт сан бол бүтэн жил үргэлжилж байгаа ийм борооноор яаж пижгэнүүлэх байсан бол гэж бодохдоо инээмсэглэжээ. Макондод өөрөө хамгийн түрүүнд гөлмөн төмөр авчирч билээ. Гадилын компани гөлмөн тмрөөр дээвэр хийхийг моод болгохоос бүр урьд шүү дээ. Тэрбээр Пера Котесийн унтлагын өрөөг дээвэрлэх гэж, дээвэр хийхийг моод болгохоос бүр урьд шүү дээ. Тэрбээр Петра Котесийн унтлагын өрөөг дээвэрлэх гэж, дээвэр нүдэх борооны чимээ амрагийг нь ойрхон байнагэсэн сэтгэл төрүүлдэг учир тэр төмрийг олж ирж билээ. Гэвч залуугийн галзуурч, өвчигнөж явснаа санахдаа ч сэтгэл хөдлөхгүй, хамгийн сүүлийн удаа наргихдаа сэгэлийн хөдөлгөөний бүх нөөцийг барчихаад, ингэсэн биш урьд баярлаж цэнгэж явсандаа харамсаж гэмших юмгүйгээр бодох гайхалтай чадвар олж авсан мэт байлаа. Бороо орсон биш тайван сууж, чөлөөтэй эргэцүүлэх завтай болжээ, хайрцагтай тосны сав, өрлөбөөр ноцолдсон биш хийж чадах байгаад хийгээгүй тустай ажлыг хийх минь яалаа гэж хожимдсон хойно гэмших болжээ гэж зэрвэс харахад санагдаж байсан боловч тиймгүй, урьдынхыгаа санасандаа ч, хал үзэж халуун чулуу долоосондоо ч тийм гэр амьтай болсонгүй ээ, Бороонд хоригдоод л тийм болж, Мелькиадесийн өрөөнд нисдэг хивс, бүхэл бүтэн онгоцыг багтай нь залгидаг аварга халимны тухай шидэт үлгэр уншиж байсан нялх багын явдлаа санахдаа тийм болжээ. Тэр нэгэн өдөр Фернанда сэрэмж алдсанаас жаахан Аурелиано гонхонд гарч ирсэнд Бага Аурелиано жаал хүүг ачаа гэж дор нь танилаа. Тэгээд хүүгийн үсийг тайрч, хувцас өмсгөж, хүнээс бишүүрхэхийг болиулбал төвгөр шанаа, гайхангуй харц, ганцаардангуй байдал гээд удам дагасан шинжийг авч төрсөн хууль ёсны Аурелиано Буэндиа гэдэгт удалгүй хэн ч эргэлзэхгүй болов. Түүнээс хойш Фернандо тайвшрав. Тэрбээр бардам зангаа татах гэж эртнээс бодсон боловч чухам яахаа мэдэхгүй, ийм байдлаас гарах боломжийн бүх аргыг бодсон боловч аль нь ч сэтгэлд таарсангүй. Бага Аурелиано санаандгүй гарч ирсэн ачаа өвгө эцгийн бодь сэтгэлээр өөд татан явахыг мэдсэн бол тэрбээр тэгж элдэвлэж, тэгж нууж хаахгүй байсан, яс махныхаа тасархайг үхүүлэх гэхээ аль ноднингийн болих байсан билээ. Нялхын шүд нь унаж, ясан шүд нь ургаж байсан Амаранта Урсулагийн хувьд зээ дүү нь борооны залхуут үед зугаагаа гаргадаг амьд тоглоом байлаа. Мемегийн хуучин унтилагын өрөөнд бүгдийг мартаж орхисон англи нэвтэрхий толь хэвтэж байсныг Бага Аурелиано санажээ. Хүүхдүүддээ зургаас нь үзүүлж, эхлээд амьтны дүрс, дараа нь газрын зураг, алсын орны байгалийн байдал, алдартай хүмүүсийн хөргийг үзүүлжээ. Бага Аурелиано

англи хэл мэдэхгүй учир хамгийн нэртэй хот, хамгийн алдартай түүхэн зүтгэлтнийг арай хийн таньж байсан тул хүүхдийн мухар шалаанаас гарах гэж өөрөө нэр олж өгч, өөрөө домог зохиох хэрэг гарчээ.

Фернандо нөхрийгөө тэнгэр зохирмогц явдаг хүүхэн рүүгээ явчихна гэж итгэж байв. Борооны эхний хэдэн сард тэрбээр нөхрөө өөрийнх нь өвөрт орох гэх вий гэж айж, тэгвэл ичгүүртэйгээр үнэнээ хүлээх, Амаранта Урсулаг гарснаас хойш эр эмийн ажил хийх чадваргүй болсноо ярих хэрэг гарах байлаа. Ингэж айсандаа үл үзэгдэх оточ нартай байн байн захидал бичилцэж байсан боловч шуудан явахаа болиход харилцаа нь байсхийгээд тасардаг байлаа. Борооны эхний хэдэн сард их салхинд төмөр замын хэд хэдэн осол гарч, Фернандо үл үзэгдэх отчийн нэг захидлаас өөрийн нь захиа очоогүйг ойлгожээ. Хожим нь үл үзэгдэх оточ нартайгаа холбоо бүрэн тасрахад Фернандо цуст багт наадмын үеэр нөхрийнхөө өмсөж байсан барын багийг өмсөөд, гадилын компанийн эмч нарт хүний нэрээр очиж үзүүлдэг юм билүү гэж үнэнхээсээ бодох болжээ. Гэвч үерээр учирсан сүйрлийн тухай шинэ сонин ирж дуулгадаг нэг хүүхнээс компанийг эмнэлгээ бороогүй нутагт нүүлгэсэн гэж мэджээ. Тэгэхэд Фернандогийн горь тасарчээ. Тэр үйлээ дагаж, бороо намдаж, шуудан дахин явтал хүлээхээр шийдэж, адуу илжиг аятай өвс иддэг этгээд хүн, Макондод үлдсэн ганц франц эмчийн гарт орсноос үхсэн нь дээр гэж санаж байсан учир нууц өвчнөө гэрийн аргаар эмчлэх боллоо. Тэрбээр аврах жорыг олоод мэдчих юуны магад гэж бодоод Урсулад ойртжээ. Гэвч юмыг нуудаг этгээд зангаасаа болоод, шалтгааныг дагалдал болгож, дотоод үзэгдлийг гадаадаар сольж, цус алдаж байгааг халуурч байгаа болгон тайлбарлахад хүрэв. Ийм байдлаар хэлбэл өвчин нь ичгүүр багатай мэт санагдаж, Урсула өвчнийг нь савны бус, гэдэснийх байна гэж зүйтэй бодож, хлорт мөнгөн ус уухыг зөвлөжээ. Ичих гэдэг өвчин тусаагүй ямар ч эмэгтэйн шившигтэй гэж огтхон ч үзэхээргүй энэ эмгэг тусаагүйсэн бол, захидал нь алга болоогүйсэн бол Фернандо насан туршаа бороонд ээрэгдсэн мэт аж төрж ирсэн учир уул азарган бороог бол тоохгүй байх байлаа. Тэрбээр хоолны хуваарийг ч өөрчилсөнгүй, хуучин нэг ч зуршлаа тавьсангүй. Хоол идэж байгаа хүмүүс хөлөө норгочих гээд байх тул ширээний хөлд туйпуу ивж, сандлаа зузаан банзан дээр донхойлгон тавих болсон боловч Фернандо голланд даавуун үтээлгээр ширээгээ бүтээж, хятад хоолны хэрэгсэл тавьж, оройн хоолны өмнө цэцэглэг тосгуурт лаа асааж, байгалийн гамшиг учирлаа гээд нэгэнт тогтсон уламжлалыг эвдэж болохгүй гэж бат итгэж байлаа. Гэрийнхнээс хэн нь ч гудамжинд үл гарна. Фернандо чаддагсан бол бороо эхлэхээс аль өмнө бүх үүд хаалгыг үүрд хаах байсан бөгөөд учир нь цоожлохын тулд л хаалга хийх болсон, гудамжинд болж байгаа явдлыг сонирхоно гэдэг янхан хүүхний л хийх ажил гэж үзэж байлаа. Гэсэн хэдий боловч тэрбээр хурандаа Геринельдо Маркесийн шарилыг байшингийн дэргэдүүр авч явна гэж дуулаад цонх тийш хамгийн түрүүнд ухасхийгээд, дутуу

онгойлгосон цонхоор харсан зүйлдээ урам нь гутаж, хэдэн сар өнгөрсөн хойно ч яах гэж тэгж гүйж очиж харлаа хэмээн харамссаар байж билээ.

Түүн шиг хөөрхийлэлтэй оршуулгыг үзсэнгүй. Авсыг энгийн үхэр тэргэнд ачиж, дээр нь салбагнасан гадилын навчин халхавч хийсэн ажээ. Бороо зогсолтгүй асгарч, тэрэгний дугуй шаварт шигдэн, халхавч нурчихгүй тогтож байгаа нь хачин. Авсыг бүтээсэн туг, дарын утаа, хүний цус болсон, хамгийн гавьяатай ахмад зүтгэлтний ч үзэн яддаг туган дээгүүр борооны гашуун ус нижигнэн бууж байлаа. Авсан дээр Амарантагийн юм оёдог өрөөнд орохдоо Геринельдо Маркесийн зочны өрөөнд, өлгүүр дээр орхидог байсан зэс, торгон цацагтай сэлмийг тавьжээ. Неерландын гэрээнээс хойш амьд үлдсэн хэдэн ахмад зүтгэлтэн өмднийхөө шуумгийг шуучихсан, зарим нь тэр ч байтугай хөл нүцгэлчихсэн, шавар шавхай шал падхийлгэн, нэг гартаа нишингийн саваа, нөгөөдөө бороонд угаагдсан цаасан цэцэг барин авсны араас дагаж явлаа. Хий сүг жагсаж яваа мэт хурандаа Аурелианр Буэндиагийн нэртэй хэвээр байгаа гудамжаар явж, хурандаагийн байшин тийш тушаал авсан юм шиг зэрэг толгойгоо эргүүлэн харснаа булан тойрон, талбай руу орж, хам хум янзалсан оршуулгын тэрэг шаварт шигдсэн учир амьтан гуйж шавраас гаргуулах хэрэг гарав. Урсула өөрийг нь өргөөд хаалган дээр аваачаад өгөөч гэж Санта Софи де ла Пьедадаас гуйлаа. Жагсаалыг их л анхааралтай ширтэж, сайн ерөөлт сахиулсан лугаа адил сунгасан гараа энхэл донхолд бэлэвсрэлийн тэрэгний яйжиг жайжиг хийхийн аяар хөдөлгөхийг нь үзсэн хэн ч түүнийг юм хардаг гэдэгт эргэлзсэнгүй.

-Хагацъя, Геринальдо хүү минь. Адистат ерөөлийг минь манайханд айлтгаж, тэнгэр цэлмэнгүүт уулзана гэж байна гэж хэлээрэй гэж Урсула хашгирав.

Бага Аурелиано элэнц эхийгээ орон дээр нь буцааж хэвтүүлэхдээ юу хэлэх гэснийг нь өнөө л эрээгүй байдлаараа асуужээ.

-Яг үнэнээ л хэлж байна. Бороо арилмагц би явна аа гэж Урсула хэллээ.

Гудамжаар дүүрэн шавар шавхай болсонд Бага Аурелиано сэтгэл түгшжээ. Малдаа өнгөрсөн хойно их л санаа зовж, бэржээнх нөмрөөд Петра Котесийнх руу явав. Петра Котес хашаандаа бүсэлхийгээрээ татсан усан дотор зогсож, үхсэн адууг хөдөлгөх гэж оролдож байлаа. Бага Аурелиано модон гадас авч хөшүүргэдэн туслав. Хөөж цүндийсэн хүүр данхагнан хөдөлснөө шингэн шавхайн урсгалаар хөвөн одов. Бороо орж эхэлснээс хойш Петра Котес хашаагаа үхсэн малын сэгээс л цэвэрлэх ажилтай болжээ. Эхний долоо хоногт Бага Аурелианод зурвас илгээж, арга шалавхан сүвэгчлээч гэж гуйсан боловч цаадах нь “Яарах юу байх вэ, нэг их болохоо больчихсон юм алга байна, бороо арилангуут нэг юм бодно” гэж хариулжээ. Петра Котес бэлчээр усанд автаж, мал ууланд хулжин гарч, тэнд идэх юм байхгүй, хар хулд бариулж, халдварт өвчнөөр хиарч байна гэж хэлүүлсэнд Бага Аурелиано “Санаа зоволтгүй ээ. Малтай болохдоо л болно, ганц тэнгэр цэлмээсэй” гэж хариулжээ. Петра

Котесийн харсаар байтал нь мал нь өч төчнөөнөөрөө үхэж, шавхайд цацаж үхэж байгаа малаа арай л гэж мөчөөр нь салгаж амжиж байлаа. Макондогийн хамгийн их, хамгийн найдвартай гэгдэж байсан хөрөнгийг нь үер сүйтгэж байгааг яаж ч чадахгүй харж, одоо түүнээс нь гагцхүү бээсэн сэгний үнэр үлджээ. Бага Аурелианог юу болж байгааг үзэхээр арайхиж нэг юм ирвэл нурж унасан агтны жүчээнд ганц эцэнхий луус, ганц морины зовлого л байлаа. Петра Котес байдаг хүнээ харахдаа гайхсан ч үгүй, баярласан ч үгүй, уурласан ч үгүй, гагцхүү ёжтойхон инээмсэглэж,

Тавтай морино уу! гэж хэлжээ. Тэрбээр хөгширч, муухай тураад, зэрлэг араатны нүд шиг шар нүд нь дан усан бороо харсаар байгаад уйтгар гуниг шингэж, үйлээрээ болохоос гэсэн байдалтай болжээ. Бага Аурелиано тэднийд гурван сар болсон нь төрсөн голомтдоо байснаас тухтайдаа тэгсэнгүй, нэг хэсэгтээ бодлоо цэгцэлж чадахгүй, дахин бэржээнх нөмөрч зүрхлэхгүй байсан учраас тэгжээ . гэртээ хэлдэг басан шигээ тэрбээр “Хаашаа чарах вэ. тэнгэр мөдхөн цэлмэх биз” гэж хэлжээ . Эхний долоо хоногт тэрвээр Петра Котесиын улирах цуаг, усан бороонд ихэд хувирсан царайнд дасаж, улмаар урьдынхаараа харах болж, урьдын газлуурч явснаа, түүнтэй хавьтахад мал нь учиргүй үрждэг байсныг санаж хоёр дахь долоо хоногийн нэ шөнө, нэг талаар хуял хөдөлж, нөгөө талаар мал өсгөх шунал хөдлөн , хүүхнийг үнэсэж үнгэлэн сэрээсэнд цаадах нь “зүгээр унтаа . Балайтаж байх цаг биш” гэж бувтнажээ . Бага Аурелиано адрын толинд өөрийгөө харж, Петра Котесийн хөх судас гүрийж хэрзийн харзайсан нурууг хараад хүүхний зөв, цаг өөрчлөгдөөгүй, харин өөрсдөө амраглах янаглах ажлаас гарснаа ойлгожээ .

Бага Аурелиано авраа чирсээр авааль гэргийдээ буцаж ирж, тэгэхдээ Урсула төдийгүй макондогийнхон бүгдээрээ бороо зогсмогц үхэхээ хүлээж багйа агэсэн итгэлтэгэр эргэж иржээ . Гудамжаар явж байхдаа байшинд хүмүүс гөлийж хоцрон, элгээ тэрэн сууж, эрхшээл , эрэмбэд орохыг үл мэдэх үргэлжилсэн цаг хэрхэн урсаж бөөгааг бүхий л бие сэтгэлээр мэдэрч, брооо л харж суухаас өөр ажилгүй учир цаг хугацааг жил, сар өдөр цаг гэж хуваах хэрэггүй ойлгожээ . Хүүхдүүд нь Бгга Аурелианог бөөн баяр хөөр болон тосож, Аурелиано ч паржигнах болсон найрал баян хуураа даран тэднийг зугаацуулах боллоо . Гэвч Буэндиагийнхний залууи үе нэвтэрхий толийн зураг үзэхийг илүү таалж, дахин Мемегийн унтлагын өрөөнд цуглах болоод Бага Аурелиано вмыг ихэл ургуулан боддог болохоороо агаарын бөмбөгийн үүлэн дунд хоноглох аятайхан газар хайн яваа нисдэг заан гэж хэлж өгчээ . Өөр нэг хуудаснаа морьтой хүний зурагбайсанд Бага Аурелиано зургийг нэгд нэггүй судалж үзээд хичнээн хачин хувцастай ч гэсэн нэг л танил юм шиг болохоор нь хурандаа Аурелиано Буэндиа байна гэж дүгнэжээ . Зургаа Фернандад үзүүлбэл, морьтой хүн хурандаатай төдийгүй , ер нь Буэндиагийнхтай адилхан юм гэдгийг хүлээжээ . Угтаа, тэр нь татар дайсны зураг байлаа .Тийнхүү Баша

Аурелиано эхнэрийнхээ зургаан клограмд давсалсан мах, шуудай цагаан будаанаас өөр юм гэрт байхгүй болсныг хэлэн хэлтэл родосын хөшөөнөөс өгсүүлээд могой

ховслогчийн хүртэл бурж, цагийг санаа зовох юмгүй нөгцөөж байлаа .

-Чи тэгээд надаар яалгах гэсэн юм ? гэж түүний асуухад

-Би мэдэхгүй, энэ бол эрэгтэй хүний л ажил гэж Фернандро хэлжээ .

-За яах вэ, бороо намжихаар нэг юм бодье гэж Бага Аурелиано хариулав.

Үдийн хоолон дээр үмх мах, атга цагаан будаа өгөх болон боловч тэрбээр ар гэрийн ажилд санаа тавихаасаа нэвтэрхий толио л илүү сонирхосон хэвээрээ байлаа .

“Одоо яах ч аргагүй. Бороо мөнх орно гэж байхгүй” гэж ярина. Агуулахаа хүнсээр дүүргэхэд санаа тавихаа хойшлуулахын хэрээр

Фернандо улам ондууцаж, нэг үгэлж ирснээ больсхийгээд байдагб айснаа сүүлдээ зогсоо зайгүй янших болж, өглөөгүүр дуу

нь зүйрлэвээс гитарын бүдүүн утас нэгэн хэвээр дүнгэнэх аятай

байснаа роой тийшээгээ улам ччангарч, улам хурц хөг аялгуутай болох боллоо. Бага Аурелиано эхлээд энэ мигуйн концертыг тоохгүй байсан

боловч маргааш нь өглөөний хоолны дараа тэр дүгэнэн борооны чимээнээс ч чихэнд чийртэй, чанга тод болж ирлээ . Цернанда гэр дотуур холхин үглэсэн нь:

хааны хатны байдлаар хүмүүжсэн байтлаа энэ галзуугийн байшинд ирээд, шивэгчин боллоо, хүн нуруугаа бөгцийтөл зүтгэж, тангараг андайгн хүчинд л тогтож байдаг

энэ гэрийг авч явах гэж үүр цүүрээр аваад үдэш орой болтол угааж арчиж, цэвэрлэж цэгцэлж, засаж сэлбэж байхад төнгөрийн хишиг хэзээ

өөрөө аманд ороод ирэх нь вэ гэж амаа ангайгаад орон дээрээ алхайж хэвтэж байдаг ийм анхиагүй, шашин номгүй,

завхай зайдан унтахаар хэвтэхэд нүд миьн, элс орчихсон юм шиг аргах юм . “сайн байна уу, Фернанда, сайн унтав уу?, Фернанда” гэж хэн ч хэзээ ч хэлэхгүй.

“”Яагаалд царай чинь цонхигор байна, яагаад нүд чинь хөхөрчихсөн босож ирж байна? гэж хэн ч хүний урам байна, асуухгүй, танайхаар хэзээ ч хайрлуулахгүй ,

гэхдээ намайг газрын гай, тогооны алчуур гэж үздэг , олдохгүйд мундахгүй амьтан гэж боддог энэ гэрийнхнээс харж хандана байгаа гэж горьдохгүй, үхсэн хойноо , танайхан дандаа л намайг далдуур ад үзэж, намайг засдаг зантай,

хоёр нүүртэй хуурамч зальхай энэ тэр гэж есөн өнгөөр хэлдэг, тэр ч байтугай Амаранта, тэнгэрийн бодь хутгийн олох байтугай, намайг “хоногыг их мацгаас

ялгагдаггүй гэж амьтанд зарлаж байсан. Ямар ч муухай юм хэлдэг юм, тэнгэр миьн, тэгэхэд нь би тэнгэрийн бошгийг дагаад тэвчээд л өнгөрүүлсэн, одоо бол чадахгүй ээ,

адгийн муу Бага Хосе Аркадио гэрт банзалтай качаког оруулснаас голомт маань цайлаа гэсэн, боддог бол бодоод үз, банзалтай качако, эзэн тэнгэр миьн, нүглийг миьн

өршөөгөөрэй би хүний хэлснийг хэлж байгааюм шүү, гичий гаралтай качака , ажилчдыг алуулахаар засгийн газрын явуулсан качако гээд байгаа юм

даа, даанч гомдмоор,герцог Альбагийн загалмай зүүлэгсэн намайг, ерөнхийлөгч нарын гэргийн атаархаж байсан язгуур сайтай хатагтай, арван нэгэн

испани нэрээр гарсын үсэг зурах эрхтэй цэвэр тайж, сурвалжит хүүхэн, залбасуудын энэ хотын оронцогт арван зургаан

хүний ширээг сандрангүй засаж ячадах цорын ганц цсан нүдэт цусан зүрхт намайг тэгж хэлж байгаа юм даа, эр нөхрийн нэр үзүүсэн цаашгүй , тэлээгүй

банзал хүртэл элэг хатан хөхөрч ийм олон халбага усэрээ, ийм олон хутга ,ц



айны халбага ажран хөлиөд л хэрэг болдог юм уу гэхээс сайн үйлт христос шашинтанд хэрэг байхгүй гэж байгаа юм даа, цагаан дарсыг хэдийд өгөх ямар гараар өгөх, ямар жүнзэнд хийхийг хэн мэдэх вэ, би л ганцаараа мэднэ, гэтэл хөдөөний бүдүүлэг Амаранта, тэнгэрт сүнс нь очих болтугай, цагаан дарсыг өдлөр, улааныг үдэш өгдөг гэдэг бөйсан , би энэ хавьдаа л ганцаараа үөнийн алтан хөтөвчинд мөр хардаг гэж сайрхаж болно, гэтэл муу хорлонтой , далд битүү хурандаа Аурелиано Буэндиа , тэнгэрийн бодь хутгийг олох болтугай, намайг яагаад ийм эрх ямбатай болсон юм, удвал цэцгээр баадаг болоод тэр үү гэж тохуурхаж байгаа юм даа, бодоод үз, яг л ингэж хэлсэн дээ, төрүүлсэн охин Рената минь намайг унтлагыхн өрөөнд өтгөн мөр харж байгааг үзээд хөтөвч нь сүлд мулд болсон үнэхээр алтан юм даа, гагцхүү дотор гаргасан юм, ердийн , хамгийн энгийн , тэр ч байтугай бүр долоон доор качакогийн баас юм гэж байсан, үнэн, юм үнэнээрээ , өөрийн минь охин тэр шүү дээ , бодоод үз, эндхийн бусаднв ч дээрэмдэх юмгүй , таасран таар шуудайнууд , гэвч нөхрийн оронцог чамаас ядахдаа өчүүхэн ч атугай намайг хүндэлдэг болоосой гэж харалгүй яах вэ, яагаад гэвэл чи юу ч гэлээ гэсэн тэнгэрийн өмнө, улс амьтан өмнө богтолж авсан нөхөр минь, өөрийнхөө хүслээр , тэнгэрийн зарилгаар ихээхэн үүрэг хүлээсэн өмөөрөх ёстой хүн минь, дутагдаж гачигдахыг мэдэхгүй, бодож санах юмгүй сууж, оршуулгын цэцгийн эрих цаг нөгцөөн хэлхэж байхад минь эцэг эхийн минь гэрээм чи л лав авч ирсэн , гэтэл загалмай зүүлгэсэн эцэг маань өөрөө нэрээ тавьж , бөлзгөөрөө лацадсан захидал ирүүлж , загалмай зөрүүлж бариулан гэрээс минь амьсгалах аргагүы бүгчим энэ халуун тамд авчирчихаад , мацгийн үед салхи фээрийг ч махиж амжаагүй байтал хар авдар , хахир хуур хоёрын чирээд тэр муу өөдөө барсан янхан, арчаагаа алсдан банзалтайгаа ёс тэрсгүүлэн амьдрах гээд яваад өгч байгаа юм даа. Ямар гэгч олхиогүй амьтан , ямар гээч өөдгүй адгуус болох нь бөгсийг нь харахад л андашгүй , анаас нь багтаад ийн үг гарчихлаа , яадаг юм цус, залуу гүүнийх шиг том бөгсөө хөдөлгөж байгааг нь харахад л ил , гэтэл би бол хааны ордонд ч гахайн байранд ч, ширээний ард ч орон дотроо ч хүүхний дайай хүүхэн, , тэнгэрээс айдаг ёсыг барьдаг , үйлээ дагадаг төрөлхийн язгуурт хүүхэн , мэдээж, би бузар муухай юм хийнэ гэж гонж, нөгөө муу бол тийм юм хийхдээ л хийнэ, яахаас ч буцахгүй , франц дуус эмсээс ч түмэнтээ дор, шудрага бус амьдаря үүдэндээ улаан дэнлүү өлгөдөг боловч тэр хавьд дээр, нөхрийн оронцог болсон чи муу хатагтайы Ренато Аргато, ноён Фернандо дель Карпио хоёрын охиныг ингэж муухай чадах л дутаж гэнэ. Гэтэл Фернандо дель Карпио гэдэг чинь хутагт хүн, үнэнхүү сүсэгтэн , “Ариун авчсан” одонт хүн, эх эцэг хосёр маань булшинд орохдоо ялзардаггүй , арьс нь үхсэн хойноо ч шинэхэн бэрийн пүүсүү палааж шиг цэвэрхэн , толигор , нүд нь амьд б бөгөөд маргад эрдэнэ шиг тунгалаг айсан гэтэл ньв Аурелиано үгийг нь тасалж, -Энэ ч худлаа , хүүрийг нь авчираад таггүй үнэр ханхалж байсан гэжээ . тэрбээр фернандогийн алдаж хэлэхийг анан бүтэн өдөржин тэвчээртэй чагнажээ . Фернандо хариу хэлэснгүй , гагцхүү дуугаа намсгав. Энэ үдэш оройн хоолон дээр Фернандогийн улигнөөн бавтанах нь галзуурмаар болж,

борооны чимээг ч дарлаа .  
Бага Аурелиано толгой унжуулан сууж, яльтай юм идсэнгүй . унтлагынхаа өрөө рүү эртхэн оров. Маргааш н т өглөөний хоолон дээр Фернандо салганатал чичирч , шөнөжиэ цурам хийгээгүй байдалтай байсан  
боловч урьд дарлуулж байсандаа шаналж тарчлахаа больсон бололтой . гэвч Бага Аурелианог чанаан өндөг өгөөя гэж гуйхад Фернандо өндөг өнгөрсөн долоо хоногш дууссаныг зүгээр нэг хэлсэнгүй, муусайн эрчүүл болжморын элэг аваад ир гэж ичихгүй шаардана гээч гэж ирээд л үмхий үгээр дайрч гарчээ . Бага Аурелиано урьдынхаараа хүүхдүүдээ цуглуулж, нэвтэрхий толийн зураг зурах үзэх гэсэн боловч Фернандо өрөөг нь фэвэрлэж байгаа дүр үзүүлж ичих нүүэрндээ илэг наасанг амьтан д нэвтэрхий толинд хурандаа Аурелиано Буэндиаг зурсан байна бана гэж юм мэдэхгүй балчир хүүхлийн толгойг эргүүлж бах даа гэж зориуд яихэнд хонх уясаар байлаа . Аурелиано гонхонд суутао Фернандо хажууд нь очиж, даажигнан тохуурхаж, хэдгэнэ шиг салахгүй дүнгэнэн хажууд нь эргэлдэж, гэрт чулуунаас өөр идэх мгүй болто манай лут хар хүн ч персийн султан шиг бороо хараад л суух болно. Залхуу , хоолны сав , өөдгүй амьтан арга байж уу дээ, бүсгүй хүний хүчийг завшиж сурчихсан , халимын тухай үлгэрээр маллаад бай болох Илны авгайта гэрлэсэн гэж бодож дээ хэмээн эрүүдэж гарлаа . Бага Аурелиано гэргийнхээ эрүүний шөл уулгахыг хоёр ц аг гаруй дүлий юм шиг тархинд нь дуулиатна. Үдэш болтол тэвчээд, тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх вэ гэгчээр  
-Христос тэнгэрийг бодож амиа хамхиаг гэж гайхжээ . Фернандо хариудн харин ч дуугаа өндөрлөж “Тэгнэ вйи! Миний үгэнд дургүй чинь хүрч багаа бол тонилохгүй юу гэж хэлжээ . тэгэхэл л Бага Аурелианогийн уур нь дэлбэрэв. Тэрбээр суниах гэж байгаа мэт алгурхан босож, тавиур дээрээс ваартай хайтан ойм, хахуун цэцгийн шүүрэн шүүрэн авч нэг нэгээр нь шалан дээр чулуудав. Фернандо улангасан үглэхдээ хүний хорыг ийм аймаар хөдөлгөнө гэж өнөө болтол санаагүй тул айж, “эвлэрье” хэмээвч оройтсон байлаа  
. Бага Аурелиано нэгэнт цагаандаа гарч шийдчихсэн хүний байдалтай шилэн хоргыг хагалаад ,, дотроос нь сав смуулгыг аван , аяга , таваг, хундага шал руу шидэж гарлаа . тэгэхдээ тун тайван байж, урьд гэрийнхээ хананд мөнгө нааж байсан шигээ тун нямбайхан , туйлын нухацтай , махруу байдалтайгаар богемийн болор, гараар хээлсэн цэцгийн вааранд сарнай ачсан завинд суугаад бүсгүйчүүлийн зураг, алтан жаазтайы тол гээд зочдын өрөөнөөс авахуулаад агуулдар хүртэл бүх өрөөнд байгаа хагалж болох бүхнийг хана руу чулуудан хагалж байлаа . Гал зууханд байсан то шавар домбо хамгийн сүүлд гарт нь тааралджээ . Домбо бөмбөг дэлбэрэх мэт чимээ гарган түмэн хэсэг болон яарав. Дараа нь Бага Аурелиано гараа угааж, бэржээнх нөмөрч аваад гарч явснаа шөнө дундын алдад давсалсан хатуу мах, шуудайтай цагаан будаа, эрдэнэ шиш, хамарт цох, гадилын хэдэн хорчгор хонгорцогтой буцаж ирэв. Түүнээс хойш гэрт идэх уух юмаар дутсангүй .  
Амаранта Урсула, жаахан Аурелиано нар тэр бороот хэдэн жилийг энэ яваа насныхаа хамгийн жаргалтай үе гэж дурсан санаж байжээ . Фернандогийн хорьсоор байтал хашаан дотуур шавар

дундуур, шал палхийтэл гүйлдэж барьж аван , хөл толгойг нь тасалж , эрвээхэйний далавчнаас авсан тоосонцрыг санта Софи де ла Пьедадаас нуун тогоонд хийж шөлөнд хор хольж байна гэж тоглодог байлаа . Тэд Урсулаг тоглоом болгохдоо хамгтын дуртай байв. Эмгэнийг хуучирсан том хүүхэлдэй аятай үзэж , байшингийн өнцөг булан руу чирч эрээн мяраан даавуу зүүж, нүүэрнд нь хөө түрхжэж , бөөхны нүд ухдаг шигээ цэцэрлэгийн хайчаар эгээл нүдийг нь сох хатгасангүй . Эмгэнийг дэмийрч эхлэхээр тэд онцгой баясдаг байлаа . Борооны гурва дахь жил Урсулагийн ой ухаан үнээр оон гэрэн болсон бололтой , өнөө маргаашийг ялгахаа байж, өнөөдрийн юмыг аль дивангарт болсон юмтай хольж хутган, зуу гаруй жилийн өмнө өнгөрсөн элэнц ээж Петронила Игуарандаа үхтлээ гэж бүтэн гурван өдөр тайтгаруулах янзгүй үйлжээ . Тархинд нь бүх юм хутгалдаж орхиод, жаахан Аурелианог мөс зүүхээр явж байсан насандаа байгаа хурандаа хүүгээ гэж андуурч , шашны сургуульд байгаа Хосе Аркадиоог цыган дагаад явчихсан ууган хүүтэйгээ эндүүрнэ. Урсула гэр орныхоо тухай дандаа уймрах тул хүүхдүүд нь огт ондоо ондоо үед амьдарч байнаа олон жилийн өмнө үхсэн төрөл садангын нь тэр төн дээр ирлээ, энэ утан дээр ирлээ гэж үймүүлдэг байлаа . Үсээ үнсээр будуулж, нүдээ улаан даөвүүгаар боолгосон боловч Амаранта Урсула, Аурелиано хоёрын үнэхээр хараад ярьж байгаа юм шиг барим тавим ярих төрөл төрөгсдийнхөө дунд сууж байх нь эмгэнд сайхан байдаг байлаа . Өөрийнх нь төрөө өмнө ыолсон явдлын тухай элэнц хуланц нартайгаа хуучилж тэдний ярьж байгааг ихэд сонирхож тэдний үхсэнээс хойш байсан төрөд садныхаа үхэхэд тэдэнтэй хамт гашуудан байлаа. Урсула даны үеэр бо соо хүний дайтай хутагт Иоёофийн гөлтгөнө ыббаримлыг авчраад “Бороо өнгөртөл балгаач” гэж гуйсан хүн хэн байсныг олж мэдэх гэж ихэд улайж байгааг хүүхдүүд нь дорхоно анзаарчээ . Тэгэхэд нь л Бага Аурелиано нуусан газрыг нь ганц Урсула мэдэх эрдэнэсийн санаад , хичнээн цохиж сауугаад , ам алдуулах гэж оролдоод бүзтсэнгүй , Урсула хэчнээн дэмийр ч солиорч байлаа ч гэсэн нууцаа хэнд ч хэлэхгүй байх ухаанаа хадгалж ,нуусан газраа хэлж өгөхөөр бат шийджээ . Бага Аурелиано хуучин архины нэг найзаа эрдэнэсийн эзэн болгох гэж үзсэн боловч, Урсула их л нарийн шалган байцааж, өдий төдий гэнэ сэрэггүй юм асуугаад түүнийг суудлгаж орхижээ Урсулаг нууцаа хэлэлгүй байсар үхэх нь гэж итгэсэн Бага Аруелиано хашаа болон арын хашаанд ус гадгаш ургах сувгаар татах, нэрийдлээр газар ухдаг ажилчдыг хөлсөлж , төмөр саваагаар газрыг нэлэнхүйд нь нь хатгаж төнхөж, боломжийн гэсэн бүх металл эрэгчээр тэмтэрч хийх зэргээр гурван сар эцтэлээ эрээд алт гэхихсээр юм олдсонгүй . Тэгэхэ газар ухагчдыг хөлслөөд болдоггүй юм бол хөзрөөр мэргэлүүлээд олдог гэж шийдээд Пилар Тернерагаас туслахыг гуйсанд цаадахи нь гагцхүү Урсула хөзрийг гараараа сөхсөн цагт л мэргэононо гэж хэлжээ . гэсэн ч төлөгч авга эрдэнэс бийг нотлоод , зэс утсаар амыг нь боосон гурван зотон хүүдий долоон мянга хоёр зуун арван дөрвөн алтан зоос

байгааг нарийвчлан хэож , түүнийг хааш хаашаа зуун хорин хоёр метр тойрогт булсны төв нь Урсулагийн ор байна хэмээн хэлж өгчээ . гэхдээ бороо арилахаас нааш , бороо арилсны дараа гурвантаа кургадугаар сар гарч, намай энэ марьбн наранд хатахаас нааш эрдэнэс олдохгүй гэж Пилар Тернера сануулан хэлжээ. Энэ мэдээ дэлгэрэнгүй боловч туйлын бүрхэг, хий үзэгдлийн тухай цуутай тун адилхан байсныг Бага Аурелиано эрэгцүүлээд , дөнгөж наймдугаар са гарч, мэргийн хугацаа болтол наана хаяхад гурван жил үлдэж байсан боловч эрлээ үргэлжлүүлэхээр шийдэв. Урсулагийн орноос арын хашаа хүртэл яг зуун хорин хоёр метр байсан Бага Аурелианл туйлгүй гайхан хажуугаар нь бас мэдгджээ . Фернанда , Бага Аурелианлгийн өрөө тасалгааг хамжиж байгааг харж, газар хагчид “сцвгийг нэг метр гүнийзгийд ” гэж байгааг дуулаад түүнийг дүү шигээ солиорчихоогүй байгаа гэж айжээ . Эдэнц эцэг нь аугаа их нээлт хийх гэж байсан шиг эрдийн өвчин тусаж үлдсэн жаахан өөхөө гээж ихрийн өрөөсөнэйгөө урьдынх шигээ дахин адил болж , Бага Хосе Аркадиотой эцэнхий , дохиогоороо төдийгүй хайнга харж зожиг байдлаараа даилхан болжээ Хүүхэдтэй но ололдохоо болив. Хамаг би? нь туж шавар болчихсон тэрбээр хэзээ ч хамаагүй , гал зуухны нэ буланд хоолооо босоогоороо хам хум идсэн болж санта Софи дела Пьедадын юм асууха хариу хэлсэн болоод ч ажилдаа орно. Бага Аурелианоог ингэж улайран ажиллахын чинээ санаагүй Фернандо түүний ийнхүү махарч байгааг ажиглагсдаа ингэж байгааг , хөлжиж авъя гэж үхтлээ улайрч байгааг , нэг зүтгэхээрээ л бүтээж байж салдагаа ингэж бие гаргуунд гагаж б айна гэж бодоод түүгийг хөдөлгөх гэж шарыг малтаж , хорон үгээр дайрч байснаа санахдаа зовох шиг болж байдаа . гэвч Бага Аурелиано тэгж нялууран эвлэрч байх завгүй байлаа . Илжирсэн мөчир, ялзарсан цэцэгтэй балчиг дунд хоолойгоороо татуулан зогсож , цэцэрлэгийн ухаж дуусаад, ар , өврийг хашааг малтаж бараад, дорно сэжүүрийн гохны суурийг доогуур нь гүн сэндийлжээ . Нэг шөнө гэрийнхэн газар доргин тар няр хийхэд цочин сэрээд гакар хөдөлж байна уу гэж бодтол үзвээс байшингийн гурван өрөөний шал цөмөрөөд , гохны шалнаа Фернандагийн өрөөг хүрсэн асар том ангал гарсан байлаа . Гэвч үүний хойноч Бага Аруелиано эрлээ орхисонгүй . Сүүлчийн найдвар тасарч, гагцхүү хөзрийнхөө мэргээр баримжаалаад өөр мэхгүй бо лсоэ боловч ганхсан суурийг бөхөлж ангальг шохойн уусмалаар бөглөж гаваад өрнө этгээл газар ухаж гарав. Энд малъяж ажлаа дуусаагүй байхал нь дараа нь оны зургадугаар сарын хоёрдугаар долоо хоног гарч, бороо намдах төлөвтэй болж эхэллээ . үүл сарниж тэнгэро хариугүй зохирох янз оров. үнэхээр ч тэглээ . Баасан гаригт өдрийн хоёр цагт тэнэгхэн , ээлтэй наран ертөнцийг гийгүүлж , тоосго шиг улаан, шүрүүн , ус шиг цэвцэрхэн , тунгалагхан байлаа . Энэ өдрөөс хойш чилийсэн арван жиол бороо орсонгүй . Макондо балгас болжээ . гувамж байсан газар намаг цолж , энд тэнд шавар, замаг дотроос өнцгийн цахилдагт баригдсан эвдэрхий тавилга, салын арга яс цухуйх нь ирсэн шигээ санд мэнд зугтсан харийхны сүүлчийн дурсгал гэлтэй . гадилын дон тусах үеэр яаран барьсан байшин эзгүйрчээ

. гадилын зомпани бүр хөрөнгө зөөрөө зөөн аваачиж , төмөр дотрон хашаата жижигхэн хотын бууцан дээр овоолоостой хог л үлдсэн байлаа . Үдэшдээ санаа амар хөзөр тоглон суудагб айсан сэрүүн асартай модон байшингууд хэдэн жилийн хойно Макондог газрын хөрснөөс арчих тэр шуурганы угтал болсон салхинд хийсэн арилсан мэт алга болжээ . Алаг нүдэн цэцэгээр хэрэгдсэн хөнгөн тэргэнд дотор Патрици Брауны мартаж орхисон бээлийгээр энд хүн урьд сууж байжаа гэж хамгийн залгисан хар хавсарганы дараа мэдвэл мэдэж болох байлаа . Хотыг анх байгуулах үеэр Хосе Аркадио Буэндиагийн шинжилж , хожим нь гадилын тариалан цээглэж байсан илбэдүүлсэн газар одоо цул намаг болж, дотор нь өмрхөрсөн модын ёзоор ёрдойж , ил болсон тэнгэрийн хаяанаа хэдэн жилийн турш далай чимээгүйхэн хөөсрөн байж билээ . Бага Аурелиано эхний ням гаригт хуурай хувцас өмсөөд , хот юу болсныг харах гэж гарахдаа хртхийн цочжээ . Бороонд тэсэж үлдсэн хүмүс нарны бараа харайхиж харан баярлан суугааг үзвэл цөм гадилын дайрлага дайрахаас өмнө Макондод суурьшигшад байлаа . Арьс нь замаг шиг ногоовтор хэвээрээ , борооны жилд агуулахын үнэр орсон нь сайн гараагүй байсан боловч төрсөн хотынхоо эзэд дахиад боллоо гэж бодохооё баярын мишээл нүүрэнд нь тодорчээ . Туркийн сайхан гудамж дахин урьдынх шигээ боллоо . Зуузайгүй шаахай угаласан , зузаан металл ээмэг зүүсэн арабууд дэин дэлхийгээр ххэрсээр Макондод ирээд лэсний бараа тотиор арилжин байсаар мянган жилийн хэрмэл байжаа гэж хамгийн залгисан хар хавсарганы дараа мэдвэл мэдэж болох байлаа . Хотыг анх байгуулах үеэр Хосе Аркадио Буэндиагийн шинжилж , хожим нь гадилын тариалан цээглэж байсан илбэдүүлсэн газар одоо цул намаг болж, дотор нь өмрхөрсөн модын ёзоор ёрдойж , ил болсон тэнгэрийн хаяанаа хэдэн жилийн турш далай чимээгүйхэн хөөсрөн байж билээ . Бага Аурелиано эхний ням гаригт хуурай хувцас өмсөөд , хот юу болсныг харах гэж гарахдаа хртхийн цочжээ . Бороонд тэсэж үлдсэн хүмүс нарны бараа харайхиж харан баярлан суугааг үзвэл цөм гадилын дайрлага дайрахаас өмнө Макондод суурьшигшад байлаа . Арьс нь замаг шиг ногоовтор хэвээрээ , борооны жилд агуулахын үнэр орсон нь сайн гараагүй байсан боловч төрсөн хотынхоо эзэд дахиад боллоо гэж бодохооё баярын мишээл нүүрэнд нь тодорчээ . Туркийн сайхан гудамж дахин урьдынх шигээ боллоо . Зуузайгүй шаахай угаласан , зузаан металл ээмэг зүүсэн арабууд дэин дэлхийгээр ххэрсээр Макондод ирээд лэсний бараа тотиор арилжин байсаар мянган жилийн хэрмэл амьдарлаа орхин найдвартай хоргодох оронтой болсон билээ . Борооны үед үүргийн хайрцаг дээр дэлгэсэн бараа, тутран унаж, хаалган дотор тавьсан бараа хөгцөрч , лангуу тавиур морин шоргоолжинд идүүлж , хана туурганад чийгэнд цохиулсан байхрад гурав дахь үеийн арабууд элэнц хуланц , өвөг эцуэг нар нь шигээ дуугардаггүй , догдолж сандардаггүй , цагийн урсгалд далидардаггүй ,б айгадийн гамшигт ч дийлэгдэхгүй , нойр хулжих өвчин дайрсны дараагаар ч хурандаа Аурцлианл Буэндиагийн гучин гурван пайсан сүүлээр ч амьд байсан шигээ, магадгүй үхсэн байсан шигээ нөгөө л байрандаа , нөгөө л янзаараа сууцгааж байлаа . Тоглоомын ширээ, шарсан махны ширээний эвдэрхий ,б ай буудах газрын үдэнхий , зүүдний учир тайлж , хойичний явдлыг мэргэлэдэг басан

гудамжны нуранхай дунд арабууд санаа сэтгэлээр унаагүй байгаад Бага Аурелиано гайхахын ихээр гайхаж, мөнөөхөн эрээгүй зангаараа “Шуурганы үеэр ямар далдын хүч урьсныг хүчинд живэлгүй гарав, чөтгөр алгад гэж, яаж усанд цацаж үхэлгүй үлдэв?” гэж тэндээс асууж, айл айлаас очиж шалгаахад цаадуул нь хаа нь л бол хаана цөмөөрөө л зальтайхан инээмсэглэж, цөмөөрөө л санаашрангүй ширтэж, цөмөөрөө л :

-Бид хөвж явсны хүчинд л гарлаа гэ нэг л хариу хэлж байлаа .

Хотын бусад бүх улсын дотроос ганц Петра Котес л арабууд шиг зүрхтэй байжээ . харсаар байтал нь үхрийн хороо, адууны жишчээний хана нурж байсан боловч сэтгэлээр унасангүй гэр дотрохио цэвэр цэмцгэр байлгаж байлаа . Сүүлийн жил Бага Аурелианог ир гэж удаа дараа зурвас явуулсан боловч “хэзээ тэднийд эргэж очихыг хэлж өөрөө смэдэхгүй байна, гэвч хэзээ ч очлоо гэсэн хүүдий дүүрэн алт авч очоод унтлагын өрөөнд дэвсээд өгнө” гэж хариулж байлаа . Петра Котес , гашуун төөргөө давахд нь туслах хүч эрн сэтгэлээ шинжээд , тэндээс хорсол, байдаг хүнийхээ үрсэн, , бороо хурын сйүтгэсэн хөрөнгийг дахин сэргээнэ гэж ам тангараг тавьжээ . Ингэж сэтгэл шулууджээ . Бага Аурелианог сүүлийн зурвасыг авснаас хойш, найман сар болоход ирэхэд царай нь зэвхийрч , үс нь сэгсийжэ , арьс нь хамуунд идүүлчихсэн эзэштэй тасархай тасрахай цаасан дээр тоо бичин, сугалааны билет хийх гэж оролдож байжээ . Бага Аурелиано гэж тув туранхай , тун ёсорхуу юм өмнө н мэл гайхаж , дуугүй зогссонд насан туршаа дэр нийлүүлсэн хайртай хүнээ биш, ихрийн өрөөсөнг нь харж байгаа мэт Петра Котест санагджээ .

-Чи чинь галзуурав уу? Чи юу хожих гээ вэ? яс уу? гэж Бага Аурелиано асуужээ .

Тэгэхэд Петро Котес түүнийг унтлагынхаа өрөөг шагайж үз гэсэнд , үзвэл тэнд луус нь байжээ. Луус нь эзэн авгай шигээ арьс яс болсон байсан ч эзэн авгай шигээ шийдэмгий , эрэмгий ажээ . Петро Котес түүнийг хорслоор тэтгэж, өвс ч үгүй, эрдэнэ шиш ч үгүй, төмс ч үгүй болоход унтлагынхаа өрөөнд оуулж , перкаль даавуу, перс хивс, ямаан хилэн хөнжил, хамба хилэн хөшиг , альан саа хамгамаллаж , торгон цацаг унжуулсан хамба ламынг олрны бүтээлгээр тэжээсэн ажээ .

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Урсула бороо зогсонгуут үхэн гэж хэлсэндээ хүрэх гэж ихээхэн чармайх хэрэг гарав. Борооны үед ухаан бараг орохгүй байсан бол наймдугаар сараас халуун салхи үлээж , сарнайн бутыг хатааж , бүх балгдыг чулуу болгож, Макондогийн зуун наст бүйлсний сод байшингийн зэвэрсэн дээврийг хаоуун тоосоор үүрд лдарснаас хойш үе үе ухаан нь саруулсах болов. Урсула гурван жил хүүхдийн наадам болж байснаа мэдээд өөрийгөө өрөвдөн уйлжээ . тэрбээр нүүрнийхээ үаврыг угааж, биеэнр нь дүүрэн зүүсэн эрээн даавауу, хатсан гүрүвэл , бах, эрих, сувсыг авч хаяад Амарантаг үхсэнээс хойш анх удаа орноосоо өөрөө,ө бусдын дэмгүйгээр , гэрийнхээ амьдралд оролцоход бэлхэн босож ирлээ . мохошгүй зүрхээрээ пад харанхуй зүгээ олж байлаа . Эмгэний итгэлгүйхэн хөдөлж

байгааг анзаарч, толгойн тус газраа архангель богд шиг өргөсөн тэнхэлгүй болсныг нв өрөвдөхөөс биш ердөө юм харахаа больсон гэж огт санахгүй байлаа . Гэвч Урсула нүдгүй боловч байшингаа анх өргөтгөхөөс эхлээд хичээнгүйлэн тордож байсан цэцгийн мандал нь усанд урсан, Бага Аурелианод ухуулсан байшингийнхнаа нь хана туурга цуурч хагарсан , тавилга юм нь ганхаж холхисон гандаж онгосон , хаалга цонх нь нугаснаасаа салж, унасан гэрт нь урьд байгаагүйгээр уруу хүлэцэнгүй , уй гашуутай болсон годгийг харж байлаа . Ханхай хоосон унтлагын өрөөгөр тэмтэйн явж дотуур нь хувцасын шүүгннд хвэн хорхой байнга бужигнан , мод мэрж байгааг шоргоолжны зогсолтгүй шажигнах , борооны хэдэн жилд үржсэн асар том улаан жрогоолж байшингийн суурь хөндийлөн шижигнэхийг сонсож байлаа . нэг уда хувцас хунар хийсэн авдрынхаа тагийг мсөхвөл өөдөөс нь бараг бүх юмыг нь идчихсэн жоом бөөн бөөнөөрөө гүйлдэн гарч ирсэн тул санта Софи дела Пьедадыг дуудах хэрэг гарч билээ .

“Харах эзэнгүй юм шиг ингэж байж яаж болох вэ . Энэ амьтанд сүүлдээ биднийг ч барих болно ” гэж хэлжээ . Үүнээс хойш Урсула бори бохисхийхийг болив. Хар нүд хуу татаад л бүх улсыг , тэр ч байтугай хүүхдийг дуудаж, бүтэн үлдсэн хувас, хэрэглэж болохоор цагаан хэрэглэл наранд эврээхээр блгөж, элдэв хор цацан жоом хөөж , хаалга цонхны жаазанд морин шоргоолжны гарсан нүхийг бөглөж, түүхий шохоогоор шоргоолжийг нүэхнэд нь алаа . хамгийг сэргээх гэж дотнохоо онхи мартагдсан өрөөнд ч хүрч , Хосе Аркадио Бууэндиагийн эрдэнийн рилуу шамдан эрж тархиа гашилгаж байсан өрөөний хог, аалзны шүлсийг цэвэрлэж , цэргүүдийн хол толгойг нь алдуулсан урланг янзалж, хамгийн сүүлд Мелькиадесийн өрөө ямар янзтай байгааг үэх гэж түлхүүрийг нь авах гэлээ . Өөрийг нь үхлээ гэж яг мэдсэнээс хойш хэнийг ч бүү оруулаарай гэж Бага Хосе Аркадиагийн захисныг санта Софи дела Пьедад гүйцэтгэж, Урсулаг оруулахгүй санаатай элдвээр аргаж, худал хэлж үзсэн боловч эмгэн байшингийн хамгийн хүн хүрдэггүй мухарт шавьжийг устгахаар хатуу шимйдэн зүтгээп , Санта Софи дела Пьедадын арга саамыг даван, гурван өдрин дараа сайхь өрөөг онгойлож дөнгөв. хаалгыг нээхэд үмхий самхай ханх тавин, Урсула золтой л ухаан алдсангүй , хаалганы энгэсэгнээс зуурч тогтохдоо энэ тасалгаанд Мемегийн сургуулийн найз охидод авсан далайн хоёр хөтөвч байдаг, мөнхүү бороо эхэлж байх нэг шөнө цэргүүд гэрийг нь туушид нь нэгжин Бага Хосе Аркадио эрээд олоогүйг санажээ .

-Тэнгэр минь! Чамайг замбараатай болгох гэж хэчээн махаа идлээ, гэтэл чи энд гахай шиг балиартаад сууж байдаг хэмээн яг л нүдээрээ харж байгаа вч шиг хэлжээ .

Бага хосе Аркадио эртний бичгийн учрыг олсоор л суужээ . Нүүрийг нь халхлан унжсан адууны дэл шиг ширэлдсэн үсэн дундаас ногоон хөгс суусан шүд, гөлийсөн нүд л харагдана. Элэнц эхийнхээ дууг таниад толгойгоо үүд рүүгээ эргүүлж , инээмсэглэж аядвсанаа , Урсулагийн эрт урьд хэлж байсан үгийг өөрөө мэдэлгүй давтан.

\*-Та юу гэ бодоо вэ? Цаг ч талийж одож шүү дээ гэжээ .

-Тийм нь ч тийм , гэхдээ л ...

Хурандаа Аурешлиано Буэндиа цаазлуулах ялтны өрөөнд б айхдаа өөрт нь яг ингэж хариулж байсныш Урсула санаад, өөрийнх нь сүүлийн үед болох болсон шиг цаг яваад өнгөрдөггүй, хариун дугуй тойргоор явж байгаа юм шиг эргэж буцаад байдаг юм байна гэж бодохдоо цочисхийжээ. гэвч Урсула энэ удаа ч бууж өгсөнгүй. Бага хосе Аркадиоог нялх хүүхэд аятай зад загнаж, нүүр гарыг нь угаалгаж сахал самбаагийн нь авахуулж, гэрээөөд татахад нь хамжилц гэжээ. Биеэ сай дураараа хорьсэн тэр хүн явж явж яс амар, сэтгэл тайван байх болсноо өрөөнөөсөө гарна гэхээс хиртхийн айжээ. “Эндээс намайг хэнбугай нь ч гаргахгүй, хүр ачсан хоёр зуун вогоон орой бүр Макондогоос далай руу чвж байсан харж чадахгүй. Өртөөн дээр байсан гурван мянга дөрвөн зуун найман хүн бүгд тэгд байгаа” гэж бархирч гарав. Хосе Аркалиог өөрийнх нь төөрөн будилж яваа харанхуй ертөнцөөс ч илүү пад харанхуйд төөрч, элэнц эцгийнх шигээ түгжигдмэл, ганцаардмал ертөнцөд орсныг Урсула сая л ойлгожээ. тэгээд Бага Хосе Аркадиоог зоргоор нь орхисон боловч хаалганд нь өлгөөтэй цоожийг авч, өдөр бүр өрөөг нь цэвэрлэж, хөтөвчнөөс нэгийг л үлдээгээд бусдыг нв хаяж, элэнц зугийг нь туулайн бөөр өчнөө жил байлгасны адил тэр алагчийг цэвэр замбараатай байлга угэж айлджээ. Эхлээд Цернанда эмгэнийг зөнөчихөөд ингэж хөдөлж байна гэж бодоод дургүй нь байгаагаа арайл ил гаргаж чадахгүй больж байв. гэтэл Ромоос хосе Аркадиоог явуулсан захидал нь энэ үеэр ирж тарсныг үзвэл насны сахил хүртэхийн урьдтай макондогоор орох бодолтой байгаагаа бичсэн байлаа. Фернандо энэ сайхан сураг дуулаад магнай тэнийж, өөрөө өглөөнөөс үдэш болтол гэрээ янзалж, цэцгээ өдөрт дөрөв усалж, хүүгээ ирэхэд төрсөн гэрийг нь аль болохоор өнгөтэй өөдтэй байлгах гэж зүтгэв. Тэрбээр үл үзэгдэгч оточ нартай дахин захидлаар харилцах болж, савтай ойм, халуун, хайтан цэцэг тэргүүтнийг Бага Аурелиано уурын мунхагаар бүгдийг нь устгасан гэж урсулаг мэдэхээс бүр өмнө гонхонд дахин тавьжээ. дараа нь Фернандо хоолныб мөнгөн хэрэглэлээ зараад шавар сав, цайран таваг, шанага, цайран хэрэглэл худалдаж авснаас хойш хоёр Энэтхэгийн комданийн шаазан сав бог емийн болор хадгалж байсан ханы шүүгээ нь тун хөөхийлөлтэй харагдах болжээ. Гэвч Урсула энэ нь дутуу санагдаж байв. “Цонх хаалгаа нээ. Мах, загас шар, хамгийн итом яст мэлхий худалдаж ав, гадаадынхан ирж л байг, ор дэвсгэрээ хаана ч хамаагүй засаа лб айг, сарнай дээрээс шээж л байг. гэдэснийхээ хэрээр чихэж л байг, хэхэрч л байг, чөөлчиж л байг, мангар том гутлаа тайлалгүй тасалгаагаар тэнэж л байг, шавар шавхай чирч л байг, тэд санаандаа орсон болгоныг хийж байг, тэгж л гэмэ нь л бид сүйрэхгүй байж чадна” гэж хашгирч байлаа. Гэвч Урсула бүтэшгүй юманд санаархжээ. тэр даанч хөгширч, хорвоогийн тоосыг даанч удаан хөдөлгөж, мөсөн чихэр хийж а худалдаж байсан үеийнх шигээ гялалзуулж чадахаа нэгэнт больж үр сад нь түүний амьдрахын хүчийг авч төрсөнгүй. Фернандо загнаад хаалгыг нээлгэхгүй байлаа. Петра Котесийнх руу авдраа дахин чирч очсон Бага Аурелианогийн олж байгаа мөнгөөр гэрийнхэн нь мөчиг тачигнах аамь зуух болов. Илжгээ сугалаанд тавьж хожсон мөнгөөр Бага Аурелиано Петра Котес хоёр шинэ мал худалдаж аваад, сугалааны бүдүүлэгдүүхэн ажил эрхлэх болов. Бага Аурелиано тасархай цаасаа сонирхон татахаар үнэмшилтэй болго



х гэж айл айлаар явдаг байлаа олон  
ч түүний сугалааг баярлаж авахнаасаа өрөвдөөд авч байгааг  
ажигладаггүй бололтой байв. гэвч хамгийн өрөвч худалдан авагч ч гэсэн  
хорин мөнгөөр гахай, гучин хоёр мөнөөр тугал авчихаж гэж горьдохгүй яах  
вэ. тэд тэгж грьдсондоо мягмар  
гаригийн орой Петр Котесийн хашаанд бөөгнөрөн цуглаж, аз мэдэг гэж  
сонгож авсан жаал рүү хэдийд азтай дугаарыг татан гаргаж ирэх бол хэмээн хүлээн  
зогсдог байлаа . тэгж цугларсаар сүүлдээ доло хоногийн яармаг гаргах болж,  
үдэш болмогц ширээн дээх жигнэсэн мах дэлгэж , лангуун дээр ундаа өрж, аз  
дайрсан хүн нэгнийхээ хөгжимчин урьж, архи гаргах юм  
бол хожсон малаа нийтийн тогоонд нийлүүлж , ийнхүү Бага Аурелиано өөрийн эрхгүй  
дахин найраг баян хуураа барьж , хэнхгүүдийн даруухан  
тэмцээнд дахин оролцох болров. Урьдын ахотод баясгалантай найрыг бодьол өрөвдөл  
тэй энэ цэнгээнд оролцох болсон Бага Аурелиано гол хөгжөөгч ,  
бүжигч байсан үеийн нь эрч хүч , юмыг бодож смэтгэх их чадвар  
алга болсныг ойлгожээ . тийм ээ, тэр өөр болж Мэгжтэй үзэлцэж байх үед зуун хорин  
кл татаж байсан бол одоо жин нь далан найм болтлоо хасагджээ . Архинд  
бэлцийн хөөгөөд яст мэлхий шамшгар хоншоор шиг болсон цайлгандуу царай  
нь барайжээ . Гүрвэлийн хоншоортой илүү адил  
Хношоортой илүү адил болжээ . Энэ царайнаас  
сэтгэлээр унаж, сульдаж ядарсаан байдал үл сална. Нгэвч  
Петра Котес Бага Аурелианод хэзээ ч одоогийнх шиг ийм хайртай байсангүй  
. Түүнийг өрөвдөж байгаагаа, хоёул хоосон ядуу боллоо шүү дээ гэж бодсоноо ч хайр  
гэж андуурсан баж болох юм . Ганхаж хоцорсон хуучин индрэн оро  
ндээрээ урьд загас наадуулж бөайдаг байсан бол одоо аминчлан ярилцан суудаг  
болов. Тэдний хөдлөх бүрийг давтдаг байсан толио зараад, сугалааны хонжворт тави  
х мал худалдаж авчээ . Хуял  
хөдөлгөдөг перкааль даавуу, хилэн хөжлийг нь луус хивчихсэн учир  
одоо урьдын нууц амрагуд нойрноос гарсан хоёр хөгшин бадлаар шөнө  
дөл болтол сэрүүн сууж, тамираа баран оволзож байсан цагаараа олсон  
мөнгө тоолж байдаг болов. заримдаа эхний тахиа дуугартал  
сууж мөнгөө хуваан, үүнийг Фернандо ,  
түүнийг Амаранта Урсулад шагайвч авахад, үүнийг замбараа алдсан үеэс  
хойш плаажая солиогүй санта Софи дела Пьедад , түүнийг Урсулаг үхвэл авс авахад ,  
үүнийг гурван сар болоод л фунт нь  
нэг сентаворгор нэмэгдэж байгаа кофе авахад, түүнийг өдөр бүр  
амт муухай болж байгаа ёотон авахад үүнийг борооны үеэс хойш хатаагүй байгаа т  
үлээ, тэрүүнийг сугалааны билет хийх  
цаас, өнгийн бэх авахад, бүх билет худалдчихаад байтал тугал боомтож арьсыг  
нь азаар бүтэн авсан учир үүнийг дөрөвдүгээр сарын  
сугалааны билетийг үнэнд буцааж өгөхөд гэх зэргээр мөнгө зоосоо хэдэн  
хэсэш бөөгнуулан хуваана. Тэд өглөгийг хармын сэтгэлгүй хувааж, хамгийн сайнаа  
л Фернандод барьдаг , гэмшиж, зовдогтоо ч биш , нигүүлсэх сэтгэлтэйдээ ч  
биш, Фернандог аятайхан сайхан байлгавал өөрсдөө хамаагүй гэж боддогтоо рэгдэг  
байлаа . Үнэнийг хэлэхэд, хоёулаа охинтой болхон гэж  
хэчнээн хүсэвч үрийн хутгаггүй байсандаа Фернандог тэр заяагаагүй охиноо

гэж боддог байжээ . Фернандод голланп даавуун бүтээлэг авч өгөх гэж гурав хоног дэан эрдэнэ шишийн бэрээсээ идэж ч байлаа . гэвч тэр хоёр ядаж ч үхэн хатан зүтгэлээ гээд, хэчнээн, мөнгө оллоо гээд, ямар ч нарийн арга сэдлээ гээд нэмэргүй , амь зуухад хүргэх гэж хуруу хумсаа тайрсаар байтал ивээгч тэнгэр нь хүлээж чадалгүй унтаж хоцордог байдаа . мөнгө хүрнэ гэж ер бахгүй, нойро хулжаан зовж, энэ орчлон чинь юу болов, яагаад мал урьдынх шигээ үржихээ болив, я агаад мөнгө зарж амжаагүй байхад л ханшгүй болж байна , багц мөнгө бодох юмгүй шатаад кумбиамба<sup>1</sup> бүжиж байсан хүмүүс одоо “зургаан тахианы хонжвортой сугалаанд орж арван хоёр муу сентаво төлөөч” гэж гуйхад “Гэгээн цагаа өдөр дээрэм хийлээ” гэж яагаад хашгирч байна гэж доор доороо бодолхийлдэг байлаа . Бүтлийн бүрээ хазайсны учир нь хүрээлэн байгаа ертөнцөд байгаа бус, Петра Котесийн битүүлэг зүрхний нууцлагдсан буланд л байна, үерийн үеэр тэнд л нэг юм хөдөлж, түүнээс болоод мал төлөхөө болилоо, мөнгө тэгрэг гарын салаагаар ус шиг алдагдах боллоо гэж Бага Аурелиано боддог боловч ил гаргаж хэлдэггүй байлаа . Энэ нууцыг нь мэдэх санаатай дурлалт хүүхнийхээ сэтгэлийг лав өнгийн харж, ашиг хонжоо эрсэн биш хайр сэтгэлийг олж , хохмой сэтгэлээр Петра Котесийн тачаалыг хөдөлгөх гэсэн биш өөрөө түүнд дурлалчихлаа . Петра Котес болохоор Бага Аурелиано өөрийг нь улам энхрийлэн хайрлаж байгааг мэдэх тусам түүнд улам янаг хайртай болж , насныхаа намар ирсэн хойно “Ядуу хүн хайрлаж чаддаг” гэсэн зүйр үгэнд хүүхэд шиг гэнэхэн итгэх болжээ . Одо тэр хоёр далай шиг бялхасан найр хийн галзуурч , багтаж, ядсан эд хөрөнгөөр туйлж хэрээс хэтэрхий ужид самуун ашилж байснаа ичих, харамсах хослуулан дурсаж , даанч их үнээр хоёулаа ганаардахын диваажинг олж авлаа гэж гэмшдэг байлаа . Өчнөөн жил үр хүүхэдтэй бололгүй нууцаар ханилсаны дараа бие биендээ халуун хайртай болсон тэр хоёр хоолныб ширээний ард орон дээрхээс илүү бие биеэ хайрлаж болно гэдгийг мэдээд мэдэхийн аргагүй юм ид шидээр нээж олсон юм шиг баясаж , хэчнээн ядарч сульдэн нас ахисан боловч чандага шиг цовхчиж , нохой шиг хэмхэлдэн жаргах болжээ . Сугалаанаас олдог мөнгө арвижахгүй байлаа . Эхний үед Бага Аурелиано малын худалдаачин байх үеийн хуучин контороо долоо хоногт гурван удаа түгжиж аваад сугалаанд ямар хонжвор байгааг харгалзан улаан үнээ, ногоон гах ай буюу хэдэн цэнхэр тахиаг нэлээд төсөөтэй зуран Петра Котесийн ажлаа нэрлэсээ р “Эзэн тэнгэрийн сугалаа” гэж хичнээгүйлэн дармалдан бичдэг байжээ . заримдаа долоо хоногт хоёр мянган гаруй сугалаа зурах тул сүүлдээ бүр ядарч , сугалааны нэр , амьтны дүрс , дугаар бүхий тамга захиалжээ . түүнээс хой, өнгийн бэхэнд тамгаа хүргээлд л дарах ажилтай болжээ . Бага Аурелиано үхэхийнхээ өмнө хэдэн жилийн сугалааныхаа дугаарыгбг оньсгоор сольж, хонжворыг оньсого таасан хүнтэй хуваах бодол төрсөн боловч энэ нь тун төвөгтүйн дээр амьтан хүн элдвээр сэжиглэн тул тэгэх гэж хоёр үзээд аргагүйн больжээ

үрийн гэгээнээс үдшийн б бүрий болтол Бага  
Аурелианл сугалаагаа нэр хүндтэй болгох гэж хөөцөлдөх тул хүүхдээ эргэх  
зав араайхийж гаргадаг ыбайлаа . Фернанда жилд зургаахан эмэгтэй хүүхэд авдаг  
хувийн сургуульд Амаранта Урсулаг оруулсан  
боловч жаахан Аурелианог хотын сургуульд орохыг зөвшөөрөсөнгүй . Түүнийг гэр  
дотуур ёчөлөөтэй явуулж байгааг хамгийн их юм гэж бодож байлаа . Үүний  
дээр сургууль, каталок ёсоор гэрлэсэн эх эцэг хоёроос төрсөн хууль ёсны  
хүүхэд авдаг байв. Аурелианог хийж ирсэн сагнаас угжтай хамт уясан төрсний  
гэрчилгээний хүүхдийг “орхидос” гэж бичсэн байлаа . Тийнхүү Аурелиано Санта Софи  
дела Пьедад ба (ухаан саруусах үед нь)  
Урсула хоёрын асрамжинд цоожтой сууж хоёр эмгэний  
яриаг сонсож, гэрийн дөрвөн ханаар хязгаарлагдсан явцуу ертөнцийг ухаарч байлаа .  
Тэрбээр эелдэг ихэрхүү хүүхэд болж, юмны учрыг байнга шалгаан томчуулыг  
уцаарлуулдаг боловч , тэр насандаа далдыг хардаг билгийн нүдгүй , харин  
ч хайнгадуу хардаг, тэр ч байтугай байн байн анивчадгаараа хурандаагаас өөр байлаа  
 . Амаранта Урсулаг сургаальд сурч байхад Ауршелиано цэцүүлэгт өгт ухаж ,  
хорхой тамладаг байлаа . нэг удаа хайрцагт хорхой дүүргээд Урсулагийн оронд хаях  
гшэж байхад нь Фернанда барьж аваад АМмегийн унтлагын өрөөнд цоожилсинад ,  
уйдахдаа нэвтэрхий толийн зураг үзэж суутал  
нь Урсула багц халгай барьчихсан өрөөгөөр тэнэж, ханыг цэвэр усаар цавдан яваад  
түнийг мөргөчихөв. Жаал хүүтэй олон даралдсан ч гэлээ хэн болохыг нь асуужээ .  
-Би Аурелианл Буэндиа байна гэж цаадах нь хэлжээ .  
-Тийм байна . Чи уран вархбн ажил хийх нас чинь болжээ гэж Урсула хариулжээ .  
Түүнийг дахиад хүүгээ гэж андуурч , борооны дараа үлээх болсон халун салхи дөнгөж  
намдмагц Урсулагийн хаан түр зуур саруулссанаа дахин балартах боллоо . Өрөөндөө  
орохд н Петронила игуаран өргөн банзал өмсөж ,  
дээдсийн хүрээлэнд бараалаха үедээ нөмөрдөг өлбөн халдсан том алчуураа нөмөрчих  
сөн сууж, саа туссан транкилина  
Мари Миниата Алакоке Буэндиа тогосын Транкилина мари Миниата  
Алакоке Буэндиа тосгоны өдөн дэбүүрээр дэвьэн, ганхуур сандал дээр сууж ,  
Урсулагийн элэнц эцэг  
хаанб торгон цэргийн дүрэмт хувцастай Аурелиано Аркадио. Буэндиа ,  
уншингуут солнын авгалдайн үхрээс унаад үхчихдэг тарни зохиосон түүний  
эцэг Аурелианл игуаран, сүсэг ихтэй ээж , гахай сүүлтэй төрсөн үеэл  
ах нь Хосе Аркадио Буэндиа , талийгаач хүүхдүүд нь цөмөөрөө цуглачихсан ,  
ханын дутуу тавьсан сандал дээр зочилж ирээгүй, хойдын буян үйлдэн сахих  
гэж ирсэн юм шиг сууж байдаг байлаа . Тэрбээр тэдэнтэй урамтай гэгч  
нь хөөрөлдөж орон , цагийн ямар ч холбоогүй үйл явдлын тухай өгүүлж , сургуулиас  
ирсэн Амаранта Урсула , нэвтэрхий толиос уйдсан Аурелианл хоёрыг унтлагын  
өрөөнд ороход орон дээрээ суучихсан ганцаараа дүнгэр дүнгэр ярьж ,  
урьдын явдлаа эн тэнл нь оруулан дурсаж байлаа . нэг удаа гэнэт “Гал гарлаа” гэж  
аймаар муухай чарлаж, гэрийнхээ барьц алдуулсан бөгөөд угтаа бол  
дөрвөн настай байхдаа агтны жүчээ шатахын харснаа санасан байжээ .  
Тэрбээр үхэхийнхээ өмнө хоёр гурван удаа ухаан түр цэлмэснээсээ бусад бүх  
цагт өнгөрснийг одоотой холин будилж тухайн үедээ мэдэрч байсан юмаа ярьж байна  
уу, эсвэл урьдын юмаа дурсаж байна уу гэдэг нь огт мэдэгдэхгүй байлаа . Урсула амьд

байхдаа л борц аятай хатангиршиж , үхэхийн өмнөхөн хнэдэн сар бие нь шөнийн хувцсанд ороод олдохгүй болсон үрчгэр хар чавга шиг, дандаа сарвайж явдаг гарт нь бичний савар шиг болжээ . Урсула хэдэн өдрөөр огт хөдөлөхгүй болчих тул Санта Софи дела Пьедад амьд байна уу гэж сэгсчиж үзэн , өвдөг дээрээ суулгаад чихэртэй ус уу гэж халбагдаж өгдөг байлаа . Урсула нялх хүүхэд шиг болж. Амаранта Урсула , Аурелиано хоёр унтлагын өрөөн длотуур өргөн явж, жаал Христосоос хэр үэрэг томыг нь үзэх гэж шүтээн дээр тавьж нэг орой агуулахын шүүгээнд н нуучихсан нь эгээ л харханд идүүлчихсэнгүй гарчээ. Бургаасын ням гаригт<sup>1</sup> Фернандаг

хурал хурахыг сонсож байх

хооронд хоёул унтдлагын өрөөнд орж Урсулаг толгой, шилбэнээс нь татаж ,

-Хөөхрий хуланц ээж минь үхлээ дээ гэж Амаранта Урсула хэлжээ .

Урсула давхийж

-Би амьд байна гэжээ .

-Харахгүй юу , амьсгалахгүй байна гэж Амаранта Урсула инээд барьж ядан хэлэв.

-Би ярьж байна шүү! гэж Урсула хашгирав.

-Ярихгүй л бана шүү дээ . Хүрэлзгэнэ шиг үхчихсэн гэж Аурелиано хэлэв.

Тэгэхэд нь Урсула аргагүйн үнэнд гүйцэндэж “Тэнгэр минь ! Үхэх гэдэг энэ юм байлгүй” гэж аярахан дуу алджээ . Тэрбээр ямар ч холбоогшүй , урт уншлага хоёр өдөр аялгуулан уншиж , мягмар гаригт тэнгэр бурхныг нэг дуудах, “Улаан шоргоолжийг хядахгүй бол байшин нурж унана”, “Ремедиосын зургийн өмнөх зулыг бүү бөхөөгөөрэй”, “Нэг ч Буэндиа хамаатнаасаа эхнэр авч болохгүй, тэгвэл гахай сүүлттэй хүүхэд төрнө” гэж гэрээсээ нэг айлдах зэргээр үг солиото болж ирлээ . Бага Аурелиано түүний дэмийрч байгааг далимдуулан алт хаана булсныг нь хэлүүлээд авах гэж үзсэн боловч санасны гарз болжээ .”Энэ нь ирэхэд тэнгээ бурхан овуныг нь нээгдүүлж , тэр өөрөө эрдэнэсийг олно” гэж Урсула хэлжээ . Тэр хэдэн өдөр, сарнай цэцгээс агийн үнэр гарч, тарвасан тавагнаас асгасан шошийн үр шалан дээр далайн одны яг зөв дүрс үүсгэж, нэг шөнө ягаан гэрэлтэй зээрэнцэг тэнгэрээс нисэж өнгөрсөн зэрэг үл ойлгогдох үзэгдэл байгальд ажиглагдсан учир Урсула хэзээ мөдгүй үхнэ гэж Санта Софе де ла Ньедад итгэж байлаа .

Тэрбээр зовлонг тэвчих долоо хоногийн пүрэв гаригт өглөө эрт амьсгал хураав. Гадилын компанийн үед Урсула хамаатан садаараа туслуулж байгаад нас сүүдэр хэд хүрснээ тогтоох гэж оролдон , зуун арван таваас доошгүй , зуун хорин хоёроос илүүгүй байна гэж тоолжээ . Аурелиано хийж

ирсэн сагснаас яльгүй томхон авсанд хийж оршуулав. Нутаглуулах ёслолд хүн цөөн ирсэн нь нэгтээгүүр оло нь Урсулаг мартаж, нөгөөтэйгүүр нохой гаслам халуун байсных ажэ . Үдээр сум шиг нисүүт ирж хана мөргөх буюу црхны төмөр ит торыг цоо татаап унтлагын өрөөнд үхэж байлаа .

Эхлээд шувууг тахаар үхэж байна уу гэж боджээ . Эзэгтэй нар үхсэн шувууг (“Ялангуяа үдийн амралтаар их үхэж байв” тасалгаанаас шүүрдэн тамаа цайж , шувууны хүүрийг бүтэн тэргээр аячин голд хийж байлаа . Христосын хүүрийг бүтэн тэргээр ачин голд хийж байлаа . Христосын саруул ням

гаригт нас сүүдэр зуу  
хүрсэн Антони Исабель лам шувууны тахлыг Хэрмэл Жүүд илгээсэн  
байна гэж сэнтийсэн айлджээ. Гэгээн ламхай урьд шөнө нь түүнийг өөрийн  
мэлмийгээр халиасан гэнэ. Тэрбээр  
түүнийг ухнатай нөгцсөн чаралба эхнэрийн зулбасга , тамын амьтан гэж ,  
амьсгалахад нь агаар улайсаж, үзэгдэхэд нь эмэгтэйчүүдийн хэвлийд а  
олдсон хүүхэд адгийн шаар болно гэж айлджээ . Дацангийн лам хөгшрөөд мунаж  
хоцорсон гэж хот нийтээрээ мэдэх тул галав юулна гэх нь холгүй тэр  
яриаг үнэмшэн хүн ховор. Гэвч лхавга гаригт өглөө  
эрт нэг эмэгтэй орь дуу тавин айлынхныгаа босгожээ . Хоёр хөлтэй , салаа  
туурайтай үл мэдэх амьтны мөр олсон юмсанжээ . мөр тов тодхон байсану чир ламын  
ярьсан мангас шиг амаар амьтны мөр байна гэж харсан бүхэн эргэлзэхгүй байлаа .  
Тэгээд айл ы болгон гадаанаа занга тавив. Хэсэг хугацаа өнгөрөхөд учир  
битүүлэг тэр амьтан баригджээ

. Урсулаг үхсэнээс хойш хоёр долоо хонож байтал шөнө дунд Бага Аурелиано ,  
Петра Котес хоёр, бухан бяруугаа мөөрөх шиг дотор арзасхийж уйлах  
дуу хажуугийн хашаанд гарахад сэржээ . юу болсны гарч  
харвал бөөн харцуул хуурай навчаар бүтээсэн нүхний ёроолд зоосон хурц  
үзүүртэй гадаснаас чөдрийг салгаж авч байв. Чөтгөр нэгэнт мөөрөхөө больсон байлаа .  
Арван хэдтэй хүүхдийн дайны биеээй боловч гунан бухын жинтэй  
түүний шархнаас нь наалданги ногоон цус шүүрэн байлаа . Бие  
нь хувалз шигдсэн бүдүн үсээр бүрхэгдэж , даг дайр болсон бөгөөд түүний зарим  
нь эрхтэн нь хүнийхтэй төсөөтэйгээр ламын үзсэн тамын амьтнаас ялгаатай байлаа .  
Тодруулан хэлбэл, алагдсан амьтан хүнтэй ч бас төсөөгүй ,  
эмгэгт баригдсан сахиулсантай төсөөтэй, цэвэрхэн , нарийхан гартай, асар  
том будангуйрсан нүдтэй, даландаа хоёр мухар  
эвэртэй нь түлээчинд сүхээр цавчуулсан бололтой хоёр хүчирхэг далины ор ажээ.  
Хүүрийг олонд үзүүлэх гэж буйлсийн модноос хөлөөр нь дүүжилж  
, бээж эхлэхтэй нь хамт түүдэг асаан шатааж орхив. Учир нь  
түүнийг усанд үйвэл зохих амьтан юм  
уу, оршуулбал зохилтой христос шашинтан юмуу гэдгийг таних аргагүй байлаа .  
Үнэхээр түүнээс болж шувуу үхэж бав уу  
гэдгийг мээж чадалгшй өнгөрөв. харин эрд шинээр гарсан нэг ч бүсгүй олоо  
нхүүхэд адгийн шаар байсангүй , дүүгэм халуун ч буурсангүй.

Жилийн эцсээр Ребека өөд  
болов. түүний үнэнч зарц Архенида эзэгтэйнхээ гурван эвдэж өгөөч  
гэж эрх баригчдаас гүйжээ . хаалгыг хэмхэн орвол үлдэнд халцран толгойтой Ребека  
өнчин орон дээрээ эмгэн хумс шиг эвхэрчихсэн , эрхий хуруугаа шмхчихсэн хэвтэж  
байлаа . Бага Аурелиано оршуулах ажлыг гардаж, байшинг нь засаад зарчих гэж  
санасан боловч эр  
ньв цаанаасаа засал авахаа нэгэнт өнгөрсөн байж, хана туургыг нь  
будаад тавихад будаг нь эргэн холцорч ховхроод , шалны  
нь завсар чижээд орхиход хогийн ургамад гарч ирээд, тулгуур модыг засааж янзалах  
ад дорхноо ороонго өвсөнд баригдан өмхрөөд болж өгсөнгүй \_

Бороо зогссон ы дараа макондогийн аж амьдрал иймэрхүү байдалтай байлаа  
. хөдөлж ядан үлбийсэн хүмүүс мартагч г гэдэг

өвчинд арчаагүй баригдаж, урьдын хүмүүс март  
мартсаар улсын ерөнхийлөгчийн элч Неерландпын гэрээний  
ойгоор хурандаа Аурелиано Буэндиагийн өчнөөн удаа цааргалаад аваагүй одонг заав  
ал гардуулах даалгавартайгаар Макондод ирж, баатруудын үр садыг хаа  
байгааг мэддэг хүнийг олох гэж оройжин тэнэхэд тэдэнд зааж  
өгч мэдэхээ больсон байж билээ . Бага Аурелианог одонг шижир атаар хийсэн  
гэж бодоод аван алдсан боловч зохисгүй хэрэг гэж Петра Котесийн хорьсонд ч ,  
ерөнхийлөгчийн төлөөлөгчийн найрал хөгжмийн хөлсөлж , гардуулах ёслол дээр хэлэх  
үгээ бэлдчихсэн байтал нь авахаас татгалзжээ . Яг  
энэ үеэр макондод Мелькиандесийн эрдмийг өвлөсөн сүүлчийн цыганууд ирж, хотыг  
орхигдож , хүн амьтан нь гадаад ертөнцөөс бүр тасарсныг үзээд, айл  
айлаар соронзот төмөр барин явж, “Вавилионы мэргэдийн сүүлийн үеийн бүтээл”  
хэмээн түүнийг тайлбарлаж , асар том галт шилээр нарны илчийг дахин  
хураасанд тавиур дээрээс төмпөн ховх , үсэрч тогоо соронзон гүр рүү  
татагдан давхиж байгааг мангайн харах ухаантан, цыган эмэгтэй хиймэл шүдээ  
амнаасаа аван байранд нь эргүүлэн хийж байгааг үзэх  
гэж тавин сентова төлөхөд бэлхэн сониуч амьтад мундахгүй байжээ  
. Хоосорсон өртөөн дээр хэдэн шар вогоон чирсэн сарампай галт  
тэрэг хувь хэртэй зогсох өгөөд урьдын хөл хөдөлгөөнөөс , ноён  
Брауны шилэн оройтон , ямбаны вогооноо зүүдэг зорчигч дүүрэн галт тэрэгнээс ,  
оройн турш өртөөн дээр дараа дараагаар ирдэг тус бүрдээ зуун хорин вогоонтой урт  
цуваанаас үлдсэн юм гэвэл энэ л байлаа . Шувууны  
хачин тахлын тухай, хэрмэл Жүүдийг гайд гаргасан тухай мэдээг газар  
дээр нь шалгахаар ирсэн шүүхийн түшмэлүүдэд Антанио Исабель ламыг  
хүүхэдтэй нуугдаж тоглож байхад нь тааралдаад, мэдээлсэнийг нь зөнөөд хий  
юм үзсэн байна гэж үзэн, ламыг галзуугийн эмнэлэгт хүргүүлжээ . хэдэн  
өдрийн дараа хотод шинэ үеийн загалмайтаны Аугусто Анхель лам ирлээ . Зориг зүрх  
гэж чулуу тэрбээр сүсэгтэн олны сүнсийг сэрүүн байлгах гэж янз  
бүрийн хонх өдөрт хэд хэд гардан дэлдэж, айл айлаар орон нойрмоглогчдыг сэрээн  
эргэл мөргөлд оч гэж яатгалаа . Гэвч жил болоогүй байхад Аугуста  
Анхель дийлдсэнээ арга буюу хүлэж, агаар, улайдан, тоосонд оршиж , хаа л  
бол шургалан , хэнийг л бол хөгшрөөх залуугийн эзэн, үйдийн шатаам халуун  
цаг үдийн хоолонд заавал өгдөг бөөрөнхий махан хуургаар эрхэм хутагт өөрийг  
нь нозооруулан унтуулдаг нойрын эзнийг давж чадахгүйгээ мэджээ .

Урсулаг үхсэн дараа, гэр орон нь дахин өөд нар харахыг больж шийдэмгий ,  
зоригтой бүсгүй Амаранта Урсула хүртэл түүнийг өөд татаж чадсангүй .  
Олоон жилийн хойно мухар сүжиггүй, хөгжил наргиантай , хоёр хөлөөрөө  
газарт бат гишгэсэн, орчин шүеийн хүүхэн болчихсон тэрбээр  
эвдэж сүйтгэх эзэнг айлган хөөх гэж хаалга цонхоо цэлийтэл нээн  
хаашаа цэцэрлэгээ тордон додомдож, гэгээн цагаан өдөр цалан дээгүүр гүйлдэх болсон  
улаан шоргоолжийг хядан устгаж , Буэндиагийн орон гэрийн зочломтгой байдал  
алга болсныг сэргээх гэж оролдоод, оролдсныг гарз болгожээ. Фернанда зожгорон суух  
дуртай басан нь Урсулагийн зуу наслахдаа зүтгэж бүтээх замд нь  
давагдашгүй боомт болжээ . Фернанда гангийн улаан салхи зогмоход хаалгаа  
нээгээгүйгээр барахгүй эцэг эх хоёрынхоо гэрээсийг даган өөрийгөө амьдаар  
нь оршуулах гэж цонхоор модоор загалмай болгон дарж

хадахыг тушаажээ. Үл үзэгдэх оточ нарын их л үгэ төлөн харилцаж байсан нь огт талаах өнгөрөв. олонтаа хойшлуулсаны эцэст Фернада товлосон өдөр цагт толгойгоо умар зүг харууланг , дан фагаан даау нөмрөн орон дээрээ хэвтлээ . шөнийн нэг цагт хүйтэн нойтон алчуур нүүрэн дээр нь тавьж байгааг мэлжээ . Түүнгийг сэрэхэд цонхоор нар тусаж , гэдсэн дээр нь цавинаас нь аваад өрцийн нь хүрсэн муухай дугуй сорви улайжээ . гэвч мэс заслын дараах зохих амралтын хугацаа дуусаагүй байтал Фернанда үл үдэгдэгч оточ нараас аягүй захидал авчээ. Тэр захидалд өгүүлсэн нь, зургаан цагийн турш нарийн шинжилгээ хийж үзэхэд удаа дараа тодорхой бичээд байсан шинж тэмдгийг үүсгэх дотоод ямар ч согог байхгүй байна гэжээ. Юмыг үнэнээр нь хэлдэггүй муу дантайгийнх нь гор дахин гарчээ. Алсаас мэс засал хийгчид сав нь шаарсныг л ганц олж, мэс засад хийлгүйгээр даруулгаар засаж болно гэсэн байла. Урам хугарсан Фернанда бүр нарийн талйбарлуулах гэсэн боловч үл үзэгдэх оточ нар түүний захианы хариуг ирүүлсэнгүй. “Даруулга” гэсэн үгийг ойлгохгүйдээ ихэд гутарсан тэрбээр ичихээ болиод франц эмчээс асуух гэсэн боловч тэр эмч гурван сарын өмнө саравчны шувуун нуруунаас боож үхээд, ард олны дургүйцсээр батйал дайны нэг зүтгэлтэн, хурандаа Аурелиано Буэндиагийн зэвсэг нэгт хуучин анд түүнийг оршуулгын газар нутаглуулсныг мэдэв. Тэгэхэд нь Фернанда хүү Хосе Аркадиодоо итгэн бичиж, хүү нь Ромоос хэд хэдэн даруулгыг яаж хэрэглэдэг зааврын хамт явуулсан байлаа. Фернанда зааврыг цээжлээд, өвчнийхээ шиэжийг мэдэгдүүлэхгүй гэж зааврыг жорлонд хийжээ. Ингэж болгоомжлох нь илүүц байсан бөгөөд учир нь гэрт үлдсэн хэд Фернадаг ер хайрхахаа больсон байлаа. Санта Софи де ла Пьедад хөгшран тэрүүхэндээ л төвхнөж, гэрийнхэнд тарчигхан хоол хийж өгөөд бусад цагт тнь Бага Хос? Аркадио л харж хандаж байх болов. Сайхан Ремедиосын гоо үзэсгэлэнг зарим талаар дуурайсан Амаранта Урсула, Урсулаг зовоож цагаа үрдэг байснаа одоо хийчээл хийж цагийг өнгөрөөх болжээ. Охии нь хосгүй ухаантайн шинж бүрдэж, туйлын нягт хичээнгүй байдал тодорсонд аав нь урьд Мемег тийм болох нь гэж найдаж байсан шигээ түүнд дотроо найдлага тавих боллоо. Тэрбээр бүр гадилын компанийн үед тогтсон үаншлаар түүнийг Брюссельд явуулж боловсролыг нь гүйцээнэ гэж амлаад ингэж мөрөөдөхдөө үерт сүйрсэн газрын дахин ашиглах гэж оролдсон авай. Яваандаа Фернанда бүр хөрөөд хүний хүн шиг болж байсан учир Бага Аурелиано гэрийн бараа ховорхон харж, Амаранта Урсулагаа л гэж хааяа үзэгддэг байлаа. Фернанда хөгшрөхдөө сэтгэл зөөлөрч ад шоо үзсэн ачийг нь олны дунд оруулах байх, тэнд түүний уг гарлыг ухаж төнхөх хэн байх вэ гэж Бага Аурелиано итгэж байлаа. Гэвч Ауреоиано ганц биеэр зожгорон суухыг эрхэмлээд гэрийнхээ босгоноос цаашихыг таньж мэдэх гэж өчүүхэн ч хүсэхгүй байдаг шиг болов. Мелькиадесийн өрөөг Урсулагийн онгойлгосноос хойш Аурелиано хаалган тушаа нь эргэлдэж, завсраар нь шагайх болж, нэг л мэдэхэд Бага Хосе Аркапио тэр хоёр бие биеийг найршааж нөхөрлөж амжсан байлаа. Бага Аурелиано тэр хоёрын нөхөрлөх болсныг олон долоо хоногийн хойно, өртөөнд болсон цуст яргаллын тухай жаал хүүгийн ярихад л сая мэджээ. Надилын компани Макондроогоос явсан нь хэрэггүй юм боллоо, түүнийг явснаас хойш л хот мөхөх зам руугаа орлоо гэж нэг нь харамстал жаахан Аурелиано түүнтэй маргаж хэлэх гэсэнээ хэлчихэж чаддаг цээнд хүрсэн хүний байдалтай хэвлүүхэн үг хэлжээ. “Макондо бол их ирээдүйтэй цэцэглэж байсан хот байсан юм, гэтэл гадилын компани зөв замыг нь алдуулан, завхруудж, юу ч үгүй болтол тонон дээрэмдсэн, энэ компаний инженерүүд ажилчдад буулт хийхгүй гэдгээ зад удсан” гэж хэлсэн нь бүх нийтийн бодон дассанаас өөр байлаа. Жаал хүү тун ухаалаг ярьж байснаараа номч мэргэн Есусыг доромжлон элэглэж байх мэт Фернандад санагджээ.

Цэргүүд өртөнө дээр цугласан гурван мянга гаруй ажилчдыг хэрхэн пулемётоор буудсан, хүүрийг хэрхэн хоёр зуун вагон ачиж, далайд хаясан зэргийг маш нарий, үнэмшихүйц ярьжээ. Галт тэрэгний буудлын дэргэдэх талбайд юу ч болоогүй гэдэг албан ёсны мэдээнд олонх хүний адил итгэдэг Фернанда жаал хүүг хурандаа аурелиано Буэндиагийн анархи санаа бодлыг авч хэмээн бодоод ихэд аягүйрхэж, түүнийг “Дуугаа аяд” гэж зандарчээ. Гэтэл Бага Аурелиано ихрийнхээ өрөөсний ярьсныг иүнэн гэж батлажээ. Бүгдээрээ солиотой гэж боддог байсан Бага Хосе Аркадио хэрэг дээрээ гэрийнхнээс хамгийн ухаантай нь байлаа. Тэрбээр жаахан Аурелиано бичиг үсэгт тайлж, эртний бичгийг судлах сонирхолтой болгож, гадилын компани Макондод ямар уршиг тарьсан тухай хувийн бодлыг түүнд итгүүлжээ. Энэ нь түүхчдийн бичсэн, сурах бичигт тайлбарласан худал мэдээтэй машид зөрж, олон жилийн хойно Аурелианоамьдралын замд ороод үүнийгээ ярихад цөмөөрөө зохиомол юм гэж үзэх болно. халуун салхи ч тоос шороо ч, төөнөх халуун ч үл нэвтрэх буйд өрөөнд, тэр хоёр өөрсдийг нь төрөхөөс хамаагүй урьд цонх руу нураагаа харуулан суугаад ертөнцийн тухай ярьж байсан хэрээний далавч шиг хүрээтэй бүрх өмссөн өвгөний хий дүрийг санадаг байлаа. Энэ тасалгаанд үргэлж гуравдугаар сар, үргэлж даваа гариг байдгийг хоёул зэрэг ажиглаад, Хосе Аркадио Буэндиаг солирсон гэж гэрийнхэн нь яасан эндүүрч байж вэ, гэтэл тэр бол цаг хугацаа урагшлахдаа бас л саад тотгортой тулгардаг, осол сүйрэлд ордог, иймээс цагийн хэсэг нь тасраад, урагш давхин одсон урсгалын хөдөлгөөнгүй хувь болон нэгэн тасалгаанд тээглэн хоцордог үнэнийг ухаарсан цорын ганц саруул ухаантай хүн байжээ гэдгийг ойлгожээ. Түүнээс гадна Бага Хосе Аркадио эртний бичээсийн нууц тэмдгийг ангилж тэдгээрээр хүснэгт зохиож чаджээ. Эдгээр нь дөчин долоогоос тавин гурван үсэгтэй цагаан толгойтой тохрч, тус тусад нь бичвэл дан дээр хатаах гээд тавьсан дотруу хувцас шиг санагдаж байгааг үзэв Аурелиано англи нэвтрэхийх тольд тиймэрхүү юм үзмэн шиг санаад, харьцуулж үзэхээр авчирвал хүснэгт үнэхээр тохирч байлаа.

Бага Аурелианго оньсоготой сугалаа хийх гэж оролдож байх үеэр нь өглөө бүр хоолойд нь бөөн юм хадуучих шиг нэг л бачуухан байх болжээ. Цаг муудсанаас болж зүгээр л чилээрхэж байгаа хэрэг гэж Петра Котес үзээд жил гаруй өглөө бүр багс барьж байгаад тагнайг зөгийн бал, цагаан луувангийн шүүсээр арчиж өгчээ. Хоолойн хавдар томорч, амьсгалахад улам хэцшүү болоход Бага Аурелиано Пилар Тернера дээр очиж, “Ямар нэг эмийн өвч мэдэхгүй биз?” гэж асуужээ.

Гэвч нууц хас хүйн эзэгтэйн хариуцалагатай тушаалд байсаар зуу насалсан дайчин эмэ эх нь анагаах ухааныг урьдын адил мухар сүжиг гэж үзэж, , хөзрөөсөө зөвөлгөө авчсан ажээ Гилбэрийн боолыг илдэнд хоолой нь шархалсан цэцгийн ночн гарсанд мэрэгч эхнэр Феранадаг нөхрөө гэртээ эргүүлж авчрах гэж зургийг нь

сүлбээр зүүгээр хатгах хуучирсан арга хэрэглээд, илбийн ухааныг төдий л мэдэхгүйн тул дотор хавлдар үүсгэчихэж гэж үзлээ . Бага Аурелиано гэр бүлийн цомогт бүв бүтэн байж байгаа хуримын гэрэд зурагнаас өөр гэрэл зураг өөрт гь байсныг санахгүй тул эхнэрээсээ нуун гэрээ тужид нь нэгжээд , хоргоны ёроолд ер бусын бодолтой зургаан даруулга байгааг олжээ . Энэ гоё бохогт илбэ жилбэтэй холбоотой байж магадгүй гэж бодон, нэгийг нь сэм нь өвөртлөөд, Пилар Тернерад үзүүлэхрээр аваачна. Тэр ч уул учир битүүлэг зүйлээр яадаг, ямар учиртай болохыг хэлж мэдэхгүй байсан боловч ихэд сэжиглэж бүгдийг нь авчруулаад хашаанд гал түлж байгаад шатааж орхив. Фернандогийн хийсэн хараалыг хариулахын тулд



Бага Аруерелиано өндөг дарсан тахиа авч, дээрээс нь шээгээд, туулайн бөөр модны доор амьдаар нь бул гэжээ . Бага Аурелианошо өөрийгөө эдгэнэ гэсэн бат итгэлтэйгээр заасныг нь гүйцэтгэж , ухсан газраа хуурай навчаар дөнгөж дарж гүйцтэл хоолой нь онгойх шиг болжээ .Фернандо даруулгаа алга болсныг үл үзэгдэх оточ нарын л өшөөгөөр оёж, хүүгийнхээ ирүүлсэн шинэ даруулгыг тэр халаасандаа хийж яваа болжээ .

Тахиаг булснаас хойш зургаан сар болоод Бага Аурелиано шөнө дунд бүшгүүлэн ханиалгаж сэрвэл асар том дигюваранз хоолойд нь орчихоод бахь мэт хавчуураараа урж зулгааж байх шиг болжээ . хэчнээн шидэт бум шатаалаа гээд, хэчнээн ч шившсэн , тахиа дээр шээлээ гээд нэмэргүй, үхэх цаг болжээ, цорын ганц гарцаагүй бөгөөд гунигт нэн энэ байна гэдэг нь чухамхүү тэр цагт толорхой боллоо . Тэр бодсоноо хэнд ч хэлсэнгүй . Амаранта Урсулаг Брюссельд явуулж амжилгүй үхчихэж магадгүй, гэж айхдаа тэрбээр насандаа б айгаагүйгээр мэрийн, долоо хоногт нэг сугалаа хийхийнг оронд гурвыг хйх болов. Үүр тэмдгэрээгүй байхалд босож , хот тойрон харайлгаж , сугалааг худалдах гэж оролдон, үхэж байгаа хүний зовлоно гунигийг эдлэн хамгийн алслагдсан , ядуу хорооллоор явж, “Эүн тэнгэр энэ байна . Зуун жилд ганцхан морилж ирнэ, энэ завшааныг бүү алдагтан ” хэмээн дуудан явна. Тэрбээр эелдэг , хөгжөөнтэй , яриа хөөрөөтэй харагдах гэж хичнээн , өрөвдмөөр чармайвч хөлстэй , цонхигор царайг нь хальт харахад ер хорвоогийн тоос удаан хөдөлгөхгүй нь илт байна . Заримлаа хүний нүднээс далд цулгүй газар түр ч атугай суудаг байлаа . Эгшигт хайрцагны дэргэд санаа алдан суугаа ганц бие эмэгтэйн толгойг том аонжвороо эргүүлж магадгүй гэж горьвдон дахиад л шөнө орой болйион хойно наргиантай хорооллоор явдаг байлаа . “Энэ дугаар дөрвөн сар оногдоогүй юм . Үүнийг алдаж болохгүй, нас гэдэг та нарын бодож байгаагаас богнихон ” гэж сугалаагаа үзүүлэн хэлдэг байлаа . Сүүл сүүлдээ тэрбээр бүр үзнэ хүндээ алдан, доромжлуулах болж, түүнийг “Дон Аурелиано ” гэхээ болиод,” Дон эзэн тэнгэр ” гэж нүүрэн дээр нь ч зовохгүй дуудах болжээ. Дуу нь сулран улам дпаргиж, сүүлдээ нохойн архирахтай адил болсон боловч Бага Аурелианл Петра Котесийн ха шаанд хонжвор тараан олны сонирхлыг татаж дөнгөөв балаа . Гэвч хоолой нь улам гарахаа больж, улам өвчин орж, мөдхөн тэсхийн аргагүй болох төлөвтэй тэрбээр сугалааны хонжвор гахай, ямаа хэчнээн тавиад оохиноо Брюсель оруулж чадахгүй нь гэж баттай ойлгов. Тэгтэл үерт халцгайрсан газрыг хоэнжворт тавья хөрөнгөтэй хүн бол түүнийг боловсруулахад авч болно гэсэн үлгэрийн юм шиг санаа төржээ . энэ санаа үнэхээр хорхой хүрмээр байсан тул хотын дарга өөрөө сугалааны тухай онцгой зарлиг гаргаж, сугалааг ширхгийг нь зуун песогоор худалдасанд бэнчин хүрэхгүйчүүд хүртэл хамжиж дэмжиж авснаар дол о хоноогүй байхад сугалаа зурагдаж дуусжээ . хонжворын тохироог гаргасны дараа хишигтэйнүүд нь урьд цагийн шуугианд найрыг зарим талаар санадуулсан том баяр хийж, түүн дээр Бага Өурелиано , үмүүг Францискогийн дууны мартагдсан аяыг найралд баян хуураараа сүүлийн удаа дарсан боловч дууг өөрөө дуулж чадсангүй билээ .

Хоёр сар болоод Амаранта Урсула Брессель явав. Бага Аурелианл ер  
бусын сугалаанаас олсон мөнгийг цөмийг нь төдийгүй сүүлийн хэдэн сард хэмнэж  
байсан бшхнээ , тэрчлэн оньст хуур, даруулт хуур, эд үзэгдэх болсон янз  
бүрийн хуучин тавилгаа зарж олсон багаахан мөнгөө охиндоо хуу өгчээ  
. түүний тооцоолсоноор энэ мөнгөн сурахы бүх жилд нь хүрэх боловч буцах  
замын зардалд хүрэх эсэх нь тодорхойгүй байлаа  
. Брессель нүгэлт Парис тун ойрхон гэж  
бодохооё бухимдан Фернандо охиныгоо явуулахгүй гэж  
зүтгэсэн боловч гэлэнмаа нарын санхүүжүүлж байдаг залуу католик бүсгүйчүүд дот  
уур байртай сургуульд Анхель лам зуучилсан захидал бичиж, Амараниа Урсула тэнд  
сууя гэж амласан хойно сая тайвгирчээ  
. Түүнээс гадна лам, Толеда очоод Брюссель орох надьартай хүн  
дагуулж явуулья гэж ам алджээ . Энэ талаар бөөн захидал махидал болж байх  
хооронд Бага Аурелиано Петра  
Котесаар элбэлцүүлэн Амаранта Урсулагийн юмыг төхөөрч байлаа .  
Фернандогийн инжийг урьд хадгалж байсан нэг авдранд юм хумыг н хийж зэхсэн  
тэр үдэш гэхэд роюутан болох ёстой бүсгүй  
Атлантын гадаад далайг туулахдаа ямар плааж, ямар тансран шагайвчаар байх вэ, эр  
эг зээр буухдаа өмсөх зэс товчтой цэмбэн пальто торгон савхин шаахайг нь хаан  
хийёсэн ба  
нгэдгийфг цээжээр алхаж орохдоо усанд ойчихгүйн тулд хаана нь гишгэхийг заалга  
ж гэлэнмээ нараас алхам ч холддохгүй байх ёстойг мэдэж , юм идэх л  
гэж өрөөнөөс гарч болох, залгай далайд э эм ямар ч хүний юм асуухад яагаад ч  
хариу хэлэхгүй байх учиртайг ойлгож авлаа . тэр далайн өвчнөөс гараар  
бичиж өгсөн шуурга хорих зургаан тарнитай дэвтэр авлаа  
. Фернандо мөнгийг нь хийх бэржээнхэн бүс оёж өгөөд, шөнө унтахдаа ч ,  
тайлахгүй байхаар тааруулж өгчээ  
. Цайруулагч уусмалаар угааж, спиртээр ариутгасан алтан  
хөтөвч Фернандо охиндоо бэлэглэх гэсэн боловч Амаранта Урсула сургуулийнх  
нь охинд элэглэх байх гэж айж байна гээд бэлгийг нь авсангүй . хэдэн сарын дараа  
Бага Аурелиано үхлээ хүлээж хэвтэхдээ охиноо сүүлчийн  
удаа ямархуу байлдалтай харснаа дурсаан санана. Амаранта Урсула хоёрдугар зэргий  
н вогооны цонхны тоос  
болсон шилийг буулган Фернандагийн захисаныг сонсох гэж дэмий л хиймэл алаг  
нүдэн цэцгийн баглаатай цайвар ягаан  
торгон палааж, намхан өсгийтэй хальстай торгон свахин шагайвч, дугуй бохотхон та  
туургатай торгон оймс өмссөн байлаа .  
тэрбээр нам нуруутай, задгай тавьсан ур үстэй, тормолзсон нүдтэй агаад түүний  
насанд Урсула яг ингэж хардаг байсан билээ .  
Салах ес хийхдээ уйлаагүй боловч инээхгүй байгаагаас нь элэнц ээжийнхээ  
сэтгэл чангатайг дуурайсан нь харагдана. Галт тэрэг  
хурдаа авахын хэрээр Бага Аурелиано алхаагаа нэмэн, Фернандаг бүдэрч унах вий г  
эж сугадан вогоонтой зэрэгцэн явав, охин нь үнэсэж байгаа  
дүр үзүүлэн хурууныхаа үзүүрээр дохихыг хараад арайхийн гараа даллаж амжжээ  
. Эр эм хоёр газар тэнгэрийн савслаганд галт  
тэрэгний жижигэрсээр хар цэг болон далдрахыг харсаар цонох халуун наранд хөдлө

лгүй зогсож байсан нь хуримнаасаа хойш анх удаа тэгж сугадалцан зогссон нь тэрб  
айжээ .

Наймдугаар сарын есөнд, Брюссельд энхны захидал ирэхээс өмнө Бага хосе  
Аркодио жаахан Аурелианотой ярилцаж байснаа гэв гэнэт яасан нь мэдэгдэхгүй,

-Гурван мянган гаруйы хүн басан, бүгдийг  
нь далайд хаясан гэдгийг үүрд санаж яв! гэж хэлжээ .

тэгээд бичээсээ духаараа дэрлэн унаж, хараастайгаа үхлээ . мөн  
энэ агшинд Фернандогийн орон дээр хоолойг нь  
урах дигюаранзын төмөр хавчуурыг ихрийн нь өрөөсөн хийсэн урт  
бөгөөд зовлонт тэмуэл дуусаж байлаа . Үүнээс долоо хоногийн  
өмнө Бага Аурелиано дуу нь гарахгүй , амьсгал нь байхгүй , арьс яс болчихсон ,  
аялдаг авдар, авах танаггүй найраг баян хуураа аваад грэтээ буцаж ирсэн  
нь гэргийнхээ дэргэд үхнэ гэж хэлсэн амандаа хүрэх гэсэн хэрэг айээ .  
Петра Кот?с дотуур хувцсаа эмхэлээд нь тусалж , ганц нулимс унагалгүй ,  
салах ёс хийсэн ыболовч авсанд өмсөх ёстой чийдмэл шаахай нь  
авдранд хийхийг мартаж орхисон байлаа . тэрбээр Бага Аурелианог өнгөрлөө эж  
дуулахдаа хар хуцвас өмсөөд, шаахайг нь сонинд цуглаад, “Шарилыг үзье” оруулаач!  
Гэж Фернандог гуйжээ .

-Чи миний оронд өөрийгөө тавиад үзээч, Би тун ахиртай байсандаа л  
ингэж муугаа үзүүлж явна, бодож хайрлаач гэж Петро котес гуйжээ .

-далдуур явалддагш байсан хүүхэн хэчнээн муугаа  
үзүүллээ гээд юу шальдаг юм . Өөртэйгээ унтаж байсан тэр олон юмныхаа  
нэгийг үхэхийг хүлээ . тэгэд түүндээ наад шаахагаа өмсүүл гэж Фернанда а  
хариулжээ .

Санта Софи дела пьедад хүүгээ амьдаар нь  
оршуулаагүйг магадлах гэхдээ толгойг нь балиусаар цавчин салгаж амандаа хүрчээ  
. Ах

дүү хоёрын хүүрийг адидхан авсанд хийсэндп бүшд үзвээс үхсэн хойноо хүүхэд бай  
хынх шигээ ав адилхан болсон байжээ . Бага Аурелианогийн архины найз нар  
“Үнээ минь тугалаад бай, нас гэдэг цэцгийн эрих авсан дээр нь тавьсанд Фернанда  
доромжилж байна хэмээн ондууцаж цэцгийг угаадсаны нүхэнд хаяулжээ .  
гэрээс авсыг өргөж гарсан гунигтай согтуунууд тэвлэж байгаа Бага  
Хьосе Аркадиог хийхээр ухсан нүхэнд Бага Аурелианогийн хүүр,  
Бага Аурелианог хийхээр ухсан нүхэнд Бага хосе Аркиодогийн хүүрийг  
солиод оршуулчихжээ .

Аруелиано Мелькиадесийн өрөөнд он удаан байлаа  
. тэрбээр элэгдэж гүйцсэн номын уран зөгнөлт домог, саат Герман ламын сургаалын  
товч, шулмын судлалын ухааны туха тэмдэглэсэн , рилү бүтээх арга ,  
Нострадамусын “Эрин зуун” ,  
тахлын тухай түүний шинжилгээг цээжээр мэдэх болж, өөрийнхөө үеийг  
мэдэхгүй мөртлөө дундадп эртний үеийн хүний  
шинжлэх ухааны нэн чухал мэдлэгтэйы бож арван хэдэн настай золголоо  
. Санта Софи дела Пьедадбг тасалгаандп нь хэдийд ч орлоо гэсэн Аурелиано ном  
л уншаад сууж байдаг байв. Өглөө эрт аяга чихэргүй зофе,  
өдөр дунд чанасан цагаан будаа, шарсан гадилын хэдэн хэлтэрхийтэй түүнд аваачиж  
ц аөгнө . Бага Аурелианг үхсэнээс хойш тэлдний иддэг юм гэвэл тэр л болжээ

. Санта Софи дела Пьедад жаахан Аурелианогийн үсийг тайрч, бөөсийг нь түүж, орхигдсон авдарнаасаа олж цуглуулсан хуучин хувас, ддотуур өмд цамцыг засан оёж өглөө

. Түүний сахалтай болход хурандаа Аурелиано Буэндиагийн сахлын хутга, шилэн аягыг авчирч өгчээ . Мемегийн хүү хурандаатай өөрийн нь төрсөн хүүхдээс нь илүү анхааран, тэр байтугай Аурелиано Хосегоос ч илүү адил агаад ялангуяа төвгөр шанаа нь ихэмсэгдүү жимбэгэр уруул нь бүр адилхан байлаа . тухайн үедээ мелькиадесийн өрөөнд Бага Аурелиано өөрөө өөртэйгөө яриад байх шиг Урсула санагддаг байсан бол Аурелиано бас тэгээд байх шиг Санта Софи дела Пьедадад бодогдож байлаа . Үнэндээ бол Аурелиано Мелькиадестай ярьдаг байжээ . Ихэр хоёрыг үхсэний дараа нэгэн халуун үдээр гэрэлтэх цонхны наана хэрээний далавч шиг хүрээтэй бүрх малгай өмссөн баргар царайтай өвгөн харагдсан нь Аурелианогийн ой тоон бүр төрөхөөс нь өмнө байж байсан тэр өвгөний бүдэг бадаг дүр байлаа . тэр үед Аурелиан эртний бичээсийн цагаан толгойг ангилж дуусаад байлаа . Иймээс Мельктадесийн ямар хэлээр энэ тэмдэглэлийг бичсэнийг олж мэдсэн эсэхийг асуухад тэрбээр:

- Самгарди хэлээр гэж түгдрэлгүй хариулжээ .

- Мелькиадес энэ өрөөнд олон ирэхийн хэрэггүй болсноо хэлэв. Гэвч тэрбээр сайх бичсэнийг зуун жил болох агшин хүртлэх хэдэн жилд аурелианл самгарди хэлийг судлаад, уг бичээсийг утгыг тайлж чадаху нь гэж мэдэн, бүр үхэх ордондоо тайван одно. Гол руу гардаг нарийн гудамжинд, гадилын зомпанийн үед заяаг мэргэлж, зүүдийг тайлж байсан газарт нэгэн каталоги хүн номын мухлаг гаргадаг, тэнд Sanakrit primer<sup>1</sup> бий, түүнийг даруй олж авахгүй бол зургаан жил болоход хивэн хорхой идүүлчих юм угэдгийг Аурелиано Мелькиандесийн мэджээ . Өдий урт наслахдаа санта Софи дела Пьедад сэтгэл хөдөлнө барина гэдгийг үзээгүй м мөртлөө

номын тавиурын хоёрдугаар эгнээний баруун буланд “Чөлөөлөгдсөн Иерусалим”, Мильтоны найраглал хоёрын хооронд байгаа номыг авчирч өгөөч гэж Аурелиано гуйхад л туйлын гайхах гэдгийг анх удаа үзжээ . Санта Софи дела Пьелал бичиг мэдэхгүй тул тэр бүх хэлснийг тогтоож аваад, урланд нуугаастай арван долоон алтан загасны нэгийг худалдан кохих мөнгө олж авчээ . Цэргүүд гэрийг нэгжээр хойш алтан кагасны хаана байгааг аурелиань тэр хосрооч өөр хүн мэдэхгүй байлаа .

Аурелианол самгардгийг сайн сурч, Мелькиадес улам цөөн үзэгдэж, улам бүр холдож, үд дундын нүд гялбаам нарны гэрэлд аажмаар замхарч байлаа . Өвгөнийг сүүлчийн удаа ирэхэд нь Аурелианл олж харсангүй, гагцхүү хажууд нь үзэгдэхгүй үхсэн юм шиг” гэж сонсогдохын төдий шивнэхийг л сонсжээ . Тэр өдрөөс хойш тоос, халуун, морин шоргоолж, удаан шроогоолж, ном, бичээсийг түүнд байгаа билгийнх нь хамт идэх учиртай хивэн хорхой тасалгаанд саадгүй орж ирэх боллоо .

Тэднийх хүнсээр дутахгүй байв. Бага аурелианог нас барсны дараа тахимдуу бус бичээстэй цэцгийн эрих авчирсан нэг найз нь талийгчаас зээлсэн мөнгө өгье гэж Фернандад хэлжээ . үүнээс хойш лвхага гариг бүрд сагстай идэш ууш авчирч өгдөг болжээ . Сагсан дотор байгаа юм нь долоо

хоног өлхөн хүрдэг байлаа . Энэ бүх идэх юмыг петра Котес явуулаад байна гэдгийг хэн ч сэжиглэсэнгүй . Петра Котеси гуйлагчинд хишиг хүртээж байгаа юм шиг инэгж юм явууснаар өөрийгөө доромжилсон этгээдээс харугаа ганцсайн авч байна гэж итгэжээ . Петра Котесийн цээжинд зангирсан хорсол бодсоноос нь хурдан намжсан боловч эхлээд бардам зандайтаа, дараа нь өрөвдсөндөө хүнсийг нь бэлэвсэн эхнэрт нь явуулсаар байлаа . Хожим нь Петра Котес сугалаа зарж хүч хүрэхээ болиод, сугалааг сонирхож хүнгүй болоход нь өөрөө өлсөү байсан ч Фернандад хоол явуулж, өрсөлдөгч тэр хүүхнээ оршуулж байхыг биеэр үзэн үзтлээ сайн удраараа тэр журмаар барьсаар байж билээ .

Ам бүв цөөрснөөр Санта Софи дела Пьедадын тавь гаруй жил үүрсэн ар гэрийнх н хүнд ажил хөнгөрмөөр санагдаж бөйлаа . тэнгэрлэг сайхан сэтгэлтэй Сайхан Ремедиос, ихэрхэгдүү байрын битүүлэг кантай Бага хоес Аркадиоог энэ айлд каяаж өгсөн дуу шуугүй зожиг энэ эмэгтэйн энэ айлд азаяаж өгсөн дуу шуугүй зожиг энэ эмэгтэйн гомдоллон үглэж байхыг хэн ч сонссонгүй . Тэрбээр энэ насыг ганц биеэр , ган хийлгүй туулахдаа хүүхэд шуухад л өлсөж , цаадуул нь түүний үр ач гэдгээ бараг санадаг ч үгүй байлаа . аурелианог төрсөн хүү шинэ бөөцийллөхдөө жичээ гэж огт сажиглэхгүй явав. Өөр айл сан бол түүнийг агуулахын шалан дээр цийрсэн дээр харх шөнөжин ноцолдох чимээн дунд хэзээ ч унтуулахгүй байсан биз ээ . нэг шөнө нэг юм харанхуйгаас хараад б айх шиг болсонд айн сэрвэл хорь могой гэдсэн дээгүүр нь мөлхөн гараад эргэн харж байсныг хэнд ч хэлээгүй билээ . Үүнийг Урсула хэлсэн бол ороо тавиад өгөхийг нь мэдэж байлаа . Гэвч тэр үел хүнээр анхааруулах гэвэл гонхонд чанга чарлавал яадаг байсан гэхээс биш , тийм юм анхаарах сөгөөтэй хүн байсангүй. яагаад гэвэл дайн болж , дайны хажуугаар дажин болж, өөрөө сөгтөө унатлаа талх барьж хүүхэд шуухад маллаж, ойр дотныхоо хүнийг бодох зав гардаггүй байлаа . Санта Софи дела Пьедадыг санаж байдаг цорын ганцу хүн бол түүнийг ганц ч хараагүй П?тра котес байлаа . тетра Котес хэдийд ч , Бага Аурелианотой сугалаагаар олсон жаахныгаа шөнөжин хуваах гэж зүдэрч байхдаа ч санта Софи дела Пьедадыг мөнхийн зараа гэж үзэх болж , хэн болохыг өчнөөн хэлүүлсэн боловч санаанд нь нэг д багтаж өгөхгүй \_ нөхрийнхөө ээж, хадам эхээ байна гэж арайхийн тогтоодог боловч дорхноо мартаж орхидог байла . Санта Софи дела Пьедад зкарагдпаж багаадаа төдийгүй төвөгшөөдөггүй бололтой байв. харин ч орь залуугаасаа амьдарсан асар том байшинг цэвэрлэж цэмцийлгэж , ялангуяа гадилын компанийн үед айлын голомт гэхээсээ цэргийн хуаран гэмээр болоход нв ч гэсэн өөд татсаар тасалгаан дотуур холхмн өнцаг нь булан бүрийг өхнгийг шагайж байх дуртай юм уу гэмээр бадаг билээ . гэвч Урсулаг үхсэний дараа, Санта Софи дела Пьедад хэчнээн хүнд баймгүй шалбалзуур , хэчнээн хачирхамаар гайхмаар ажилсаг байвч аргагүй хүч хүрэхэ больж эхэлжээ . нас хөгширчээ тэнхээ лдоройтсоноорс ч тэгэхгүй , ерөөсөө байшин нь цаг өнгөрөөх тусам, муудаж байснаас тэгжээ . Байшингийн хананд зөөлөн хөвд ургаж , хашаанд ургамалд идүүлэн шил адил хагарч, цуурсан газраар нь зуу гарцй жилийн өмнө Мелькиадесийн хиймэл эрүү хийдэг шилэн аяганаас Урсулагийн олсон шар цэцэг цухуйжээ . Санта Софи дела Пьедад байгалийн ганирсан хүчийг сөрөх цаг ч

үгүй , хүч чүгүй болоод, унтлагын өрөөнүүдээс өдөржингөө гүрвэлитийг үргэлж ы боловч цаадуул н ь шөнө буцаж ирнэ. Нэгэн өглөө үзвэл улаан шоргоолж байшингийн суурийг сэндийлж дуусаад, цэцэрлэгийг өнгөрч , хатаж хоцрон шороон өнгөтэй болсон хайтан цэцэгийг бүхий гонхоор дайрч гэрт орж ирсэн байлаа Санта Софи дела Пьедад эхлээд тэднийг зүгээр л шүүрээд хаячих гэж оролдоод , дараа эь хор цацаж , сүүлд нь түүхий шохой хэрэглэж үзсэн боловч огт болсонгүй , маргааш нь л бөөнөөрөө гарч ирсэн язганаж байдаг балаа . Фернанда хүүхдүүддээ захидал бичихээс өөр юм хийдэггүй болохоор гэр орноо эргэж сэхэхгүйгээр лоройтож байгааг цаахахгүй , Санта Софи дела Пьедад херийн өвсийг гал зууханд оруулахгүй гэж үзэлцэж , хэлхэн цаг болоод л хэрэх аалзны шүлсийг хананаас цнагаж, мод идэх шоргоожлийг нүхнээс нь хаман гаргах зэргээр цор ганцаараа үзэлцэж байлаа . гэвч өлөн тоос, аалзны шүлс орж , цэвэр байлгах гэж б айдгаараа чармайгаад байхад у тасалгаа хурандаа Аурелиано Буэндиа, залуу офицер хоёрын үзсэн тэр бохир , өөдгүй байдаолтай болсоор багааг харахад аргагүй дийлдсэнээ мэджээ . тэгэхэд нь гоёлд өмсдөг элэгдсэн палааж, Урсулагийн хуучин шаахай, Амаранта Урсулагийн бэлэглэсэн энгийн оймсыг өмсөж солих хоёр гурван дотуур хувцсаа хувсаа баадагнаж боогоод Аурелианод:

-Оддо би? хүршгүй нь ээ. Энэ гэр ядарсан надад дэндүү ахдаж б айна гэ хэлжээ .

Хаашаа явах гэж байгааг нь Аурелианогийн асуухад хойчийнхоо тухай огт төсөөлөхгүй байна уу гэлтэй гараа сарвайжээ . гэсэн хэдий ч боловч насныхаа сүүлд Риоачад байдаг үеэл дүүгээ барааддаг юм уу гэж хэлжээ . Гэвч үүнд үнэмших аргагүй б айв. Эцэг эхээ нас барснаас хойш Сата Софи де ла Пьедад Макондод хэнтэй ч харицаж ёадсангүй , төрөл садантай ч гэж дурсаж байсангүй . сантс Софи дела Пьедад ганц песо хоррни таван сентавогоос өөр юмгүй байсан тул Аурелиано арван дөрхөн алтан загасыг түүнд өгчээ . насны хүндэд дарагдан бөгцийж өнгөрч, гадаа гараад явган хаалганы нүхээр гараа оруулан, оньсыг буулгаж байжээ . Түүнээс хойш Аурелиано тэр эмгэнтэй уулзсангүй ч шүгүй, түүний тухай сураг сонссон ч үгүй билээ .

Санта Софи дела Пьедад явсныг дуулаад Фернанда өдөржин ам хамхилгүй бувтанаж , бүх авдар сав , хорго шүүгээгээ уудалж, бүх юмаа бүртгэж үзээд хадам эхийгээ у ч авч яваагүйд сая итгэжээ . дараа нь насандаа анх удаа гал ноцоох гэж оролдоод хуруугаа түлж “Кофе яаж чанадгийг үзүүлж тус болооч” гэж Аурелианогоос гуйжээ . Яваандаа залуу эр тогоо барих болов. Фернанда өглөө босоод , ширээн дээр хоол байж байхыг авч идээдг унтлагынхаа өрөөнд рхж, зууханд нурман дээр жигнээд орхисон хоолыг авах гэж үдээр нэг үзэгдэж , тарчигхан хоолроо хоолны өрөөнд аваачин, таван хоосон сандалтайы ёрог даавуугаар бүтээсэн ширээний эхэнд цэцэрлэг дэнгийн дунд сууж иднэ. Аурелиано Фернандо хоёр гэрт хочулахнаа үлдсэн боловч хувь хувиа борлуулах ажээ . тэр хоёр тус тусын унтлагын өрөг л цэвэрлэ тул аалзнь шүолс бусад өрөөг аажмаар хэрж, сарнайн бутыг торж , хана туургыг бүрхэж , шувуу нурууг зузаан давхарагаар хучлаа . Яг энэ үед Фернандо гэрийн бугтай бол гэж боджээ . Өдөр тутам гар доор хэрэглэгдэж

б айдаг юм с нь хөл орсон юм шиг болжээ . хайяа орон дээрээ яах аргагүйн тавьсан байхад л ор дэрээ урвуулж хөрвүүлж бүтэн цаг эрээд, дөрвөн өдөр ороогүйы бодоход гал зуухны тавиур дээрээс олжээ . Шургуулагнаас гэнэт сэрээ нь алга болчихоод маргааш нь зургаа нь шүтээн дээр, гурав нь угаагуурт байж байлаа . юм нь түүнтэй нуугдаж тоглох мэт болуж, ялангуяа захидал бичих гээд суух үед нь энэ наадам бүр уурыг нь б ардаг байлаа . дөнгөж ич этгээд тавьсан бэхийн сав нь солгой этгээдэд оччихно , бичгийн хавтас нь ширээн дээрээс бүр алга болоод шурав хонож байтал дэрэн дороос нь гарч, Хос? Аркодиод бичсэн захидлын хуудас Амаранта Урсулад явуулар захидлын дугтуйд орж, дугтуйг сольчих вий гэж үргэлж зовж, хэд хэд ингээд солигдсоноос хойш дахиад тэгэх юий гэж яс хавталзаж байх боллоо . нэг удаа үзэг нь алга болихжээ . хагас сарын дараа шуудан хүргэгч авчирч өгсөн байна. халааснаасаа олоод айл айлаар орохдоо эзнийг нь хайж ийнхүү уджээ . Эхлээд юм нь ингэж алга болоод байгаа нь даруулгаа алга болсноо адил үл үзэдэх оточ нарын хийгээд байгаа ажил гэж санаад тайван байлгаж үзээч ! гэж захиа бичиж эхэлсэн боловч нэг яаруу ажил гарсанд захидлаа дутуу орхиж гараад өрөөндөө эргэж ирвэл нөгөөх нь алга болж , өөрөө ч тийм захидал бичих гэж байснаа мартаж орхижээ . нэг хэсэг Аурелиано сэжиглэв. Тэгээд түүнийг мөшгөж, замд нь янз бүрийн юм хаяж аваад нууж бахад нв бариад авдаш хэрэг хэмээн анах бол болсон боловч цаадах нь Мелькиадесийн өрөө, гал зуух , жорлонгоос өөр газар ордоггүй , тэгээд ч ийм юи хийхгүй хүн байна гэдэгт удалгүй итгэжээ . Тийнхүү Фернанда гэрийн бугийг л ингээд байна гэж санаад, бүр маа байх ёстой гэдэрт нь уяж бэхэлж бахаар шийджээ . хайчаа орны толгойноос , үзгийн сав, бичгийн хавтсаа ширээний хөлнөөс уяж , бэхийн саваа ихэвчлэн цаас тавьдаг газрынхаа баруун талд ширээнийхээ тавцанд наажээ . гэвч одоо л нэг боллоо гэж бодсон нь болсонгүй , учир нь юм оёж байгаад хоёр гурван цаг болоход гэрийн буг хайчных нь уяг богинсгоод гар хрэх аргагүй болгоно. Хавтасны уяа нь тэр ч байтугай гар нь болохоо байжээ . бэхэндээ хүрч чадахгүй больдог байлаа . Брюссельд байгаа Амаранта Урсула ч , Ромд байгаа Хосе Аркадио ч Фернандагийн инэгж будилж байгааг мэдсэнгүй . Тэрбээр сайн дураа сууж байгаагаатэдэнд бичдэг, аар саар юманд зоводгүй байсан р гэртээ буцсан мэт хйх юмгүй , аа саар юм гарвал нь хийичхлээ гээд л болчихдог учир үнэндээ ч жаргалтай сайн сууж байжээ . Захидал эцэс төгсгөлгүй бичсээр байгаал Фернандо цаг хугацааг мэдэхээ байж, энэ ялангуяа Санта Софи дела Пьедадйг явснаас хойш мэдэгдэх боллоо . Цернанда хүүхдүүдээ ирэх байх гэж өдрийг баримжаалан өдөр, сар жилийг дасжээ . гэтэл хүү охин хоёр нь ирэхээ удаа дараа хойшлуулж болсноор жил нь сауумргаж , сар нь будлиантуулах , өдөр нь нэг нэгээсээ ялагдахаа больж, тэр ч байтугай цаг хугацаа өнгөрч байгаа гэж мэдэгдэхээ байжээ . Хүүхдүүдээ тийнхүү ирэхээ хойлуулаад багаад Фернандо ууралсангүй , харин ч юун ашагүй юм гэж боддог болов. Хосе Аркадио хэдэн жилийн өмнө сахил хүртэдгийн дабаанд дээр байна гэж бичсэн мөртлөө одоо шашны дээд курсийг төгсөөд дипломат бодлого судалж эхлэх гэж байна хэмээн бичихэд ч сэтгэл зовсонгүй , хуягт Петрийн сэнтийд хүрэх бартаат зам хичнээн өгсүүр бөгөөд эгц болохыг мэдэлгүй яах вэ . \_ Бусад хүний бол нэг их тоохооргүй юманд сүйд болж, жишээлбэл , хүүгээ пап

ламын үзсэн гэж бичихэд учиргүй баясжээ . Охин нь гаргууд сурч байгаагийнхаа ачаар эцгийнхээ төсөөлж чадаагүй хөнгөлөлт авсан учир Брюссель тогтоосон хугацаанаасаа илүү удаан сурч чадах боллоо гэж бичихэд нь баярлажээ .

Санта Софи дела Пьедад самгарди хэл дээр зүй авчирч өгснөөс хойш гурван жил гаруй өнгөрч, Аурелиано бичээсийн эхний хуудсыг сая л орчуулж чадан, асар их ажил хийсэн боловч испани орчуулагч ямар с утгагүй \_ нууц рүлхүүрээр бичсэн байсан учир хэмжихийн аргагүй урт замд дөнгөж анхны алхам хийсэн хэрэгб айжээ . Аурелианог нууц томъёоны түлхүүрийг олох тулгуур бичиг байхгүй басан боловч катлоны эрдэмтэний мухлагт бичээсийн гүн утганд нэтрэх болойж Фернандагаас , тэр номыг хайхаар яв явуулаач гэж гуйхаар шийдэв. Хог новш овоорч, зайтай онгорхой бүхэнд нүд ирмэхийн зуур дүүрч байгаа тасалгаандаа Аурелиано ярих үгээ б бодон , ямар байдлаар хандвал үнмэжилтэй байх бол гэж эргэцүүлж , хамгийн аятайхан үеийг тааруулах гэж анавч Фернандатай гал зууханд пийшэнгээс хоолоо авч байхад нь дайраолдаж бөгөөд түүнтэй уулзах өөр боломж байхгүйг мэдсээр байтал бодсон юмаа хэлж чадахгүй хэл нь нагац ээжээ мөшгөх болов. Унтлагынхаа бөрөөнд Фернандогийн хөдөлж явахыг отно. Шуудан зөөгчөөс хүүхдүүдийнхээ захидлыг аваад, өөрийнхий гөө өгөхөөр хаалга руу явахыг чагнаж, шөнө дөо болтол цаасан дээгүүр үзэг тасралтгүй чахран гүйхийг чих тавин , унтраалага чад хийж, Фернандагийн уншдага уншиж эхлэхэд л маргааш хүссэнээ гарцаагүй бүтнэ гэж итгэлтэйгээр унттаг б айлаа . Аурелиано гаргахын Фернандагаар зөвшөөрүүлэх гэж туйлын их хүсэж байсан учир нэг өгдөө мөрөө хүртэл ургасан үсээ тайрч, бөөгнөрөн ширэлдсэн сахлаа хусаж, нарийн өмд өмсөж , гал зууханд ороод Фернандаг хоолоо авахаар ирэхийг хүлээж гардаа . гэтэл өдөрө бүр уулздаг толгой гэдрэг, алхаа нь чанга эмэгтэй нь биш харин өмссөн байшгүй үзэсгэлэн гоо эмгэн орж ирлээ . үүнийхээ өмнө уйлж уйлчихсан юм шиг царай нь шаналангүй ажээ . Фернанда Бага Аурелианогийн авдарнаас хивэнд идүүлсэн хатан хааны хувцас галибартайгаа гайхан толины өмнө эргэлдэж байгааг нь харсан хүн бол түүний галзуурч гэж бодохоор байсан боловч тэр галзуураагүй байлаа . Ердөө л тэр хуцвсыг өмсөхөд урьдын явдао ой ухаанд нь сэргэдэг байжээ . түүнийг өмсөхөд анх удаагаа зүрх нь шимшрэн , нүдэнд нь нулимс мэлмэрэн, түүнийг хатан хаан болгоно хэмээн аваачихаар ирсэн цэргийн хүний гутлаас ханхалж байсан тоос үнэртэх шиг болж, мөрөөдөө нь биелээгүйг санахдаа гунигладаг байлаа . Фернанда өөрийнхөө хөгширсөн , танагаа алдсан , энэ яваа насныхаа хамгийн сайхан үеэс хэтэрч холдсоныг мэдэж, тэр ч байтцугай амьдралынхаа хамгийн хар



үе гэж бодож байсан тэр үеийг санаглазуулан уйтгарлаж , салхинаар гонхонд тардаг байсан хахуун цэцгийн знэр, үдшийн бүрийгээр сарнайн бутнаас гарах, униар , түүгээр барахгүй мал шиг бүдүүлэг харийхан хүртэл хэчнээн дутагдаж байгааг сая л ухаарчээ .

Дагтаршин бөөгнөрсөн үнс гэлтэй түүний зүрх өдөр тутмын ажил төрлийнхамгийн хүнд цохилтонд ч тэмэж байсан мөртлөө өнгөрснөө санан гиюүрэн анхны түрлэтийг давалгүй бут үсэрчээ . Он жил улиран өнгөрхийн хэрээр уй гашуугаас аз ж жаргалыг олж авах гэж зүтгэсээр Фернандо зэвэрч гүйцээд , тийм муу зүршилтэй болжээ . ганцаардах болсноор сэтгэл нь зөөлөрчээ . гэвч тэр өглөө гал зууханд ороод , цонхигор , хэрзгэр залууг нүдээ жгтэй глалзуулан , аягатай зоце өөдөөс нь сарвайхыг харахдаа өөрөөсөө ичих шиг болж билээ

. Фернандо Аурелиана гадагш гаргаагүйгээр барахгүй даруулгаа хадгаладаг нууц халаасандаа гэрийнхээ түлхүүрийг авя явах болов. Аурелиано гарья л гэвэл сэм гараад эргэж ирж болох байсан боловч суусаар гадаад ертөнцөд игэхгүй болсон хүний үг дагаж сурсанг зэргээс болж үгнээс нь зөрж зүрхлэхгүй . Тэрбээр өрөөндөө эргэж ирээд Фернандагийн өрөөнөөс гүнээ шүүрс алдах чимээ шөнө дөл болтол гарахыг чагнан бичээдээ үзжээ . нэг

өглдөө урьдынхаараа пийүүнгээ галлах гэж гал зууханд орвол урьд нь Фернандог тавьсан хоол үнсэн дотор царцчихсан байхыг үзээд унтлагын хаа нь өрөөг шагайвал үен нөмөрөгөөрөө хуччихсан , уарай нв урьдынхаа үзэсгэлэнтэй болсон, хар арьс

нь гантиг шиг гөлийн гялтганасан Фернандо орон дээрээ сунан хэвтсэн байлаа . Хосе Аркадио дөрвөн сарын дараа Сазондод ирэхэд Фернанда яг тэр хэвээрээ байж байлаа .

Эхтэйгээ ийм үйлийн үргүй адилхан хүн байдгийг төсөөлөхөд бэвр. Хосе Аркадио нэхмэл хар косчоом, хатуу дугуй захтай цамц өмсөж, зангианы оронд цэцэглэн зангидсан нарийхан торгон бүч зүүжээ. Энэ бол цайвар царайтай, гайхангуй харцтай зориггүйг илтгэсэн уруултай, уйтгартай байрын хүн байлаа. Хутагт нарын хиймэл үс шиг хоёр тийш нь гилийлгэн хагалж самнасан гялтганасан хар үс нь хиймэл байдалтай, лааны тос шиг цагаан эрүүгээ мөлчийтэл хуссан нь хөхрөн байгааг харахад сэтгэл үргэлж зовж явдаг хүний шинжтэй. Судас нь ногоорон гэрэлтэх бэлцгэр цайвар гар нь ажил хийдэггүй хүний гарын байдалтай. Солгой гарынхаа долоовор хуруунд гэрэлт чимэд шигтгээтэй том алтан бөлзөг зүүжээ. Аурелиано хаалга нээж өгөөд, түүнийг их холоос иржээ гэдгийг дор нь таав. Урсула сохорсон хойноо түүнийг олж байхад амар гэж толгойг нь сүрчгээр угаадаг байсан тэр үнэр явсан газарт нь үлдэж байлаа. Хосе Аркадио олон жил эзгүй байгаад ирэхдээ яагаад ч юм гунигтай, ганцаардмал, насаа идсэн хүүхэд хэвээрээ үлдсэн нь нэг л ойлгомжгүй байв. Хосе Аракадио эхийнхээ унтлагын өрөө рүү шууд очив. Аурелиано хүүрийг үмхийрүүлэхгүйн тулд Мелькиадесийн жороор өвгийнхөө хэрэглэж байсан хөөрөгт дөрвөн сар мөнгөн ус буцалгаж байжээ. Хосе Аркадио юу ч асуусангүй, үхсэн эхийнхээ духан дээр үнсэж,

банзлын нь дотоод халааснаас хэрэглээгүй үлдсэн гурван даруулга, хувцасны шүүгээний түлхүүрийг авав. Итгэлтэй ширүүн хөдлөх нь түүний уйтгартай номой байдалд огт нийцэхгүй байлаа. Шүүгээнээс торгоор ороосон, зандан үнэртсэн овгийн сүлдтэй хайрцаг гарган авч нээвэл дотор нь урт гэгчийн захидал байлаа. Фернанда сэтгэлдээ хадгалж явсан бүхнээ хэлж, амьтдаа хүүгээсээ нууж явсан бүхнээ бичсэн байлаа. Хосе Аркадио эхийнхээ захидлыг босоогоороо ихэд сонирхсон янзтай боловч сэтгэл хөдөлсөн байдалгүй уншжээ. Гуравдугаар хуудсан дээр тогтож, Аурелианог шинээр танилцаж буй мэт анхааралтай харснаа,

-Тийм байж, бутач гэдэг маанв чи юу? гэж хахир дуугаар хэлэв.

- Би Ауредиано Буэндиа байна.

- Яв, тасалгаандаа оч гэж Аркадио хэлэв.

- Аурелиано өрөө рүүгээ ороод, Фернандиог оршуулахыг ч гарч харсангүй. заримдаа Хосе Аркадио амьсгаадсаар гэр дотуур явж байх нь гад зуухнб нэллтэй хаалгаар харагдаж, өмсөхрч муудсан унтлагын өрөөнөө алх ах яимээ нь шөнө дөл болтол дууллдаг байлаа. Аурелиано түүний дууг олон сар сонссонгүй, Хосе Аркадио түүнийг тоож ярьдаггүйгээс төдийгү Аурелианл ч түүнтэй ярих өчүүхэн хүсэл байхгүй, мөн бичээсээсээ өөро юм бодох зав ч үгүй байснаас тэр билээ. Фернандаг үхсэний дараа Аурелиано үлдсэн хоёр алдтан загасны нэгийг авяч, хэрэгтэй номоо авахаар каталон эрдэмтэний номын мухлагт очив. дурсаж бодох юм, үзсэнээ харьцуулах юм огт өайхгүй учир замдаа дайралдаж байгааг огт сонирхохогүй. Эзгүйрсэн гудамж, орхигдсон байшин нь ганцхан харах сан гэж хорхойсон байсан тэр үедээ сэтгэлдээ бодож байсан шиг нь харагдаж байлаа. Тэрбээр Фернандагийн өгөөгүй зөвшөөрлийг өөрөө өөртөө олгож, тэгэхдээ ганхцан удаа, цорын ганц хэргээр, хамгийн богино хугацаагаар гарахаар шийдэж, гэрээсээ урьдын цагт зүүд тайлдаг байсан нарийн гудамуж хүртэл арван нэгэн хорооллыг тувт гүйн өнгөрөөд бөгс эргээ зайгүй шахас новширсон харанхуй өрөөнд сэтгэлд догдлон орж явчихлаа. Энэ нь номын мухлаг бус, шоргоолжны идүүлж, аалзны шүлс хэрэгдсэн тавицур дээр, травур дээр төдийгү ш шалан дээр, тавиурын хоорондох давчуухан зайд хүртэл замбараагүй овоолсон хууин номын нийтийн булш мэт санагдаж байлаа. Зузаан зузаан судар хурааснаас хотойчихсон ширээнэ мухлагийн эзэн сургаалийн дэвтрээс тастаж авсан хуудсан дээр ягаан бэхээр нэг ю юмыг эх адаггүй, муруй сарий бичиж байна. мөнгөлөг сайхан үс нь какду шувууны өрөвлөг шиг дух ругаа унжжээ. сэргэлэн, онигор хөх нүдэнд нь ертөнхийн бүх номын уншсан хүний сайхан сэтгэлийн шинж тодорч байлаа. тэрбээр даг дотуур өмдтэйгээ хамаг бие нь хөлөрчихсөн сууж, орж ирж байгааг хүнийг ч харсангаүй. Аурелиано авсан ботиудаа халтан загасныхаа хамт дуугүйхэн сарвайвал каталон эрдэмтэг номын хуудсыг эргүүлж үзсэнэ э аньсага нь хясааны хавтасм мэт хамхигдсан “Чи галзуу байхаа”

гэж унаган хэлээрээ ахэлснээ мөрөө хавчисхийгээд Аурелианогийн ном, алтан зага эргүүлэн өгч ,

- Аваад яв, . Энэ хэдэн номыг хамгийн сүүлд уншсан хүн Сохор исаак л байх , тэгэхээр юу хийж байгаагаар сайн бодоорой гэж испаниар хэлжээ .

Хосе Аркади Мемегийн унтлагын өрөөг засаж, хилэн хөшиг , хааны орны торгон лаврийг нөхүүлж цементэн усан, сангийн хашлага , барзгар хар өнгөтэй болсон угаалгын өрөөн янзлуула . Унтлага , угаалгын өрөөгөөр өөрийн эдлэнг хязгаарлаж , тос болчихсон хачин сонин, юм , хямд сүрчиг, хиймэл эрдэнэс зэрэг шал дэмий юмаар дүүрэгжээ . гэрийн бусад өрөөн дэх юмнаас шүтээн дпээр байсан хутагт нарын баримлыг л анхаарч, яагаад ч юм сэтгэд нь таасрсангүй , нэг орой шүтээн дээрээс буулгаад гадаа гарган, үнс болол нь шатааж орхижээ . ихэвчлэн өдрийн арван хоёр цагт босно. Сэрээд алтан луу хатгамалсан хууин халааз өмсөж , алтан цацагтай улавч угалж , угаалгын өрөөнд ороод,% Сайхан ремедиосын угаал үйлдээд байсантай ади л удаан гэгч ёслол үйлддэг байлаа .

Усан санд орохын өмнө гургван цагаан шилнээс анхилуун давс усанд цацааад .

Тэрбээр угаал хийхдээ Сайхан Ремедиос шиг тарвасны хальсан савраар дээ рээсээ ус хийдэггүй тансаг үнэрт цусан дотор бүр ороод хоёр цаг дээшээ харан усны сайханд бүүвээлэглэн хэвтэж, Амарантаг боддог байылаа .

Ирснээсээ хойш хэд хэдэн хоноод эндэх нцтагт дэндүү халуудах цайны ганц нэхмэл косчоомоо тайлж, Петра Креспийн бүжиг заахдаа өмсд өг байсаннархуу нарийн өмдп өмсөж, овог нэрийн эхний үсгийг хатгсан жинэхэнэ торгон цамц өмсөх болов. Энэ хувсаа долоо хоногт усан санд хоёр угаагаад , өөр солих ээлжийн хувс байхгүй тул хатаагаад , халайзтайгаа явдаг байлаа .

Хосе Аркадио гэртээ хоол огт үл иднэ. үдийн бүгчим халдуун намдмагц гэрээс гарё , шөнө орой болсон хойно буцаж ирээд , тасалгаан дотуур хүндээр амьсгаадан , Амарантаг бодсоор гиюүрэн явдаг байлаа . төрсөн гэрийнх нь тухай сэтгэлд нь үлдсэн юм гэвэл Амаранта, шөнийн дэнгийн гэрэлд аймаар гялтгангах хутагт нарын ншд, энэ хочр л байлаа . ромд наймдугаар сарын сүүмгэр шөнөөр Амарантаг тороно банзалтайгаа гантиг хашлага усан сангаас гараал д , гараа боосон чигээрээ цөлийын хүний байдалтай уйтгардан явж байгаагаар олог ч удаа зүүд, сэтгэлдээ үзжээ . Аурелиано Хосе Амарантагийн дүрд дайны цуст намагт живүүлэн мартах гэж оролдсон боловч Хосе Аркадио эхийгээ лам болох тухай үлгэрээр хуурах зуураа сэтгэлийнхээ гүнд тэр дүрийг амьдаар нь хадаглах гэж оролдож байлаа . Захидалдаа санаанаасаа зохиосон юмыг л бичиж байснаа тэр ч мэдсэнгүй . Фернанда ч мэдсэнгүй . ромд очисоныхоо дараа Хосе Аркадио шашны сургуулиас гарч, эхийнхээ

солиот захидалд үргэлж дурдах хэмжээлшгүй өвийг хураахбг  
тулд шашинб ухаан, хууль жаячгийг судалсаар байгаа тухай худал бичсээр  
байжээ . тэр хөрөнгийг өвлөвөл ийм тарчиг ядуу  
байхыг өөлж, хоёр найзтайгаа суудаг Трастверийн гудамжны бохир байши  
нгийн дээврийн хөндийгөөс гарч чадах байлаа  
. Фернандагийн үхэхээ мэдэж бичсэн ёүүлийн захидлыг аваад тансаг ббай  
длийг үзүүлэгч хувцасныхаа навтгарыг жумдаандаа эвхэж хийгээд цагаачдын  
хүйтэн ноймон, өтгөн бяслаг зулсаар ярганы үхэр  
шиг шахалдан яваа хөлөг онгоцны хөндийд суун далайг гаталжээ  
. Фернандагийн  
зовлонгоо хожимдуулсан ширхэгчилсэн тоочсон гэрээсийг гүйцэд уншилгүй  
гээр салж унасан тавилга хөсрийн өвсөнд идэгдсэн гонхыг үзээд л  
гарахгүй, Ромын хаврын очир эрдэнэ мэт туячарах гэрлийг хэзээ  
ч үзэхгүй , эртний амьсга шингэсэн агаараар  
нь амьсгалахгүй гэдэгээ мэджээ . мэнгэр  
нь хөдлөн тамираа тасартал ханиалган нойроо хулжихад зөнөсөн Урсулагий  
н өөрийг нь юм бүхнээр айлгадаг байсан баргар байшин дотуур лай  
ланчгаа дахин дахин хэмжин алхдаг байлаа . Урсула , Хосе Аркадио  
харанхуйд алдчихна гэж айхдаа унтлагын өрөөний мухарт шигдэн суудаг б  
олгон сургаж, “Энэ  
бол бүрий болохоор үхдэл гарч ирэн, гэр дотуур тэнэхдээ шагайдаггүй га  
нц газар” гэж хэлжээ. “Чи муу юу хийвэл хутгагт нар надад дор нь нь  
хэлнэ” гэж урсулаг сүрдүүлдэг байлаа . Багадаа тэрбээр энэ буланд унтах  
цаг болтол, хутагт нарын хүйтнээр цоо ширтэхэд сүнсгүй айж мухар сандал  
дээр хөдөлгөөнгүй суудагб айлаа  
. хосе Аркадио ингэж давхар зовоохын хэрэг байсангүй . учир нь тэр үед  
Хосе Аркапиог ингэж давхар зовоохын хэрэг байсангүй . учир нь тэр үед  
Хосе Аркадио орчин тойрондоо байгаа бүхнээс айдаг, амьтны дургүй  
хүргэсэн гудамжны хүүхэн, гахай сүүлтэй хүүхэлд, гаргадаг  
гэрийн эмэгтэй, заримыг нь үхүүлж салдаг нөгөө заримыг  
нь насан туршпаа гэмшиж ява болгодог зодооч тахиа, дөнгөж барингуут л  
хорин жид дайтахад хүргэдэг галтг зэюсэг , заавал урам хугалж ,  
гудзууруулж дуусдаг ойвгүй санаанаасаа, эцэст нь эзэн тэнгэрийн  
хэмжээлэшгүй сайхан сэтгэлээр бүтээгээд ,  
чөтгөр шулмын завхруулчихсан бүхнээс нэгэнт айдаг болсон байжжээ .  
Өглөө нь хар даран зүүдлээд зовж зовчихсон сэрпэг байсан  
боловч цонхооро тусах  
нарны гэрийн харж өөрийг усан санд оруулах Амарантагийн зөөлөн гарыг  
хүрэхэд шөнийн айдас ньаога болдог байлаа  
. Наранд булхсан цэцэрлэгт Урсула хүртэл огт өөр болчихсон , өөрийг нь ц  
элдэв аймаар юм  
ярьж айлгахаа болиод, пап ламын шиг яралзсан инээмсэглэж байг гэж  
шүдийг нь нухсан нүүрсээр угааж, дэлхийн дөрвөн зүг, найман  
зовихсоор Ромд очсон мөргөлчид “Пап ламын гараа  
ямар цэвэрхэн байлгадаг юм бэ” хэмээн гайхаг гэж хусцмсыгнь  
аьч, өнгөлж дад ламаас дутуугүй сайхан үнэртэг гэж сүрчиг шүршиж өгдөг

байлаа . пап ламын , Касьельгандольфо ордны тагтан дээрээс мөргөлчин олонд долоон хэлээр аврал айлдаж байхыг үзэж, үнэхээр их цагаарч , зуны баринтаг нь нүд гялбам гял цал хийж байгааг хэрэ, тансаг сүрчгийг анхилуун үнэрийг үнэртэж билээ .  
Хосе Аркадио төрсөн голостдоо ирснээс хойш жил шахам болж , мөнгөн цэцэглэг дэн, сүлд чимэглэл хөтөвчөө (Үнэнийг хэлэхэд, хөвөөчний шигтгэмэд сүлд л алт байжээ) үарж идээд хотын хүүхдүүдийг гэрт цуглуулан зоргоор нь тавьж зугаагаа гаргах болжээ . үдийн амралтын цагаар тэрбээр тэднийг цэцэрлэг дэх олсон дээгүүр хара йлгуулж , гонхонд дуу дуулуулж , олбогт сандал, буйдан орон дээгүүр хөлбөрүүлж , тэднийг хэсэш хэсгээр нь сайн юманд сургадаг байлаа . нарийн өмд , торгон цамц хэийн тайлж арабчуудын мухлагаас авсан жирийн косёчоом өмсөх болсон боловч намбаа хадгалж, пап ламын төрхөө тавиагүй байлаа . ХҮүхдүүд Мемегийн найз охидын адил тэднийд дорхноо дасжээ . үдэш орой болтол хүүхдийн дэмий чачах дуу , дуулдар товшуур бүжиг хийх нь сонсдож , тэднийх сахилга гэж байхгүй дотуур байртай сургууль шиг л байдаг байлаа . Эхлээд Аурелиано тэдний тийнхүү даварч байгааг анзаарахгүй байсан боловч гийчи Мелькиадесийн өрөөнд хүрчээ . нэг өглөө хоёр жаал хаалгыг нээгээд , юм уншин суугаа үс ноос болсон балиар хүнийг хараад айжээ . Тэр хоёр орж ёадаагүй боловч тэр жигтэй хүнийг сонирхон болов. тэгээд хаалганы дэргэд шивэр авир хийж, салхивч ны ячнз бүрийн муухай юм тасалгаан руу шидэж, нэг удаа хаалга, цонхыг гадааёс хадаж орхисонд Ауреллиано хагас өдөр ноцолдож баймааж нь гар билээ . Өөрсдийг нь залхааж эсгээхгүй байгаад эрэмшин, , бүр зориг ороод , Аурелиано гал зууханд байх хойгуур нь дөрөв н бичээсийг устгах гэж тасалгаанд оржээ . Гэвч шарласан цаастай бичээсийг шүүрээд авмагц нэгэн далдыбн хүч тэднийг дээш өргөн, Аурелиано эргэж ирэн, бичгийг тэдний гараас булаан автал хийд байлгажээ . Түүнээс хойш тэд түүнд төвөг удсангүй .  
Хэдийгээр арван хэдэн нас хүрч байгаа ыболовч өмдөө тайлаагүй яваа дөрвөн хөвгүүн Хосе Аркадиолгийн царай зүсийг янзалж өгнө. тэр дөрөв өглөө эрт бусдаасаа түрүүлж ирээд, сахлыг авч, халаасан алчуураар биеийг нь зү олгэж , үсийг нь засаж, гар хөлийнх нь хумсыг өнөлж, сүрчиг цацаж өгнө. заримдаа түүнийг усан дээр дээш харан хөвж, Амарантаг бодож байхад тэд усан санд орж, хөлөөс толгойг нь хүртэл савандаж өгнө. дараа нь биеийг энх хуурай ыболто арчиж , оодоод хувцаслана. Тэдний нэг, долгионтсон шаргал үстэй , чандага шиг цэхэр ягаан нүдтэй хүү ихэвчлэн тэднийд хононо. Тэр хүү Хосе Аркадио туйлгүй дасчихаад , мэнгэр нь хөдлөн нойргүй хонож б айхад дэргэдээс нт холдохгүй , харанхуй өрөөнүүдээр хамт хэрэн явдаг байлаа

. нэг шөнө Урсулагийн унтлагын өрөөнд орвол газар доорх нар шалыг хагархайгаар гарч байхыг ажиглаж . Ямар учиртайг үзэхийн тулд дэнлүү асаах ч хэрэгб айсангүй . хоёул Урсулагийн оо байсан хамгийн хурц гэрэл гарч иржээ . Зэс утсаар амсрыг нь боосон гургван бээжээнхэн хүүдийлд долоон мянга хоёр зуун арван дөрвөн зоос цог аятай харанхуйд гялтагнан байлаа . Эрдэнэсийг олсон нь зүйрлэвээс шөнийн харанхуйд галын хурц гэрэл хялсхийх мээ болсон ажгуу . гэвч ядуу байхдаа мөрөөдөж байснаараа гэнэт тэнгэрээс унасан баялагаа аваад ромд буцахын оронлд гэрээ амниачхан диваажин болгожээ . хилэн хөшиг болон унтлагын өрөөний лаврийг шинэчилж , угаалгын өрөөний шалыг хавтангаар өнгөлүүлж , ханыг паалантай тоосгоор бүрүүлэв. Хоолни өрөөний шүүгээндээ чихэр жимс, , утсан мах дармал хүнсний зүйл овоолж цоожилчихсон байсан агуулахдаа дахин нээж, дарс тэргүүтнээ дүүргэлээ . Эдгээр ундааг Аракиогийн нэртэй хайрцагт хийн төмөр замын өртөөн пээр хүргэн ирж, тэрбээр өөрийн биеэр очиж авдаг байлаа . нэг шөнө дөрвөн хөвгүүнтэйгээ үүр цайтал найралжээ . Өглөөний зургаан цагт унтлагын өрөөнөөс шалдан гарёч усан сангийн усыг асгаж, оронд нь шампан дарсаар дүүрэгжээ . хөвгүүд усансанд руу үсрэн орцгоож анхилуун үнэрт хөөс бүрхсэн алтлаг тэнгэрот сүрэг шувуу наадах мэт дураар тонгочиж , тэдний шуугилдан хөгжилдсөөр зайдуухан хосе Аркадио Амарантаг сэрүүнээсээ зүүдлэн, бодол болж дээшээ харан хөвж байлаа . хөвгүүд дорхноо цуцаж, бөөнөөрөө унтлагын өрөөнд орж, хилэн хөшгийг нь хуу татан , биеэ арчин хоорондоо ноцолдож , байж, үнэт толийг нь хагалаад , цугаараа орон дээр гаран овоороллдсон даврийг нь унагжээ . Хосе Аркадиог ирэхэд, түйвээж сүйтгэсэн юмныхаа дунд атиран унтацгааж байлаа . Эдвэж ёсүйтгэснийг ххаран харуусахаасаа ингэж утгагүй наргин, шалдаа буусан өөрийгөө авдрын ёроолд биеийг нь хатуужуулах өмсгөл, мах бодийг гэсгээх , гэмшүүлэх янз бүрийн төмөртэй хамт хэвтэж байсан торлогийн авч, галзуурсан юм шиг бархиран, хайртай байсан хүүхдүүдээ сүрэг цөөвөр чоныг ч ингэж занчихгүй биз гэж санагдмаар шалба туушиндан , гэрээсээ хөөж гаргав. Тэрбээр ганцаараа үлдэж, мэнгэр нь хөдлөн хэд хоног намдахгүй зовоов. Нэг их ханиалгах нь гайгүй болоод байлаа . гурва хоног дээрээ тэнхэл барагдаж дотор багтрахыг тэвчиж чадахгүй орой нь Аурелианогийн өрөөнд орж, “Оройн эмийн сангаас хоолой утах нунтаг авчирч өгч тус болооч” гэж гуйжээ . Аурелиано хоёр дахиа гадаа гарсан нь энэ байжээ . тэр хоёр хороолол гүйгээл л латин бичигтэй шаазан сав тавьсан давчуухан эмийн сангийн тоос болсон цонх харагдсанд дотогш орвол нийтийн могой шим гилбэлзсэн бүсгүй Хосе

Аркадиогийн цаасны тасархай дээр бичсэн эмийг авч өгөв. Энэ удаа ч Аурелианогийн дэнлүүний шар гэрэд тусах хоосон гудамжийг аанай л огт сонирхосонгүй. Аурелианл зугтчихлаа гэж Хосе Аркадио эхлээд бодож байтал цаадах нь аахилсаар, удтал гаралгүй сууснаас шавар

шиг болчихсон хөлөө зөөж ядсаар орж иржээ Аурелиано орчин тойрондоо байгаа юмыг илэрхийлээ хайхарахгүй байх тул хэдэн өдрийн хойно Хосе Аркадио эхийнхээ захисныг зөрчиж, түүний “Дуртай цагтаа гад агш гарч бай” гэж хэлжээ.

- гудамжинд би үүнийг хийх вэ гэж Аурелиано хариулжээ. тэр аанай л түгжээтэй суун, эртний бичээсээ үзэн бага багаар тайлж байсан боловч утгыг нь тайлбарлаж бас л чадахгүй байла. Хосе Аркадио тэр даяанчид өрөөнд нь зүсэм гахайн утсан мах, аманд нь хаврын амт үлдээх чихэртэй авчирч өгч, тэр ч байтугай жүнз сайн дарс хоёр ч аваачиж өгчээ. хосе Аркадил дураа хүртэл л үзэж болох зүйл игээд бичээсийг төдий л хайхарахсангүй боловч ховорхон эрдэмтэй, ертөнцийг гайхалтай мэддэг шооводор садангаа сонирхон болжээ

. Аурелиано англи

гадарладаг болоод бичээсийг судлахынхаа завсарт нэвтэрхий толийн зургаан ботийг сонин роман уншиж байгаа вч шиг хуудас алгасалгүйгээр уншжээ. Аурелиано нэвтэрхий тоь унүсаны хүчинл л Ромыг хэзээ язааны сууж байсан ю шиг мэддэг болсон байх гэж Хосе Аркадио эхлээд санаж байсан боловч нэвтэрхий толиос мэдэх аргагүй зүйлийг, тухайлбал юмны үнийг хүртэл мэддэгийг нь удалгүй мэджээ. “Үүнийг юунаас олж мэдэв” гэж Хосе асуухад Аурелиано нь Хосе Аркадио тасалгаагаар явж байхыг нь хөндийхнөөс хардан байснаа ойртож танилцаад ирэхдээ анх бодож байснаас нь шал өөр байсанд гайхжээ. Хосе Аркадио инээдэг, гэрийнхээ баян тансаг байсныг үе үе санан уйтгарлан, Мелькиадесийн өрөө ингэж хогондоо дарагдах гэж халаглан санаа алддаг байлаа. Яс махны тасархайы энэ хоёр аглагч ойртлоо гээд дотно болтлоо өдий байсан боловч ганцаардан зовохоо болтжээ. Үүнээс хойш Хосе Аркадио, Аурелианонтой аан уун гэж даруй, хиймээр байвч халган төвөгшөөдөг байсан гэрийн зарим ажилд түүгээр туслалцуулахаар боллоо. Аурелиано хувьд бол гонхонд суун, юмаа унших, Амаранта Урсулагийн нямбай, нь аргагүй явуулсаар байсан захиаг авах, Хосе Аркадиогийн урьд нь оруулдаггүй байсан угаалгын өрөөндз угаалга хийх боломжтой болов.

нэгэн халуун өдөрт тэр хоёр хаалга сандрангүй болбах чимээ нээр сэрэв. Хаалгыг нэгэн танихгүй өвгөн цохисон байлаа. Том ногоон нүд нь төвшин царайн дунд сүүмийн гэрэлтэж, духан дээр нь үнсэн загалмай харлана. Тэр хний навтас болсон хувцас, элэгдэж майжийсэн гутал, үүрч яваа ганц тулмыг харахад гуйлагчин вмуу гэмээр боловч гадаад төрхтэйгөө огт авцалдахгүй омог бардам байдаолтай ажээ. Энэ хүн биеэ хамгаалах зөнтэйгөө бус, ямагт айгаад сурчихсанда амиа тэжээх яваа юм байна гэдэгт нь зочдын өрөөний сүүмгэр гэрэлд ч

халт харахад л мэдэгдэж байна. Энэ бол  
хурандаа Аурелиано Бцуэндиагийн арван долоон хүүгээс  
ганцаараа амьд үлдсэн Амраг Аурелиано байлаа .

Тэрбээр оргуул босуул байдлаар махаа идэж, элдэв юманд өртчих вий гэж  
айж болгомжлох явсаар хөл, хөл ижийж амсхийх хүслэн болжээ . тэр  
нэрээ хэлээд, нойр энэ л гэрт орогнуулаач гэж гуйжээ .  
гэвч Хосе Аркадиол Аурелиано хоёр энэ садангаа танихгүй учир  
тэнүүл амьтан байна гэжсанаад гудамжинд түлхэн гаргав.

Тэр хоёр хаалган дээр зогсож , хосе Аркадиогийн төрөхөөс өмөн  
эхэлсэн эмгэнэлт явдлын тайллыг үзжээ . гудамжны нөгөө  
этгээд байгаа ыбүйлэийн модон дотроос Амраг Аурелианог олон жилийн  
турш анч нохой шиг авалж , мөрөөр нь мөшгөн хөөж явсан цагдаагийн хоёр  
төлөөлөгч духны хэрээсийг яг онож түрүүлгээ харан уналаа

Хосе Аркадио хүүхдүүдийг хөөж явуулсанаас хойш христосынмэндэлсэн ө  
дрөөс урьд Неапаль орох санаатай Атлантын далай гатлах хөлгийн сураг  
гарахыг хүлээж байна. хосе Аркадио энэ  
тухай Аурелианог хэлж, Фернандаг үхсэнээс хойш сагстай идэх  
м ирэхээ больсон учир Аурелианод амь зуугаад байхаар нэг худалдааны юм  
нээж өгөх гэж балйаа . гэвч түүний сүүлчийн энэ мөрөөдөл биелэх  
учиргүй байжээ . Есдүгээр сарын нэгэн өглөө Хосе Аркадио ,  
Аурелианотай гал

зууханд аяга зкофе уугаад, угаалгын өрөөнд угаалгаа үйлдэж дуусаж  
байтал вааран дээврийн цоорхойгоор гэрээсээ  
хөөж явуулсан дөрвөн хөвгүүн үсрэн буу , яах  
ийхийн зуургүй хувцас хунартайгаа усан сан  
руу харайн орж, түүнийг үсдэж аваад , толгойг нь усан лотор дарж, усны  
гадрага дээр хийн бөмбөлөг үзэгдэхээ больж папын  
шинэ залгамжлагчин цайвар биеийг анхилуун усны ёроол руу шингэтэл ба  
йлгажээ . Дараа нь тэр дөрөв болон хэлмэгчдийг өөр хэн ч үл мэдэх нууцаас  
гурван шуудай альыг аван арилжээ . Энэ  
бүхнийг цэргийн маягаар маш шуурхай охино байгуулалтай  
, зэрлэг байдалтай амжуулжээ .

Аурелиана цоожтой сууж байсан болохоор юу ч сэжиглэсэнгүй . орой нь л  
гал зуцухандаа ирэхдээ хосе Аркадиог үгүйлж , гэрээрээ нэг хайгаад ,  
угаалгын өрөөнөөс олжээ .  
хөөгөөд пиндийчихсэн Хосе Аркадио Амаранөдатг бодсоор усан  
сангийн анхилам үнэрт мандал дээрo хөвж байлаа . Аурелианл түүнд  
дассанаа сая л ойлгожээ .

\*\* \*\* \*

Арван хоёрдугаар сарын эхээр  
Амаранта Урсула хэлж дуулгасан юмгүй аясын салхинд туугдан гэртээ гэнэт  
буцаж ирвэй . тэрбээр нөхрөө хүзүүгээр нь торогон уяагаар оосорлон хөтөлжээ .  
Зааны ясан өнгөтэй палааж өмсөж өвдгөө хүрсэн сувдан зүүль хүзүүндээ зүүж, дугу  
й тайрсан үсээ хацар руугаа харайцайн даль шиг унжуулжээ .



Хагас жилийн өмнө түүтэй суусан хүн бол далайчин байрын гоолиг нуруутай фламанд нутгийн иэдрхэн эр байлаа . Амаранта Урсула зочдын өрөөний хаалга нээгээд л арай оройтож ирж, гэр нь санаснаас имлүү доройтож гэдгийг мэдлээ .

-Тэнгэр минь ээ! Бүсгүй ахүн байхгүй гэдэг нь илт байна гэж харамсангүй гэхээсээ баясангүй дуу алджээ .

Түүний авч ирсэн юм нь гонхонд багтсангүй\_ Амаранта Урсула Брюссель орохдоо авч явсан хуучимн авдарнаасаа гадна хуцвасны хоёр шүүгээ , дөрвөн том жумдаан , шуудай шүхэр, найман хайрцаг бүрх малгай , асар том том тортой тавин ширхэг бялзуухай , залдан тусгай дугтуйтай хийгээд эхил хуур шиг бариад явчихаж болдог унадаг дугуй авчиржээ .

Нөхрийнхөө жолоочийн бусад хэрэглэлийн хамт авчирсан хуучирсан зотон бадайг өмсөж, гэр орноо тордон домдож гарлаа . Гонхонд эзэгнэж гүйцээд байсан улаан шоргоолжийг хөөж, сарнайн бутыг сэргээж , хогийн өвсийг үндсээр нь зулгааж, цэцгийн мандалд ойм , хахуун , хайтан дахин суулгаж хэсэг мужаан засварчин, тоосгочин чулуучин г удирдан шалны завсар зайлхайг бөглөж, цуонх хаалгыг өлгөж, тавилга тэргүүтэнг засаж, ханаа гадна дотроос нь шохойдож , ирснээсээ хойш гурван сар гэхэд гэрэ зоньст хуур тоглож байсан үеийнх шигээ үалуу насны баяр баясгалан бялхаан сайхан байдалтай болголоо . хэдийд ч яаж ч байлаа гэсэн дандаа сайхан аашилж , үргэлж дуулж, бүжиглэж байдаг, хуучирсан эд, хуучирсан заншлыг хог дээр хаяхад бэлхэн Амаранта Урсулаг оршуулгын зүйлийн үлдэгдэл, буланд овоорсон хэрэгцээгүй новшийг ргаргаж хаяад, Урсулаг хүндэлдэгтэй л Ремедиосын зургийг өлгөөтэй хэвээр нь үлдээжээ .

“хараач ямар гоё вэ! Элэнц ээж маань арван дөрөвтэйдөө багйаа нь энэ !” гэж амаранта Урсула элгээ хөштөл инээн хашгирна. Гэрт буг чөтгөр оргоносон уир нуусан эрдэнсийг нь эрвэл тэднийг ганц айлгаж болзо гэж нэгэн чулуучин ярихад Амаранта хоёронтоо тас хийтэл инээд алдах зуураа эрэгтэй хүний мухар сүжигт итгэдэггүй гэж хэлжээ . Амарантагийн туйлын шулуун шууд, туйлын толгой даасан , туйлын орчин үеийн болсны Ажурелиано хараад нүүрээ хийх газар олохгүй сандарчээ . Амаранта гараа дэлгэж “Пөөх , хараач гэм! Миний хайртай махчин ямар том болоо вэ?” хэмээн хашгирчээ . Аурелиано чамин бүжиг зааж гарав. Хурандаагаасүлдсэн тос болон өмдийг эь тайлууль , цэцгэн хээтэй цамч, дэгжин гоё шаахай бэлэглэж түүнийг гудамжинлд хөөн гаргажээ .

Урсула шиг жижхргнэн , сэргэлэн мохошгүй , Сайхан Ремедиосийн гоо үзэсгэлэн , сэтгэл булаахы хувьд бараг дутахгүй Амаранта Урсула хувцсаны з загварыг урьдаас таах ховорхон авъяастай байлаа . Шуудангаар ирж байгаа хувцсаны загварын сүүлийн сэтргүүлийг үзэхэд өөрийн нь зохиож , Амарантагийн элин галавын машинаар өөрийн нь оёсон загвартай яг таарч байдаг байлаа Тэрбээр Европт гарч байгаа хувцасны загварын бүр сэтгүүл, урлаг, хөгжмийн бүх хэвлэлийн захиалж ном сэтгүүлийг авъяастай эмэгтэй тоосонл дарагдаж , ган ганчин сүйрэн голомт , нь цайж байгаа энэ хотод буцаж ирэв. Тэгэхдээ ертөнцийн хаа ч аж төрөхөд бардаагаар хүрэх хөрөнгөтэй нөхөр, өөрт

нь туйлыбн хайртай учир хүзүүнээсээ торгон уяагаар оосорлуулаад явахаа тоохгүй тийм нөхөртэй эргэж ирэв гэдэг нь ухаанд багтахгүй байлаа .

Гэвч өдөр хоног өнгөрөхд Амаранта Урсулаг Макондодоо суурьшаж , тухтай сайхан аж төрж, тавтай сайхан насаа элээх гэж хамаг байдгаараа эрмэлзэж байгаа нь тодорхой боллоо . Тортой шриг бчлзуухай авчирсанаас үзэхэд гэнэт тэгж шийдээггүй нь илт. Эхийнхээ , нэг захиандаа шувуу үхэж дууссан гэж бичсэнийг санаад , Европт хэдэн сар саатан , канарын арал дайрах хөлөг онгоцны хүлээж , түүгээр орохдоо хамгийн үүлдэр сайтай хорин таван хос блзуухай худалдан авч, Макондогийн тэнгэрт тавих гэж боджээ . Түүний үүсгэсэн юм нэг л бтэхгүй байсны дотроос хамгийн бүтэлгүй нь энэ байжээ Шриг бялуухай үржих бүрийд нь дараа дараагаар гарган тавивал шувууд суларсаар мэдэнгүүтээ хотоос нисээд явчихаж байлаа. Байшингаа бүр анх өргөтгөж байх үед Урсулагийн захиалж хийсэн торонд идээшлүүлж гэж оролдоод ядчихав. Бүйлсний мөчирт хивгээр хэчнээн ч үүр засаж өлгөөд , башингийн дээвэр дээр хэчнээн ч үр цацаж бариад , торонд байгаа бусдыг нь өдөөж жигүүртэн оргодолуудыг эргүүлэх гэж яаж ёч оролдоод нэмэргүй , суларсан ширг бялзуухай дээш байгааг эдэх гэж л хотын дээгүүр нэгэнтээ тойрон нисээд алга болдог байлаа .

Амаранта Урсулаг буцаж ирснээсээ хойш жил тойрон болж байгаа болвч макондагийнхонтой ойртож ч найрлаж цэнгэж ч ёадсөөнгүй .Гэхдээ зовлон нүүрлэсэн тэр хмүүсийн амьдарахаар хүсэлтэй болгожэ чадна гэж найдсаар л байлаа . Түүний нөрөр Гастон тэр нэгэн шатам халуун үдээр Макондод галт тэрэгнээс буухдаа эхнэрийнхээ нутгаа санаад л тэгж зүтгэснийг ойлгсон боловч элдэв юм сэдэхэд нь саад хийдэггүй байлаа .

Байдлыг үзэд ирэхлээрээ хоосон мөрөөдлөөс ангижирна биз гэж итгээд , унадаг дугуйгаа л угсарсангүй аалзны хамгийн сайхан өндөг олох гэж чулуучин , тоосгочин нарын ханаас шүүрдэн хаясан аалзны шүлсийг өдөржин ухдагб айв. Дараа нь түүнийг хусаараа уоолж, дотроос нь гарч гүйх олон жижиг аалзыг томруулдаг шилээр уйгагүй хардаг байлаа . Сүүлдээ Амаранта Урсулаг тэвчээртэйгээүзэх гэж л нгэж байна гэж бродоод, солжир дугтуйдаа ундаг дугуйтай угсарч , завтай уагаараа нутгийн шавьж хийж урьд шавжийн ухааныг нэлээд улта үзэхэд нь багшилж байсан Льежийн их сургуулийн өвгөн профессорт явуулдаг боллоо. Унадаг дугуйгаар явахдаа Гастон уран нурагчийн бие барьсан хувцас , хөгжимёчний оймс, цагдаагийн саравяит малгай өмсдөг байлаа . Явгаар гадагш гарахдаа цэв цэвэрхэн ёрог косчуум , цав цагаан шаахай , торгон зангиа, сийрсэн бүрх мөсөж, шинэ таяг барьдагб айсан. Тэрбээр нүд цэхэр агаад үүгээрээ далайчны улам адил харагдана. Живэр сахал нь хэрэмний үс шиг шаргал. Эхнэрээсээ наана хэлэхэд арван тав ах боловч залуурхдаг , эхнэрийнхээ төлөө гүйхэд хэзэ ч бэлэн , сайн эр хүний байдалтай учир үе мултарсан гэхээргүй харагддаг байлаа . хянуур болгоомжтой , хүзүүндээ оосортой , циркийн дугуйтай дөч дарсан тэр эрийг залуу эхнэртэйгээ хэдийд л бол бэлгийн ажил хийж байхаар тохирч , хуялаа хөдөлсөн үед хамгийн тохирможгй газарт ч харилцан дураа хангаж байдаг гэж хэнч бодохгүй биз ээ . Тэр хоёр анх танилцсан цагаасаа ахойш ингэсэн ,

тэгэхдээ цаг хугацаа улирч амьдралын ер бусын нөхөлтэй  
тулгарах тусам энсэн хурьцах нь цлам таяьяангүй , улам уран болж иржээ .  
Гастон тийнхиүү ургуулан болдох шавхагдашгүй ухаантай , урин  
тачаангүй эрдэмт төгс боловсорсон махруу амраг төдийгүй хнил  
цэцэг алагласан нугад янагийнхаа хамт цаашаа харуулах шахан  
байж онигор цэцэгт нугад буулгаж зүрхлэсэн түүхэнд цорын ганц эр хүн байлаа .  
Тэр хоёр хуримнаасаа гурван жилийн өмнө танилцжээ . Нэг  
удаа Гастон Амаранта Урсулагийн сурч  
байсан сургуулийн дээгүүр спортын онгоцоор эгэлдэн хөөрч байгаад , тугны  
иш мөргөчихгүй гэж жолоогоор огцом мушгиж , зотон хөнгөн цагаан хоёроор  
хийсэн бүдүүлэгхэн төхөөрөмж нь сүүлээрээ утсанд тээглэн хийд тогтжээ . тэр  
өдрөөс хойг ГАстон хөлөө чиг барьж боолгосноо ч тоохгүй бямба, гариг  
бүр Амаранта Урсулаг авахаар дотуур байранд нь очиж, дотуур байрны  
дэг журам Фернандогийн бодсоноос хавьгүй сул байсныгш  
далимдуулан бүсгүйг авч, спортын клубтээ аваачдагб айлаа . Цэнгэг сайхан  
агаарт таван зуун метрийн өндөрт байхдаа хоёулаа бие биедээ хайртай болсноо,  
газрын ювмс жижигхэн хэрээр нэг нэгийнхээ улам ойлгох болжээ  
. Амаранта Урсула Макондог энэ ертөнцийн ахмгийн сайхан, тайвдан хот  
гэж гэрээ, хахуун анхиилсан асар байшинтай гэж Гастонд хуучилж үнэнч  
сайн нөхөртэй суугаад тэндээ Аурелиано , Хосе Аркодио бус , Родриго ,  
Гонсало гэсэн хоёр дүрсгүй хүү, Ремедиос бус, Виргийн гэсэн  
охин төрүүлээд насан зүг болтлоо байх юм сан гэж ярдаг байлаа .  
Амаанта Урсулаг төрсөн хотынхоо байдлыг сэтгэлдээ байнга үзэж , эх  
нутгаа санасандаа бүр ч гоёор бодож  
байгааг Ганстон мэдэхрдээ макондод хамт очихгүй бол эхнэр нь болохыг  
зөвшөөрөхгүй нь гэж ухаарчээ . тэрбээр үүнийг нь цагийг нь  
олол хориглох хэрэггүй түр зуурын адайр ааш гэж үзэж байсан тул сүүлд  
нь хүзүүгээ оосорлуулсан шигээ аягыг нь дагаж билээ . Гэвч  
Амаранта Урсулаг нөхөртэйгээ Макондод хоёр жил болоход анх  
ирсэн өдрөөсөө ялгаагүй цуйдах янзгүй байсанд гастон баахн түгшиж эхэлжээ  
. Макондод хоёр жил болоход анх ирсэн өдрөөсөө  
ялгаагүй уйдаах янзгүй байсанд Гастон баахан түгшиж эхэлжээ. Макондонд хатааж болох  
бүх шавьжийг хатааж, испаниар нтгийн хүн шиг ярьж сураад, шуудангаар ирж байгаа  
сэтгүүлийн бүх үгийн сүлжээг бодож байлаа. Үдээс хойших халуунд ч, үмхий самхай  
усанд ч үл ажрах элгийг байгаль ээжээс өөрт нь заяаж, колони нутагт суухад таарсан бие  
хайрласан учир Гастон цаг агаар халуудаж байна гэж буцахыг шавдуулах аргагүй байлаа.  
Нутгийн хоол түүнд зохиж, тэр ч байтугай нэг удаа игуан гүрвэлийн наян хоёр өндгийг  
шарж идэж билээ. Амаранта Урсула загас, хясаа, нөөшилсөн мах, хандалсан жимснээс өөр  
юм идэж ууж чадахгүй тул эдгээрийг мөстэй хайрцаг, төмөр лаазанд хийж, галт тэргээр  
авчруулдаг байлаа. Тэрбээр гарах газаргүй, очих айлгүй, хэдий боловч европ маягаар  
хувцаслаж, хувцасны загвартай сэтгүүл захиалсаар байлаа. Энэ нутагт болохоор Гастон  
богино банзал, хазгай дарж өмссөн эсгий бүрх, долоон хэлхээстэй хүзүүний зүүлтийг нь  
үнэлье гэхэд сэтгэл нэг л төвдөхгүй байлаа. Амаранта Урсула хэзээд өөртөө ажил олж  
чаддаг, өөрөө үүсгэсэн гэрийн бүх асуудлыг өөрөө шийддэгт л далд учир нь байдаг  
бололтой. Өнөөдөр нь юмыг буруу хийгээд маргааш нь түүнийгээ засаж, тэгэхдээ нэг  
хийснээ арван гурав дахидаг удмын өвчинтэй юм гэж Фернандо бол бодохоор тэр бүхнээ

гайхмаар хичээнгүй хийдэг байлаа. Баяр хөөр нь доороосоо ундрах Амаранта Урсула шинэ пянз ирэх тоолонд нөхрөө зочдын өрөөнд барьж аваад , шөнө болтол шинэ бүжиг сурна. Сургуулийн найз нар бүжгийн зааврыг зурагтай нь ирүүлдэг байлаа. Бүжгийн хичээлийн төгсгөлд ихэвчлэн амрагийн ажил хийх бөгөөд эр эм хоёр венийн ганхуур сандал дээр юмуу, нүцгэн шалан дээр л шууд хэвтээд өгдөг байлаа. Бүрэн жаргалаа эдлэхэд нь хүүхэд л дутаж байсан боловч Амаранта ханилаад таван жил болтол хүүхэд гаргахгүй гэж тохиролцсоноо бат баримталж байв.

Гастон цаг нөхцөөхийн тулд өглөөдөө Мелькиадесийн өрөөнд орж, Аурелианотой яриа үүсгэнэ. Аурелиано нутагт нь олон жил суусан хүн шиг нутаг орныг нь нэгд нэгэнгүй мэдэх тул түүнтэй ярьж, хамгийн алс бөглүү газрыг ч дурсан санахад сайхан байдаг билээ. “Нэвтэрхий тольд ч байхгүй ийм нарийн юмыг хаанаас мэдсэн юм бэ?” гэж асуухад Хосе Аркадиод хариулсан шигээ л “Юуг ч мэдэж болно” гэж хэлжээ. Аурелиано самгардиас гадна англи, франц хэл үзэж, латин, грек хэл гадарлах болжээ. Аурелиано орой болгон гадагшаа гарна. Амаранта Урсула өөрт нь аар саар юманд долоо хоног зарах мөнгө өгөх болсноос хойш Мелькиадесийн өрөө каталон эрдэмтний номын мухлагийн салбар аятай болжээ. Аурелиано орой болтол ном шагайн суух боловч уншсанаа ярьж байгааг нь Гастон сонсоод, түүнийг мэдлэгээ сэлбэх гэхээсээ урьд мэдсэнээ батлах гэж л эрмэлздэг юмуу даа гэж бодох болжээ. Аурелиано бичээсийг юунаас ч илүү сонирхож, өглөөгүүр толгойгоо хамгийн сэргэлэнд үздэг байлаа. Гастон Амаранта хоёр Аурелианог ам бүлдээ уухайн тас авах байсан боловч цаадах нь тэднээс дөлсхийж, учир нь олдохгүй байсаар улам ч битүү дүмбэгэр болжээ. Гастон түүнтэй найзлах гэж бүр ядчихаад, цаг нөхцөөх өөр арга сүвэгчлэх болов. Чухамхүү тэгэхэд л агаарын шуудангийн алба байгуулах санаа төржээ.

Энэ нь шинэ санаа биш байлаа. Агаарын шуудангийн алба байгуулах гэж Амаранта Урсулатай суухаасаа бүүр өмнө хөөцөлдөж байжээ. Тэгэхэд гэр нь Бельгийн Конгод дал модны тосны үйлдвэрлэлд хөрөнгө оруулсан учир тус улстай агаарын шуудангаар харилцах компани байгуулах гэж санаж байжээ. Гэрлээд гэргийнхээ аяыг дагаж, Макондод хэдэн сар болохоор шийдсэн учир Гастон санаснаа аргагүй хойш тавьжээ. Гэвч Амаранта Урсула хот тохижуулах нийгэмлэг байгуулах гэж оролдон, Европ буцах тухай яриаг инээд наадмаар дйүвүүлэх тул Макондод удаан суурьших хэрэг гарах нь гэж ойлгоод, Брюссель дахь мартаж орхисон хоршоо нартайгаа захидлаар харилцах болжээ. Зам эхлэн нээхэд Африкт байна уу, Карибын тэнгист байна уу, ер нь Дэлхийн бөмбөрцгийн аль ч хэсэгт байсан ялгаа юу байх вэ? Хэлэлцээ болж байх хооронд Гастон хуучин илбэдүүлсэн байгаад одоо туж сайр болсон газарт буух талбай засаж, салхи голлон хаанаас үлээдэг болохыг тогтоож, нислэгийн тохиромжтой замыг сонгож, тэгэхдээ өөрийнх нь хийж байгаа зүйл ноён Гербертийнхтэй төсөөтэй болж, Макондогийнхон түүнийг агаарын шуудан байгуулна гэдэг нэрийдлээр гадил суулгах нь гэж бодон сэжиглэж байгааг анзаарсангүй. Фламанд эр тийм азтай санаа сэдэн, Макондод байнга суух шалтаг олсондоо урамшиж мужийн төв хэд хэд орон, эрх баригчдад бараалхаж, эрхийн бичиг авч, хөнгөлэлттэй гэрээ байгуулжээ. Үүнийхээ хажуугаар тэрбээр Фернандогийн үл үзэгдэх оточ нартай харилцаж байсан шиг Брюсселийн түнш нартайгаа захиа бичилцсээр, анхны нисэх онгоцыг туршлагатай, механикчийн хамт далайгаар явуулуулах болгож, тэр механикч нь Макондогийн ойрын боомтод онгоцоо угсраад, хотод түүгээрээ нисэж ирэхээр тохиролцжээ. Түнш нарынхаа баттай амласанд итгэсэн Гастон газрыг хэмжиж, цаг уурыг тодорхойлсноос, хойш жил өнгөрөхөд нисэх онгоц хүлээн, салхины чимээ чагнан, тэнгэр өөд харж, гудамжаар тэнэх зуршилтай болчихсон байлаа.

Өөрийн нь буцаж ирснээр Аурелианогийн амьдрал үндсээрээ өөрчлөгдсөнийг Амаранта Урсула мэдсэнгүй. Хосе Аркадиог үхсэнээс хойш Аурелиано каталон эрдэмтний номын мухлагаас салахаа больжээ. Аурелиано сул чөлөөтэй, зав ихтэй болсон учир хотыг нэлээд сонирхож, огт гайхаж хачирхах юмгүйгээр судлах болов. Эзгүй тоост гудамжаар нь тэнүүчилж, хүний хувьд сониучирхахаасаа илүү, эрдэм шинжилгээний үүднээс сонирхож, нурсан байшин, зэвэнд идүүлсэн, халуунд шувууны цоолж үхээд байсан цонхны төмөр торыг шинжилж, бөөн бодолд дарагдчихсан улсыг харж явжээ. Бас хөт, гадилын компанийн урьдын сүрлэг байдлыг сэтгэлдээ дүрслэн бодох гэж оролдоно. Усанд сэлэх сан нь ширгэж хоцроод, одоо эрэгтэй хүний ялзарсан шаахай, эмэгтэй хүний шагайвчаар дүүрч, компанийн эвдэрч нураад, өвсөнд баригдсан харшуудын дунд болд гинжин уяатайгаа үхсэн герман очарк нохойн араг яс хэвтэж, харилцах утас нь зогсолтгүй дуугарсаар байсанд Аурелиано авбал эмэгтэй хүний сандрангуй холын дуу гарч англиар юм асуусанд “Ажил хаялт дуусаад, гурван мянган үхсэн хүнийг далайд хийгээд, гадилын компани өөр газар нүүж, макондод олон жилийн хойно арайхийж амар жимэр болсон” гэж хариулмаар байвч дуугарсангүй билээ. Аурелиано тэнэсээр янхны газар байдаг өргөн хороололд иржээ. Урьдын цагт гагцхүү кумбиамбуг сэргээх гэхдээ л багц багцаар мөнгө шатааж байсан газар одоо хотын хамгийн уйтгартай, хөөрхийлэлтэй гудамжны нэг болж, улаан дэнлүү хааяа нэг гэрэлтэвч цаасан цэцгийн хэлхээ нь ноорон унжсан, бүжгийн танхимууд нь эзгүй хоосон, хэзээ ч нөхөрт гарч үзээгүй, тарган, туранхай ганц бие франц хөгшчүүл, вавилон авгайцуул эгшигт хайрцагны дэргэд суун хүн хүлээсээр ажээ. Антилийн негрүүдийн хамгийн ахмад нь болох, гэрийнхээ өмнөх цэцэрлэгт үдшийн гунигт тамалга аялсаар байгаад ганц өвгөнөөс өөр гэрийнхнийг нь, үгүйдээ гэхэд хурандаа Аурелиано Буэндиаг мэдэх хүн Аурелианод олдсонгүй болно. Хөвөн цагаан үстэй хөөн хар царай нь гэрэл зургийн хальсан дээрх зураг шиг харагдана. Аурелиано хэл хугалчихам этгээд хэлийг хэдэн долоо хоногт сураад өвгөнтэй хууч хөөрөн хоолыг нь буудаж, түүний жич охин болох тарган бүдүүн негр хүүхний хийсэн тахианы толгойн шөлнөөс иддэг байлаа. Тэр хүүхний ташаа нь гүүнийх шиг тэвхгэр, мээм нь махаар бүтсэн гуа шиг сэргэр агаад бөв бөөрөнхий толгой дээрх ширүүн өтгөн үс нь дундад эртний үеийн цэргийн дуулга аятай харагдана. Негр хүүхнийг Айшхи гэдэг байлаа. Тэр үед Аурелиано ширээний хэрэглэл, лааны тосгуурь болон гэрийн бусад аар саар зүйлээ заран амь зууж байлаа. Улаан мөнгөгүй болчих удаа олон гарах бөгөөд ингэхэд хаях гэж байсан тахианы толгойг захын наймаачнаас гуйж аваад Айшхид аваачиж өгөн наран ногоо, батраштай шөл чануулж иддэг байлаа. Айшхийн элэнц эцгийг үхэхэд Аурелиано тэднийд очихоо больёон боловч үдэшдээ негр хүүхнийг талбай дээрх бүйлс модны доор зогсоод, хааяа нэг явах шөнийн бугийг исгэрэн дуудаж байхад нь тааралддаг байлаа. Хоёулаа Айшхийн хэлээр тахианы толгойн шөлний тухай чалчин олонтаа зэрэгцэн явдаг байсан боловч Айшхи Аурелианог хамт яваад байхаар өөрийг нь хайсан хүн үргэчихээд байна гэж битүүхэн сануулснаас хойш Аурелиано тэгж явахаа больжээ. Аурелиано Айшхитай унтах сан гэж заримдаа хорхой нь хүрдэг байсан, ингэвэл хоёулангийнхаа ганцаардахын мөр дээрээс уулзаж байсны эцэст болох ёстой юм боллоо гэж Айшхи бодох байсан боловч түүнтэй унтаж үзсэнгүй. Тийнхүү Аурелиано Амаранта Урсулаг Макондод буцаж ирэхэд хүнтэй хавьтаж үзээгүй байлаа. Амарантагийн анх эгчирхэн үнсэхэд Аурелианогийн зүрх зогсчих шахжээ. Амаранта Урсулатай уулзах бүрийд, ялангуяа өөрт нь чамин бүжиг заахад Аурелиано бүр арчаагаа алдан, яс нь хавтайгаад явчих шиг болжээ. Мэргэлнэ гэдэг нэрийдлээр хуланц эцгийг нь урьдын цагт Пилар Тернера агуулах руу аваачихад яг ийм болж байсан билээ. Аурелиано зовлонгоо мартаж гэж, бичээсийг толгой өөд татахгүй үзэж,

нагац эгчийнхээ гэмгүй энхрийлэхэд шөнө нь шаналан зовох тул энхрийлэхээс нь зугтаах болсон боловч тийнхүү зугтаах тусмаа түүний цангинатал инээх, цатгалан мигуй шиг дуугарах, баярлан дуулахыг сонсохсон гэхээс байж суух аргагүй болж, гэрийн хаана ч, тэр ч байтугай хамгийн таарамжгүй газарт ч дурлалдаа шатаж байлаа. Нэг шөнө хуучин урлан байсан хажуугийн нь өрөөнд, орноос нь арваадхан метрийн тэртээд ханахыг үл мэдэх эр эм хоёр ширээн дээр шууд хэвтээд, шилэн хорго хагалан, давсны хүчил асгараад доогуур нь урсан байгааг тоохгүй бэлгийн ажлаа хийсээр байжээ. Аурелиано шөнөжин цурам хийсэнгүй, маргааш нь өдөржин чичрэн дагжиж багтартлаа уйлжээ. Тэр өдөр дуусахгүй урт болчихсон шиг санагдаж, хүсэн хүлээсэн шөнө болмогц бүйлсийн модны сүүдэрт очиж Амарантагаас гуйж авсан нэг песо тавин сентавог нойтон алгандаа атган, яадаг бол гэж итгэл алдан эвгүйрхсээр Айшхиг хүлээжээ. Тэр мөнгийг мөнгөгүйдээ ч гуйсангүй, өөрийнхөө ингэж дор орсонд Амаранта Урсулад шаралхаж, түүнийг ингэж завхайран доромжилж, гутаах гэсэндээ гуйж авчээ. Айшхи шившсэн лаа асаасан умгар тагзандаа аваачин, цул точиг болчихсон эвхмэл орон дээрээ хэвтэж, зоригтой, хөхөрчихсөн, сүнсээ алдсан жингэрийн биеэ өгчээ. Тэрбээр Аурелианог аймхай хүүхдийн дайтай бодож, шалавхан нэрдээд өнгөрье гэж бодож байтал лут хүчээр сав юугий нь эргүүлээд хаячих шиг болсонд жинхэнэ эр хүнтэй учирснаа дороо мэджээ.

Хоёул явдаг боллоо. Өглөө нь Аурелиано бичээсээ тайлан уншиж байгаад үдийн амралт болоход нозоором чимээгүй тасалгаанд очиход Айшхи түүнийг хүлээж байдаг байлаа. Хэдэн долоо хоног өнгөртөл Аурелиано нууц амрагийнхаа эхил хуурын чавхдас шиг юмаар хийсэн, ган хатуу бөгөөд амгүй битүү цагариг бүсэлхийгээрээ зүүж явааг мэджээ. Учир нь Айшхи түүнтэйгээ төрж өссөн юм байжээ. Янагийн жаргал эдэлж байхынхаа завсарт мансуурам халуунд орон дээрээ ямагт шалдан суугаад өлөө дарах бөгөөд зэвэнд идэгдсэн цайран дээврийн нь нүх од шиг ярайж байдаг байлаа. Айшхи байнгын эр хүнтэй, үхтлээ инээн байж хэлдгээр нь бол өөрийн “хоногийн бортой” болж, тэр ч байтугай бүр ханилаад суучихаж ч магад гэж горьдох болж байтал Аурелиано Амаранта Урсулад тачаах болсноо хэлжээ. Өөр хүүхэнтэй унтаж тачаалаа намжаах гэсэн боловч болсонгүй, амрагийн явдалд улам туршлагажихийн хэрээр бүр ч тэсвэрлэхийн аргагүй шаналах болж байлаа. Ингэж нууцаа хэлсний дараагаар Айшхи Аурелианог урьдынх шигээ халуунаар хүлээн авсаар байсан боловч тус болсныхоо хариуд хөлс заавал нэхэх болж, Аурелианод мөнгө байхгүй байвал хаалганыхаа ард өрийн данс хөтөлж, тоог бичих бус эрхий хурууныхаа хумсаар зураас зурж тэмдэглэдэг боллоо. Аурелиано гэр рүүгээ явж, гонхны хажуугаар гарахдаа яг хоолоо идэж суугаад Амаранта Урсула, Гастон хоёртой гадны хүн шиг халти мэндлээд өрөөндөө орон түгжиж, шөнө байшин доргитол инээх, аминчлан шивнэлдэх, урьдчилан ноололдох, дур тавин амь тэмцэхийг сонсохдоо сэтгэл үймрэн зовж, уншиж ч бичиж ч тэр ч байтугай бодож ч чадахаа болино. Гастоныг онгоц хүлээж эхлэхээс өмнөх хоёр жилд Аурелиано иймэрхүү л аж төрж дунэдад эртний үе жжомыг устгаж асан аргын тухай зад маргалдаж байгаа дөрвөн чалчаа залуутай каталон эрдэмтний номын мухлагт танилцах хүртлээ ч ингэж л аж төрсөөр байлаа. Чин бишрэлт Бедагийн уншсан номд Аурелианогийн дурладгийг мэддэг өвгөн эзэн тэдний ийнхүү ном хаялцахад мэргаан таслагч болооч гэж эцэг хүний заль гарган залууг өдсөнд цаадах нь гуйлгаад байсангүй. /Жоом бол дэлхий дээрх хамгийн эртний далавчит шавьж юм, түүнийг улавчаар цохиж алдаг тухай бүүр хуучин гэрээс сударт айлдсан байдаг боловч шавьжны энэ намыг устгах гэж ямар ч арга хэрэглээд, тухайлбал улаан лоолийн хэлтэрхийд хумсаа шингээж хаяхаас эхлэн гурил элсэн чихэртэй хутгаж тавих хүртэл хамаг арга хэрэглээд тус болоогүй, шинжлэх ухаанд мэдэгдэж байгаа 1600 төрлийн жоом

эрт дээр цагаас нааш зогсоо зайгүй, хайр найргүй хядуулж ирсэн хүнтөрөлхтөний түүхэнд хүмүүс өөр ямар ч амьтныг, тэр ч байтугай өөрийн төрлийн амьтныг тэгж мөрдөж хавчиж байгаагүй, үнэнийг хэлэхэд жоомыг устгах эрмэлзэл бол чухамхүү хүний өөрөө үржих зөнтэй дүйцэх тийм зөн мөн, тэгэхдээ жоом алах зөн нь хувьгүй тод илэрдэг, юунд ч дарагдашгүй зөн нь юм, одоо жоом бүрэн хядуулалгүй байгаад байгаа нь харанхуй буланд нуугддагийн л ач, төрөлхөөсөө харанхуйгаас айдаг хүн ингээд жоомонд хүрэх аргагүй болсон юм, гэхдээ үд дундын хурц гэрэлд жоом дахиад л амархан өртөмхий болдог учир жоомыг устгах цорын ганц найдвартай арга бол дунд эртний үед ч одоо үед ч ер нь үеийн үед нарны гэрлээр гялбуулах юу гэж тайлбарлаж гарчээ. Ийнхүү уул сэдвийг нэвтэрхий мэдэх үүднээс тавилантай юм тавилангаараа болдог гэдгийг номлосноос хойш Альваро, Герман Альфансо, Габриэль гэсэн дөрвөн цэц булаалдагчтай Аурелиано орой болгон уулзаж төө зайгүй үерхэх болов. Тэд бол түүний насандаа ганц үерхэж үзсэн найз нар байлаа. Номноос уншсан ертөнцөд аж төрж ирсэн даяанчийн хувьд оройн зургаан цагт номын мухлагт эхлээд, үүрээр хас хүйд дуусдаг энэ шуугиантай цуглаан цоо шинэ юм байлаа. Утга зохиол бол хүнийг даажигнахын тулд бодож олсон хамгийн урдаа барих зугаа гэдгийг Аурелиано өнөө хүртэл санаагүй явтал шөнийн нэгэн архидааны үеэр Альварогоос түүнийг олж мэдээд түүнд итгэжээ. Нэлээд хугацаа өнгөрсөн хойно л Аурелиано Альварог тийнхүү зоригтой эргэцүүлэгтэй турш шош бэлтгэх шинэ арга олоход л туслахааргүй бол эрдмийг эрдэм гэж үздэггүй каталон эрдэмтнийг дуурайсныг ойлгожээ. Жоомны тухай эрдэм шинжилгээний илтгэл Аурелианогийн тавьсан тэр үдэш маргаан үргэлжилсээр Макондогийн нэгэн дүүргийн сүүмгэр хас хүйд өссөндөө биеэ худалдсан бүсгүйчүүдийн дэргэд дуусчээ. Тэр хас хүйн эзэгтэйн хаалгаа нээж хаахын дон туссан, малийтал инээсэн бялангач авгай байлаа. Дотроо бодож явдаг юмаа үнэхээр гэж санадаг үйлчлүүлэгчдийнхээ итгэмтгийг дандаа тэгж инээмсэглэж явдаг болов уу гэж бодогдмоор. Учир нь энэ байшинд бариад авч болох юм хүртэл биегүй байлаа. Буйдан суунгуут салж унана, доторхийг нь гаргаад хаячихсан эгшигт хайрцагт тахиа өндөг дарж байна, цэцэрлэгт нь цаасан цэцэг байна, хананд нь гадилын компани ирэхээс өмнөх хуанли, хэзээ ч хэвлэгдээгүй сэтгүүлээс хайчлан авсан жаазтай чулуун барын зураг өлгөөтэй байна. Үйлчүүлэх хүн ирлээ гэж эзэгтэйгээ хэлэхэд халирхай залуу янхан хүүхнүүд хажуугийн байшингаас гүйлдэн гарч ирдэг нь ч шал худлаа байлаа. Тэд таван жилийн өмнө цэцгийн хээтэй байсан болов уу гэмээр даавуун палаажтайгаа орж ирээд хувцасаа өмссөн шигээ хэнэггүй тайлж чулуудаад, тачаалаа арзаганахад “Үгүй мөн хачин аа! Адар нурж байгааг хараач” гэж дуу алддаг байв. Нэг песо тавин сентав аваад малилзтал инээмсэглэх эзэгтэйгээсээ бяслаган хачиртай талх худалдан авна. Эзэгтэй нь тэр талхыг бусад бүх зүйл шигээ хуурамч гэдгийг мэдэх болохоороо инээж байгаа нь тэр. Ертөнц гэдэг Мелькиадесийн бичээсээр эхэлж, Айшхийн ороор дуусдаг байсан Аурелианогийн хувьд энэ хас хүйн хий үзэгдэл нь айхыг эмчлэх сайн эм болж байлаа. Яг ид ажлын үеэр эзэгтэй өрөөнд орж ирээд яаж яанглавал сайн болох талаар янз бүрийн юм зөвлөх тул Аурелиано эхний үед ажлаа дуусгаж чаддаггүй байлаа. Гэвч аажимдаа залуу амьдралын ийм аар юманд дасчээ. Аурелиано дөрвөн нөхрөө яг адил дотночлон үздэг, тэднийг нэг л хүн шигээр цөөнгүй боддог боловч Габриэльд арай илүү элэгтэй байдаг байлаа. Нэг орой Аурелиано хурандаа Аурелиано Буэндиагийн тухай санамсаргүй ярьж, Габриэль цор ганцаар үнэн хэлж байна гэж итгэснээс хойш ийм ойр болжээ. Тэр ч байтугай ярианд оролцдоггүй хас хүйн эзэгтэй, “Хурандаа Аурелиано Буэндиа гэж нэг удаа нээрээ дуулсан юм байна, тэгэхдээ либералуудийг алах шалтаг хайж байсан засгийн газар түүнийг санаанаасаа зохиосон гэнэ билээ” хэмээн үйлийн үргүй ховч хүний хэл ам

нь загатнасан байдлаар итгэжээ. Габриэль хурандаа Аурелиано Буэндиагийн зэвсэг нэгт нөхөр, хагацашгүй анд хурандаа Геринальдо Маркесын жич учир хурандаагийн байсан эсэхэд эргэлзсэнгүй билээ. Ажилчдыг буудсан тухай яриа гарахад Макондогийнхон бүр юу ч санахаа болино. Аурелианог энэ талаар яриа үүсгэхэд эзэгтэй төдийгүй арай ахмад хүмүүс ч өртөөн дээр ажилчдыг цэрэг бүсэлсэн, хоёр зуун вагон дүүрэн хүүрийг аваачиж далайд хаясан явдлыг үлгэр хэмээн няцааж “Гадилын компани хэзээ ч энд байгаагүй гэж тухайн үед шүүхээс дүгнэлт гаргасан, бага сургуулийн сурах бичигт тэгж бичсэн” хэмээн зүтгэдэг байлаа. Тийнхүү Аурелиано Габриэль хоёр бусдын зөвшөөрдөггүй бодит баримтад итгэдэгээрээ тийнхүү нийлжээ. Энэ баримт нь хоёр найзад асар их нөлөө үзүүлж, тэр хоёрыг аль эрт нөхөөд гунигаас өөр юу ч үлдээгүй ертөнц тийш далайн таталтын буцах давалгаа шиг хаман аваачжээ. Габриэль дайралдсан газартаа л унтаад өгнө. Аурелианог дагаж очоод урланд хэд унтсан боловч үүр цайтал үхдэлүүд тасалгаагаар тэнээд байсан учир шөнөжин дуг хийлгүй хонож билээ. Хожим нь Аурелиано Габриэлийг Айшхийн халамжид өгч, тэрбээр буруу л дуулаагүй бол “Үгүй” гэдэггүй болохоор нөхрийг нь өвөртөө оруулж, хаалганы арын ханан дээр Аурелианогийн өрийн дансны хажуугийн бяцхан зайд хумсаараа зураас зуран данс хөтөлнө. Таван найз замбараагүй байдаг боловч каталон эрдэмтний шаардсанаар мөнхийн юм хийх гэж оролдож байлаа. Чухамхүү энэ эрдэмтнийг ёнгодог эртний утга зохиолын багш байсан туршлагатай, олон ховор номтойн ачаар тэд гучин долоо дахь түгшүүрт байдлыг эрэн шөнөжин суух чадвартай болжээ. Хэн ч дунд сургуулийн мэдлэгээс цааш ахих хүсэлгүй, боломжгүй болсон хотод ингэнэ гэдэг гайхмаар байлаа. Үерхэхийн сайханд татагдаж Фернандогийн хатуу сэтгэлтэйн улмаас саяхан болтол өөрийг нь үзээгүй байсан ертөнцийн гайхамшигт сэтгэл булаагдсан Аурелиано Мелькиадесийн мэдэгдэл бүхий нууц түлхүүрт шүлгийг уншигдахаар болж байхад нь орхив. Гэвч цаг юу ч хийсэн хүрэлцэнэ, тэр ч байтугай хас хүйг ч орхихын хэрэггүй гэдэгт хожим нь итгэж, Мелькиадесийн тасалгаанд иргэж ирээд, тайлах сүүлчийн түлхүүрийг олохоос нааш ажлаа зогсоохгүй гэж хатуу шийдэж, бичээсээ дахин улайран үзэж эхэллээ. Гастон нисэх онгоц ирэхийг хүлээж, Амаранта Урсула туйлгүй ганцаардаад нэг сайхан өглөө Аурелианогийн өрөөнд оров. Махчин минь, ажил явж байна уу? Дахин агуйдаа сууж авсан уу? гэж инээжээ. Амаранта Урсула чамин палааж, загасны нуруугаар хийсэн урт зүүлттэйгээ эзтэй хөөрхөн харагдаж байлаа. Нөхрийнхөө үнэнчит итгэн, хүзүүвчнээс нь тавьж, Макондод ирснээсээ хойш анх удаа зав зай гарсан нь тэр шиг байлаа. Аурелиано түүний орж ирснийг тэртэй тэргүй мэдэж байсан учир биеийг нь харах ч дуугий нь сонсох хэрэг байсангүй. Ажлынх нь ширээг тохойлдоход түүний тун ойрхон, тун туниагүй байсанд Аурелианогийн зүрх нь зогсчих шиг болж, бичээс рүүгээ л аргаа баран тонгойжээ. Тэрбээр догдолсон сэтгэлээ дарж ядан алга болчих гээд байгаа дуугаа шахан, өөрийг нь орхичих гээд байгаа аминаасаа зууралдан дүйрэн балартах гээд байгаа ойгоо дайчлан самгарди бичгийн онцгой учиртайг цаасан дээр бичсэн бичгийг гэрэлд нөгөө талаас нь харвал ямар байдаг вэ, цагийн зузааныг тийнхүү нэвт гэрэлтэн харагдах ирээдүйг шинжлэх ухааны үүднээс харах боломжтойг, өөрөө өөрсдийгөө сөнөөчихгүйн тулд бэлэгдлийг тайлах хэрэгтэйг, Нострадамусын “Эрин зуун” хутагт Мильяны зөгнөн хэлсэн Кантабрийн үхлийг ярьж гарчээ. Лекцийг зогсоолгүйгээр эхийн хэвлийгээс унасан өдрөөс нь түүнд байсан зөндөө хөтлөгдөн, Амаранта Урсулагийн гар дээр алгаа тавьж, ийнхүү зүрх гаргавал үймэрч сандрахаа болино гэж боджээ. Гэвч Амаранта Урсула хүүхэд байхынх шигээ хуруунаас нь хайртайхан барьж аваад, Аурелианог өөрийг нь асуусанд хариулж байх хооронд огт тавьсангүй. Тийнхүү тэд мөс мэт хүйтэн долоовор хуруугаар холбогдон хэсэг болсон



боловч тийнхүү хүрэлцсэнээс хоёр биенд нь жирсхийх байдал огт мэдэгдсэнгүй. Амаранта Урсула түр мэлрэн байснаа сэхээ орж духаа алгдан “Шоргоолж” гэж дуу алджээ. Залуу бүсгүй бичээсийг агшнаа мартаж хаалга тийш бүжих мэт яаран алхаж, Брюссель орохдоо эцэгтэйгээ салах ёс гүйцэтгэсэн шигээ үүдэн дээрээс үнсэх байдал үзүүлэн хуруугаараа дохиод

-Чи надад дараа тайлбарлаж өгөөрэй. Өнөөдөр шоргоолжны нүхэнд шохой хийхээ онхи мартаж орхиж гэж хэлжээ. Амаранта Урсула байшингийнхаа энэ талд хийх юм гарвал Аурелианогийн өрөөгөөр орж ирэн нөхрийнхөө тэнгэр тольдож байх хооронд хэдэн минут саатах болжээ. Ингэж Амаранта Урсулаг орж гарах болсонд төөрөлдсөн Аурелиано түүний ирснээс хойших хэдэн сард гэртээ үдийн хоол идэхээ больсон байснаа дахин идэх болов. Аурелианогийн байх болсон нь Гастонд аятайхан санагдана. Ширээнээ цаг гаруй хөөрөхдөө Гастон Аурелианод түнш нараа муу хэлнэ. Өөрийг нь маллаад байх шиг байна. Онгоцыг далайгаар явуулсан гэх боловч хөлөг нь ирдэггүй, Карибын тэнгисийн боомтуудын хөлөг онгоцны бүртгэлд ороогүй учир хэзээ ч ирэхгүй гэж далайн агентлаг баталж байна. Гэтэл түнш нар нь онгоцыг аль хэдийн явуулсан гэж аанай л зүтгэж өөрийг нь залилж байж мэднэ гэж битүүхэн хардаж байна хэмээн гоморхон ярина. Бие биедээ улам итгэхээ больж Гастон захиа бичихээ байгаад хэдэн өдөр Брюссель орж байдлыг газар дээр нь шалгаад нисэх онгоцоор эргэж ирдэг юм билүү гэж бодох болжээ. Гэтэл Амаранта Урсула Макондогоос хэрхэвч явахгүй, тэр ч байтугай нөхрөөсөө салах болсон ч явахгүй гэж эртний шийдсэнээ хэлсэнд түүний бодож байсан нь санахын гарз болжээ. Эхний үед Аурелиано Гастоныг дугуй унасан тэнэг амьтан байна гэж олны санадагтай адил санаж, муухан өрөвддөг байжээ. Хожим нь хас хүйд эрчүүдийн харыг улам сайн таних болж, фламанд эрийн эхнэрийнхээ үгнээс гардаггүйг ухаангүй тачаалаасаа болж байна гэж бодох болов. Гэвч Гастоныг сайн мэдэх болохдоо түүний жинхэнэ зан, өнгөний дуулгавартай байдал хоёр зөрчилдөж байгааг ажиглаж, түүний бүх явдал, тэр ч байтугай онгоц хүлээж байгаа нь ердөө л сайн жүжиглэж байгаа хэрэг гэж сэжиглэх боллоо. Тэгэхэд Гастоныг амьтны боддог шиг тэнэг хүн бус харин ч эхнэртээ байнга бууж өгөн ганц удаа үгнээс нь зөрөлгүй туйлын чих зөөлөнтэй дүр үзүүлсээр бүр ядрааж аваад, өөрийг нь гарын аяар амьтан гэж хий бодсоор уйдаж гүйцэхдээ европ буцах гэж жумдаанаа өөрөө баглах болтол нь хэрсэн торонд нь улам орооцолдуулж байгаад, эхнэрээ дийлэхээр шийдсэн тун тогтвортой, туйлын зальтай, тоймгүй тэвчээртэй хүн гэж бодох болжээ. Үүнээс хойш Гастоныг өрөвддөг байснаа яснаасаа үзэн ядах боллоо. Гастоны арга маш гэмтэйн зэрэгцээгээр нэн явууртай ёнагдсанд Аурелиано үүнийгээ Амаранта Урсулад зориглон хэлжээ. Гэвч хүүхэн хайрлах, үл итгэх, хардах ямар хүнд ачаа зүрхэндээ тээж явдгаа огтхон ч мэдүүлэлгүйгээр түүнийг сэжиглэмхий байна гэж шоолжээ. Амаранта тэр нэгэн өдөр лаазтай тоор задалж байгаад хуруугаа эсгэчихсэнд Аурелиано ухасхийн биеийг нь дагжтал цусыг нь шунаг агаад үнэнчээр сорохыг хүртэл, Аурелианог өөрт нь дүүгийн хувьд дотно байхаас арай ондоо байна гэдгийг ухааралгүй явжээ.

-Аурелиано чи дэндүү ширүүдээд хүний цус сордог сайн ороолон болж чадахгүй нь гэж албаар тачигнатал инээжээ.

-Тэгэхэд л Аурелиано тэссэнгүй. Эсгэсэн гарынх нь алганы хонхорхойг арга барагдангуй үнсэн үнсэн, сэтгэл зүрхнийхээ угт хадгалж байдаг бүхнээ ханзалжээ. Өөрөө шөнө босоод угаалгын өрөөнд Амаранта Урсулагийн хатаах гэдэг өлгөчихсөн шуудаг тэргүүтэнд нүүрээ наан аргаа барж, галзуурахад ганц хуруу дутуу болсондоо цурхиран уйлдгаа ярьжээ. Айшхийг муур шиг гийнаач гэж, “Гастон,Гастон, Гастон” гэж үглээч гэж яаж гуйж өлсөглөнгөс бие худалдсан бүсгүйчүүдийн хүзүүнээс Амарантагийн үнэрийг

үнэрлэх гэж сүрчгийг ямар овсгоотой хулгайлан авч байснаа ярьжээ. Ийнхүү долоон булчирхайгаа ийм тачаангуй тоочиж байгаагаас айсан Амаранта Урсула аажмаар хуруугаа нугалсанд хясаа хамхигдах мэт алга нь атгагдан, эсгэсэн нь гар нь бөөн маргад, молор, мэдээгүй, хатуу бөөрөнхий яс болов.

- Мал! Эхний онгоцоор Бельги явлаа гэж тэр хэлэв.

Нэг орой Альваро амьтны хас хүй оллоо гэж дуу шуу болсоор каталон эрдэмтний мухлагт орж иржээ. “Алтан хүү” гэж нэртэй тэр хас хүй нь хоёр зуугаас доошгүй бух шувуу шидэт дуугаараа цаг зарлан сул явах задгай том танхим байлаа. Бүжгийн тайлбайн торйонд, төмөр тороор хүрээлсэн хашанд амазошнкийн асар том сарнай цэцгийн дунд зүсэн бүрийн дэглий, гахай шиг бордуулсан яст матар, арван хоёр торчигнууртай дуут могой оршин, бяцхан хиймэл далайд хуягтай яст мэлхий шумбах ажээ. Агаар тэнд дөнгөж сая бий болгосон юм шиг онгон бөгөөд цусан улаан цэцэгсийн дунд, моодноос гарчихсан пянзны дэргэд нядвар байхгүй байхад найдан хүлээх сайхан эрлийз хүүхнүүд нь хорвоогийн диваажингаас эрчүүдийн авчрахаа мартчихсан урин тачаангуй хурц илдийг төгс боловсруулсан ажээ. Тэр шөнөө л таван найз б хоосон санааны энэ хүлэмжинд айлчилж, хаалган дээр ороонго сүлжин хийсэн ганхуур сандал дээр суугаа олон үггүй сүрлэг эмгэн анх ор жирж байгаа тваын дотор татаар шанаатай, ертөнц бүтэхээс эхлээд үеийн үед ганцаардахын цэцэг өвчний тэмдэгтэй, янхигар, уйтгартай залууг хараад, цаг эргэ жорчоод байдаг юмуу гэж санаж,

- Ай, Аурелиано гэж шивнэжээ.

Өмнө нь хуранада Аурелиано Буэндиа дахиад зогсож байлаа. Ийм насан дээрээ явсан тэрбээр бүх дайн дажнаас өмнө, алдар хүндийн боол болохоосоо өмнө, ганцаар цөхрөн суухаасаа өмнө, тэртээ нэгэн гөлөө унтлагынх нь өрөөнд орж ирээд өөртөө дурла гэж амьдралынхаа анхны тушаалыг өгч байхдаа дэнлүүний гэрэлд яг л ийм харагдаж байсан билээ. Тэр эмгэн бол Пилара Тернера байжээ. Нас сүүдэр зуун дөчин тав хүрээд, насаа тоолох муу зуршлыг орхиж, хөзрөөр хойчинхйоо явдлыг мэргэлэн будилж төөрөх юмгүйгээр хожмын цагт яг л инэгэн гэж алдалгүй тогтоогоод нэг л юмыг дурсан санаж тэрүүхэндээ зожигорон суух болжээ.

Тэр шөнөөс хойш Аурелиано өөрийнхөө одоо болтол мэдэхгүй байсан, элэнц эхийнхээ хайр, энэрийг үзжээ. Сүлжмэл ганхуур садал дээрээ найган ганхсаар Пилар Тернера дотроо буэниагийн угсаа хэчнээн хүчирхэг байгаад уруудан доройтсоныг, Макондо хэнээн сүр жавхлантай байгаад буурч сүйрснийг санагалзан суудаг байлаа. Энэ завсар Альваро матар үргэтэл тас тас хөхөрч, Альфонсо өнгөрсөн долоо хоногт бух шувуу ёозгүй авирласан дөрвөн хүний нүдийг ухсан тухай цуст гүүх зохиож, Габриэль бодлогошронгуй эрлийз хүүхний өрөөнд цаг өнгөрөөж, цаадах нь унтсаны хөлсөнд авах мөнгөнийхөө оронд Оринокогийн нөгөө этгээдэд гянаднд

хоригдож байгаа сүйт хархүүдэ эзахидал бичүүлнэ. Хил давуулан хулгайн юм зувчуулдаг түүнд нь хилчин туулга өгөөд хөтөвчинд суулгасан чинь хө удаан жил даяанчлан суудаг энэхүү жинхэнэ, бодитой хас хүйс шиг диваажинд байх сан гэж мөрөөдөж байлаа .Энд салахын аргагүй сайхан байсан учир өөр газар очино гэж боохын ч хэрэггүй байтал тэр нэгэн үдэш Амаранта Урсула мөрөөдлийг нь юу ч үгүй хийж орхиж билээ. Аурелиано сэтгээлэ онгойтол ярих юм сан гаж санааширч нэг хүн цээжийг нь багласан хүлээсийг тайлаад өгөөсэй гэж хүсэж байсан боловч Пилар Тернерагийн хормойд нүүрээ наан хүч сэлбэдэг халуун нулимс асгаруулан уйлахаас өөр яаж ч чадсангүй билээ .Пилар Тернера хурууныхаа үзүүрээр залуугийн үсийг нь илэн тайвшрахыг нь хүлээж, эрэгтэй хүн анх үүсэхдээ яахаараа уйлсныг мэдэх тул, хайр сэтгэлтэй болсноос уйлж байна гэж түүний хэлээгүй байхад нь

- Хүү минь, боль! Цаадах чинь хэн бэ надад хэлчих гэж эелдгээр хэлжээ.

Аурелиано нэрийг нь хэлэнгүүт Пилар Тернера аанйа л бясаглантай инээв. Гэвч инээд нь он жилийн эргэлтээр гагтааны сөөнгөдүү, гөвтнөхтэй адил болсон ажээ. Буэндиагийнхны төрлийнхний зүрхний нууцыг тэр бээр тайлж байх учиртай байжээ. Энэ гэр бүлийн түүх гарцаагүй давтагдан эргэж байдаг, тэнхлэг нь улам улам элэгдэн муудаагүй сэн бол хүрд нь эцэс төгсгөлгүй эргэлдсээр байх байсан гэдгийг Пилар Тернера хөзрийн мэргэ, өөрийн туршлагаараа олж мэдсэн билээ.

- Санаа зоволтгүй ээ. Цаадах чинь хаана ч байлаа гэсэн чамайг хүлээж байгаа гэж Пилар Тернера инээмсэглэв.

Таван цаг хагаст Амаранта Урсула угаалгын өрөөнөөс гарав. Тэрбээр халааз нөмөрч, үсээ алчуураар овойлгон боочихоод өрөөний нь хажуугаар гарала. Аурелиано согтуу юм шиг гуйвсаар араас нь мяраан дагаж, Амаранта Урсулаг халаазныхаа энгэрийг яг ярж байхад нь эр э эм хоёрын унтлагын өрөөнд орж очвол Амаранта Урсула айхдаа энгэрээ дахин хумиад, хаалга нь дутуу хаалттай байгаа хажуугийн өрөө рүү заавал Гастон тэнд захидал бичиж байлаа.

- Яв гэж Амаранта Урсула зөвхөн уруулаа хөдөлгөв.

Аурелиано инээмсэглэж, хоёр гараараа бүсэлхийгээр нь тэврэн аваад ваартай цэцэг шиг өргөн орон дээр нь дээш нь харуулан чулуулдла. Амаранта Урсулаг саад хийхийн зуургүй Аурелиано ганцхан ширүүн угз татаад цамцыг нь тайлан хаятал саяхан угаасан нүцгэн бие ил гарсанд шөнийн харанхуд түүний төслөөн боож байсанчлан ээн биенд ганц ч толбо, ганц ч үс, ганц ч нууц мэнгэ байсангүйд ангал руу хийсчихэв үү гэмээр толгой нь эргээд явчихжээ. Амаранта Урсула зэрлэг өлөгчин амьтан мэт шалмаг хөдөлж, биеэ үнэнээсээ хамгаалан тэмцлээ. Чоно оготных шиг гилийсэн, туялзсан, анхилам үнэрт хамаг биеэрээ гулбалзан мушгирч, өвдгөөрөө Аурелианогийн бөөрийг ёврох гэж оролдон, үүнийхээ зэрэгцээгээр нүүэрнд нь хумсаа шигтгэн ноцолдох боловч

тэр хоёрын хэн ч сэдэв авахуулах нэг ч амьсгаа гаргасангүй нь дөрөвдүгээр сарын намуун үдшийг нээлттэй цонхоор харж байгаа хүний тайван амьсгалж гаргасангүй нь дөрөвдүгээр сарын намуун үдүшийг нээлттэй цонхоор харж байгаа хүнгий тайван амьсгалж байгаатай л адил байлаа. Улаангалзуу ноцолдож, үхэх сэхэхийг үзэн тэмцэлдэж байгаа мэт байсан боовч гаднас нь харвал тийм байж чадсангүй, учир нь нэг нь удаан, болгоомжтой, баяртай довтолж, нгөө нь удаан, болгоомжтой, баяртай мултарч, ингэ жбайх хоохонд нь усанб аданги дахин цэцэглэж амжихаар хажуугийн өрөөнд Гастон нисэх онгоц мөрөөдөж байснаа мартахаар ббайлаа. Энэ бүхнийг харахад хэрэлдсэн хоёр амраг тунгалаг усан сангийн ёроолд эвлэрэх гэж оролдож байна уу гэмээр ажээ. Амаранта хамгийн ширүүн, ёсорхуу эсэргүүцэж байхдаа өөрсдийг нь дув дуугай байгаад байвал нөхөрт нь нэг л жигтэй санагдаж,, тэдний гаргахгүй гэж мэрийж байгаа шуугинаас илүү сэжиг төрүүлж магадгүй гэж ухаараад ноцлодохоо больсонгүй боловч уруулаа жимийн нээж, гэхндээ худлаа хазсан болж, урьдынх шигээ биеэ суллах гэж ширүүн хөдлөхөө байж, удалгүй нэг мэдвэл хоёулаа ноцолдох ч бус, харин ноололдож, хамгаалх нь дүрээс цаашгүй болж, довтлох нь энхрийлэх болж хувирсан байлаа. Тэгснээ Амаранта Урсула наргиан болгох гэсэн шиг, нэг мэх хийх гэсэн мэт агшин зуур эсэргүүцэхээ нэгэнт оройтсон байлаа. Хүүхэн гараа явуулан, тэмтэрсээр байж алуур олоод мигуй шиг орилохгүй байх гэж шүдээрээ арайхийн хазаж амжжээ.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Пилар Тернера диваажингийнхаа үүдийг манасаар ороонгон ганхуур сандал дээрээ баярын урьд шөнө үхжээ. Сүүлчийн нь захиас ёсоор бүрлээчийг австай оршуулсангүй, бүжгийн талбайн тэхий голд ухсан асар том нүхэнд шууд ганхуур сандалтай нь найман эрэгтэ хүн олсоор буулгажээ. Нулимсандаа цонхийсон, хар хувцас өмссөн эрлийз хүүхнүүд илбэ жилбийн ёсыг гүйцээгээд ээмэг, хавчаар, блэзгөө аван нүх рүү чулуудаж, булшийг нэр, он, сар, өдөргүй чулуун хавтангаар таглаж, хавтангийн дээр амазонкийн сарнайн томоос том овоо бсогов. Дараа нь эрлийзүүдз бүх араатан, жигүүртнийг суллаж тавиад, хаалга цонхоо тоосго, шавраар битүүлээд, хутагт нарыг хөрөг, сэтгүүлийн өнгөтэй зураг наасан, эрдэнийн чулуугаар баадаг, махчин шиг бие биеэ барьж иддэг гэж, аль эсвэл далай тэнгисээр хэрэн тэндэг титэмлүүлсэн хөзрийн ноён байсан гэж зохион бодсон зуурдын хархүү нарынхаа зургаар доторлосон модон хайрцгаа үүрээд толгой хандсан зүгтээ таран явжээ.

Хорвоод ингээд өнгөрчээ. Каталон эрдэмтэн носмын мухлагаа үнэ хаялуулан худалдаад, жинхэнэ урт хавраа сана, Газрын дундад тэнгисийн эрэгт,

төрсөн тосгондоо буцсанаас хойш Макондогоос үлсдэн жаахан ю, өнгөрсөн үеийн үлдэгдэл, Пилар Тернерагийн булшнаа янхан хүүхнүүдийн хийсэн шалихгүй эрдэнэсийн хамт ялзарч байлаа. Өвгөнийг явчихна гэж хэн ч сансангүй. Тэрбээр гадилын компани цэцэглэж байхад, тоо томшгүй дайны хөлөөс амь зулбаж Макондод ирээд, эртний янз бүрийн хэлээр гарсан анхны хэвлэлүүдийн мухлаг нээхээс өөр аятай юм боджо олж чадсангүй. Эсрэг талын байшинд зүүд тайлагч дээр орох ээлжээ хүлээх зуураа цаг нөгцөөх гэжүүгээр орж ирдэг санаандгүй хүмүүс эдгээр номыг хогон дээрээс олсон мэт болгоомжгүй эргүүлж үздэг байлаа. Каталон өвгөн лангууны арын бүгчим өрөөнд цагийнхаа тэн хагасыг өнгөрүүлж, сургуулийн дэвтрээс тастаж авсан цаасан дээр гогцоорсон үсгээр нэг юм бичих боловч түүний юу бичиж байгааг хэн ч тодорхой хэлж чаддаггүй байлаа. Аурелианотой танилцах үед өвгөн, Мелькиадесийн бичээсийг санагдуулам хоёр авдар замбараагүй овоолсон цаастай болсон байлаа. Явтлаа дахин нэг хайрцаг дүүргэж амжсаныг үзэхэд Макондод байхдаа өөр юу ч хийж байсангүй юу гэж бодогдмоор байлаа. Өвгөний харилцдаг хүмүүс гэвэл нь ердөө дөрвөн найз байж, тэдний сургуульд сурч байхад нь тэдэнд эрчигнүүр, цаасан шувууны барьцаатайгаар ном өгч, хэдэн жаалыг Сенека, Овидий нарын зохиолын амтанд оруулжээ. Тэрбээр сонгодог зохиолчдыг урь нэг тогооноо схамт хоол идэж байсан юм шиг нэг их ёсорхон хүндлэхгүй, энэ тэр хэмээн ярьж, Хутагт Августин баринтаг дотуураа арван дөрвөн жил тайлаагүй ноосон хантааз өмсөж явсан тарнич Арнольдо де Вилланова хүүхэд байхдаа хилэнцэт хорхойд хазуулаад бэлгийн сулралтай болчихосн зэрэг хэн ч мэдмээргүй олон юмыг мэддэг байлаа. Каталон өвгөн номыг машинд хүндэлхийн зэрэгцээгээр онхид ойшдооггүй ибайв. Өөрийн бичээсэнд ч ийнхүү хоёрдмол хандана. Альфонсо өвгөний гар бичмэлийг испани хэлнээ орчуулах гэж бодолхийлэн каталон хэлийг зориуд судалж, баахан хуудас халаасандаа хийж яваад, нэг шөнө өлсөхдөө биеэ худалдсан охидтой хас хүйд байж байгаад гэж орхижээ. Тэр ер нь сонины хайчилбар, ер бусын мэргэжлийн удирдамж халаасандаа чихэж явдаг байлаа. каталон эрдэмтэн үүнийг мэдэхдээ ббөн юм болохб айх гэж Альфонсо айж байтал “Утга зохиолдбүрнээ тохиолдож болох явдал байна гээд огт тоохгүй элгээ хөштөл инээж байсан мөртлөө “Гурван хайрцаг гар бичмэлийг төрсөн тосгон руу чирж яваад яах юм” гэж яаж ч ятгаад үг авсангүй, тэр ч байтугай “Хайргааа тусгай ачаанд өг” гэж шаардсан төмөр замын шалгагчдыг бүр Карфагенд хэрэглэдэж байсан хараалаар толгой түрүүгүй харааж, авдартай нь суудлын вагонд үлдээх болтол тайвширсангүй” Хүн өөрөө нэгдүүг зэргийн вогонд зарлаад номоо ачааны вогондоор тээдэг болбол ертөнц сүйрэхийн дохио” гэж хэлээд хөдлөн хөдөлтөл ганц үг дуугарсангүй. Бүтэн долоо хоног юм хумаа төхөөрчээ. Энэ нь каталон эрдэмтний хувьд хар долоо хоног боллоо. Явах цаг ойртох тусам өвгөн санаа сэтгэлээр улам унаж, хийх гэж байснаа байсхийгээд мартаж, барьсан тавьснаа мэдэхээ больж, нэг

газар тавьсан юм нь огт өөр газар орчихсон байдаг нь нэг үе Фернандаг зовоож байсан мөнөөхөн гэрийнб уг тэр юмыг нь сольж тавиад байна уу гэмээр болжээ. -Collons1 гэж хараал тваин –Лондоны дацангийн хурлын хорин долдугаар жаяг шиг гэнэ.

Герман, Аурелиано хоёр өвгөнийг бөөцийлөх болов. Түүнд яг хүүхэд шиг санаа тавьж, халаасанд нь зоричх пиу, шижлүүлгийн аримт бичгийг нь тараан хийж өгч, халаасыг нь англи сүлбээр зүүгээр даруулж, Макондогоос гараад, Барселон хүртэл юу юу хийхийг нь нарийвчлан бичиж өгсөн боловч каталон өөрөө мэдэлгүйгээр өмдөө мөнгөнийхөө хагастай хог дээр хаяж дөнгөсөн байлаа. Хайрцаг саваа хадан, хувцас хунараа Макондод ирэхдээ авч ирсэн нөгөө жумдаандаа хийгээд явахынхаа өмнө өвгөн хясааны тал шиг зовхио буулган, адис хүртээж байгаа юм уу даа гэж санагдмаар дохин эх орноосоо хол байхыг тэсэж гарахад нь тусалсан овоолоостой номыг зааж,  
- Энэ муусайныг та нарт үлдээе! Гэж нөхдөдөө хэлжээ.

Гурван сар болоод өвгөнөөс том дугтуй ирсэн нь, задгай далайд завтай байхдаа бичсэн хорин есөн захидал, авахуулсан тваин гэрэл зургийг дотор нь хийсэн байлаа. Каталон өвгөн захидлаа тэтгээгүй боловч эдгээрийг ямар дэс дараатай бичсэнийг нь ойлгож ядах юмгүй байлаа. Хамгийн эхнийхэд нь усан онгоцны өрөөнд хайцргийг тавиулаагүй ачаа авагчийг далайд чулуудмаар болсонтухай, мухар жүигтэйдээ бус, дутуу гэж бодсондоо арван гурав гэдэг тооноо сайдаг нэг ноёны тэнэг зангийн туахй, “Хөлөг дээрх ус хажуугийн нь

## 1 Каталон хараал

талбайгаас шөнө гарах манжингийн үнэр шингэсэн Лериадагийн рашааны амттай байна” гэж эхний оройн хоолон дээр мөрий тавиад хожсон тухай зэрэг аян замынхаа паянг аана л хошигнон бичсэн байлаа. Гэвч өдөр хоног өнгөрөх туса мхөлөг дээрх амьдрал сонирхолгүй болж, Макондогийн хамгийн саяхны, хамгийн энгийн явдлыг ч санахдаа уйтгарлах болж, хөлөг алслан холдохын хэрээр санаагаар унах болжээ. Өнгөрснөө тийнхүү санан уйтгарласан нь гэрэл зураг дээрээс ч тод харагдаж байлаа. Эхний гэрэлт зураг дээр тэрбээр аравдугаар сард ихэвчлэн хурган үүлсээр хучаастай байдаг Карибын тэнгисийн дэвсгэр дээр цав цагаан цамцтай, мөнгөн сортой үстэй их л баяртай сайхан гарчээ. Сүүлийн зураг дээр тэрбээр хар дарсан зүүдэнд үзэгддэг намрын далайгаар тэнүүчлэн яваа нэргүй хөлөг онгоцны тавцангийн голд хар пальто өмсөж, торгон хүзүүний зүүлт зүүж, сэтгэлээр уначихсан байдалтай зогсож байлаа. Герман, Аурелиано хоёр өвгөний захидалд хариу бичнэ. Эхний хэдэн сард тэрбээр дандаа захидал бичиж, урьд Макондод байхаасаа ч ойр байгаа юм шиг найз нарт санагдаж, түүний

үгүйлэгдэн байсан нь гайгүй болох шиг болжээ. Эхлээд тэр бүх юм хуучнаараа байна, төрсөн гэрт нь далайн ягаан хясаа одоо болтол байаг байна, талхны зөөлөнд хийсэн утмал май загас өнөө л амттай хэвээрээ, тосгоны рашаан үдэшдээ анхилам үнэг рагасан хэвээрээ байна гэж бичиж байлаа. Тэрбээр аанай л сургуулийн юэврийн хуудсан дээр алтанб эхээр муруй хазгай бичиж, хүн ту сбүрд тусгай хуудас зориулсан байдаг байлаа. Гэвч каталон эрдэмтэн яваандаа өөрөө мэдэлгүйгээр илээршиж байгаа хүний өөдрөг байдлаар бус, өвдсөн хүний цөхрөнгүй аясаар бичих боллоо. Макондод байхдаа өвгөн зайдгай зуухан дээр тогоотой шөл буцлах, кофены үрийн худалдаачны гудамжнаа хашгирах, хаврын явуулын болжморын жиргэхийг санадаг байсан шигээ нутагтаа очоод өвлийн үдэш, задгай зууханд тогоотой шөл буцлах зуур Макондо дахь номын мухлагийн мухрын дулаахан өрөөгөө, бүйлсийн модны тоост навчин дунд хангинах нарыг үдийн амралтаар цангинах галт тэрэгний дохиог санан уйтгарлаж байлаа. Өөд өөдөөс нь харуулан зоосон хоёр толинд туссан тусгал шиг ээн хоёр юмыг санагалзан зовсондоо тэрбээр бодитой бус юмыг гайхан бахаддаг байснаа больж найз нарыг Макондогоос яв, хорвоо, ертөнц, хүний сэтгэлийн талаар сургасан бүхнийг нь март, Горацийг нулимж орхни хаана ч очлоо гэсэн урьдын үе гэдэг бол оргүй хоосон юм, ой ухаанд гэдрэг эргэх зам байхгүй, өнгөрсөн хавар бүхэн эргэж ирэхгүй, хамгийн ухаангүй, бат дурлал ч зуурдын юм гэдгийг дандаа санаж яв хэмээн зөвлөх дээрээ хүрсэн байлаа.

Альваро Макондогоос яваарай” гэж өвгөний зөвлөснийг хамгийн түрүүнд дагав. Тэрбээр бүх юмаа, тэр ч байтугай хашаанд нь гинжин уяатай, хажуугаараа өнгөрөгсдийг айлган байсан хар хулыг хүртэл зараад, очих очих өртөө байхгүй галт тэрэгний байнгын пиу авчээ. Завсрын зогсоолоос явуулсан ил захидалд Альваро вогооны цонхны цаана жирэлзэн өнгөрөх юмсыг тоочин бичсэн нь зүйрлэвээс хөвөрсөн урт зуигийг хэсэг хэсэг таслаад, тэр тасархайгаа дор дор нь мартахуйн хоосон руу чулуудаж байх мэт ээ. Лиузианы хөвөнгийн тариалан дээр хий сүг мэт негрүүд ажиллаж, Кентуккийн хөх ногоон дээр гуурстай хүлэг бэлчиж, Аризоны тамын бүрэнхийд грек нууц амрагууд уулзаж, Мичиган нуурын байгалийг усан будгаар зурж байсан улаан ноосон цамцтай бүсгүй Альварог бийрээрээ даллаж, тэгэхдээ галт тэрэгний буцаж ирэхгүйг эс мэдэхийн учир салах ёс гүйцэтгэн далласангүй, учрахын ерөөл тавин даллаж байсан гэнэ. Дараа нь Альфонсо, Герман хоёр “Даваа гаригт буцаж ирнэ” гээд бямба гаригт явсан боловч сураг ажиг тасрав. Каталон эрдэмтний явснаас хойш жил өнгөрөхөд Макондод ганц Габриэль л үлдэж, Аймхийн осолтой өглөгийг хүртэж, францын нэгэн сэтгүүл асуултын уралдаан зарлаж түрүүлсэн хүнийг Парист жуулчуулахболзол гаргасан учир уг асуултад хариулан, явах эсэхээ шийдэж ядан байлаа. Энэ сэтгүүлийг захиалдаг Аурелиано асуултыг бөглөхөд нь түүнд тусалж, заримдаа гэртээ, олонхдоо Габриэлийн нууц амраг Мерседесийн суудаг, цор ганцаараа бүтэн үлдсэн, бамбайн үнэр ханх тавьсан

эмийн санд шаазан савнуудын дунд сууж бөглөдөг байлаа. Энэ эмийн сан л хотод хуучнаас ганцаар үлдэж, өнгөрсөн юм дуусваргүй эвдэрсээр хариугүй дуусах нь дээ гэхэд хэзээ ч дуусдаггүйчлэн эвдэрч дуусахгүй тэсээд байжээ. Макондо бүр эзгүйрсэн учир Габриэль уралдаанд түрүүлээд хоёр ээлжийн дотуур хувцас, хос шаахай Раблегийн бүрэн ботитойгоор Парис орох болохдоо Макондогийн өртөөн дээр галт тэргээ зогсоогооч гэж жолоочид нь дохин зангаж баймааж нь зогсоолгон суужээ. Туркийн хуучин гудамж энэ үед бүр орхигдож, сүүлчийн ам даавуу олон жилийн өмнө худалдагдаад үзмэрийн ёозгүй цонхонд толгойгүй хиймэл хүн л үлдсэн боловч мухлагийнхаа үүдэнд сүүлийн арабууд нь үхэхээ тайван хүлээж мянган жилийнхээ заншлаар суусаар байжээ. Алабама муж улсын Пратвилл хотод, арьсны өнгөөр ялгаварлахыг үл тэвчдэг, өргөст хэмх даршилдаг алдартай нутагт Патрици Браун гадилын компанийн хотын тухай ач нартаа үдэш ярьж өгөх гэж оролддог байж магадгүй боловч уг хот нэгэнт өвс ургасан тэгш тал болсон байлаа. Анхель ламын орыг залгасан, нэрийг нь хэн ч мэдэхгүй өвгөн лам эргэлзсэнээс болж тулай, норй хулжих өвчин тусан шаналж, дүүжин орон дээр хэвтэн, тэнгэрийн нигүүлсэхийг хүлээж байхад гүрвэл, харх түүнтэй айлсаж, сүмийг нь эзэмших эрхийг бие биеэс урьтаж олж авах гэж өрсөлдөж байлаа. Шувуу ч тогтохоо байсан, байнгын халуун, тоос хоёрт амьсгалахад ч хэцүү болсон энэ Макондод, шоргоолжны үүсгэх дуунд цурам хийх аргагүй болсон байшиндаа Аурелиано, Амаранта Урсула хоёр ганцаардах, дурлахыг зэрэгцүүлсэн, дэлхийд хамгийн жаргалтай хүмүүс, хамгийн жаргалтай амьтад болжээ.

Гастон Брюссель буцжээ. Тэрбээр онгоц хүлээж бүр залхаад, нэгэн сайхан өдөр хэрэгтэй юм, бүх захидлаа хамж жумдаандаа хийгээд, түүнийхээс хавьгүй илүү төслийг мужийн эрх баригчдад толилуулсан германы нисэх онгоц зохион бүтээгчдийн нийгэмлэгт хөнгөлөлттэй лицензийг нь өгчихөөс өмнө онгоцоор ирнэ гэсэн бодолтойгоор Макондогоос явжээ. Энгэр зөрүүлсэн анхны үдшээс хойш Аурелиано Амаранта Урсула хоёр Гастоны хааяа бөгс өндийхийг самбаачлах болж, ингэж учрахад туйлын осолтой, Гастон гэнэт буцаж ирэх тул дандаа шахам дутуу больж, оргилсон их хүслээ хазаарлахаас аргагүй болдог байлаа. Гастоныг явсанд хоёр амраг хоёулхнаа үлдэж аваад, ханашгүй сэтгэлээ жолоогүй тавьжээ. Энэ нь тэднийг хэзээ ч амар заяа үл үзүүлэгч, Фернандогийн ясыг үргэлж өндөлзүүлэгч, ухаангүй, хөнөөлтэй тачаал байлаа. Амаранта Урсулагийн чарлах, дур тавин орилох дуун өдрийн хоёр цагт хоолны ширээнээ, шөнийн хоёр цагт агуулахад гарна. Өчнөөн цаг дэмий алдсан маань л юунаас илүү харамсмаар гэж Амаранта Урсула инээнэ. Шоргоолж цэцэрлэгийг цөлмөж, байшингийн модон хэсгийг идэж, улмаар гонхонг эзэгнэж эхэлснийг харж байсан боловч тачаал хүсэлдээ мансуураад, тэднийг унталгын өрөөнд орж ирсэн хойно л сая утстгаж эхэлжээ. Аурелиано бичээсээ орхиж, гэрийн мухар сахин, каталон эрдэмтний захидалд хааяа нэг хариу бичнэ. Амрагууд орчин тойронд юу болж байгаа, цаг хугацаа гэж юу облохыг мэдэхээ больж, өдөр тутмын



амьдралын хэмнэлийг алдав. Хаалга цонхоотаг хааж, хувцас хунараа тайлаад илүү цаг идэхгүйн тул Сайхан Ремедиосын дандаа мөрөөдөг байсан тэр байдлаар гэр дотуураа явах болж, шалбааг дотор шалдан хэвтэж, усан сан дотор загас наадуулж байж золтой л цацаж үхсэнгүй. Ахархан хугацаанд тэр хоёр шоргоолжноос ч илүү юм хумаа эвдэж, зочдын өрөөний тавилгыг хэмхэлж, хурандаа Аурелиано Буэндиагийн аян замын баясгалангүй амрагийн явдлыг дажгүй тэсээд гарсан дүүжин орыг урж, матраас хүүлэн доторхыг нь гаргаж шалан дээр асгасан нь, бужигнасан хөвөн дотор багтрах шахан хөвөлзүүлж байх нь сайхан санагдсан ажээ. Аурелиано амрагийн хувьд яасан өрсөлдөгчөөсөө дутахааргүй ширүүн байсан боловч энхүү сүйрлийн диваажинд Амаранта Урсула санаанд оромгүй юм хийх авьяастай, ханахыг мэдэхгүй сэтгэлтэйгээрээ түүнийг дагуулахгүй байлаа. Хуланц эхийнхээ мөсөн чихэр хийхэд мохошгүй хүч зарч байсанчлан бүсгүй амраглах янаглахад яг тийм хүч гаргаж байх шиг санагдах ажээ. Амаранта Урсула өөрийнхөө бодож олсонд сэтгэл ханан дуулж, элгээ хөштөл инээж байхад Аурелиано дурлалдаа дотуур автаж, дотроо үхэж байсан учир улам дуугаа хураан бодлогошронгийг болж байлаа.

Нэг сэхээ орохдоо Амаранта Урсула Гастоны захидалд хариу бичнэ. Гастон хар элгийн, хаа холын санагдаж, түүнийг эргэж ирнэ гэж санаанд нь огт багтахгүй байлаа. Эхийнхээ нэг захидалд Гастон бичихдээ, түнш нар нь үнэхээр түүнд нисэх онгоц явуулсан боловч Брюсеелийн далайн агентлаг түүнийг нь эндүүрээд Танганьик руу явуулж, тэнд түүнийг нь макондо овгийнхонд өгч орхижээ. Энэ будлианаас болж бөөн бэрхшээл учирч нисэх онгоцыг тэндээс зөвхөн авахад л хоёр жилорох болзошгүй байлаа. Иймээс Амаранта Урсула нөхрөө гэнэт хүрээд ирэх вий гэж айхгүй байлаа. Аурелиано ч каталон эрдэмтний захидал, эмийн сангийн дуугүй эзэгтэй Мерседесээр дамжуулан Габриэлэс авч байсан захиагаар л гадаад ертөнцтэй холбоо барьж байлаа. Эхлээд тэд барим тавим харилцаж байлаа. Габриэль Парист үлдэхийн тулд буцах пиуныхаа оронд мөнгө аваад, Дофины гудамжны дүнсгэр зочид буудлын зарц нарын хаядаг хуучин сонин, хоосон лонхыг заран амь зуух болжээ. Тэр үед Аурелиано нөхрөө ямар байгааг сэтгэлдээ ядаж цөхөх юмгүй төсөөлдөг байлаа. Найзыгаа өндөр захай ноосон цамцтай явж, тэр цамцаа ханар Монпарнасын эрэгт дурлалт хосууд дүүрэхэд зөвхөн тайлж, өлсөж байгаагаа мартаж гэж өдөр нь утнаж чанамал өнгөт байцааны үнэр ханх тавьсан, Рокамадурын 1 нас барсан умгар өрөөндөө юм бичиж байгаагаар төсөөлдөг байлаа. Гэвч Габриэлийн тухай сураг улам бүрхэг, каталон эрдэмтний захидал улам алдаг оног, уйтгар гунигтай болсоор сүүлдээ Аурелиано нь Габриэло өвгөн хоёрын тухай бараг бодохоо больж Амаранта Урсула ч нөхрөө бас мартаж, хоёр амраг хүнгүй ертөнцөд үлдэж, энэ ертөнцөд өдөр тутмын, ашид мөнхийн цорын ганц үнэн гэвэл хайр сэтгэл л байлаа.

Тийнхүү ухаангүй жаргалын мананд төөрч байтал “Гастон буцаж ирнэ” гэсэн мэдээ цэлмэг өдөр аянга ниргэх мэт хүрч рлээ. Аурелиано, Амаранта

Урсула хоёр нүдээ нээж, сэтгэл доторхоо шинжиж, зүрхэн дээрээ гараа тавин бие биеийнхээ царайг хараад, амьдын хагацал үзсэнээс амь насаа өгсөн нь дээр гэж үзэх болтлоо бие сэтгэл нийлснээ ойлгожээ. Тэгэхэд Амарнат Урсула Гастонд хайртай, уулзахын мөрөөс бож байдаг гэж батлахын зэрэгцээгээр гайт оноо төөргөө дагаж Аурелианогүйгээр амьдрах аргагүй болсноо хлээн, үнэн гэхэд худал, худал гэхэд үнэн захидал бичжээ. Тэд нэлээд эмээж байсан боловч Гастон бараг эцгийн буурьтай тайван захиа ирүүлж, эхний хоёрбүтэн хуудсанд хуял тачаал хурдан өөрчлөгддөгөөс болгоомжлохыг зөвлөж, төгсгөлд нь өөрийнх нь ахархан зуур ханилан байхдаа жаргалтай байсан шиг тэднийг жаргалтай сайхан суугаарай гэсэн ерөөлийг шулуухан дэвшүүлсэн байлаа. Амаранта Урсула Гастоныг ингэнэ чинээ санаагүйдээ яг гаргуунд хаях гээд байхад нь өрөө морийг нь эмээллээд явуулчихаж гэж бодон, биеэ ихэд

1 Аргентиний зохиолч Хулио Кортасарын “Анги болж тоглосон нь” романы баатар

доромжлуулсанд үзжээ. Хагас жилийн дараа Гастон онгоцоо Леопольдвильдээс арайхийн олж аваад, Макондод өөрийн нь үлдээсэн юман дотроос цорын ганц үнэтэй юм болох унадаг дугуйгаа явуулна уу гэж хүссэнээс өөр юу ч бичээгүй захидал ирүүлсэнд Амаранта Урсула бүр ч уур нь шатжээ. Хор нь туйлгүй хөдөлсөн Амаранта Урсулаг Аурелиано уйгагүй аргадаж, жаргал зовлонгийн алинд ч сайн нөхөр болж чадахаа харуулах гэж оролдож байлаа. Гастоны мөнгө дуусмагц өдөр тутмын ажил төрөл толгой дээр нь буугаад ирэхэд тэр хоёр ханийн сэтгэлээр нэг нэгнээ дотночилж, тэгэхдээ нүдийг халхалж, бүхнийг мартаадаг тачаалыг огоорон бие биеэ энгүүн хайрлаж, аз жаргалын сайхныг амтлан байсан нь галзуу мэт хурьцан байдгаас нь ер дутуугүй гоё байжээ. Пилар Тернераг үхэх үед Амаранта Урсула нэгэнт хөл хүнд болсон байв.

Амаранта хүүхдээ гэдсэн байхад загасны нуруугаар хүзүүний зүүлт хийж худалдах гэж оролдсон боловч Мерседес л арван хоёр хэртэйг авснаас өөр авах хүн олдсонгүй. Хэлний авьяас, нэвтэрхий тиолины дайтай мэдлэг, очиж үзээгүй алс холын үйл явдал, газар нутгийг нэгд нэгэнгүй санах ховорхон билиг нь Макондогийн сүүлийн хүмүүсийн бүх мөнгийг нийлүүлсэнтэй тэнцэх өртөгтэй эхнэрийн нь эрдэнэс бүхий өвийнхарцаг шиг ямар ч ашиггүйг Аурелиано насандаа анх үзжээ. Тэд азаар л нэг юм гол зогоож байлаа. Амаранта Урсула санаа сэтгэлээр ч унасангүй, амраглан жаргахдаа дүрсгүйтэн наадах авяасаа ч орхисонгүй боловч хоолны дараагаар унталгүй, элдвийг мөрөөдөн гонхонд суудаг ш заншилтай болжээ. Аурелиано дэргэдээс нь үл холдоно. Заримдаа тэр хоёр өөд өөдөөсөө харан тийнхүү юу ч ярихгүй, харанхуй ботол ширэлцэн

сууж, алжаал тайлах агаад ийнхүү налайтал сууж жаргахдаа начигнатал загас наадуулдаг шигээ л бие биендээ халуун хайртай байдаг байлаа. Хойч ирээдүйдээ итгэл алдах учир, хойно өнгөрснөө санагалзах болов. Тэд олон жилийн их борооны үеэр диваажингийн оронд байснаа санаж, хашаанд шавхай туучин гүүлдэж, гүрвэл алаад Урсулагаас зүүж, түүнийг амьдаар нь оршуулж байна гэж тоглож байсана дурсан, ийнхүү санахад ухаан орсон цагаасаа хойш хоёулахнаа байхад л жаргалтай сайхан байсан тэр үнэнийг ойлгосон авай. Нэгэн үдэш Амаранта Урсулаг урланд орж очиход Фернанда жаахан Аурелианог голоор сагстай хөвж явахад нь олсон өнчин хүүхэд гэж хэлжээ. Тэр хоёрэнэ үгэнд итгэхүй байсан болвч энэ л ортой байх гэхээр өөр дуулж барьсан юм байхгүй байлаа. Хоёулаа элдвээр эрэгцүүлсэний эцэст Фернанда Аурелианогийн ээж байж таарахгүй гэдэгт итгэв. Амаранта Урсула Аурелианог Петра Котсейин хүү болов уу гэж тааварлаж байсан боловч эцгийнхээ нууц амрагийн тухай элдэв булай хов дуулж байсан учир тэгж бодохоос дотор нь муухай оргидог байв.

Өөрийгөө эхнэрийхээ дүүб айх гэж зовдог Аурелиано ламын гэрт сэм орж, чийгэнд цохиулж, хивэнд идүүлсэн архивт өөрийнөхө уг гарлын талаар латай юу байна гэж хайжээ. Түүний олсон төрөгсдийн хамгийн хуучин бүртгэлд Никанор Рейн лам шоколадаар илбэ үзүүлэн тэнгэрийн бийг нотлох гэж ородож байхдаа Амаранта буэндиаг арван хэдэн насанд нь адиласан туахй өгүүлсэн байлаа. Сэтгэл нь хөдлөн салганасан Аурелианог төрлөө эрэн төөрч байгааг тулайд баригдан зовсон өвгөн ла мхараад нэрийг нь өрөвдөнгүй асуусанд,

- Намайг Аурелиано Буэндиа гэдэг гэжээ.
- Өө тэгвэл биеэ дэмий бүү зобоо. Олон жилийн өмнө энд тийм нэртэй гудамж байан ю, тэр үед улс хүүхдээ гудамжны нэрээр нэрлэдэг заншилтай байсан м гэж лам итгэлтэй нь аргагүй хэлжээ.
- Аурелиано хилэн бадарсандаа дагжтал чичирч,
- Тийм үү Тэгэхлээр та чбас итгэхүй байгаа вий гэсэнд
- Юунд, хүүхээ! Гэжээ.
- Хурандаа Аурелиано Буэндиа гучин хоёр иргэний дайн үүсгээд гучин хоёуланд нь ялагдсанд. Цэрэг гурван мянган ажилчинг бүслэн хааж байгаад буудан хороож, хүүрийг нь хоёр зуун вогоонд ачин, далайд аваачиж хаясанд гэж Аурелиано хариулав.

Лам өрөвдсөн харцаар түүнийг ширтээд,

- Ай хүү минь, одоо чи бид хоёрын байгаад итгэж байгаа маань л миний хувьд олз гэж санаа алджээ.

Тийнхүү Аурелиано, Амаранта Урсула хоёр Аурелианог сагстай хөвж ирсэн гэдгийг үнэн гэж итгэсэнгүй боловч, сэтгэлээ тайтгаруулах гэсэндэ этийм

байгаасай гэж боджээ. Амаранта Урсулагийн гэдэс томрох тусам тэр хоёр бие, сэтгэл улам нэг болж, салхи ялихгүй л үлээвэл нурж унахад бэлхэн энэ байшиндаа хоёулхнаа байж бүр идээшсэн байлаа. Одоо тэр хоёр Фернандагийн унтлагын өрөө, гонхны хагаст л байх болж, унтлагын өрөөнд нь байран байж амраглаж янаглахын баяр хөөрийг амсаж гонхны талд нь Аурелиано эрдэмтэн каталонд хааяа нэг захидал бичих хооронд Амаранта Урсула төрөх хүүхдэдээ бойтог, оройвч нэхэж байдаг болжээ. Гэрийнб усад хэсэг нь зогсолтгүй эвдэрч сүйдсээр байлаа. Дархны урлан, Мелькиадесийн өрөө, Санта Софи де ла Пьедадын байсан анир чимээгүй, эзгүй буйдхан буланб алар шигүү ширгэнгэнд баригдах мэт байшингийн алсын мухарт үлдэж, тийш орох зүрхтэй хүн байхгүй болжээ. Үл цадах байгальд тал талаасаа энэрэлгүй хашигдсан тэр хоёр хахуун, хайтан цэцгээ арчилж балар эрт цагаас хүн шоргоолж хоёрын хийж ирсэн дайнлд сүүлийн саадыг босгож, түүхий шохой тойруулан асгаж өөрсдийн ертөнцийг хамгаалж байлаа. Жирэмсэн болсноос булбарай биеийн галбир алдагдаж, үс нь урган сэгсийж, нүүрэнд нь хар хар толбо гарч хөл гар нь хавагнасан Амаранта Урсула нхөрөө хүзүүнээс нь оосорлон, найдсанаар нь бололгүй нисэд явчихсан шриг бялзуухайгаар дүүрэн гор барьсаар гэртээ эргэж ирсэн тэрөдийнх шигээ залуу харагдахаа больсон боловч санаа сэтгэл сэргэлэн хэвээрээ байла. “Золиг алгад гэж!” Үнэхээр махчин шиг ингэж амьдрах гэж хэн саналаа!” хэмээн тэр инээнэ. Ертөнцтэй тэднийг холбож байсан сүүлчийн шижим Амаранта Урсула гэдсэнд хүүхэд олоод зургаан сар болж байхад тасарлаа. Нэг захидал ирснийг үзвэл тэр нь каталон эрдэмтнийх биш байлаа. Тэр захидлыг Барселоноос явуулсан боловч дугтуй дээрх хаягийг албан ёсны мэдэгдэх хуудасных шиг хөх бэхээр хичээнгүйлэн бичсэн байлаа. Дайсны өгсөн бэлэг мэт гэмгүй, эзэнгүй байдалтай тэр захидлыг Амаранта Урсула задлах гэсэнд Аурелиано гараас нь булаан аваад,

- Уншихыг больё. Энд бичсэнийг мэдээд яах юм гэж хэлжээ.

Түүнийг совин татаад байснаар каталон эрдэмтэн захидал бичихийг болилоо. Хэний ч задалж уншаагүй хар элгийн хүний захидал Фернандагийн хуримын бөлзгөө мөртөж орхион нөгөө тавиур дээр хивэнгийн хоол болон хэвтэж, дотор нь байгаа муу мэдээнийхээ галд өрөө шатан идэгдэж байхад даяанч хоёр амраг, ахмьдралыг төгсгөх цагийн усргал, тэднийг цөхрөх, умартахуйн хоосон цөлд аваачих гэж дэмий л оролдон өөрийгөө барах хөнөөлт, гарцаагүй цагийн усргалыг сөрөн хөвж байлаа. Аурелиано Амаранта Урсула энэ аюулыг ухаарч сүүлийн хэдэн сард гар гараасаа барин бие биеэ хайрлаж, ухаангүй дурлалд шатаж байхадаа ослон хүүгийнхээ арван сарыг нь гүйцээж байлаа. Шөнө нь хоёул тэврэлдэн хэвтэхэд сарын саруулд шоргоолжны торжигнуулахаас ч, хивлэн хорхойн шоржигнуулахаас ч, хажуугийн өрөөнд ургах шарилжийн тодхон бөгөөд тасралтгүй сэрчгэнэхээс айхаа больдог байлаа.

Үхэгсэд яваад тэднийг ихэвчлэн сэрээчихнэ. Урсула гал голмотоо сахих гэж ертөнц бүтэх жамтай хэрэхэн үзэоцэж, Хосе Аркадио Буэндиа их нээлт хийх үргүй үнэнийг хэрхэн эрж, Фернанда уншлагаа хэрхэн уншиж, хурандаа Аурелиано Буэндиа цөхрөн гутарч, дайтан тулалдаж, алтан загас хийхээр хэрхэн мал шиг болж Бага аурелиано хөгжөөнт найрын ид дундуур хэрхэн ганцаардан үхэж байгааг тэр хоёр сонсохдоо нэг юмыг ягштал баримталбал үхлийг дийлдэг юм байна эгж ойлгож, өөрснөө хий сүг болсон хойноо ч, хүмүүсээс шавьжны удахгүй булаан авах гэж байгаа тэр өчүүхэн энхжинг ирээдүйн амьд амьтны бусад төрөл эргүүлэн явсны дараа ч бие биеэ хайрласаар байх нь гэдэгт итгэн дахин баяр хөөр болдог байлаа.

Нэгэн ням гаригийн үдэш зургаан цагт Амаранта Урсула нярайлах гэж өвдөж эхэллээ. Өлсөөд биеэ худалдсан бүсгүйчүүдийг эмнэж байсан инээмсэглэмтгий эх баригч Амаранта Урсулаг хоолны ширээн дээр хэвтүүлэн гэдсэн дээр нь мордон галзуу юм шиг цогъж, хашгируулан зовоож байтал сайхан гэгчийн эрэгтэй хүүхдийн дуу часхийгээд явчихлаа. Тэр бол Хосе Аркадио нэртэй, том, биерхүү, дураараа Буэндиагийн нэг, Аурелиано нэртэй хараастай төрдөг, далдыг үздэг Буэндиагийн нэг бөгөөд гал голомтныхоо эхийг дахин тавьж, хөнөөлт согогоос нь ангижруулж, ганцаардах тавилангаас нь Урсула нүдэндээ нулимс гүйлгэнүүлэн харжээ. Учир нь юу гэвэл, зуун жилийн турш төрсөн бүх Буэндиагийн дотроос цор ганцаараа энэ жаал жинхээн дурлалаас олдсон байлаа.

- Ёстой махчин байна. Родриго гэж нэр өгье гэж Амаранта Урсулаг хэлбэл нөхөр нь эсэргүүцэж,
- Үгүй ээ. Аурелиано гэж нэр өгнө. Энэ хүү гучин хоёр дайнд ялж гарна гэж хэлжээ.

Авсан ээж нь хүүгийн хүйг огтолж, бүх биеийг нь бүрхсэн хөх өнгөрийг алчуураар арчиж, Аурелиано дэнлүүгээр гэрэлтүүлж өгч байлаа. Жаал хүүг доош эргүүлэхэд л хүн хүнд байдаггүй юм харагдсанд тонгойн үзвэл тэр нь гахайн сүүл байлаа. Аурелиано, Амаранта Урсула хоёр айж зовсонгүй. Тэд Буэндиагийн удам угсаанд ийм явдал гарч байсныг мэдэхгүй, Урсулагийн аймшигт гэрээсийг дуулаагүйн дээр, жаал хүүгийн нялхын шүдийг унах үед тайраад хаячихаж болох биз гэж авсан ээжийн нь хэлэхэд бүр ч тайвширжээ. Тэгээд Амаранта Урсула цус алдаж, цус нь сад тавин, яагаад ч тогтож өгөхгүй байсан тул түүнийг бодохтой манатай болжээ. Нялх биетэй эхэд туслах гэж ородон, аалзны шүлс, үнс тавих боловч энэ нь усан оргилуурыг хуруугаар таглах гэж ородохтой л адил ажээ. Эхний үед Амаранта Урсула сэргэлэн цовоо байх гэж хүчилж байлаа. Аурелианогийн гарыг барьж, өөр шиг нь шөрмөстэй хүн үхнэ л гэж бодоогүй бол үхнэ гэж зангүй хэмээн аргадаж, эх баригчийн сандарч хөдөлж байгааг харахдаа тачигнатал инээж байлаа. Гэвч

Аурелианогийн найдлага тасрахын хэрээр эхнэр нь чилхаа алдан харлаж, тэгсээр хүнд нойронд дарагдав.

Даваа гаригийн үүрээр цус тогтоох тарни урьдаг авгайг авчран орны нь дэргэд шившлэг хийлгүүлэв. Түүний шившихэд ямар ч хүн, амьтны цус гарцаагүй тогтдог боловч Амаранта Урсулагийн халуун цус хайр дуралалтай холбоогүй ямар ч арга чаргад дийлэхгүй байлаа. Тийнхүү аргаа барсаар байтал хорин дөрвөн цаг өнгөрч, үдэш бодоход Амаранта Урсула нэгэнт үхэж, цусан горхи татар татарсаар алаг болж, нүүр шөвийж, царайны нь шанлагаа арилан гөлтгөнө аятай гэрэлтэн ирж, уруулд нь дахиад инээмсэглэл тодорлоо.

Гагцхүү тэгэхэд л Аурелиано найз нартаа хэчнээн хайртай, тэд нь түүнд хэчнээн үгүйлэгдэж байгааг хийгээд энэ агшинд тэдэнтэйгээ хамт байхын тулд юугаа ч хайрлахгүйгээ мэджээ. Тэрбээр хүүгэ ээхийнх нь бэлтгэсэн сагсанд хийгээд, талийгаачийнхаа нүүрийг хөнжлөөр бүтээж, өнгөрсөн үе рүү хүргэх жимийг хайн эзгүй хотоор тэнүүчлэв. Эртнээс нааш ороогүй эмийн сангийн хаалгыг тогшвол тэр нь мужааны газар болчихсон байлаа. Дэнлүү барин гарч ирж хаалга нээж өгсөн эмгэн Аурелианогийн эндүүрсэнд өрөвдөж, Энд хэзээ ч эмийн сан байгаагүй, Мерседес гэдэг нэртэй, сайхан хүзүүтэй талимаарсан нүдтэй эмэгтэйг хүн болсоор хараагүй гэж ам шүд алдан байлаа. Тэрбээр каталон эрдэмтний номын хуучин мухлагийн үүдэнд духа анаан уйлахдаа хайртай хүнийхээ сэтгэлийг эвдэхгүй гэж биеэ барьж байснаа үхсэн эрдэмтний хойноо содоо л гашуудан уйлж байгаагаа ойлголоо. Тэрбээр “Алтан хү”-гийн ханыг гараа няцартал нүдэн, бух шувуутай хашаанаас хүүхэд шиг шохоорхон ажигладаг байсан ягаан зээрэнцэг тэнгэрээр нисэхийг ч анзаарах сөгөөгүй Пилар Тернераг дуудаж үзлээ. Янхны газрын хаягдсан хорооллын бүтэн үлдсэн ганц танхимд найраг буян хуурчдын чуулга хамбын зээ, Хүмүүн Францискогийн нууцыг залгамжилсан Рафаэль Эскалоны дууг хөгжимдөж байлаа. Эхдээ гар хүрснээс өрөөсөн гар нь хатаж ханчир болсон танхимын эзэн Аурелианог өөртэйгөө лонх архни хувааж уугаач гэж гуйжээ. Танхимын эзэн гараа ийм болсон зовлонг ярьж, Аурелиано эгчдээ бүдүүн зориг гарган дурласнаас хатаж хоцорсон зүрхнийхээ зовлонг ярьжээ. Тэгж хоёулаа мэлмэртэл уйлж, Аурелианогийн зүрхний шимшрэл түр намдах шиг болжээ. Гэвч Макондогийн түүхэнд хамгийн сүүлчийн удаа цайж байгаа үүрийн туяаны гэрэлд гарч дахин ганцаардахдаа талбайн голд зогсоод гараа сарвайн даян хорвоог сэрээхээс буцалгүй,

- Найз нар гэж хуншгүй амьтад! Хэмээн сэтгэлийнхээ угаас хашгирчээ.

Айшхи түүнийг нус нулимс, бөөлжис хаалжсан дотросо нь чирэн гаргаж, гэртээ аваачин, юм хумыг нь цэвэрлэж, аяга усан шөл уулгажээ. Айшхи сэтгэлийг нь тайвшруулах гэхдэ эөнөө болтол төлөөгүй байсан энгэр төрүүлснийх нь тоо томшгүй өрийг авахаа болин дансыг нь нүүрсээр дарж, Аурелианог ганцааранг уйлуулахгүйн тулд өөрөө уйлах гэж хамгийн гунигтай,

хамгийн уй гашуутай юмыг зоиуд дотроо бодож гарчээ. Үүрээр Аурелиано зовуурьтай гэгч нь дугхийгээд сэрэв. Толгой нь хагачих шахан өвдөж байгааг хамгийн түрүүнд мэдэж, нүдээ нээгээд хүүхдээ санажээ.

Сагсанд хүүхэд нь байсангүй. Аурелиано, Амаранта Урсулаг амь ороод хүүгээ авч гэж бодон агшин зуур сэтгэлд нь баярын оч гялсхийв. Гэвч тэр нь хөнжлөөр хучаастай, чулуу шиг хатуу хэвээрээ хавтэж байлаа. Гэртэ эирэхд нь унтлагын өрөөний хаалга онгорхой байсныг санахдаа хахуун цэцгийн өглөө гаргадаг үнэр ханхлах гонхыг өнгөрч, том тогоо, цус бослон цагаан даавуу, үнстэй шавар сав, ширээн дээр дэлгэсэн өлгийн голд хэвтэх хайч, шидмэсний дэргэд байга хүүхдийн мушгиран хатсан хүй гээд төрсний ул мөр хэвээрээ байгаа зочдын өрөөнд орлоо. Аурелиано эх баригч эхнэрийг шөнө буцаж ирээд хүүхдийг авч гэж санаад, тэгж тааварлахдаа түр амсхийн, бодлоо цэглэх гэж оролдов. Тэгээд Ребекагийн юм хатгамаллаж байхдаа суудагб айсан, Амарантагийн Геринельдо Маркестэй даам тоглодог байсан, Амаранта Урсулагийн хүүхдэдээ дотуур хувцас оёж байсан тэр ганхуур сандал дээр лагхийтэл унаад, өнгөрсний ийм их хүнд дарамтыг сэтгэл нь дааж гарахгүйг энэхэн агшинд түр ухаанорохдоо ойлгожээ. Өөрийн хийгээд өрөөлийн уй гашууны жаданд үхтэл шархалсан тэрбээр хатсан сарнайн буцыг даанч дээ гэмээр хэрсэн аалзын шүлс, хаанаас л бол мөлхөн гар чхөсрийн өвс, хоёрдугаар сарын тунгалаг өглөөний тайван агаарыг гайхан ширтэж байтлаа гэнэт хүүхдээ олж харлаа. Ертөнцийн дөрвөн зүг найман зовхисоос цугласан шоргоолж хүүхдийн нь хатан үрчийсэн алгын чиеэ арьсыг цэцэрлэгийн чулуу дэвссэн замаар нүх рүүгээ хичээнгүйлэн чирч байлаа. Гайхаж, айсандаа ч бус, энэ ер бусын хоромд Мелькиадесийн нууц бичээсийн сүүлчийн түлхүүрийг олж үзсэндээ мэлмэрэн хөшжээ. Тэрбээр уг бичээсийн өмнөх үгийг хүний ертөнцийн цаг хугаца, орон зай лугаа ягштал тохируулан “Энэ удмынхны эхнийх нь модонд хүлүүлж, эцсийнх нь шоргоолжинд бариулна” гэж бичсэн байсныг саналаа.

Аурелиано насандаа хэзээ ч энэ өглөөнийх шиг ухаалаг байсангүй. Тэрбээр үхэгсдээ мартаж, тэдний хойноос гашуудахыг ч умартаж, орчлонгийн явдалд сэтгэл хоргодохгүйн тул Фернандагийн модон загалмайгаар хаалга, цонхоо дахин дарж хадав. Тэрбээр Мелькиадесийн бичээст өөрийнх нь хувь заяаг өгүүлсэн гэдгийг нэгэнт мэдлээ. Уг бичээсийг тэрбээр галбын үеийн ургамлын дундаас, шалбаагны баагих ууран дундаас, газар дээр хүн байсны ул мөрийг энэ тасалгаанд бүрэн арилгасан гэрэлт шавьжны дундаас бүв бүтэн байж байхад нь олж авлаа. Тэрбээр бичээсийг гэрэлд авч гарах тэвчээр хүрсэнгүй, тэндээ зогсоод түүнийг испаниар бичсэн мэт, үд дундын нүд гялбам хурц гэрэлд уншиж байгаа мэт түгдрэлгүй чангаар тайлан дуудаж гарав. Энэ Буэндиангийнхны угийн бичиг байлаа. Тэгэхдээ Мелькиадес тэднийхний явдлыг өдөр өдрөөр нь тоочин, тэгэхдээ зуун жилийн явдлыг урьдаас харж бичсэн ажээ. Цыган төрөлх самгарди хэлээрээ бичиж, тэгш шадтай шүлгийг

Август хааны<sup>1</sup> хувийн бичгийн түлхүүрээр, сондогйг нь лакедемоны<sup>2</sup> цэргийн бичгийн түлхүүрээр бичсэн байлаа. Амаранта Урсуладр сэтгэлтэй болон амар тайвнаа алдсан үедээ Аурелианогийн тайлж эхлээд байсан Мелькиадесийн сүүлийн заль юу байв гэвэл өвгөн үйл явдлыг хүмүүсийн дассан ердийн цагийн дарааллаар өгүүлсэнгүй, бүтэн зуунд болсон өдөр тутмын явдлыг цөмийг нь базаад ганцхан агшинд болсноор харуулжээ. Үүнийг олж мэдсэндээ бүр улайрсан Аурелиано, Мелькиадесийн урьд Аркадиод уншиж өгөх гэж оролдсон “ая оруулсан лүндэнг” чангаар уншвал энэ нь үнэдээ Аркадиогийн буудуулахыг урьдчилан өгүүлсэн хэсэг байжээ. Дараа нь Аурелиано бие сэтгэлээрээ тэнгэрт гарах дэлхийн хамгийн хөөрхөн

1 Манай эриний өмнөх 63 оноос 14 он хүртэл амьдарч байсан Ромын эзэн хаан. – Орч.

2. Лакедемон буюу Спарта –эртний грекийн бие даасан улсын байдалтай хот. – Орч

хүүхний төрөх тухай бэлгэдлийг олж, чадваргүй, тогтворгүйдээ төдийгүй цаг нь болоогүй учир бичээсийг тайлбарлаж чадахгүй хоёр ихэр цэгийнхээ үхсэний дараа төрөх тухай хэсгийг уншив. Аурелиано өөрийнхөө гарлыг мэдэх гэж яарахдаа хэд хэдэн хуудас алгасав. Яг энэ агшинд сэвэлзсэн салхи гарчээ. Өвгөн мягмансанжийн шивнгээ, үл салах гунигийн өмнө урам хугаран шүүрс алдах чимээ зэрэг өнгөрсөн үеийн дуу хоолой шингэсэн энэ салхи одоохондоо намуухан, дөнгөж л хөдөлж эхлээд байлаа. Сайхан хүүхнийг жаргаахгүй мөртлөө олж авах гэж эрэлд гаран зэрэглээн ертөнцийг хөнгөмсгөөсөө болж туулсан хуялч өвгөөсөө өөрийнхөө анхны шинж тэмдгийг яг энэ үед олж байсан учир Аурелиано тэр салхийг анзаарсангүй. Аурелиано өвгөө таниад, гарлиынхаа нууц жимээр цааш мөшгөн хөөсөөр угаалгын бүүдгэр өрөөнөө хилэнцэт хорхой, эрвээхийн дунд нэгэн ажилчин эсэргүүцлэх сэтгэлээр биеэ өгсөн эмэгтэй тачаалаа хангах үед өөрийнхөө гэдсэнд олдсон яг тэр агшинд хүрлээ. Аурелиано тэр бүхнийг уншаад ухаангүй байсан учир дахин хуй хөдөлж, хаалга цонхыг нугаснаас нь тас савж, гонхны дорнод хэсгийн дээврийг хуу татаж, байшингийн суурийг урвуулан хаясныг мэдсэнгүй. Энэ үед Аурелиано Амаранта Урсула түүний төрсөн эгч нь бус, нагац эгч нь байсныг, яс махны ээдрээн дунд тэднийг бие биеэ олж, үр удмыг нь таслах үлгэрийн амьтныг гаргах хүртэл төөрөг гэж Риочаг Фрэнсис Дрейк байлдсаныг мэдэв. Макондод галав үлэх шуурганы дайтай хүчит хуй хуйлран дэгдэж байхад Аурелиано сайн мэдэх юмыг уншиж цаг алдахгүйн үүднээс арван нэгэн хуудас алгасаж, шдэт толинд харах мэт хувь заяагаа өөрөө урьдчилан үзэх эгж өнөөгийн үеийн тухай өгүүлсэн шүлгийг тайлж гарлаа. Тэр өөрийнхөө хэдийд яаж үхэхийг мэдэх гэж хэдэн хуудас орхив. Гэвч сүүлийн шүлэгт хүрээгүй



байхада энэ тасалгаанаас гарах хувьгүй болсноо ойлгожээ. Бичээсэд бэлгэдэн биссэнээр Аурелиано Бабилоньяг бичээсийг тайлан уншиж дуусах яг тэр агшинд тунгалаг (буюу гандирсын) хот шуурганд газрын хөрснөөс арчигдаж, хүний ой тойноос арилан алга болно, түүнд бичигдсэн зүйл хэзээ ч дахиад давтагдахгүй, учир юун хэмээвээс, зуун жил ганцаардах гэсгээл хүртсэн хүний удам газар дэлхийд эргэж төрдөггүй авай хамээсэн үүнийг молхи орчуулагч миний бие XVI жарны улаан барс жилийн өвлийн тэргүүн сарын гуравны хар морь өдөр орчуулан бараад дахиж эхтэ нь тулгасаар XVII жарны улаагчин туулай жилийн хаврын дунд сарын улаагчин үхэр өдөр нягтлан засаж дуусгавай.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

Колумбийн их бичгийн хүн Габриэль Гарсиа Маркесийн арван долоон настайдаа эхний нь өгүүлбэрийг тавиад, санааг нь хориод жил сэтгэлдээ боловсруулж, гучин наймтайдаа сая бичиж дуусгасан “Зуун жилийн ганцаардал” романыг сайхан номоор цаг ямагт ундаасаж байдаг эрхэм уншигч та сая уншин соёрхоод төдийлөн чилээгүй болов уу. Хэрэв чилсэн аваас орчуулагч миний муугаас болсон гэдгийг хүлээгээд хүлцэл өчье. Энэ зууны хоёрдугаар хагаст дэлхийн утга зохиолын түүхнээ юунд ч торолгүйгээр түрэн орж ирээд, хүн төрөлхтөний хүртэл болж байгаа латин америкийн шинэ романы оргил гэгдсэн энэ бүтээлийг анх уншаад аялгуу сайхан монгол хэлээрээ орчуулан, өнө эртнээс номын далайд аялж ирсэн монгол уншигчиддаа танилцуулах гэсэн өөрөөс ахадсан том санаа санасан минь энэ билээ. Испани хэлтэй мэргэд энэ сайхан зохиолыг эх хэлнээс нь ойд бууж, нүдэнд үзэгдэж, сэтгэлд уянгалтал орчуулан гаргана гэдэгт өчүүхэн би эргэлзэхгүй байсан боловч “маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги” гэгчээр уншигчдадаа толилуулах гэж сэтгэл яарахдаа тэр сипани хэлтний орчуулахыг хүлээлгүй, орос хэлнээс бөх зүрх гарган дам орчууллаа. Тэгэхдээ зарим эргэлзсэн гайхсан зүйлийг испани эхээс нь тольдон үзэх ипанич нөхдөөс уйгагүй лавлан хоргоох зэргээр утгыг дүйлгэн, уран санааг нь буулгах гэж чадах ядахын хэрээр оролдлоо. Колумбийн утга зохиолын шүүмжлэгч Альваро Дельгадо Колумбийн Коммунист хэвлэл “Документос Политикос” сэтгүүлд “Жинхэнэ үндэсний ардын зохиолын хувьд энэ роман манай утга зохиолын түүхэнд анх удаагаа нийт хүн ь төлөхтний соёлын үнэт зүйлсийн энд хүрлээ” гэж бахархан бичсэн нь бий. Иймээс энэ гаймшигт зохиол манай утга зохиод ч “нийт хүн төрөлхтний соёлын үнэт зүйлсийн энд хүрэх” тийм зохиол гарахад түлхэц өгөөсэй гэсэн сэтгэл давхар өвөрлөснөө ялдамд хэлье.

Маркесийн өгүүлсэн нь: “Тэр нэгэн орой романаа дуусгаад сандаласаа босон хаалгаа нээтэл өрөөнд цэнхэр муур орж ирлээ. Энэ ном маань нэлээд

хэдэн удаа хэвлэгдэх нь дээ гэж тэгэхэд бодогсдон юм” гэжээ. Хэдийгээр тэр үлгэрийн муурын араас гараа нэл цэнхэр будаг болгочихсон хүүхдүүд нь орж ирсэн боловч зохиогчийн бэлгэшээн бодсон нь талаар бодсонгүй, “Зун жилийн ганцаардал” роман дорхноо даян дэлхийд алдаршиж, латин америкийн испани хэлт бүх оронд хэвлэгдээд зогссонгүй итали, франц, орос, герман, англи, болгар, румын, фин, голланд болон бусад олон хэлээр орчуулагдан гарчээ. 1982 онд Г.Маркес энэ номоороо дэлхийн утга зохиолд гарсан хамгийн шилдэг бүтээлд олгодог Нобелийн шагналыг хүртжээ.

Энэ романы өмнөх түүхийг сөхөхөд сонин. Энэ нь зохиолчийн бага нас, бүр урагшлуулан хөөвөл либерал, консервативчуудын дөрвөн жилийн (1899-1903) дайны төгсөлттэй холбогдоно, Тэр үед Атлантын далайн эргээс холгүй орших хөдөөгийн жижигхэн Аракатак хотод хурандаа Николас Маркес гэгчийн гэр бүл суурьшжээ. Либералуудын талд байлдаж байсан тэр хурандаа хотын нэн нөлөөтэй хүн болж, өнөр өтгөн тэднийх хөдөөгийн хэвшин тогтсон амьдралын уламжлалыг хадгалан сахигч болжээ.

Хэдэн жилийн дараа америкийн “Юнайтед фрут компани”-ий салбар намуухан Аракатакт цөмрөн орж, эргэн тойрны нь газарт гадилын тариалан байгуулжээ. Тус орны өнцөг булан бүрээс, тэр ч байтугай хилийн чанадаас ирсэн аз жаргалын эрэлчингүүд хотоор дүүрч, модон саравчнаас бүтсэн бүхэл бүтэн хороолол, янхны газар, мөрийтэй тоглоомын газар байгуулжээ. Хотын уугуул иргэд хар элэгтэй харийнхнаас дөлж, тэднийг “хөрмөг” хэмээн шоглон нэрлэдэг байлаа. Иймээс цагаачдын нэг, цахилгаан мэдээний ажилчин Габриэль Гарсиа хурандаа Маркесийн охинтой хайр сэтгэлтэй боллоцоход хурандаагийнхан тэр хоёрыг гэрлүүлэхгүй гэж байдгаараа зүтгэжээ. Дурлалт хос аз жаргалынхаа төлөө тэмцэж, баясгалантай ч, гунигтай ч олон юм үзсэнийг “Зуун жилийн ганцаардал” романд Меме Буэндиа, ажилчин Маурисио Бабилонья хоёрын дурлалаар гаргажээ. Гэвч тэр хоёрын явдал роман дахь шиг эмгэнэлтэй дууссангүй, харин аятай сайхнаар төгссөн байна. Хурандаа арга буюу бууж өгсөн боловч хоёрзалууг Аракатакт байлгхгүй гэсэн учир тэр хоёр Риоачад очиж суужээ. Охиныхоо хөл хүнд болсныг Николас Маркес мэдэхдээ гэртээ авчирч, 1928 оны гуравдугаар сарын 6-нд охин нь хүү төрүүлсэн нь Габриэль Гарсиа Маркес билээ. хөнгөрснийхөө дараа эх нь Риоачад буцаж, жаал хүү өвгө, эмгэ хоёрынхоо гар дээр үлдсэн байна.

Маркесийг төрсөн жил эрх баригчдын тушаалаар Аракатакт хүмүүсийг бөөнөөр нь хядсан аймшигт явдал болжээ. “Юнайтед фрит компани”-ий шаардлагаар цэргүүд төмөр замын өртөөн дээр цугласан ажил хаягчдыг бүсэлж байгаад пулемётоор шүршжээ. Энэ талаар хотынхны дунд элдэв яриа байдгийг Маркес романдаа оруулсан байна.

Жаал хүүг ухаан сууж байх үед “гадилын өвчин” намдаж, тариалан орхигдож, хот хөл татраад, сөнөсөн мэт болжээ. Түүний цөөхөн суугчид

өнгөрснийг дурсаж, иргэний дайны явдлыг Аракатакийн цэцэглэж байсантай, үнэн явдлыг зохиомол зүйлтэй хольж хутган хуучилж суудаг байжээ.

Хожим нь Маркес ярихдаа “Манайд Петра эгчийн нас бас нэг хоосон өрөө байлаа... Оройн зургаан цагт нас барсан бас нэг хоосон өрөө байлаа... Оройн зургаан цагт эмээ маань намайг буланд аваачиж суулгаад, “Эндээс хөдөлж болохгүй, хөдлөх л юм бол Петра эгч чинь өрөөнөөсөө, Ласаро ах чинь өрөөнөөсөө гарч ирнэ шүү” гэдэг басан. Би айгаад хөдөлж ч чаадхгүй суудаг сан” гэжээ. Багадаа тийнхүү айж сууж байснаа романдаа Урсула Буэндиагийн ач Хосе Аркадиогийн дүрээр гаргажээ.

Нэг удаа Габриэлийн нэг авга эгч оршуулгын хулдас нэхэж эхэлжээ. Зээгийнхээ яаж гэж үүнийг хийж байгааг асуухад тэр эгч нь “Хүү минь, би үхэх гэж бйгаа юм аа” гэж тайван хариулжээ. Үнэхээр ч тэр эгч нь хулдсаа нэхэж дуусаад бие барсан байна. Романд Амаранта бас тэгдэг билээ.

Гэрийн хамаг хүндийг үүрч байсан эмгэ эх Транкилина нь жаал хүүг хүмүүжүүлжээ. Эцэж ядрахыг мэддэггүй, маш олон үлгэр, аракатакийн домог мэддэг тэрбээр Урсула Буэндиагийн эх дүр болсон байна.

Гэвч жаалхан Габриэлийн хувьд хамгийн дотно хүн нь өвгө эцэг Николас нь байлаа. Иргэний дайнд оролцогчдод олгоно гэж засгийн газрын амласан тэтгэвэрийг хүлээж насныхаа сүүлийн жилүүдийг барсан хурандаа алдарт генерал Рафаэль Уриб Урибын удирдлагад тулалдаж явснаа, иргэний дайны аян замд учирч байсан адал явдлаа ачда уйгагүй ярьж өгдөг байжээ. Өвгө нь ганц бөхт тэмээ үзүүлэх гэж өөрийг нь нүүдлийн цирк аваачсан нэг явдал жаал хүүгийн сэтгэлд үүрд хадагджээ. “зуун жилийн ганцаарал” романы эхний өгүүлбэрт гардаг жаал хүүгийн дүрээс ургаж уг роман бүтсэн гэж зохиогч өөрөө нэг удаа хэлсэн билээ.

Маркесийг найман настай байхад нь өвгө аав нь нас баржээ. Эцэг эх нь түүнийг Аркатакаас авч явсан байна. “Түүнээс хойш миний амьдралд ямар ч сонин юм болоогүй” гэж хожим нь Маркес бичсэн билээ. Хүүхэд насны нь сэтгэгдэл зохиолчийн уран бүтээлд яаж тусгасныг үзэхэд тэгж хэлсэн нь тийм ч их хэтрүүлэг биш шиг санагдана.

1946 онд Гарсиа Маркес Боготын их сургуулийн хуулийн ангид оржээ. 1948 онд либерал, консервативчуудын тэмцэл өрнөж, гудамжны тулалдаан болж, энэ нь олон жилийн зэвсэгт тэмцэл болж даамжирлаа. Их сургууль хаагдлаа. Маркес Картагенд очиж, тэндхийн их сургуульд үргэлжлүүлэн суралцах гэсэн боовч ирээдүйн мэргэжилдээ сонь буурсан тул сургуулиа бүрмөсөн орхижээ. Картагенд өнгөрүүлсэн дөрвөн жил Маркесийн уран бүтээлчийн хувьд төлөвшихөд үлэмж үүрэг гүйцэтгэжээ. Энд сонин сурвалжлагчаар ажиллаж, дөрвөн найзтай болсон нь Альваро Сепеда, Герман Варгас, Альфонсо Фуэмайор гэсэн гурван залуу сэтгүүлж, тэдний хүмүүжүүлэгч багш, номын мухлагийн эзэн, каталон өвгөн Раомон Виньес нар

байлаа. Тэр хэд үдэшдээ кафед уулзаж, эцэс төгсгөлгүй маргаж, нэртэй нэртэй хүмүүсийг шоглон шоолж, ертөнцийн бүх юмыг шүүмжлэн хэлэлцдэг байжээ.

Тэр үеийн амьдралаа романахаа сүүлийн бүлэгт оруулсан байна.. Тэр дөрөв дээр өөр нэг залууг нэмсэн нь Габриэль Гарсиа Маркес өөрөө билээ. Дашрамд хэлэхэд, энэ баатрын нууц амраг үзэсгэлэнт Мерседес мөн бодит хүн, номд гардгаар эмийн санчийн охин байсан бөгөөд тэрбээр зохиолч Габриэль Гарсиа Маркесийн гэргий болжээ.

Картахенд байхдаа “Хөрмөг” туужаа дуусгажээ. Энэ тууж залуу орчуулагч Нарантуяагийн орчуулгаар “Цог” сэтгүүлд хэвлэгдсэнийг уншиг чта сонирхон уншсан нь мэдээж. “хөмрөг” туужаа бичиж байхдаа бодит байдлыг яруу сайхнаар буулгасан л бол сайн рмоан болно гэж бодож байлаа. Гэтэл нөхөд маань уул туужийг уншаад, нийгмийн гэм согогийг илчилсэн юм даан ч байхгүй байна гэж намайг ёстой бут авсан” гэж зохиолч сүүлд нь бичсэн билээ.

1954 онд Боготод очиж, “Эль Эспектадор” сонин сурвалжлагчаар ажиллаж, Колумбийн улс төрийн амьдралд умбан оров. Эрх баригч бүлгийнхэн өөрсдийн дарангуйлал тогтоохын тулд хайр найргүй аллага хядлага үйлдэх болов. Тэсвэрлэхийн аргагүй болсон ард түмэн зэвсэг барин бослоо. Залуу сэтгүүлч эх орон нэгтнийхээ зовлон зүдгүүрийг зүгээр харж суусангйү .Тэр бээр нууц байдалд ажиллаж байсан коммунист намтай ойртож, үйл ажиллагаанд нь оролцох болов. 1955 оны зургадугаар сард “Эль Эспектадор” түүнийг Европ дахь сурвалжлагчаараа томилсон байна. Ромд хэдэн сар байхдаа сурвалжлагчийн үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээгээр “Кино урлагийн туршилтын төвд” найруулагчийн курст суралцжээ. Дараа нь Парист очоод байхад нь колумбийн дарангуйлагч Рохас Панилья “Эль Эспектадор” сонинг либерал чиглэлтэй гэж хаасан тухай гунигт мэдээ иржээ. Тийнхүү Маркес ажилгүй болсон байна. Сонины нь газар буцахын зардлыг түүнд өгч явуулсан боловч тэрбээр буцсангүй, Латины хороололд хямдхан тасалгаа хөлслөөд, хожим нь “Цэвүүн цаг” нэртэй болсон романаа бичиж эхэллээ. Бичиж байтал нь уг романы хоёрдугаар зэргийн баатар буюу засгийн газрыг тэтгэвэр өгөх байх гэж хүлээн суугаа өвгөн хурандаагийн дүр товойн гарч ирсэнд романаа дутуу орхиод, “Мартагдсан хурандаа” туужаа бичиж эхэлжээ. Энэ туужийн эхний нооргийг 1956 онд дуусгасан боловч хэвлүүлэхийнхээ өмнө есөн удаа хуулан засжээ. Зохиол чэнэ номоо хамгийн сайн болсон номынхоо нэг гэж үздэг байна. Энэ тууждаа зохиолч ганцаардлыг нийгмийн эмгэнэлт явдал гэж харуулсан байна. 1961 онд Кубад хувьсгал мандахад баяр хүргэж, Кубад ирэн, “Пренс Латина” агентлагийн сурвалжлагчаар Каракас, Богота, Нью-Йоркод ажиллаж байлаа. 1966 онд “Цэвүүн цаг” романаа дүүргэн хэвлүүлжээ. “Зуун жилийн ганцаардал” романы дараа бичсэн “Дарангуйлагчийн намар” романаа зохиолч “нэрийг минь мартагдахаас аврах ном” гэж үнэлсэн билээ. Зохиогч “Хөрмөг”-өөс эхлээд “Зуун жилийн ганцаардал” –аар дараалуулаад бүхий л уран бүтээлдээ дарангуйланчийн аймшигт дүрийг гаргажээ. Тэгэхдээ тэднийг гагцхүү гаднаас

нь зурж байсан байна. Чухамхүү “Дарангуйалгчийн намар”-т түүнийг жинхэнэ дотоод талаас нь гаргаж чаджээ. Маркес 1986 онд “Тахлын үеийн дурлал” романаа хэвлүүлэв. Залуудаа хайртай байгаад, ханилан сууж чадаагүй хоёр хүн ная орчим насандаа уулзахдаа эргэн дурлалцаж байгаа тухай ээн романдаа өгүүлжээ. Тэгээд энэ талаар өөрөө тайлбарлахдаа “Би баатрууддаа насны нь үүднээс бус, зөрчил, асуудлын үүднээс ханддаг юм. Хүний хувьд дотоод сэтгэл гол болохоос нас гол бус билээ” гэжээ.

Латин Америкийн шинэ роман эн зууны хорёдугаар хагаст товойн гарч, сая сая хүн ардын оюун санааг эзэмдэх боллоо. Куба Алехо Карпентьер, гватемал Мигель Анхел Астуриас, мексик Хуан Рульфо, Карлос Фуэнтес, бразиль Жоан Гимараэнс Роза, парагвай Аугустой Роа Бастос аргентин Хулиа Кортассер, перу Марио Варгас Льюсын туурвисан бүтээлүүд даян дэлхийд алдаршив. Латин Америкийн орчин үеийн романы гоо сайхны шинэчлэл нь түүнийг зохиогчид эртний домгийн сэтгэлгээнд хандаж байгад оршино гэж оон судлаачид үзэж байна. Тэгээд энэ шинэ романыг “шидэт реализм” гэсэн нэр томжёогоор тодорхойлж байна. “Зуун жилийн ганцаардал” романыг чухамхүү шидэт реализмын бүтээлийн оргил гэж үздэг. Гэтэл Маркес өөрийгөө “цэвэр реалист” тэр ч байтугай “гашуун реалист” гэж хэлэдг билээ. “гэхдээ хамгийн итгэмгүй үлгэрийг, хамгийн санаанд оромгүй явдлыг үнэн гэжүнэмшихээр өгүүлэхэд учир нь байгаа мю” эгж зохилч хэлсэн юм. Тийнүү Маркесийн “Зуун жилийн ганцаардал” романд домог, бодит байдал хоёр салшгүй сүлжилджээ. Энэ библийн домгоос авсан зүйл бий. Жишээлэхэд, романы эх ертөнц анх бүтсэн тухай, төгсгөл нь галав юүлэх тухай домгийг санагдуулж байна. Төрөл садантайгаа гэрлэснээс айхавтар цээрлэлд унаж, гахай сүүлтэй хүүхэд төрүүлж байгаа сэдвийг өнө эртний домгоос авчээ. Сайхан Ремедиос цагаан даавуу хөлөглөн тэнгэрт гарч, цыган Мелькиадес үхээд босож ирнэ. Дуучин, чөтгөртэй уралдаж, Амаранта эрлэгийн элчийн зарлигаар хулдсаа нэхнэ. Энэ бүхэн нь ардын үлгэрийн сэдэвтэй. Зохиолч баатруудынха адүрийг туульсын шинжтэй болгох далд санаагаар ийнхүү үлгэр домгийн сэдвийг өргөн ашиглажээ.

Маркесийн энэ романы зохиомжийн ноён нуруу нь Буэндиангийн зургаан үеийнхэн, анхны Буэндиагийн үндэслээд, сүүлчийн Буэндиатай хамт мөхөж байгаа Макондо хотын түүх юм. Нэгд үүнийг Буэндиагийнхны угийн бичиг гэж хэлж болно. Цашилбал энэ нь Колумбийн хөдөө нутаг, эхлээд онгон зэлүүд байснаа өвөр хоорондын цуст тулалдаанд нэрвэгдэж, хэсэгхэн зуур гадилын компаний хүчинд цэцэглээд, хэсэгхэн зуур гадилын компаний хүчинд цэцэглээд, дахин орхигдон мартагдсан Колумбийн тэр нутгийн түүх юм. Эцэст нь энэ нь хүн төрөлхтөний үүсэж хөгжиж ирсэн түүх юм. Энэ л үүднээс уг романыг ойлгох нь зүйтэй бололтой.

Ганцаардал нь уг романы үндсэн санаа юм. Энэ сэдэв “Хөрмөг” “Мартагдсан хурандаа” гээд олонхи зохиолд нь нэвт явж ирсэн билээ. Маркес

ганцаардахыг Буэндиагийнхны төрөлх шинж болгон харуулжээ. Гэхдээ энэ нь амьдралын янз бүрийн нөхцөл байдлаас болж байна. Хурандаа Аурелиано Буэндиа нийгмийн гэж болох шалтгаанаар ганцаардаж байхад Урсула сохорч өтөлсний улмаас Меме, Реебека нар дурлалаа бүтэлгүй болоход, Аркадио, сүүлчийн Хосе Аркадио нар хүүхэд байхаасаа эвдэрснээс болж ганцаардаж байна. Пилар Тернера, Пьетро Креспи, Санта Софи де ла Пьедад, Геринельдо Маркес зэрэг романы бусад баатар ч адилхан юм. Гэсэн ч идэвхтэй тэмцэлд дуудсан яриа Маркесийн энэрэнгүй үзэлд нэвт шингэжээ. Хүнд буюу нийгэмд учирч болох хамгийн муу юм гэвэл ганцаардан зориг мохож, өнгөрснийг мартаж, муу муухайд бууж өгөх явдал мөн. Тэгвэл хүнийг юу ч аварч чадахгүй, түүнийг улаан шоргоолж идчих буюу энэ ертөнцөд дүүрэн байгаа бузар булай бүхэн дорхон нь залгих болно гэдгийг Маркес харуулсан байна. чухамхүү үүнд “Зуун жилийн ганцаардал” романы жинхэнэ ардач чанар оршино. Ийнхүү уг романы талаар олон зүлийг хэлж болно. Гэвч Габриэль Гарсиа Маркес “Зуун жилийн ганцаардал” романыхаа далд санааг тайлж хэлээч гэж сурвалжлагч нарын хүсэхэд “би үүнд хариулж чадахгүй”гээд “Миний романыг хүн уншаад өөрийнхөөрөө ойлгож, баатруудыг нь өөрийнхөөрөө төсөөлж байгаасай, энэ бол зохиогч уншигчтай дотоод сэтгэлээрээ харилцаж байгаа хэрэг гэж би боддог” гэж хариулсан байдаг. Уран сэтгэмж сайтай, ухаан тгөс манай уншигч энэхүү романыг уншаад, мөн л өөрийнхөөрөө ургуулан бодсон миний бие итгэж байна гэснээр нуршуудуухан төгсгөийн үгээ дуусгая. !!